- 2005-2007 он Улаанбаатар хот, Төв Хасбанк, үндсэн хөрөнгийн бүртгэл хариуцсан менежер;
- 2002-2005 он Сүхбаатар аймаг Хасбанк, салбарын захирал;
- 1999-2002 он Сүхбаатар аймаг Монгол Шуудан банк, нягтлан бодогч;
- 1994-1999 он Сүхбаатар аймаг Монголбанк, оператор нягтлан бодогч.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-14
БҮРТГЭВ-03



**Б.Агваанцэрэн – Даатгалын газрын захирал**

*Боловсрол, мэргэжил:*

- 2004-2008 он МУИС-МКС- Эдийн засгийн математик загварчлал, Эдийн засагч математикч, бакалавр;
- 2008-2010 он СЭЗДС, Бизнесийн удирдлагын магистр;
- 2011-2013 он ХУИС, Эрдмийн сургууль, Англи хэлний орчуулагч.

*Ажлын туршлага:*

- 2022.05 оноос хойш Төрийн банк, Даатгалын газрын захирал;
- 2013-2022 он Төрийн банк, Маркетингийн хэлтэст Маркетингийн менежер, Сурталчилгаа, идэвхжүүлэлтийн албаны менежер;
- 2012-2013 он Хадгаламж банк, Маркетингийн менежер;
- 2011-2012 он Эрдхул ХХК, Дэд захирал;
- 2009-2010 он Дөтфранчайзинг ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2008-2009 он Сонгинохангай ХХК, Эконометрикч, менежер;
- 2008 он Мацумод ХХК, Ажилтан.

---



**А.Батмөнх –Дотоод хяналт,шалгалтын газрын захирал**

*Боловсрол, мэргэжил:*

- 2000-2004 он СЭЗДС, Бизнесийн удирдлагын бакалавр;
- 2008-2010 он ШУТИС КТМС, Санхүүгийн удирдлагын магистр.

*Ажлын туршлага:*

- 2018.01 оноос хойш Төрийн банк, Дотоод хяналт, шалгалтын газрын захирал;
- 2010-2018 он Төрийн банк, салбар хариуцсан ажилтан, ахлах мэргэжилтэн, Орон нутгийн үйл ажиллагааны хэлтсийн захирал, Улаанбаатар хот дахь үйл ажиллагааны хэлтсийн захирал, Зайны хяналтын хэлтсийн захирал, Хяналт шалгалтын

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
ГҮЙДЕК

газрын захирал, Хяналт шалгалтын газрын орлогч захирал;
- 2006-2010 он Монгол шуудан банк, Эдийн засагч, Бүс хариуцсан менежер;
- 2005-2006 он Мөрөн Интернэшнл ХХК, Эдийн засагч, эрсдэлийн удирдлагын мэргэжилтэн;
- 2004-2005 он Хаан банк, теллер, эдийн засагч, ахлах эдийн засагч.



**Б.Сугар – Харилцагчийн үйлчилгээний газрын захирал**

*Боловсрол, мэргэжил:*

- 2000-2004 он МУИС Эдийн Засгийн сургууль, Нягтлан бодох бүртгэл, эдийн засагч, бакалавр;
- 2016-2019 он МУИС Хууль зүйн сургууль, Эрх зүйч, бакалавр;
- 2019-2020 он МУИС Бизнесийн сургууль, Бизнесийн удирдлагын магистр.

*Ажлын туршлага:*

- 2021.09 оноос хойш Төрийн банк, Харилцагчийн үйлчилгээний газрын захирал;
- 2016-2021 он Төрийн банканд Зам тээврийн яам, Тооцооны төвийн захирал, Үйл ажиллагааны эрсдэлийн хэлтэст үйл ажиллагааны эрсдэлийн шинжээч;
- 2009-2015 он Төрийн банк, Эрсдэлийн удирдлагын хэлтэст ахлах ажилтан, Дотоод аудитын газарт аудитор, Аудитын төлөвлөлт эрсдэлийн үнэлгээний албаны захирал, Үйл ажиллагааны аудитын хэлтсийн захирал;
- 2006-2009 он Зоосбанк, Дотоод аудитын газрын хянан шалгагч;
- 2004-2006 он Хаан банк, Хянан шалгагч.



**Т.Баттулга – Аюулгүй байдлын газрын захирал**

*Боловсрол, мэргэжил:*

- 2008-2012 он Эдийн засгийн бизнесийн дээд сургууль, Олон улсын харилцаа, эдийн засаг, бакалавр;

- 2016-2019 он Удирдлагын академи, төрийн захиргааны менежмент магистр.

*Ажлын туршлага:*

- 2018.02 оноос хойш Төрийн банк, Аюулгүй байдлын газрын захирал;
- 2016-2018 он Төрийн банк, Хамгаалалт аюулгүй байдлын хэлтсийн захирал;
- 2012-2016 он Миллениум лайт ХХК, Гүйцэтгэх захирал.

---



**Н.Ганзориг – Үйл ажиллагааны газрын захирал**

*Боловсрол, мэргэжил*:

- 2007-2011 он Бээжингийн Олон улсын эдийн засаг худалдааны их сургууль эдийн засагч, бакалавр.

*Ажлын туршлага:*

- 2022.02 оноос хойш Төрийн банк, Ерөнхий эдийн засагч, Үйл ажиллагааны газрын захирал;
- 2018- 2022 он Төрийн банк, Ерөнхий үйлчилгээний хэлтэст Худалдан авалт хариуцсан мэргэжилтэн, Ерөнхий үйлчилгээний хэлтсийн захирал;
- 2015-2018 он Нэтив сэнд ХХК-д менежер;
- 2011-2015 он "Номин Трейдинг" ХХК-д Импортын менежер.

## БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ДЭРГЭДЭХ ХОРООД

### 1. Актив, пассивын удирдлагын хороо

Тус хороо нь банкны бусдаас татан төвлөрүүлсэн болон өөрийн хөрөнгийг өндөр үр ашигтай хэлбэрээр банкны активт байршуулах, хугацаа болон хүүний хувьд оновчтой удирдаж, тэдгээрийн харьцааг Монголбанкнаас тогтоосон зохистой хэмжээнд байлгаж, банкны ашигт ажиллагааг эрсдэл тооцсон нийт дүнд хамгийн өндөр байлгахад чиглэсэн үйл ажиллагааг зохицуулах үндсэн чиг үүрэгтэй бөгөөд нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй.

### 2. Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хороо

Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хороо нь банкны алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн харилцагчийн эрэлт хэрэгцээг хангахуйц, банканд үр өгөөжтэй, бүтээгдэхүүн, үйлчилгээг судлах, нэвтрүүлэх, зах зээлд гарсан бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах, идэвхжүүлэхтэй

холбоотой саналыг хэлэлцэж шийдвэрлэдэг ба нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй.

**3. Зээлийн ерөнхий хороо**

Зээлийн ерөнхий хороо нь Төрийн банкны ТУЗ-өөс баталсан Зээлийн бодлогын хүрээнд зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, бодлогын хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлд холбогдох журам зааврыг батлах, хэрэгжилтийг хангуулах, банкны зээлийн багцын чанар, тогтоосон хязгаарт байнга хяналт тавих, зээлийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй бөгөөд 7 гишүүний бүрэлдэхүүнтэй.

**4. Зээлийн дэд хороо**

Зээлийн дэд хороо нь Зээлийн ерөнхий хорооноос тогтоосон хэм хэмжээний хүрээнд зээлийн өргөдлийг хэлэлцэн шийдвэрлэх, банкны зээлийн багцын чанар, тогтоосон хязгаарт тогтмол хяналт тавих, зээлийн эрсдэлийг бууруулах чиглэлээр холбогдох журам зааврын хэрэгжилтийг хангуулах үндсэн чиг үүрэгтэй бөгөөд 5 гишүүний бүрэлдэхүүнтэй.

**5. Мэдээллийн технологийн хороо**

Банкны бизнес төлөвлөгөөг дэмжин, мэдээллийн технологийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан ажиллах, шаардлагатай технологийн хөрөнгө оруулалтын хэрэгцээг бизнесийн шаардлагад нийцүүлэн төлөвлөх, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах үндсэн чиг үүрэгтэй бөгөөд нийт 7 гишүүний бүрэлдэхүүнтэй.

**6. Хүний нөөцийн хороо**

Банкны эрхэм зорилго, стратегийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг тодорхойлох, банкны газар, хэлтэс нэгжийн чиг үүрэг, орон тоог төлөвлөх хуваарилах, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, сургаж хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, гүйцэтгэл үр дүнд суурилсан цалин хөлс, шагнал урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох, нийгмийн баталгааг хангах, боловсон хүчний зардал, хүний нөөцийн сургалт, үйл ажиллагаатай холбоотой төсөв санхүүг төлөвлөх, хөдөлмөрийн харилцааг зохицуулах зэрэг асуудалд бодлого, удирдлагын чиглэл, шийдвэр гаргах үндсэн чиг үүрэгтэй бөгөөд 7 гишүүний бүрэлдэхүүнтэй.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-14
БҮРТГЭВ-03

### 7. Эрсдэлийн удирдлагын хороо

Эрсдэлийн удирдлагын хороо нь Монгол улсын холбогдох хууль тогтоомж, Банкны эрсдэлийн удирдлагын бодлого, холбогдох бусад журам, заавар, хорооны ажиллах журмыг удирдлага болгон банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг хамгийн бага байлгах зарчмыг баримтлан зээлийн болон үйл ажиллагааны эрсдэлийн түвшин, нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж холбогдох шийдвэрийг гаргах, гүйцэтгэлд хяналт тавьж, гүйцэтгэлийг хэлэлцэн дүгнэж ажилладаг ба 9 гишүүний бүрэлдэхүүнтэй.

## ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Төрийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын асуудал эрхэлсэн хороо болон Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны үйл ажиллагаагаараа дамжуулан хяналтын чиг үүргээ хэрэгжүүлдэг. Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн харьяа Дотоод аудитын газар нь компанийн засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны зохистой байдалд хараат бус, бие даасан үнэлгээ хийх, зөвлөх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Банкны гүйцэтгэх удирдлагын хувьд дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж, удирдан зохион байгуулах үндсэн үүргийн хүрээнд банкны эрсдэлийн түвшин хамгийн бага байх хяналтын нэгдсэн бүтцийг бүрдүүлж ажилладаг бөгөөд гурван давхар хамгаалалтын шугам бүхий эрсдэлд суурилсан дотоод хяналтын тогтолцоог хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- Хамгаалалтын нэгдүгээр шугам-Банкны нэгжүүд нь эрсдэлийн удирдлагыг үйл ажиллагаандаа үр дүнтэй хэрэгжүүлж ажилладаг ба нэгжүүдийн өдөр тутмын шат дараалсан хяналт хэрэгжүүлж, өөрийн эрх мэдэл, үүрэг хариуцлагаас давсан, банканд томоохон хэмжээний эрсдэл авчирч болохуйц эрсдэлийн талаар холбогдох дээд удирдлага, нэгжийн Эрсдэлийн удирдлагын хороо болон банкны Эрсдэлийн удирдлагын хороонд танилцуулан зөвлөмж, шийдвэр гаргуулан, хэрэгжүүлж ажилладаг.
- Хамгаалалтын хоёрдугаар шугам- Банкны төвийн газар, хэлтэс, алба нь өөрийн чиг үүрэгт тусгагдсан ажлууд болон бизнесийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх бодлогын баримт бичигт эрсдэлийн удирдлага, шат дараалсан хяналтын тогтолцоог бүрдүүлж ажилладаг. Удирдлагын багийн хувьд Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын баталсан бодлого, эрсдэлийн аппетит, эрсдэлийн хязгаарлалтыг зохистой түвшинд хангаж ажиллах шийдвэрийг гаргаж, холбогдох чиглэл, үүрэг даалгавар өгч ажилладаг.
- Хамгаалалтын гуравдугаар шугам- Дотоод аудитын газар нь банкны засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх, бодлогын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд сайжруулах арга хэмжээний талаар зөвлөмжийг өгөх, түүнд эргэн хяналт тавих байдлаар ажилладаг.

## 1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ МЭДЭЭЛЭЛ

### ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

*Схем 2. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц*




### ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

*Хүснэгт 2. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид*

| № | Хувьцаа эзэмшигч | Хувьцаа гаргахаас өмнө | | Хувьцаа гаргасны дараа | |
|---|---|---|---|---|---|
| | | Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг | Эзэмшлийн хувь | Эзэмших хувьцааны тоо ширхэг | Эзэмшлийн хувь |
| 1 | Сангийн яам | 372,000,000 | 52.25% | 372,000,000 | 49.63% |
| 2 | Хадгаламжийн даатгалын корпораци | 340,000,000 | 47.75% | 340,000,000 | 45.37% |
| 3 | Олон нийт | - | - | 37,475,000 | 5.0% |
| | НИЙТ ДҮН | 712,000,000 | 100% | 749,475,000 | 100% |

| № | Хувьцаа эзэмшигчийн оноосон нэр | Улсын бүртгэлийн дугаар | Регистрийн дугаар | Хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэр |
|---|---|---|---|---|
| 1 | Сангийн яам | 9070005013 | 9131787 | Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлчилгээний газар |
| 2 | Хадгаламжийн даатгалын корпораци | 9081001124 | 8108994 | Сан |

## БАНКНЫ ХОЛБОГДОХ ЭТГЭЭД

Банкны холбогдох этгээдийг Монгол улсын "Банкны тухай хууль"-ийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.30 дахь заалтын хүрээнд авч үзэх бөгөөд үүнээс дараах этгээдүүдийг онцлон дурдав. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигч хуулийн этгээд

| № | Банкны хувьцаа эзэмшигч | Хувьцааны эзэмшлийн хувь | Хувьцааны тоо ширхэг | Регистрийн дугаар | Улсын бүртгэлийн дугаар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Сангийн яам | 52.25% | 372,000,000 | 9131787 | 9070005013 |
| 2 | Хадгаламжийн даатгалын корпораци | 47.75% | 340,000,000 | 8108994 | 9081001124 |

2. Хувьцааных нь тав болон түүнээс дээш хувийг банк эзэмшдэг хуулийн этгээд

| № | Хуулийн этгээдийн нэр | Хувьцааны эзэмшлийн хувь | Хувьцааны тоо ширхэг |
|---|---|---|---|
| 1 | МВАРМ ХХК | 20.41% | 81,550 |

3. Банкны эрх бүхий албан тушаалтан

Төрийн банкны дүрмийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтад зааснаар банкны эрх бүхий албан тушаалтанд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, газар, хэлтэс, албадын захирал, салбар, тооцооны төв, кассын захирал, эрхлэгч, системийн хэмжээний нягтлан, ахлах менежерүүд хамаардаг болно.

4. Зэргэлдээ компани

Дараах хуулийн этгээдүүд банкны зэргэлдээ компанид хамаарч байгаа болно.

| № | Хуулийн этгээдийн нэр | Хувьцаа эзэмшигч | Хувьцааны эзэмшлийн хувь |
|---|---|---|---|
| 1 | Монголын хөрөнгийн бирж ТӨХК | Сангийн яам | 100% |
| 2 | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК | Сангийн яам | 100% |
| 3 | Үндэсний давхар даатгал ХК | Сангийн яам | 100% |
| 4 | Монгол Улсын Хөгжлийн банк ХХК | Сангийн яам | 100% |
| 5 | Монголын Үнэт цаасны клирингийн төв ХХК | Сангийн яам | 100% |

# 1.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

## 1.4.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭЗЭМШИЖ БУЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

### Монголбанкны тусгай зөвшөөрөл:

1 Мөнгөн хадгаламж
2 Зээл
3 Төлбөр тооцоо
4 Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах
5 Үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах
6 Үнэт зүйл хадгалах
7 Гадаад төлбөр тооцоо хийх
8 Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах
9 Гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх
10 Салбар тооцооны төв байгуулах
11 Картын үйл ажиллагаа

### Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөл:

- Даатгалын зуучлагч

## 1.4.2 АМЖИЛТ ОЛОЛТ, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

**Амжилт ололт**




**“Bloomberg TV mongolia awards”-аас шагнал хүртлээ**

Монгол Улсын хөгжилд бодитой хувь нэмэр оруулж эдийн засаг, бизнес, санхүүгийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн шилдгүүдийг шалгаруулдаг “Bloomberg TV Mongolia Awards”-аас Төрийн банк “Шилдэг Өсөлт” шагналыг хүртлээ.




**Монгол улсын топ-100 аж ахуйн нэгжээр дахин тодорлоо**

Төрийн банк нь Монгол Улсын Засгийн Газар, МҮХАҮТ-аас жил бүр тодруулдаг ТОП-100 аж ахуйн нэгжээс 8 дугаар байрт эрэмбэлэгдэж, банкны салбарын шилдэг 4 банкны нэгээр шалгаран, өмнөх жилүүдийн амжилтаа ахиуллаа.




**“Шилдэг татвар төлөгч”-өөр шалгарлаа**

Төрийн банк Монгол Улсын нийгэм эдийн засагт томоохон хувь нэмэр оруулан 2021 онд 24.9 тэрбум төгрөгийн татвар төлж, улсын төсөвт 15.8 тэрбум, орон нутгийн төсөвт 9.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлж Монгол Улсын Сангийн яам, Татварын ерөнхий газрын талархлыг хүртсэн.

**“Эрнст энд янг монголия аудит” байгууллага санхүүгийн тайланг баталгаажууллаа**

Банк 2021 оны санхүүгийн тайландаа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Эрнст Энд Янг” хөндлөнгийн аудитын байгууллагаар аудит хийлгэж, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэж дүгнэгдлээ.



**“Үлгэр жишээч” аж ахуйн нэгжээр шалгаруулллаа**

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас төрийн өмчит компаниудтай байгуулсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г 2020 оны жилийн эцсээр дүгнэж, гэрээний үүргээ хангалттай сайн биелүүлсэн Төрийн банкийг “Үлгэр жишээч” аж ахуйн нэгжээр шалгаруулсан.



**Алсын хараа, стратегийг шинэчлэн баталлаа**

Төрийн банк алсын хараагаа шинэчлэн “Дундаж давхаргыг дэмжигч, Үндэсний тэргүүлэгч банк” болгон баталж, энэхүү алсын хараа, эрхэм зорилгын хүрээнд 2021-2024 онд “Дундаж давхаргыг дэмжих банкны үйл ажиллагааны цогц төлөвлөгөө”-г боловсруулан, амжилттай хэрэгжүүлж байна.




**Технологийн шинэчлэлт хийж, NES системд шилжлээ**

Технологийн шинэчлэл хийж NES системд шилжсэнээр харилцагчийн мэдээллийн аюулгүй байдал сайжирч, дансны дугаарлалт олон улсын нэгдсэн дугаарлалт /IBAN/-д шилжиж байгаа бөгөөд цаашид системийн найдвартай, тасралтгүй байдлыг хангах боломжийг бүрдүүллээ.




**E-mongolia.mn-д нэгдлээ**

Төрийн банкны харилцагч Гялсбанкны эрхээрээ E-Mongolia.mn системд нэвтрэн орж, Төрийн үйлчилгээг хурдан шуурхай авах боломжтой боллоо.




**Репо хэлцэл амжилттай хийлээ**

Төрийн банк 2018 оноос хойш репо хэлцлээр бага хүүтэй, хямд эх үүсвэр амжилттай татан ажиллаж байна.



### ТОС-ын тогтолцоог хэрэгжүүлэгч банк

"Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ToC)-ийн гишүүдээс хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний баримт бичиг"-т тусгагдсан зарчмуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн банк холбогдох бэлтгэл ажлыг бүрэн хангаж, үнэлгээ хийлгэн "B" үнэлгээг авав.



### Санхүүгийн боловсрол олгох зорилтот аянуудад амжилттай оролцлоо

Монголбанкнаас олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй аянуудад Төрийн банк тогтмол амжилттай оролцож, "Ятгах тусам нягтал" аянд III байр, "Дэлхийн мөнгөний 7 хоног" олон улсын аянд дэд байр эзлэн хүндэт цомын эзэн боллоо.

## Нийгмийн хариуцлага

Төрийн банк нь нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль дэлхийд ээлтэй төсөл, хөтөлбөрүүдийг дэмжин ажиллахын зэрэгцээ нийгмийн зорилтот хэсэг хүүхэд, залуусын хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулан ажилласаар байна.

Байгаль орчин, ногоон төслийг дэмжсэн үйл ажиллагаа:



### "Байгальд ээлтэй Гялс цэвэрлэгээ" аян

Төрийн банк нь байгаль орчноо хамгаалах, байгальд ээлтэй бизнесийг дэмжихэд онцгой анхааран ажилладаг бөгөөд олон нийтийн анхаарлыг байгаль хамгаалах асуудалд хандуулах зорилт тавин, "Байгальд ээлтэй Гялс цэвэрлэгээ" аяныг жил бүр санаачлан зохион байгуулж байна.

Тус аяны хүрээнд Монгол Улсын бүх хот сууринд байрлах Төрийн банкны 500 нэгжийн 4000 ажилтан, албан хаагчид өөрсдийн амьдарч буй хот, аймаг, дүүрэг, сумын гол горхи, ундны усны сав газрыг цэвэрлэж, 700-800 тонн буюу нийт 400 орчим машин хог хаягдлыг цуглуулж ачуулдаг. Байгаль Орчны Яамны Харьяа Туул Голын Сав Газрын захиргаанаас "Байгальд ээлтэй Гялс цэвэрлэгээ" аяныг амжилттай хэрэгжүүлж, байгаль хамгаалах үйлсэд бодит хувь нэмрээ оруулж байгааг үнэлэн Төрийн банкны хамт олонд "Талархал"-ыг гардуулсан билээ.

СЗХ 2022 09 21 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 2022-09-14 БҮРТГЭВ-03
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК



### “Нэг ажилтан, нэг мод” аян

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд Төрийн банк нэгдэж, мод суулгах үйл ажиллагаанд ажилтан, хамт олноороо манлайлан оролцлоо. Төрийн банк “Модыг мода болгоё” уриан дор “Ажилтан бүр нэг мод” аяныг жил бүр уламжлал болгон өрнүүлж, Монгол Улсын өнцөг булан бүрт байрлах 500 орчим салбар нэгжийн 4000 гаруй ажилтныхаа оролцоотойгоор 5,000 орчим мод суулгаад байна.




### Хүрээлэн төсөл

Төрийн банк нь хойч үеэ байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, байгаль, амьтанд хайртай зөв хүн болгон төлөвшүүлэхэд өөрийн бодит хувь нэмрээ оруулах зорилгоор “Хүрээлэн” төсөлтэй хамтран “Эко карт”-ыг зах зээлд нэвтрүүлж, борлуулсан карт бүрээсээ 1000 төгрөгийг “Хүрээлэн” төслийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулж, байгаль, ховор амьтдаа хамгаалах ажлыг дэмжин ажиллаж байна.




### Миний Монгол хөтөлбөр

Төрийн банк нь 21 аймгийн байгалийн үзэсгэлэнт зурагтай “Миний Монгол” олон улсын виза картыг зах зээлд гаргасан бөгөөд борлуулсан карт бүрийн жилийн хураамжийн тодорхой хувь нь тухайн аймгийн байгаль хамгаалах үйлсэд зориулагдаж байна.

Нийгмийн зорилтот бүлэгт хандсан үйл ажиллагаа:




### Хүндэтгэлийн аян

Төрийн банк нь нийт салбар нэгжээрээ дамжуулан 620 харилцагч ахмадуудад хүнсний дэмжлэг үзүүлж, Улаанбаатар хотын салбар нэгжээр үйлчлүүлж буй карт, цахим үйлчилгээнд бүртгэлтэй ахмадуудад Гялсбанк болон АТМ-ыг хэрхэн ашиглах талаар зөвлөмж, мэдээллийг өгч ажиллалаа.




### Хуримтлалтай дундаж давхаргыг дэмжих хөтөлбөр

Төрийн банк нь хуримтлалтай дундаж давхаргыг бойжуулах, зорилтот бүлгийг хуримтлалтай болгох, тэдний санхүүгээ зөв удирдах, хуримтлуулах зуршлыг нь дэмжих зорилгоор “Мөрөөдлөө

хадгалъя" хадгаламжийн урамшуулалт аяныг хэрэгжүүллээ. Тус аяны хүрээнд санхүүгийн зөвлөх, лектор, нэр хүндтэй нөлөөлөгчдөөр дамжуулан харилцагчдад хуримтлал үүсгэх болон санхүүгийн сахилга баттай холбоотой зөвлөгөө, мэдээллийг хүргэсэн.



### Шинэ үеийн залуус

Төрийн банк шинэ үеийн залуусын "Z" картыг шинээр нэвтрүүлж, оюунлаг, нийгмийн идэвхтэй, шилдэг залуустаа зориулан "Z" картын урамшуулалт хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд "Элсэлтийн ерөнхий шалгалт"-ын 10 хичээл тус бүрээс 800 оноо авсан оюунлаг залуусаа "Z" картаар урамшууллаа.



### "Оюунлаг залуусаа дэмжье" хөтөлбөр

Төрийн банкнаас Монгол хүний оюуны чадамжийг Дэлхийд гайхуулж буй "Оюунлаг залуусаа дэмжих" хөтөлбөрийн хүрээнд Монголын шатрын холбоотой хамтран ажиллаж, Шатрын их мастер, Монгол Улсын Гавьяат тамирчин Ц.Батчулуун Дэлхийн 3 удаагийн аварга, өсвөрийн шатарчин Д.Мөнхзулыг дэмжин ажиллалаа.





### Үндэсний бахархлыг дэмжигч байгууллага

Төрийн банк нь Монголын соёлын өвийг дэлхийд сурталчлах, түүх, өв соёлыг таниулах контент, хөтөлбөрийг дэмжин ажилладаг. Тухайлбал, "Их Монгол" цахим наадам, хүүхдэд зориулсан Монголын нууц товчоо комик номыг бэлтгэх ажилд хувь нэмрээ оруулав.



### "Цусаа хандивлан, Амьдрал бэлэглэе" өдөрлөг

Төрийн банк Цус сэлбэлтийн судлалын үндэсний төвтэй хамтран "Цусаа хандивлан, Амьдрал бэлэглэе" өдөрлөгийг зохион байгуулж, Улаанбаатар хотын салбар нэгж болон төвийн газар, хэлтсийн ажилтнуудаа хамрууллаа.

## Цар тахлын үеэр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа:

Төрийн банк нь цар тахлын дэгдэлт, хорио цээрийн үед иргэд, бичил, жижиг бизнес эрхлэгчдээ санхүүгийн хүндрэл бэрхшээлийг даван туулахад нь дэмжин ажилласны зэрэгцээ харилцагчдаа халамжилсан нийгмийн хариуцлагын ажлуудыг зохион байгууллаа.




### Цахим дархлаа хөтөлбөр

Төрийн банк Коронавирусын эсрэг III тунгийн вакцинжуулалтын ажлыг дэмжиж, харилцагчдыг III тундаа идэвхтэй хамрагдахыг уриалан, зайнаас цахим үйлчилгээг авах боломжийг олгох зорилгоор "Цахим дархлаажуулалт" аяныг хэрэгжүүлж, III тунд хамрагдсан харилцагчийн Гялсбанкны хураамжийг бүрэн чөлөөллөө.




### Онлайн золголт

Сар шинийн баярын үеэр цар тахлын тархалт өндөр байгаатай холбоотойгоор олон нийтийг цахимаар золгохыг уриалан, "Онлайн золголт"-ын кампанит ажлыг орон даяар зохион байгуулж, Гялсбанкны жилийн хураамжийг чөлөөлсөн.




### Зөвлөмж мэдээлэл

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн 12 цуврал зөвлөмжийг нийт 200,000 харилцагчдадаа хүргэв.

### 1.4.3 БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

Төрийн банк нь арилжааны банкуудаас хамгийн олон төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд нийцүүлэн санал болгодог бөгөөд 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 144 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг 2.3 сая харилцагчдадаа үзүүлж байна. Үүнд харилцах, хадгаламжийн 26, төслийн болон өөрийн эх үүсвэртэй зээлийн 58 бүтээгдэхүүн, 24 төрлийн карт, 9 төрлийн цахим бүтээгдэхүүн болон бусад бүтээгдэхүүн үйлчилгээг 495 салбар нэгж, 40 киоск, 347 АТМ, 5500 гаруй ПОС төхөөрөмжөөр дамжуулан хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна.

*Схем 3. Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн үйлчилгээ*




### Харилцах, хадгаламжийн үйлчилгээ

Төрийн банк нь 11 төрлийн харилцах дансны үйлчилгээгээрээ хүүхдийн мөнгө, тэтгэвэр, халамж, малчны урамшуулал гэх мэт төрийн үйлчилгээний 80 хувийг үзүүлж байна. Мөн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг эрсдэлгүй найдвартай хадгалах зорилгоор хугацаагүй болон 370 хоног хүртэл хугацаатай, жилийн 10.2% хүртэл хүүтэй, нийт 15 төрлийн хадгаламжийн бүтээгдэхүүнээр харилцагчдадаа хуримтлал үүсгэх, хүүгийн орлого олох боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

**Онцлох бүтээгдэхүүн:**

Дундаж давхаргаа дэмжсэн, харилцагчийг хуримтлалтай болгох боломжийг бүрдүүлсэн хадгаламжийн бүтээгдэхүүнүүдийг харилцагчдадаа дараах нөхцөлтэй санал болгон үйлчилж байна.

*Иргэдэд зориулсан үйлчилгээ:*

Хамгийн олон харилцагчтай, нийгмийн бүхий л давхаргад үйлчилдэг Төрийн банкны харилцагчдын ихэнх хувийг малчид болон орон нутгийн иргэд, бизнес эрхлэгчид эзэлдэг.

**Төрийн банканд иргэд хадгаламжийн данс эзэмшихийн давуу талууд:**

- Өрсөлдөхүйц өндөр хүүгээр хадгалуулах;
- Харилцагчийн хүсэлтээр хүү үндсэн дансанд орох эсвэл тухайн харилцагчийн нэр дээрх бусад дансанд орохоор тохируулах боломжтой;
- Хүүгийн орлогоо сар бүр авах болон хүүгээс хүү тооцуулж авах;
- Гялсбанкны үйлчилгээг ашиглан дансаа удирдах боломжтой;

**“Таван эрдэнэ” хадгаламж**

Төрийн банкнаас хуримтлалтай дундаж давхаргыг дэмжих зорилтын хүрээнд орон нутгийн иргэд, малчдад зориулан өрхийн бүтээмж, эдийн засгийн чадамжаа нэмэгдүүлэх, хадгаламжийн хүүгээр мөнгөө өсгөх болон сар бүр хадгалуулсан мөнгөндөө бодогдсон хүүг авч хэрэглээндээ зарцуулах боломжийг олгодог хөнгөлөлттэй нөхцөлтэй, хугацаатай хадгаламж юм.




***“Таван эрдэнэ” хадгаламж нь 5 давуу талтай. Үүнд:***

- Хадгаламжийн хүүгээ сар бүр тооцуулж, үндсэн хадгаламждаа нэмэгдүүлэн хүүгийн хүү авах эсвэл хүүгээ картандаа сар бүр авч ашиглах;
- Мөнгөн хадгаламжаа 3 сар болон түүнээс дээш хугацаагаар байршуулсан бол гэрээний хугацаанд 1 удаа хүү бууруулахгүйгээр зарлага гаргах;
- Гар утсаараа дансаа удирдах боломжтой “Гялсбанк” үйлчилгээнд үнэгүй бүртгүүлэх;

СЗХ
2022 оны 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -09- 14
БҮРТГЭВ-03

- Таван эрдэнэ хадгаламж нээлгэж, хуримтлал үүсгэснээр Төрийн банкны ЭКО карт болон "Миний Монгол" брэнд картыг эхний жилийн хураамжаас чөлөөлөх;
- Малчны зээлийг хүүгийн хөнгөлөлттэй нөхцөлөөр авах боломжийг тус тус олгодог.

### Байгууллагад зориулсан үйлчилгээ

Төрийн банк нь байгууллагуудад зориулсан харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бизнесийн үйл ажиллагааг тогтвортой явуулах нөхцөлийг бүрдүүлэх, мэргэжлийн түвшинд, найдвартай, шуурхай хүргэх зорилготой ажилладаг бөгөөд нийт 17 мянга гаруй аж ахуйн нэгж Төрийн банкны харилцах, хадгаламжийн дансыг идэвхтэй ашиглаж байна.



**Харилцах дансны үйлчилгээ** – Тус дансыг нээлгэснээр аж ахуйн нэгжийн өдөр тутмын бэлэн болон бэлэн бус төлбөр тооцоо, гадаад, дотоодын шилжүүлэг, Гялсбанкны үйлчилгээ, онлайн орлого, зарлагын гүйлгээ гэх мэт олон төрлийн үйлчилгээг нэг дороос авах таатай боломжийг бүрдүүлдгээрээ онцлогтой.

**Хугацаатай хадгаламж** - Аж ахуйн нэгж нь мөнгөн хөрөнгөө хадгалуулснаар жилийн 10.0 хувь хүртэлх хүүгийн орлого олж, гэрээний хугацааны туршид зарлага гаргах боломж зэрэг таатай нөхцөлтэй хадгаламжуудыг санал болгодог.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5344469 ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ
ГҮЙДСЕК ҮЦК ХХК
ТТБ8674 5208173

СЗХ
он 2022 сар 09 21 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022-09-14
БҮРТГЭВ-03

**Онцлох бүтээгдэхүүн:**



**Тэтгэврийн сан хадгаламж:**

Байгууллагын ажилтан цалин орлогоосоо тодорхой хувь хэмжээгээр урт хугацаанд хуримтлал үүсгэх, сар бүр хүүгээс хүү тооцуулах нөхцөл бүхий "Тэтгэврийн сан хадгаламж"-ийн бүтээгдэхүүнийг санал болгож байна. Тус хадгаламж нь ажил олгогч, ажилтан, банктай гурвалсан гэрээ байгуулж, сар бүр тогтмол хуримтлал үүсгэснээр байгууллага ажилтнаа урт хугацаанд тогтвор суурьшилтай ажиллуулах, ажилтан ирээдүйн хувийн тэтгэврийн сан бий болгох боломжийг бүрдүүлнэ.

***Платинум хадгаламж болон Арвижих хадгаламж:***



Байгууллагад зориулан сар бүр хүү авах, зарлага гаргах уян хатан нөхцөл бүхий "Платинум" болон "Арвижих" хугацаатай хадгаламжийн бүтээгдэхүүн санал болгож байна.

**Төрийн банканд байгууллагын хадгаламжийн данс эзэмшихийн давуу талууд:**

- Байгууллагын хүсэлтээр хүү үндсэн дансанд орох эсвэл тухайн байгууллагын нэр дээрх бусад дансанд орохоор тохируулах боломжтой
- Гялсбанкны үйлчилгээг ашиглан дансаа удирдах боломжтой.
- Хүүгийн орлогоо сар бүр авах болон хүүгээс хүү тооцуулж авах
- Хүү бууруулахгүйгээр сар бүр зарлага гаргах эрхтэй хадгаламжийн онцлох үйлчилгээ
- Байгууллага ажилтнуудаа урт хугацаанд тогтвор суурьшилтай, сэтгэл ханамжтай ажиллуулах хуримтлалын бүтээгдэхүүнийг тус тус санал болгож байна.

## Зээлийн бүтээгдэхүүн

Төрийн банк нь харилцагч иргэн, ААН-үүдэд үндсэн 5 төрлийн зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлж байна.

1. Бизнесийн зээл
2. Хэрэглээний зээл
3. Орон сууцны зээл
4. Хөдөө, аж ахуйн зээл
5. Төслийн зээл

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК

### *1. Бизнесийн зээл*

Төрийн банк нь харилцагч байгууллага болон иргэдэд бизнесийн эргэлтийн хөрөнгийг нь санхүүжүүлэх зорилгоор Бичил бизнесийн зээл, Эргэлтийн хөрөнгийн зээл, Хөдөө аж ахуйн биржийн зээл, Шугамын зээл, Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл, ПОС-ын орлого барьцаалсан зээлийг, тоног төхөөрөмж худалдан авах, үйлдвэрлэл, үйлчилгээгээ өргөтгөх, шинэчлэх зэрэг бизнесийн үйл ажиллагаанд нь зориулан Хөрөнгө оруулалтын зээл, Зоорь барих, засварлах болон худалдан авах зээл, Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл, Тээврийн бизнесийн зээл, Үл хөдлөх хөрөнгө худалдан авах зээлийг тус тус санал болгож байна.

*Онцлог:*

Байнгын найдвартай зээлдэгч, стратегийн ач холбогдол бүхий иргэн, байгууллагын хувьд зээлийн хүсэлт, судалгаа шинжилгээ, үр ашигт үндэслэн хүүг сарын 1.2 хувь хүртэл бууруулж, 96 сар хүртэл хугацаатай, урьдчилгаа төлбөр, шимтгэл хураамжийн хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох боломжтойгоороо онцлог юм.

**Онцлох бүтээгдэхүүн:**













### *2.Хэрэглээний зээл*

Төрийн банк нь харилцагчдадаа иргэдийн өрх гэр, хувийн хэрэгцээнд зориулан Цалингийн зээл, Хөрөнгө барьцаалсан хэрэглээний зээл, Ахуйн хэрэглээний зээл, Автомашины зээл, Кредит карт, Тэтгэврийн зээл, Хадгаламж барьцаалсан зээл /онлайн/, Сургалтын төлбөрийн зээл, Гялс зээл зэрэг зээлийг сарын 1.0 хувь хүртэл хүүтэйгээр авах боломжийг олгон ажилладаг.

## Онцлох бүтээгдэхүүн




Цахилгаан тээврийн хэрэгслийн зээл: Төрийн банкны Ногоон зээлийн бүтээгдэхүүн нь 100% цахилгаан хөдөлгүүрт Эко автомашин, Цахилгаан скүүтер, Унадаг дугуй зэргийг хамгийн бага хүүтэйгээр авах боломжтой. Энэхүү ногоон зээл нь урьдчилгаа төлбөргүй, сарын 1.0 хувийн хүүтэй, 30 сар хүртэл хугацаагаар авах боломжтой гэдгээрээ онцлогтой.

*Гялс зээл:*




Гэнэтийн санхүүгийн хэрэгцээгээ хангах зорилгоор цахимаар хүсэлтээ илгээн, цалин болон бизнесийн орлогоо судлуулан 3.0 сая хүртэл төгрөгийг ажлын 3 цагийн дотор шийдвэрлүүлэн авах боломжтой хялбар хэрэглээний зээл юм.

*Шинэ автомашины зээл:*




Гэр бүлийн хэрэглээндээ зориулан цоо шинэ автомашин авах хүсэлтэй харилцагч нартаа зориулан урьдчилгаа төлбөрийг 0% хүртэл бууруулан, сарын 1.0%-ийн хүүтэйгээр, иргэн бол 30 сар, байгууллага бол 96 хүртэл сарын

хугацаатайгаар авах давуу нөхцөлтэй зээлийг санал болгодог.

### 3. *Орон сууцны зээл*

*Орон сууцны ипотекийн зээл:* Төрийн банк нь “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-ыг үндэслэн улсын комисс ашиглалтад хүлээн авсан, улсын бүртгэлд бүртгэгдсэн, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээгээр баталгаажсан орон сууц шинээр худалдан авахад зориулан энэхүү зээлийг олгодог.

**Өөрийн эх үүсвэртэй орон сууц, амины сууц, хашаа байшингийн зээл:**

Тогтмол мөнгөн орлоготой иргэдийн орон сууц, амины сууц, хашаа байшин худалдан авах болон амины сууц, хашаа байшин барихад шаардагдах санхүүгийн хэрэгцээг хангахад зориулсан, сарын хүүг 1.2 хувь хүртэл шатлан бууруулж, 200 хүртэл сая төгрөгийг олгох боломжтой зээл юм.

**ОНЦЛОХ БҮТЭЭГДЭХҮҮН:**

***Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зээл***: Дулааны алдагдалгүй, эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй амины сууц бариулах болон худалдан авах харилцагч нарт ногоон таксономиг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд хамгийн бага буюу сарын 1.0 хувийн хүүтэй орон сууцны зээлийг санал болгож байна.



СЭХ
2022 .07. 21
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03

## 4. Хөдөө аж ахуйн зээл

Төрийн банк орон нутгийн иргэдийнхээ хэрэгцээнд нийцүүлэн дундаж давхаргыг дэмжихэд чиглэх зорилгын хүрээнд малчин, мал бүхий өрхөд малчны зээл, малчны ахуйн хэрэглээний зээл, даатгалын хураамжийн зээл, малчны орон сууцны зээлүүдийг санал болгодог бол газар тариалан эрхлэгч иргэн, аж ахуй нэгжид газар тариалангийн зээлийн бүтээгдэхүүнүүдийг 495 салбар нэгжээрээ дамжуулан хүртээмжтэй хүргэж байна.

**Онцлох бүтээгдэхүүн**

**Малчны зээл:**

Малчин өрхөд хөрөнгө худалдан авах болон хэрэглээний зориулалтаар олгох зээл юм.

Зээлийн төрөл:

- Малчны зээл
- Малчны даатгалын зээл
- Малчны ахуйн хэрэглээний зээл

| Зээлийн нөхцөл | |
|---|---|
| Зээлийн хүү /сар/ | 1.5% - 1.8% |
| Зээлийн хугацаа | 24 хүртэл сар |

**Малчны ахуйн хэрэглээний зээл**

Банктай ахуйн хэрэглээний зээлээр хамтран ажиллах гэрээ байгуулсан хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагаас малчин өөрөө эзэмших, ашиглах зориулалтаар хөрөнгө худалдан авахад зориулагдсан зээл юм.



**Малчны орон сууцны зээл**

Тус зээл нь малчин өрх орон сууц, хашаа байшин, амины сууц худалдан авах, барихад зориулсан зээл юм.

| Зээлийн нөхцөл | |
|---|---|
| Зээлийн хэмжээ | 100.0 сая төгрөг хүртэл |
| Зээлийн хүү /сар/ | 1.5%-1.4% |
| Зээлийн хугацаа | 96 хүртэл сар |

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ХХК

## 5. Төслийн зээл

Монгол Улсын Засгийн Газар, Монголбанк болон бусад байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилтийг хэрэгжүүлж байна.

Тухайлбал, Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө” -ний дагуу Ажлын байрыг дэмжих зээл, Газар тариалангийн зээл, Ноолуурын түүхий эд бэлтгэх эргэлтийн хөрөнгийн зээл, Хаврын тариалалтын зээл, Орон сууц ипотекийн зээл болон Малчдыг дэмжих зээлийг Төрийн банкаар дамжуулан олгосон.






**Картын бүтээгдэхүүн**

Нийгмийн хариуцлагын хүрээнд төсөл хөтөлбөрүүдийг дэмжсэн, нийгмийн бүх давхаргыг хамарсан картын бүтээгдэхүүнийг санал болгодог ба иргэнд 22 төрөл, байгууллагад 2 төрлийн картаар төлбөр тооцоог түргэн шуурхай үзүүлэх боломжийг олгож 1.1 сая карт эзэмшигчдэдээ таатай нөхцөлийг санал болгон ажиллаж байна.

Төрийн банк нь дотоодын ₮ карт, VISA, Union Pay, JCB гэсэн үндсэн 4 төрлийн брэндийн картыг харилцагчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн олон төрлийн сонголттойгоор гаргадаг. Эдгээр картууд нь нууцлал аюулгүй байдлын олон улсын стандартад нийцсэн EMV чиптэй, PayWave зайнаас унших технологитой.

**Дотоодын ₮ карт:**

Картын төрөл: Энгийн карт, Цалингийн карт, Тэтгэврийн карт, Сурагчийн карт, Бизнес болон Төсвийн байгууллагын карт, Эко карт, Хүнс талоны карт, Халамжийн карт, Хүүхдийн мөнгөний картуудыг харилцагчдадаа санал болгож байна.

**Эко карт:**

Хүрээлэн төсөлтэй хамтран нэн ховордсон амьтдын зурагтай Эко картыг Монголд анх удаа зах зээлд гаргаж, төлбөр тооцоонд ашиглахаас гадна картын жилийн хураамжаас 1,000 төгрөгийг нэн ховордсон амьтдыг хамгаалах санд хандивладаг.



**Олон улсын карт:**

VISA брэндийн карт нь дэлхийн 220 улсад ашиглагддаг бөгөөд Энгийн, Алтан, Байгууллагын бизнес карт мөн энгийн, алтан гэсэн 2 төрлийн кредит картыг харилцагчдадаа санал болгодог.

**Залууст зориулсан Z карт:**

Шинэ үеийн /17-29 насны/ залуучуудад зориулан дотоодод болон олон улсад төлбөр тооцоонд ашиглагдах, PayWave зайнаас унших технологитой карт.



Хөнгөлөлт урамшуулал:

- Төрийн банкны АТМ-ээс бэлэн мөнгө авахад шимтгэлгүй
- Гялсбанкны эхний жилийн хураамжгүй
- Гэнэтийн ослын даатгалын хураамжгүй
- Захиалсан картаа шуудангаар үнэгүй хүргүүлэх

| № | Нөхцөл | Валют | Дансны доод үлдэгдэл | Хугацаа | Жилийн хураамж |
|---|---|---|---|---|---|
| 1 | Z карт | MNT/USD | 0₮ /0$ | 4 жил | 10,000₮ тэнцэх валют |

***Миний Монгол карт:***

21 аймгийн үзэсгэлэнт байгалийн зурагтай, иргэдийн өдөр тутмын тооцоо болон олон улсад төлбөр тооцоонд ашиглагдах нууцлал, аюулгүй байдлыг хангасан EMV чиптэй, ПОС төхөөрөмж дээр зайнаас унших Pay wave технологи бүхий төгрөг болон ам.долларын валютын сонголттой виза дебит картыг харилцагч нартаа санал болгож байна.



Тус картыг авснаар “Миний Монгол” картын жилийн хураамжийн орлогоос 1,000 төгрөг тухайн орон нутагт мод тарих үйлсэд зарцуулагддагаараа онцлог.

| № | Нэр/ Нөхцөл | Валют | Дансны доод үлдэгдэл | Хугацаа | Жилийн хураамж |
|---|---|---|---|---|---|
| 1 | Миний Монгол карт | MNT/USD | 1,000₮ /1$ | 4 жил | 20,000₮ тэнцэх валют |

UP брэндийн карт нь дэлхийн 180 улсад ашиглагддаг бөгөөд банк Дебит Энгийн, Алтан, Платинум картыг харилцагч нартаа санал болгож байна.

**Онцлох бүтээгдэхүүн:**

Платинум карт:



- Гадаад зорчигчийн даатгал /90 хоног/ үнэгүй
- Олон Улсын нисэх VIP танхимаар үйлчилгээ авах урамшууллын Priority pass картыг дагалдуулан олгодог.

JCB брэндийн карт нь дэлхийн 19 улсад ашиглагддаг бөгөөд Төрийн банк нь төгрөг болон иений сонголттойгоор харилцагчдадаа санал болгож байна.



Монголд анх удаа JCB брэндийн картыг карт гаргагчаар гаргасан цор ганц банк юм.

Дээрх олон улсын Алтан болон Платинум карт эзэмшигч харилцагчдадаа дурын салбар нэгж дээр дараалал хүлээлгэхгүйгээр VIP үйлчилгээ үзүүлж байна.

## Цахим бүтээгдэхүүн

Төрийн банк нь Дунд хугацааны стратеги төлөвлөгөөндөө "Цахим шилжилт хийх" зорилтыг тусгаж, харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн цахим үйлчилгээг хүртээмжтэй хүргэхээр ажиллаж байна. Харилцагч иргэн, аж ахуй нэгжүүдэд 9 төрлийн цахим үйлчилгээг санал болгодгоос Гялсбанк үйлчилгээ, Мессеж мэдээ үйлчилгээг давхардсан тоогоор 1.7 сая харилцагч зайнаас авч, өдөр тутмын төлбөр тооцоондоо ашигладаг.

Мөн Монгол улсад анх удаа Хувийн дугаар үйлчилгээ, Цахим төгрөг үйлчилгээ, Автомат хуримтлал үйлчилгээнүүдийг нэвтрүүлсэн.

Төрийн банканд харилцагчаар бүртгүүлснээр онлайнаар зайнаас данс нээх, Гялсбанк үйлчилгээнд бүртгүүлэх, карт захиалах, дахин захиалах болон зээлийн хүсэлт илгээх, Киоск төхөөрөмжөөр банкны бүх төрлийн үйлчилгээг авах боломжтой байна.

### Онцлог үйлчилгээ

### Гялсбанк үйлчилгээ



Бүх төрлийн санхүүгийн хэрэгцээг хангах боломжтой цахим үйлчилгээний цогц шийдэл Төрийн банкны Гялсбанк үйлчилгээ нь 4 төрлийн буюу интернэт банк, смарт аппликейшн, мобайл банк, мессеж банкны үйлчилгээгээр бүх төрлийн санхүүгийн үйлчилгээг зайнаас авах, төлбөр тооцоогоо цаг хугацаа, орон зайнаас үл хамааран түргэн шуурхай гүйцэтгэх боломжийг олгодог.

Харилцагч Гялсбанкаараа онлайнаар болон гар утсаа ашиглан банкны 80 гаруй төрлийн үйлчилгээг зайнаас авах боломжтой. Үүнд:

СЭХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
ТӨРИЙН БАНК
2022-09-14

- Дансны бүх төрлийн үйлчилгээ авах, банк хооронд болон гадаад шилжүүлэг хийх
- Хэрэглээний төлбөрөө төлөх, автоматаар төлөх үйлчилгээнд холбох
- Утасны төлбөр төлөх, нэгж авах, дата авах
- Гааль, нийгмийн даатгал болон төлбөрүүд төлөх
- Торгууль төлөх, татвар төлөх;
- Цахим төгрөг (АТМ-ээс картгүйгээр бэлэн мөнгө авах) үйлчилгээний гүйвуулгын код авах;
- Зээл авах, төлөх, эргэн төлөлтийн графиктай танилцах
- Данс нээх, хадгаламжийн хугацаа сунгах, карт захиалах
- Хугацаагүй хадгаламжийн дансаа хугацаатай хадгаламжид шилжүүлэх
- Картаа хаах, нээх, интернэт пин код авах
- Багц гүйлгээ хийх / нэг үйлдлээр олон данс руу зэрэг гүйлгээ хийх/
- Онлайнаар арилжааны хэлцэл хийх
- Бүх төрлийн цахим үйлчилгээнд бүртгүүлэх гэх мэт банкны үйлчилгээг илүү хялбараар авах боломжийг олгоно.

*Схем 4. Гялсбанк үйлчилгээ*




Төрийн банк нь Улаанбаатар хот, орон нутагт байрлах 495 салбар нэгжээрээ дамжуулан 1,500 орчим СӨХ, Биллер байгууллагатай хамтран ажиллаж, давхардсан тоогоор жилд 10 сая гаруй хэрэглээний төлбөрийн гүйлгээ хийдэг бөгөөд биллингийн зах зээлийн 90 хувийг эзэлж байна. Тэд харилцагчийнхаа эрэлт хэрэгцээнд тулгуурлан хэрэглээний төлбөрийг дараах цахим

КАПИТАЛ ҮЦК ХХК
ТӨРИЙН БАНК
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

сувгуудаар бүртгэлийн хураамжгүй, түргэн шуурхай төлөх боломжийг бүрдүүлсэн.

- И-Биллинг үйлчилгээнд харилцагч банканд ирж бүртгэл хийлгэлгүйгээр Төрийн банкны www.statebank.mn хуудсаар дамжуулан өөрөө онлайнаар бүртгүүлж, өөрийн болон бусдын хэрэглээний төлбөрийг лавлах, төлөх боломжтой.
- Автомат биллинг үйлчилгээнд банканд нэг удаа ирж автомат биллинг үйлчилгээний гэрээ байгуулснаар сар бүрийн хэрэглээний төлбөр, дараа төлбөрт хэрэглэгчийн ярианы төлбөрөө данснаасаа автоматаар төлөх , төлбөрийн баримтыг харилцагчийн бүртгэлтэй и-мэйл хаягаар хүргэдэг.
- Гялсбанк биллинг үйлчилгээгээр Гялсбанканд бүртгэлтэй харилцагч Банкны цахим хуудас аппликейшн, гар утасны симд суулгасан цэс болон мессеж сувгийг ашиглан хэрэглээний төлбөрөө лавлах, төлөх боломжтой.
- Төрийн банкны карттай харилцагч өөрт ойрхон АТМ дээр хэрэглээний төлбөрөө төлөх боломжтой.

Төрийн банкны цахим сувгуудаар хэрэглээний төлбөр төлөхөд ямар ч шимтгэлгүй бөгөөд хэрэглээний төлбөр төлсөн и-баримт нь харилцагчийн бүртгэлтэй и-мэйл хаягт илгээгдэж, НӨАТУС-д автоматаар бүртгэгддэг.

**Киоск төхөөрөмж**

Төрийн банк нь дэвшилтэт технологид суурилсан шинэлэг үйлчилгээг тасралтгүй хөгжүүлж, нэгжийн ачааллыг бууруулах, харилцагчийн хүлээлгийн хугацааг богиносгох, харилцагчид санхүүгийн үйлчилгээг хялбар түргэн шуурхай үзүүлэх зорилгоор харилцагч өөртөө үйлчлэх цахим теллер буюу киоск төхөөрөмжийг 2021 онд зах зах зээлд нэвтрүүлсэн.



*Киоск төхөөрөмж ашиглан дараах үйлчилгээг хялбараар авах боломжтой:*

- Орон сууцны төлбөр, Гар утасны төлбөр, Интернэт, Торгууль, татвар төлөх
- Өөрийн данс, Банк дотор, Банк хооронд гүйлгээ хийх
- Карт захиалах, И-Пин код авах
- Хадгаламж барьцаалсан зээл авах
- Дансны хуулга, тодорхойлолт авах
- Хадгаламж болон харилцах данс нээх, сунгах

Киоск төхөөрөмжөөр бүх банкны бүх төрлийн картаар төлбөр төлөх боломжийг нэвтрүүлсэн анхны банк болсон.

**Автомат хуримтлал үйлчилгээ:**




Автомат хуримтлалын үйлчилгээ нь данс болон картаараа худалдан авалт хийх, зээл төлөх, цахим үйлчилгээг ашиглан хэрэглээний төлбөрөө төлөхөд таны сонгосон дүнгээр бүхэлчлэн зарлага гарч, зөрүү мөнгөө дансандаа автоматаар хуримтлуулах үйлчилгээ юм. Таны хийсэн төлбөрийн гүйлгээний дүнгээс мянгачлах, таван мянгачлах, арван мянгачлах 3 сонголтоор бүхэлчлэл тооцогдоно. Зөвхөн Төрийн банканд байдаг энэ үйлчилгээ нь харилцагчид санхүүгийн дарамт учруулахгүйгээр хялбар аргаар хуримтлал үүсгэх боломжийг олгодог.

**Хувийн дугаар үйлчилгээ**

Хувийн дугаар үйлчилгээ нь 4-8 оронтой дугаарыг дансны дугаарын оронд ашиглан гүйлгээ хийх боломжтой Төрийн банкны дэвшилтэт үйлчилгээ юм. Дансны дугаарыг төлөөлөх, цээжлэхэд хялбар, хүссэн тоогоо Хувийн дугаараар сонгож, үнэгүй авах боломжтой.

## Дансны тусгай дугаарын үйлчилгээ




Төрийн банк нь Монголоос хамгийн түрүүн дансны дугаарлалтын олон улсын баталгаажуулалт /IBAN/-д шилжиж мэдээллийн аюулгүй байдал сайжруулан технологийн шинэчлэлт хийн үндсэн системээ NES систем руу шилжүүлснээр харилцагчид хүссэн оронтой дансны дугаараа сонгох боломжийг олгон "Дансны тусгай дугаарын үйлчилгээ"-г нэвтрүүлсэн. Дансны тусгай дугаарыг бүх төрлийн валютын харилцах данс, хугацаагүй болон хугацаатай хадгаламжийн дансанд олгодог үйлчилгээ юм.

*Схем 5. Дансны тусгай дугаарын бүтэц*




## Мөнгөн гуйвуулга

Төрийн банк нь 6 орны 15 банктай корреспондент харилцаатай ажилладаг. БНСУ-д төлөөлөгчийн газартайгаар үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд олон улсын SWIFT, ВЕСТЕРН ЮНИОН, КОНТАКТ гэсэн 3 төрлийн гадаад төлбөр тооцооны бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлдэг.



СЗХ
оны 2022 сар 08 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-14

- SWIFT сүлжээг ашиглан таны гадаад төлбөр тооцоог хүссэн газарт тань хамгийн түргэн шуурхай, найдвартай дамжуулах болон хүлээн авах үйлчилгээг үзүүлж байна. Дэлхийн аль ч оронд түгээмэл ашиглагддаг Америк доллар /USD/, Евро /EUR/, Английн фунт /GBP/, Хятадын юань /CNY/, Японы иен /JPY/, Оросын рубль /RUB/, Солонгосын вон /KRW/ зэрэг валютаар гадаад гуйвуулга илгээх боломжтой.
- ВЕСТЕРН ЮНИОН мөнгөн гуйвуулга нь нууцлалыг дээд зэргийн хамгаалсан байх ба гуйвуулга бvрийг хяналтын дугаар, таны сонгосон нууц vгээр давхар шалгаж баталгаажуулдаг. Шилжvvлгийн мөнгөн дvн болон илгээгч, хvлээн авагчийн тухай мэдээллийг бид чанд нууцалдаг.
- ВЕСТЕРН ЮНИОН мөнгөн гуйвуулгын үйлчилгээг авахын тулд банканд данстай байх шаардлагагүй, хэн ч хаана ч авах боломжтой.
- КОНТАКТ мөнгөн гуйвуулга нь олон улс хооронд хямд шимтгэлтэйгээр мөнгө шилжүүлэх, хүлээн авах иргэдэд зориулсан үйлчилгээ юм. Контакт гуйвуулгаар дамжуулан 130 гаруй улс орон руу шилжүүлэг хийх боломжтой.

**Аккредитив**

Аккредитив нь гадаад худалдааны уламжлалт төлбөр тооцооны хэрэгслүүдийн нэг бөгөөд худалдаа эрхлэгч талуудын гэрээний үүргийн биелэлтийг хангахад чухал ач холбогдолтой үйлчилгээ юм. Гадаад худалдаанд оролцогч талууд алслагдсан зайд орших тул барааг нийлүүлэх болон төлбөр тооцоог гүйцэтгэх ажиллагаа цаг хугацааны хувьд аль нэг нь түрүүлж явагддаг. Иймд аккредитивын үйлчилгээгээр дамжуулан талууд гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг харилцан хянах боломжтой болдог онцлогтой.

Төрийн банк нь харилцагчдадаа аккредитивын үйлчилгээг дараах давуу нөхцөлтэйгөөр үзүүлж байна:

• COMPLEX: Төлбөр тооцоо + Төлбөрийн баталгаа + Хямд санхүүжилт хосолсон үйлчилгээ;
• RELIABLE: Гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах, анх удаа худалдаа хийж буй талуудын хооронд харилцан итгэлцэл бий болгох;
• FLEXIBLE: Талууд барааны төлбөрийн уян хатан нөхцөл тогтоох боломжтой.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ХХК

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭВ-03

*Хүснэгт 3. Гадаад худалдааны уламжлалт төлбөр тооцоо*

| Бүтээгдэхүүн, үйлчилгээ | Олон улсын нэршил | Харилцагч | Зориулалт |
|---|---|---|---|
| Импортын аккредитив нээх (эх үүсвэртэй, эх үүсвэргүй) | Issuing a letter of credit | Импортлогч | Барааны төлбөр шилжүүлэх |
| Экспортын аккредитив хүлээн авах | Advising a letter of credit | Экспортлогч | Барааны төлбөр хүлээн авах |
| Импортын аккредитивд давхар баталгаа гаргуулах | Letter of credit confirmation | Импортлогч | Олон улсын банкаар давхар баталгаа гаргуулах |
| Аккредитивын дараах санхүүжилт | Letter of credit post-finance | Импортлогч | Импортын аккредитивын төлбөрийг санхүүжүүлэх |
| Аккредитивын төлбөрийг санхүүжүүлэх | Letter of credit re-finance | Импортлогч | Аккредитивын төлбөрийг Төрийн банкны бизнесийн зээлээр санхүүжүүлэх |

**Даатгалын зуучлалын үйл ажиллагаа**

Төрийн банк нь Банкны тухай хууль болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 296 дугаар тогтоолоор тусгай зөвшөөрөл авч даатгалын зуучлалын үйл ажиллагаа эхлүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд арилжааны 10 банк даатгалын зуучлалын үйл ажиллагааг гүйцэтгэдэг ба Монголын банкны холбооны дэргэдэх Даатгалын зуучлалын мэргэжлийн зөвлөлийг сүүлийн хоёр жил Төрийн банк удирдан ажиллаж байна.

**Хамтын ажиллагаа:**

Харилцагчийн эрсдэлийг тараан байршуулах, таатай нөхцөлөөр даатгуулах сонголт хийх боломжийг олгох зорилгоор 2022 онд Монгол улсад даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй 15 ердийн даатгалын компаниас шаардлага хангасан 12 даатгалын компани болон давхар даатгалын “Үндэсний давхар даатгал” ХК, урт хугацааны даатгалын “Нэйшнл лайф даатгал” ХХК, Албан журмын даатгалын холбоотой тус тус “Хамтран ажиллах гэрээ” байгуулж “БАНК-ДААТГАЛ”-ын цогц үйлчилгээг үзүүлж байна.

СЗХ
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ-03

**Бүтээгдэхүүн үйлчилгээ:**




Төрийн банк нь харилцагчид санхүүгийн хэрэгцээг нэг цэгээс бүрэн хангах боломжийг бүрдүүлэх, чанартай даатгалын бүтээгдэхүүнийг нэг дор харьцуулж, бага хураамжаар өндөр эрсдэлийн хамгаалалт авах боломжоор хангаж 40 орчим нэр төрлийн бүтээгдэхүүнийг 495 салбар, нэгжээрээ дамжуулан зуучлан борлуулж байна. Төрийн банкаар зуучлуулан даатгуулсан харилцагч нарт жилд дунджаар 5,000 харилцагчид тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулж, тэдгээрт учирсан бодит санхүүгийн эрсдэлийг бууруулж, үүссэн эрсдэлээс хамгаалж ажиллаж байна.

## 1.4.4 ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ

*Хүснэгт 4. Монгол улсын зээлжих зэрэглэл*

| Үнэлгээ | |
|---|---|
| **Төрийн банк ХХК** | |
| Улс | Монгол |
| Урт хугацааны crr | B3 |
| Төрөл | Lt counterparty risk rating - fgn curr |
| Төлөв | - |
| Урт хугацааны өр төлбөр | - |
| Урт хугацааны хадгаламж | B3 |
| Төрөл | Lt bank deposits - fgn curr |
| Төлөв | Тогтвортой |

Төрийн банк ХХК-ийн B3 зэрэглэл нь Суурь Зээлийн Чадамжийн Үнэлгээ (BCA)-ний B3-тай ижил түвшинд байна.

Банкны үйл ажиллагаа иргэдэд илүүтэй чиглэсэн тул санхүүжилт болон хөрвөх чадвар нь тогтвортой, нарийн судалсан зээлийн түүхүүдтэй олон тооны жижиг зээлдэгчдээс бүрдсэн, Монгол Улсын Засгийн газар (B3 тогтвортой) шууд бусаар эзэмшдэг тул төрөөс тодорхой дэмжлэгтэй ба капиталжуулалт тогтвортой хийгддэг гэж үзэж BCA үнэлгээг B3 гэж тогтоов.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

СЗХ он 2022 сар 09 өдөр 2? БҮРТГЭВ № 5

2022-09-14 БҮРТГЭВ-03

## 1.4.5 ДУНД ХУГАЦААНЫ БИЗНЕСИЙН СТРАТЕГИ, МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төрийн банк нь дунд хугацаандаа:

- ✓ Дундаж давхаргыг дэмжих
- ✓ Жижиг дунд бизнесийг хөгжүүлэх
- ✓ Өрхийг орон сууцжуулах
- ✓ Барилгын салбарын ажлын байрыг нэмэгдүүлэх
- ✓ Иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх зэрэгт тус тус чиглэсэн олон улсын жишигт нийцсэн санхүүгийн цогц үйлчилгээг үзүүлэх замаар нийгмийн дундаж давхаргыг бий болгогч Үндэсний тэргүүлэгч, дэвшилтэт банк байх зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

2022-2024 оны Дунд хугацааны зорилгыг хэрэгжүүлэх стратегийн тэргүүлэх 3 чиглэлийг тодорхойлж, үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Дундаж давхаргад зориулсан санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүгийн боловсрол олгох
2. Цахим шилжилт хийж дундаж давхаргын харилцагчид чиглэсэн бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх,
3. Банкны үйл ажиллагааг байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, зохистой засаглалыг бэхжүүлэх чиглэлд хандуулах.

Дундаж давхаргад зориулсан санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүгийн боловсрол олгох

- Дундаж давхаргыг бий болгоход дэмжих бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх:

**Зорилт:** Төрөөс хэрэгжүүлж буй бодлого чиглэлийг дэмжиж санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, өрхийг орон сууцжуулах, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн банкны үйлчилгээг хүргэх зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэснээр Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засгаа сэргээх цогц төлөвлөгөөг дэмжих замаар дундаж давхаргыг бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ.

- ✓ Салбар нэгжийн бүтээгдэхүүн борлуулалтыг нэмэгдүүлж, үйлчилгээний ачааллыг бууруулах, харилцагчид чиглэсэн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулна.
- ✓ Иргэдэд ОСИЗ авах боломжийг хялбаршуулах. Засгийн газраас дэд бүтцийг шийдвэрлэж байгаа орон сууцны барилгуудыг барих компаниудыг санхүүгийн үйлчилгээгээр дэмжин ажиллана.

**2022 он**

Дундаж давхаргыг дэмжих, хуримтлал үүсгэх боломжийг бүрдүүлсэн 2 шинэ хадгаламжийн бүтээгдэхүүн нэвтрүүлнэ:

- Халамжтай хадгаламж;
- Дундаж давхаргын хуримтлалын хадгаламж;

Зээлийн шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлнэ:

- Гарааны бизнесийн зээл;
- Халамжтай хадгаламж барьцаалсан зээл;
- Орон нутгийн иргэдийн өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зээл;

**2023 он**

- Эрүүл иргэн хадгаламж;
- Хүүгүй зээлийн эрх;
- Байгаль орчин, Нийгэм, Засаглалын зарчимд нийцсэн зээл;

**2024 он**

- Аяллын хадгаламж;
- Орон сууцны барилгын төслийг санхүүжүүлэх зээл;
- Санхүүгийн түрээс;

- Дундаж давхаргыг дэмжихэд чиглэсэн идэвхжүүлэлт, санхүүгийн боловсрол олгох арга хэмжээг хэрэгжүүлэх

**Зорилт:** Дундаж давхаргыг бий болгогч Үндэсний тэргүүлэгч банк байх алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн дундаж давхаргад чиглэсэн санхүүгийн боловсрол олгох дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- ✓ Санхүүгийн боловсрол олгох сургалтыг үе шаттай зохион байгуулах, хэрэгжүүлэх;
- ✓ Төрийн банкны харилцагч ЖДҮ, гарааны бизнес эрхлэгчдэд борлуулалтыг дэмжсэн үзэсгэлэн худалдаа, форумыг хамтран зохион байгуулах;
- ✓ Дундаж давхаргын иргэдэд хуримтлал үүсгэх зуршил бүтээх, Хуримтлал үүсгэх, Амжилтын кейс сурталчлах өдөрлөг арга хэмжээ зохион байгуулах;
- ✓ Санхүүгийн боловсрол олгох, Хуримтлал үүсгэх ач холбогдлын чиглэлээр цуврал контентууд бэлтгэх, Боловсролын төслүүдтэй хамтран ажиллах, залуучуудыг дэмжих "Сан" байгуулах ажлуудыг зохион байгуулна;
- ✓ Нийгмийн халамж үйлчилгээ банкаар дамжуулан авдаг харилцагч нарт зориулсан "Санхүүгийн боловсрол олгох өдөрлөг" арга хэмжээг зохион байгуулна;

- Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчийн бизнесийн үйл ажиллагаа болон ажлын байрыг дэмжих санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэх

**Зорилт:** ЖДҮ эрхлэгчдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, Төрөөс явуулж буй бодлогыг дэмжиж бага хүүтэй зээл олгох. Банкны бүх төрлийн үйлчилгээг цогцоор үзүүлэх зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэснээр Жижиг, дунд, бизнес эрхлэгч аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллана.

- ✓ Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхэд, жендерийн эрх тэгш байдал, хөгжлийн

СЭХ
он сар өдөр
2022 09 14
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭВ-03

бэрхшээлтэй иргэдэд тэгш байдал хангах зарчмыг баримтлан үйлчлэх;
- ✓ Дундаж давхаргыг бойжуулагч банк концепцийг олон нийтэд түгээх, ойлгуулах, хоногшуулахын тулд банкны брэнд реклам гаргах. ЖДҮ-н газартай хамтран ажиллах, инкубатор төв байгуулах ажлыг хэрэгжүүлэх;
- ✓ Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих бизнесийн зээлийн багцыг өсгөж ашигт ажиллагааг нэмэгдүүлэх;
- ✓ Бичил болон жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих БИЗНЕС ИНКУБАТОР төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, Инкубатор төвөөр дамжуулан бизнес эрхлэгч нарыг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Төрийн болон төрийн бус байгууллагууд, төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах, бизнес эрхлэгчдийг мэдээ, мэдээлэл, зөвлөгөөгөөр хангах;
- ✓ Жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, харилцагчид санхүүгийн боловсрол олгох;
- ✓ Бизнес төв болон нэгжүүдээр дамжуулан бизнес эрхлэгчдэд мэдээлэл хүргүүлэх, сургалт зохион байгуулах ажлыг тухай бүр зохион байгуулах.
- ✓ Бизнес эрхлэгч нарт зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээ, гарааны бизнес болон жендерийн тэгш байдал, хөгжлийн бэрхшээлтэй бизнес эрхлэгчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, албан бус секторт ажиллаж буй бизнес эрхлэгч нарыг дэмжсэн зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, нөхцөлийг сайжруулах, хүрч үйлчлэх.

- Зах зээлээ тэлэх, салбар нэгжийг оновчтой зохион байгуулах

**Зорилт:** Том аж ахуйн нэгж болон жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг татах, ПОС, QR код, Гялсбанкны үйлчилгээгээр хамтран ажиллах. Олон улсын чиг хандлага, дотоод зах зээл, өрсөлдөөний судалгаа болон бүтээгдэхүүн тус бүрээр борлуулалт, үр өгөөжийг тооцож, судлах. Улаанбаатар, орон нутгийн салбар, нэгжийн байрны тохижилт, чанар байдлыг сайжруулж, хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

- ✓ Их дээд сургуулиуд болон томоохон байгууллага ААН, бизнес эрхлэгчидтэй уулзалт, аян зохион байгуулж татан төвлөрүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлнэ.
- ✓ Жил бүр ПОС төхөөрөмжийн тоог нэмэгдүүлж, цахим үйлчилгээг өргөжүүлнэ.
- ✓ Датад суурилсан маркетинг хийхэд шаардлагатай программ хангамжуудыг нэвтрүүлэх хөгжүүлэх, үйл ажиллагаандаа ашиглах

2022-2024 онд хүрэх санхүүгийн зорилт

- Банкны системийн нийт активт эзлэх хувийг 10.2 хувьд хүргэх;

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО
ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

- Банкны системийн нийт депозитын зах зээлд эзлэх хувийг 11 хувиас бууруулахгүй байх.

**Хөрөнгийн удирдлага:**

- ✓ Олон улсын нэр хүнд бүхий зэрэглэл тогтоогч байгууллагаар банкны зээлжих зэрэглэлийг тогтоолгох;
- ✓ Гадаад хамтын ажиллагааг тогтвортой байлгах, өргөжүүлэх;
- ✓ Олон улсын зах зээлээс татах эх үүсвэрийг нэмэгдүүлэх.

- Банкны системийн нийт зээлийн багцад эзлэх хувийг 12.8 хувьд хүргэх;

- ✓ Зээлийн хүүг бууруулах стратегийг баримтлан зээлийн багцыг оновчтой бүрдүүлэн ажиллана.
- ✓ Жижиг дунд бизнес эрхлэгч ААНБ харилцагчаар татах, зээлийн санхүүжилт олгох замаар харилцагчдын бизнесийн цар хүрээг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлж зээлийн багцыг нэмэгдүүлж ажиллана.
- ✓ Засгийн газар болон төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийг дэмжиж, хамтарч ажиллана.
- ✓ Харилцагчид зээл авах таатай нөхцөлийг бүрдүүлэх, шинээр зах зээлд нэвтрүүлэх зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан таниулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- Ашгийн хэмжээг өөрийн хөрөнгийн 14.5 хувьд хүргэх

- ✓ Нэгж бүрийг ашигтай ажиллуулахад анхаарч өнгөрсөн хугацааны ашгийг нэмэгдүүлж ажиллана.
- ✓ Гадаад худалдаа эрхлэгч байгууллагуудыг татах, банкны худалдааны санхүүжилтийн үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлнэ.

- Шимтгэл хураамжийн орлогыг 15 хувиар нэмэгдүүлэх

- ✓ Хүүгийн бус орлогыг нэмэгдүүлэхийн тулд ПОС-ын зах зээл эзлэлтийг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний борлуулалтыг идэвхжүүлнэ.
- ✓ Гадаад валютын арилжааны зах зээлийг харилцагчид нээлттэй хүртээмжтэй болгох, тэдэнд зах зээлд өрсөлдөхүйц сайн гадаад валютын арилжааны бүтээгдэхүүн санал болгох.
- ✓ Экспортын үйл ажиллагаа эрхэлдэг томоохон аж ахуйн нэгжүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх, тэдний валютын орлогыг төвлөрүүлэх, төгрөгт хөрвүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх.
- ✓ Биет алтны арилжааг идэвхжүүлэх, биет алттай холбоотой бусад бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх.
- ✓ Кастодиан банкны үйлчилгээг нэвтрүүлэх.
- ✓ Даатгалын зуучлалын үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэх.

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -09- 14
БҮРТГЭВ-03

✓ Ажилтнуудын борлуулалт хийх идэвхи санаачилгыг сайжруулж, цахим бүтээгдэхүүний борлуулалтыг өсгөснөөр бүтээгдэхүүн үйлчилгээний шимтгэл хураамжийн орлогыг нэмэгдүүлнэ.

- Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээг 8 хувиас хэтрүүлэхгүй

✓ Зээлийн багцын чанарыг тогтмол сайжруулах;
✓ Чанаргүй активыг бууруулах стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах.
✓ Өмчлөх бусад хөрөнгө, борлуулах зориулалттай хөрөнгийг худалдан борлуулах, активын хөрвөх чадварыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах.
✓ Хугацаа хэтэрсэн болон чанаргүй актив, бусад авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах.

## Цахим шилжилт хийж дундаж давхаргын харилцагчид чиглэсэн бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх

- Төрийн банкны нийт харилцагчийн 50 хувийг цахим үйлчилгээ хэрэглэгч болгосноор нийт гүйлгээнд эзлэх цахим гүйлгээний тоог 70 хувьд хүргэх

**Зорилт:** Гялсбанкны харилцагчийн тоог 2024 онд 1 сая хүргэх зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэснээр харилцагчийн гүйлгээний 70 хувийг цахимжуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

✓ Улирал тутам ачаалал өндөртэй нэгжүүд дээр хамтарсан баг ажиллаж цахим үйлчилгээг сурталчилж идэвхжүүлнэ.
✓ Финтекийг банкны үйл ажиллагаанд ашиглах боломжтой болгож нэвтрүүлэх.
✓ Банкны ашигт ажиллагаа, харилцагчийн амьдралын хэв маягт тохирсон дижитал платформд суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, борлуулах сувгийг нэмэгдүүлэх.
✓ Гар утсанд суурилсан төлбөр тооцооны системийг өргөжүүлэх.
✓ Сурталчилгааны контентыг цахим бүтээгдэхүүн үйлчилгээ, картын зах зээлд хандуулах.

- Картын гүйлгээний зах зээл эзлэлтийг нэмэгдүүлэх, дундаж давхаргыг дэмжихэд чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртээмжтэй хүргэх

**Зорилт:** Цахим бүтээгдэхүүн борлуулалт, гүйлгээний тоо хэмжээг нэмэгдүүлснээр харилцагчийн цаг зав, зардлыг хэмнэсэн цахим үйлчилгээний хэрэглээг дэмжинэ.

✓ Картын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж шинэ картуудыг нэвтрүүлнэ.
✓ Банкны үйлчилгээг цахим банк руу чиглүүлнэ.

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК
5163555

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК
ТТБ0374 5208173

- ✓ Ухаалаг пос, виртуал картыг нэвтрүүлнэ.
- ✓ Картаар үйлчлэгч байгууллагуудад зориулсан өдөрлөг арга хэмжээ зохион байгуулна.

- Банкны цахим шилжилт: Банкны үйл ажиллагааг цахимжуулж, ажилтнуудыг чадавхжуулах. Удирдлагын мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэх

**Зорилт:** Банк дотоод цахим шилжилт хийснээр, цаас хэмнэж, үйл ажиллагаа шуурхай болно.

- ✓ Дижитал хариуцсан нэгж байгуулах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх.
- ✓ Өгөгдлийн сангийн дэд бүтэц, өгөгдлийн санг судалгаа шинжилгээ хийхэд оновчтой болгох.
- ✓ Салбар нэгжүүдийг цахимжуулах боломжийг нэмэх.
- ✓ Business intelligence-г банкны үйл ажиллагаанд нэвтрүүлэх.

- Харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, хүлээлгийн хугацааг 30% бууруулах

**Зорилт:** Харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлж, хүлээлгийн хугацааг богиносгох зорилгоор дараах ажлуудыг хийнэ.

- ✓ Улаанбаатар, Орон нутгийн салбар, нэгжийн байрны тохижилт, чанар байдлыг сайжруулж, хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх.
- ✓ Бүтээгдэхүүний огтлолцоо борлуулалтыг нэмэгдүүлж харилцагч бүрийн бүтээгдэхүүн ашиглалтыг нэмэгдүүлэх.
- ✓ Бага дунд орлоготой иргэдэд зориулсан Хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүний зуучлалыг нэмэгдүүлэх, идэвхжүүлэх.
- ✓ Мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийг үе шаттай шинэчлэх
- ✓ Банкийг нэр хүндийн эрсдэлээс хамгаалах, нэр хүндийг нэмэгдүүлэх.
- ✓ Харилцагчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх.

- Нэгжийн ачааллыг бууруулах, бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтыг нэмэгдүүлэх

**Зорилт:** Киоскийн тоог нэмэгдүүлж, цахим үйлчилгээний борлуулалтыг нэмэгдүүлснээр теллер дээр хийгдэх гүйлгээний тоог 35 хувиар бууруулна.

- ✓ Киоск машинаар үзүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх.
- ✓ Салбар нэгжийн ачааллыг бууруулах чиглэлээр харилцагчийн өдөрлөг болон дотоод маркетингийн ажлууд зохион байгуулах.
- ✓ Теллерүүдийг идэвхжүүлэх, цахим бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэхэд анхааран ажиллах.

## Банкны үйл ажиллагааг байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, зохистой засаглалыг бэхжүүлэх чиглэлд хандуулах

- Ажилтнуудын ажлын гүйцэтгэл, ур чадварыг бодитоор үнэлж, түүнд тохирсон цалин урамшуулал, карьер хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

**Зорилт:** Ажилтны гүйцэтгэлд суурилсан үнэлгээний системийг нэвтрүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

- ✓ Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг улирал бүр үнэлж, гүйцэтгэлийн удирдлагын хэрэгжилт, хяналтыг сайжруулах.
- ✓ Ажилтнууд дунд ур чадварын уралдааныг зохион байгуулж, банкны ур чадвартай ажилтны нөөц /talent pool/ бүрдүүлж, залгамж халааг бэлтгэх.

- Банкны бизнесийн стратеги зорилтуудыг дэмжих чиглэлд сургалт хөгжлийн бодлогыг шинэчлэн тодорхойлж, ажилтнуудыг мэргэшүүлэх, чадваржуулах ажлыг үе шаттай зохион байгуулж, сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

- Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, ажилтнуудын сэтгэл ханамж, ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

- Нийгмийн хариуцлагын хүрээнд боловсрол, хүрээлэн буй орчны чиглэлээр төсөл хөтөлбөрүүдийг дэмжин ажиллана.

**Зорилт:** Банкны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, ногоон зээлийн багцын өсөлт бий болгох, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх, банканд байгаль орчин, нийгэм, зохистой засаглалын олон улсын туршлагыг нэвтрүүлэн гадны байгууллагаас хямд өртөгтэй, урт хугацаат эх үүсвэрийг татах, байгаль орчин, нийгэмдээ хувь нэмэр оруулах боломжуудыг бүрдүүлнэ.

- Банкны тасралтгүй үйл ажиллагааг хангах

**Зорилт:** Банкны мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдлыг бодлого, журам, бүтэц зохион байгуулалт, тоног төхөөрөмж, программ хангамжаар дамжуулан хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO/IEC 27001 стандарт, COBIT тогтолцоо болон PCI-DSS стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж банкны мэдээллийн аюулгүй байдлыг хангана.

Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь олон улсын стандартад нийцсэн байх, арга аргачлалыг сайжруулах, үйл ажиллагааны эрсдэлийн шинжилгээ, судалгааг эрсдэлийн тохиолдлын мэдээлэл, статистикт тулгуурлаж хийх, үнэлгээнд шаардлагатай тоон мэдээллийн баазыг бүрдүүлж байх, банкны бизнесийн дотоод үйл ажиллагааны мэдээлэл болон харилцагчдын мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг сайжруулж ажиллана. Мэдээллийн

технологийн COBIT тогтолцооны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх удирдамжийн хүрээнд банкны мэдээллийн технологийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлж хэвшүүлэх, мэдээллийн сан үүсгэнэ.

Комплаенсийн олон улсын стандартын дагуу банканд комплаенсийн соёл нутагшиж, шүгэл үлээх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлнэ. Монгол Улсын МУТС-тэй тэмцэх тухай хуулийн дагуу харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, магадлан шалгах, харилцагчийн данс гүйлгээнд тогтмол хяналтыг хэрэгжүүлэх, программ хангамжийг хөгжүүлэх сайжруулах ажлыг тасралтгүй хийнэ.

## 1.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

### АУДИТЫН ДҮГНЭЛТ

"Эрнст энд Янг Монголия Аудит" ХХК нь Төрийн Банк ХХК ("Банк")-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Банкны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэсэн.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд ("СТОУС")-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

### САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

*Хүснэгт 5. Санхүү байдлын тайлан (Сүүлийн 3 жилээр )*

| Мян.төг | 2019 | 2020 | 2021 | Дундаж өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | | |
| Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах | 380,259,480 | 238,774,076 | 250,920,691 | -18.8% |
| Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж | 20,412,695 | 21,932,821 | 28,534,316 | 18.2% |
| Үүсмэл санхүүгийн хэрэгсэл | 5,419 | 165,759 | 759,107 | 1083.6% |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 1,740,834,868 | 1,754,078,880 | 2,237,147,348 | 13.4% |
| Санхүүгийн хөрөнгө оруулалт-борлуулахад бэлэн | 91,138,292 | 47,955,448 | 7,310,813 | -71.7% |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө | 32,637,420 | 41,984,457 | 80,844,572 | 57.4% |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэгсэл | 881,734,414 | 1,217,540,739 | 967,315,767 | 4.7% |
| Хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн хэрэгсэл | | | 67,786,597 | 100.0% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэгсэл | 117,630 | 119,658 | 118,385 | 0.3% |
| Бусад хөрөнгө | 23,261,229 | 26,836,566 | 21,266,799 | -4.4% |
| Борлуулах зориулалттай хөрөнгө | 5,416,432 | 4,593,611 | 6,762,299 | 11.7% |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | - | - | 2,364,878 | 100.0% |
| Үндсэн хөрөнгө | 112,512,697 | 119,645,215 | 115,918,630 | 1.5% |
| Биет бус хөрөнгө | 2,801,904 | 5,445,776 | 5,630,775 | 41.8% |
| Ашиглах эрхтэй хөрөнгө | 6,337,553 | 3,195,396 | 53,279 | -90.8% |
| **Нийт хөрөнгийн дүн** | **3,297,470,033** | **3,482,268,402** | **3,792,734,256** | **7.2%** |
| **ӨР ТӨЛБӨР** | | | | |
| Бусад банк санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж | 100,047,947 | 134,165,793 | 115,952,799 | 7.7% |
| Репо хэлцэл | - | 71,242,456 | 153,809,693 | 115.9% |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 2,575,230,812 | 2,678,442,356 | 2,856,798,045 | 5.3% |
| Үүсмэл санхүүгийн хэрэгсэл | 93,106 | 596,957 | 1,549,920 | 308.0% |
| Зээлээр авсан санхүүжилт | 289,110,716 | 227,021,274 | 252,376,321 | -6.6% |
| Бусад өр төлбөр | 11,731,954 | 12,989,278 | 15,847,976 | 16.2% |
| Түрээсийн өглөг | 7,358,784 | 4,011,845 | 234,557 | -82.1% |
| Орлогын татварын өглөг | 2,368,913 | 2,126,460 | 4,865,246 | 43.3% |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 596,258 | 3,910,382 | 2,815,761 | 117.3% |
| **Нийт өр төлбөрийн дүн** | **2,986,538,490** | **3,134,506,801** | **3,404,250,318** | **6.8%** |
| **ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | | | | |
| Энгийн хувьцаа | 133,900,000 | 133,900,000 | 178,000,000 | 15.3% |
| Бусад нөөц | 28,256,859 | 34,393,463 | 29,368,212 | 1.9% |
| Хоёрдогч өглөг | 44,100,000 | 44,100,000 | - | -100.0% |
| Хуримтлагдсан ашиг | 104,674,684 | 135,368,138 | 181,115,726 | 31.5% |
| **Нийт эздийн өмч** | **310,931,543** | **347,761,601** | **388,483,938** | **11.8%** |
| **Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн** | **3,297,470,033** | **3,482,268,402** | **3,792,734,256** | **7.2%** |

*Эх сурвалж: "Төрийн банк" ХХК*

## ОРЛОГЫН ТАЙЛАН

*Хүснэгт 6. Орлогын тайлан (Сүүлийн 3 жилээр )*

| Мян.төг | 2019 | 2020 | 2021 | Дундаж өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| Үр ашигт хүүгийн аргачлалаар бодсон хүүгийн орлого | 349,722,129 | 345,091,373 | 363,500,188 | 2.0% |
| Бусад хүү болон түүнтэй адилтгах орлого | 27,653,830 | 22,758,027 | 21,973,641 | -10.9% |
| Хүү болон түүнтэй адилтгах зардал | (244,555,739) | (234,022,180) | (190,640,521) | -11.7% |
| **Цэвэр хүүгийн орлого** | **132,820,220** | **133,827,220** | **194,833,308** | **21.1%** |
| Хураамж, шимтгэлийн орлого | 22,864,055 | 26,217,733 | 29,053,607 | 12.7% |
| Хураамж ба шимтгэлийн зардал | (6,882,853) | (5,379,633) | (6,718,631) | -1.2% |
| **Хураамж ба шимтгэлийн орлого** | **15,981,202** | **20,838,100** | **22,334,976** | **18.2%** |
| Арилжааны цэвэр орлого | 7,845,901 | 13,601,732 | 4,006,641 | -28.5% |
| Үйл ажиллагааны бусад орлого(зардал) | (3,797,175) | (7,076,623) | (17,541,753) | 114.9% |
| **Үйл ажиллагааны орлого** | **152,850,148** | **161,190,429** | **203,633,172** | **15.4%** |
| Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан | (38,612,810) | (17,239,843) | (32,012,890) | -8.9% |
| **Үйл ажиллагааны цэвэр орлого** | **114,237,338** | **143,950,586** | **171,620,282** | **22.6%** |
| Үйл ажиллагааны зардал | (91,553,470) | (104,701,615) | (110,605,423) | 9.9% |
| **Татварын өмнөх ашиг** | **22,683,868** | **39,248,971** | **61,014,859** | **64.0%** |
| Орлогын албан татварын зардал | (2,411,221) | (8,637,086) | (15,267,271) | 151.6% |
| **Тайлант жилийн ашиг** | **20,272,647** | **30,611,885** | **45,747,588** | **50.2%** |
| Нэгж хувьцаанд ногдох ашиг | | | | |
| Хувьцаа эзэмшигчдэд хуваарилах тухайн жилийн ашиг, үндсэн | - | 228.62 | 272.94 | 19.4% |
| Хувьцаа эзэмшигчдэд хуваарилах тухайн жилийн ашиг, хорогдуулсан | - | 171.98 | 272.94 | 58.7% |
| Бусад дэлгэрэнгүй орлого (зардал) | 3,927,495 | 6,218,176 | (5,025,251) | -13.1% |
| Тайлант жилийн татварын дараах нийт дэлгэрэнгүй орлого | 24,200,142 | 36,830,061 | 40,722,337 | 29.7% |

*Эх сурвалж: "Төрийн банк" ХХК*

* Дундаж өөрчлөлтийг тооцохдоо арифметик дундажаас ялгаатайгаар динамик санхүүгийн тоон мэдээлэлд ашигладаг **CAGR** тооцох аргачлалыг ашиглан тооцсон. Дундаж өөрчлөлт= $(\frac{\text{Эцсийн дүн}}{\text{Эхний дүн}})^{\frac{1}{t-1}} - 1$ , t=хугацаа

## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭ

*Хүснэгт 7. Санхүүгийн тайлангийн бүтэц (Сүүлийн 3 жилээр)*

| Санхүү байдлын тайлан | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах | 11.5% | 6.9% | 6.6% |
| Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж | 0.6% | 0.6% | 0.7% |
| Үүсмэл санхүүгийн хэрэгсэл | 0.0% | 0.0% | 0.0% |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 52.8% | 50.4% | 59.0% |
| Санхүүгийн хөрөнгө оруулалт-борлуулахад бэлэн | 2.8% | 1.4% | 0.2% |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө | 1.0% | 1.2% | 2.1% |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэгсэл | 26.7% | 35.0% | 25.5% |
| Хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн хэрэгсэл | 0.0% | 0.0% | 1.8% |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэгсэл | 0.0% | 0.0% | 0.0% |
| Бусад хөрөнгө | 0.7% | 0.7% | 0.6% |
| Борлуулах зориулалттай хөрөнгө | 0.2% | 0.1% | 0.2% |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 0.0% | 0.0% | 0.1% |
| Үндсэн хөрөнгө | 3.4% | 3.4% | 3.1% |
| Биет бус хөрөнгө | 0.1% | 0.2% | 0.1% |
| Ашиглах эрхтэй хөрөнгө | 0.2% | 0.1% | 0.0% |
| **Нийт хөрөнгийн дүн** | 100.0% | 100.0% | 100.0% |
| **ӨР ТӨЛБӨР** | 0.0% | 0.0% | 0.0% |
| Бусад банк санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж | 3.0% | 3.9% | 3.1% |
| Репо хэлцэл | 0.0% | 2.0% | 4.1% |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 78.1% | 76.9% | 75.3% |
| Үүсмэл санхүүгийн хэрэгсэл | 0.0% | 0.0% | 0.0% |
| Зээлээр авсан санхүүжилт | 8.8% | 6.5% | 6.7% |
| Бусад өр төлбөр | 0.4% | 0.4% | 0.4% |
| Түрээсийн өглөг | 0.2% | 0.1% | 0.0% |
| Орлогын татварын өглөг | 0.1% | 0.1% | 0.1% |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 0.0% | 0.1% | 0.1% |
| **Нийт өр төлбөрийн дүн** | 90.6% | 90.0% | 89.8% |
| **ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | 0.0% | 0.0% | 0.0% |
| Энгийн хувьцаа | 4.1% | 3.8% | 4.7% |
| Бусад нөөц | 0.8% | 1.0% | 0.7% |
| Хоёрдогч өглөг | 1.3% | 1.3% | 0.0% |
| Хуримтлагдсан ашиг | 3.2% | 3.9% | 4.8% |
| Нийт эздийн өмч | 9.4% | 10.0% | 10.2% |
| **Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн** | 100.0% | 100.0% | 100.0% |

*Эх сурвалж: "Төрийн банк" ХХК*

*Хүснэгт 8. Орлогын тайлангийн бүтэц (Сүүлийн 3 жилээр)*

| Орлогын тайлан | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| Үр ашигт хүүгийн аргачлалаар бодсон хүүгийн орлого | 100.0% | 100.0% | 100.0% |
| Бусад хүү болон түүнтэй адилтгах орлого | 7.9% | 6.6% | 6.0% |
| Хүү болон түүнтэй адилтгах зардал | -69.9% | -67.8% | -52.4% |
| **Цэвэр хүүгийн орлого** | 38.0% | 38.8% | 53.6% |
| Хураамж, шимтгэлийн орлого | 6.5% | 7.6% | 8.0% |
| Хураамж ба шимтгэлийн зардал | -2.0% | -1.6% | -1.8% |
| **Хураамж ба шимтгэлийн орлого** | 4.6% | 6.0% | 6.1% |
| Арилжааны цэвэр орлого | 2.2% | 3.9% | 1.1% |
| Үйл ажиллагааны бусад орлого(зардал) | -1.1% | -2.1% | -4.8% |
| **Үйл ажиллагааны орлого** | 43.7% | 46.7% | 56.0% |
| Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан | -11.0% | -5.0% | -8.8% |
| **Үйл ажиллагааны цэвэр орлого** | 32.7% | 41.7% | 47.2% |
| Үйл ажиллагааны зардал | -26.2% | -30.3% | -30.4% |
| **Татварын өмнөх ашиг** | 6.5% | 11.4% | 16.8% |
| Орлогын албан татварын зардал | -0.7% | -2.5% | -4.2% |
| **Тайлант жилийн ашиг** | 5.8% | 8.9% | 12.6% |

*Эх сурвалж: "Төрийн банк" ХХК*

## Нийт хөрөнгө

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн хэмжээ 2019-өөс 2021 оны хооронд дунджаар 7.2%-аар өсөж 3.3 их наядаас 2021 онд 3.8 их наяд болж өссөн үзүүлэлтэй байна. Ийнхүү нийт хөрөнгийн хэмжээ өссөн нь түүхэн онуудад дунджаар цэвэр зээлийн дүн 13%-аар, санхүүгийн хөрөнгө 57%-аар, Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж 18%-аар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Өнгөрсөн 3 жилийн түүхэн дунджаар нийт хөрөнгийн 54.0%-ийг харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа буюу цэвэр зээл, 8.3%-ийг бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан харилцах, 32.6%-ийг хөрөнгө оруулалт, 3.4%-ийг үндсэн болон биет бус хөрөнгө, үлдсэн 1.7%-ийг бусад хөрөнгүүд эзэлж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-09-14 БҮРТГЭВ-03

*График 1. Нийт хөрөнгийн бүтэц, түүний өсөлт (тэрбум төгрөг, хувиар)*




**Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах**

Үнэт цаас гаргагчийн бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах 2019-2021 онд жилд дунджаар 18.8%-аар буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд уг үзүүлэлт 2019-2020 онд 37.2%-аар буурсан нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Монголбанкнаас төгрөгийн заавал байлгах нөөцийн хэмжээг 2.5%-аар бууруулж 6%-д хүргэснээр Монголбанканд байршуулсан харилцахын хэмжээ багассантай холбоотой.

Үнэт цаас гаргагчийн банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнге түүхэн дунджаар 24 орчим тэрбум төгрөг байгаа бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар өмнөх жилийн 21.9 тэрбум төгрөгөөс 28.5 тэрбум төгрөг болж 30.1%-аар өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

*График 2. Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах (тэрбум төгрөгөөр)*



СЭХ
БҮРТГЭВ



2022-03-14
БҮРТГЭВ-03

## Санхүүгийн хөрөнгө

Үнэт цаас гаргагчийн түүхэн үзүүлэлтээс харахад санхүүгийн хөрөнгө 2019 оноос 2020 онд 30.0% өсч 1,005.6 тэрбум төгрөгөөс 1,307.6 тэрбум төгрөг болсон бол 2021 онд 14.1%-аар буурч 1,307.6 тэрбум төгрөгөөс 1,123.4 тэрбум төгрөг болсон байна.

2019 онтой харьцуулахад 2020 онд санхүүгийн хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 30.0 хувиар өсч 1.3 их наяд төгрөгт хүрсэн нь “Иргэдийн тэтгэвэр барьцаалсан зээлийг төрөөс нэг удаа төлөх тухай” хуулийн хүрээнд тэтгэврийн зээл төлөгдсөн болон Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас үүдэлтэй арилжааны банкууд эрсдэл багатай активын сонголт болох Төвбанкны үнэт цаасанд эх үүсвэрээ байршуулсантай холбоотой.

2021 оны байдлаар санхүүгийн хөрөнгийн 92.1 хувийг өрийн хэрэгсэл, 7.2 хувийг ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө, 0.7 хувийг борлуулахад бэлэн санхүүгийн хэрэгсэл тус тус эзэлж байна.

*График 3. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөг, хувиар)*




## Зээл

Үнэт цаас гаргагчийн нийт зээлийн багц 2019-өөс 2021 онуудад дунджаар 14 %-аар буюу 1.7 их наяд төгрөгөөс 2020 онд 1.8 их наяд төгрөг, 2021 онд 2.2 их наяд төгрөг болж өссөн байна. Ийнхүү 2021 онд нийт зээлийн багц өмнөх оноосоо 28 хувиар өсөж зээл олголт мэдэгдэхүйц нэмэгдсэн нь Ковид-19 цар тахлын дараа Засгийн газраас эрүүл мэндээ хамгаалах, эдийн засгаа сэргээх цогц

хөтөлбөр хэрэгжүүлж бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээл олгосонтой холбоотой. Нөгөө талаар цар тахлын үед Монголбанкны зүгээс эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор мөнгөний зөөлөн бодлого хэрэгжүүлж, бодлогын хүү 2020 оны 03 дугаар сараас үе шаттайгаар бууруулан 2021 онд 6.0 хувьд хүргэсэн нь банкны зээлийн хүү буурах, зээлийн олголт нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

*График 4. Үнэт цаас гаргагчийн нийт зээл, түүний чанар (тэрбум төгрөг, хувиар)*




Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн зээлийн багцын дундаж өсөлт 13.4% бөгөөд 2019 онд 1.9%-аар буурсан, 2020 онд 0.8%-аар өсч багцын өсөлт саарсан нь 2019 оноос Монголбанкнаас иргэдийн зээлийн өрийн дарамтыг бууруулах, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх зорилгоор хэрэглээний зээлийн өр орлогын харьцааны дээд хязгаар тогтоосон, мөн "Иргэдийн тэтгэвэр барьцаалсан зээлийг төрөөс нэг удаа төлөх тухай" хуулийн хүрээнд тэтгэврийн зээл төлөгдсөнтэй холбоотой байна.

Сүүлийн 3 жилийн дунджаас харахад нийт зээлийн 88.3% нь хэвийн зээл, 1.8% нь анхаарал хандуулах ангилалтай зээл, 9.9% нь чанаргүй зээл тус тус эзэлж байна. Зээлийн ангиллыг Монголбанканд гаргаж өгдөг тайлангийн дагуу ангилсан.

Түүхэн үзүүлэлтээс харахад активын чанарын үнэлгээний дагуу 2019-2021 оны дунджаар нийт чанаргүй зээлийн 86.6%-д зээлийн эрсдэлийн санг байгуулж ажилласан байна.

*График 5. Үнэт цаас гаргагчийн чанаргүй зээл болон эрсдэлийн сан (тэрбум төгрөг, хувиар)*




Үнэт цаас гаргагчийн зээлийн бүтцийг задалж үзвэл 2019-өөс 2021 оны дунджаар дийлэнх буюу 43.8%-ийг хэрэглээний зээл, 30.8%-ийг бизнесийн зээл, 16.4%-ийг хөдөө аж ахуйн зээл, үлдсэн 9.0%-ийг орон сууцны зээл эзэлж байна.

*График 6. Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын бүтэц (бүтээгдэхүүнээр, хувиар)*




Сүүлийн жилүүдэд буюу 2019 оноос хэрэглээний зээлийн багцын эзлэх хувь багассан нь хэрэглээний зээлд өр орлогын харьцааны дээд хязгаар тогтоосон Монголбанкны бодлогын нөлөө болон 2020 онд "Иргэдийн тэтгэвэр барьцаалсан зээлийг төрөөс нэг удаа төлөх тухай" хуулийн хүрээнд тэтгэврийн зээл төлөгдсөн, мөн Засгийн газраас Ковид-19 цар тахалтай холбоотой авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээтэй холбоотой байна.

## Нийт эх үүсвэр

Үнэт цаас гаргагчийн нийт эх үүсвэрийн хэмжээ 2019-өөс 2021 онуудад дунджаар 7.2%-аар өсөж 3.3 их наядаас 2021 онд 3.8 их наяд болж өссөн үзүүлэлттэй байна. Түүхэн дунджаар нийт эх үүсвэрийн 90%-ийг өр төлбөр, 10%-ийг эздийн өмч эзэлж байгаагаас 76.8%-ийг харилцах, хадгаламж, 3.3%-ийг банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, 7.3%-ийг зээлээр авсан санхүүжилт, 2.7%-ийг бусад өр төлбөр, 4.2%-ийг хувь нийлүүлсэн хөрөнгө, 3.9%-ийг хуримтлагдсан ашиг, бусад эх үүсвэр 1.8% тус тус эзэлж байна.

*График 7. Үнэт цаас гаргагчийн нийт эх үүсвэр, түүний бүтэц (тэрбум төгрөг, хувиар)*




## Харилцагчаас татсан эх үүсвэр

Үнэт цаас гаргагчийн харилцагчаас татсан эх үүсвэр 2019-өөс 2021 онуудад жилд дунджаар 5.3%-ийн өсөлт үзүүлж энэхүү хугацаанд 2.6 их наяд төгрөгөөс 2.9 их наяд төгрөг болж өссөн эерэг үзүүлэлттэй байна.

Түүхэн үзүүлэлтээс харахад дунджаар нийт харилцагчаас татсан эх үүсвэрийн 16.9%-ийг хугацаагүй хадгаламж, 61.0%-ийг хугацаатай хадгаламж, 22.1%-ийг харилцах тус тус эзэлж байна.

*График 8. Үнэт цаас гаргагчийн харилцагчаас татсан эх үүсвэр, өр төлбөрийн бүтэц (тэрбум төгрөг, хувиар)*




Харилцагчдын төрлөөр харилцагчаас татсан эх үүсвэрийг задалж үзвэл дунджаар 74.3%-ийг иргэд, 5.3%-ийг хувийн сектор, 20.4%-ийг засгийн газрын эх үүсвэр тус тус эзэлж байгаагаас харвал үнэт цаас гаргагчийн хувьд иргэдийн харилцах, хадгаламж томоохон эх үүсвэрийн нэгт зүй ёсоор багтаж байна.

Харилцах, хадгаламжийн хэмжээ 2019-өөс 2021 онуудад жилд дунджаар 5.3%-ийн өсөлтийг үзүүлсэн бөгөөд 2021 оны жил эцсийн байдлаар 2019 оны жилийн эцсээс 281.5 тэрбум төгрөгөөр өсөж 2.8 их наяд төгрөгт хүрсэн байна. Хувийн секторын харилцах, хадгаламжийн дүн 2019 онд 24.8%-аар буурсан үзүүлэлттэй байсан бол 2020 онд 16.6%, 2021 онд 26.6%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

*График 9. Харилцах хадгаламжийн бүтэц (хувиар)*



Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах хадгаламж ба зээлээр авсан санхүүжилт

Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламжид дотоод, гадаадын банк болон бусад санхүүгийн байгууллагуудын харилцах дансны болон хугацаат хадгаламжууд ордог бөгөөд дунджаар нийт эх үүсвэрийн 10.6%-ийг эзэлж байна.

## Өөрийн хөрөнгө

Үнэт цаас гаргагч нь түүхэн дунджаар нийт эх үүсвэрийн 10%-ийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа бөгөөд өөрийн хөрөнгө 2019-өөс 2021 онуудад жилд дунджаар 11.8%-аар өсөж 2021 оны байдлаар 388.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар 45.8%-ийг энгийн хувьцаа, 46.6%-ийг хуримтлагдсан ашиг, 7.6%-ийг бусад нөөц эзэлж байна.

*График 10. Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөг, хувиар)*




## Орлогын тайлангийн шинжилгээ

Үнэт цаас гаргагчийн жилийн нийт орлого сүүлийн гурван жилийн дотор 408 тэрбум төгрөгөөс 419 тэрбум төгрөг болж 2.7% буюу 11 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Түүхэн дунджаар жилийн нийт орлогын 91.6%-ийг 376.9 тэрбум төгрөгийн хүүгийн орлого, 6.3%-ийг 26.0 тэрбум төгрөгийн хураамж, шимтгэлийн орлого, 2.1%-ийг 8.5 тэрбум төгрөгийн арилжааны цэвэр орлого эзэлж байна.

Нийт зардал сүүлийн 3 жилийн дунджаар 370.5 тэрбум төгрөг байгаа бөгөөд нийт зардлын 60.2%-ийг 223.1 тэрбум төгрөгийн хүү болон түүнтэй адилтгах зардал, 27.6%-ийг 102.3 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардал, 8%-ийг 29.3 тэрбум төгрөгийн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан буюу

эрсдэлийн сангийн зардал, 1.7%-ийг 6.3 тэрбум төгрөгийн хураамж ба шимтгэлийн зардал, 2.5%-ийг 9.5 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны бусад зардал тус тус эзэлж байна.

*График 11. Үнэт цаас гаргагчийн нийт орлого, зардлын бүтэц (тэрбум төгрөг, хувиар)*




Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаанаас олох хүүгийн орлогоос холбоотой зардлуудыг хасаж тооцсон хүүгийн цэвэр орлого 2019 оноос тасралтгүй өсөж 194.8 тэрбум төгрөгт хүрсэн. 2020 онд цэвэр хүүгийн орлогын өсөлт 0.8%-д хүрч багассан нь Ковид-19 цар тахлын нөлөөгөөр зээлийн эргэн төлөлт удааширсан, бодлогын хүү буурсан зэргээс шалтгаалж өсөлтийн хувь буурсан хэдий ч цар тахлын дараах эдийн засгийн сэргэлт зэргээс үүдэлтэйгээр 2021 оны жилийн эцсийн байдлаар цэвэр хүүгийн орлого 45.6%-аар өссөн эерэг үзүүлэлттэй байна.

*График 12. Үнэт цаас гаргагчийн цэвэр хүүгийн орлого (тэрбум төгрөгөөр)*



Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны орлого нь 2019 оны эцэстэй харьцуулахад 2021 онд 51 тэрбум төгрөгөөр өссөн байгаа нь хүүгийн цэвэр орлого 2019-өөс 2021 онуудад жилд дунджаар 21.1%-ийн өсөлт, хураамж шимтгэлийн цэвэр орлого 12.7%-аар тус тус өссөнтэй холбоотой.

Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн сангийн зардал 2019 болон 2020 онуудад өмнөх оноосоо 55.4%-аар буурсан үзүүлэлттэй байсан хэдий ч 2021 онд Ковид-19 цар тахлын үеийн болон дараах нийлүүлэлтийн сүлжээний доголдлоос үүсэлтэй бизнесийн үйл ажиллагааны хүндрэл, инфляцын өсөлт зэргээс иргэдийн худалдан авах чадвар буурч чанаргүй зээлийн хэмжээ өссөнтэй холбоотойгоор өмнөх оноосоо 85.7%-аар өсөж 32.0 тэрбум төгрөгт хүрсэн байна.

*График 13. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны орлого, эрсдэлийн сангийн зардал ба үйл ажиллагааны ашиг, түүний өсөлт (тэрбум төгрөг, хувиар)*




Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны орлогод эзлэх үйл ажиллагааны зардлын хувь 2019-өөс 2021 онуудад дунджаар 72.3% байна. 2021 оны байдлаар 110.6 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардлын 48%-ийг цалин хөлс, 12%-ийг үндсэн хөрөнгийн элэгдэл, 7%-ийг нийгмийн даатгалын шимтгэл, 6%-ийг даатгалын хураамж, үлдсэн 27%-ийг бусад зардлууд эзэлж байна.

Үнэт цаас гаргагчийн цэвэр ашиг

2019 онд өмнөх оноосоо 912% өсөж, 20.3 тэрбум төгрөг болж нэмэгдсэн нь цэвэр хүүгийн орлого 13.7% буюу 16 тэрбум төгрөгөөр өссөн, эрсдэлийн сангийн зардал 31.1%-аар буюу 17.4 тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна. Ийнхүү 2019 оноос хойш цэвэр ашгийн хэмжээ тогтмол

өсөлттэй байгаа нь жилд дунджаар хүүгийн цэвэр орлого 21.1%, хураамж шимтгэлийн орлого 12.7% тус тус өссөнтэй холбоотой.

*График 14. Үнэт цаас гаргагчийн цэвэр ашиг (тэрбум төгрөг, хувиар)*




САНХҮҮГИЙН ХАРЬЦААНЫ ШИНЖИЛГЭЭ

Цэвэр хүүгийн ахиуц (Net Interest Margin)

Цэвэр хүүгийн ахиуц нь цэвэр хүүгийн орлогыг хүүгийн орлого олдог хөрөнгөнд харьцуулж банкны үр ашгийг илэрхийлдэг гол харьцаа үзүүлэлтийн нэг бөгөөд үнэт цаас гаргагчийн цэвэр хүүгийн ахиуц дунджаар 7.6%-тай буюу харьцангуй тогтвортой байна. 2021 онд 8.7% болж өссөн нь банк орлого олдог хөрөнгөөс хүртэх ашгийн хэмжээ өссөн байгааг илэрхийлж байна.

Зардал, орлогын харьцаа (Cost to income)

Зардал орлогын харьцаа нь үйл ажиллагааны зардлыг үйл ажиллагааны орлогод харьцуулдаг ашигт ажиллагааг илэрхийлдэг үзүүлэлт бөгөөд 2020 онд уг харьцаа түүхэн хугацааны хамгийн өндөр буюу 65.0% хүрсэн нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор үйл ажиллагааны орлогоос илүү үйл ажиллагааны зардал нэмэгдсэнтэй холбоотой. Харин 2021 онд үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаа сайжирснаар зардал, орлогын харьцаа өмнөх онуудаас буурч 54.3% хүрсэн эерэг үзүүлэлттэй байна.

*График 15. Үнэт цаас гаргагчийн цэвэр хүүгийн ахиуц ба зардал, орлогын харьцаа (хувиар)*




Өөрийн хөрөнгийн өгөөж (Return on equity) ба Нийт хөрөнгийн өгөөж (Return on total assets)

Нийт хөрөнгийн өгөөж болон өөрийн хөрөнгийн өгөөж нь хөрөнгийн ашиглалт хэр түвшинд байгааг илэрхийлдэг. Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн өгөөж, нийт хөрөнгийн өгөөж 2019 оноос хойш тасралтгүй өссөн байгаа нь ашигт ажиллагаа сайжирч байгааг илэрхийлж байна. 2019 онд өмнөх онтой харьцуулахад 6.5% болж огцом өссөн нь тайлант жилийн ашиг 18.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

*График 16. Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн өгөөж (хувиар)*




Цэвэр ашгийн ахиуц (Net Profit Margin)

Цэвэр ашгийн ахиуц нь нийт хүүгийн орлогын хэдэн хувийг цэвэр ашиг болгож хувиргаж байгааг илэрхийлдэг үзүүлэлт бөгөөд 2019 оноос өссөөр 2021 онд 11.8% болж өссөн эерэг үзүүлэлттэй байна. Ийнхүү өсөлттэй байгаа нь сүүлийн жилүүдэд үнэт цаас гаргагчийн ашгийн хэмжээ өсөлттэй байгаатай холбоотой.

СЗХ он 2022 сар 09 21 БҮРТГЭВ

*График 17. Үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн ахиуц (хувиар)*

2022-09-14 БҮРТГЭВ-03




## МОНГОЛБАНКНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Банкны системийн найдвартай тасралтгүй ажиллагааг хангах, болзошгүй эрсдэлээс сэргийлэхийн тулд Монголбанкнаас банкуудад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг мөрдүүлж хяналт тавьдаг.

Үнэт цаас гаргагчийн хувьд Монголбанкнаас тогтоосон дүрэм, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг дагаж, бүхий л шалгууруудыг бүрэн хангаж ажиллаж байгаа нь санхүүгийн хувьд тогтвортой үйл ажиллагаагаа явуулж байгааг илэрхийлж байна.

*Хүснэгт 9. Үнэт цаас гаргагчийн Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт (хувиар)*

| Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт | Байвал зохих | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа | > 9% | 11.8% | 12.8% | 15.3% |
| Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа | > 12% | 14.9% | 15.6% | 15.3% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт | > 25% | 42.1% | 39.0% | 31.7% |
| Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа /нэгж валютаар/ | < (±15%) | -2.4% | 12.7% | 9.5% |
| Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа /нийт/ | < (±30%) | 2.7% | 14.6% | 10.9% |

Монголбанкнаас банкны өөрийн хөрөнгийн хэмжээ нь зээл болон бусад эрсдэл өндөр хөрөнгийн хэмжээтэй харьцуулан эрсдэл даах хэмжээнд буюу нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа 9%-аас, өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 12%-аас тус тус дээш байхыг шаарддаг.

Үнэт цаас гаргагч нь түүхэн хугацаанд Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг зохистой хэмжээнд барьж үйл ажиллагаагаа явуулсаар ирсэн байна. Тухайлбал 2021 оны жил эцсийн байдлаар өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаанууд 15.3% буюу байвал зохих түвшнээс өндөр байна.

*График 18. Үнэт цаас гаргагчийн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон өөрийн хөрөнгийн эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаанууд (хувиар)*




Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа нь банкны харилцагчийн өмнө хүлээсэн төлбөр тооцооны үүргээ хангах, актив пассивын эргэн төлөгдөх хугацаа, бүтцийг тэнцвэртэй байлгах зорилготой зохистой харьцааны үзүүлэлт билээ.

Үнэт цаас гаргагч нь өнгөрсөн хугацаанд шаардлагатай зохистой харьцааг давуулан биелүүлсээр ирсэн нь төлбөрийн чадварын эрсдэл бага байгааг илэрхийлж байна.

*График 19. Үнэт цаас гаргагчийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт (хувиар)*



Монголбанкны зохистой харьцааны үзүүлэлтийн шаардлагаар нэгж гадаад валютын позицыг нийт актив, пассивын 15 хувиас, нийт гадаад валютын позицыг 30 хувиас тус тус хэтрэхгүй байхыг шаарддаг. Энэ нь тухайн банкийг гадаад валютын ханшийн эрсдэлийг сэргийлэхэд тусалдаг.

Үнэт цаас гаргагчийн сүүлийн таван жилийн үзүүлэлтээс харахад нийт болон нэгж гадаад валютын позицийн зохистой түвшинг жил бүр хангаж байгаа нь гадаад валютын эрсдэлийг хянан үйл ажиллагаагаа явуулсаар ирснийг илэрхийлж байна.

*График 20. Үнэт цаас гаргагчийн нийт болон нэгж гадаад валютын позиц (хувиар)*



## 1.6 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ БА СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ГЭРЭЭ ХЭЛЦЭЛ, ХУУЛИЙН КОМПАНИЙН ДҮГНЭЛТ

Үнэт цаас гаргагчийн сүүлийн гурван жилийн дотор хийсэн их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэл, Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий хэлцэл байгаа бол хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх талаарх хуулийн зөвлөх компанийн хураангуй дүгнэлтийг дор дурдаж байна.

*Хүснэгт 10. Үнэт цаас гаргагчийн гэрээ хэлцэл(сүүлийн 3 жилээр)*

| | Их хэмжээний хэлцэл | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | ХНХ-ийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний хэлцэл |
|---|---|---|---|
| Нийт хийгдсэн хэлцлийн тоо | - | 40 | 6 |
| Хэрэгжиж дууссан хэлцэл | - | 30 | 2 |
| Одоо хэрэгжиж буй хэлцэл | - | 10 | 4 |

Төрийн Банк нь дурдсан хугацаанд их хэмжээний буюу активын нийт дүнгийн 25 хувиас дээш дүн бүхий аливаа гэрээ, хэлцэл байгуулаагүй байна.

## 1.7 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

### Эрсдэлийн хүчин зүйлс

Банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, хянах замаар банкны хүлээж болзошгүй хохирлыг бууруулах эрсдэлийн удирдлагын үр ашигтай тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх зорилт тавьж ажилладаг.

### Эрсдэлийн удирдлагын хамрах хүрээ

*Схем 6. Эрсдэлийн удирдлагын хамрах хүрээ*




### Эрсдэлийн удирдлагын засаглал

- Банкны эрсдэлийн удирдлагыг нэгдсэн байдлаар хэрэгжүүлэх ба эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь үйл ажиллагаа, чиг үүргүүдийг оновчтой хуваарилж, эрсдэлийн түвшин хамгийн бага байх хяналтын нэгдсэн бүтцийг бүрдүүлж ажилладаг бөгөөд гурван давхар хамгаалалтын шугам бүхий эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлдэг.
- Хамгаалалтын нэгдүгээр шугам-Бизнесийн нэгжүүд нь эрсдэлийн удирдлагыг үйл ажиллагаандаа үр дүнтэй хэрэгжүүлж ажиллана. Өөрийн эрх мэдэл, үүрэг хариуцлагаас давсан, банканд томоохон хэмжээний эрсдэл авчирч болохуйц эрсдэлийн талаар холбогдох дээд удирдлага, Нэгжийн эрсдэлийн удирдлагын хороо, банкны Эрсдэлийн

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№

2022-09-14
БҮРТГЭВ-03

удирдлагын хороонд танилцуулан зөвлөмж, шийдвэр гаргуулан, хэрэгжүүлж ажилладаг.

- Хамгаалалтын хоёрдугаар шугам- Банкны төвийн газар, хэлтэс, алба нь өөрийн чиг үүрэгт тусгагдсан ажлууд болон бизнесийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх бодлогын баримт бичигт эрсдэлийн удирдлагын болон шат дараалсан хяналтын тогтолцоог бүрдүүлж ажилладаг.
- Хамгаалалтын гуравдугаар шугам- Дотоод аудитын газар банкны эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдал, бодлогын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд сайжруулах арга хэмжээний зөвлөмжийг өгч, ТУЗ-д тайлагнана.
- ТУЗ - Банкны эрсдэлийн удирдлагын үндсэн чиг хандлагыг тодорхойлж, стратеги, бодлого, зарчмыг батлах ба гүйцэтгэх удирдлагаас банкны үйл ажиллагаанд мөрдүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулдаг.
- ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын асуудал эрхэлсэн хороо - банкны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулдаг.
- Гүйцэтгэх удирдлага, Эрсдэлийн удирдлагын хороо банкны эрсдэлийн удирдлагын дотоод дүрэм, журмыг боловсруулж ТУЗ-д танилцуулж батлуулах, мөрдөн ажиллах ба банкны эрсдэлд суурилсан дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна.

**Эрсдэлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

**Зээлийн эрсдэлийн удирдлага**

Зээлийн эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь зээлийн үйл ажиллагаанаас учрах эрсдэл болон хүлээгдэх өгөөжийг хамгийн оновчтой түвшинд байлгахад орших ба дараах байдлаар хэрэгжүүлдэг.Үүнд:

- ТУЗ-ийн хурлаар батлагдсан “Эрсдэлийн удирдлагын бодлого”, “Зээлийн бодлого”, “Төрийн банкны чанаргүй активыг бууруулах удирдлага, үйл ажиллагааны журам”, Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан “Зээлийн үйл ажиллагааны журам”, “Төслийн зээлийн бүтээгдэхүүний журам”, “Хөрөнгийн үнэлгээ тогтоох журам”, “Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам”, “Активыг ангилах, болзошгүй эрсдэлийн сан байгуулах, активын үнэ цэнийг бууруулж тооцох, активыг эрсдэлийн сангаас хоргодуулах журам”, “Скорингийн үнэлгээний журам” болон холбогдох бусад журам, заавар, аргачлалыг тус тус өдөр тутмын ажилдаа мөрдлөг болгон ажилладаг бөгөөд эдгээр эрхзүйн баримт бичгийн хүрээнд зээлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг.
- Зээлийн судалгаа шинжилгээг чанартай гүйцэтгэх, барьцаа хөрөнгийн үнэлгээг олон улсын стандартын дагуу үнэлэх, зээлийн багцын эрсдэлийг оновчтой удирдахад тоон болон чанарын үнэлгээг ашиглах бөгөөд хэрэглээний зээлийн судалгаа шинжилгээнд Скорингийн

ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТБ8674 5203173

СЭХ
он сар өдөр
2022 09 21
БҮРТГЭВ
№ 01

үнэлгээ, бизнесийн зээлийн хувьд рейтингийн үнэлгээний аргачлалаар эрсдэлийг үнэлэн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг.

Зээлийн эргэн төлөлтөд хүндрэл учирсан, хууль зүйн мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа авч ажиллах шаардлагатай зээлүүдийн хувьд банкны Тусгай актив хариуцсан нэгжид шилжүүлэх шаардлагатай эсэхэд Эрсдэлийн удирдлага болон Хуулийн газраас дүгнэлт гаргаж Эрсдэлийн удирдлагын хорооны хурлаар танилцуулж, шийдвэрлүүлдэг. Зээлийн эргэн төлөлтөд хүндрэл учирсан зээлүүдийг эхний ээлжид тухайн зээлийг шүүхийн бус аргаар төлүүлэх ба шаардлагатай тохиолдолд шүүх, хууль хяналтын байгууллагад хандаж зээлийг төлүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч ажилладаг.

**Зах зээл, хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага**

Зах зээл, хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь банк зах зээлийн хэвийн болон хэвийн бус нөхцөлд харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь биелүүлэх чадваргүй болох эсхүл тухайн үүргийг биелүүлэхэд ихээхэн хэмжээний зардал гарах эрсдэлийг тодорхойлох, хэмжих, үнэлэх, хязгаарлах, арга хэмжээ авах, хянах цогц үйл ажиллагаанд орших ба эрсдэлийн удирдлагыг дараах байдлаар хэрэгжүүлдэг.

- Гадаад валютын ханшийн эрсдэл: Тухайн нэг гадаад валют болон нийт нээлттэй позиц, өөрийн хөрөнгийн харьцааны үзүүлэлт, арилжаа болон ханш тэгшитгэлийн нэг өдрийн алдагдлын дотооддоо мөрдөх хязгаарыг АПУХ-ны шийдвэрээр тогтоож мөрддөг. Гадаад валютын зохистой харьцааны үзүүлэлтийг тогтоосон загвараар нийт болон тухайн нэг гадаад валютын нээлттэй позиц тус бүрээр өдөр тутам тооцож удирдлагыг мэдээллээр хангаж шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлж ажилладаг.

- Хүүгийн эрсдэл: Банк нь ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо, Эрсдэлийн асуудал эрхэлсэн хороо, Дотоод аудитын үйл ажиллагаа хариуцсан нэгж болон Зээлийн хороод, Эрсдэлийн удирдлагын хороогоор дамжуулан үйл ажиллагаанд хүүгийн эрсдэлийг тодорхойлох, сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээ авах талаар эрсдэлийн удирдлагын бодлого, холбогдох эрсдэл болон хороодын журмын хүрээнд тодорхойлогдсоноор эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажилладаг. Мөн хагас жил тутамд стресс тестийн шинжилгээг хийж, судалгаанд үндэслэсэн эрсдэл бууруулахад авах арга хэмжээний санал, зөвлөмжийг боловсруулан ажилладаг.

- Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ банкны актив пассивын бүтцийн тогтвортой байдлыг хангах, төвлөрлийг бууруулах, эх үүсвэрийн тогтвортой байдлыг хангах, тараан байршуулах, өөрийн хөрөнгийн хүрэлцээг хангах чиглэлийг баримталж ажилладаг. Мөн зохицуулагч байгууллагаас гаргасан шалгуур үзүүлэлт болон дотоод хязгаар үзүүлэлтийг өдөр бүр тогтмол хянаж удирдлагыг мэдээллээр хангаж ажилладаг.

ӨЛЗИЙ ЭНД КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК 534146 ГСТ5332
ГҮҮДСЕК ТТБ8674 5208173

## Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ Банкны эрсдэлийн удирдлагын бодлогод заасан үндсэн зарчмуудыг баримталж эрсдэлийг урьдчилан оновчтой тодорхойлж, эрсдэлийг удирдах арга замыг тогтоож, эрсдэл бууруулах төлөвлөгөөг боловсруулан гүйцэтгэлийг үнэлж, хянаж ажилладаг. Банкны газар, хэлтэс, алба, нэгж, ажилтан нь үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын нэгжтэй хамтран өөрийн үйл ажиллагааны эрсдэлийг үйл ажиллагааны урсгал (Operational Flow Chart), Эрсдэл ба хяналтын үнэлгээний аргачлалын дагуу тодорхойлж, эрсдэл бууруулах төлөвлөгөөг батлуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг. Үйл ажиллагааны эрсдэлийн аппетит буюу эрсдэлийн хязгаарыг жил бүр холбогдох судалгаа, тооцоолол хийсний үндсэн дээр тодорхойлон, ЭУХ-ны хурлаар хэлэлцүүлж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулдаг бөгөөд үйл ажиллагааны эрсдэлийн төрөл тус бүрээр хэрэгжилтийг гаргаж ТУЗ-ийн дэргэдэх ЭУАЭХ-нд тайлагнаж ажиллаж байна. Банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, хаах, эрсдэлийн тохиолдлыг бага хохиролтойгоор давах зорилгоор Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй ердийн даатгалын компаниуд болон Үндэсний давхар даатгалын компанитай хамтран ажилладаг. Энэ хүрээнд: Барилга үл хөдлөх хөрөнгийн даатгал, Жолоочийн хариуцлагын даатгал, Тээврийн хэрэгслийн даатгал, Техник тоног төхөөрөмжийн даатгалаар, Хариуцлагын даатгал /удирдлага болон ажилтан/, Ажилтны гэнэтийн осол хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгал, Бэлэн мөнгөний даатгалаар тус тус хамтран ажиллаж эдгээр гэрээний хүрээнд эрсдэлийн тохиолдол үүсвэл нөхөн төлбөрийг авч банканд учирсан эрсдэлийг бууруулж ажилладаг.

## Мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага

Банк нь "Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам", Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний аргачлал, "Банкны нэгдсэн эрсдэлийг үнэлэх аргачлал" дахь Мэдээллийн технологийн эрсдэлийг үнэлэх аргачлалын дагуу Мэдээллийн технологийн эрсдэлийг бүртгэж тодорхойлж, шинжилгээ хийж, үнэлж, хариу арга хэмжээ авах төлөвлөгөө боловсруулж ажилладаг. Мөн Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг Олон улсын ISO27000 стандарт, PCIDSS стандартын шаардлагад нийцүүлэн шинэчилсэн ба Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг мэдээллийн технологийн COBIT тогтолцооны эрсдэлийг удирдах зөвлөмжийн хүрээнд боловсруулсан бөгөөд эдгээр аргачлалын дагуу тогтоосон хугацаанд эрсдэлийн үнэлгээ хийж төлөв байдлын тайланг ЭУХ-нд танилцуулж шаардлагатай тохиолдолд Эрсдэл бууруулах төлөвлөгөө боловсруулан ЭУХ-оор батлуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг.

СЭХ
он сар өдөр
2022 09 21
БҮРТГЭВ



MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -09- 14
БҮРТГЭВ

## Комплаенсийн эрсдэлийн удирдлага

Банк нь НҮБ, АНУ, ЕХ, Их Британийн болон бусад олон улсын эрх бүхий байгууллага, түүнчлэн корреспондент харилцаатай банкнаас гүйлгээ хийх, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг хориглосон "хориг арга хэмжээний жагсаалт"-д багтсан этгээдэд Банкны аливаа ажил, үйлчилгээг үзүүлэхгүй байх зарчмыг баримтлан ажилладаг. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой үүсэх эрсдэлийн хувьд харилцагчийн таньж мэдэх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх, Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуульд заасан бүх төрлийн гүйлгээнд тогтмол хяналт тавих, хяналтын процессыг сайжруулах, Гүйлгээний хяналтыг хэрэгжүүлсний дагуу сэжигтэй гүйлгээг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх, нэгжийн ажилтнуудыг сургалт, мэдээллээр тогтмол хангах ажлыг зохион байгуулж ажилладаг.

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрсдэлээс сэргийлэх зорилгоор Комплаенсын бодлого, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах, банкны дотоод программд "Хориг арга хэмжээний жагсаалт"-ыг тогтмол шинэчлэх, бүртгэлгүй харилцагчид үйлчилгээ үзүүлэх тохиолдолд тус программаас шалгах, салбар, нэгжийн ажилтнуудыг сургалт, мэдээллээр тогтмол хангах, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас шинээр корреспондент харилцаа тогтоох хүсэлт ирүүлсэн тохиолдолд судалж, дүгнэлт гарган холбогдох хорооны хурлаар шийдвэрлүүлэх, "Хориг арга хэмжээний жагсаалт"-д багтаагүй банк санхүүгийн байгууллагатай корреспондент харилцаа үүсгэж, гадаад гүйлгээг хэвийн явуулах боломжийг бий болгоход чиглэн ажиллаж байна.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК

СЭХ
он сар өдөр
2022 09 21
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-14

## 1.8 НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Компани дунд хугацааны стратеги төлөвлөгөө, зах зээлийн нөхцөл байдлыг үнэлсний үндсэн дээр хувьцаа эзэмшигчдэд санхүүгийн жилд нэг удаа ногдол ашиг хуваарилж болно.

Ногдол ашгийг дор дурдсан нөхцөлүүд бүрэн хангагдсан тохиолдолд хуваарилж болно.

- ✓ Тухайн санхүүгийн жилд банк нь ашигтай ажилласан байх,
- ✓ Банкны үйл ажиллагааг өргөжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн хүртэх өгөөжийг өсгөх зорилгоор ТУЗ-өөс боловсруулсан бизнес төлөвлөгөө, төсөл хөтөлбөрийг тэргүүн ээлжид хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт үлдсэн байх,
- ✓ Банк нь ногдол ашиг хуваарилсны дараа Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хязгаарлалт, Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны болон бусад шалгуур үзүүлэлтийг бүрэн хангахаар байх,
- ✓ Банк нь ногдол ашиг хуваарилсны дараа бусадтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүрэг зөрчигдөхгүй байх,
- ✓ Ногдол ашиг олгосны дараа Банкны өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс их байх.
- ✓ Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт заасан шаардлага хангагдаж байх.
- ✓ Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.

Ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэр

- ✓ ТУЗ санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэнэ.
- ✓ ТУЗ нь ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэр гаргахдаа зохицуулагч байгууллагуудаас тавьж буй шаардлага, зах зээл дэх хувьцааны үнийн өөрчлөлт, банкны гэрээгээр бусдын өмнө хүлээсэн үүргийг харгалзан үзнэ.
- ✓ Компанийн жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан дахь цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалтыг хасаад үлдэх хэсгээс ногдол ашиг хуваарилна.
- ✓ ТУЗ ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн бол үндэслэл болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тайлант жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулна.
- ✓ Ногдол ашгийг ТУЗ-өөс тогтоосон хэлбэрээр хуваарилах бөгөөд бэлэн мөнгө болон эд хөрөнгө, эсхүл банкны үнэт цаасны хэлбэрээр төлж болно.
- ✓ ТУЗ нь ногдол ашиг хуваарилах шийдвэрт дараах зүйлсийг тусгана. Үүнд:
    - Нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ
    - Ногдол ашиг төлөх хугацаа
    - Ногдол ашиг төлөх хэлбэр
    - Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах өдөр буюу бүртгэлийн өдөр

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
ТӨРИЙН БАНК
5341469
УЛААНБААТАР ХОТ
ГҮЙДЭЛ ҮЦК ХХК

СЭХ
2022 оны 08 сарын 2 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ТӨРИЙН БАНК
ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

# ХОЁР. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА 2022

СЭХ 2022 оны 09 сарын 2 өдөр БҮРТГЭВ

2022-09-14 БҮРТГЭВ-03

## 2.1 ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

### 2.1.1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

2021 онд дэлхийн улс орнууд сүүлийн 2 жил хэрэгжүүлсэн цар тахлыг даван гарах мөнгөний зөөлөн бодлогоос хатуу бодлого руу шилжиж, хэрэглээний үнийн өсөлтийг хязгаарлах бодлогоо эхлүүлсэн жил байлаа. 2021 онд Ковид-19-ын омикрон, дельта зэрэг шинэ хувилбаруудын дэгдэлт гарсан нь дөнгөж сэргэж байсан улс орнуудын эдийн засагт хүчтэй сөрөг нөлөө үзүүлсэн. 2022 онд нийлүүлэлтийн сүлжээний тасалдал, үүнээс шалтгаалсан үйлдвэрлэлийн зардалын өсөлт Украины дайны улмаас улам даамжирч байна. Тиймээс шатахуун, эрчим хүчний үнийн өсөлт, Төв банкуудын мөнгөний хатуу бодлого, нийлүүлэлтийн хомсдол гэх мэт хүчин зүйлс эдийн засгийн удаашралд нөлөөлөх хэвээр байна.

Дэлхийн улс орнуудад Ковид-19-ын эсрэг вакцинжуулалтын хамралт, хүрэлцээ нэмэгдэж байгаа нь цар тахлын хөл хорио, хязгаарлалтын дэглэм багасаж нийгэм, эдийн засгийн хэвийн үйл ажиллагаа аажмаар сэргэх хандлагатай байгаа хэдий ч сэргэлтийн хурд нь Украины нөхцөл байдал, түүхий эд экспортлогч орнуудын геополитикийн бодлогоос шууд хамаарах төлөвтэй байна. Дунд хугацаанд дэлхийн эдийн засагт нөлөөлөх тодорхойгүй нөхцөл байдал олон байгаа бөгөөд түүн дотроос дараах 4 зүйлд ач холбогдол өгч дурдлаа. Үүнд:

1. Украины нөхцөл байдал. Энэхүү нөхцөл байдал нь сунжирвал дэлхийн эдийн засаг төрөл бүрийн шууд болон дам сөрөг нөлөөг үзүүлэх юм. Мөн барууны орнуудын ОХУ-ын эсрэг авч хэрэгжүүлж буй эдийн засгийн хориг арга хэмжээнээс үүдэн тус улсаас гарах дэлхийн томоохон компаниудын тоо нэмэгдэхийн хэрээр хүлээх алдагдал үлэмж байхаар байна. Цаашилбал, түүхий эд болон эрчим хүчний үнэ өсч худалдааны ашиг, алдагдлын тэнцвэргүй байдал улам хурцдаж, ялангуяа байгалийн баялаг импортлогч орнуудын эдийн засгийн сэргэлтэд сөргөөр нөлөөлөхөөр байна.
2. Бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийн дарамт. Түүхий эд болон эрчим хүчний үнийн өсөлттэй холбоотой зардал, цар тахлын нөлөөлөл буурахтай зэрэгцсэн эрэлтийн өсөлтөөс үүдэлтэй инфляцын нөлөөгөөр дэлхийн улс орнуудад инфляц түүхэн дээд түвшиндээ хүрээд байна.
3. АНУ-ын Мөнгөний бодлого. Эрэлтээс үүдэлтэй инфляцын дарамт нэмэгдэж байгаа бөгөөд Холбооны Нөөцийн Сан 2018 оноос хойш анх удаагаа бодлогын хүүгээ 0.25 нэгж хувиар нэмэгдүүлсэн. Цар тахлын хямралыг давахын тулд 2020-оос 2021 онуудад сар бүр 120 тэрбум ам.долларын бонд худалдан авалт, бодлогын хүүг 0 хувь орчимд хадгалах гэх мэт мөнгөний зөөлөн бодлогын нөлөөгөөр тус улсын инфляц сүүлийн 40 жилийн түүхэн дээд түвшинд хүрч өссөн. Иймээс АНУ-ын Төв банкны ерөнхийлөгч Жером Пауэл хэрэглээний үнийн өсөлтийг хязгаарлахын тулд үргэлжлүүлэн бодлогын хүүгээ

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 902031195 СТС2420

УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК 5341469 СТ5382

ГҮҮДСЕК ҮЦК ХХК ТТБ9674 5208173

нэмэх дохио өгөөд байна. АНУ-ын мөнгөний хатуу бодлого нь өөрийн орны хэрэглээ, хөрөнгө оруулалтыг хязгаарлах хүчин зүйл болох боловч АНУ-ын эдийн засаг боломжит өсөлтийн хурдаа тодорхой хэмжээнд хадгалж, харин хөгжиж буй эдийн засагтай орнуудын хувьд мөнгөн тэмдэгтийн ханшийн уналт нь инфляцын дарамтыг улам нэмэгдүүлж, эдийн засагт уналт үүсгэж болохоор байна.

4. БНХАУ-ын цар тахлын эсрэг авч буй арга хэмжээ. Тус улс нь цар тахлыг таслан зогсоохын тулд гол үйлдвэрлэл, бизнесийн бүсүүддээ хөл хорио тогтоож байгаа бөгөөд энэ нь дэлхийн хамгийн том хэрэглэгч улсын эдийн засгийг удаашруулах нөхцөл болж байна. Хятад улсын засгийн газраас цар тахал, түүнд үзүүлж буй хариу арга хэмжээнээс үүдсэн эдийн засгийн уналтыг нөхөхөд чиглэсэн төсөв, мөнгөний бодлого хэрэгжүүлэх төлөвтэй байгаа хэдий ч 2022 оны зорилтот түвшин болох 5.5%-д хүргэхэд амаргүй бөгөөд дотоодын хэрэглээ, үйлдвэрлэлийн зогсонги байдал нь дэлхийн эдийн засагт үлэмж хэмжээний сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай байна.

Дээрх нөхцөл байдлуудаас шалтгаалсан геополитикийн эрсдэл нэмэгдсэн энэ үед 2 дугаар сарын дундаас 3 дугаар сарын дунд үе хүртэлх хугацаанд ам.долларын ханш голлох валютуудын эсрэг 2%-аар чангараад байна.

Мөн түүхий эдийн үнэ сүүлийн 1 жилийн хугацаанд Эрчим хүч 79.2% -аар, Хөдөө аж ахуйн түүхий эд 33.3%-аар, Үнэт металл 4.5%-аар тус тус өссөн байна.

*График 21. Түүхий эдийн үнэ (сүүлийн 5 жилээр)*




*Эх сурвалж: World Bank 2022*

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

## 2.1.2 ДОТООДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

2020 онд эдийн засаг 2019 онтой харьцуулахад 4.4%-аар агшиж байсан бол 2021 онд эдийн засгийн өсөлт сул байсан. Энэ нь дотоодын эдийн засгийн тулгуур болоод байгаа уул уурхайн салбарын сэргэлт удаан, тус салбарын үйлдвэрлэлийн хэмжээ буурсантай холбоотой. 2021 оны хувьд нэгдүгээр улиралд уул уурхайн үйлдвэрлэл эрчимжсэн, экспортын түүхий эдийн үнэ өндөр байсан зэрэг нь нөлөөлж эдийн засгийн өсөлт 15 орчим хувьд хүрсэн бол хоёрдугаар улирлаас эхлэн урд хөрш болох БНХАУ-тай холбогдох хил гааль дээр саатал үүссэний улмаас экспортийн биет хэмжээ хязгаарлагдаж, мөн үйлдвэрлэлийн гол орцуудын импорт буурч эдийн засгийн сэргэлт эрс хумигдсан.

Өнгөрсөн онд цар тахлын шинэ хувилбарын дэгдэлтийн улмаас хөл хорионы дэглэм тогтоосон нь дотоод эдийн засаг, түүн дотор хувийн хэрэглээ, уул уурхайн бус хөрөнгө оруулалт зэрэгт сөрөг нөлөө үзүүлсэн нь 2021 онд Монгол улсын бодит ДНБ сул өсөлттэй байсан голлох шалтгаанууд болж байна.

Инфляц энэ онд хоёр оронтой тоо давсан, гадаад худалдааны тасалдал үргэлжилж байгаа, гадаад санхүүжилтийн нөхцөлүүд урьд өмнөхөөс илүү чангарах хүлээлттэй болсон, мөн геополитикийн төвөгтэй асуудал шинээр бий болж эрсдэл нэмэгдсэн зэрэг нь дотоодын эдийн засгийн өсөлтийг 2022 онд үлэмж хязгаарлах тухай Азийн Хөгжлийн Банкнаас гаргасан тайланд дурдсан байх бөгөөд мөн тайландаа 2021 оны 1.4%-ийн сул өсөлтөөс 2022 онд 2.3%-аар, 2023 онд дотоодын эрэлт, хөрөнгө оруулалт болон хөдөө аж ахуй, аж үйлдвэр, үйлчилгээний салбар дахь сэргэлтийн эерэг нөлөөгөөр 5.6%-аар өсөх төлөвтэй тухай дурдсан байна.

Дотоодын эдийн засгийн цаашдын ойрын төлөв байдал нь худалдааны гол боомтуудад тулгараад байгаа асуудал, цар тахлын халдварын нөхцөл байдал, дахин дэгдэх эсэх, Украины дайны нөлөөнөөс үүсэж буй сөрөг нөлөөллийг хэрхэн зөөлрүүлэх хариу арга хэмжээ зэргээс шууд хамаарахаар байна.

Үүнээс гадна дотоодын санхүүгийн байгууллагуудын активын чанар муудаж, чанаргүй зээлийн хэмжээ өсөх, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа хүндэрч эрсдэлд орох нь дунд хугацааны дотоодын эдийн засгийн төлөв болон санхүүгийн тогтвортой байдалд томоохон эрсдэл болж болзошгүй байна.

*Хүснэгт 11. Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүд (сүүлийн 5 жил, %-аар)*

| | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|
| **Бодит ДНБ-ий өсөлт** | **5.64** | **7.75** | **5.6** | **-4.6** | **1.4** |
| Өрхийн хэрэглээ | 4.3 | 11.7 | 5.8 | 2.1 | -6.6 |
| Төрийн байгууллагын хэрэглээ | -2.4 | 1.1 | 12.3 | 14.6 | 5.7 |
| Үндсэн хөрөнгийн хуримтлал | 28.2 | 31.8 | 14 | -21.1 | 14 |
| Бараа, үйлчилгээний экспорт | 3.7 | 6.1 | 12 | -5.3 | 14.5 |
| Бараа, үйлчилгээний импорт | 11.5 | 32.7 | 8.6 | -15.5 | 9.6 |
| **Инфляцын түвшин /хувиар/** | **6.4** | **8.1** | **5.2** | **2.3** | **13.4** |

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

## Дотоодын нийт бүтээгдэхүүн

Монгол улсын бодит дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт өнгөрсөн 2021 онд өмнөх 2020 онтой харьцуулахад 1.4%-ийн цэвэр өсөлттэй буюу 43.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 5.6 их наяд төгрөгөөр өсөж, 2015 оны зэрэгцүүлэх үнээр 27.0 их наяд төгрөг болсон байна.

Уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг (2015 оны зэрэгцүүлэх үнээр) өнгөрсөн онд 3.7 их наяд төгрөгт хүрч, 2020 оныхоос 62 тэрбум төгрөг буюу 1.7%-аар өссөн байна. Үүнд газрын тосны салбарын олборлолт өмнөх оныхоос 13.7%-аар, зэсийн баяжмалын үйлдвэрлэл 3.9%-аар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Мөн үйлчилгээний салбар 2020 онд өсөлттэй гарсан ба тодруулбал тус салбарын нэмэгдэл өртөг 2021 онд 3.9%-аар өсөж 12.6 их наяд төгрөгт хүрсэн байна. Харин хөдөө аж ахуй 5.5%-аар, аж үйлдвэр, барилгын салбар -7.0%-аар нэмэгдэл өртөг тус тус бууралттай гарсан байна.

*График 22. Дотоодын нийт бүтээгдэхүүний цэвэр өсөлт, бууралт (сүүлийн 5 жил, их наяд төгрөг болон %-аар)*




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

## Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт (М2 мөнгө) 2020 оноос 15.0%-аар өсөж 27.9 их наяд төгрөгт хүрч, М2 мөнгөний жилийн өсөлтийн 9.1 нэгж хувийг төгрөгийн харилцах, 6.8 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 1.5 нэгж хувийг гадаад валютын харилцах, 0.4 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, -2.8 нэгж хувийг гадаад валютын хадгаламж тус тус бүрдүүлж байна.

*График 23. Мөнгөний нийлүүлэлт (сүүлийн 5 жил, их наяд төгрөг болон %-аар)*




*Эх сурвалж: Монголбанк*

## Төлбөрийн тэнцэл

2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр төлбөрийн тэнцэл 221.6 сая ам.долларын алдагдалтай байсан нь өнгөрсөн 2020 оноос 1,008.5 сая ам.доллароор буурсан үзүүлэлт болж, 2021 онд урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 1,994.5 сая ам.долларт, санхүүгийн дансны алдагдал 1,982.2 сая ам.долларт хүрсэн байна.

Монгол Улсын хэрэглээний сагсны бараг тэн хагасыг импортын бараа бүрдүүлэх тул худалдааны тасалдал, логистикийн хүндрэл бэрхшээлүүд нь импортын үнийн өсөлтийг дагуулж байна.

Хэлбэлзэл ихтэй хүнс болон шатахууны үнийг хассан суурь инфляц мөн эрчимжиж 2021 оны 12 дугаар сард жилийн 12.7%-д хүрсэн байна. Бодит ханш үлэмж чангарч, экспорт саарсан нь урсгал тэнцлийн алдагдлыг нэмэгдүүлж, гадаад валютын нийт албан нөөц буурахад хүргэсэн.

*График 24. Төлбөрийн тэнцэл (сүүлийн 5 жил, сая ам.доллараар)*



СЭХ он сар өдөр № 01

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

2022-09-14 БҮРТГЭВ-03

## Инфляц

Хэрэглээний үнийн улсын индекс 2021 оны 12 дугаар сарын байдлаар сарын инфляц 2.1%, жилийн 13.4% байна. Жилийн инфляцыг авч үзвэл 8.1 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 5.3 нэгж хувийг хүнсний барааны үнийн өсөлт бүрдүүлж байна.

Инфляц 2021 онд өсөж, төлбөрийн тэнцэл муудаж байсан ч мөнгөний бодлогын төлөв байдал сул байсан. Боомтын үйл ажиллагаа тасалдаж, нэвтрүүлэх чадвар, нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлсний зэрэгцээ дотоодын зээлийн өсөлтөөс шалтгаалан 2021 оны жилийн инфляц 13.4% болж эрс өсжээ. Монгол Улсын хэрэглээний сагсны бараг тэн хагасыг импортын бараа бүрдүүлэх тул худалдааны тасалдал, логистикийн хүндрэл бэрхшээлүүд нь импортын үнийн өсөлтийг дагуулаад байна. Хэлбэлзэл ихтэй хүнс болон шатахууны үнийг хассан суурь инфляц мөн эрчимжиж 2022 оны 3 дугаар сард 15.8%-д хүрсэн байна. Бодит ханш үлэмж чангарч, экспорт саарсан нь урсгал тэнцлийн алдагдлыг нэмэгдүүлж, гадаад валютын нийт албан нөөц буурахад хүргэсэн байна.

*График 25. Инфляцын түвшин (сүүлийн 5 жилээр)*




## Мөнгөний бодлого

Ковид-19 цар тахал олон улсад хурдтай дэлгэрснээр дэлхийн эдийн засагт хүчтэй сөрөг нөлөө үзүүлж, гадаад болон дотоод эдийн засгийн орчны байдал, цаашдын төлөвийг эрс өөрчилсний зэрэгцээ буцаж сэргэх хугацаа тодорхойгүй байна. Хөгжсөн болон хөгжиж буй улс орнуудад нийгмийн эрүүл мэндийг хамгаалахаар хэрэгжүүлсэн гадаад болон дотоод карантин, хөл хорионы арга хэмжээ нь бизнесийн үйл ажиллагааг хумьж, зах зээл дээр савлагаа үүсгэн эдийн засагт хүчтэй агшилт, уналтыг бий болгосон.

Ковид-19 цар тахал хүмүүсийн хөдөлмөрлөх, хэрэглэх, хадгалах зан, төлөв болоод хөрөнгө оруулалтын шийдвэр, бизнесийн арга барил, нийлүүлэлтийн сүлжээнд олон өөрчлөлтийг түр зуур, зарим тохиолдолд бүрмөсөн бий болгосноор эдийн засагт бүтцийн шинжтэй шилжилтийг бий болгож байна.

ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 СТС2420
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК 5341469 СТ5382
УЛААНБААТАР ХОТ ҮЦК ХХК

Монголбанк зах зээлийн зарчимд тулгуурлан үнийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлснээр инфляц сүүлийн 3 жилд зорилтот 8%-ийн түвшинд тогтвортой хадгалагдаж байв. 2006-аас 2016 онд жилийн дунджаар 10% буюу харьцангуй өндөр түвшинд, өндөр хэлбэлзэлтэй байсан инфляцыг ийнхүү тогтворжуулснаар Төв банк инфляцын зорилтыг бууруулах боломж бүрдээд байсан.

Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ Монголбанк i) ирээдүйд чиглэсэн, ii) зах зээлийн зарчимд суурилсан, iii) эрэлтийн гаралтай инфляцыг зохистой түвшинд хадгалах стратегийг баримталж байна.

Мөн Макро зохистой бодлогыг Ковид-19 цар тахлаас шалтгаалан эдийн засгийн төлөв, санхүүгийн орчинд бий болсон сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, банкны системийн эрсдэлээс сэргийлэх, санхүүгийн зуучлалыг тасалдуулахгүй байлгах зорилгоор мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлж байна.

## Монголбанкны бодлого, арга хэмжээ

Ковид-19-ийн эдийн засгийн хүндрэлийн үед мөчлөг сөрсөн арга хэрэгслийг ашиглан банкны салбарын эрсдэл даах чадварыг хадгалах, хяналт шалгалтын болон зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, хууль, эрх зүйн орчны шинэтгэлийг үргэлжлүүлэх ажлууд төлөвлөгдсөн, цар тахал цаашид хэдий хугацаанд үргэлжлэх нь тодорхой бус байгаа хэдий ч 2021 онд Монголбанкны хяналт шалгалтын бодлого i) хүндрэлийг хохирол багатай даван туулж, санхүүгийн зуучлалын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогын арга хэмжээнүүдийн хувилбаруудыг боловсруулж хэрэгжүүлэх, ii) түр хугацааны мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээнүүдээс аажмаар гарах төлөвлөгөөг боловсруулахад чиглэж ирсэн байна. Үүний зэрэгцээ, банкны зохистой харьцаа, активын ангилал, төлбөрийн чадварын үзүүлэлт болон хяналт шалгалтын хүрээнд тавигддаг шаардлагуудыг Базелийн цуврал стандарттай нийцүүлэн шат дараатай нэвтрүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх суурь шилжилтийг тасралтгүй үргэлжлүүлж ирсэн байна.

Мөн Бие даасан 10 гаруй хуулийг багтаасан “Банкны салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хууль тогтоомжийн давхардал, хийдэл зөрчлийг арилган уялдаа холбоог сайжруулснаар санхүүгийн зах зээл илүү үр ашигтай ажиллах, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагч, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зах зээлд технологийн дэвшил нэвтэрч шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ бий болох орчныг бүрдүүлэх, санхүүгийн зуучлалыг өргөжүүлэхийг зорилт болгосон байна.

*Эх сурвалж: Монголбанк*

## Гадаад сектор

2021 онд Монгол Улс дэлхийн 159 оронтой худалдаа хийж гадаад худалдааны нийт бараа эргэлт 16,086.6 сая ам.доллар болж 2020 оны гүйцэтгэлээс 3,211.4 сая ам.доллар буюу 24.9%-аар өссөн. Экспортын дүн импортын дүнгээс 2,395.7 сая ам.доллараар давж, гадаад худалдааны баланс эерэг гарсан байна.

*График 26. Гадаад худалдааны тэнцэл (сүүлийн 6 жил, сая ам.доллар)*




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

## Монгол улсын зээлжих зэрэглэл

Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Фитч агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг "B", төлвийг "Тогтвортой" хэвээр үлдээснээ 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдөр зарласан. Фитч агентлагийн дүгнэлтээр Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал дараах үндэслэлүүдээр тогтвортой байна гэж үзсэн байна. Үүнд:

- Монгол Улсын засаглалын үзүүлэлтүүд, нэг хүнд ногдох орлого нь "B" түвшинтэй бусад орнуудтай харьцуулахад өндөр байна. Мөн дунд хугацаанд эдийн засгийн өсөлт таатай төлөвтэй,
- Ойрын хугацаанд эдийн засгийн өсөлт тогтвортой хэвээр байна: Ковид-19-ийн эсрэг вакцинжуулалтын түвшин нэмэгдэж, экспортын түүхий эдийн үнэ өсөж, хил дахин нээгдсэн ч Фитч агентлаг нь Монгол Улсын энэ оны бодит эдийн засгийн өсөлтийг 1.2% гэж таамаглаж байна. Учир нь БНХАУ-ын "динамик тэг Ковид" бодлогын нөлөөгөөр хилийн боомтууд бүрэн нээгдээгүй байгаа нь Монгол Улсын нүүрсний экспорт болон бусад барааны худалдааг тасалдуулж байна. Фитч агентлагаас 2023 онд хил дээрх худалдааны тасалдал багасна гэсэн хүлээлттэй,

СЭХ
он 2022 сар 9 өдөр
БҮРТГЭВ
№ 01



- Дунд хугацааны өсөлтийн таатай төлөв: Гадаад худалдааны тасалдал, Украин дахь дайны улмаас үүссэн сөрөг нөлөө буурч, экспортын гол түүхий эдийг худалдан авах БНХАУ-ын эрэлт тогтвортой хэвээр байх тул Фитчээс Монгол Улсын ДНБ-ий өсөлтийг 2023 онд 6.3%, 2024 онд 6.8% хүртэл өснө гэж төсөөлж байна. Оюутолгойн далд уурхай ашиглалтад орж, хил дээрх дэд бүтцүүд сайжирснаар Монгол Улсын эдийн засагт илүү их үр өгөөж өгөх тул байгалийн баялгийн нөөцөө бүрэн ашиглах боломжтой,

- Оюутолгой төслийн бүтээн байгуулалтад гарсан ахиц: Стратегийн ач холбогдол бүхий Оюутолгой төслийн талаар Засгийн газар болон хөрөнгө оруулагч талуудын сүүлд байгуулсан гэрээ нь төслийн саатал, зардлын хэтрэлт, татвараас үүдсэн маргаантай харилцаа намжсан гэдгийг харуулж байна. Энэхүү гэрээ нь гадаадын хөрөнгө оруулагчдад болон далд уурхайн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэхэд эергээр нөлөөлнө,

- Улсын төсөв: Төсвийн алдагдлыг 2022 онд ДНБ-ийн 4.4% (В зэрэглэлтэй бусад улсуудын дундаж: 4.7%) болж өснө гэж төсөөлж байна. Цаашид Монгол Улсын эдийн засаг сэргэх хандлагатай байгаа тул төсвийн орлого бүрдүүлэлт эрчимжсэнээр алдагдал 2023 онд 3.7% хүртэл буурна,

- Гадаад валютын нөөцийн төсөөлөл: Фитчээс Монгол Улсын урсгал тэнцлийн алдагдлыг 2022 онд ДНБ-ий 16%, гадаад өрийн үлдэгдэл ДНБ-ий 167%-тай байна гэж төсөөлсөн бөгөөд гадаад валютын нөөцийг 2022 оны эцэс гэхэд 3.6 тэрбум ам. доллар байна гэж төсөөлсөн.

  *Эх сурвалж: Монголбанк*

Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг нэгтгэн дүгнэвэл 2020 онд Ковид-19 цар тахал болон гадаад орчны бусад таагүй нөлөөгөөр экспорт, хөрөнгө оруулалт саарч, эдийн засаг агших, инфляцын дарамт харьцангуй бага байлаа. Харин сэргэх хугацааны хувьд олон улсад тодорхойгүй байгаа тул түүнээс улбаалан дотоод эдийн засгийн сэргэлтэд гадаад орчноос үзүүлэх дэмжлэг тодорхойгүй байна. Гэсэн хэдий ч төсвийн алдагдал болон төлбөрийн тэнцлийн алдагдал нэгэн зэрэг нэмэгдэн эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлж, ирэх онуудад томоохон гадаад өрийн эргэн төлөлт хүлээгдэж буй нь эмзэг байдлыг улам нэмэгдүүлж байна. Цаашид Ковид-19 цар тахлын нөлөөгөөр эдийн засагт гарч буй сөрөг нөлөөллийг бууруулахын зэрэгцээ үүсэж болзошгүй эрсдэлүүдээс сэргийлж, макро эдийн засаг, ажил эрхлэлтийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах замаар эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд макро эдийн засгийн бодлогууд чиглэгдэхээр байна.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
СТС2420

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

СЭХ он сар өдөр БҮРТГЭВ № 01

2022-09-14

### 2.1.3 САНХҮҮГИЙН САЛБАР

2021 оны жилийн эцсийн байдлаар 11 арилжааны банк, 534 ББСБ, 209 ХЗХ, 55 үнэт цаасны компани, 15 даатгалын компани, 57 даатгалын зуучлагч, 25 даатгалын хохирол үнэлэгч компани үйл ажиллагаа явуулж байна.

*Хүснэгт 12. Санхүүгийн салбарын голлох үзүүлэлтүүд /2021 он, тэрбум төгрөгөөр/*

| Үзүүлэлтүүд | Банк | ББСБ | ХЗХ | Даатгал |
|---|---|---|---|---|
| **Актив** | 40,936 | 2,710 | 291 | 425 |
| **Өр төлбөр** | 36,923 | 911 | 227 | 32 |
| **Эзэмшигчдийн өмч** | 4,013 | 1800 | 64 | 200 |
| **Чанаргүй зээл** | 1,738 | 140 | 7 | - |
| **Тайлант үеийн ашиг** | 549 | 210 | 11 | 25 |
| **Даатгалын хураамжийн орлого** | - | - | - | 247 |
| **Даатгалын нөхөн төлбөр** | - | - | - | 70 |

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Дэлхий даяар тархаад буй Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас Монгол Улсын эдийн засаг 2020 онд хурдтай агшиж, аж ахуйн нэгж, өрхүүдийн секторт орлого тасалдах, зээлийн эргэн төлөлт доголдож төлбөрийн чадварын хүндрэлд орох нөхцөл байдал үүссэн.

Санхүүгийн системийн эрсдэлийн нэгдсэн индексээс харахад 2020 оны эхнээс системийн эрсдэл эрчимтэй нэмэгдсэн бөгөөд үүний 50 гаруй хувийг макро болон гадаад секторын эрсдэл дангаараа бүрдүүлж байлаа. Банкны сектор, хөрөнгийн зах, хөрвөх чадвар, санхүүжилтийн эрсдэлүүд мөн нэмэгдэж, нийт системийн эрсдэл үргэлжлэн нэмэгдэх хандлагатай болсон нь цаашлаад системийн тогтвортой байдал алдагдах эрсдэлийг үүсгэх тул санхүүгийн зохицуулагч байгууллагуудын зүгээс иргэд, аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн дарамтыг бууруулж, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх зорилгоор шат дараатай арга хэмжээг өргөн хүрээнд авч хэрэгжүүлсэн байна. Үүний үр дүнд иргэд, аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадвар сайжирч, банк, санхүүгийн системийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлсэн байна.

Дээрх зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй тохиолдолд банкны системийн чанаргүй зээл 1.5 их наяд төгрөгөөр илүү дүнд хүрэх төлөвтэй байсан бөгөөд улмаар чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 16.1%-д хүрэхээр байсан. Энэ нь 2008-аас 2009 оны дэлхийн санхүүгийн хямралын үед Монгол улсад тохиолдож байсан банкны салбарын хүндрэлийн нөхцөл байдалтай ижил буюу уг зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй нөхцөлд банк, санхүүгийн системд томоохон хэмжээний хүндрэл үүсэж болзошгүй байсан дүр зураг ажиглагдаж байна.

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ ГҮЙЦЭК

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
2022-09-14

## Банк бус санхүүгийн байгууллагын салбар

2021 оны жилийн эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 534 ББСБ байгаа нь 2020 оны мөн үеэс 2 ББСБ буюу 0.4%-аар өссөн үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 83 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 28 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 4 ББСБ байна.

*Хүснэгт 13. Банк бус санхүүгийн байгууллагын салбарын хөрөнгө оруулалтын бүтэц (Гадаад, Дотоодын хөрөнгө оруулалтаар)*

| | ББСБ-ын тоо | Нийт хөрөнгө | | Нийт зээл | | Харилцагчдын тоо | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хэмжээ /тэрбум төг/ | % | Хэмжээ /тэрбум төг/ | % | Тоо | % |
| **Дотоодын хөрөнгө оруулалттай** | 506 | 2,341.3 | 86% | 1,724.6 | 86% | 4,726,234.0 | 98% |
| **Гадаадын хөрөнгө оруулалттай** | 28 | 368.6 | 14% | 287.6 | 14% | 94,390.0 | 2% |

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 534 ББСБ есөн төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 92.9% нь буюу 496 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 61.0% нь буюу 326 ББСБ зөвхөн зээлийн үйл ажиллагааг дагнан эрхэлж байна. Харин гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 146 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 27%, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 38 ББСБ нийт ББСБ-уудын 7.1%-ийг тус тус бүрдүүлж байна.

Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оны мөн 6 үеэс 2.7%-аар буурч, бусад төрлийн үйл ажиллагааны тоо нэмэгдэж байгаа нь ББСБ-ууд үйл ажиллагааны цар хүрээгээ тэлж байгааг харуулж байна. Харин 2020 оноос нэг жилийн хугацаанд нэмэгдсэн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ 81.8%-аар, факторингийн үйлчилгээ 17.6%-аар, төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ 14.3%-аар, итгэлцлийн үйлчилгээ 14.0%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

*График 27. Банк санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө болон зээлийн хэмжээ (сүүлийн 5 жил, тэрбум төгрөгөөр)*

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ЗЭЭЛИЙН ҮЦК ХХК

СЗХ 2022 оны 09 сар 21 өдөр БҮРТГЭВ № 01

2022-09-14




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

2021 онд Монгол Улсын хэмжээнд ББСБ-аас нэг зээлдэгч дунджаар 1,199.1 мянган төгрөгийн зээл авсан бол орон нутагт энэхүү үзүүлэлт 1,932.6 мянган төгрөг, Улаанбаатар хотын хувьд 1,189.5 мянган төгрөг байна. Харин уг үзүүлэлт 2020 онд улсын хэмжээнд 1.7 сая төгрөг байсан ба 2021 онд ББСБ-ын нэг зээлдэгчид ногдох зээлийн дундаж хэмжээ 564.8 мянган төгрөгөөр буюу 1.5 дахин буурчээ. Энэхүү бууралт нь зээлдэгчдийн тооны өсөлт, зээлийн өсөлтөөс өндөр байгаатай холбоотой. Нийт зээлдэгчдийн тоо 1.7 сая байгаа нь давхардсан тоогоор хөдөлмөрийн насны буюу 18-64 насны 100 хүн тутмын 85 нь ББСБ-аас зээлтэй байна.

## Даатгалын салбар

2021 оны жилийн эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн үндсэн дээр 2021 онд нийт 322 даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч, аудитын компани, актуарч, аудитор мөн 2,403 даатгалын төлөөлөгч үйл ажиллагаа эрхэлж байна. 2021 онд нийт хөрөнгийн хэмжээ 2020 оноос 11.3%-аар өсөж 425.4 тэрбум төгрөгт хүрсэн бол 2017 оноос 73.8%-аар өсжээ.

Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ бусад даатгалын төрөлтэй харьцуулахад өмнөх оноос 13.0%-аар өсөж 358.3 тэрбум төгрөг хүрч, салбарын нийт хөрөнгийн 84.2%-ийг эзэлж байна. Давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө өмнөх онтой харьцуулахад 4.7%-аар өсөж, 57.8 тэрбум төгрөг хүрсэн нь салбарын нийт хөрөнгийн 13.6%-ийг эзэлж байна. Урт хугацааны даатгалын компаний нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 5.1%-аар буурч, 9.3 тэрбум төгрөгт хүрч, салбарын 2.2%-ийг эзэлж байна.

*График 28. Даатгалын салбар болон салбарын нийт хөрөнгийн өсөлт (сүүлийн 5 жил, тэрбум төгрөгөөр)*




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

2021 оны жилийн эцсийн байдлаар Даатгалын зуучлагч банкуудын тухайн үйлчилгээний хураамжийн орлого 26.6 тэрбум төгрөг, шимтгэлийн орлого 6.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

СЭХ
2022 09 21
БҮРТГЭВ



Хүснэгт 14. Даатгалын зуучлагч банкуудын орлогын үзүүлэлт (сая төгрөгөөр)

| Даатгалын зуучлагч | Зуучилсан даатгалын хураамжийн орлого | Даатгалын зуучлалын шимтгэлийн орлого | Харьцаа |
|---|---|---|---|
| Ариг банк | 70.1 | 12.1 | 17.2% |
| Богд банк | 42.0 | 8.4 | 20.0% |
| Голомт банк | 6,283.7 | 1,570.9 | 25.0% |
| Капитрон банк | 439.6 | 109.5 | 24.9% |
| Төрийн банк | 4,814.1 | 1,116.4 | 23.2% |
| Тээвэр хөгжлийн банк | 154.0 | 11.3 | 7.3% |
| Үндэсний хөрөнгө оруулалтын банк | 25.3 | 5.7 | 22.6% |
| Хаан банк | 7,247.2 | 1,705.8 | 23.5% |
| Хас банк | 2,887.2 | 504.5 | 17.5% |
| Худалдаа хөгжлийн банк | 4,649.1 | 1,151.2 | 24.8% |
| **Нийт** | **26,612.4** | **6,195.8** | **19.9%** |

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

## Үнэт цаасны зах зээл

### Зах зээлийн үнэлгээ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2021 оны жилийн эцсийн байдлаар 5.98 их наяд төгрөг болсон нь 2020 оны жилийн эцэстэй харьцуулахад 97.5%-аар өссөн бөгөөд уг үзүүлэлт ДНБ-ний 13.9%-ийг эзэлж байна.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
5183855
СТС2420
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК
ТТБ8674 5208173

*График 29. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь (сүүлийн 5 жил, тэрбум төгрөгөөр)*




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

**Үнэт цаасны зах зээлийн нийлүүлэлт**

2021 онд нийт 1.41 их наяд төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн байна. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага дээр өмнөх онуудад зөвхөн хувьцаа, өрийн хэрэгсэл, ЗГҮЦ гэсэн 3 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагддаг байсан бол 2020 онд анх удаа хамтын хөрөнгө оруулалтын сан, 2021 оны 1 дүгээр улиралд хамгийн анхны нийтэд санал болгон гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас арилжаалагдсан.

Мөн 2021 онд зах зээл дээр компанийн өрийн хэрэгсэл түлхүү гарч, компанийн өрийн хэрэгслийн арилжааны хэмжээ огцом өссөн бөгөөд нийт үнэт цаасны арилжааны 21.6%-ийг хувьцаа, 74.1%-ийг компанийн өрийн хэрэгсэл, 4.0%-ийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, 0.3 %-ийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа тус тус эзэлсэн байна.

2021 онд нийт үнэт цаасны арилжааны хэмжээ өмнөх онтой харьцуулахад 21.6 дахин өссөн бөгөөд компанийн бондын арилжаа 181 дахин өссөн нь Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-нд зээл, санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойлогдсон томоохон төслүүдийн бүтээн байгуулалтыг идэвхжүүлж, эдийн засгийг сэргээх хөшүүрэг болгох чиглэлээр “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан 692.5 тэрбум төгрөгийн бондын арилжаа голчлон нөлөөлсөн байна.

Хөдөө аж ахуйн биржээр 2021 онд 6 төрлийн нийт 794.6 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 305.9 тэрбум төгрөгөөр буюу 62.6%-аар өссөн байна.

*График 30. Хөрөнгийн биржийн арилжаанд бүтээгдэхүүний эзлэх хувь (сүүлийн 5 жилээр)*




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

**Хөрвөх чадвар**

Дэлхийн банкнаас гаргасан үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын багтдаг ангилал буюу дунджаас бага орлоготой орнуудын хөрвөх чадварын үзүүлэлт 53.6% байгаа бол өндөр орлоготой орнуудын хөрвөх чадварын үзүүлэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар 98.6%-тай байна.

Монгол Улсын хувьд хувьцааны хөрвөх чадвар 2021 оны жилийн эцсийн байдлаар 2.25 пунктээр өсөж 3.8%-д хүрсэн бөгөөд хувьцааны арилжаа 2020 онтой харьцуулахад 5.7 дахин өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

*График 31. Хөрвөх чадварын үзүүлэлт (сүүлийн 5 жилээр)*




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

## Хадгаламж зээлийн хоршоо

2021 онд Санхүүгийн зохицуулах хорооноос үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 209 хадгаламж, зээлийн хоршоо үйл ажиллагаа явуулж байгаа нь 2020 онтой харьцуулахад 40 хадгаламж, зээлийн хоршоо буюу 16.1%-аар буурсан үзүүлэлт юм.

Нийт хадгаламж, зээлийн хоршоодын 44.5% буюу 93 ХЗХ орон нутагт, 55.5% буюу 116 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна. 2017 оноос хойш хадгаламж, зээлийн хоршоодын тоо тасралтгүй буурсаар байгаа нь иргэд, аж ахуй нэгжүүдийн ХЗХ-дод итгэл буурсантай холбон тайлбарлаж болохоор байна.

*График 32. Үйл ажиллагаа явуулж буй Хадгаламж зээлийн хоршоод (сүүлийн 5 жилээр)*




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

## 2.1.4 БАНКНЫ САЛБАР

2021 оны байдлаар Монгол улсад нийт 11 арилжааны банк, 1,393 салбар, нэгж болон 15,958 ажилчидтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Банкны салбар нь санхүүгийн салбарын 92.4%-ийг бүрдүүлж байгаа бөгөөд системийн нөлөө бүхий 5 банк болох Төрийн банк, Хаан банк, Худалдаа Хөгжлийн банк, Голомт банк, Хас банкууд нь системийн 90-ээс дээш хувийг бүрдүүлж байна.

**Банкны салбарын түүхэн хөгжил**

Монгол туургатан эрт дээр үеэс металл болон цаасан мөнгө гарган гүйлгээнд хэрэглэж байсан бөгөөд Мөнх хааны үед буюу 1253 онд цаасан мөнгөн дэвсгэрт гаргаж, мөнгөний хэрэг эрхлэх газар, Хубилай хаан Хархорумд 1260 онд мөнгө тушаах банк байгуулж, 1282 оноос “Олон замд тэгшитгэх банк” нэртэй банкны салбаруудыг байгуулан ажиллуулж байсан түүхтэй. Харин Манж, Хятадын дарлалын үед энэ түүхэн уламжлал тасарч Монголын зах зээл дээр Хятад, Оросын зэрэг валютууд өргөн хэрэглэгдэж байсны дээр 19 дүгээр зууны сүүлээр Нийслэл хүрээ, Улиастай зэрэг газар Хятад, Оросын зарим банкны салбар ажиллаж байжээ. Үүний дараагаар 1921 оны ардын хувьсгалын дараа Монгол Улсад үндэсний банк, зээлийн систем хөгжих боломж бүрдсэн байна.

1924 оны 6 дугаар сарын 2-нд Монгол, Зөвлөлт Орос улсын хувь нийлүүлсэн хөрөнгөөр Монголын худалдаа, аж үйлдвэрийн банк байгуулагдан, нээгдэхдээ 260 мянган янчааны хөрөнгөтэй, 22 орон тоотой, үүний дотор зөвлөлтийн мэргэжилтэн 18, монгол ажилчид 4 байсан нь Монгол Улсад банкны системийн суурь тавигдсан үйл явдал гэж үзсэн байна.

1950-аад он гэхэд Монголбанкны аппарат өргөжин бэхжиж бүх аймаг, томоохон хот сууринд өөрийн салбартай болж, Зөвлөлт Холбоот Улсын мэргэжилтнүүдийн тусламжаар үндэсний боловсон хүчин бэлтгэгдэж нийт ажилчдын 98%-ийг эзлэх болсон бөгөөд Зөвлөлт Холбоот Улс Монголбанкинд оруулсан өөрийн хувь хөрөнгө, хувьцаа 1954 онд монголын талд шилжүүлэн

өгснөөр Монголбанк БНМАУ-ын Улсын банк болон зохион байгуулагдсан байна.

1990 онд улс төр, нийгэм, эдийн засагт шинэчлэл хийгдэж, тухайн жилдээ "Аж ахуйн банк байгуулах болон түүний үйл ажиллагааны нийтлэг дүрэм", 1991 онд "Банкны тухай хууль" батлагдсанаар Монгол Улсад 2 шатлалт банкны тогтолцооны хөрс суурь тавигдсан. Банкны 2 шатлалтай тогтолцоонд шилжсэнээс хойш өдгөөг хүртэл арилжааны 31 банк байгуулагдаж, үйл ажиллагаа явуулснаас 17 банк өөрийн үйл ажиллагааны алдаа, эндэгдлээс шалтгаалан санхүү, төлбөрийн чадваргүй болон дампуурч, дүрмийн санг тогтоосон хэмжээнд хүргээгүй, бусад банктай нэгдэх, татан буугдах зэргээр үйл ажиллагаагаа зогсоож, улмаар Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болсон байна.

2016 оны байдлаар нийт 14 арилжааны банк үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд эдгээр банкууд нь өөрийн 1,386 салбар, нэгжээр дамжуулан Монгол Улсын бүх аймаг, хот, сум, суурин газруудад үйлчилж байсан, салбарын хэмжээнд нийт 13,564 ажиллагсад ажиллах хэмжээнд хүрсэн зэрэг тухайн салбарын өсөлтийг илтгэх нэгээхэн хэмжүүр болсон байдаг.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад банкны салбар нь эрчимтэйгээр хөгжиж орчин үеийн шинэлэг технологиудыг амжилттай нэвтрүүлж ирсэн. 2021 оны байдлаар нийт 11 арилжааны банкууд нь 1393 салбар, нэгж болон 15,958 ажилчидтайгаар үйл ажиллагаа явуулж байгаа, санхүүгийн салбарын 92.4%-ийг бүрдүүлдэг, түүн дотроо Хаан банк, Худалдаа Хөгжлийн банк, Голомт банк, Төрийн банк, Хас банк гэх системийн нөлөө бүхий 5 банкууд системийн 90-ээс дээш хувийг бүрдүүлж байгааг Монголбанкнаас тодорхойлсон байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар банкны салбарын нийт активын хэмжээ 41 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны жилийн эцсээс 11.8%-аар буюу 4.3 их наяд төгрөгөөр өссөн байна. Энэхүү үзүүлэлтийг 5 жилийн өмнөх үзүүлэлттэй харьцуулахад 61.9%, 10 жилийн өмнөх үзүүлэлттэй харьцуулахад 337.6% болж тус тус өссөн байна.

## Банкийг нээлттэй хувьцаат компани болгох үйл ажиллагаа

Монгол Улсын Их хурлын 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн чуулганаар баталсан “Банкны тухай хууль”-ийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд банкны салбарт томоохон хэмжээний шинэтгэлийг нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Уг өөрчлөлтөөр: 1) банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, 2) банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах зохицуулалтыг нэвтрүүлж, банкны зохистой засаглал, үйл ажиллагааны ил тод болон хүртээмжтэй байдлыг сайжруулах орчныг бий болгосон.

Банкны тухай хуулийн дагуу банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувь эзэмшлийн төвлөрлийг 20% хүртэл бууруулах үйл ажиллагааны хүрээнд Монголбанкаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь дээрх зураглалд дүрсэлсэн 9 шатнаас бүрдэнэ. Үүнд:

**I шат**: Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны Даргын 2021 оны А-90/85 дугаар хамтарсан тушаалаар "Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам"-ыг баталсан. Энэхүү түр журмын дагуу банкны системд нөлөө бүхий банкийг нээлттэй хувьцаат компани, бусад банкийг хаалттай эсвэл нээлттэй хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор нэг хувьцаа эзэмшигчийн хувь эзэмшлийг 20 хувь хүртэл бууруулах төлөвлөгөөг боловсруулж, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлэх үүрэгтэй;

**II шат**: Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны А-104 дүгээр тушаалаар "Банкны системд нөлөө бүхий банкийг тогтоох аргачлал"-ыг баталсан. Уг аргачлалын дагуу Монголбанкны бодлого, зохицуулалтын чиг үүрэг бүхий газраас банкны системд нөлөө бүхий болон бусад банкуудыг тэдгээрийн хөрөнгө, өр төлбөрийн хэмжээ, төлбөрийн систем дэх гүйлгээний нийт дүн, үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн тогтолцоо дахь хамаарал зэрэг үзүүлэлтийг үндэслэн тогтооно. Банкны системд нөлөө бүхий болон бусад банкуудыг тогтоох нь банкны зохицуулалт, хяналт шалгалтын оновчтой байдлыг сайжруулахын зэрэгцээ аль банкууд "Банкны тухай хууль"-ийн дагуу нээлттэй хувьцаат компани болох шаардлагатайг тодорхойлох юм;

**III шат**: Банк хувьцаат компанийн хэлбэрт шилжин хувьцаагаа хөрөнгийн зах зээлд арилжаалж эхэлж байгаатай холбогдуулан "Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах журам"-ын төслийг боловсруулж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу олон нийтээс санал авсан;

**IV, V шат**: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос түр журмын дагуу 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэх банкны төлөвлөгөөг хянаж, хэрэгжих боломжтой, үндэслэлтэй, хувьцаат компани хэлбэрт шилжих үйл ажиллагаа нь холбогдох хууль, журмын зохицуулалттай нийцтэй эсэхийг үнэлнэ;

**VI шат**: Банкны салбарын эрсдэл буюу алдагдал даах чадварыг бэхжүүлэх, уян хатан байдлыг нэмэгдүүлэх, үүгээрээ банкны салбарын тогтвортой байдлыг хангах зориулалт бүхий хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг банкууд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны А-276 дугаар тушаалын дагуу 100.0 тэрбум төгрөг хүртэл нэмэгдүүлнэ. Энэ шаардлагыг хэрхэн хэрэгжүүлэх талаар банкууд төлөвлөгөөндөө мөн тусгах шаардлагатай;

**VI, VII шат**: Хуулийн дагуу банкууд 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор компанийн хариуцлагын хэлбэрээ хувьцаат компани болгож

СЭХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14
БҮРТГЭВ-03

өөрчилнө. Банк хаалттай эсвэл нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжихэд дараах алхмуудыг баримтална. Үүнд:

1. Нээлттэй хувьцаат компани болоход: Банк түр журмаар ирүүлсэн төлөвлөгөөг хүлээн авсан тухай мэдэгдлийг Монголбанкаас хүлээн авсны дараагаар Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын үнэт цаас бүртгэх харилцааг зохицуулсан журамд нийцүүлэн боловсруулсан үнэт цаасны танилцуулгаа эдгээр байгууллагуудад бүртгүүлнэ. Ингэснээр тухайн банкны үнэт цаас буюу хувьцааг нийтэд санал болгон анх удаагаа гаргах нөхцөл бүрдэж, хувьцаагаа анхдагч зах зээлээр дамжуулан нээлттэйгээр арилжаална. Үүний дараа тухайн банкны хувьцааны өмчлөлийн мэдээллийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгэж, хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх бөгөөд тухайн банкийг улсын бүртгэлд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн бүртгэнэ;

2. Хаалттай хувьцаат компани болоход: Дээрх түр журмын дагуу ирүүлсэн төлөвлөгөөг Монголбанк хүлээн авсан тухай мэдэгдлийг үндэслэн банк Санхүүгийн зохицуулах хорооны “Хаалттай хувьцаат компанийн тухай журам”, “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ын дагуу банкийг Санхүүгийн зохицуулах хороонд, тухайн банкны үнэт цаасыг Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоонд тус тус бүртгүүлж, банкийг улсын бүртгэлд хаалттай хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн бүртгэнэ (хаалттай хүрээнд худалдсан хувьцааны өмчлөлийн мэдээллийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага мөн бүртгэнэ).

**VIII, IX шат**: Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны хэмжээ тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байхаар зохицуулсан. Энэхүү хуулийн шаардлагыг биелүүлэх зорилгоор банк болон банкны хувьцаа эзэмшигчид өөрсдийн эзэмшилд буй хувьцааг биржийн бус зах зээл, хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар дамжуулан худалдаж, 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор нэг хувьцаа эзэмшигчийн хувь эзэмшлийн төвлөрлийг 20 хувиас хэтрүүлэхгүй байх үүрэгтэй. Энэхүү өөрчлөлт нь банкуудын хувь эзэмшлийн хэт төвлөрлийг бууруулж, өмчлөл-хяналтын тогтолцоог сайжруулан сайн засаглал, давхар хяналтын орчныг бэхжүүлэх юм.

*Эх сурвалж: Монголбанк*

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК
ТТ56674 5208173

СЭХ 2022 оны ... өдөр БҮРТГЭВ № 01
2022-09-14

## 2.2 ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА

### 2.2.1 БАНКУУДЫН ХАРИЛЦАГЧИД ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

2021 оны байдлаар улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 11 арилжааны банкууд нийт 272 салбар, 1,028 тооцооны төв, 62 валют солих цэг зэрэг нийт 1,393 салбар нэгжээр дамжуулан үйлчилгээ үзүүлж байна.

Төрийн Банкны хувьд Монгол улсын хэмжээнд нийт 495 салбар, нэгж үүнээс Улаанбаатар хотод 84, орон нутагт 411 салбар, нэгж болон 347 АТМ-ээр дамжуулан үйлчилгээгээ үзүүлж байгаа нь салбартаа хоёрдугаарт орох үзүүлэлт болж байна.

Улсын хэмжээнд Нийгмийн халамжийн сангаас 2021 онд давхардсан тоогоор 2.5 сая иргэнд нийт 1,971.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, халамжийг арилжааны банкуудаар дамжуулан олгосон бөгөөд үүний дийлэнхийг Төрийн банкаар дамжуулсан хэрэгжүүлсэн байна. Мөн орон сууц хэрэглээний төлбөрийн 90 гаруй хувийн гүйлгээг Төрийн банк дангаар гүйцэтгэж байна.

*Хүснэгт 15. Арилжааны банкуудын салбар, нэгжийн тоо (2021 оны байдлаар)*

| Банк | Салбарын тоо | Тооцооны төвийн тоо | Валют солих цэгийн тоо | Төлөөлөгчийн газрын тоо | Бусад нэгжийн тоо | Нийт салбар нэгжийн тоо |
|---|---|---|---|---|---|---|
| ХААН банк | 32 | 490 | 2 | 1 | 22 | 547 |
| **Төрийн банк** | **35** | **449** | **9** | **1** | **1** | **495** |
| Голомт | 64 | 12 | 24 | 1 | - | 101 |
| Худалдаа хөгжлийн банк | 64 | 12 | 14 | 1 | - | 91 |
| Хас банк | 33 | 41 | 4 | - | - | 78 |
| Капитрон | 20 | 12 | 7 | - | - | 39 |
| Ариг | 1 | 12 | - | - | 1 | 14 |
| Богд | 11 | - | - | - | - | 11 |
| Тээвэр хөгжлийн банк | 7 | - | 1 | - | - | 8 |
| Үндэсний хөрөнгө оруулалтын банк | 3 | - | - | - | 3 | 6 |
| Чингис Хаан банк | 2 | - | 1 | - | - | 3 |
| **Нийт** | **272** | **1,028** | **62** | **4** | **27** | **1,393** |

*Эх сурвалж: Монголбанк*

УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК 5341499 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ ТТБ0674 5208173

Монгол Улс нь 2020 оны банкны өрсөлдөх чадварын Ерөнхий индексээр 39 улсаас 26 дугаар байранд жагсаж байгаа бол Хүртээмжийн индексээр 1 дүгээр байранд жагсаж байна.

Тухайн улсын харилцагчдад банкны үйлчилгээ хэр хүртээмжтэй, хүрэлцээтэй байгааг АТМ-н тоо, салбарын тоо, түүнчлэн зээл, хадгаламжийн дансны тоо гэх мэт үзүүлэлтээр тооцдог бөгөөд 2019 оны байдлаар Монгол Улсын хувьд 2 хүн тутмын 1 нь мобайл банктай, 3 хүн тутмын 1 нь интернэт банктай, 3 хүн тутмын 1 нь зээлтэй байна. Энэ нь Хүртээмжийн индексээр 1 дүгээр байранд жагсахад голлон нөлөөлсөн байна.

Арилжааны банкуудын нийт харилцагчдын тоо 11 банкны хэмжээнд давхардсан тоогоор 8.3 саяд хүрээд байна. Үүний дотор Төрийн банк болон Хаан банкууд харилцагчдын тоогоор тэргүүлж байна.

*График 33. Харилцагчид хүртээмжтэй байдал, цар хүрээ*




*Эх сурвалж: Банкуудын вебсайт, Монголбанк*

### 2.2.3 БАНКУУДЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

Арилжааны банкны үндсэн үүрэг нь мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй байгаа хэсгээс хөрөнгийг татаж, дутагдалтай байгаа хэсэгт шилжүүлэн, харилцагчдын итгэл дээр суурилсан санхүүгийн зуучлалын үйлчилгээ үзүүлэх, харилцагчдын хоорондын төлбөр тооцоог хийж гүйцэтгэх байдаг ба эцсийн зорилго нь санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан ашиг олох байдаг.

Орчин үед банкууд харилцагчдынхаа цаг хугацаа, ажлыг хөнгөвчлөн бүтээгдэхүүн үйлчилгээгээ цахимжуулж, интернэт банк, мобайл банк, олон төрлийн карт, орлого, зарлага, мөнгөн шилжүүлэг хийдэг бэлэн мөнгөний машин АТМ, харилцагчдад санхүүгийн зөвлөгөө мэдээлэл өгөх зэрэг олон үйлчилгээг үзүүлж байна.

*Хүснэгт 16. Арилжааны банкуудын бүтээгдэхүүн үйлчилгээ*

| Хадгаламж | Зээл | Карт |
|---|---|---|
| • Харилцах<br>• Хадгаламж /хугацаатай, хугацаагүй/<br>• Хадгаламжийн сертификат | • Хэрэглээний зээл<br>• Бизнесийн зээл<br>• Орон сууцны зээл<br>• Лизингийн зээл<br>• Төслийн зээл<br>• Тэтгэврийн зээл<br>• Малчны зээл | • Дотоодын карт<br>• Олон улсын карт<br>• Кредит карт<br>• АТМ |
| **Цахим банкны үйлчилгээ** | **Гадаад төлбөр тооцоо** | **Бусад санхүүгийн үйлчилгээ** |
| • Мобайл банк<br>• Интернэт банк<br>И-биллинг | • Гадаад гуйвуулга<br>• Вестэрн юнион<br>• Мониграм<br>• Харилцагч банкууд | • Даатгалын зуучлал<br>• Кастодиан<br>• Баталгаа, батлан даалт<br>• Санхүүгийн мэдээлэл, зөвлөгөө<br>• Үнэт зүйл хадгалах үйлчилгээ |

## Банкуудын зээл

Сүүлийн 5 жилийн хугацаанд арилжааны банкуудын нийт олгосон зээлийн хэмжээ 2017 оны жилийн эцэст 13.6 их наяд байснаас 2021 оны жилийн эцэст 20.7 их наяд төгрөг болж 52%, Зээлдэгчийн тоо 1 саяас 1.45 сая болж 43.1%-аар тус тус нэмэгдсэн байна.

*График 34. Банкны салбарын нийт зээлийн үлдэгдэл /тэрбум төгрөгөөр/*




Эх сурвалж: Монголбанк

Төрийн банк нь 2021 оны жилийн эцсийн байдлаар олгосон зээлийн хэмжээгээрээ арилжааны нийт 11 банкнаас дөрөвдүгээрт жагсаж, нийт зээлийн 11 хувийг олгосон байна.

*График 35. Арилжааны банкуудын зээл, цэвэр /тэрбум төгрөгөөр/*




*Эх сурвалж: Банкуудын санхүүгийн тайлан, 2021 он*

2021 оны байдлаар системийн нөлөө бүхий 5 банкны нийт зээлийн өсөлтийг задалж авч үзвэл Хаан банк 33.8%-аар, Төрийн Банк 27.5%-аар, Худалдаа Хөгжлийн Банк 11.7%-аар, Хас Банк 34.1%-аар, Голомт банк 10.2%-аар тус тус өссөн байна.

*График 36. Арилжааны банкуудын нийт зээлийн өсөлт (системийн нөлөө бүхий 5 банкны үзүүлэлт, системийн нөлөө бүхий 5 банкаар)*




*Эх сурвалж: Банкуудын санхүүгийн тайлан, 2021 он*

## Банкуудын харилцах, хадгаламж

Төрийн банк нь 2021 оны жилийн эцсийн байдлаар харилцах, хадгаламжийн хэмжээгээрээ арилжааны нийт 11 банкнаас дөрөвдүгээрт жагсаж байгаа бөгөөд банкны системийн хэмжээнд 28 орчим их наяд төгрөгийн харилцах, хадгаламжийн үлдэгдэлтэй байна.

*График 37. Арилжааны банкуудын харилцах, хадгаламж (тэрбум төгрөгөөр)*




*Эх сурвалж: Банкуудын санхүүгийн тайлан, 2021 он*

Харилцах, хадгаламжийн үзүүлэлтээр Хаан банк 9 орчим хувийн, Худалдаа Хөгжлийн банк 13 орчим хувийн, Голомт банк 3 орчим хувийн, Хас банк 11 орчим хувийн, Төрийн банк 6.7%-ийн өсөлттэй байна.

*График 38. Арилжааны банкуудын нийт харилцах, хадгаламжийн өсөлт (системийн нөлөө бүхий 5 банкны үзүүлэлт, системийн нөлөө бүхий 5 банкаар)*




*Эх сурвалж: Арилжааны банкуудын санхүүгийн тайлан*

## Банкуудын зах зээлд эзлэх хувь

Нийт активын хэмжээгээр банкны салбарын 32.9%-ийг Хаан банк, 23.3%-ийг Худалдаа Хөгжлийн Банк, 19.5%-ийг Голомт Банк, 9.3%-ийг Төрийн Банк, 8.5%-ийг Хас Банк үлдсэн 6.4%-ийг дээрхээс бусад банкууд эзэлж байна.

*График 39. Зах зээлд эзлэх хувь /сүүлийн 5 жилээр/*




*Эх сурвалж: Монголбанк*

## 2.2.4 БАНКУУДЫН АКТИВ, ПАССИВЫН ҮЗҮҮЛЭЛТ

Банкны салбарын нийт активын хэмжээ 2021 оны жилийн эцсээр 40.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 11.9%-аар буюу 4.3 их наяд төгрөгөөр өссөн байна.

*График 40. Арилжааны банкуудын хөрөнгийн хэмжээ /тэрбум төгрөгөөр/*




2020 оны мөн үетэй харьцуулахад зээл 3.4 их наяд төгрөгөөр, банкуудын эрсдэл багатай үнэт цаас дахь хөрөнгө оруулалт, тухайлбал, Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалт 0.9 их наяд төгрөгөөр өссөн бол банкны нөөц 0.4 их наяд төгрөгөөр өссөн байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор банкууд тэнцэл дэх эрсдэлээ бууруулан эрсдэл багатай үнэт цаас дахь хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх арга хэмжээ авснаар активын бүтэц өөрчлөгдөж, зээлийн багцын эзлэх хувь буурсан боловч Эдийн засгийг идэвхжүүлэх хөтөлбөрийн үр дүнд зээл олголт нэмэгдэж, банкуудын Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалтын өсөлтийн хурд саарч байна.

Банкуудын нийт активыг бүтцээр нь авч үзвэл 47% нь Зээл, 21% нь Төв банкны үнэт цаас, 11% нь Мөнгөн хөрөнгө, 4% нь Засгийн газрын үнэт цаас, үлдэх 17% нь бусад хөрөнгө байна.

СЗХ
2022 .09. 21
БҮРТГЭВ
№ 01



2022 -09- 14
БҮРТГЭВ-03

*График 41. Арилжааны банкуудын активын бүтэц /сүүлийн 5 жил, их наяд төгрөгөөр/*




*Эх сурвалж: Монголбанк*

Хурдацтай өсөлттэй байсан иргэдийн зээлийг хязгаарлах зорилгоор өрхийн өр-орлогын харьцаанд тогтоосон макро-зохистой бодлогын хязгаарлалтыг 2019 оны эхнээс мөрдүүлснээр тухайн жилдээ хэрэглээний зээлийн өсөлтийн хурд буурсан. Харин хэрэглээний зээлийн өсөлт 2020 оны эхнээс сөрөг утгатай болсон нь цар тахалтай холбоотойгоор тогтоосон хөл хорионы улмаас банкууд зээл олголтыг хязгаарласантай холбоотой байсан. 2021 оны 2 дугаар улирлаас хэрэгжсэн Эдийн засгийг идэвхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд зээл олголт нэмэгдсэнээр хэрэглээний зээлд өсөлт ажиглагдаж эхэлсэн.

2021 оны байдлаар нийт зээлийн 87.4% хувь буюу 17.6 их наяд төгрөгийн зээл хэвийн ангилалд, 4.6% буюу 0.9 их наяд төгрөгийн зээл анхаарал хандуулах ангилалд, 8.6% буюу 1.7 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд тус тус ангилагдсан байна.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

*График 42. Банкуудын чанаргүй зээлийн хувь /сүүлийн 5 жил, нийт зээлд эзлэх %-аар/*




*Эх сурвалж: Монголбанк*

Банкны салбарын нийт пассивыг бүтцээр нь авч үзвэл 70.0%-ийг харилцах, хадгаламж, 11.0%-ийг өөрийн хөрөнгө, үлдэх 20%-ийг бусад төрлийн эх үүсвэрүүд бүрдүүлж байна.

*График 43. Арилжааны банкуудын пассив хөрөнгийн бүтэц /сүүлийн 5 жилээр/*




*Эх сурвалж: Монголбанк*

2021 онд иргэд, аж ахуйн нэгж, төрийн байгууллагаас татсан харилцахын үлдэгдэл 40.1%-аар, бусад эх үүсвэр 12.9%-аар, иргэд, аж ахуйн нэгж, төрийн байгууллагын хадгаламж 5.2%-аар тус тус өссөн байна. Харилцах, хадгаламж нь системийн хувьд тогтвортой эх үүсвэрт тооцогддог бөгөөд түүний өсөлт нь банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон томоохон төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх чадварыг сайжруулж байна.

## 2.2.5 СИСТЕМИЙН НӨЛӨӨ БҮХИЙ БАНКУУД

### Системийн нөлөө бүхий банкуудын санхүүгийн тайлангийн харьцуулалт

2021 оны байдлаар системийн нөлөө бүхий 5 том арилжааны банк нь системийн нийт хөрөнгийн 93.6%-ийг, харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны 87.0%-ийг, нийт өр төлбөрийн 92.0%-ийг , цэвэр ашгийн 98.0%-ийг тус тус бүрдүүлж байна.

*Хүснэгт 17. Системийн нөлөө бүхий 5 банкны санхүүгийн тайлангийн үзүүлэлт /сая төгрөгөөр/*

| | Төрийн Банк | Хаан Банк | Голомт Банк | Худалдаа Хөгжлийн Банк | Хас Банк |
|---|---|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 817,604 | 4,526,980 | 972,298 | 976,352 | 462,545 |
| Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө | 199,392 | 809,082 | 1,056,448 | 504,418 | 42,487 |
| Хөрөнгө оруулалт | 385,834 | 912,159 | 1,997,913 | 2,602,647 | 1,003,003 |
| Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт | - | 302 | - | 506 | - |
| Зээл (цэвэр дүнгээр) | 2,237,147 | 6,589,299 | 3,339,175 | 4,588,465 | 1,791,558 |
| Дериватив санхүүгийн хөрөнгө | 759 | 27,087 | 208,917 | 101,647 | 49,223 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 647 | 10,087 | 106,953 | 200,052 | 64,206 |
| Бусад санхүүгийн бус хөрөнгө | 20,470 | 78,095 | 52,974 | 7,903 | - |
| Үндсэн хөрөнгө | 116,123 | 455,595 | 150,019 | 480,838 | 67,214 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 2,365 | - | 17,428 | 79,903 | 4,135 |
| Борлуулах зориулалттай хөрөнгө | 6,762 | - | 74,085 | 3,606 | 134 |
| Биет бус хөрөнгө | 5,631 | 54,765 | 17,849 | 2,334 | 15,453 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **3,792,734** | **13,463,449** | **7,994,058** | **9,548,672** | **3,499,959** |
| **ӨР ТӨЛБӨР** | | | | | |
| Харилцах | 658,270 | 3,084,764 | 1,802,918 | 2,288,775 | 1,792,877 |
| Хадгаламж | 2,187,565 | 7,126,687 | 3,660,626 | 3,931,122 | 461,914 |
| Банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр | 268,563 | 1,227,771 | 1,509,446 | 1,408,740 | 768,776 |
| Бусад эх үүсвэр | 264,539 | 620,803 | 238,695 | 350,144 | 8,404 |
| Дериватив | - | 320 | - | 78,036 | 371 |
| Бусад өр төлбөр | 25,314 | 118,594 | 123,711 | 471,745 | 83,622 |
| **Нийт өр төлбөрийн дүн** | **3,404,250** | **12,178,939** | **7,335,395** | **8,528,563** | **3,115,964** |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 178,000 | 172,098 | 194,739 | 323,810 | 100,000 |
| Нэмж төлөгдсөн капитал | - | - | 169,486 | 0 | 1,818 |
| Халаасны хувьцаа | - | - | (9,712) | - | - |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | 22,666 | 90,385 | - | 151,189 | 84,602 |
| Хуримтлагдсан ашиг, алдагдал | 181,116 | 1,018,134 | 242,436 | 486,155 | 197,575 |
| Бусад өөрийн хөрөнгө | 6,702 | 3,894 | 61,714 | 58,954 | - |
| **Өөрийн хөрөнгийн дүн** | **388,484** | **1,284,510** | **658,663** | **1,020,109** | **383,995** |
| **Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн** | **3,792,734** | **13,463,449** | **7,994,058** | **9,548,672** | **3,499,959** |

*Эх сурвалж: Банкуудын санхүүгийн аудитлагдсан тайлан, 2021 он*

СЭХ
2022.09.21
БҮРТГЭВ
2022-09-14
БҮРТГЭВ-03

## Системийн нөлөө бүхий банкуудын орлогын тайлан

Системийн банкуудын орлогын гол үзүүлэлт болох хүүгийн орлогын хэсгийг бүтцээр задалж үзвэл 71%-ийг зээлийн хүүгийн орлого, 24%-ийг үнэт цаасны хүүгийн орлого, 3%-ийг Монголбанканд байршуулсан хөрөнгийн хүүгийн орлого гэсэн үзүүлэлтүүд бүрдүүлдэг бөгөөд зардлын гол үзүүлэлт болох хүүгийн зардал хэсгийг бүтцээр задалж үзвэл 73%-ийг хадгаламжид төлсөн хүү, 15%-ийг зээлийн хүүгийн зардал, 5%-ийг үнэт цаасны хүүгийн зардал, 7%-ийг бусад зардлууд гэсэн үзүүлэлтүүд бүрдүүлж байна.

*Хүснэгт 18. Системийн нөлөө бүхий 5 банкны орлогын тайлангийн үзүүлэлт /сая төгрөгөөр/*

| | Төрийн Банк | Хаан Банк | Голомт Банк | Худалдаа Хөгжлийн Банк | Хас Банк |
|---|---|---|---|---|---|
| **ОРЛОГЫН ТАЙЛАН** | | | | | |
| **Хүүгийн орлого** | **385,474** | **1,178,769** | **554,778** | **597,107** | **332,086** |
| Монголбанканд байршуулсан хөрөнгийн | 4,718 | 236,117 | 8,343 | 5,018 | 3,236 |
| Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн | 228 | 2,187 | 21,179 | 2,347 | 340 |
| Үнэт цаасны | 76,265 | 53,007 | 90,178 | 182,751 | 71,182 |
| Зээлийн | 301,280 | 848,641 | 405,727 | 379,891 | 249,777 |
| Бусад хүүгийн орлого | 2,984 | 38,817 | 29,351 | 27,099 | 7,551 |
| **Хүүгийн зардал** | **190,641** | **544,192** | **272,819** | **405,637** | **174,330** |
| Харилцахад төлсөн хүү | - | - | - | 0 | - |
| Хадгаламжид төлсөн хүү | 170,883 | 452,519 | 219,370 | 260,185 | 107,416 |
| Зээлийн хүүгийн зардал | 2,443 | 45,930 | 43,690 | 116,374 | 46,494 |
| Үнэт цаасны хүүгийн зардал | 6,331 | - | - | 12,800 | 18,908 |
| Бусад хүүгийн зардал | 10,984 | 45,743 | 9,758 | 16,277 | 1,512 |
| Хүүгийн цэвэр орлого | 194,833 | 634,577 | 281,959 | 191,471 | 157,756 |
| Эрсдэлийн сангийн зардал | 31,595 | 64,707 | 35,770 | (57,706) | 2,046 |
| Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн | - | - | - | - | - |
| Үнэт цаасны | - | - | - | - | - |
| Зээлийн | - | - | - | - | - |
| Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого | 163,238 | 569,870 | 246,189 | 249,176 | 155,711 |
| Бусад орлого | 33,967 | 233,373 | 99,176 | 65,237 | 36,740 |
| Хүүгийн бус орлого | 33,182 | 212,086 | 68,505 | 65,237 | 36,740 |
| Арилжааны орлого | 3,757 | - | - | - | 6,195 |
| Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого | - | - | - | - | - |
| Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 29,054 | 212,086 | 62,493 | 65,237 | 26,944 |
| Бусад хүүгийн бус орлого | 372 | - | 6,012 | | 3,602 |
| Бусад орлого, олз | 785 | 21,287 | 30,671 | - | - |
| Бусад зардал | 136,190 | 416,684 | 292,794 | 193,874 | 89,983 |
| Хүүгийн бус зардал | 135,502 | 414,785 | 240,067 | 193,874 | 89,983 |
| Бусад эрсдэлийн сангийн зардал | 3,931 | 23,112 | 81,213 | | 2,526 |
| Арилжааны зардал | 50 | - | - | 13,406 | - |
| Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал | 953 | - | - | - | - |
| Хураамж шимтгэлийн зардал | 6,719 | 17,478 | 21,714 | 20,801 | 8,019 |

ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК 5341469
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ХХК

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ № 01

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны бусад зардал | 123,848 | 374,195 | 137,140 | 159,667 | 79,438 |
| Бусад зардал, гарз | 688 | 1,899 | 52,728 | - | - |
| **Татварын өмнөх ашиг, алдагдал** | **61,015** | **386,559** | **52,571** | **120,539** | **102,468** |
| Орлогын татварын зардал | 15,267 | 95,030 | 26,634 | 15,729 | 27,205 |
| **Татварын дараах ашиг, алдагдал** | **45,748** | **291,529** | **25,937** | **104,810** | **75,263** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | (5,025) | (16,037) | 2,876 | (5,057) | 3,000 |
| **Тайлант хугацааны татварын дараах нийт дэлгэрэнгүй орлогын дүн** | **40,722** | **275,492** | **28,813** | **99,754** | **78,263** |

*Эх сурвалж: Банкуудын санхүүгийн аудитлагдсан тайлан, 2021 он*

Банкны салбарын цэвэр ашгийн хэмжээ 2020 оны жилийн эцсээр 289.5 тэрбум төгрөг байсан бол 2021 оны эцсээр 548.6 тэрбум төгрөг болж өссөн байна.

Системийн нөлөө бүхий 5 банк нь хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийг ханган ажиллаж байна. Төрийн банкны хөрвөх чадварын харьцаа ялимгүй буурсан бол зээлийн олголт буурсантай холбоотойгоор бүх банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өндөр хэвээр байна.

*График 44. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт*




*Эх сурвалж: Арилжааны банкуудын санхүүгийн тайлан*

СЗХ
БҮРТГЭВ

## Системийн нөлөө бүхий банкуудын санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтэд гарсан өөрчлөлтүүд

2021 оны жилийн эцсээр хүүгийн цэвэр орлого Хаан банк 46.7%-аар, Голомт банк 38.0%-аар, Хас банк 44.9%-аар хувиар, Төрийн банк 45.6%-аар өссөн бол Худалдаа Хөгжлийн Банк 5.1%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Зээл цэвэр дүнгээр Хаан банк 34.9%-аар, Худалдаа Хөгжлийн Банк 11.7%-аар, Голомт банк 10.2%-аар, Хас банк 34.1%-аар, Төрийн банк 27.5%-аар тус тус өссөн байна.

2021 онд нийт хөрөнгийн хувьд Хаан банк 11.2%-аар, ХХБ 17.6 %-аар, Голомт банк 9.8-аар, Хас банк 7.9%-аар, Төрийн банк 8.9%-аар тус тус хувиар өссөн байна.

*Хүснэгт 19. Системийн нөлөө бүхий банкуудын санхүүгийн тайлангийн голлох үзүүлэлтэд гарсан өөрчлөлт (2021 он)*

| Голлох үзүүлэлт | Төрийн Банк | Хаан Банк | Худалдаа Хөгжлийн Банк | Голомт Банк | Хас Банк |
|---|---|---|---|---|---|
| Хүүгийн цэвэр орлого | 45.6% | 46.7% | -5.1% | 38.0% | 44.9% |
| Тайлант жилийн ашиг | 49.4% | 80.8% | 410.2% | 149.5% | 154.1% |
| Зээл /цэвэр/ | 27.5% | 33.8% | 11.7% | 10.2% | 34.1% |
| Хэвийн | 29.1% | 49.8% | 7.9% | 11.8% | 10.5% |
| Чанаргүй зээл | 21.3% | -7.1% | 49.6% | 1.2% | -17.9% |
| Нийт хөрөнгө | 8.9% | 11.2% | 17.6% | 9.8% | 7.9% |
| Харилцах, Хадгаламж | 6.7% | 9.0% | 12.8% | 3.4% | 11.2% |
| Өөрийн хөрөнгө | 11.7% | 4.5% | 0.3% | 4.3% | 38.8% |

*Эх сурвалж: Банкуудын санхүүгийн аудитлагдсан тайлан, 2021 он*

Нийт хөрөнгийн бүтцээр авч үзвэл нийт хөрөнгөд эзлэх цэвэр зээлийн хувь Хаан банк 49%, Худалдаа Хөгжлийн Банк 48%, Голомт Банк 42%, Хас Банк 51%, Төрийн Банк 59%-ийг эзэлж байна.

Банкны системийн найдвартай тасралтгүй ажиллагааг хангахын тулд Монголбанкнаас банкуудад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг мөрдүүлж хяналт тавьдаг. Системийн нөлөө бүхий 5 банкууд нь энэхүү харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллаж байна.

*Хүснэгт 20. Монголбанкнаас тавигддаг зохистой харьцааны шалгуур үзүүлэлт (2021 он)*

| | Төрийн Банк | Хаан Банк | Худалдаа Хөгжлийн Банк | Голомт Банк | Хас Банк |
|---|---|---|---|---|---|
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа >9% | 15.3% | 15.6% | 13.0% | 13.0% | 17.4% |

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 .09 .21
он сар өдөр
БҮРТГЭВ



2022 -09- 14
БҮРТГЭВ-03

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа >12% | 15.3% | 15.6% | 13.0% | 13.3% | 17.4% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт >25% | 31.7% | 46.9% | 40.6% | 41.3% | 44.3% |
| Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) <+-15% | 9.5% | -1.9% | -10.5% | 12.0% | -1.1% |
| Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт) <+-30% | 10.9% | -2.2% | -15.3% | 15.1% | -2.2% |

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183656

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК
ТТБ0674 5208173

СЗХ
2022 09 21
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ-03

## 2.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөллийг 2022 оноос 2024 оны дунд хугацааны бизнес төлөвлөгөө буюу дундаж давхаргыг дэмжихэд чиглэсэн зорилтын хүрээнд авч хэрэгжүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэлт болон бодлого, эдийн засгийн хэтийн төлөв байдал зэрэг хүчин зүйлсэд тулгуурлан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу боловсруулсан.

Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг гүйцэтгэхдээ Монголбанкны тайлагналын стандартын дагуу боловсруулсан учир санхүүгийн байдлын төсөөлөл үнэт цаас гаргагчийн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартаар бэлтгэсэн санхүүгийн байдлын төсөөллөөс бага зэрэг зөрүү үүссэн байгааг анхаарна уу.

*Хүснэгт 21. Санхүү байдлын тайлангийн төсөөлөл*

| Сая.төг | 2022F | 2023F | 2024F |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах | 353,963 | 479,238 | 508,213 |
| Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж | 50,000 | 50,000 | 50,000 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 2,463,063 | 2,674,950 | 2,960,229 |
| Санхүүгийн хөрөнгө оруулалт-борлуулахад бэлэн | 1,138,180 | 1,171,134 | 1,252,218 |
| Бусад хөрөнгө | 7,882 | 9,922 | 9,911 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 595 | 3,768 | - |
| Үндсэн хөрөнгө | 124,826 | 121,060 | 127,417 |
| Биет бус хөрөнгө | 5,729 | 5,845 | 5,963 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **4,144,239** | **4,515,917** | **4,913,950** |
| **ӨР ТӨЛБӨР** | | | |
| Бусад банк санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж | 348,986 | 450,789 | 469,832 |
| Репо хэлцэл | 87,201 | 76,193 | 110,193 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 3,108,399 | 3,358,592 | 3,625,896 |
| Зээлээр авсан санхүүжилт | 127,944 | 100,792 | 94,412 |
| Бусад өр төлбөр | 21,690 | 20,000 | 20,000 |
| Түрээсийн өглөг | 24 | 25 | 25 |
| **Нийт өр төлбөрийн дүн** | **3,694,244** | **4,006,392** | **4,320,359** |
| **ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | | | |
| Энгийн хувьцаа | 200,109 | 200,109 | 200,109 |
| Бусад нөөц | 22,666 | 22,666 | 22,666 |
| Хоёрдогч өглөг | 21,426 | 18,281 | 18,281 |
| Хуримтлагдсан ашиг | 205,793 | 268,469 | 352,535 |
| Нийт эздийн өмч | 449,994 | 509,525 | 593,591 |
| **Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн** | **4,144,239** | **4,515,917** | **4,913,950** |

*Эх сурвалж: "Төрийн банк" ХХК*

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

СЭХ он сар өдөр 2022 09 21 БҮРТГЭВ № 01

2022-09-14

## Нийт хөрөнгө

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө 2019-2021 онд жилд дунджаар 7.2%-ийн өсөлт үзүүлж байсан бол 2022 оноос 9%-ийн өсөлт үзүүлж, 2022 онд нийт хөрөнгө 4.1 их наядаас 2024 онд 4.9 их наяд болж өсөх төсөөлөлтэй байна. Нийт хөрөнгийн 59%-аас 60%-ийг цэвэр зээл, 26%-ийг хөрөнгө оруулалт, 1%-ийг банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, 10%-ийг бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах, үлдсэн 3%-ийг бусад хөрөнгүүд эзлэхээр байна.

*График 45. Нийт хөрөнгө ба түүний бүтэц (тэрбум төгрөг, хувиар)*




## Бэлэн мөнгө, Монголбанкан дахь харилцах ба банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө

Үнэт цаас гаргагчийн бэлэн мөнгө болон банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө 2022-2024 онуудад тогтвортой байхаар, Монголбанкны харилцах нийт хөрөнгөнд эзлэх түүхэн хугацааны хувийн жинг хадгалж байхаар төсөөлсөн байна.

### Хөрөнгө оруулалт

Үнэт цаас гаргагч 2017-2021 онуудад мөнгөн хөрөнгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, харилцагчдад олгосон зээлд байршуулаагүй үлдэгдэл хөрөнгийг хөрөнгө оруулалт хэлбэрээр байршуулж ирсэн бөгөөд цаашдын төсөөлөлд сул мөнгөн хөрөнгийг мөн эргэлтэд оруулж байхаар төсөөлж, нийт хөрөнгийн 26%-30%-ийг үнэт цаас хэлбэрээр байршуулахаар төлөвлөсөн байна. Эдгээр

ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
ТӨРИЙН БАНК
ГҮНДИЙН ҮЦК ХХК

үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын 77%-оос 80%-ийг түргэн борлогдох үнэт цаас эзлэхээр байна.

## Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

Үнэт цаас гаргагчийн дундаж давхаргыг дэмжих, жижиг дунд бизнесийг хөгжүүлэх, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн дунд хугацааны бизнес төлөвлөгөө болон эдийн засгийн өсөлтийн хүрээнд зах зээлд эзлэх байр сууриа тэлэх, өөрийн хөрөнгийн ашигт ажиллагааг сайжруулах, бүтээгдэхүүн үйлчилгээний үр ашиг, хүртээмжийг дээшлүүлэхтэй холбоотойгоор нийт зээл жилд дунджаар 2022 онд 2.5 их наяд төгрөгөөс 2024 онд 2.96 их наяд төгрөгт хүрч жилд дунджаар 10%-ийн өсөлт үзүүлж 2024 онд зах зээлд эзлэх зээлийн багцын хувь 12.8%-д хүрэх төлөвлөгөөтэй байна.

Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 2017-2021 онуудад дунджаар 10%-тай байсан бөгөөд зээлийн хяналтын тогтолцоог сайжруулах, зээлийн багцыг оновчтой болгох, тэдгээрийн чанарыг сайжруулахад чиглэсэн дунд хугацааны төлөвлөгөөний хүрээнд 2022 онд 9.2%, 2023 онд 9.0%, 2024 онд 8%-д хүргэж ажиллахаар төлөвлөсөн байна.

*График 46. Нийт зээл ба түүний бүтэц*




Үнэт цаас гаргагч нь активын чанарын удирдлагыг сайжруулах зорилгоор эрсдэлийн санг 2022 онд нийт чанаргүй зээлийн 87%-д, 2023 болон 2024 онуудад 90%-тай байгуулах төсөөлөлтэй байна.

*График 47. Зээлийн эрсдэлийн сан /тэрбум төгрөг, %-аар/*



СЗХ
2022 09 21
БҮРТГЭВ
№ 01

### Бусад хөрөнгө

Үнэт цаас гаргагчийн бусад хөрөнгөнд биет бус хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө зэрэг бага дүнтэй хөрөнгүүд болон үндсэн хөрөнгө буюу барилга, байшин, оффис, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл зэрэг хөрөнгүүдийг багтаасан. Үүнээс банкны ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг харьцангуй удаан хугацаанд ашиглагддаг үндсэн хөрөнгө 2021 онд 115.9 тэрбум төгрөг байсан бол 2024 онд 127.4 тэрбум төгрөг болж 10%-ийн өсөлттэй байх төлөвлөгөөтэй байна.

### Нийт эх үүсвэр

Үнэт цаас гаргагчийн нийт эх үүсвэрийн дүн 2021 онд 3.8 их наяд орчим төгрөг байсан бол 2022 оноос жилд 9%-ийн өсөлт үзүүлж 2024 онд 4.9 их наяд гаран төгрөг болох төсөөлөлтэй байна. 2019-2021 онуудад нийт эх үүсвэрийн 75%-аас 78%-ийг харилцагчдын харилцах, хадгаламж эзэлж байсан бол банкны нийт депозитийн зах зээлд эзлэх хувиа хадгалж, 2022 оноос 75%-ийг харилцагчдын харилцах хадгаламж, 2022-оос 2024 онуудад дунджаар 2%-ийг зээлээр авсан санхүүжилт, 9%-ийг дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж буюу банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, 4%-аас 5%-ийг энгийн хувьцаа, 5%-аас 7%-ийг хуримтлагдсан ашиг, үлдсэн 2%-аас 3%-ийг бусад эх үүсвэр ба өр төлбөрүүд эзлэх төсөөлөлтэй байна.

*График 48. Эх үүсвэрийн бүтэц ба өсөлтийн хувь /тэрбум төгрөг, хувиар/*




УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ он 2022 сар 09 өдөр 21 БҮРТГЭВ № 01

2022-09-14

## Харилцагчдын харилцах, хадгаламж

Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний нийт банкны депозитэд эзлэх байр сууриа хадгалах зорилтын хүрээнд Улаанбаатар болон Орон нутгуудын салбаруудад хэрэгжүүлэх бодлого, Монгол улсын эдийн засгийн цаашдын өсөлт, зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан харилцагчдын харилцах, хадгаламжийг нэмэгдүүлж, 2022-аас 2024 онуудад жилд дунджаар 8%-ийн өсөлт үзүүлж, 2024 онд 3.6 их наяд төгрөгийн харилцах, хадгаламж татан төвлөрүүлэхээр төсөөлөлтэй байна.

*График 49. Харилцагчдын хадгаламж ба өсөлтийн хувь /тэрбум төгрөг, хувиар/*




## Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр ба зээл

Үнэт цаас гаргагчийн банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр нь үнэт цаас гаргагчийн дунд хугацааны төлөвлөгөөний хүрээнд олон улсын зах зээлээс хямд эх үүсвэр татаж, банкны эх үүсвэрийн зардлыг бууруулах арга хэмжээг авч ажиллахтай холбогдуулан гадаадын банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн эх үүсвэр болон дотоодын банк санхүүгийн байгууллагаас татсан хадгаламжийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор 2022 онд 349.0 тэрбум төгрөгөөс 2024 онд 469.8 тэрбум болж өсөх төлөвлөгөөтэй байна.

УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ 2022 он 09 сар 21 өдөр БҮРТГЭВ

2022-09-14 БҮРТГЭВ-03

*График 50. Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр /тэрбум төгрөг, хувиар/*




## Нийт өөрийн хөрөнгө

Үнэт цаас гаргагчийн нийт эздийн өмч 2022-2024 онуудад жилд дунджаар 14%-ийн өсөлт үзүүлж, 2024 оны байдлаар 594 тэрбум төгрөгт хүрэхээр төсөөлөлтэй байна. Хуримтлагдсан ашгийн түвшин 2017-2021 онуудад жилд дунджаар 22%-ийн өсөлттэй байсан бөгөөд Бизнесийн дунд хугацааны төлөвлөгөөний дагуу ашигт ажиллагааг нэмэгдүүлснээр хуримтлагдсан ашиг өмнөх онтойгоо харьцуулахад 2022 онд 14%-аар, 2023 онд 30%, 2024 онд 31%-аар тус тус өсөх төсөөлөлтэй байна.

*График 51. Нийт өөрийн хөрөнгийн дүн ба бүтэц /тэрбум төгрөг, хувиар/*




УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
БУЛЛБАНК ҮЦК ХХК

## Орлогын тайлангийн төсөөлөл

*Хүснэгт 22. Орлогын тайлангийн төсөөлөл*

| Сая.төг | 2022F | 2023F | 2024F |
|---|---|---|---|
| Үр ашигт хүүгийн аргачлалаар бодсон хүүгийн орлого | 411,556 | 488,633 | 514,209 |
| Хүү болон түүнтэй адилтгах зардал | -220,186 | -251,519 | -266,992 |
| **Цэвэр хүүгийн орлого** | **191,370** | **237,114** | **247,217** |
| Хураамж, шимтгэлийн орлого | 30,104 | 33,115 | 38,082 |
| Хураамж ба шимтгэлийн зардал | -2,032 | -2,000 | -2,000 |
| **Хураамж ба шимтгэлийн орлого** | **28,072** | **31,115** | **36,082** |
| Арилжааны цэвэр орлого | 2,996 | 3,000 | 3,000 |
| Үйл ажиллагааны бусад орлого(зардал) | 1,134 | 1,100 | 1,100 |
| **Үйл ажиллагааны орлого** | **223,573** | **272,329** | **287,399** |
| Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан | -15,311 | -19,102 | 6,201 |
| **Үйл ажиллагааны цэвэр орлого** | **208,262** | **253,227** | **293,600** |
| Үйл ажиллагааны зардал | -164,951 | -173,158 | -184,099 |
| **Татварын өмнөх ашиг** | **43,311** | **80,069** | **109,501** |
| Орлогын албан татварын зардал | -10,909 | -17,398 | -25,434 |
| **Тайлант жилийн ашиг** | **32,402** | **62,671** | **84,066** |

*Эх сурвалж: "Төрийн банк" ХХК*

*График 52. Үйл ажиллагааны орлого зарлага /тэрбум төгрөг, хувиар/*



СЗХ
2022 .08сар21. өдөр
БҮРТГЭВ
№ 01

ТӨРИЙН БАНК
ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

# ГУРАВ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА 2022

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-14

## 3.1 ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагч нь хувьцааны нэмж гаргаж буй 5 хувь буюу нийт 37,475,000 ширхэг хувьцааг хөрөнгө оруулагчдад амжилттай борлуулсан тохиолдолд анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсон гэж үзнэ.

*Хүснэгт 23. Үнэт цаасны товч танилцуулга*

| Үнэт цаас гаргагч | “ТӨРИЙН БАНК” ХХК |
|---|---|
| Үнэт цаасны төрөл | Энгийн хувьцаа |
| Нийт гаргасан хувьцааны тоо ширхэг | 712,000,000 ширхэг |
| Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ | 250 ₮ |
| Нэмж гаргах хувь | 5.0 хувь |
| Нэмж гаргах хувьцааны тоо ширхэг | 37,475,000 ширхэг |
| • Стратегийн хөрөнгө оруулагчид санал болгох | 70 хувь |
| • Жижиглэн хөрөнгө оруулагчид санал болгох | 30 хувь |
| Нэмж гаргасны дараах хувьцааны тоо ширхэг | 749,475,000 ширхэг |
| Анхдагч зах зээлд санал болгох үнэ | 590 ₮ |
| Татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ | 22,110,250,000 ₮ |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт | Байгаль орчин, нийгэм, засаглалын зарчимд нийцсэн, Дундаж давхаргыг дэмжсэн зээлийн санхүүжилт |
| Арилжаалах арга хэлбэр | Тогтоосон үнийн арга |

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

СЗХ
он 2022 сар 09 21 өдөр
БҮРТГЭВ

2022-09-14
БҮРТГЭВ

## 3.2 ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Төрийн Банк нь олон нийтээс татан төвлөрүүлж буй хөрөнгөө банкны үндсэн үйл ажиллагааг дэмжих, үүн дотроо Байгаль орчин, нийгэм, засаглалын зарчимд нийцсэн болон Дундаж давхаргыг дэмжсэн зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, зах зээлд нэвтрүүлэхэд 100 хувь зарцуулах төлөвлөгөөтэй байна. Үүнд:

- Байгаль орчин, нийгэм, засаглалын зарчимд нийцсэн зээлийн бүтээгдэхүүн - 50 хувь
- Дундаж давхаргыг дэмжсэн зээлийн бүтээгдэхүүн - 50 хувь
  Ингэхдээ төр засгаас явуулж буй бодлого шийдвэрүүдэд нийцүүлэн УБ хотын төвлөрлийг бууруулах, орон нутгийн иргэд, жижиг дунд аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх чиглэлийг баримталж нийт зээлийн санхүүжилтийн 60-70 хувийг орон нутгийн салбар нэгжүүдээрээ дамжуулан хүргэхээр төлөвлөж байна.

## 3.3 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Үнэт цаас гаргагчийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ.

1. Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах шийдвэр гаргах үед ТУЗ-өөс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч хуралд оролцож, хэлэлцэж буй асуудлаар өөрийн эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;
2. ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн бол эзэмшиж буй хувьцаанд оногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль журамд заасан хугацаандаа олгохгүй бол алданги төлөхийг шаардах;
3. Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу, тогтоосон журмын дагуу үндсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
4. Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу тэргүүн ээлжинд худалдан авах;
5. Дор дурдсан асуудлаар гаргасан хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувь эзэмшигч бүр өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрхтэй. Үүнд:

5.1 Нийлэх, нэгдэх, хуваах, болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгон өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах болсон бол;

5.2 Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
21031195 СТС2420

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382

ГҮҮДСЕК
ТТБ8674 5208173

дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргасан зэргээр их хэмжээний хэлцэл хийсэн бол;

5.3.Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан бол;

5.4.Хувьцаа эзэмшигч дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.

6. Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшиж буй этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д санал хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал зарлагдсан үед хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг шаардан гаргуулах;
7. Хувьцаа эзэмшигч нь улирал бүр компанийн санхүүгийн тайлантай танилцах эрхтэй.
8. Хууль тогтоомж болон компанийн дүрмээр тогтоосон бусад эрх.

Үнэт цаас гаргагчийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах үүрэг хүлээнэ.

1. Компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин суугаа хаяг болон өөрийн эзэмшилдээ байгаа үнэт цаасны тоо, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар бүртгэл хөтлөх этгээдэд зохих журмын дагуу мэдэгдэх.
2. Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны хэмжээ нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байна.
3. Нийт гаргасан хувьцааны 5-с дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшсэн бол өмчлөх эрх үүссэнээс ажлын 3 хоногийн дотор компанид бичгээр мэдэгдэнэ.
4. Компанийн тухай хуулийн 9 дүгээр бүлгийн 9.4, 9.5 дахь хэсэгт заасанаас бусад тохиолдолд өөрийн эзэмшлийн хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
5. Хувьцаа эзэмшигч нь компанийн нэрийг хувийн ашиг сонирхолд ашиглах, компанийн ажил хэргийн нэр хүнд, өмч хөрөнгөнд гэм хор учруулж болзошгүй үйлдэл хийхийг хориглоно.
6. Хууль тогтоомж болон компанийн дүрмээр тогтоосон бусад үүрэг.

## 3.4 ХУВЬЦААГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Андеррайтер нь хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг МХБ-тэй Анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах гэрээ байгуулан явуулах ба үнэт цаасыг МХБ-ийн "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын 4 дүгээр бүлэгт заасан "ТОГТООСОН ҮНИЙН АРГА"-ыг ашиглан нийтэд нээлттэй арилжаална.

Тогтоосон үнийн аргаар хийх арилжаа нь МХБ-ийн "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын 3.1.3-т заасaнаар үнэт цаас гаргагчийн тогтоосон тодорхой үнээр санал болгон арилжих үйл ажиллагааг хэлэх бөгөөд Үнэт цаас гаргагч нь хувьцааг анхдагч зах зээлд санал болгох үнийг дараах байдлаар тогтоосон.

| *Хөрөнгө оруулагчид* | Нэмж гаргах хувьцаанаас санал болгох | Санал болгох хувьцааны тоо | Санал болгох үнэ (төгрөг) | Татан төвлөрүүлэх хөрөнгө |
|---|---|---|---|---|
| *Стратегийн* | ≤70% | ≤26,232,500 | ₮590 | ≤15,477,175,000 |
| *Жижиглэн* | ≥30% | ≥11,242,500 | ₮590 | ≥6,633,075,000 |
| *Нийт* | 100% | 37,475,000 | ₮590 | 22,110,250,000 |

"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 56.6-т заасны дагуу Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.5-д заасан улс төрд нөлөө бүхий этгээд, түүний хамаарал бүхий этгээд биржээр арилжаалах төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг эзэмшихийг хориглоно.

Стратегийн хөрөнгө оруулагч гэдэг нь Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.4 дэх хэсэгт "Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд давуу талыг бий болгох, үнэт цаасаа 6 сараас доошгүй хугацаанд тусгаарлуулах үүрэгтэй хөрөнгө оруулагчийг стратегийн хөрөнгө оруулагч гэж ойлгох бөгөөд үнэт цаасны танилцуулгад өөрөөр тусгаагүй бол андеррайтер нь үнэт цаас гаргагчтай зөвшилцсөний үндсэн дээр олон нийтэд санал болгож буй хувьцааны 50 хүртэл хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад хуваарилж болно. Тухайн хөрөнгө оруулагчийг стратегийн хөрөнгө оруулагч гэж үзсэн тайлбараа хөрөнгийн бирж болон олон нийтэд мэдээлнэ." гэж заасныг үндэслэн дараах шаардлагыг зэрэг хангасан хөрөнгө оруулагчийг ойлгоно. Үүнд:

1. 50.0 сая төгрөг болон түүнээс дээш дүнгээр хөрөнгө оруулсан;
2. Хувьцаагаа 6 сарын хугацаанд тусгаарлуулах үүрэг хүлээж, хүлээн зөвшөөрсөн;

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ №01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 2022-09-14 БҮРТГЭВ-03

Анхдагч зах зээлийн захиалгыг биелүүлэх үйл ажиллагаа:

- Стратегийн хөрөнгө оруулагчийн хувьцааны захиалгыг биелүүлэхдээ СЗХ-оос 2021 оны 06 сарын 11-ний өдрийн 225 тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 7.2 болон 7.14-дүгээр хэсэгт тус тус үндэслэн захиалгыг биелүүлнэ.
- Бусад хөрөнгө оруулагчдын /жижиглэн/ хувьд МХБ-н "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын 10.1 дэх хэсгийн дагуу "Харилцагч худалдан авах захиалгыг зөвхөн тогтоосон үнээр өгөх бөгөөд энэ аргыг ашиглах үед үнийн болон цаг хугацааны ахлах дараалал үйлчлэхгүй" гэж заасныг мөрдөнө.

СЗХ-ны үнэт цаасны бүртгэлийн журмын 7.20-д зааснаар анхдагч зах зээлд хувьцааны захиалгын эрэлтийн хэмжээ нь нийлүүлэлтийн хэмжээнээс давсан тохиолдолд андеррайтер, үнэт цаас гаргагч тохиролцсоны үндсэн дээр нийтэд гаргасан хувьцааны 15.0 хүртэлх хувийг нэмж гаргаж болно гэж заасан байдаг бөгөөд үнэт цаас гаргагч андеррайтер зөвшилцөн 15.0 хүртэлх хувийг нэмж гаргахаар шийдвэрлэсэн. Түүнээс давсан тохиолдолд хувь тэнцүүлэх аргыг ашиглан үнэт цаасны хуваарилалтыг хийнэ. Энэхүү хувь тэнцүүлэх коэффициентыг олохдоо дараах томьёог ашиглана. Үүнд:

$K = C1/C2$

K- Хувь тэнцүүлэх коэффициент

C1 - Арилжихаар санал болгож буй нийт үнэт цаасны тоо

C2 - Худалдан авах захиалгад багтсан нийт үнэт цаасны тоо

Худалдан авах захиалга тус бүрийг хувь тэнцүүлэх коэффициентээр үржүүлж, харилцагч бүрд оногдох үнэт цаасны тоог гаргана. Хувь тэнцүүлэх коэффициентоор үржүүлж гарсан тооны бутархай орон нь 0.5-аас дээш бол 1 бүхэл нэгжид, 0.5-аас доош бол 0 нэгжид шилжүүлэн тооцно.

Бутархай оронг бүхэл тоонд шилжүүлсний дараа хуваарилалт хийгдсэн нийт хувьцааны тоо арилжихаар санал болгож буй хувьцааны тооноос илүү гарсан тохиолдолд хамгийн олон ширхэг хувьцаа авах захиалга өгсөн харилцагчдын үнэт цаасны тооноос тус бүр нэг ширхгийг хасах зарчмаар арилжихаар санал болгож буй тоотой тэнцүүлнэ.

**Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах хуваарь**

1. Бүртгэл – МХБ болон СЗХ-нд хүсэлт явуулах зөвшөөрөл авах
2. Танилцуулга – Олон нийтэд мэдээлэл өгөх, танилцуулга
3. Захиалга – Анхдагч зах зээлийн захиалга авах захиалгын сан бүрдүүлэх
4. Арилжаа – Захиалгыг эхлүүлэх хувьцааг зах зээлд нийлүүлэх
5. Төлбөр тооцоо – Журмын дагуу төлбөр тооцоог гүйцэтгэх

Анхдагч зах зээлийн арилжааны биелэлтэд хүлээх андеррайтерийн үүрэг:

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК

СЗХ
2022 .09. 21 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

Үндсэн андеррайтер болон Туслах андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн хувьцааг олон нийтэд анх удаа санал болгон гаргах үнэт цааснаас арилжаалагдаагүй үлдсэн хэсгийг бүхэлд нь нийтэд санал болгосон үнээр худалдан авах үүрэг хүлээсэн бөгөөд энэхүү нөхцөл байдалд хэрхэн санхүүжилтийн эх үүсвэрээ шийдэх талаар төлөвлөгөө гаргасан болно.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

## 3.5 ҮНЭ ТОГТВОРЖУУЛАХ ХӨТӨЛБӨР

Үндсэн андеррайтер “Өлзий энд Ко капитал ҮЦК” ХХК болон Туслах андеррайтер “Гүүдсек ҮЦК” ХХК нь үнэт цаас гаргагчийн гаргасан нийт энгийн хувьцааг хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны үнийн хэт өсөлт, бууралтаас хамгаалах, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах зорилгоор хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд Үндсэн андеррайтер болон Туслах андеррайтер нь Монголын хөрөнгийн бирж дээр Үнэт цаас гаргагчийн хувьцааг хоёрдогч зах зээлийн арилжаанаас эргүүлэн худалдаж авах буюу хувьцааны үнийг тогтворжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр Үнэт цаас гаргачтай гэрээ байгуулсан.

Тус хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааг дараах нөхцөлтэйгээр явуулах бөгөөд Хөтөлбөрийг Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 сарын 11-ний өдрийн 225 тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 8 дугаар зүйлд заасан зохицуулалтын хүрээнд хэрэгжүүлнэ.

Үнэт цаас гаргагчийн хувьцааг хоёрдогч зах зээлийн арилжаанаас эргүүлэн худалдан авах нөхцөл:

| | Нөхцөл | Хязгаарлалт |
|---|---|---|
| 1.1 | Эргүүлэн худалдаж авах хувьцааны үнийн дүн | 600,000,000 (зургаан зуун сая) төгрөгийн үнийн дүнгээр худалдан авах ажиллагааг хэрэгжүүлнэ. |
| 1.2 | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа | Хөтөлбөрийн үйл ажиллагааг хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 1 сарын хугацаанд гүйцэтгэнэ. |
| 1.3 | Хувьцааг эргүүлэн худалдаж авах хөтөлбөрийн бэлтгэл | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа эхлэхээс ажлын 1 хоногийн өмнө хувьцааг худалдан авах мөнгөн хөрөнгийг өөрийн арилжаа хийх дансанд байршуулна. |
| 1.4 | Эргүүлэн худалдаж авах ажиллагааны эх үүсвэр бүрдүүлэлт | Үнийн дүнг Үндсэн андеррайтер, Туслах андеррайтер нар 50/50 хувиар тооцон хувааж тус бүрийн нэрийн хувьцааны арилжааны дансанд байршуулна. |
| 1.5 | Арилжааны худалдан авах үнийн дүнгийн дээд хэмжээ | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд гэрээнд заасан үнийн дүнгээс хэтэрсэн тохиолдолд үнийн дүнг нэмж байршуулах замаар хөтөлбөрийг үргэлжлүүлнэ. |
| 1.6 | Зах зээлийг урвуулан ашиглах тухай | Хувьцааны үнийг тогтворжуулах нэрийн дор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасан хэлбэрээр зах зээлийг урвуулан ашиглахгүй. |

Түүнчлэн Андеррайтер, зах зээл үүсгэгч нь үнэт цаас гаргагчийн хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагаа дууссан өдрөөс хойш тогтворжуулалтын чиглэлээр хийсэн гүйлгээний тайланг ажлын 3 өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 8.4-т заасан мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

СЗХ 2022 он 03 сар 21 өдөр БҮРТГЭВ № 01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2022 -09- 14 БҮРТГЭВ

## 3.6 ХУВЬЦАА ХУДАЛДАН АВАХ ЗААВАР

1. Монгол улсад бүртгэлтэй үнэт цаасны компанид үнэт цаасны данс нээлгэх
2. Өөрийн хүссэн банкаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх өөрийн нэр дээрх дансандаа хувьцаа худалдан авах мөнгөө байршуулах

| | |
|---|---|
| *Хүлээн авагч банк:* | Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв |
| *Хүлээн авагчийн нэр:* | Овог, нэр |
| *Дансны дугаар:* | 12 орон бүхий үнэт цаасны дансны дугаар (ҮЦК-аас лавлах) |
| *Үнийн дүн:* | Хувьцааны үнэ + шимтгэл |
| *Гүйлгээний утга:* | *Хувьцааны мөнгө (Овог, нэр, регистрийн дугаар)* |

3. Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хувьцаа худалдан авах захиалга өгнө.

Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай хаагдсанаар хөрөнгө оруулагчийн нэр дээр хувьцаа шилжинэ.

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 СТС2420

УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК 534146 ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ТТБ0674 5208173

СЗХ
он сар өдөр
2022 09 21
БҮРТГЭВ
№ 01

ТӨРИЙН БАНК
ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

# ДӨРӨВ. ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН ДҮГНЭЛТ

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА 2022

СЗХ
он 2022 сар 08 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ТӨРИЙН БАНК
2022-08-14
БҮРТГЭВ-03

## 4.1 ХУУЛИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ

| “ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС” ХХН | |
|---|---|
| УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААР | 9022001010 |
| РЕГИСТРИЙН ДУГААР | 5495997 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ | Өмгөөлөл, хууль зүйн зөвлөх үйлчилгээ |
| И-МЭЙЛ | info@mdsa.mn |
| УТАС | +976 – 11 - 330048 |
| ВЕБ ХУУДАС | www.mdsa.mn |
| ХАЯГ | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай гудамж, Сентрал Тауэр, 13 давхар, 1301 тоот |
| **“БАТБАЯР ЭНД ПАРТНЕРС” ХХН** | |
| УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААР | 9022001074 |
| РЕГИСТРИЙН ДУГААР | 5722292 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ | Хууль зүйн зөвлөгөө өгөх |
| И-МЭЙЛ | contact@bnp.mn |
| УТАС | +976 - 77119009 |
| ВЕБ ХУУДАС | www.bnp.mn |
| ХАЯГ | Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө хааны нэрэмжит талбай гудамж, Монгол ТВ цамхаг 10 давхар |

“Өмгөөллийн Эм Ди Эс энд ХаанЛекс” ХХН нь Монгол Улсын томоохон хуулийн фирмүүдийн нэг бөгөөд “Илүү сайн үйлчилгээ үзүүлэх” зорилготойгоор 2011 онд байгуулагдсан цагаасаа хойш гадаад, дотоодын бизнесийн байгууллагуудад дэлхийн стандартад нийцсэн хууль зүйн үйлчилгээг дотоодын туршлага, ур чадвартай хослуулан хүргэдэг.

“Өмгөөллийн Эм Ди Эс энд ХаанЛекс” ХХН нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3.2.1-д заасан үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр бүртгэгдсэн /СЗХ-ны 2016 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 42 тоот тогтоолын дагуу/, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд бөгөөд тус зах зээл дээр хөрөнгө босгож буй компаниудтай хамтран ажиллаж байсан арвин туршлагатай. Тухайлбал, Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Монгол, Хонг Конг, Лондонгийн хөрөнгийн бирж дээр хувьцааг нийтэд анх удаа санал болгох “Wolf” төслийн Монголын хууль тогтоомжтой холбоотой зөвлөгөөг өгөх, эрх зүйн магадлан шалгалт хийх, хууль

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183855
9022031195 СТС2420
ТӨРИЙН БАНК
5341459 ГСТ5382
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТБ3674 5203173

зүйн дүгнэлтийн төсөл боловсруулах; Монгол Улсын Хөрөнгийн Бирж дээр гаргасан анхны 100 хувь даатгагдсан Эрчим бонд гаргах ажилд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хууль зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлт гаргах; ЛэндМН ББСБ ХК-ийн IPO, 2 удаа бонд гаргаж олон нийтэд санал болгох төсөл; Инвескор ББСБ ХК-ийн IPO, бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган олон нийтэд санал болгох, нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох төслүүд, биржийн бус зах зээлд компанийн өрийн хэрэгсэл гаргах төсөл; Түмэн шувуут ХК-ийн IPO гаргах төсөл; Хөвсгөл Алтандуулга ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах төсөл; Сүү ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах төсөл; Монголын Ипотекийн Корпораци ХХК-ийн 1-13, 21, 23, 24, 28, 29 дэх орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах төсөл дээр хууль зүйн судалгаа шинжилгээ хийж, хууль зүйн дүгнэлт гаргах зэрэг ажлуудыг тус тус гүйцэтгэсэн туршлагатай.

Хуульч, хуулийн фирмүүдийн чансаа тогтоодог AsiaLaw сэтгүүл Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс ХХН-ийг "2021 оны Монгол улсын шилдэг хуулийн фирм"-ээр шалгаруулсан бөгөөд тус фирмийн хөрөнгийн зах зээлд үзүүлсэн үйлчилгээг онцлон тэмдэглэсэн байна.

"Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс" ХХН /"Хуулийн фирм"/ нь 2013 оны 6 дугаар сарын 18-ны өдөр улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн мэргэшсэн бизнесийн хуулийн фирм юм. Тус Хуулийн фирм нь концесс, төр хувийн хэвшлийн түншлэл (дэд бүтэц - төмөр зам, авто зам, угаах үйлдвэр, барилга, эрчим хүчний салбар), бизнес, компанийн хууль, эрх зүйн түгээмэл тохиолддог асуудлуудаар аж ахуй нэгж, бизнес эрхлэгч, компаниудад хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд уул уурхай, барилга, ашигт малтмал, санхүүгийн салбарт мэргэшсэн туршлагатай.

Хуулийн фирм нь үнэт цаасны зах зээлийн оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны №72 тоот тогтоолын дагуу авсан бөгөөд үнэт цаасны зах зээлийн оролцогчдод хууль зүйн туслалцаа, хөндлөнгийн дүгнэлт гаргаж өгөх үйлчилгээ үзүүлэх эрхтэй, гадаад, дотоодын хөрөнгийн биржид хувьцаа, өрийн бичиг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахад үнэт цаасны зах зээлийн бүхий л үе шатанд ажиллаж байсан туршлагатай.

Тухайлбал Симпл Ассет ТЗК-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж нийтэд санал болгох, Монголын Ипотекийн Корпораци ОССК ХХК-ийн олон улсын хөрөнгийн зах зээл 250 сая ам.доллар болон 300 сая ам.долларын өрийн хэрэгсэл буюу бонд гаргах, Канад Улсын Торонтогийн хөрөнгийн бирж /TSX/ дээр арилжаалагдаж буй хувьцааг Монгол Улсын нэр бүхий арилжааны банк барьцаалахтай холбоотой барьцааны гэрээ байгуулах, барьцааг гадаад улсын хууль тогтоомжийн дагуу бүртгүүлэх, хуулийн хүчин төгөлдөр байдлыг хангуулах төсөл, Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьцааг дотоодын хөрөнгийн зах зээлийн арилжаа эрхлэх, зохицуулагч байгууллагын бүртгэлд бүртгүүлэх, 2 их наяд төгрөг хүртэлх өрийн хэрэгсэл буюу бонд гаргах, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хэлбэрийг өөрчлөх замаар анх удаа нийтэд санал болгон

СЗХ
2022 09 21 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



үнэт цаас гаргах, Монголын даатгалын салбарт анхдагч IPO болох Мандал даатгал ХХК-ийн хэлбэрийг өөрчлөх замаар анх удаа нийтэд санал болгон үнэт цаас гаргах, Монгол Улсын анхны финтек компани МОСТ Финтек ХХК-ийн хэлбэрийг өөрчлөх замаар анх удаа нийтэд санал болгон үнэт цаас гаргах, тусгай зориулалтын компанид АПУ ХК-ийг нэгтгэх, АПУ ХК-иас нэмж хувьцаа гаргах замаар нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдсэн үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах, Улаанбаатар БҮК ХК-аас хувьцаа нэмж гаргах, өрийг хувьцаагаар сольж, үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах, Монголын Ипотекийн Корпораци ХХК-ийн ипотекийн зээлээр баталгаажсан бонд гаргах, тусгай зориулалтын компаниар дамжуулан үнэт цаас гаргах 2-8, 11, 12, 15, 16, 17, 22, 25, 26 дугаар ээлжийн хэлцэлд хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийх, хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, үнэт цаас гаргах зэрэг ажилд хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийх, хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлж ажилласан туршлагатай.

Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг:

Энэхүү гэрээний зорилго нь Үнэт цаас гаргагч үнэт цаас гаргахтай холбоотой үйл ажиллагаанд хуулийн зөвлөх нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл үнэн зөв, хуульд нийцсэн эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргах, үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэхтэй холбогдсон асуудлаар хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

- Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхтэй холбоотойгоор тухай бүр шаардлагатай мэдээ мэдээлэл, баримт бичгийг үнэт цаас гаргагчаас шаардан авах эрхтэй.

- Хуулийн зөвлөх нь гаргасан хөндлөнгийн шинжилгээний тайлан, хуулийн дүгнэлттэй холбогдуулан шаардлагатай тохиолдолд зөвлөмж гаргах, шалгасан материалын хүрээнд тодруулга өгөх, танилцуулга хийх үүрэгтэй.

- Хуулийн зөвлөх нь гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэхдээ үнэн бодит мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлсэн талаар бүртгэл хөтлөх, дүгнэлт гаргах, үнэт цаас гаргагчийн нууцыг хадгалах үүрэгтэй.

- Үнэт цаас гаргагч нь Хуулийн зөвлөхөд Зөвлөх үйлчилгээтэй холбоотой байж болох аливаа бүх мэдээллийг бүрэн бөгөөд үнэн зөвөөр өгөх үүрэгтэй.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

## 4.2 ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ

| МӨНХ-ОРГИЛ ТРЕЙД ХХК | |
|---|---|
| **УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААР** | 9011106018 |
| **РЕГИСТРИЙН ДУГААР** | 2041537 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ** | • Хөрөнгийн үнэлгээ,<br>• Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ,<br>• Бизнесийн зөвлөх үйлчилгээ |
| **И-МЭЙЛ** | bestcon6@gmail.com |
| **УТАС** | 976-70123256 |
| **ХАЯГ** | Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, МҮЭ-ийн Холбооны байр, 201 тоот |

Мөнх-Оргил трейд ХХК нь анх 1996 онд Монгол Улсын “Компанийн тухай” хуулийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.

Мөнх-Оргил трейд ХХК нь 1998 оноос эхлэн хөрөнгийн үнэлгээний чиглэлээр тасралтгүй, тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооноос тавигддаг шаардлагуудыг хангаж, 2013 оноос Монгол Улсын Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний үйлчилгээ үзүүлж байна.

Мөнх-Оргил трейд ХХК нь газар, барилга, үл хөдлөх хөрөнгө, уул уурхай, хөдөө аж ахуй, газар тариалан, харилцаа холбоо, тээвэр, авто зам, эрчим хүчний салбарт бизнесийн болон хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлж ирсэн туршлагатай. Бодь групп, Бодь интернэйшнл, Голомт банк, Алтай групп, ДЦС-4 ТӨХК, Монгол базальт ХК зэрэг томоохон компани, бизнесийн нэгжүүд болон түүний охин, хамаарал бүхий компаниудын бизнесийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

Сүүлийн жилүүдэд тус компани нь Хөшигийн хөндийн Олон Улсын Шинэ Нисэх Буудлын нийт үндсэн хөрөнгийн үнэлгээг санхүүгийн тайлагналын зориулалтаар /2019 он/, “Цэцэнс майнинг энд Энержи” ХХК-ийн бизнесийн үнэлгээ, Нүүрсний уурхайд түшиглэсэн 600мВ цахилгаан станцын “Бөөрөлжүүт” төслийн үнэлгээ /2019/, “ДЦС-2” ТӨХК-ийн нийт үндсэн хөрөнгийн үнэлгээг санхүүгийн тайлагналын зориулалтаар /2020 он/, “Монголросцветмет” ТӨҮГ-ын нийт үндсэн хөрөнгийн үнэлгээг санхүүгийн тайлагналын зориулалтаар /2020 он/, “Хөгжлийн банк”-ны зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээний ажил /2019, 2021 он/, “Эрдэнэс сольюшинс” ХХК, “Хархорин пропертис” ХК-уудын бизнесийн үнэлгээг бизнесийн нэгдэлтийн зориулалтаар /2020 он/, “Бодь групп”-ийн охин компаниуд “Инкон” ХХК, “Өндөр Улаан тревел” ХХК, “Грийнстит гарден” ХХК, “Ред рок катеринг” зэрэг

СЗХ 2022 он 03 сар 21 өдөр БҮРТГЭВ №01

компаниудыг бизнесийн үнэлгээг хөрөнгө оруулалтын зориулалтаар /2021 он/, "Эрхэт Монгол групп" ХХК-тай хийсэн гэрээний хүрээнд "Мегавууд" ХХК-ийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ, "Хонхор Барилгын материалын худалдаа, үйлдвэрлэл, технологийн парк" төслийн үнэлгээ зэрэг зөвлөх үйлчилгээний ажлуудыг амжилттай хийсэн.

Мөнх-Оргил трейд ХХК-ний үндсэн үнэлгээчдийн мэдээлэл

*Хүснэгт 24. Үнэлгээчдийн мэдээлэл*

| Тусгай зөвшөөрөл эзэмшигч | Тусгай зөвшөөрөл олгосон байгууллага | Тусгай зөвшөөрлийн нэр, дугаар, олгосон огноо | Тусгай зөвшөөрлийн сунгалт | Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа | Үнэт цаасны зах зээлийн сургалтад хамрагдсан он |
|---|---|---|---|---|---|
| Б.Эрдэнэбаатар /Тэргүүлэх үнэлгээчин/ | Сангийн яам | 1. Хөрөнгийн үнэлгээ хийх, 07120004, 2010.12.20 | 2013, 2017, 2019 онуудад сунгуулсан | 2022.12.17 | 2021 |
| Ч.Дарамбазар /Тэргүүлэх үнэлгээчин/ | Сангийн яам | 2. Хөрөнгийн үнэлгээ хийх, 071200078, 2010.12.20 | 2013, 2017, 2019 онуудад сунгуулсан | 2022.12.17 | 2020 |
| Ц.Сэржээ /Тэргүүлэх үнэлгээчин/ | Сангийн яам | 3. Хөрөнгийн үнэлгээ хийх, 071200016, 2010.12.20 | 2013, 2017, 2019 онуудад сунгуулсан | 2022.12.17 | 2020 |
| Э.Цацрал /Мэргэшсэн үнэлгээчин/ | Сангийн яам | 4. Хөрөнгийн үнэлгээ хийх, 131200016, 2013.12.20 | 2017, 2019 онуудад сунгуулсан | 2022.12.17 | 2020 |

Үндсэн үнэлгээчдээс гадна тусгай зөвшөөрөлтэй 20 гаруй үнэлгээчидтэй гэрээний үндсэн дээр хамтран ажилладаг.

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2013 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 297 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хөрөнгийн үнэлгээ хийх эрх авсан.

## Үнэлгээний үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Мөнх-Оргил трейд ХХК нь СЗХ-ны 2013 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 297 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлийн хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Үнэт цаас гаргагч Төрийн банктай байгуулсан ТБ/МОТ-08-2022, 01а/305 тоот "Хөрөнгийн болон Бизнесийн Үнэлгээний үйлчилгээ үзүүлэх" гэрээ байгуулсан.

СЗХ
2022 09 21
БҮРТГЭВ



2022-09-14

Үнэлгээний ажлын даалгавар нь Захиалагчтай байгуулсан 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн ТБ/МОТ-08-2022, 01а/305 тоот гэрээний 3.3-р зүйлийн дагуу дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

- Олон улсын стандарт, "Хөрөнгийн үнэлгээний тухай" Монгол улсын хууль, тогтоомж болон холбогдох бусад заавар, аргачлалын дагуу Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийж, тайлан гаргах, үнэт цаас гаргагчийн нэгж хувьцааны үнэ цэнийг тодорхойлох;
- Үл хөдлөх ба хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг бизнесийн үнэлгээнд ашиглах зориулалтаар тооцож, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5.16-д заасан хөрөнгийн үнэлгээний тайланг боловсруулах;
- Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний тайлан нь Олон улсын Стандарт, "Хөрөнгийн үнэлгээний тухай" Монгол Улсын хууль болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн шаардлагыг хангасан байх;
- Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2011 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 274/240 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Бизнесийн үнэлгээ хийх аргачлал"-ын хүрээнд дүгнэлт, зөвлөмж өгөх;
- Энэхүү гэрээний хүрээнд Зөвлөх дараах үүргийг хүлээхээр тохиролцсон:
- Зөвлөх нь Зөвлөх үйлчилгээг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ, МХБ-ийн бүртгэлийн журам болон хувьцаа гаргах бэлтгэл ажлыг хангахад дагаж мөрдөх шаардлагатай холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх;
- Гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд Зөвлөх үйлчилгээний явц, үр дүн, тайланг тухай бүр Үнэт цаас гаргагчид танилцуулж, цаашид хийгдэх ажлын тухай мэдээллээр хангах;
- Зөвлөхөөс үл хамаарах шалтгаанаар, Зөвлөх үйлчилгээний чанар, үр дүнд муугаар нөлөөлөх ямар нэг нөхцөл байдал бий болсон тохиолдолд Үнэт цаас гаргагчид нэн даруй мэдэгдэх;
- Зөвлөх нь ажлын цар хүрээг бодитой тодорхойлох бөгөөд Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 6.3.2 дахь заалтын шаардлагын дагуу үнэлгээний зүйл, түүний шинж байдлыг үнэн зөв тодорхойлж ажлыг гүйцэтгэсэн байх;
- Гэрээний дагуу Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн бичиг баримт, материалын бүрэн бүтэн байдлыг хангах талаар өөрөөс шалтгаалах бүхий л арга хэмжээг авах;
- Үнэт цаас гаргагчийн нууцад хамаарах мэдээ, мэдээлэл, нийтэд тараагдаагүй байгаа мэдээллийн нууцыг чандлан хадгалах;
- Зөвлөх үйлчилгээтэй холбоотой гуравдагч этгээдтэй харилцах аливаа харилцаанд Үнэт цаас гаргагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183856
9020031195 СТС2420
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДЕН ҮЦК ХХК

СЗХ
он 2022 сар 09 өдөр 21
БҮРТГЭВ
№-01

- Зөвлөх нь гэрээний хугацаанд зөвлөх үйлчилгээний хүрээнд боловсруулсан судалгаа, тайлан, зураг, график, үнэлгээний тайлан, баримт бичгийг эх хувиар нь Үнэт цаас гаргагчид хүлээлгэн өгөх;
- Зөвлөхийн удирдлага, менежментийн баг нь хувьцааг нийтэд санал болгон нээлттэй хувьцаат компанийн хэлбэртэй болгох үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхүйц ёс зүйн зөрчил гаргахгүй байх, аливаа зөрчил гарсан тохиолдолд хариуцлагыг үнэт цаас гаргагчийн өмнө зөвлөх хариуцах;
- Зөвлөх нь Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийж, тайлан гаргаж, энэхүү гэрээ дуусгавар болох хүртэл хугацаанд ижил төрлийн зөвлөх үйлчилгээг бусад арилжааны банканд гүйцэтгэхгүй;
- Зөвлөх нь энэ Гэрээний 3.1 дэх хэсэгт заасан үйлчилгээг үзүүлэхдээ Үнэт цаас гаргагч болон Андеррайтертай хамтран ажиллаж, тэдгээрт ажлын явц, үр дүнгийн талаар тогтмол танилцуулж байна.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183355
9021031195 СТС2420

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ
ГҮЙДЭЛ ҮЦК ХХК
ТТБ5674 Д.5290173

## 4.3 АУДИТЫН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ

**“ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ” ХХК**

| | |
|---|---|
| **УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААР** | 9019015029 |
| **РЕГИСТРИЙН ДУГААР** | 2665247 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ** | Аудитын үйл ажиллагаа |
| **ВЕБ ХУУДАС** | www.ey.com |
| **УТАС** | +976-11-314032 |
| **ХАЯГ** | Монгол улс, Улаанбаатар хот 14251, Сүхбаатар Сөүл гудамж 21, Найман Зовхис, 200 тоот |

“Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК нь дэлхийн шилдэг 4 нягтлан бодох бүртгэлийн компанийн нэг болох Эрнст энд Янг Глобал сүлжээний бүрэн эрхт гишүүн бөгөөд 2001 онд Монгол Улсын Сангийн яамнаас аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авснаар Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. “Эрнст энд Янг Глобал” нь дэлхий дахинаа нийт 150 гаруй оронд, 700 гаруй оффист, нийт 310,000 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

“Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК нь дотоодын болон гадаадын нийт 100 гаруй мэргэжилтнээс бүрдсэн өндөр түвшний, баялаг туршлага бүхий хамт олон бөгөөд үйлчлүүлэгчдээ аудитын цогц үйлчилгээгээр хангаж ажилладаг.

Дүгнэлт:

"Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК нь Төрийн Банк ХХК (“Банк”)-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Банкны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэсэн.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НББОУСЗ”)-өөс баталж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (“СТОУС”)-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855 9021021195 СТС2420

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК
ТТБ8674 5208173

## 4.4 АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ

| "ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК" ХХК | |
|---|---|
| УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААР | 9011125147 |
| РЕГИСТРИЙН ДУГААР | 5183855 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ | Брокер, Дилер, Андеррайтер |
| ВЕБ ХУУДАС | www.ucc.mn |
| УТАС | +976-77776377 |
| ХАЯГ | Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Сити Тауэр, 25 давхар, 2506 тоот |

"Өлзий энд ко капитал ҮЦК" ХХК нь Монголын тэргүүний үнэт цаасны компаниудын нэг бөгөөд хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээг үзүүлэх үндсэн зорилготойгоор 2007 онд байгуулагдсан. Тус компани нь үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, андеррайтерийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, Монголын хөрөнгийн бирж болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн байгууллага юм.

Өлзий энд ко капитал нь Монголд анх удаа HKEX, LSE, ASX and NYSE зэрэг гадаадын биржийн арилжаанд оролцох үйлчилгээг нэвтрүүлсэн бөгөөд цаашлаад захиалгын бүртгэлийн аргыг анх удаа IPO захиалгад ашигласан, хамгийн олон хаалттай бондын төсөлд андеррайтераар ажилласан, анхны андеррайтер төвтэй, Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооны хамтран хэрэгжүүлсэн Sand box төслийн дижитал бондыг гаргасан гэх мэт олон төслийг амжилттай хэрэгжүүлжээ.

Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд оруулж буй манай компанийн хувь нэмрийг үнэлж Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн холбооноос 2011 онд "Шилдэг Брокерийн компани"-аар, 2013 онд Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал GRAND BULL AWARDS "Шилдэг Шинийг Санаачлагч" байгууллагаар тус тус шалгарч байсан бөгөөд 2018 онд гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр нь Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал GRAND BULL AWARDS "Шилдэг Мэргэжилтэн", 2020 онд Монголын үндэсний олон нийтийн телевизийн "Цагийн хүрдийн баатар"-р тодорсон билээ. Тэрээр 2015 оноос хойш Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны удирдах зөвлөлийн даргаар сонгогдон ажиллаж, хөрөнгийн зах зээлийн хөгжилд мэдлэг, чадвар, чин сэтгэлээ зориулан, үнэтэй хувь нэмэр оруулж буй манлайлагч юм.

Он цагийн дараалал:

- 2008 он Брокер, дилер, андеррайтерийн тусгай зөвшөөрөл авсан.
- 2009 он, Лондонгийн хөрөнгийн бирж болон АНУ-н банк Bank New York Mellon-той хөрөнгө босгох боломжийн талаарх форумыг анх удаа

СЗХ
2022 .09. 21
БҮРТГЭВ
№ 01

2022 -09- 14
БҮРТГЭВ-03

зохион байгуулсан.

- 2010 он, Монголд анх удаа HKEX, LSE, ASX, NYSE зэрэг биржүүдийн гадаадын арилжаанд оролцох үйлчилгээг нэвтрүүлсэн.
- 2010 он, Bank of China International-тай түншлэв.
- 2011 он, Шилдэг брокерын компани
- 2011 он, Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны гишүүн
- 2013 он, Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал Grand Bull Awards "Шинийг санаачлагч байгууллага"
- 2015-2018 он, Япон улсын JICA хамтын ажиллагааны байгууллагад макро эдийн засгийн зөвлөх
- 2016 Австралийн CPS Capital ҮЦК-ийн Монгол дахь төлөөлөгч
- 2018 МҮОНТ-ийн "Ногоон сум" реалити шоуны ялагч
- 2018 он, Гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр нь Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал Grand Bull Awards "Шилдэг Мэргэжилтэн"
- 2019-2020 онд Үнэт цаасны арилжаанд голлох байр суурьтай оролцож, МХБ-ийн ТОП-5 ҮЦК-д багтсан.
- 2019 он "Ард Кредит ББСБ" ХК-ийн IPO-д үндсэн андеррайтераар ажиллаж хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа захиалгын бүртгэлийн аргыг ашиглан, эрэлтэд үндэслэн хувьцааны үнийг тогтоов.
- 2020 он "ЛэндМН" ББСБ ХК-ийн нээлттэй бондын үндсэн андеррайтер
- 2020 он, Монголын Үнэт Цаасны Клирингийн төвийн шууд гишүүн
- 2020 он, МҮОНТ-н "Цагийн хүрдийн баатар"
- 2020 он Европын сэргээн босголт хөгжлийн банкны брокер
- 2021 он Биржийн бус зах зээл /OTC/-ийн анхны гишүүн байгууллага
- 2021 он Монголбанк, СЗХ, Сангийн яамны хамтарсан тушаалаар баталсан "Sandbox" төслийн анхны бүтээгдэхүүн болох "Монпэй" бондын андеррайтер
- 2021 он Биржийн бус зах зээлийн /OTC/-ийн анхны "БИД" бондын андеррайтер
- 2022 он Биржийн бус зах зээл /OTC/-д гаргасан "Ашид капитал ББСБ" ХХК хаалттай бондын үндсэн андеррайтер
- 2022 он Симпл ассет ТЗК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээр нээлттэй гаргах үйл ажиллагаанд Үндсэн андеррайтер
- 2022 он МҮОНТ-ийн орон даяарх "Ногоон сум" аянд хамтрагч компани

Андеррайтер нь дотоодын тэргүүлэгч банк, банк бус санхүүгийн байгууллагууд болон уул уурхай, үйлдвэрлэл, харилцаа холбоо, барилга, технологийн салбарын компаниудад андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээ үзүүлэн нийт +150.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлээд байна.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК
ТТБ8674 5208173

СЗХ
2022 .09. 21
он сар өдөр
БҮРТГЭВ



2022 -09- 14
БҮРТГЭЛ-03

## “ГҮҮДСЕК ҮЦК” ХХК

| | |
|---|---|
| **УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААР** | 901142091 |
| **РЕГИСТРИЙН ДУГААР** | 5208173 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ** | Брокер, Дилер, Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх |
| **ВЕБ ХУУДАС** | www.goodsec.mn |
| **УТАС** | +976-11-331878 |
| **ХАЯГ** | Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Сити Тауэр, 18 давхар, 1803 тоот |

“Гүүдсек ҮЦК” ХХК нь Монгол улсын хэмжээнд бүртгэлтэй харилцагчдын тоогоор салбартаа тэргүүлэгч компани бөгөөд үнэт цаасны арилжааны цахим системийг нэвтрүүлсэн, цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхаж буй үнэт цаасны компаниудын нэг юм. Тус компани нь СЗХ-ны 2016 оны 03-р дугаар сарын 11-ний өдрийн 74 тоот тогтоолын дагуу андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан байна.

Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн холбогдох журмын дагуу андеррайтерийн болон хөрөнгө оруулалтын зөвлөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд болох Үндсэн болон Туслах андеррайтерууд нь Үнэт цаас гаргагчийн хувьцааг олон нийтэд анх удаа санал болгох худалдах үйл ажиллагаанд хамтран “Түншлэл” хэлбэрээр ажиллан андеррайтерийн үйлчилгээ үзүүлхээр тохиролцсон болно.

### Андеррайтерийн үйлчилгээний гэрээгээр хүлээсэн эрх, үүрэгт:

- Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай бүхий л мэдээ мэдээлэл, тоо баримт, санхүүгийн тайлангууд болон бусад холбогдох бичиг баримтуудыг Үнэт цаас гаргагчаас гаргуулан авах
- Эрх бүхий төрийн байгууллагаас тогтоосон үнэлгээг Андеррайтерийн зүгээс хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах
- Үнэт цаас гаргагчийг гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах
- Андеррайтерийн үйлчилгээтэй холбоотой гуравдагч этгээдтэй харилцах аливаа харилцаанд Үнэт цаас гаргагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах
- Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргах үнэт цааснаас арилжаалагдаагүй үлдсэн хэсгийг бүхэлд нь нийтэд санал болгосон үнээр худалдан авах

ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
5183855
ТӨРИЙН БАНК
5341439 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК
ТТБ8674 5208173

- Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн бичиг баримт, материалын бүрэн бүтэн байдлыг хангах талаар өөрөөс шалтгаалсан бүхий л арга хэмжээг авах
- Андеррайтер нь гэрээний хугацаанд зөвлөх үйлчилгээний хүрээнд боловсруулсан судалгаа, тайлан, зураг, график, үнэт цаасны танилцуулга, баримт бичгийг эх хувиар нь Үнэт цаас гаргагчид хүлээлгэн өгөх

СЗХ 2022.09.21 он сар өдөр БҮРТГЭВ

## АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ

2022-09-14

Үндсэн андеррайтер болох “Өлзий энд ко капитал ҮЦК” ХХК нь 2008 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны 86 дугаар тогтоолоор авсан “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх” 3/42 тоот тусгай зөвшөөрлийн хүрээнд үнэт цаас гаргагч “Төрийн банк” ХХК-тай байгуулсан 2021 оны 6 дугаар сарын 23-ний өдрийн 01а/162 тоот “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний дагуу мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх андеррайтерийн үүрэг гүйцэтгэж байгаа болно.

Үндсэн андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн хувьцааг олон нийтэд санал болгох үйл ажиллагааг Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны тухай хууль, Банкны тухай хууль, Улсын их хурал, Засгийн газрын тогтоол болон Монголын хөрөнгийн биржийн ТУЗ-ийн 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам болон бусад холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэж байгаа болно.

Үндсэн андеррайтер “Өлзий энд ко капитал ҮЦК” ХХК нь өнгөрсөн хугацаанд 150.0 тэрбум давсан төгрөгийг хаалттай болон нээлттэй хүрээнд амжилттай татан төвлөрүүлж байсны хувьд андеррайтинг хийх, дүгнэлт гаргах чадвартай, мэргэшсэн, хангалттай нөөц бололцоо, туршлагатай гэж үзэж байна. Андеррайтер нь үнэт цаас гаргагч болон түүний хувь эзэмшигчидтэй холбоо хамааралгүй, нэгдмэл сонирхолгүй бөгөөд үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай танилцаж, судалгааг явуулсны үндсэн дээр болон хараат бус хөндлөнгийн байгууллагуудын дүгнэлт, тайланд үндэслэн холбогдох хууль, журмын дагуу энэхүү үнэт цаасны танилцуулгыг боловсруулж андеррайтерийн бие даасан, хөндлөнгийн дүгнэлтийг гаргалаа.

“Өлзий энд ко капитал ҮЦК” ХХК нь энэхүү дүгнэлтийг боловсруулахдаа Санхүүгийн зохицуулах хорооноос хүлээн зөвшөөрсөн эрх бүхий хараат бус аудитор “Эрнст энд янг монголиа аудит” ХХК, үнэлгээний “Мөнх-оргил трейд” ХХК, хуулийн фирмүүд болох Өмгөөллийн “Эм Ди Эс Хаанлекс” ХХН болон Өмгөөллийн “Батбаяр энд Партнэрс" ХХН-ийн гаргасан Хуулийн дүгнэлт, мэдээлэлд үндэслэв. Түүнчлэн олон улсын санхүүгийн байгууллагууд болох ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Мүүдиз агентлаг, Монголбанк, Үндэсний статистикийн хорооноос гаргасан зах зээлийн тоон мэдээ, баримтыг шүүж, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй салбарын хөгжил, бодлого, хууль эрх зүйн орчин зэрэг макро болон микро орчинг судалж, үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаатай танилцаж, Банкны ажилтнууд болон удирдлагатай уулзаж ярилцах, Банкны дунд хугацааны бизнес төлөвлөгөө, санхүүгийн тайлан гэрээ болон бусад бичиг баримтууд зэрэг үнэт цаас гаргагчаас албан ёсны тайлан, төлөвлөгөө, бодлогын баримт бичгүүдийг ашиглаж мэргэжлийн ёс зүйг баримтлан хуулийн хүрээнд ажиллалаа. Үнэт цаас гаргагч нь Үндсэн андеррайтертай үйлчилгээний гэрээ байгуулан ажиллахаас гадна дараах бэлтгэл ажлуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:

СЭХ
он сар өдөр
2022 09 21
БҮРТГЭВ
№ 01



1. Үнэт цаас гаргагч нь Өмгөөллийн "Эм ди эс энд хаанлекс" ХХН болон Өмгөөллийн "Батбаяр энд Партнерс" ХХН-тай 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр 01а/307 дугаар Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох үйл ажиллагаанд хөндлөнгийн хуулийн дүгнэлт гаргах ажлыг гүйцэтгүүлсэн.
2. Үнэт цаас гаргагч нь "Эрнст энд янг монголиа аудит" ХХК-тай 2021 оны 4 дүгээр сарын 29–ний өдөр 01а/318 дугаар Аудитын үйлчилгээний гэрээг байгуулан үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох үйл ажиллагааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн мэдээллүүд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 34, бусад холбогдох СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар нягтлах ажлыг гүйцэтгүүлсэн.
3. Үнэт цаас гаргагч нь "Мөнх-оргил трейд" ХХК-тай 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр 01а/305 дугаар Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээг байгуулан үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээний дүгнэлтүүдийг гаргуулсан.
4. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 5 дугаар сарын 25-ны 03 тоот тогтоолын дагуу компанийн хэлбэрийг өөрчлөх асуудлыг Засгийн газрын хуралд хэлэлцүүлэхтэй холбоотой бэлтгэл ажлыг ханган ажиллаж Монгол улсын Засгийн газрын 2022 оны 6 сарын 22-ны өдрийн 34 дүгээр тэмдэглэлээр "Төрийн банк" ХХК-ийг олон нийтэд нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжүүлэх хөтөлбөрийг батлахыг үүрэг болгосны дагуу Сангийн сайд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 06 дугаар 27-ны өдрийн 130/А-191 дугаар тушаалаар хөтөлбөрийг баталсан.
5. Үнэт цаас гаргагч нь Үндсэн андеррайтер "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК-тай 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдөр 01а/162 дугаар Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан.

Үнэт цаас гаргагчийн хувьцааг олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгон арилжих ажлын хүрээнд Үндсэн андеррайтер нь мэргэжлийн түвшинд хийгдсэн судалгаа шинжилгээний үр дүнд тулгуурлан Үнэт цаасны танилцуулгыг боловсруулан, дараах мэргэжлийн дүгнэлтийг танилцуулж байна. Үүнд:

- Үнэт цаас гаргагчийн бизнес, үйл ажиллагаа
- Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн төлөв байдал
- Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны стратеги болон бизнес төлөвлөгөө
- Үнэт цаас гаргагчийн санхүүгийн шинжилгээ
- Үнэт цаас гаргагчийн татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт
- Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн шинжилгээ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5163855
9071031195 СТС2420
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК
7VE9674 5208178

СЭХ он сар өдөр 2022 09 21 БҮРТГЭВ №01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-09-14 БҮРТГЭВ 03

Үнэт цаас гаргагчийн тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 348 тоот тогтоолын дагуу Сангийн сайдын 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 259 тоот тушаалаар 100 хувь Төрийн өмчит Төрийн банкийг Монгол Улсын банк, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хадгаламж эзэмшигч, харилцагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс үүсгэн байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд тус банк нь өнгөрсөн 13 жилийн хугацаанд Монголын банк, санхүүгийн салбар дахь өөрийн гэсэн дүр төрхийг бий болгож, орчин үеийн банкны үйлчилгээг ард иргэддээ саадгүй хүргэн ажиллаж ирсэн.

## Үнэт цаас гаргагчийн бизнес, үйл ажиллагаа

Монгол улсын Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 375 дугаартай тушаалаар батлагдсан "Банк, түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам"-ыг үндэслэн Монголбанкнаас 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Банкны зөвшөөрлийн гэрчилгээ олгосон.

Төрийн банк нь Монгол орны бүхий л сум, суурин бүрт нийт 495 салбар нэгж, 347 АТМ, 4,200 гаруй картаар үйлчлэгч байгууллагуудаар дамжуулан 2.3 сая харилцагчдадаа банкны үйлчилгээг эрсдэлгүй, найдвартай хүргэж, үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тус банкны нийт активын хэмжээ 2022 оны нэгдүгээр улирлын байдлаар 3.7 их наяд төгрөгт хүрч, өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон бусад үзүүлэлтээр Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллаж байна.

## Үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн төлөв

Макро эдийн засгийн төлөв

2021 онд дэлхийн улс орнууд сүүлийн 2 жил хэрэгжүүлсэн цар тахлыг даван гарах мөнгөний зөөлөн бодлогоос хатуу бодлого руу шилжиж, хэрэглээний үнийн өсөлтийг хязгаарлах бодлогоо эхлүүлсэн жил байлаа. 2021 онд Ковид-19-ын омикрон, дельта зэрэг шинэ хувилбаруудын дэгдэлт гарсан нь дөнгөж сэргэж байсан улс орнуудын эдийн засагт хүчтэй сөрөг нөлөө үзүүлсэн. 2022 онд нийлүүлэлтийн сүлжээний тасалдал, үйлдвэрлэлийн зардлын өсөлтийн дарамт Украины дайны улмаас улам даамжирч байна. Тиймээс шатахуун, эрчим хүчний үнийн өсөлт, Төв банкуудын мөнгөний хатуу бодлого, нийлүүлэлтийн хомсдол гэх мэт хүчин зүйлс эдийн засгийн удаашралд үргэлжлүүлэн нөлөөлөх нь хэвээр байна.

Дэлхийн улс орнуудад Ковид-19-ын эсрэг вакцинжуулалтын хамралт, хүрэлцээ нэмэгдэж байгаа нь цар тахлын хөл хорио, хязгаарлалтын дэглэм багасаж нийгэм, эдийн засгийн хэвийн үйл ажиллагаа аажмаар сэргэх боломжийг өгч байгаа хэдий ч сэргэлтийн хурд нь Украины нөхцөл байдал, түүхий эд экспортлогч орнуудын геополитикийн бодлогоос шууд хамаарах төлөвтэй

КАПИТАЛ ҮЦК ХХК 5183858 9011031155 СТС2420
ТӨРИЙН БАНК 5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДЕК ТТЕ9674 5208173

СЗХ
2022 09 21 өдөр
БҮРТГЭВ
2022-09-14

байна. Дунд хугацаанд дэлхийн эдийн засагт нөлөөлөх тодорхойгүй нөхцөл байдалд нийлүүлэлтийн тасалдал, эрчим хүчний үнийн өсөлт, БНХАУ-ын хатуу хөл хорио, Украины хямрал шууд нөлөөлнө гэж дүгнэж байна.

Банкны салбарын төлөв

2021 оны байдлаар арилжааны нийт 11 банк, 1,393 салбар, нэгж болон 15,958 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байгаа, санхүүгийн салбарын 92.4 хувийг бүрдүүлдэг, түүн дотроо Төрийн банк, Хаан банк, Худалдаа Хөгжлийн банк, Голомт банк, Хас банк гэх системийн нөлөө бүхий 5 банк системийн 90-ээс дээш хувийг бүрдүүлж байгааг Монголбанкнаас тодорхойлсон байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар банкны салбарын нийт активын хэмжээ 41.04 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны жилийн эцсээс 11.8 хувиар буюу 4.3 их наяд төгрөгөөр өссөн байна. Энэхүү үзүүлэлтийг 5 болон 10 жилийн өмнөх үзүүлэлттэй харьцуулахад 61.9 хувь болон 337.6 хувиар тус тус өссөн байна.

2021 оны байдлаар системийн нөлөө бүхий 5 том арилжааны банк нь системийн нийт хөрөнгийн 93.6 хувийг, харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны 87 хувийг, нийт өр төлбөрийн 92 хувийг, цэвэр ашгийн 98 хувийг бүрдүүлдэг.

Төрийн Банк нь Монголбанкнаас тавигддаг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн ханган ажиллаж байгаа бөгөөд төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа, өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа үзүүлэлтээр салбартаа тэргүүлж байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор банкууд тэнцэл дэх эрсдэлээ бууруулан эрсдэл багатай үнэт цаас дахь хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх арга хэмжээ авснаар активын бүтэц өөрчлөгдөж, зээлийн багцын эзлэх хувь буурсан боловч Эдийн засгийг идэвхжүүлэх хөтөлбөрийн үр дүнд зээл олголт нэмэгдэж, банкуудын Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалтын өсөлтийн хурд саарч байна.

Хурдацтай өсөлттэй байсан иргэдийн зээлийг хязгаарлах зорилгоор өрхийн өр-орлогын харьцаанд тогтоосон макро-зохистой бодлогын хязгаарлалтыг 2019 оны эхнээс мөрдүүлснээр 2019 онд хэрэглээний зээлийн өсөлтийн хурд буурсан. Харин хэрэглээний зээлийн өсөлт 2020 оны эхнээс сөрөг утгатай болсон нь цар тахалтай холбоотойгоор тогтоосон хөл хорионы улмаас банкууд зээл олголтыг хязгаарласантай холбоотой. 2021 оны хоёрдугаар улирлаас хэрэгжсэн Эдийн засгийг идэвхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд зээл олголт нэмэгдсэнээр хэрэглээний зээлд өсөлт ажиглагдаж эхлээд байна.

2021 онд иргэд, аж ахуйн нэгж, төрийн байгууллагаас татсан харилцахын үлдэгдэл 40.1 хувиар, бусад эх үүсвэр 12.9 хувиар, иргэд, аж ахуйн нэгж, төрийн байгууллагын хадгаламж 5.2 хувиар тус тус өссөн байна. Харилцах, хадгаламж нь системийн хувьд тогтвортой эх үүсвэр тооцогддог бөгөөд түүний өсөлт нь банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон томоохон төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх чадварыг сайжруулж байдаг.

Системийн банкуудын орлогын гол үзүүлэлт болох хүүгийн орлогын хэсгийг бүтцээр задалж үзвэл 71 хувийг зээлийн хүүгийн орлого, 24 хувийг үнэт цаасны хүүгийн орлого, 3 хувийг Монголбанкинд байршуулсан хөрөнгийн хүүгийн орлого гэсэн үзүүлэлтүүд бүрдүүлдэг байна.

Системийн банкуудын зардлын гол үзүүлэлт болох хүүгийн зардал хэсгийг бүтцээр задалж үзвэл 73 хувийг хадгаламжид төлсөн хүү, 15 хувийг зээлийн хүүгийн зардал, 5 хувийг үнэт цаасны хүүгийн зардал, 7 хувийг бусад зардлууд гэсэн үзүүлэлтүүд бүрдүүлдэг байна.

## Бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөлөл

Төрийн банк нь дунд хугацаандаа хэрэгжүүлэх стратегийн тэргүүлэх 3 чиглэлийг тодорхойлж, үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Дундаж давхаргад зориулсан санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүгийн боловсрол олгох

Төрөөс хэрэгжүүлж буй бодлого чиглэлийг дэмжиж санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, өрхийг орон сууцжуулах, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн банкны үйлчилгээг хүргэх хүрээнд ажлуудыг хийж гүйцэтгэснээр Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засгийг сэргээх цогц төлөвлөгөөг дэмжих замаар дундаж давхаргыг бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ.

2. Цахим шилжилт хийж дундаж давхаргын харилцагчдад чиглэсэн бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх

Төрийн банкны нийт харилцагчийн 50 хувийг цахим үйлчилгээ хэрэглэгч болгосноор нийт гүйлгээнд эзлэх цахим гүйлгээний тоог 70 хувьд хүргэнэ.

3. Банкны үйл ажиллагааг байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, зохистой засаглалыг бэхжүүлэх чиглэлд хандуулах

Банкны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, ногоон зээлийн багцын өсөлт бий болгох, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх, банканд байгаль орчин, нийгэм, зохистой засаглалын олон улсын туршлагыг нэвтрүүлэн гадны байгууллагаас хямд өртөгтэй, урт хугацаат эх үүсвэрийг татах, байгаль орчин, нийгэмдээ хувь нэмэр оруулах боломжуудыг бүрдүүлнэ.

Банкны мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдлыг бодлого, журам, бүтэц зохион байгуулалт, тоног төхөөрөмж, программ хангамжаар дамжуулан хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны COBIT тогтолцоо, ISO/IEC 27001, PCI-DSS стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж банкны мэдээллийн аюулгүй байдлыг хангана.

Санхүүгийн төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн 2022 оноос 2024 оны санхүүгийн төсөөллийг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу боловсруулсан бөгөөд бизнесийн үнэлгээг Монголбанкны тайлагналын стандартын дагуу боловсруулсан учир үнэт цаас гаргагчийн СТОУС-аар бэлтгэсэн санхүүгийн төсөөллөөс бага зэрэг зөрүү үүсэхийг анхаарна уу.

СЭХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-14
БҮРТГЭВ-03

Санхүү байдлын тайлангийн төсөөлөл

| Баланс /Сая.төг/ | 2022F | 2023F | 2024F |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах | 353,963 | 479,238 | 508,213 |
| Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж | 50,000 | 50,000 | 50,000 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 2,463,063 | 2,674,950 | 2,960,229 |
| Санхүүгийн хөрөнгө оруулалт-борлуулахад бэлэн | 1,138,180 | 1,171,134 | 1,252,218 |
| Бусад хөрөнгө | 7,882 | 9,922 | 9,911 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 595 | 3,768 | - |
| Үндсэн хөрөнгө | 124,826 | 121,060 | 127,417 |
| Биет бус хөрөнгө | 5,729 | 5,845 | 5,963 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **4,144,239** | **4,515,917** | **4,913,950** |
| **ӨР ТӨЛБӨР** | | | |
| Бусад банк санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж | 348,986 | 450,789 | 469,832 |
| Репо хэлцэл | 87,201 | 76,193 | 110,193 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 3,108,399 | 3,358,592 | 3,625,896 |
| Зээлээр авсан санхүүжилт | 127,944 | 100,792 | 94,412 |
| Бусад өр төлбөр | 21,690 | 20,000 | 20,000 |
| Түрээсийн өглөг | 24 | 25 | 25 |
| **Нийт өр төлбөрийн дүн** | **3,694,244** | **4,006,392** | **4,320,359** |
| **ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | | | |
| Энгийн хувьцаа | 200,109 | 200,109 | 200,109 |
| Нэмж төлөгдсөн капитал | 22,666 | 22,666 | 22,666 |
| Бусад нөөц | 21,426 | 18,281 | 18,281 |
| Хуримтлагдсан ашиг | 205,793 | 268,469 | 352,535 |
| Нийт эздийн өмч | 449,994 | 509,525 | 593,591 |
| **Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн** | **4,144,239** | **4,515,917** | **4,913,950** |

Орлогын тайлангийн төсөөлөл

| Орлого үр, дүн /Сая.төг/ | 2022F | 2023F | 2024F |
|---|---|---|---|
| Үр ашигт хүүгийн аргачлалаар бодсон хүүгийн орлого | 411,556 | 488,633 | 514,209 |
| Хүү болон түүнтэй адилтгах зардал | -220,186 | -251,519 | -266,992 |
| **Цэвэр хүүгийн орлого** | **191,370** | **237,114** | **247,217** |
| Хураамж, шимтгэлийн орлого | 30,104 | 33,115 | 38,082 |
| Хураамж ба шимтгэлийн зардал | -2,032 | -2,000 | -2,000 |
| **Хураамж ба шимтгэлийн орлого** | **28,072** | **31,115** | **36,082** |
| Арилжааны цэвэр орлого | 2,996 | 3,000 | 3,000 |
| Үйл ажиллагааны бусад орлого(зардал) | 1,134 | 1,100 | 1,100 |
| **Үйл ажиллагааны орлого** | **223,573** | **272,329** | **287,399** |
| Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан | -15,311 | -19,102 | 6,201 |
| **Үйл ажиллагааны цэвэр орлого** | **208,262** | **253,227** | **293,600** |
| Үйл ажиллагааны зардал | -164,951 | -173,158 | -184,099 |
| **Татварын өмнөх ашиг** | **43,311** | **80,069** | **109,501** |
| Орлогын албан татварын зардал | -10,909 | -17,398 | -25,434 |
| **Тайлант жилийн ашиг** | **32,402** | **62,671** | **84,066** |

КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 CTC2420
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК 5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ГҮҮДСЕК ТТБ8674 5208173

СЗХ
20__ сар __ өдөр
БҮРТГЭВ



2022-09-14

**Санхүүгийн шинжилгээ**

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө 2019-2021 онуудад дунджаар 7.2 хувийн өсөлт үзүүлж байсан бол 2022 оноос 9 хувийн өсөлт үзүүлж, 2022 - 2024 онуудад нийт хөрөнгө 4.1 их наяд төгрөгөөс 4.9 их наяд төгрөг болж өсөх төсөөлөлтэй байна. Нийт хөрөнгийн 59 - 60 хувийг цэвэр зээл, 26 хувийг хөрөнгө оруулалт, 1 хувийг банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, 10 хувийг бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах, үлдсэн 3 хувийг бусад хөрөнгүүд эзлэхээр байна.

Бэлэн мөнгө болон банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө 2022-2024 онуудад тогтвортой, Монголбанкны харилцах нийт хөрөнгөнд эзлэх түүхэн хугацааны хувийн жинг хадгалж байхаар төсөөлсөн байна.

**Хөрөнгө оруулалт**

Үнэт цаас гаргагч 2017-2021 онуудад мөнгөн хөрөнгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, харилцагчдад олгосон зээлд байршуулаагүй үлдэгдэл хөрөнгийг хөрөнгө оруулалт хэлбэрээр байршуулж ирсэн бөгөөд цаашдын төсөөлөлд сул мөнгөн хөрөнгийг мөн эргэлтэд оруулж байхаар төсөөлж, нийт хөрөнгийн 26%-30%-ийг үнэт цаас хэлбэрээр байршуулахаар төлөвлөсөн байна. Эдгээр хөрөнгө оруулалтын 77%- 80%-ийг түргэн борлогдох үнэт цаас эзлэхээр байна.

**Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа**

Нийт зээл 2022 онд 2.5 их наяд төгрөгөөс 2024 онд 2.96 их наяд төгрөгт хүрч жилд дунджаар 10%-ийн өсөлт үзүүлж 2024 онд зах зээлд эзлэх зээлийн багцын хувь 12.8%-д хүрэх төлөвлөгөөтэй байна.

Чанаргүй зээлийн хувь хэмжээ 2017-2021 онуудад дунджаар 10 хувь байсан бөгөөд зээлийн хяналтын тогтолцоог сайжруулах, зээлийн багцын удирдлагыг оновчтой болгох, тэдгээрийн чанарыг сайжруулах төлөвлөгөөний хүрээнд 2022 онд 9.2 хувь, 2023 онд 9.0 хувь, 2024 онд 8.0 хувьд хүргэж ажиллахаар төлөвлөсөн байна.

Үнэт цаас гаргагч нь активын чанарын удирдлагыг сайжруулах зорилгоор эрсдэлийн санг 2022 онд нийт чанаргүй зээлийн 87 хувьд, 2023 болон 2024 онуудад 90 хувьтай байгуулах төсөөлөлтэй байна.

**Бусад хөрөнгө**

Үнэт цаас гаргагчийн бусад хөрөнгөнд биет бус хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө зэрэг бага дүнтэй хөрөнгүүд болон үндсэн хөрөнгө буюу барилга, байшин, оффис, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл зэрэг хөрөнгүүдийг багтаасан. Үүнээс банкны ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг харьцангуй удаан хугацаанд ашиглагддаг үндсэн хөрөнгө 2021 онд 115.9 тэрбум төгрөг байсан бол 2024 онд 127.4 тэрбум төгрөг болж 10 хувийн өсөлттэй байхаар байна.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
6021031195 СТС2420
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ХХК
ТТБ6674 6308173

## Нийт эх үүсвэр

Нийт эх үүсвэрийн дүн 2021 онд 3.8 их наяд орчим төгрөг байсан бол 2022 оноос жилд 9 хувийн өсөлт үзүүлж 2024 онд 4.9 их наяд гаран төгрөг болох төсөөлөлтэй байна. 2019-2021 онуудад нийт хөрөнгийн 75 хувиас 78 хувийг харилцагчдын харилцах, хадгаламж эзэлж байсан бол банкны нийт депозитийн зах зээлд эзлэх хувиа хадгалж, 2022 оноос 75 хувийг харилцагчдын харилцах хадгаламж, 2022-оос 2024 онуудад дунджаар 2 хувийг зээлээр авсан санхүүжилт, 9 хувийг дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж буюу банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, 4-5 хувийг энгийн хувьцаа, 5 - 7 хувийг хуримтлагдсан ашиг, үлдсэн 2 - 3 хувийг бусад эх үүсвэр ба өр төлбөрүүд эзлэх төсөөлөлтэй байна.

## Харилцагчдын харилцах, хадгаламж

Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний нийт банкны депозитэд эзлэх байр сууриа хадгалах зорилтын хүрээнд харилцагчдын харилцах, хадгаламжийг нэмэгдүүлж, 2022-аас 2024 онуудад жилд дунджаар 8 хувийн өсөлт үзүүлж, 2024 онд 3.6 их наяд төгрөгийн харилцах, хадгаламж татан төвлөрүүлэхээр төсөөлөлтэй байна.

## Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр ба зээл

Олон улсын зах зээлээс хямд эх үүсвэр татаж, банкны эх үүсвэрийн зардлыг бууруулах арга хэмжээг авч ажиллахтай холбогдуулан гадаадын банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн эх үүсвэр болон дотоодын банк санхүүгийн байгууллагаас татсан хадгаламжийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор 2022 онд 349.0 тэрбум төгрөгөөс 2024 онд 469.8 тэрбум төгрөг болж өсөх төлөвлөгөөтэй байна.

## Өөрийн хөрөнгө

Нийт өөрийн хөрөнгө 2022-2024 онуудад жилд дунджаар 14 хувийн өсөлт үзүүлж, 2024 оны байдлаар 594 тэрбум төгрөгт хүрэхээр төсөөлөлтэй байна. Хуримтлагдсан ашгийн түвшин 2017-2021 онуудад жилд дунджаар 22 хувийн өсөлттэй байсан бөгөөд дунд хугацааны төлөвлөгөөний дагуу ашигт ажиллагааг нэмэгдүүлснээр хуримтлагдсан ашиг өмнөх онтойгоо харьцуулахад 2022 онд 14 хувиар, 2023 онд 30 хувь, 2024 онд 31 хувиар тус тус өсөх төсөөлөлтэй байна.

## Бизнесийн үнэлгээ

“Мөнх-Оргил трейд” ХХК нь Төрийн банктай 2022 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр танай байгууллагатай байгуулсан ТБ/МОТ-08-2022, 01а/305 тоот “Бизнесийн болон хөрөнгийн үнэлгээ хийх гэрээ” – нд заасны дагуу үнэт цаасны зах зээлд шинээр хувьцаа гаргах зорилгоор бизнесийн үнэ цэнийг тогтоох ажлын хүрээнд Банкны эзэмшигчдийн өмчийн 100.0 хувийн хувь оролцоог 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар үнэлж, үнэлгээний тайланг боловсруулсан. Тодорхойлсон үнэ, цэнэ нь “Үнэлгээний Олон Улсын Стандарт-2020-200. Бизнес ба бизнесийн хувь оролцоо”-ны 20.3 (г)-д заасны

СЗХ
2022 .09. 21
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022 -09- 14

дагуу "Өмчийн бүх хувьцаа эзэмшигчдэд хамаарах бизнесийн үнэ, цэнэ" болно.

Бизнесийн үнэлгээг орлогын хандлагаар хорогдуулсан мөнгөн урсгалын аргыг ашигласан гүйцэтгэсэн. Энэ аргын давуу тал нь тухайн банкны бизнесийг сонирхож буй худалдан авагчийн ирээдүйн жил тутам олох орлогын өнөөгийн үнэ цэнийн нийлбэрийг тооцдогт оршино. Хөрөнгө оруулагч банкны бизнесээс орж ирэх орлого болон өгөөжийг сонирхож өөрөөр хэлбэл банкны бизнесийн зах зээлийн үнэ нь хөрөнгийн ашиглалтаас ирээдүйд гарах үр ашгийн өнөөгийн үнэ цэнэтэй тэнцүү байна гэсэн үг юм. Энэхүү аргаар үнэлгээг тооцоолоход дараах 2 хүчин зүйлээс хамаарч бизнесийн үнэ цэнэ хир зэрэг үнэн бодитой гарах эсэх нь шалтгаална. Үүнд:

- Ирээдүйн мөнгөн урсгалын төсөөлөл болон төсөөлж буй хугацааны эцэст үлдэх өртөг буюу Терминал үнэ,
- Хорогдуулалтын хувийг оновчтой тооцоолох.

Бизнесийн үнэлгээний Орлогын хандлагын үнэлгээнд доорх төсөөллийг хийсэн болно. Үүнд:

- Жишиг компаний хүрээнд сонгон авсан компаниудын татварын үзүүлэлт болон банкны ирээдүйн хугацаанд төлөвлөсөн татварын үзүүлэлтийг банкны 2021 оны санхүүгийн тайлангийн татварын үзүүлэлт болох 25.02 хувь байхаар төсөөлсөн,
- Жишиг компаний хүрээнд сонгон авсан компаниудын хувьцааны үнийн сүүлийн хагас жилийн мэдээлэл нь үнэлгээний өдрөөрх зах зээлийн нөхцөлийг төлөөлөх боломжтой гэж төсөөлсөн,
- Том компани болон жижиг компанийн өгөөжийн өөрчлөлт болох тоон хэмжээний шагналыг Монголын хөрөнгийн зах зээлийн хүрээнд "тухайн тохиолдол"-д тооцох боломжтой гэж төсөөлсөн,
- Банкны 2022-2026 оны санхүүгийн мөнгөн урсгалын төлөвлөлтөд элэгдэл, хорогдуулалтын зардал болон капитал зарцуулалтын зардлыг үйлчилгээний салбарын байгууллагуудын нийтлэг үзүүлэлт болох нийт борлуулалтын орлогын 2 хувь байхаар төсөөлсөн.

## Үнэт цаасны үнэ тогтоосон үндэслэл

Бизнесийн үнэ цэнийн дундаж үр дүн болох 494.2 тэрбум төгрөг нь үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэ цэнийг илүү сайн илтгэж чадна гэж үзсэн ба нэгж хувьцааны дотоод үнэ цэнэ 659 төгрөг байх юм.

| Хувьцаа гаргасны дараах хувьцааны тоо ширхэг | Бизнесийн үнэ цэнэ | Нэгж хувьцааны дотоод үнэ цэнэ |
|---|---|---|
| 749,475,000 | 494,291,500,000₮ | 659.5₮ |

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад таатай нөхцөлийг санал болгох үүднээс өөрийн хувьцааг худалдах үнийг 590 төгрөг байхаар тогтоон дотоод үнэ цэнэ болох 659 төгрөгөөс 10.54 хувиар хямдруулан хөрөнгө оруулагчдад санал болгож байна.

СЭХ
он 2022 сар 09. 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

Төрийн Банк нь олон нийтээс татан төвлөрүүлж буй хөрөнгөө банкны үндсэн үйл ажиллагааг дэмжих, үүн дотроо Байгаль орчин, нийгэм, засаглалын зарчимд нийцсэн болон Дундаж давхаргыг дэмжсэн зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, зах зээлд нэвтрүүлэхэд 100 хувь зарцуулах төлөвлөгөөтэй байна. Үүнд:

- ✓ Байгаль орчин, нийгэм, засаглалын зарчимд нийцсэн зээлийн бүтээгдэхүүн - 50 хувь
- ✓ Дундаж давхаргыг дэмжсэн зээлийн бүтээгдэхүүн - 50 хувь

Ингэхдээ төр засгаас явуулж буй бодлого шийдвэрүүдэд нийцүүлэн УБ хотын төвлөрлийг бууруулах, орон нутгийн иргэд, жижиг дунд аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх чиглэлийг баримталж нийт зээлийн санхүүжилтийн 60-70 хувийг орон нутгийн салбар нэгжүүдээрээ дамжуулан хүргэхээр төлөвлөж байна.

## Эрсдэлийн бодлого

Банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, хянах замаар банкны хүлээж болзошгүй хохирлыг бууруулах эрсдэлийн удирдлагын үр ашигтай тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх зорилт тавьж ажилладаг.

Банкны эрсдэлийн удирдлагыг нэгдсэн байдлаар хэрэгжүүлэх ба эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь үйл ажиллагаа, чиг үүргүүдийг оновчтой хуваарилж, эрсдэлийн түвшин хамгийн бага байх хяналтын нэгдсэн бүтцийг бүрдүүлж ажилладаг бөгөөд гурван давхар хамгаалалтын шугам бүхий эрсдэлийн тогтолцоог хэрэгжүүлдэг.

- Хамгаалалтын нэгдүгээр шугам-Бизнесийн нэгжүүд нь эрсдэлийн удирдлагыг үйл ажиллагаандаа үр дүнтэй хэрэгжүүлж ажиллана. Өөрийн эрх мэдэл, үүрэг хариуцлагаас давсан, банканд томоохон хэмжээний эрсдэл авчирч болохуйц эрсдэлийн талаар холбогдох дээд удирдлага, Нэгжийн эрсдэлийн удирдлагын хороо, банкны Эрсдэлийн удирдлагын хороонд танилцуулан зөвлөмж, шийдвэр гаргуулан, хэрэгжүүлж ажилладаг.

- Хамгаалалтын хоёрдугаар шугам- Банкны төвийн газар, хэлтэс, алба нь өөрийн чиг үүрэгт тусгагдсан ажлууд болон бизнесийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх бодлогын баримт бичигт эрсдэлийн удирдлагын болон шат дараалсан хяналтын тогтолцоог бүрдүүлж ажилладаг.

- Хамгаалалтын гуравдугаар шугам - Дотоод аудитын газар банкны эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдал, бодлогын

ТӨРИЙН БАНК
ГҮЙДСЕК
УЛААНБААТАР ХОТ

хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд сайжруулах арга хэмжээний зөвлөмжийг өгч, ТУЗ-д тайлагнана.

- ТУЗ - Банкны эрсдэлийн удирдлагын үндсэн чиг хандлагыг тодорхойлж, стратеги, бодлого, зарчмыг батлах ба гүйцэтгэх удирдлагаас банкны үйл ажиллагаанд мөрдүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулдаг.

- ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын асуудал эрхэлсэн хороо - банкны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулдаг.

- Гүйцэтгэх удирдлага, Эрсдэлийн удирдлагын хороо банкны эрсдэлийн удирдлагын дотоод дүрэм, журмыг боловсруулж ТУЗ-д танилцуулж батлуулах, мөрдөн ажиллах ба банкны эрсдэлд суурилсан дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна.

Эрсдэлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээнд Зээлийн эрсдэлийн удирдлага, Зах зээл, хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага, Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага, Мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага, Комплаенсийн эрсдэлийн удирдлага багтдаг.

## Монголын хөрөнгийн биржийн I ангиллын шалгуурыг хангах нь

Монголын хөрөнгийн биржид үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлтэй үнэт цаас гаргагч нь үнэт цаасны ангиллаас үл хамааран биелүүлэх нийтлэг шаардлага, мөн ангилал тус бүрд тогтоосон шалгуурын шаардлагыг хангасан байна:

<u>- Үнэт цаас гаргагч нь татварын болон хугацаа хэтэрсэн их хэмжээний зээлийн өргүй байх;</u>

Төрийн банк нь татварын, нийгмийн даатгалын, банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхүйц их хэмжээний өргүй тухай хуулийн дүгнэлтийн 120-р зүйлд тусгасан байна. Мөн үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх захирал нь хугацаа хэтэрсэн зээлийн өргүй тухай уг дүгнэлтийн 120-т тусгасан байна. Хугацаа хэтэрсэн их хэмжээний өргүй тухай Хуулийн дүгнэлтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

<u>- Үнэт цаас гаргагчийн хөрөнгө нь бүхэлдээ эсхүл дийлэнх хэсэг нь мөнгөн хөрөнгө болон богино хугацаат үнэт цааснаас бүрдээгүй байх. Энэ шаардлагыг компанийн үйл ажиллагааны чиглэлээс хамааруулан хөнгөлж болно;</u>

Төрийн банкны 2021 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон аудитлагдсан тайланд тусгагдсанаар мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн 250.9 тэрбум буюу энэ нь нийт хөрөнгийн 6.6 хувийг бүрдүүлж байна.

СЗХ 2022 он 09 сар 21 өдөр БҮРТГЭВ

MONGOLIAN STOCK EXCHANGE 2022 09 14 БҮРТГЭВ-03

Санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүй мэдээллийг аудитын тайлангаас дэлгэрүүлэн үзнэ үү.

- <u>Үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргахаас өмнөх хамгийн сүүлийн санхүүгийн жилийн үеэр санхүүгийн тайлагналын хугацаагаа өөрчлөөгүй байх;</u>

Төрийн банк нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1-д зааснаар “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 1-р сарын 1-ний өдрөөс эхэлж 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болно” гэж заасны дагуу санхүүгийн тайлагналыг хөтөлж байна.

- <u>Үнэт цаас гаргагчийн биржид бүртгүүлэх хүсэлт гаргахаас өмнөх санхүүгийн тайлангийн сүүлийн хугацаа нь 6 сараас ихгүй байх ба заасан хугацаанаас их байгаа тохиолдолд хамгийн сүүлийн улирлын тайланг аудитаар баталгаажуулах эсхүл уг тайланд материаллаг өөрчлөлт ороогүй тухай мэдэгдэл;</u>

Төрийн банк нь Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд үнэт цаас бүртгүүлэх өргөдлийг 2022 оны 2-р улиралд өгч байгаа тул Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхгүй.

- <u>Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам болон өөрийн эрх зүйн баримт бичгийг бүрэн дагаж мөрддөг байх;</u>

Төрийн банк нь Монгол Улсын Иргэний хууль, Банкны тухай хууль, Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, журмыг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж байна.

Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекс, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 09 сарын 30-ны өдрийн №А-151 тоот тушаалаар батлагдсан Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 03 сарын 22-ны өдрийн №А-86 тоот тушаалаар батлагдсан Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам болон бусад Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан Банкны хэмжээнд дагаж мөрдвөл зохих дүрэм, журмыг тус тус баримтлан ажиллаж байна.

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 СТС2420
ТӨРИЙН БАНК 5341469 ГСТ5332
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

Үнэт цаас гаргагч нь Банкны үйл ажиллагааны тусгай зөвшөөрлөөр гүйцэтгэх гадагш чиглэсэн дүрэм, журам болон засаглалд хамаарах дүрэм, журам, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр Монголбанканд бүртгүүлэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн №42 тоот тушаалаар батлагдсан Банкны эрхзүйн баримт бичгийг бүртгэх тухай журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна

- ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь үнэнч шударга, ёс зүйтэй байх;

Төрийн банкны ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлага нь үнэнч шударга, ёс зүйтэй болно.

- Эрх бүхий албан тушаалтнууд нь компанийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай мэдлэг, туршлагатай байх;

Төрийн банкны ТУЗ-ийн бүрэлдэхүүнд банк, эдийн засаг, бизнесийн удирдлага, санхүүгийн чиглэлээр мэргэшсэн, өндөр мэдлэг, туршлагатай хүмүүс байгаа болно. ТУЗ-ийн бүх гишүүд нь Компанийн тухай хуулийн 75.8-д заасны дагуу компанийн ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга нарт зориулсан компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан. Гүйцэтгэх удирдлагын баг нь бизнесийн удирдлага, санхүүгийн шинжилгээ, эдийн засагч чиглэлээр мэргэшсэн ба компанийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай мэдлэг туршлагатай гэж үзэж байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвшөөрөл болон Гүйцэтгэх захирал Ө.Гантөрийн гаргаж өгсөн холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа тухай Баталгаанд үндэслэн Төрийн банк ХХК-ийн Гүйцэтгэх захирал нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байна гэж дүгнэсэн болно.

Иймд Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнууд нь холбогдох хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа бөгөөд тэдгээр нь Компанийг удирдах чадвар, дадлага туршлагатай гэж дүгнэв.

Компанийн ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын багийн намтрыг хуулийн дүгнэлт болон энэхүү үнэт цаасны танилцуулгаас дэлгэрүүлэн үзнэ үү.

- Компанийн удирдлага болон хяналтын багц эзэмшигчид бүртгэгдсэнээс хойш 6 сарын хугацаанд хувьцаагаа худалдахгүй байх.

Төрийн банкны одоогийн хувьцаа эзэмшигчид нь Монголын хөрөнгийн биржид бүртгэгдсэнээс хойш 6-аас доошгүй сарын хугацаанд өөрсдийн эзэмшлийн хувьцааг худалдахгүй.

Монголын хөрөнгийн биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 11.1-т заасны дагуу хувьцааны бүртгэлийн I ангилалд бүртгүүлэх үнэт цаас гаргагч дараах шалгуур хангасан байна.

- Өргөдөл гаргахаас өмнө 3-аас доошгүй жил тухайн чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;

Төрийн банк нь 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын Засгийн Газрын 348 тоот тогтоолын дагуу, мөн тус өдрийн Сангийн сайдын 259 тоот тушаалаар 100 хувь төрийн өмчтэйгөөр Монгол Улсын банк, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хадгаламж эзэмшигч, харилцагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс үүсгэн байгуулсан. Үүнээс хойш 13 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулахдаа Монголын банк, санхүүгийн салбар дахь өөрийн гэсэн дүр төрхийг бий болгож, орчин үеийн банкны үйлчилгээг ард иргэддээ саадгүй хүргэн ажиллаж ирсэн.

- Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /IFRS/-ын дагуу бэлтгэж, аудитын байгууллагаар баталгаажуулан, дүгнэлт гаргуулсан байна.

Төрийн банкны 2021 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланг “Эрнст энд янг монголиа аудит” ХХК хийн баталгаажуулсан байна. 2021 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланг “Эрнст энд янг монголиа аудит” ХХК дүгнэхдээ “Санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөлөөс баталж гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна” хэмээжээ. Компанийн санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүй мэдээллийг Аудитын тайлангаас дэлгэрүүлэн үзнэ үү.

- Үнэт цаас гаргагч нь сүүлийн жилд 5 000 000 000 /таван тэрбум/ төгрөгөөс доошгүй хэмжээний борлуулалтын орлоготой эсхүл 1 000 000 000 /нэг тэрбум/ төгрөгөөс доошгүй хэмжээний цэвэр ашигтай ажилласан байх ба орлого, зардал, цэвэр ашгийн тооцоололд үндсэн үйл ажиллагаанаас бусад орлого, зардал, онцгой шинжтэй олз, гарзыг тооцохгүй;

Төрийн банкны 2021 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн аудитлагдсан тайланд дурдсанаар үнэт цаас гаргагч нь 2021 онд 203,633,172,000 төгрөгийн орлоготой, 45,747,588,000 төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Компанийн санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүй мэдээллийг аудитын тайлангаас дэлгэрүүлэн үзнэ үү.

Сүүлийн 2 жилийн дотор компанийн гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүний 2/3 хэмжээнд болон сүүлийн 1 жилд хувьцааны хяналтын багц эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт ороогүй байх;

Төрийн банкны гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүний 2/3 хэмжээнд сүүлийн 2 жилийн дотор өөрчлөлт ороогүй бөгөөд хяналтын багц эзэмшигчдийн бүтцэд сүүлийн 1 жилд өөрчлөлт мөн ороогүй байна.

- Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх;

Төрийн банк нь Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 оны 3-р сарын 23-ны өдөр 145 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан "Компанийн засаглалын кодекс"-ийг компанийн дүрэм, дүрмийн төсөл болон ТУЗ-өөс баталсан журмуудад тусган үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Компанийн засаглалд хамаарах Компанийн дүрэм, журам нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Компанийн засаглалын кодекс, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 09 сарын 30-ны өдрийн №А-151 тоот тушаалаар батлагдсан Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 03 сарын 22-ны өдрийн №А-86 тоот тушаалаар батлагдсан Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан Банкны хэмжээнд дагаж мөрдвөл зохих дүрэм, журамд тус тус нийцсэн эсэх талаар Хуулийн дүгнэлтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

**Хувьцааны бүртгэлийн I ангилалд бүртгүүлэх үнэт цаас нь дараах шалгуур хангасан байна:**

- Үнэт цаасыг арилжаанд оруулах өдөр үнэт цаас гаргагчийн зах зээлийн үнэлгээ нь 10 000 000 000 /арван тэрбум/ төгрөгөөс дээш байх ба зах зээлийн үнэлгээг үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны тоо ширхэг болон олон нийтэд санал болгож буй үнээр тооцно;

Төрийн банкны үнэт цаасыг арилжаанд оруулах өдөр зах зээлийн үнэлгээ нь 10,000,000,000 төгрөгөөс дээш буюу 442,190,250,000 төгрөг байх юм. Шинээр 37,475,000 хувьцаа нэмж гаргаснаар нийт гаргасан хувьцааны тоо 749,475,000 болох бөгөөд нэгж хувьцааны олон нийтэд санал болгож буй үнэ 590 төгрөг байх юм.

- Үнэт цаас гаргагчийн Бирж дээр бүртгүүлэх нийт хувьцааны 25-аас доошгүй хувийг олон нийтэд санал болгосон байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаанд хэвээр хадгалагдах. 20 000 000 000 /хорин тэрбум/ төгрөгөөс дээш зах зээлийн үнэлгээтэй үнэт цаас гаргагчийн олон нийтэд эзэмшүүлэх хувь хэмжээнд хөнгөлөлт үзүүлж болно;

Төрийн банкны зах зээлийн үнэлгээ 442,190,250,000 төгрөг буюу 20,000,000,000 төгрөгөөс дээш зах зээлийн үнэлгээтэй тул бирж дээр

бүртгүүлэх нийт хувьцаа 25 хувиас доош буюу 5 хувийг олон нийтэд санал болгож байгаа болно.

- Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн тоо 100-аас доошгүй байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаанд хэвээр хадгалагдах;

Төрийн банкны хувьцаа эзэмшигчдийн тоо 100-аас доошгүй байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаанд хэвээр хадгалагдана.

- Бүртгүүлэх үнэт цаас нь барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр хязгаарлагдаагүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой байх.

Төрийн банкны бүртгүүлэх үнэт цаас нь барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр хязгаарлагдаагүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой байгаа болно.

## Хөрөнгө оруулалтын боломж

Үнэт цаас гаргагч нь нэгж хувьцаагаа 590 төгрөгөөр санал болгож байгаа бөгөөд 2024 онд бизнес төлөвлөгөөний дагуу ажиллахад хөрөнгө оруулагчид 45%-ийн өгөөж хүртэж болохоор таамаглаж байна. Доорх өгөөжийн тооцоолол нь үнэт цаас гаргагчийн ирэх 3 жилийн санхүүгийн төлөвлөгөөнд үндэслэн хувьцааны дансны үнэ болон үржүүлэгчийн харьцаагаар тооцоолж таамагласан бөгөөд үнэ-эздийн өмчийн (P/B) үржүүлэгчийг үнэлгээний тайлангийн жишгээр авсан болно.

*Хүснэгт 25. Нэгж хувьцааны өгөөж, Төрийн банкны санхүүгийн төсөөлөл дээр суурилсан*

| | 2022F | 2023F | 2024F |
|---|---|---|---|
| Нийт хувьцааны ширхэг | 749,475,000 | 749,475,000 | 749,475,000 |
| Цэвэр ашиг (сая төгрөг) | 32,402 | 62,670 | 84,066 |
| Эздийн өмч (сая төгрөг) | 449,994 | 509,525 | 593,591 |
| Дансны үнэ | 600.4 | 679.8 | 792.0 |
| Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS) | 43.2 | 83.6 | 112.2 |
| **Форвард үнэ-ашгийн харьцаа (P/E)-д суурилсан үнэлгээ** | | | |
| Форвард үнэ-ашгийн харьцаа (P/E), орон нутгийн банкуудын хувьд | 8.7 | 8.7 | 8.7 |
| Форвард (P/E)-д суурилсан ханш, орон нутгийн банкуудын хувьд | 376.1 | 727.5 | 975.8 |
| Форвард үнэ-ашгийн харьцаа (P/E), олон талт үйл ажиллагаатай банкуудын хувьд | 8.1 | 8.1 | 8.1 |
| Форвард (P/E)-д суурилсан ханш, олон талт үйл ажиллагаатай банкуудын хувьд | 350.2 | 677.3 | 908.5 |
| Үнэ-ашгийн харьцааны дундаж ханш | 363.2 | 702.4 | 942.2 |
| **Боломжит нийт үнэлгээ (сая төгрөг)** | 272,179 | 526,435 | 706,155 |
| **Үнэ-эздийн өмчийн харьцаа (P/B)-д суурилсан үнэлгээ** | | | |
| Эздийн өмчийн үнэлгээ (P/B) | 1.08 | 1.08 | 1.08 |
| Боломжит (P/B)-д суурилсан ханш | 648.4 | 734.2 | 855.4 |
| Жилийн өгөөж | 9% | 13% | 16% |
| IPO өгөөж 590₮ | 9% | 24% | 45% |
| **Боломжит нийт үнэлгээ (сая төгрөг)** | 485,994 | 550,287 | 641,078 |

УИХ-ын чуулганы 2022 оны 1 сарын 28-нд эхэлсэн ээлжит бус хурлаар 2022 оны төсөвт тодотгол хийсэн билээ. Уг хуулийн үйлчлэх хугацааг 2022 оныг дуустал хүчинтэй хэвээр байлгах шийдвэр гарсан ба ингэснээр харилцах, хугацаагүй хадгаламжийн дансанд хүү тооцохгүй байх хуулийн заалт үргэлжлэн хэрэгжихээр болсон. Энэ нь банкны харилцах, хугацаагүй хадгаламжид төлөх байсан банкны хүүгийн зардлыг бууруулж өгсөн юм. Мөн Монголбанкны бодлогын хүүгийн өсөлт нь мөнгөний захын суурь хүүг нэмэгдүүлснээр банкны хүүгийн орлого нэмэгдэх үндсэн нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд эдгээр зохицуулалтын арга хэмжээнүүд болон Төрийн банкны 2022 оны жилийн эхний хагасын урьдчилсан гүйцэтгэлийн тайлан дээр үндэслэн тус банкны жилийн цэвэр ашгийн хэмжээг өмнөх оноос 22.4 хувийн өсөлт үзүүлнэ гэж андеррайтерийн зүгээс таамаглав. 2020-2021 оны хооронд Төрийн банкны цэвэр ашгийн өсөлт 49.4 хувь байсан ба 2022 оны өсөлтийг 22.4 хувь буюу харьцангуй тогтвортой өсөлтийн түвшинд төсөөлсөн болно.

*Хүснэгт 26. Нэгж хувьцааны өгөөж, Андеррайтерийн санхүүгийн төсөөлөл дээр суурилсан*

| | 2022F | 2023F | 2024F |
|---|---|---|---|
| Нийт хувьцааны ширхэг | 749,475,000 | 749,475,000 | 749,475,000 |
| Цэвэр ашиг (сая төгрөг) | 56,000 | 62,670 | 84,066 |
| Эздийн өмч (сая төгрөг) | 473,592 | 533,122 | 617,188 |
| Дансны үнэ | 631.9 | 711.3 | 823.5 |
| Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS) | 74.7 | 83.6 | 112.2 |
| **Форвард үнэ-ашгийн харьцаа (P/E)-д суурилсан үнэлгээ** | | | |
| Форвард үнэ-ашгийн харьцаа (P/E), орон нутгийн банкуудын хувьд | 8.7 | 8.7 | 8.7 |
| Форвард (P/E)-д суурилсан ханш, орон нутгийн банкуудын хувьд | 650.1 | 727.5 | 975.8 |
| Форвард үнэ-ашгийн харьцаа (P/E), олон талт үйл ажиллагаатай банкуудын хувьд | 8.1 | 8.1 | 8.1 |
| Форвард (P/E)-д суурилсан ханш, олон талт үйл ажиллагаатай банкуудын хувьд | 605.2 | 677.3 | 908.5 |
| Үнэ-ашгийн харьцааны дундаж ханш | 627.6 | 702.4 | 942.2 |
| **Боломжит нийт үнэлгээ (сая төгрөг)** | 470,400 | 526,435 | 706,155 |
| **Үнэ-эздийн өмчийн харьцаа (P/B)-д суурилсан үнэлгээ** | | | |
| Эздийн өмчийн үнэлгээ (P/B) | 1.08 | 1.08 | 1.08 |
| Боломжит (P/B)-д суурилсан ханш | 682.5 | 768.2 | 889.4 |
| Жилийн өгөөж | 15% | 12% | 15% |
| IPO өгөөж 590₮ | 15% | 30% | 50% |
| **Боломжит нийт үнэлгээ (сая төгрөг)** | 511,479 | 575,772 | 666,563 |

АНУ-ын S&P 500 индекс буюу олон нийтэд нээлттэй 500 орчим компанийн үнэ -ашгийн харьцааны 27 жилийн түүхэн өгөгдөл дээр үндэслэн хувьцааны зохимжтой зах зээлийн үржүүлэгчийг тооцож гаргасан. Тус индексэд багтдаг Санхүүгийн салбарын компаниудаас бүс нутаг, мужуудад олон салбартай, харилцах хадгаламжаа салбарын харилцагчдаар дамжуулж эх үүсвэрээ бүрдүүлдэг Монгол улсын хувь хэрэглэгчдэд чиглэсэн банкуудын бизнес загвартай тун төстэй хэв шинж бүхий орон нутгийн (Regional banks) банкуудын үзүүлэлтийг ашигласан.

Мөн Монгол улсын арилжааны банкуудын үзүүлж буй олон төрлийн уламжлалт санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлдэг олон талт үйл ажиллагаатай (diversified banks) банкуудын үнэ-ашгийн харьцааг үнэлгээнд ашигласан болно. Энэхүү хоёр төрлийн дэд салбарын банкуудын үнэ-ашгийн харьцааны (P/E ratio) гэнэтийн хэт өндөр өсөлт, бууралтыг нөлөөг багасгаж тооцсон нормчлогдсон үнэ-ашгийн харьцааг зохиомжтой үзүүлэлт болгож сонгон тооцсон.

Үнэ-ашгийн харьцаа үржүүлэгч нь эерэг ашигт ажиллагаатай компаниудын үнэлгээнд ашигладаг зах зээл дээр суурилсан түгээмэл үнэлгээний аргачлал юм. Энэхүү үржүүлэгчийг тооцоход тухайн тайлант үеийн нэгж хувьцаанд ногдох буй ашгийн хэмжээг ашигладаг учраас ирээдүйн ашгийн өсөлтийг илэрхийлэхгүй байх сул талтай байдаг. Иймээс ирээдүйн ашгийн өсөлтийг үнэлгээнд тусгахын тулд форвард үнэ-ашгийн харьцааг ашигласан болно.

Яардани судалгааны төвөөс (Yardeni Research) гаргасан мэдээнд форвард үнэ-ашгийн харьцаа 2022 оны 6-р сарын 16-ны өдрийн байдлаар орон нутгийн банкуудын хувьд 8.7, олон талт үйл ажиллагаатай банкуудын хувьд 8.1 байгаа бөгөөд энэхүү харьцаа нь түүхэн дундаж руу ойртсон үзүүлэлт гэж үзэж хувьцааны харьцуулсан үнэлгээнд ашиглав.

Үнэт цаас гаргагчийн хувьцааны үнэлгээг форвард үнэ-ашгийн үржүүлэгчийн аргаар тооцоход 2022 онд орон нутгийн банкны дэд салбарын үржүүлэгчээр 650.1 төгрөг, олон талт үйл ажиллагаатай банкны дэд салбарын үржүүлэгчээр 605.2 төгрөг, үнэ-дансны үнийн харьцааны үржүүлэгчээр 682.5 буюу нэрлэсэн хувьцааны үнэ 590.0 төгрөгөөс тус бүр харгалзан 10.1%, 2.5% болон 15.6%-аар хувиар өсөж бодит үнэлгээндээ ойртох хөрөнгө оруулалтын ашгийн боломжийг илэрхийлж байна. Гэхдээ андеррайтерийн зүгээс эдийн засгийн орчны огцом суурь өөрчлөлт, урьдчилж таамаглагдаагүй шок нь тооцоолсон хувьцааны үнэлгээг өөрчлөх боломжтой гэдгийг хөрөнгө оруулагчдад анхааруулж байна.

## Нийт хөрөнгө болон өөрийн хөрөнгийн өгөөж

Банкны өөрийн хөрөнгийн өгөөж нь 2022 онд 7.2%, 2023 онд 12.3% хувь болох тооцоололтой байгаа ба цаашид өссөөр 14.2% байх төсөөлөлтэй байна. Харин нийт хөрөнгийн өгөөж 2022 оноос 2024 оны хооронд дунджаар 1.3% болох төлөвтэй байна.

*График 53. Нийт хөрөнгийн болон өөрийн хөрөнгийн өгөөж*




Банкны харьцаа үзүүлэлтийн шинжилгээнээс харахад банкны орлого, цэвэр ашгийн хэмжээ өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд хөрөнгийн эргэц мөн өссөн үзүүлэлттэй байна. Төрийн банк нь үйл ажиллагаагаа өргөжүүлж, харилцагчийн тоогоо нэмэгдүүлснээр цэвэр ашиг 2024 он хүртэл дунджаар 61% өсөх төлөвтэй байна.

## Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах талаар

Хувьцааг анхдагч зах зээлд арилжаалах аргачлал

Үнэт цаас гаргагч нь хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг Монголын хөрөнгийн биржтэй анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах гэрээ байгуулан явуулах ба үнэт цаасыг МХБ-ийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 4 дүгээр бүлэгт заасан “Тогтоосон үнийн арга”-ыг ашиглан санал болгоно.

Тогтоосон үнийн аргаар хийх арилжаа нь МХБ-ийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.1.3-т зааснаар үнэт цаас гаргагчийн тогтоосон тодорхой үнээр санал болгон арилжих үйл ажиллагааг хэлэх бөгөөд Үнэт цаас гаргагч нь хувьцааг анхдагч зах зээлд санал болгох үнийг тогтоосон байна.

Стратегийн хөрөнгө оруулагч

Монголын хөрөнгийн биржийн Үнэт цаасны анхдагч арилжааны журмын 3.4-т заасанаар Стратегийн хөрөнгө оруулагч гэж Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд давуу талыг бий болгох, үнэт цаасаа 6-аас доошгүй сарын хугацаанд тусгаарлуулах үүрэгтэй хөрөнгө оруулагчийг стратегийн хөрөнгө оруулагч гэж ойлгоно. Олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээнээс нийт захиалгын хэмжээ давсан тохиолдолд стратегийн хөрөнгө оруулагч бүрийн захиалгын хувь тэнцүүлэх аргачлалд оруулалгүйгээр шууд биелүүлэн тооцно.

Нийт худалдан авах захиалгын тоо ширхэг нь нийт санал болгосон үнэт цаасны тоо ширхгээс илүү гарсан тохиолдолд хувь тэнцүүлэх аргыг ашиглан үнэт цаасны хуваарилалтыг хийнэ.

## Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны төлөвлөгөө

Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссанаас хойш ажлын гурван өдөрт багтаан арилжааны тайланг СЗХ-нд хүргүүлнэ. СЗХ нь уг тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийх болон арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус ажлын гурван өдөрт багтаан олгоно.

## Хувьцаатай холбоотой шимтгэл ба орлогын албан татвар

Хувьцааны арилжааны шимтгэл

Хөрөнгө оруулагч нь хувьцааны арилжааны шимтгэлийг хувьцааг зуучлуулан авсан брокерын компанид төлнө. Үнэт цаас борлуулсан орлогын албан татварыг арилжаанд оролцсон хувь хүн, аж ахуйн нэгж жилийн эцэст нэг удаа доорх байдлаар төлнө. Үүнд:

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т заасан “хувьцаа, үнэт цаас, санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлого”-д 20 дугаар зүйлийн 20.1-д заасанаар 10 хувийн татвар, 9 дүгээр зүйлийн 9.1.3-т заасан “ногдол ашгийн орлого”-д 20 дугаар зүйлийн 20.2.1-д заасанаар 10 хувийн татвар тус тус ногдуулна.

Хувь хүний орлогын албан татвар

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-т заасан “ногдол ашгийн орлого”, 10 дугаар зүйлийн 10.1.4-т заасан “хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлого”-д тус хуулийн 21.5-д заасанаар 5 хувиар албан татвар ногдуулна.

## Хөрөнгө оруулагчдад зөвлөх нь

Үнэт цаас гаргагч болох Төрийн банк нь Монголын хөрөнгийн биржид үнэт цаасаа санал болгон нээлттэй хувьцаат компани болохоор зорьж ирсэн ба энэхүү андеррайтерийн дүгнэлтэд дурдсанчлан Монголын хөрөнгийн биржийн хувьцааны I ангиллын шалгуурыг хангаж байгаа юм.

Хөрөнгө оруулагчид нь Төрийн банкны хувьцааг авснаар системд нөлөө бүхий 5 том банкны нэг, салбарын тоогоор тэргүүлэгчдийн нэг, дундаж давхаргыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа явуулагч банкны ирээдүйн боломжуудаас ашиг хүртэх боломжтой болох юм. Банкны салбар 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт активын хэмжээ 41.04 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны жилийн эцсээс 11.8 хувиар буюу 4.3 их наяд төгрөгөөр өссөн байна. Энэхүү үзүүлэлтийг 5 болон 10 жилийн өмнөх үзүүлэлттэй харьцуулахад 61.9 хувь болон 337.6 хувиар тус тус өссөн байна. Харин Банкны салбарын цэвэр ашгийн хэмжээ 2020 оны жилийн эцсээр 289.5 тэрбум төгрөг байсан бол 2021 оны эцсээр 548.6 тэрбум төгрөг болж өссөн байгаа нь банкны салбар цаашид илүү их өсөлт үзүүлэх боломжтойг харуулж байна.

Үнэт цаас гаргагч нь өөрийн хувьцааг 590 төгрөгөөр олон нийтэд санал болгож байгаа нь дотоод үнэ цэнэ болох 659 төгрөгөөс 10.54 хувь хямдруулсан үнэ юм. Үнэт цаас гаргагч нь өөрийн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэн, үйл ажиллагааг амжилттай өргөжүүлснээр эхний жилд 9 хувийн өгөөж, дунд хугацаандаа буюу 3 жилд 45 хувийн өгөөжийг хүртэх боломжтой хэмээн тооцоолж байна.

Хөрөнгө оруулагч нь аливаа өгөөж болон эрсдэлийг харьцуулан дүн шинжилгээ хийн, ирээдүйд үнэт цаас гаргагч банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг харгалзан үзэж дүгнэсний эцэст хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд дотоод болон гадаад хүчин зүйлүүд нөлөөлж болох бөгөөд үүнд зээлийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, нэр хүндийн эрсдэл, макро эдийн засгийн эрсдэл, технологийн эрсдэл зэрэг багтана. Хөрөнгө оруулагч нь үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын тухай мэдээллийг энэхүү үнэт цаасны танилцуулгын 95-99 дүгээр хуудаснаас дэлгэрүүлэн унших боломжтой.

## Дүгнэлт

"Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК нь андеррайтерийн үйлчилгээний хүрээнд хийсэн дээрх болон бусад шинжилгээ, тооцоолол, судалгаа, үнэт цаас гаргахтай холбогдуулан бусад мэргэжлийн байгууллагуудын хийсэн тайлан дүгнэлтүүдэд үндэслэн Төрийн банкны хувьцааг олон нийтэд санал болгон арилжаалах боломжтой гэж дүгнэсэн.

2021 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн УИХ-ын намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу банк олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсноор банкны хувьцаа эзэмшлийн төвлөрөл буурч, өмчлөл-удирдлага-хяналтын тэнцвэртэй байдлыг бүрдүүлэх ач холбогдолтой. Түүнчлэн арилжааны банкуудад хувьцаа эзэмшил, удирдлагын төвлөрсөн байдлаас үүдэлтэй эрсдэл буурч, банкны хувьцааны эзэмшил, мэдээллийн хүртээмжээр дамжуулан олон нийтийн хяналт бий болох, зах зээлийн дохиолол бүрдэх, банкны хяналт шалгалтын бие даасан байдал нэмэгдэх тул олон нийтэд өөрийн хувьцаагаа санал болгож байна.

Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс нийтэд санал болгон гаргах үнэт цаас, түүний танилцуулгыг бүртгэсэн, нийтэд санал болгох болон үнэт цаасны анхдагч зах зээлд худалдах зөвшөөрөл олгосныг тухайн үнэт цаасанд өгч байгаа баталгаа гэж үзэхгүй бөгөөд үнэт цаасыг худалдан авсны улмаас хөрөнгө оруулагчид учирсан хохирлыг бүртгэсэн байгууллага хариуцахгүй гэдгийг хөрөнгө оруулагч та анхаарна уу.

Энэ хувьцааг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ямагт эрсдэлтэй үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, үнэт цаасны танилцуулга, хувьцаа гаргах ажиллагааг сайтар анхааран

судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

Мөн хөрөнгө оруулагч нь үнэт цаас гаргагчийн танилцуулгын бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөлөл зэрэг хэсэгт тусгагдсан урьдчилсан төсөөллүүд нь олон тооны таамаглалд суурилсан ба бодит бизнес, үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн байдал, салбарын хөгжил нь энэхүү үнэт цаасны танилцуулгад тусгагдсан урьдчилсан төсөөллөөс материаллаг зөрүүтэй байж болно гэдгийг анхаарна уу.

СЗХ 2022.09.21 өдөр БҮРТГЭВ

MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-09-14 БҮРТГЭВ-03

# БАТЛАХ ХУУДАС

Бирж болон Хороонд хүргүүлж байгаа танилцуулга адил, ямар нэг зөрүүтэй мэдээлэл тусгагдаагүй болно.

Үнэт цаас гаргагчийн хувьцааг олон нийтэд анх удаа санал болгох үйл ажиллагаанд оролцогч мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь хоорондоо болон Үнэт цаас гаргагчтай аливаа сонирхлын зөрчилгүй болно.

Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл үнэн зөв болохыг батлав.

| | |
|---|---|
| *Овог, нэр: Б.Тэлмүүн*<br>*Албан тушаал: Үнэт цаас гаргагч "Төрийн банк" ХХК-ийн ТУЗ-ийн дарга*<br>*Гарын үсэг:..........................*<br>*(Тамга/тэмдэг)* | *Овог, нэр: Б. Өлзийбаяр*<br>*Албан тушаал: Андеррайтерийн "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК -ийн Гүйцэтгэх захирал*<br>*Гарын үсэг:..........................*<br>*(Тамга/тэмдэг)* |
| *Овог, нэр: Ө. Гантөр*<br>*Албан тушаал: Үнэт цаас гаргагч "Төрийн банк" ХХК-ийн гүйцэтгэх захирал*<br>*Гарын үсэг:..........................*<br>*(Тамга/тэмдэг)* | *Овог, нэр: У. Энхтайван*<br>*Албан тушаал: Андеррайтерийн "Гүүдсек ҮЦК" ХХК -ийн гүйцэтгэх захирал*<br>*Гарын үсэг:..........................*<br>*(Тамга/тэмдэг)* |
| *Овог, нэр: М.Гантуяа*<br>*Албан тушаал: Үнэт цаас гаргагч "Төрийн банк" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогчийг төлөөлж Санхүү хариуцсан захирал*<br>*Гарын үсэг:..........................*<br>*(Тамга/тэмдэг)* | |

СЭХ
2022 .08р 21 өдөр
БҮРТГЭВ
№ 31

СЗХ
2022 оны 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-14
БҮРТГЭВ-03

# ХАВСРАЛТ -1 Аудитын дүгнэлт

**ТӨРИЙН БАНК ХХК**

**(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)**

**Аудитлагдсан санхүүгийн тайлан**
**2021 оны 12 дугаар сарын 31**

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -09- 14
БҮРТГЭВ-03

**ТӨРИЙН БАНК ХХК**

**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

| АГУУЛГА | ХУУДАС |
|---|---|
| БАНКНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ | 1 |
| ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ | 2 |
| ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3 – 4 |
| АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН | 5 |
| САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН | 6 |
| ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН | 7 |
| МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН | 8 |
| САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД | 9 – 91 |

СЭХ
2022 .09. 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -09- 14
БҮРТГЭВ-03

**ТӨРИЙН БАНК ХХК**

**БАНКНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

---

| | |
|---|---|
| **ТУЗ-ИЙН ГИШҮҮД:** | Жигжидийн Ганбат<br>Ургамалын Бямбасүрэн<br>Пүрэвжавын Сайнзориг<br>Мишигийн Батжаргал<br>Данзанбалжирын Энхжаргал<br>Сосорын Цэнд-Аюуш |
| **НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:** | Ганболдын Баясгалан |
| **АЛБАН ХАЯГ:** | Төрийн Банк ХХК-ийн байр<br>Бага тойруу – 7/1, 1-р Хороо,<br>Чингэлтэй Дүүрэг,<br>Улаанбаатар-210644,<br>Монгол Улс |
| **АУДИТОРУУД:** | Эрнст энд Янг Монголия Аудит ХХК<br>Мэргэшсэн нягтлан бодогчид |



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК
ТТБ3674 5208173

**ТӨРИЙН БАНК ХХК**

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ**

---

Төрийн Банк ХХК-ийн (цаашид "Банк" гэх) Төлөөлөн Удирдах Зөвлөл ("ТУЗ")- ийн дарга Жигжидийн Ганбат, Гүйцэтгэх захирал Өлзийгийн Гантөр болон Санхүү хариуцсан дэд захирал Долгоржавын Баттулга, бид энэхүү тайлангийн 5 – 91 дугаар хуудсанд үзүүлсэн, Банкны санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

ЖИГЖИДИЙН ГАНБАТ
(Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга)

ӨЛЗИЙГИЙН ГАНТӨР
(Гүйцэтгэх захирал)

ДОЛГОРЖАВЫН БАТТУЛГА
(Санхүү хариуцсан дэд захирал)

Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2022 оны 3 сарын 15

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭВ-03
2022.09.21

EY
Building a better working world

Ernst & Young Mongolia Audit LLC
Suite 200, 8 Zovkhis Building
Seoul Street 21
Ulaanbaatar 14251
Mongolia

Tel : +976 11 314032 / +976 11 312005
Fax : +976 11 312042
ey.com

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**Төрийн Банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд**

---

**Дүгнэлт**

Бид Төрийн Банк ХХК ("Банк")-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Банкны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд ("СТОУС")-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн *"Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага"* хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм" болон "Хараат бус байдлын олон улсын стандарт"-ийн дагуу Банкнаас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

**Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага**

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Банкны удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Банкны үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Банкны үйл ажиллагаар тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй. Засаглал хариуцсан этгээдүүд нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

**Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч "АОУС"-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг тооцогдоно.

"АОУС"-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД ЭНД КО
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5362
УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

СЭХ
2022 .03 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ТӨРИЙН БАНК
2022 -03- 14
БҮРТГЭВ-03

EY
Building a better working world

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)**

**Төрийн Банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)**

---

**Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)**

- Банкны дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Банкны тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

**Бусад зүйл**

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Банкны хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Банкны хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Ernst & Young Mongolia Audit LLC

**ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК**
Мэргэшсэн нягтлан бодогчид

| **Гарын үсэг зурсан** | **Баталсан** |
|---|---|
| Хабылхайрат Буланбай | Адриан Чу |
| Захирал | Партнер |

Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2022 оны 3 дугаар сарын 15



УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭВ-03

**ТӨРИЙН БАНК ХХК**

**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН**

**АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

| | Тод. | 2021 мян.төг | 2020 мян.төг |
|---|---|---|---|
| Үр ашигт хүүгийн аргачлалаар бодсон хүүгийн орлого | 5 | 363,500,188 | 345,091,373 |
| Бусад хүү болон түүнтэй адилтгах орлого | 5 | 21,973,641 | 22,758,027 |
| Хүү болон түүнтэй адилтгах зардал | 6 | (190,640,521) | (234,022,180) |
| **Цэвэр хүүгийн орлого** | | **194,833,308** | **133,827,220** |
| Хураамж ба шимтгэлийн орлого | 7 | 29,053,607 | 26,217,733 |
| Хураамж ба шимтгэлийн зардал | 7 | (6,718,631) | (5,379,633) |
| **Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого** | | **22,334,976** | **20,838,100** |
| Арилжааны цэвэр орлого | 8 | 4,006,641 | 13,601,732 |
| Үйл ажиллагааны бусад зардал | 9 | (17,541,753) | (7,076,623) |
| **Үйл ажиллагааны орлого** | | **203,633,172** | **161,190,429** |
| Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн зардал | 10 | (32,012,890) | (17,239,843) |
| **Үйл ажиллагааны цэвэр орлого** | | **171,620,282** | **143,950,586** |
| Үйл ажиллагааны зардал | 11 | (110,605,423) | (104,701,615) |
| **Татварын өмнөх ашиг** | | **61,014,859** | **39,248,971** |
| Орлогын албан татварын зардал | 12 | (15,267,271) | (8,637,086) |
| **Тайлант жилийн ашиг** | | **45,747,588** | **30,611,885** |
| **Нэгж хувьцаанд ноогдох ашиг** | | | |
| Хувьцаа эзэмшигчдэд хуваарилах тухайн жилийн ашиг, үндсэн | 30 | **272.94** | **228.62** |
| Хувьцаа эзэмшигчдэд хуваарилах тухайн жилийн ашиг, хорогдуулсан | 30 | **272.94** | **171.98** |
| **Бусад дэлгэрэнгүй орлого (татварын дараах):** | | | |
| *Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдах бусад дэлгэрэнгүй орлого – (татварын дараах):* | | | |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэгслийн бодит үнэ цэнийн цэвэр өөрчлөлт | 30 | (4,987,873) | 6,231,419 |
| *Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдахгүй бусад дэлгэрэнгүй орлого – (татварын дараах):* | | | |
| Нийгмийн хөгжлийн сангийн зарцуулалт | 30 | (37,378) | (13,243) |
| **Бусад дэлгэрэнгүй орлого/(зардал)** | | **(5,025,251)** | **6,218,176** |
| **Тайлант жилийн татварын дараах нийт дэлгэрэнгүй орлого** | | **40,722,337** | **36,830,061** |

***Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.***



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469
УЛААНБААТАР ХОТ
ЕРХЭСБЕК ҮЦК ХХК

СЭХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ТӨРИЙН БАНК
2022 -09- 14
БҮРТГЭВ-03

**ТӨРИЙН БАНК ХХК**

**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

| | Тод. | 2021 оны 12 сарын 31 мян.төг | 2020 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | |
| Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах | 13 | 250,920,691 | 238,774,076 |
| Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж | 14 | 28,534,316 | 21,932,821 |
| Үүсмэл санхүүгийн хэрэгсэл | 15 | 759,107 | 165,759 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 16 | 2,237,147,348 | 1,754,078,880 |
| Санхүүгийн хөрөнгө оруулалт – арилжаалах зорилалттай | 17 | 7,310,813 | 47,955,448 |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө | 17 | 80,844,572 | 41,984,457 |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэгсэл | 18 | 967,315,767 | 1,217,540,739 |
| Хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн хэрэгсэл | 18 | 67,786,597 | – |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэгсэл | 18 | 118,385 | 119,658 |
| Бусад хөрөнгө | 19 | 21,266,799 | 26,836,566 |
| Борлуулах зорилалттай хөрөнгө | 20 | 6,762,299 | 4,593,611 |
| Хөрөнгө оруулалтын зорилалттай үл хөдлөх хөрөнгө | 21 | 2,364,878 | – |
| Үндсэн хөрөнгө | 22 | 115,918,630 | 119,645,215 |
| Биет бус хөрөнгө | 23 | 5,630,775 | 5,445,776 |
| Ашиглах эрхийн хөрөнгө | 24 | 53,279 | 3,195,396 |
| **Нийт хөрөнгө** | | **3,792,734,256** | **3,482,268,402** |
| **Өр төлбөр** | | | |
| Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж | 25 | 115,952,799 | 134,165,793 |
| Репо хэлцэл | 26 | 153,809,693 | 71,242,456 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 27 | 2,856,798,045 | 2,678,442,356 |
| Үүсмэл санхүүгийн хэрэгсэл | 15 | 1,549,920 | 596,957 |
| Зээлээр авсан санхүүжилт | 28 | 252,376,321 | 227,021,274 |
| Бусад өр төлбөр | 29 | 15,847,976 | 12,989,278 |
| Түрээсийн өглөг | 24 | 234,557 | 4,011,845 |
| Орлогын татварын өглөг | 12 | 4,865,246 | 2,126,460 |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 12 | 2,815,761 | 3,910,382 |
| **Нийт өр төлбөр** | | **3,404,250,318** | **3,134,506,801** |
| **Эздийн өмч** | | | |
| Энгийн хувьцаа | 30 | 178,000,000 | 133,900,000 |
| Бусад нөөц | 30 | 29,368,212 | 34,393,463 |
| Хоёрдогч өглөг | 31 | – | 44,100,000 |
| Хуримтлагдсан ашиг | | 181,115,726 | 135,368,138 |
| **Нийт эздийн өмч** | | **388,483,938** | **347,761,601** |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | | **3,792,734,256** | **3,482,268,402** |

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.*



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
5183935
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469
УЛААНБААТАР ХОТ
ГҮЙЦЭТГЭХ
ТТБ8674 5208173

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭВ-03

**ТӨРИЙН БАНК ХХК**

**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН**

**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

| | **Энгийн хувьцаа мян.төг** (Тод. 30) | **Нөөцийн сан мян.төг** (Тод. 30) | **Хуримтлагдсан ашиг мян.төг** | **Хоёрдогч өглөг мян.төг** (Тод. 31) | **Нийт өөрийн хөрөнгө мян.төг** |
|---|---|---|---|---|---|
| **2020 оны 1 дүгээр сарын 1-ээр** | 133,900,000 | 28,256,856 | 104,674,684 | 44,100,000 | 310,931,540 |
| Тайлант жилийн ашиг | – | – | 30,611,885 | – | 30,611,885 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | – | 6,218,176 | – | – | 6,218,176 |
| **Нийт дэлгэрэнгүй орлого** | – | **6,218,176** | **30,611,885** | – | **36,830,061** |
| Хэрэгжсэн дахин үнэлгээний нөөц | – | (81,569) | 81,569 | – | – |
| **2020 оны 12 сарын 31 болон 2021 оны 1 сарын 1-ээр** | **133,900,000** | **34,393,463** | **135,368,138** | **44,100,000** | **347,761,601** |
| Тайлант жилийн ашиг | – | – | 45,747,588 | – | 45,747,588 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | – | (5,025,251) | – | – | (5,025,251) |
| **Нийт дэлгэрэнгүй орлого** | – | **(5,025,251)** | **45,747,588** | – | **40,722,337** |
| Хувьцаа руу хөрвөсөн хоёрдогч өглөг | 44,100,000 | – | – | (44,100,000) | – |
| **2021 оны 12 сарын 31-ээр** | **178,000,000** | **29,368,212** | **181,115,726** | – | **388,483,938** |

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.*



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 СТ5382
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК

СЗХ 2022 .09. 21 он сар өдөр БҮРТГЭВ № 01

ТӨРИЙН БАНК ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022 -09- 14 БҮРТГЭВ-03

**ТӨРИЙН БАНК ХХК**

**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

| | Тод. | 2021 мян.төг | 2020 мян.төг |
|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| **Татварын өмнөх ашиг** | | 61,014,859 | 39,248,971 |
| *Тохируулгууд:* | | | |
| Санхүүгийн деривативуудын бодит үнэ цэнийн өөрчлөлт | | 359,615 | 343,511 |
| Арилжаалах зориулалттай санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт | | (733) | (406,437) |
| Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн эрсдэлийн сан | 9 | 3,553,750 | 2,711,103 |
| Зээл ба авлагын үнэ цэнийн бууралтын хүлээгдэж буй алдагдал | 10 | 32,012,890 | 17,239,843 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | 11 | 13,147,220 | 11,531,525 |
| Биет бус хөрөнгийн хорогдуулга | 11 | 924,743 | 1,551,200 |
| Ашиглах эрхтэй хөрөнгийн хорогдуулга | 11 | 3,621,726 | 3,142,157 |
| Үндсэн хөрөнгө борлуулсны гарз | | – | 12,662 |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз | 11 | 174,792 | 367,349 |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз | 11 | – | 10,351 |
| Зээлээр авсан эх үүсвэрийн хүүгийн зардал | 32 | 7,201,098 | 11,736,041 |
| Гэрээний нөхцөл өөрчлөлтийн цэвэр алдагдал | 9,32 | 13,930,889 | 8,210,795 |
| Гэрээний нөхцөл өөрчлөлтийн алдагдлаас үүссэн цэвэр хүүгийн хорогдол | 32 | (10,429,557) | (4,737,894) |
| Түрээсийн өглөгийн хүүгийн зардал | 6 | 344,962 | 946,004 |
| Нийгмийн хөгжлийн сангийн зарцуулалт | 30 | (37,378) | (13,243) |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн бус гүйлгээ | | 32,110 | 38,288 |
| **Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг** | | **125,850,986** | **91,932,226** |
| Үйл ажиллагааны хөрөнгө өр төлбөрийн өөрчлөлтүүд: | | | |
| Монголбанкинд заавал байлгах нөөц | | (22,735,604) | 95,242,143 |
| Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж | | (142,535) | (165,787) |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | | (516,812,315) | (42,104,098) |
| Бусад хөрөнгө | | 1,638,393 | 1,637,339 |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө | | (2,168,688) | 822,821 |
| Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж | | (18,212,994) | 34,117,846 |
| Репо хэлцэл | | 82,567,237 | 71,242,456 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | | 178,355,689 | 103,211,544 |
| Бусад өр төлбөр | | 2,858,698 | 1,257,325 |
| **Үйл ажиллагаанд (зарцуулсан)/олсон мөнгөн гүйлгээ** | | **(168,801,133)** | **357,193,815** |
| Орлогын албан татварын төлөлт | 12 | (11,961,341) | (8,376,870) |
| Түрээсийн өглөгийн хүүгийн хэсэгт хамаарах төлөлт | 32 | (344,962) | (946,004) |
| Зээлээр авсан эх үүсвэрт төлсөн хүү | 32 | (6,383,780) | (11,884,467) |
| **Үйл ажиллагаанд (зарцуулсан)/олсон цэвэр мөнгөн гүйлгээ** | | **(187,491,216)** | **335,986,474** |
| | | | |
| **Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ** | | | |
| Санхүүгийн хөрөнгө оруулалт худалдан авалт | | (18,334,174,054) | (11,360,858,464) |
| Санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсны орлого | | 18,359,834,907 | 11,228,001,903 |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | – | 35,738 |
| Үндсэн хөрөнгө худалдан авалт | 22 | (11,960,305) | (19,079,792) |
| Биет бус хөрөнгө худалдан авалт | 23 | (1,109,742) | (4,205,423) |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд олсон/(зарцуулсан) цэвэр мөнгөн гүйлгээ** | | **12,590,806** | **(156,106,038)** |
| | | | |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Зээлээр татсан эх үүсвэр | 32 | 274,843,524 | 253,898,499 |
| Зээлээр татсан эх үүсвэрийн эргэн төлөлт | 32 | (250,173,749) | (315,543,373) |
| Түрээсийн өглөгийн үндсэн хэсэгт хамаарах төлөлт | 32 | (4,256,897) | (3,346,939) |
| **Санхүүгийн үйл ажиллагаанд олсон/(зарцуулсан) цэвэр мөнгөн гүйлгээ** | | **20,412,878** | **(64,991,813)** |
| | | | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт)/өсөлт** | | **(154,487,532)** | **114,888,623** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 952,485,725 | 837,597,102 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 32 | **797,998,193** | **952,485,725** |
| | | | |
| **Мөнгөн бус үйл ажиллагаанууд:** | | | |
| Ашиглах эрхийн хөрөнгө | 24 | 479,609 | – |
| Түрээсийн өглөг | 24 | (479,609) | – |

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.*



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК

УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

СЗХ
2022 .09. 21
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022 -09- 14
БҮРТГЭВ-03

**ТӨРИЙН БАНК ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2021 ОНЫ 12 САРЫН 31**

## 1. БАНКНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тус банк нь Монголбанкнаас ("МБ") олгосон 26 тоот зөвшөөрлийн дагуу банк, санхүүгийн үндсэн үйлчилгээ үзүүлдэг. Тайлант жилийн хугацаа буюу 2021 онд Банкны үйл ажиллагаанд ямар нэг томоохон өөрчлөлт гараагүй. Банк нь Монгол улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Банкны төв байрны албан ёсны хаяг нь Төрийн Банк ХХК-ийн байр, Бага тойруу-7/1, 1-р Хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот - 210644, Монгол Улс.

Банкны хувьцааны 52.25% -ийг (2020: 36.52%) Монгол улсын Сангийн яам болон 47.75% -ийг (2020: 63.48%) Монгол Улсын Хадгаламжийн Даатгалын Корпораци эзэмшдэг. Хадгаламжийн даатгалын корпорацийг Монгол Улсын Засгийн газар хянадаг аж ахуйн нэгж бөгөөд банкинд саналын эрхгүй.

Төрийн Банк ХХК нь 2022 оны 3 дугаар сарын 15-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрээр Банкны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлангуудыг баталж, нийтэд мэдээлэхийг зөвшөөрсөн.

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО

### 2.1 Тайлан бэлтгэх үндэслэл

Банкны санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталж гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")-ын дагуу бэлтгэгдсэн болно.

Санхүүгийн тайлангууд нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн болон өмчийн хэрэгсэл, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хэрэгсэл, бодит үнэ цэнийн аргаар бүртгэгдэх үүсмэл санхүүгийн хэрэгсэл болон хөрөнгүүдээс бусад тохиолдолд түүхэн өртгийн зарчмаар бэлтгэгдсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд мянгачилан, Банкны үйл ажиллагааг Монгол Улсын мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр тайлагнасан.

### 2.2 Санхүүгийн тайлангийн толилуулга

Банк нь санхүүгийн байдлын тайлангийн зүйлсийг хөрвөх чадварынх нь дараалалаар толилуулсан. Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараах 12 сарын дотор (богино хугацаанд) ба 12 сараас хойших хугацаанд (урт хугацаанд) хүлээн авах эсвэл төлөх төлбөрийн талаарх шинжилгээг тодруулга 37-д толилуулсан.

Ирээдүйн үйл явдлаас хамааралгүйгээр хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй ба доорх бүх нөхцөлд цэвэр дүнгээр нь барагдуулах хандлагатай байгаа үед санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлж, цэвэр дүнг санхүүгийн байдлын тайланд толилуулна. Үүнд:

- Бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед
- Чанаргүйдэл гарсан үед
- Банк эсвэл түүний хамтрагч талууд төлбөрийн чадваргүй болсон эсвэл дампуурсан үед.

Мастер цэвэршүүлэлтийн гэрээтэй үүсмэл хөрөнгө болон өр төлбөрийг зөвхөн чанаргүйдэл үүссэн үед биш дээрх бүх нөхцлүүдэд цэвэршүүлэлтийн шаардлага хангаж байгаа үед зөвхөн цэвэр дүнгээр нь толилуулна.

### 2.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба толилуулгад орсон өөрчлөлтүүд

Банк 2021 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойших хугацаанд хүчин төгөлдөр болсон зарим стандартууд болон нэмэлт өөрчлөлтийг анх удаа хэрэгжүүлж эхэлсэн. Банк бусад батлагдсан стандарт болон стандартын тайлбар, нэмэлт өөрчлөлтүүдийг хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хугацаанаас нь өмнө хэрэгжүүлээгүй болно.

- СТОУС 9, НББОУС 39, СТОУС 7, СТОУС 4 ба СТОУС 16-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд — *Жишиг зээлийн хүүгийн шинэчлэл (ЖЗХШ)- 2-р үе шат*
- СТОУС 16-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд — *2021 оны 6 сарын 30-аас хойших Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлт*



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2022 .09 .21
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ТӨРИЙН БАНК
ЭРСДЭЛГҮЙ ӨРСӨЛДӨӨНИЙ БАТАЛГАА
2022 -09- 14
БҮРТГЭВ-03



## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба толилуулгад орсон өөрчлөлтүүд (үргэлжлэл)

***Жишиг зээлийн хүүгийн шинэчлэл- 2-р үе шатанд СТОУС 9, НББОУС 39, СТОУС 7, СТОУС 4 ба СТОУС 16-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд***

Нэмэлт өөрчлөлтүүд нь банк хоорондын санал болгож буй жишиг хүүгээс эрсдэлгүй хүү (ЭХ)-д шилжүүлэх үед санхүүгийн тайлангийн нөлөөлөлд түр зуурын хөнгөлөлтүүдийг үзүүлнэ. Нэмэлт өөрчлөлтүүд нь дараах практик хэрэгцээг агуулна:

- Зах зээлийн хүүгийн өөрчлөлттэй дүйцэхүйц хөвөгч хүүгийн өөрчлөлт гэж үзэхийн тулд гэрээнд өөрчлөлт оруулах, эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг шаардах нь шинэчлэлд практик ач холбогдолтой.
- ЖХ-ийн шинэчлэлд Хейджийн харилцааг зогсоолгүйгээр хейджийн тэмдэглэгээ, хейджийн баримт бичгийг өөрчлөхийг зөвшөөрөх
- ЭХ-ийн санхүүгийн хэрэгслийг хейджийн эрсдэлийн бүрэлдэхүүн хэсэг гэж тодорхойлох шаардлагуудад түр зуурын хөнгөлөлт үзүүлэх

Нэмэлт өөрчлөлтүүд нь Банкинд нөлөөлөхгүй гэж үзэж байна. Банк нь практик ач холбогдлуудыг хүчин төгөлдөр болох үед хэрэгжүүлэхээр зорьж байна.

***СТОУС 16 өөрчлөлт КОВИД 19 холбоотой 2021 оны 06 сарын 30-с хойш бусад түрээсийн хөнгөлөлт***

2020 оны 5-р сарын 28-нд ННББОУСЗ нь Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтийн тухай СТОУС 16-д түрээсийн нэмэлт, өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлгүүд нь түрээслэгчдэд Ковид-19 цар тахлын шууд үр дагавраас үүдэлтэй түрээсийн хөнгөлөлтийг бүртгэх түрээсийн өөрчлөлтийн бүртгэлийн талаарх СТОУС 16-н зааврыг хэрэгжүүлэхэд хөнгөлөлт үзүүлдэг. Энэхүү хөнгөлөлтийн зорилго нь түрээслэгч нь түрээслүүлэгчээс Ковид-19-тэй холбоотой авсан түрээсийн хөнгөлөлтийг түрээсийн өөрчлөлт мөн эсэхийг үнэлэхгүй байж болох сонголтыг оруулж өгсөн. Энэ сонголтыг хийсэн түрээслэгч нь Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтийг СТОУС 16-д заасан түрээсийн өөрчлөлт гэж үзээгүй үед тооцсонтой адил аргаар тооцно.

Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2021 оны 6-р сарын 30–ний өдөр хүртэл хэрэгжихээр байсан боловч Ковид 19 цар тахлын нөлөөлөл үргэлжилсээр байгаа тул 2021 оны 3-р сарын 31–ний өдөр НББОУСЗ-өөс энэхүү хөнгөлөлтийн ач холбогдлыг 2022 оны 6-р сарын 30–ний өдөр хүртэл сунгасан. Хөнгөлөлт нь 2021 оны 4-р сарын 1–ний өдөр болон түүнээс хойших тайлант жилийн хугацаанд хамаарна. Банк нь Ковид-19–тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтийг хэрэгжүүлэхгүй боловч зөвшөөрөгдсөн тайлант хугацаанд хэрэгжих боломжтой болсон тохиолдолд практикт хэрэглэхээр төлөвлөж байна.

### 2.4 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд

Банкны санхүүгийн тайлангуудыг бэлтгэж гаргах өдрийн байдлаар батлагдаж гарсан боловч хэрэгжиж эхлээгүй байсан стандартуудын жагсаалтыг дор үзүүлэв. Банк нь эдгээр стандартуудыг хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрөөс мөрдөж эхэлнэ.

| | |
|---|---|
| • СТОУС 17 | *Даатгалын гэрээ* [2] |
| • НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт | *Богино хугацаат болон урт хугацаат өр төлбөрийн ангилал* [2] |
| • СТОУС 3-т оруулсан нэмэлт өөрчлөлт | *Үзэл баримтлалын хүрээний зөвлөмж* [1] |
| • НББОУС 16-д оруулсан нэмэлт өөрчлөлт | *Үндсэн хөрөнгө: Зориулалтаар ашиглаж эхлэхээс өмнөх орлого* [1] |
| • НББОУС 37-д оруулсан нэмэлт өөрчлөлт | *Давагдашгүй гэрээ - Гэрээ биелүүлэх зардал* [1] |
| • СТОУС 1 Олон улсын санхүүгийн тайлагналын стандартыг анхны удаа хэрэгжүүлэх | *Охин компани нь анх удаа хэрэгжүүлэгчийн хувьд* [1] |
| • СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл | *Санхүүгийн өр төлбөрийг хэрэгсэхгүй болгох '10 хувь" тай тэнцэх төлбөрийн хураамжийн тест* [1] |
| • НББОУС 41 Хөдөө аж ахуй | *Бодит үнэ цэнийн хэмжилтэд татвар ногдуулах* [1] |
| • НББОУС 8 нэмэлт өөрчлөлт | *Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт* [2] |
| • НББОУС 1 болон СТОУС Практик тайлагналын 2 нэмэлт өөрчлөлт | *НББ-ийн бодлогын толилуулга* [2] |

[1] *2022 оны 1 сарын 1-ээс хойших тайлант жилүүдэд хүчинтэй*
[2] *2023 оны 1 сарын 1-ээс хойших тайлант жилүүдэд хүчинтэй.*

Банкинд хамаарах СТОУС-ын талаарх нэмэлт мэдээллийг доор тайлбарласан болно.



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГС75382
УЛААНБААТАР ХОТ
ТТ59674 5265173

ТӨРИЙН БАНК
ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

СЗХ
2022 09 21
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14
БҮРТГЭВ-03



## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба толилуулгад орсон өөрчлөлтүүд (үргэлжлэл)

***СТОУС 17 Даатгалын гэрээ***

2017 оны 5-р сард НББОУСЗ нь даатгалын гэрээний хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, тайлагнал болон толилуулгын зарчмуудыг тусгасан нягтлан бодох бүртгэлийн цж бүрэн шинэ стандарт болох СТОУС 17 Даатгалын гэрээ стандартыг баталсан. СТОУС 17 нь хүчин төгөлдөр болох хугацаанаасаа эхлэн 2005 онд батлагдсан СТОУС 4 Даатгалын гэрээ стандартыг орлоно. СТОУС 17 нь даатгалыг гаргаж буй аж ахуйн нэгжийн төрлөөс үл хамааран бүх төрлийн даатгалын гэрээнд (жишээлбэл, амь нас, шууд бус даатгал, дахин даатгал гэх мэт) мөн түүнчлэн тодорхой оноцлог бүхий баталгаа болон санхүүгийн хэрэгслүүдийг хамаарна. Хамрах хүрээний хувьд цөөн хэдэн зүйлсийг үл хамарна. СТОУС 17 нь СТОУС 9 эсвэл СТОУС 17-ийн хүрээнд ямар хэрэгслүүд эсвэл тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүд болохыг тодорхойлоход нөлөөлж болох даатгалын шинж чанар бүхий банкны бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн шинэ шаардлагыг нэвтрүүлж байна.

Даатгалын үйлчилгээ үзүүлдэг зээлийн карт ба түүнтэй адилтгах бүтээгдэхүүнүүд: эдгээр бүтээгдэхүүнийг ихэнх олгогчид СТОУС 9-ийн дагуу санхүүгийн хэрэгсэл болох нягтлан бодох бүртгэлийн зарчмаар үргэлжлүүлэх боломжтой болно. СТОУС 17 нь даатгалын гэрээний тодорхойлолтыг хангасан зээлийн картын гэрээг (мөн түүнтэй адилтгах зээлийн болон төлбөрийн зохицуулалт бүхий бусад гэрээг) зөвхөн хэрвээ тухайн үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээний үнийг тогтоохдоо үйлчлүүлэгчийн даатгалтай холбоотой эрсдэлийг үнэлээгүй бол хамрахгүй.
Даатгалын төлбөрийг зээлийн картын гэрээний нөхцөлөөр хангах тохиолдолд, олгогч нь дараах зүйлийг хийх шаардлагатай:

- Даатгалын бүрэлдэхүүн хэсгийг салгаж, түүнд СТОУС 17-г хэрэглэнэ
- Холбогдох бусад стандартуудыг (жишээлбэл, СТОУС 9, СТОУС 15 Хэрэглэгчидтэй байгуулсан гэрээний орлого эсвэл НББОУС 37 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө гэх мэт) бусад бүрэлдэхүүн хэсгүүдэд хэрэглэнэ.

Даатгалын тодорхойлолтыг хангасан боловч даатгалын тохиолдлын нөхөн төлбөрийг гэрээний дагуу даатгуулагчийн үүргийг биелүүлэхэд шаардагдах хэмжээгээр хязгаарласан зээлийн гэрээ: Зээл олгогчид – жишээ нь. нас баралтаас болон чөлөөлөгдсөн зээл - СТОУС 9 эсвэл СТОУС 17-г хэрэглэх сонголттой тул сонголт нь багцын түвшинд явагдах бөгөөд эргэлт буцалтгүй болно.
СТОУС 17 нь 2023 оны 1-р сарын 1-н болон түүнээс хойш эхэлсэн тайлангийн хугацаанд хүчин төгөлдөр болно. Банк нь анх удаа СТОУС 17-г хэрэглэх өдрөөс өмнө буюу түүнээс өмнө СТОУС 9 ба СТОУС 15-ийг хэрэгжүүлсэн тохиолдолд хүчин төгөлдөр болох хугацаанаас өмнө хэрэглэхийг зөвшөөрнө. Банк одоогоор СТОУС 17-г хэрэгжүүлэх нь санхүүгийн тайландаа хэрхэн нөлөөлөхийг үнэлэх шатандаа явж байна.

***НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт: Богино хугацаат болон урт хугацаат өр төлбөрийн ангилал***

2020 оны 1-р сард НББОУСЗ нь НББОУС 1-ийн 69-76-р хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулах замаар өр төлбөрийг урт ба богино хугацаат гэж ангилах шаардлагыг тодорхойлсон. Нэмэлт өөрчлөлтүүд нь:

- Төлбөр тооцоог хойшлуулах эрх гэж юу болох
- Хойшлуулах эрх нь тайлант хугацааны эцэст олгогдсон байх
- Аж ахуйн нэгжийн хойшлуулах эрхээ хэрэгжүүлэх магадлал энэ ангилалд нөлөөлөхгүй
- Зөвхөн хэрвээ өр төлбөрт оруулсан дериватив нь өөрөө өмчийн хэрэгсэл болох тохиолдолд л өр төлбөрийн хугацаа нь түүний ангилалд нөлөөлөхгүй.

Нэмэлт өөрчлөлтүүд нь 2023 оны 1-р сарын 1-нээс хойших тайлант жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилдэг болох бөгөөд эдгээрийг ухрааж бүртгэх аргаар хэрэгжүүлнэ. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь банкны санхүүгийн тайланд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.

***Үзэл баримтлалын хүрээний зөвлөмж- СТОУС 3-т оруулсан нэмэлт өөрчлөлтүүд***

2020 оны 5-р сард НББОУСЗ-өөс СТОУС 3 Бизнесийн нэгдэл - үзэл баримтлалын хүрээний талаарх нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Нэмэлт өөрчлөлтүүд нь 1989 онд гаргасан Санхүүгийн тайланг бэлтгэх, танилцуулах хүрээ, түүний шаардлагыг мэдэгдэхүйц өөрчлөхгүйгээр 2018 оны 3-р сард баталсан Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын хүрээний зөвлөмжөөр солих зорилготой байсан.

Түүнчлэн удирдах зөвлөлөөс НББОУС 37 эсвэл СТОУТХ 21 Татварт хамаарах өр төлбөр ба болзошгүй өр төлбөрийн улмаас үүсэх "2 дахь өдөр" болзошгүй ашиг, алдагдлаас зайлсхийх үүднээс СТОУС 3-г хүлээн зөвшөөрөх зарчимд үл хамаарах зүйлийг нэмэлтээр оруулсан. Мөн удирдах зөвлөлөөс санхүүгийн тайлан бэлтгэх, танилцуулах тогтолцооны зөвлөмжийг орлуулснаар нөлөөлөлд өртөж болзошгүй хөрөнгийн талаар СТОУС 3-т байгаа удирдамжийг тодруулж өгсөн.

Нэмэлт өөрчлөлтүүд нь 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойших тайлангийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ. Нэмэлт өөрчлөлтүүд нь Банкинд нөлөөлөхгүй гэж үзэж байна.



УЛААНБААТАР ХОТ
ӨВӨЛ ЗАРАЙЧ
КАПИТАЛ ҮЦК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8674 5208173

СЭХ
2022 .09. 21
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -09- 14
БҮРТГЭВ-03

**ТӨРИЙН БАНК ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2021 ОНЫ 12 САРЫН 31**

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба толилуулгад орсон өөрчлөлтүүд (үргэлжлэл)

***Үндсэн хөрөнгө: Зориулалтаар ашиглаж эхлэхээс өмнөх орлого - НББОУС 16-д оруулсан нэмэлт өөрчлөлт***

2020 оны 5-р сард НББОУС-аас "Үндсэн хөрөнгө - Зориулалтаар ашиглаж эхлэхээс өмнөх орлого"-г батласан бөгөөд үүнд аж ахуйн нэгж байгууллагууд үндсэн хөрөнгийг өөрийн өртгөөс тухайн хөрөнгийг байршил, нөхцөл байдалд нь авчрах явцад үүссэн/бий болсон эд хөрөнгийг зарж борлуулахаас олсон орлогыг хасахыг хориглосон. Үүний оронд аж ахуйн нэгж эдгээр зүйлсийн борлуулалтаас олсон орлого, эдгээр бүтээгдэхүүнтэй холбоотой зардлыг ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ.

Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойших тайлангийн хугацаанд хүчин төгөлдөр болох бөгөөд тухайн хөрөнгө хэрэглэхэд бэлэн болсон аль эсвэл анх удаа нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлж эхлэсэн хугацаанаас өмнөх хамгийн боломжит хугацаа руу аваачин урвуу хамааралтайгаар хэрэгжүүлнэ. Энэхүү өөрчлөлт нь санхүүгийн тайланд нь материаллаг нөлөө үзүүлэхгүй гэсэн хүлээлттэй байна.

***Давагдашгүй гэрээ - Гэрээ биелүүлэх зардал - НББОУС 37-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд***

2020 оны 5-р сард НББОУСЗ-өөс НББОУС 37-д нэмэлт өөрчлөлт оруулж, гэрээ нь давагдашгүй эсвэл алдагдалтай эсэхийг үнэлэхдээ аж ахуйн нэгж ямар зардлыг тооцох шаардлагатайг тодорхойлсон. Нэмэлт өөрчлөлтүүд нь "шууд хамааралтай зардлын хандлагыг" хэрэгжүүлдэг. Бараа, үйлчилгээ үзүүлэх гэрээнд шууд хамааралтай зардлууд нь нэмэгдсэн өртөг болон гэрээний үйл ажиллагаатай шууд холбоотой зардлын хуваарилалтыг хоёуланг багтаана. Ерөнхий болон захиргааны зардал нь гэрээнд шууд хамааралгүй бөгөөд гэрээнд заасны дагуу нөгөө талдаа тодорхой төлбөр тооцоогүй тохиолдолд хасагдана.

Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойших тайлангийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ. Банк эдгээр нэмэлт өөрчлөлтийг анх оруулсан тайлангийн жилийн эхэнд бүх үүргээ биелүүлээгүй байгаа гэрээнүүдэд хэрэгжүүлнэ. Банк энэхүү нэмэлт өөрчлөлтийн үр нөлөөг үнэлж байна.

***СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл - Санхүүгийн өр төлбөрийг хэрэгсэхгүй болгох '10 хувь" тай тэнцэх төлбөрийн хураамжийн тест***

2018-2020 оны туршид НББОУС-ын үйл явцыг жил бүр сайжруулж, НББОУСЗ-өөс СТОУС 9-д нэмэлт өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлтөөр аж ахуйн нэгж шинэ эсвэл өөрчлөгдсөн санхүүгийн өр төлбөрийн нөхцөл нь анхны санхүүгийн өр төлбөрийн нөхцөлөөс ялгаатай эсэхийг үнэлэхдээ төлбөрийн хэмжээг нэмж оруулсан болно. Эдгээр төлбөрт зөвхөн зээлдэгч ба зээлдүүлэгчийн хооронд төлсөн эсвэл хүлээн авсан төлбөр орох бөгөөд үүнд бусдын өмнөөс зээлдэгч эсвэл зээлдүүлэгчийн төлсөн буюу авсан төлбөр багтсан болно. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг тухайн аж ахуйн нэгжид анх хэрэгжүүлсэн тайлант жилд эсвэл дараа нь өөрчилсөн эсвэл солигдсон санхүүгийн өр төлбөрт энэхүү нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлнэ.

Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойших тайлангийн хугацаанд хүчин төгөлдөр болно. Банк энэхүү өөрчлөлтийг хэрэгжүүлж эхэлснээс хойш эсвэл дараа нь өөрчилсөн санхүүгийн өр төлбөрүүдэд хэрэгжүүлэх ба энэ нь санхүүгийн тайланд нь материаллаг нөлөө үзүүлэхгүй гэсэн хүлээлттэй байна.

***НББОУС 8 нэмэлт өөрчлөлт: Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт***

2021 оны 2-р сард НББОУСЗ нь НББОУС 8-ийн НББ-ийн тооцооллын тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулсан.
Энэхүү өөрчлөлтүүд нь НББ-ын тооцооллын өөрчлөлт, НББ-ийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга зэргийн хоорондын ялгааг тодорхойлсон. Мөн аж ах ахуй нэгжүүд НББ-ийн тооцооллыг боловсруулахад хэмжилтийн техник болон өгөгдөл хэрхэн хэрэглэдгийг тодруулж өгсөн.

Нэмэлт өөрчлөлтүүд нь 2023 оны 1-р сарын 1 –ний өдрөөс эсвэл түүнээс хойших тайлант жилээс хүчин төгөлдөр болох бөгөөд НББ-ийн тооцооллын өөрчлөлт, НББ-ийн бодлогын өөрчлөлтүүдэд үйлчилнэ. Баримтуудыг толилуулсан тохиолдолд эрт хэрэгжүүлэхийг зөвшөөрнө. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТБ8674 рд.5208173

СЭХ
2022.09.21. өдөр
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭВ-03



## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба толилуулгад орсон өөрчлөлтүүд (үргэлжлэл)

***НББОУС 1 болон СТОУС Практик тайлагналын 2 нэмэлт өөрчлөлтүүд: НББ-ийн бодлогын толилуулга***

2021 оны 2-р сард НББОУСЗ-өөс НББОУС 1 болон СТОУС Практик тайлагналын 2-т материаллаг байдлын дүгнэлт хийх нэмэлт өөрчлөлтүүд оруулсан. Энэ нь НББ-ийн толилуулгад материаллаг байдлын дүгнэлтийг ашиглах заавар жишээг багтаасан. Нэмэлт өөрчлөлтүүд нь аж ахуйн нэгжүүдэд "гол" нягтлан бодох бүртгэлийн толилуулах шаардлагыг "материаллаг" нягтлан бодох бүртгэлийн бодлогоо ил тод болгох шаардлагаар сольж, аж ахуйн нэгжүүд материаллаг байдлын үзэл баримтлалыг хэрхэн ашиглах талаар зааварчилгааг нэмж оруулснаар илүү хүртээмжтэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгыг гаргахад туслах зорилготой юм.

Нэмэлт өөрчлөлтүүд нь 2023 оны 1-р сарын 1-ний өдрөөс эсвэл түүнээс хойших тайлант жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд өмнө хэрэгжүүлэхийг зөвшөөрнө. Практик тайлагналын 2 нь НББ-ийн мэдээлэлд материаллаг байдлыг тодорхойлох заавал шаардагдахгүй зааварчилгаа гаргасан тул энэ өөрчлөлтөд хүчин төгөлдөр болох огноо шаардлагагүй болно. Банк одоогоор энэхүү нэмэлт, өөрчлөлт нь НББ-ийн бодлогын тодруулгад хэрхэн нөлөөлөхийг үнэлж байна.

**Гадаад валютын ханшийн тэгшитгэл**

Банкны үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн тэмдэгт нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох "Монгол төгрөг" юм. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрийг тайлагналын өдрийн спот ханшаар дахин хөрвүүлдэг. Мөнгөн зүйлсийн ханшийн тэгшитгэл эсвэл төлбөр тооцооноос үүссэн аливаа зөрүүг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Түүхэн өртгөөр бүртгэдэг мөнгөн бус зүйлсийг анх гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлнэ. Харин өмчийн хөрөнгө оруулалт зэрэг бодит үнэ цэнэ нь гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг бодит өртгийг тодорхойлсон өдрийн ханшаар хөрвүүлж бүртгэнэ. Бодит үнэ цэнийн аргаар бүртгэдэг мөнгөн бус зүйлсийн ханшийн тэгшитгэлээс үүссэн олз эсвэл гарзыг бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз ба гарз хэсэгт толилуулна.

**Орлого хүлээн зөвшөөрөлт**

*Үр ашигт хүүгийн аргачлал*

СТОУС 9-ийн дагуу хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн санхүүгийн хөрөнгүүд, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүдийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан тодорхойлно. СТОУС 9-ийн дагуу бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүдийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан тодорхойлно. Үр ашигт хүү гэдэг нь санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалуудыг хугацааных нь туршид эсвэл тохиромжтой гэж үзсэн богино хугацаанд дансны үнэ хүртэл нь дискаунтчилсан хүү юм.

Үр ашигт хүүг (цаашлаад, санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртгийг) үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын хөнгөлөлт, урамшуулал, шимтгэл болон зардлыг оролцуулан тооцдог. Банк нь зээлийн нийт хугацааны турш тогтмол өгөөж хүртэнэ гэсэн хамгийн сайн тооцооллыг илэрхийлэх өгөөжийн хувиар хүүгийн орлогыг бүртгэдэг. Тиймээс өөр шатлалуудад тооцогдсон хүүгийн түвшнүүдийн нөлөөлөл болон бүтээгдэхүүний нийт хугацааны бусад шинж чанаруудыг (урьдчилж төлсөн төлбөр, нэмэгдүүлсэн хүү болон шимтгэлүүд) оролцуулан тооцдог.

Хэрэв санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй мөнгөн урсгал нь зээлийн эрсдэлээс бусад шалтгаанаар өөрчлөгдсөн бол ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалуудын өөрчлөлтийг анхны үр ашигт хүүгээр дискаунтчилан цаашлаад дансны үнийг тохируулна. Уг өөрчлөлт нь эерэг эсвэл сөрөг залруулгаар санхүүгийн байдлын тайланд тухайн санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны үнэд нөлөөлж үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон хүүгийн орлого/зардлыг нэмэгдүүлж эсвэл бууруулж болно.

Хөвөгч хүүтэй санхүүгийн хэрэгслийн хувьд үр ашигт хүүд өөрчлөлт оруулж буй зах зээлийн хүүгийн өөрчлөлтийн нөлөөг тооцоололд оруулахын тулд мөнгөн урсгалын тооцооллыг тогтмол хийх боловч санхүүгийн хэрэгсэл нь хамгийн анх үндсэн үнээрээ хүлээн зөвшөөрөгдсөн тохиолдолд ирээдүйн хүүгийн төлбөрүүдийн дахин тооцоолол нь хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэд материаллаг нөлөө үзүүлэхгүй болно.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

СЭХ
2022 оны 09 сарын 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14
БҮРТГЭВ-03



## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

**Орлого хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)**

*Үр ашигт хүүгийн аргачлал (үргэлжлэл)*

ЖХШ 2-р үе шатанд орон өөрчлөлтүүд нь тодорхой шалгууруудыг хангаснаар гэрээний дагуу бий болсон мөнгөн гүйлгээг тодорхойлох үндэслэлд өөрчлөлт оруулах нь хөвөгч хүүгийн өөрчлөлтөд тооцогдох бөгөөд практик ач холбогдолтой юм. Шалгуурын хувьд ЖХШ-ийн шууд үр дагаврууд нь эдийн засгийн хувьд ижил зарчмаар явагдана.

*Хүү болон түүнтэй адилтгах орлого/зардал*

Цэвэр хүүгийн орлого болон зардлыг үр ашигт хүүгийн арга болон бусад аргыг ашиглан тооцдог. Эдгээрийг хүүгийн орлого болон зардлын аль алины хувьд харьцуулагдахуйц мэдээллийг харуулахын тулд орлогын тайланд тусад нь толилуулсан болно.

Банк нь зөвхөн дээр дурдсан санхүүгийн хэрэгслүүдийн хувьд үр ашигт хүүгийн аргаар хүүгийн орлого болон зардлыг тооцоолдог.

Бусад хүүгийн орлого болон зардалд үүсмэл санхүүгийн хэрэгслийн хейдж хэлцлийн хүү болон бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэхээр хэмжигддэг бүх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийн хүү (гэрээний хүүгийн хувь хэмжээгээр тооцдог худалдах зорилгоор эзэмшиж буй хөрөнгөөс бусад) орно.

Арилжааны зориулалттай санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн хүүгийн орлого болон зардал нь "Арилжааны цэвэр орлого"-д бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр хүлээн зөвшөөрөгдсөн болно.

Банк нь үнэ цэнэ буурсан гэж үзсэнээс бусад санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргаар уг санхүүгийн хөрөнгийн дансны үнээс тооцдог.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурч ("Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ бууралт" тодруулгын дагуу), "3-р шатлал" –д орсон тохиолдолд Банк үр ашигт хүүгийн аргыг ашиглан санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан цэвэр өртгөөс хүүгийн орлогыг тооцно. Санхүүгийн хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орохоо больсон ("Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ бууралт" тодруулгын дагуу) тохиолдолд хүүгийн орлогыг дансны үнээс тооцно.

**Хураамж ба шимтгэлийн орлого**

Банк нь өөрийн харилцагч нарт үзүүлдэг төрөл бүрийн үйлчилгээнээс хураамж, шимтгэлийн орлого олдог. Хураамж болон шимтгэлийн орлогыг Банк үзүүлсэн үйлчилгээний оронд хүлээн авах төлбөрийн дүнг тусгасан хэмжээгээр хүлээн зөвшөөрнө.

Гүйцэтгэлийн үүрэг, түүнчлэн тэдгээрийг биелүүлэх хугацааг гэрээ байгуулагдах үед тодорхойлно. Банкны орлого олох гэрээнд ихэвчлэн олон гүйцэтгэлийн үүрэг байдаггүй бөгөөд эдгээрийг доорх байдлаар тайлбарласан.

Банк үйлчлүүлэгчдэд үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд хүлээн авах төлбөрийг нэн даруй нэхэмжилдэг. Аль эсвэл хугацааны туршид үзүүлэх үйлчилгээний гэрээний хугацааны төгсгөлд нэхэмжлэхийг гаргадаг (доор өөрөөр заагаагүй бол). Банк нь харилцагчид үйлчилгээ үзүүлэхээс өмнө үйлчилгээний хяналт нь Банкинд байдаг тул орлого хүлээн зөвшөөрлөлтөд үндсэн үүрэг гүйцэтгэгч гэж дүгнэсэн.

*Тодорхой хугацааны туршид үзүүлж байгаа үйлчилгээнүүдээс олсон хураамжийн орлого*

Тодорхой хугацааны туршид үйлчилгээг үзүүлж олох орлогыг тэр хугацааны туршид нь хуримтлуулна. Эдгээр хураамжид шимтгэлийн орлого, хөрөнгийн зохицуулалт, хамгаалалт, бусад зохицуулалт болон зөвлөгөөний хураамжууд орно.

*Гүйлгээний үйл ажиллагаанаас олсон шимтгэлийн орлого*

Хувьцаа эсвэл бусад үнэт цаас худалдан авах болон бизнес худалдан авах эсвэл зарах гэх мэт тодорхой хугацааны туршид үйлчилгээг үзүүлж олох орлогыг үндсэн гүйлгээ хийгдэж дууссан үед хүлээн зөвшөөрнө. Шимтгэлийн бүрэлдэхүүн хэсгийн төлбөрийг гүйцэтгэлийн зохих шалгуурыг биелүүлсний дараа хүлээн зөвшөөрнө.



УЛААНБААТАР ХОТ
ЭРДЭНЭ ЭНЕРЖИ ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК

СЭХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14
БҮРТГЭВ-03

**ТӨРИЙН БАНК ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2021 ОНЫ 12 САРЫН 31**

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

*Холбогдох санхүүгийн хэрэгслийн салшгүй хэсэг болох хураамжийн орлого*

Банкны холбогдох санхүүгийн хэрэгслийн салшгүй хэсэг болох хураамжийн орлого нь: зээл олголтын шимтгэл, татан авагдах магадлалтай зээлүүд дээр зээлийн үйлчилгээний шимтгэл болон зээлтэй холбоотой бусад шимтгэлүүд орно. Эдгээр шимтгэл нь (өсөн нэмэгдэх аливаа зардлын хамт) зээлийн үр ашигт хүүгийн залруулга гэж хүүгийн орлогоор хүлээн зөвшөөрөгдөнө. Харин татан авахгүй нь ерөнхийдөө тодорхой болсон зээлүүдийн зээлийн үйлчилгээний шимтгэл нь хугацааны эцэст орлогоор хүлээн зөвшөөрөгдөнө.

**Арилжааны цэвэр орлого**

Арилжааны цэвэр орлогод арилжаалахад зориулагдсан санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт, түүнтэй холбоотой хүүгийн орлого/зардал, ногдол ашиг багтана.

**Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн цэвэр ашиг, алдагдал**

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хэрэгслийн цэвэр ашиг эсвэл алдагдал СТОУС 9-т шаардсан эсвэл заасны дагуу эдийн засгийн хейджийн харилцаанд эрсдэлийн удирдлагын зорилгоор ашиглагддаг боловч хейджийн бүртгэлийн шаардлага хангахгүй арилжааны бус үүсмэл хэрэглүүд, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр мөн түүнчлэн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх арилжааны бус хөрөнгүүдийн бодит үнэ цэнийн өөрчлөлт, хүү болон гадаад валютын ханшийн зөрүүнүүд орно.

**Хорогдуулсан өртгөөр эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүдийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүсэх цэвэр ашиг, алдагдал**

Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүдийг үл хүлээн зөвшөөрөхөд үүсэх цэвэр ашиг, алдагдал нь хорогдуулсан өртгөөр хэмжигдэх эсвэл бодит үнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэх санхүүгийн хөрөнгүүдийг борлуулах эсвэл үл хүлээн зөвшөөрөх үеийн хүлээн авсан орлого болон дансны үнэ (үнэ цэнэ бууралт тооцсон) хоорондын зөрүүгээр тооцсон алдагдал (эсвэл ашиг)-аар хэмжигдэнэ.

**Санхүүгийн хэрэгсэл - анхны хүлээн зөвшөөрөлт**

*Хүлээн зөвшөөрөх өдөр*
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа, харилцагчдын харилцах болон хадгаламжаас бусад бүх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө арилжаа хийсэн өдрөөр (Банк нь тухайн хэрэгслийн гэрээний нэг тал болсон өдөр) хүлээн зөвшөөрнө. Үүнд хэвийн нөхцөлтэй арилжаа буюу санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдахад холбогдох хөрөнгийг зах зээлийн журам, хэлцлээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаардсан арилжаа орно. Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа нь хөрөнгийг харилцагчдын дансанд шилжүүлсэн үед хүлээн зөвшөөрнө. Банк нь харилцагчдын харилцах, хадгаламжийг Банкинд шилжсэн үед хүлээн зөвшөөрнө.

*Санхүүгийн хэрэгслийн анхны хэмжилт*
Санхүүгийн хэрэгслийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн ангилал нь гэрээний нөхцөл болон бизнес загвар дээр үндэслэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрөөс бусад бүх санхүүгийн хэрэгслүүдийн анхны хэмжилт нь тэдгээрийн бодит үнэ цэнэ дээр гүйлгээний зардлыг нэмсэн дүн байна. Худалдааны авлагын анхны хэмжилт нь гүйлгээний дүнгээр байна. Санхүүгийн хэрэгслийн анхны хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнэ нь ажил гүйлгээний үнээс ялгаатай үед Банк дор дурдсан "Эхний өдөр"-ийн ашиг ба алдагдал гэх бүртгэлийн аргачлалыг баримталдаг.

*"Эхний өдөр"-ийн ашиг ба алдагдал*
Ажил гүйлгээний үнэ нь бодит үнэ цэнээсээ ялгаатай бөгөөд бодит үнэ цэнэ нь зах зээлийн ажил гүйлгээнээс ажиглагдахуйц өгөгдөлд суурилсан үнэлгээний аргачлал ашигласан байвал Банк нь бодит үнэ цэнэ болон ажил гүйлгээний үнийн зөрүүг цэвэр арилжааны орлогоор хүлээн зөвшөөрнө. Зарим өгөгдөл нь ажиглагдахуйц мэдээлэлд суурилаагүй үнэлгээний загвараар тооцсон тохиолдолд ажил гүйлгээний үнэ болон бодит үнэ цэнийн зөрүүг зөвхөн орлого орж ирэх нь тодорхой болсон эсвэл санхүүгийн хэрэгслийг үл хүлээн зөвшөөрөх тохиолдолд л орлого зардалд хүлээн зөвшөөрнө.



УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД НЭ КАПИТАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ГҮЙЦЭТГЭХ ХОТ ҮНДЭ ХХК
ТТБ8674 5208173

**ТӨРИЙН БАНК ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2021 ОНЫ 12 САРЫН 31**

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

*Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хэмжих ангилал*

Банк өөрийн бүх хөрөнгийг бизнесийн загвар болон гэрээний нөхцөл дээр үндэслэн дараах аль нэгээр нь ангилна:

- Хорогдуулсан өртгөөр бүртгэх;
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх;
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх

Банк нь үүсмэл санхүүгийн хэрэгсэл болон арилжааны үнэт цаасны багцыг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөөр ангилж хэмжинэ. Хэмжилт болон хүлээн зөвшөөрөлт нь орлого үр дүнгийн тайлангийн хэлбэлзлийг бууруулж байгаа нөхцөлд Банк нь санхүүгийн хэрэгслийг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх гэж тодорхойлж болно.

Зээлийн баталгаанаас бусад санхүүгийн өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр бүртгэх эсвэл арилжаалах үүсмэл санхүүгийн хэрэгсэл эсвэл бодит үнэ цэнийн зорилгоор эзэмшиж байгаа бол бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэхээр ангилна.

**Бодит үнэ цэнийн тодорхойлолт**

Банк нь үнэлгээний аргачлалуудыг ашиглан санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийг тодорхойлох, толилуулахдаа дараах түвшинийг хэрэглэдэг. Үүнд:

- Түвшин 1- санхүүгийн хэрэгслүүд - Үнэлгээнд ашиглагдсан өгөгдлүүд нь хэмжилтийн өдрөөрх бирж дээр бүртгэлтэй ижил төсөөтэй хөрөнгө болон өр төлбөрийн (залруулаагүй) идэвхтэй зах зээл дээрх үнэ. Банк нь хэмжээ болон төлбөрийн чадварын хувьд адил төсөөтэй хөрөнгө болон өр төлбөрийн санхүүгийн тайлангийн өдрөөр боломжтой, заавал болон хэрэгжих үнийн хангалттай арилжааны үйл ажиллагаатай байхыг идэвхтэй зах зээл гэж үзнэ.
- Түвшин 2- санхүүгийн хэрэгслүүд - Үнэлгээнд ашиглагдсан өгөгдлүүд нь, санхүүгийн хэрэгслийн амьдралын мөчлөгийн туршид боломжтой байх зах зээлийн бүх өгөгдлүүдээс шууд болон шууд бусаар үнэлгээнд ашигласан өгөгдлүүд юм. Эдгээр өгөгдлүүдийн дотор идэвхтэй зах зээл дээрх ижил төстэй хөрөнгө болон өр төлбөрийн үнэ, идэвхгүй зах зээл дээрх ижил төстэй хэрэгслийн үнэ болон үнээс өөр хүүгийн түвшин, өгөөжийн муруй, харгалзах хэлбэлзэл болон зээлийн эрсдэлийн үнэ гэх зэрэг ажиглагдахуйц өгөгдлүүд орно. Мөн түүнчлэн, тухайн хөрөнгийн нөхцөл байдал болон байршил мөн харьцуулах зүйлсийн аль нь үнэлэгдсэн хэрэгсэлтэй холбогдох зэргээс залруулга шаардлагатай байж болно. Гэвч ажиглагдахуйц бус өгөгдөл дээр үндэслэн нийт хэмжилтэд чухал ач холбогдолтой дээрх залруулгыг хийсэн бол Банк нь хэрэгслүүдийг Түвшин 3-р ангилна.
- Түвшин 3 - санхүүгийн хэрэгслүүд - Эдгээрт, хэмжилтийн бүхэлд нь чухал ач холбогдолтой, нэг болон түүнээс дээш ажиглагдахуйц бус өгөгдлүүд багтана.

Банк нь үнэлгээний техник болон хэрэгжүүлж буй аргачлалууд болон загварын тохируулгуудыг тогтмол шалгаж үздэг. Гэвч суурь загвар нь Банкны санхүүгийн хэрэгслийг үнэлэхтэй холбоотой бүх хүчин зүйлүүд болох зээлийн эрсдэл, өөрийн зээлийн болон/эсвэл санхүүжилтийн зардал зэргийг бүрэн дүүрэн хамруулж чадахгүй байх магадлалтай юм. Иймд Банк нь бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хэрэгсэлтэй холбоотой зээлийн эрсдэлийг тооцоолоход төрөл бүрийн техник хэрэглэдэг ба үүнд хөрөнгө тус бүрийн хувьд ашиглалтын хугацааны туршид холбогдох талд хүлээгдэж буй зээлийн эрсдэлийг багцад суурилсан аргачлалаар тооцох нь багтдаг бөгөөд энэ нь холбогдох талд хүлээгдэж буй барьцаагүй санхүүгийн хэрэгслийн зээлийн эрсдэлийг тусгахын тулд хийгддэг. Банк өөрийн зээлийн үнэ цэнийг зах зээлийн бодит өгөгдлүүдээс, тухайлбал, арилжаалагдсан өрийн хоёрдогч үнэ, анхдагч свопт тархсан зээл болон арилжаалагдсан өр зэргээс тооцдог.

Тайлант хугацааны эцэс бүрт Банк нь санхүүгийн тайландаа тайлагнасан хөрөнгө, өр төлбөрийн хувьд түвшин хоорондын хөдөлгөөн гарсан эсэхийг дахин нягталж үздэг.

СЗХ
2022 .09. 21
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
2022 -09- 14
БҮРТГЭВ-03



## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

**Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр**

***Бусад Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах хадгаламж, харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа болон хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хэрэгслүүд***

Банк нь доорх нөхцөлүүд хангагдсан тохиолдолд бусад Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах хадгаламж, харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа болон бусад санхүүгийн хэрэгслүүдийг хорогдуулсан өртгөөр бүртгэхэд ангилна:

- Бизнесийн загварын зорилго нь гэрээнд заасан мөнгөн төлбөрийг цуглуулах зорилгоор санхүүгийн хөрөнгийг эзэмшиж байгаа
- Санхүүгийн хөрөнгүүдийн гэрээний нөхцөл нь тодорхой үед үлдэгдлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийн мөнгөн гүйлгээг үүсгэдэг.

Эдгээр нөхцөлүүдийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв.

*Бизнесийн загварын тест*
Банкны бизнес загвар нь хэрэгслийн түвшинд биш нийлмэл багцын түвшинд хянагддаг ба дараах ажиглагдахуйц хүчин зүйлсээс хамааран:

- Бизнес загварын (тухайн бизнес загварт хамаарагдах санхүүгийн хөрөнгө) гүйцэтгэлд нөлөөлж буй эрсдэл ба эдгээр эрсдэлийг хэрхэн хянах аргачлал
- Эдгээр хөрөнгүүдээс мөнгөн гүйлгээг өмнө нь хэрхэн хүлээн авч байсан туршлага
- Багцын гүйцэтгэлийг хэмжих болон тайлагнахад ашигласан хэмжигдэхүүнүүд
- Байгууллагын удирдлагуудад хэрхэн урамшуулал олгодог (санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ эсвэл гэрээний цуглуулсан мөнгөн урсгал дээр үндэслэдэг)

Борлуулалтын хүлээгдэж буй давтамж, үнэ цэнэ ба хугацаа нь үнэлгээ хийхэд чухал хүчин зүйл болно. Бизнес загварын тест нь хамгийн боломжит хувилбар дээр үндэслэдэг ба 'хамгийн муу' эсвэл 'стрэсс' нөхцөлүүдийг харгалзан үздэггүй. Хэрэв анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах мөнгөн урсгал нь анхны таамагласан хүлээлтээс өөр байвал Банк тухайн бизнес загварт хамааралтай санхүүгийн хөрөнгийн ангиллыг солихгүй бөгөөд харин уг мэдээллийг шинээр санхүүгийн хөрөнгө худалдаж авах үед үнэлгээндээ оруулан үздэг.

*Үндсэн төлбөр ба хүүгийн төлбөрийн шалгуур (ҮТХТ шалгуур)*
Санхүүгийн хэрэгслийн ангиллын хоёр дахь шат бол Банк үндсэн төлбөр ба хүүгийн шалгуурын шаардлагыг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд санхүүгийн хэрэгслийн гэрээний нөхцлийг дүгнэдэг.

Энэхүү шалгуурын хүрээнд 'Үндсэн' гэдэг нь анхны хүлээн зөвшөөрөх үеийн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ бөгөөд санхүүгийн хөрөнгийн ашиглах хугацааны туршид өөрчлөгдөж болно (жишээ нь үндсэн төлбөрийн эргэн төлөлт эсвэл урамшуулал/хөнгөлөлтийн хорогдуулалт).

Зээлийн гэрээн дэх хүүгийн хамгийн гол элемент нь мөнгөний өнөөгийн үнэ цэнэ болон зээлийн эрсдэл байдаг. Үндсэн төлбөр ба хүүгийн төлбөрийн шалгуурын үнэлгээг хийхийн тулд Банк нь хүүгийн түвшинийг тогтоосон хугацаа гэх мэт холбогдох хүчин зүйлс, үнэлэмжийг авч үздэг.

Нөгөө талаас, эрсдэл үүрэх магадлал багатай гэрээний заалт эсхүл үндсэн зээлийн зохицуулалттай холбоогүй гэрээний мөнгөн гүйлгээний тогтворгүй байдал зэрэг нь зөвхөн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл дүнгийн гэрээний мөнгөн гүйлгээнд нөлөөлөхгүй. Ийм тохиолдолд санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ.

***Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэх үүсмэл санхүүгийн хэрэгслүүд***

Үүсмэл санхүүгийн хэрэгсэл нь санхүүгийн хэрэгсэл эсвэл бусад гэрээ байхын тулд доорх 3 шинж чанарыг бүгдийг агуулах шаардлагатай:

- Үнэ цэнэ нь тодорхой хүүгийн түвшин, санхүүгийн хэрэгслийн үнэ, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ, валютын ханшийн өөрчлөлт, зээлжих зэрэглэл болон гэрээний холбогдох талын үүрэг харицуулагад хамаарахгүй бусад хувьсагчийн өөрчлөлтөөс хамаардаг бол
- Анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаггүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил байдлаар хандахаар хүлээгдэж буй адил төсөөтэй гэрээнд шаардлагатайгаас бага анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаг бол
- Ирээдүйд төлөгдөхөөр бол



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5163635
9021031995 СТС2420
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341 09 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТБ8674 ₮ 5208173

СЭХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 31



ТӨРИЙН БАНК
ХӨГЖЛИЙН ИРЭЭДҮЙН БАТАЛГАА
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -09- 14
БҮРТГЭВ-03



## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

***Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэх үүсмэл санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)***

Банк нь төрөл бүрийн харилцагчидтай үүсмэл санхүүгийн хэрэгслийн хэлцлүүд хийдэг бөгөөд эдгээрт кросс своп, гадаад валютын болон хүүгийн форвард гэрээ хэлцлүүд зэрэг орно. Үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг ба бодит үнэ цэнэ нь эерэг байгаа үед хөрөнгө, харин сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ. Үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэл хэрэглэж байгаагаас бусад үед “Арилжааны цэвэр орлого”-д бүртгэдэг.

***Арилжаалах зориулалттай санхүүгийн хөрөнгө***

Банк нь санхүүгийн хөрөнгийг арилжааны үйл ажиллагаагаар дамжуулан богино хугацаанд ашиг олох зорилгоор худалдаж авсан эсвэл багцаар нь удирдаж буй санхүүгийн хэрэгслийн багцын нэг хэсэг болгон арилжаалах зориулалттай гэж ангилдаг. Арилжаалах зориулалттай хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь хэмжин бүртгэдэг. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг цэвэр арилжааны орлогод хүлээн зөвшөөрнө. Хүү, ногдол ашгийн орлого болон зардлыг гэрээний нөхцлийн дагуу, эсвэл төлбөр хийх эрх нь тогтоогдсон үед арилжааны цэвэр орлогод бүртгэнэ.

Энэ ангилалд зарах эсвэл богино хугацаанд эргүүлэн худалдаж авах зорилгоор өрийн болон өмчийн үнэт цааснууд багтсан болно.

***Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэх өмчийн хэрэгсэл***

Анх хүлээн зөвшөөрсний дараа, Банк НББОУС-32 санхүүгийн хэрэгсэл толилуулга болон арилжаалах зорилгоор эзэмшдэггүй өмчийн тодорхойлолтод нийцсэн зарим өмчийн хэрэгслийг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх өмчийн хэрэгсэл рүү буцаах боломжгүйгээр ангилна. Энэ ангилал нь хэрэгслийн түвшинд суурилан тодорхойлогддог.

Энэ өмчийн хэрэгслийн олз гарзыг хэзээ ч ашиг алдагдлын тайланд бүртгэхгүй. Банк хүлээн авах орлогын санхүүгийн хэрэгсэлтэй холбоотой зардлыг нөхөн төлбөрт ашигласан тохиолдолд ашиг нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх бол бусад үед төлбөрийн эрх нь баталгаажсан тохиолдолд ногдол ашгийг бусад үйл ажиллагааны орлого гэж ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэх өмчийн хэрэгсэл нь үнэ цэнийн бууралтын үнэлгээнд хамаарахгүй.

***Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэх өрийн хэрэгсэл***

Банк нь өрийн хэрэгслийг доорх нөхцөлүүдийг хангасан тохиолдолд Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх өрийн хэрэгсэлд ангилна:

- Бизнесийн загварын зорилгоор эзэмшиж байгаа санхүүгийн хэрэгсэл, гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах болон борлуулах зорилгоор эзэмших
- Санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөл нь зөвхөн үндсэн төлбөр ба хүүгийн шалгуурын хангах

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэгсэл нь бодит үнэ цэнээр хэмжигдэх бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз, гарз нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэнэ. Хүүгийн орлого болон гадаад валютын ханшийн олз, гарзыг хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгүүдийн адил ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэгслийн зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын тооцооллыг доорх тодруулгуудад тайлбарласан. Банк нь нэг төрлийн үнэт цааснаас нэгээс олныг эзэмшдэг бол эхэлж авснаа эхэлж зарлагадахаар бүртгэнэ. Үл хүлээн зөвшөөрөх үед бусад орлогод хуримтлагдсан олз, гарз нь бусад дэлгэрэнгүй орлогын тайлангаас ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдана.

***Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр***

Энэ ангилал дахь санхүүгийн хөрөнгө нь арилжаалах зорилгоор эзэмшээгүй бөгөөд анх хүлээн зөвшөөрөхдөө удирдлагаас тодорхойлогдсон эсвэл СТОУС-9-н дагуу заавал бодит үнэ цэнээр хэмжих шаардлагатай гэж тодорхойлсон. Банк нь өрийн хэрэгслийг доорх нөхцөлүүдийг хангасан тохиолдолд Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх өрийн хэрэгсэлд ангилна. Өрийн хэрэгслээс хамаарч дараах загварчлалыг ашигладаг



УЛААНБААТАР ХОТ
9021031155 СТС2420
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК
ТТБ8674 5208173

СЭХ 2022 .09. 21 он сар өдөр БҮРТГЭВ №

2022 -09- 14 БҮРТГЭВ-03



## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

***Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр (үргэлжлэл)***

- Загварчлал нь ашиг, алдагдал, хөрөнгө болон өр төлбөрийн үнэлэхэд учирдаг нийцтэй бус байдлыг арилгах эсвэл бууруулдаг.
- Өр төлбөр нь бүлэг санхүүгийн өр төлбөрийг хэлэх бөгөөд тэдгээр нь эрсдэлийн удирдлага эсвэл хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу бодит үнэ цэнээр хэмжигдэнэ.
- Өр төлбөр нь нэг болон түүнээс дээш санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг нэгдлийг агуулдаг. Гэвч санхүүгийн үүсмэл хэрэгслүүд нь гэрээнд заасны дагуу мөнгөн урсгалд их хэмжээний нөлөө үзүүлэхүйц, аль эсвэл нэгтгэж бүртгэх нь хориглодог санхүүгийн хэрэгслийг шинжилгээ хийхгүйгээр эсвэл багахан шинжилгээгээр нэгтгэлд оруулахгүй.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө нь санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр бүртгэгдэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөд тодорхойлсон хэрэгслүүдээс олсон хүүгийн орлого эсвэл зардал нь үр ашигт хүүг ашиглан мөн хөнгөлөлт/урамшууллыг нь харгалзан дүнгээр тооцдог.

***Гаргасан өрийн хэрэгсэл ба зээлээр авсан санхүүжилт***

Анх хүлээн зөвшөөрсний дараа, зээллэгүүдийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцохдоо зээл авах үеийн хөнгөлөлт, урамшуулал ба үр ашигт хүүгийн нэг салшгүй хэсэг болж буй зардлуудыг авч үзнэ. Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн аль алиных нь элементүүдийг агуулсан нийлмэл санхүүгийн хэрэгслүүдийн бүрэлдэхүүн хэсгүүдийг, хүлээн зөвшөөрөгдөх өдөр салгана.

Банк нь эдгээр үүсмэл бус санхүүгийн хэрэгслүүдийг бүртгэлд тусгахдаа, эхлээд тухайн хэрэгсэл нь нийлмэл эсэх талаар болон тухайн хэрэгслүүд болон бүрэлдэхүүн хэсгүүдийг НББОУС 32-н дагуу санхүүгийн өр төлбөр болон хөрөнгө эсвэл өөрийн хөрөнгө гэж ангилна. Банк нь санхүүгийн хэрэгслийн бүрэлдэхүүн хэсгүүдийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө: (а) Банкинд санхүүгийн өр төлбөр болж байвал, (б) Тухайн хэрэгслийг эзэмшигчид, хэрэгслийг Банкны өөрийн хөрөнгийн хэрэгсэлд хөрвөх боломжоо өгч байвал. Хөрвөх хэрэгслийн өр төлбөр болон өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнүүдийн ангилал нь, тухайн хөрвөх нөхцөл нь зарим нэг эзэмшигчдийн хувьд эдийн засгийн давуу талтай байсан ч хөрвөх нөхцөл нь хэрэгжих эсэх болон түүний өөрчлөгдөх магадлалаас шалтгаалан өөрчлөгддөггүй. Хөрвөх санхүүгийн хэрэгслийн өөрийн хөрөнгө болон өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн бүртгэлийн дүнг хуваарилахдаа, өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүний дүн нь тухайн хэрэгслийн нийт бодит үнэ цэнээс өр төлбөрийн бүрэлдэхүүн гэж тусад нь тодорхойлсон дүнг хассанаас үлдсэн дүн байна. Нийлмэл санхүүгийн хэрэгсэлд агуулагдсан өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнээс (өөрийн хөрөнгийн хөрвөх нөхцөл гэх мэт) бусад аливаа үүсмэл хэрэгслийн үнэ цэнэ нь (худалдан авах опцион гэх мэт) өр төлбөрийн бүрэлдэхүүнд багтана.

Банк нь тухайн хэрэгслийн өөрийн хөрөнгө болон өр төлбөрийн бүрэлдэхүүнүүдийг салгах гэж буй бол тухайн өр төлбөрт салгах шаардлагатай агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэгсэл байгаа эсэхийг үнэлнэ. Банк нь агуулагч гэрээ болон дансдаас агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэгслийг зөвхөн доорх нөхцөлд салгана:

- Агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэгслийн эдийн засгийн болон эрсдэлийн шинж чанар нь агуулагч гэрээний эдийн засгийн болон эрсдэлийн шинж чанартай нягт холбоотой биш үед
- Агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэгсэлтэй ижил нөхцөлтэй салангид хэрэгсэл нь санхүүгийн үүсмэл хэрэгслийн тодорхойлолтыг хангаж буй тохиолдолд
- Холимог (нэгтгэсэн) хэрэгсэл нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдсэн өөрчлөлттэйгээ бодит үнэ цэнээрээ бүртгэгддэггүй (жишээ нь, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого зарлагын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрт агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэгсэл)

Зээлээр авсан санхүүжилт нь эздийн өмчид хамаарах хоёрдогч өглөг тодруулга 31-т тодруулсны дагуу хувьцаанд хөрвөх нөхцөлтэй болно.



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК 5183858 9021011195 СТС2420
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК 534 469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ ТУХСЕЙН ҮЦК ХХК ТТ58674 5208173

СЗХ
2022 .09. 21
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022 -09- 14
БҮРТГЭВ-03



## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

***Санхүүгийн баталгаа, аккредитив болон олгогдоогүй зээлийн үүрэг***

Банк нь санхүүгийн баталгаа, аккредитив болон зээлийн амлалт гаргадаг. Санхүүгийн баталгаа гаргаж өгсний улмаас хүлээн авсан урамшууллыг санхүүгийн тайлангуудад анхлан бүртгэхдээ бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Ийнхүү анхлан хүлээн зөвшөөрсний дараагийн тайлант үед баталгаа бүрт Банкны хүлээх харпуцлагыг хэмжихдээ анхлан хүлээн зөвшөөрсөн дүнгээс ашиг, алдагдлын тайланд бүртгэсэн хуримтлагдсан хорогдлыг хассан дүн хоёрын аль өндрөөр нь хэмжинэ.

Хүлээн авсан урамшууллыг баталгааны хугацааны туршид ашиг, алдагдлын тайланд “Хураамж ба шимтгэлийн орлого”-оор хүлээн зөвшөөрнө.

Олгогдоогүй зээлийн амлалт болон аккредитив нь амлалт бөгөөд энэхүү амлалтын хугацаанд Банк нь урьдчилан тодорхойлсон нөхцөлтэй зээлийг харилцагчид олгох шаардлагатай. Санхүүгийн баталгааны гэрээнүүдийн адилаар тэдгээр гэрээнүүдэд “Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал”-ын шаардлагуудын дагуу сан байгуулна.

Санхүүгийн баталгаа, аккредитив болон ашиглагдаагүй зээлийн гэрээний үнэ цэнэ нь зах зээлд олгогдох зээлийн гэрээний нөхцөлтэй ижил байхаас гадна санхүүгийн байдлын тайланд тусгагдахгүй. Энэхүү санхүүгийн хэрэгслүүдийн нэрлэсэн үнэ болон үнэ цэнийн бууралтын хүлээгдэж буй алдагдал нь Тодруулга 33-д тусгагдсан.

***Харилцагчдын харилцах, хадгаламж***

Үүнд харилцагчдаас авсан харилцах, хугацаагүй, хугацаатай хадгаламж болон Банкны баталгааны эх үүсвэр хамаарна. Анхны хэмжилтийн дараа үед харилцагчдад өгөх өр төлбөрүүдийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

***Бусад санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж***

Бусад Банк, санхүүгийн байгууллагуудаас татсан төгрөгийн болон валютын хадгаламжууд болон дотоод гадаадын арилжааны банкууд, Монголбанкны хугацаатай хадгаламжууд мөн хамаарна. Банк нь, харилцагчдийн харилцах хадгаламжийг мөнгөн хөрөнгө нь Банкинд шилжсэн үед хүлээн зөвшөөрдөг. Анхны хэмжилтийн дараа бусад Банкуудад өгөх өр төлбөрийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

**Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн дахин ангилал**

Банк санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсөнөөс хойш бизнесийн шугам худалдан авах, дуусгах болон цуцлах онцгой нөхцөл байдлаас бусад нөхцөлд дахин ангилахгүй. Санхүүгийн өр төлбөр дахин ангилагддагүй.

**Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн өөрчлөлт**

***Санхүүгийн хөрөнгийн өөрчлөлт***

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын болон зээлийн эрсдэлийн бус шалтгаанаар арилжааны бүтцийн өөрчлөлтийн үйл ажиллагааны үр дүнд гэрээний мөнгөн гүйлгээг дахин тохиролцсон эсвэл өөр хэлбэрээр бүтцийн өөрчлөлт оруулсан тохиолдолд, Банк уг өөрчлөлт нь тухайн санхүүгийн хөрөнгийг данснаас хасахад хүргэсэн эсэхийг тодорхойлох үнэлгээг хийдэг. Санхүүгийн хөрөнгийн хувьд энэхүү үнэлгээ нь чанарын хүчин зүйл дээр суурилдаг.

Банк харилцагчид олгосон зээлийг үл хүлээн зөвшөөрөх эсэхийг үнэлэхдээ доорх нөхцөлүүдийг авч үздэг:

- зээлийн валют өөрчлөгдсөн
- өмчийн шинж чанар тодорхойлогдсон
- бизнесийн түнш өөрчлөгдсөн
- өөрчлөлтийн улмаас ҮТХТ-ийн шалгуур хангахгүй байх

Хэрвээ өөрчлөлт нь мөнгөн урсгалд мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй бол энэ өөрчлөлтийг үл хүлээн зөвшөөрөх гэж авч үзэхгүй. Мөнгөн урсгалын өөрчлөлтийг анхны үр ашигт хүүгээр хорогдуулсан дүнд үндэслэн Банк үнэ цэнийн бууралтын алдагдал бүртгээгүй бол өөрчлөлтийг нь ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ.



УЛААНБААТАР ХОТ
5163035
2021031195 СТС2420
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341159 ГСТ5332
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК
ТТБ8674 5208173

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022-09-14
БҮРТГЭВ-03



## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

*Санхүүгийн өр төлбөрийн өөрчлөлт*

Одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн нөхцлийн өөрчлөлт нь мэдэгдэхүйц нөлөөтэй гэж үзээгүй, улмаар данснаас хасахад хүргэхгүй тохиолдолд санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг гэрээнд заасан прээдүйн тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцоолохдоо санхүүгийн өр төлбөрийн анхны үр ашигт хүүгийн хувиар хорогдуулан дахин тооцоолно. Үүний үр дүнд гарсан аливаа зөрүүг шууд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Банк санхүүгийн өр төлбөрийн хувьд, чанарын хүчин зүйлээс хамаарч, засварласан хямдруулсан өнөөгийн үнэ цэнэ болон санхүүгийн өр төлбөрийн анхны дансны үнийн хооронд арав буюу түүнээс дээш хувьтай зөрүү гарахад хүргэсэн өөрчлөлтийг мэдэгдэхүйц гэж үзнэ.

**Санхүүгийн хөрөнгө үл хүлээн зөвшөөрөлт**

*Хугацаа болон нөхцөлд их хэмжээгээр өөрчлөлт орсонтой холбоотой үл хүлээн зөвшөөрөх*

Харилцагчдад олгосон зээл гэх мэт санхүүгийн хөрөнгийг гэрээний нөхцөл нь шинэ зээл шиг болж өөрчлөгдөхөд үл хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралт хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд эдгээр хөрөнгийн хувьд зөрүүг нь үл хүлээн зөвшөөрөлтийн олз, гарзаар бүртгэнэ. Шинээр хүлээн зөвшөөрсөн зээл нь үнэ цэнэ буурсан зээлийг худалдаж авсан нөхцөлд биш бол уг зээл нь зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал тооцоолох үүднээс 1-р шатлалд ангилагдана.

*Санхүүгийн хөрөнгө*

Банк санхүүгийн хөрөнгийг (санхүүгийн хөрөнгийн хэсэг эсвэл хоорондоо төстэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн хэсэг) тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан үед үл хүлээн зөвшөөрнө. Мөн Банк нь хөрөнгийг шилжүүлсэн бөгөөд шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх шаардлагыг хангаж байгаа нөхцөлд хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (санхүүгийн хөрөнгийн хэсэг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгийн хэсэг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Банк тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн, эсвэл
- "Дамжуулан өнгөрөөх" хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн

Дамжуулан өнгөрөөх хэлцэл нь Банк тухайн санхүүгийн хөрөнгөөс хүлээх гэрээний эрхээ хадгалж үлдэх бөгөөд (анхны хөрөнгө) доорх гурван нөхцөл биелж байх нөхцөлд гэрээний үүргийн дагуу тэдгээр хүлээн авсан мөнгөн урсгалыг нэг болон түүнээс дээш байгууллагад (эцсийн хүлээн авагчид) шилжүүлнэ:

- Хэрэв тухайн нэг байгууллагын зээлдүүлсэн дүн дээр хаx зээлийн хүүгээр хуримтлагдсан хүүтэй хамт бүрэн авах эрхтэй богино хугацаат урьдчилгаа оруулалгүйгээр Банк нь эцсийн хүлээн авагчид анхны хөрөнгө нь дүйцэх хэмжээний мөнгөн урсгалыг цуглуулаагүй цагт ямар нэгэн төлбөр төлөх үүрэггүй болно.
- Банк нь эцсийн хүлээн авагчдаас үнэт цааснаас бусад нөхцөлөөр анхны хөрөнгийг зарах эсвэл барьцаалж болохгүй,

Үүнээс гадна, Банк нь тэдгээр мөнгөн урсгалыг, цуглуулсан өдрөөс шаардлагатай гүйвүүлгын өдөр хүртэлх мөнгө болон түүнтэй адилттах хөрөнгө оруулалт хийсэн хугацаанаас бусад үед дахин хөрөнгө оруулалтад оруулахгүй.

Шилжүүлэлтийг зөвхөн доорх нөхцөлүүдийг хангасан тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө:

- Банк хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн, эсвэл
- Банк тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй болон хадгалж үлдээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

Хэрвээ шилжүүлэгч холбогдолгүй гуравдагч этгээдэд хөрөнгийг бүхэлд нь зарах болон шилжүүлэхэд нэмэлт хязгаарлалтгүйгээр тухайн чадварыг эзэмшдэг гэж үзсэн үед Банк хяналтыг шилжүүлсэн гэж үзнэ.



УЛААНБААТАР ХОТ
ЭНЭЙ ЭНД КА
5183536
9021031185 СТС2420

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341459 ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК
ТТ58674 5208173

СЭХ
2022.09.21
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ-03



## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

*Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)*

Банк хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл “дамжуулан өнгөрөөх” хэлцэл хийсэн болович хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Банкны үг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Банк холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөр Банкны хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан суурьтай хэмжигдэнэ.

Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Банкны төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

Хэрэв шилжүүлсэн хөрөнгөд үргэлжилсэн оролцоо бичгээр эсвэл худалдан авах опцион (эсвэл аль аль нь) хэлбэрээр байвал, Банкны үргэлжилсэн оролцоо нь эргүүлэн худалдан авахад төлөх шаардлагатай дүнгээр хэмжигдэнэ. Хөрөнгөд бичгээр худалдан авах опцион заасан байгууллагын үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ болон нөхцөлийн хэрэгжих үнийн аль багаар хязгаарлагдана.

*Санхүүгийн өр төлбөр*

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ болович ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзнэ. Анхны санхүүгийн өр төлбөрийн бүртгэлийн дүн ба төлсөн дүн хоёрын зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

**Санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг цэвэршүүлэх**

Ирээдүйн үйл явдлаас хамааралгүйгээр хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй ба доорх бүх нөхцөлд цэвэр дүнгээр нь барагдуулах хандлагатай байгаа үед санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлж, цэвэр дүнг санхүүгийн байдлын тайланд толилуулна.

Санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг СТОУС-ын цэвэршүүлэх шалгуурыг хангасан тохиолдлоос бусад тохиолдолд нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд тусад нь тусгадаг.

Дериватив нь зөвхөн ирээдүйд тохиолдох үйл явдлаас шалтгаалахгүйгээр хүлээн зөвшөөрөгдсөн дүнг нөхөх болзолгүй хууль ёсны эрхтэй байхаас гадна Банк дараах бүх тохиолдолд цэвэр зарчмаар төлбөр тооцоо хийхээр төлөвлөж байгаа тохиолдолд л цэвэр дүнгээр тооцож, тайлагнана.

- Бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед
- Чанаргүйдэл гарсан үед
- Банк эсвэл түүний хамтрагч талууд төлбөрийн чадваргүй болсон эсвэл дампуурсан үед.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО
КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮЙЦЭТГЭХ ҮЦК ХХК

СЗХ
он 2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022 -09- 14
БҮРТГЭВ



## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

**Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт**

***Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал (ЗҮЦХА) аргын ерөнхий ойлголт***

Банк "санхүүгийн хэрэгсэл" ангилалд хамаарах зээлийн үүрэг болон санхүүгийн баталгаа, бодит үнэ цэнийн өөрчлөлт ашиг, алдагдлын тайланд бүртгэгдээгүй бусад өрийн хэрэгсэл болон бүх зээлд зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын сан бүртгэсэн. СТОУС 9-н дагуу өмчийн хэрэгсэл нь үнэ цэнийн бууралтад орохгүй.

ЗҮЦХА нь хөрөнгийн ашиглалтын нийт хугацаанд үүсэх зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлаас хамаарна. Хэрэв анх бүртгэснээс хойш алдагдал нь мэдэгдэхүйц хэмжээгээр өсөөгүй бол алдагдал нь 12 сарын хүлээгдэж буй алдагдлаас хамаарна. Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өөрчлөгдсөн эсэхийг хэмжих Банкны бодлого журмыг тодруулга 30-д тайлбарлав.

Ирээдүйн 12 сарын ЗҮЦХА нь нийт хугацааны ЗҮЦХА аргын нэг хэсэг байх бөгөөд тайлагналын өдрийн дараах 12 сард санхүүгийн хэрэгслийн чанаргүйдлийн магадлалын үр дүнгээр ЗҮЦХА-г илэрхийлнэ.

Санхүүгийн хэрэгслийн үндсэн багцаас шалтгаалан нийт хугацааны ЗҮЦХА болон ирээдүйн 12 сарын ЗҮЦХА-г тусгай болон бүлгийн үнэлгээгээр тооцоолно. Банк нь бүлэг санхүүгийн хөрөнгийг бүлгийн үнэлгээний аргаар хэмжинэ.

Банк нь үнэлгээ хийх журмыг тодорхойлсон бөгөөд тайлант үеийн эцэс бүрт санхүүгийн хэрэгслийн үлдэх хугацаанд үүсч болох эрсдэлийн өөрчлөлтийг харгалзан санхүүгийн хэрэгслийг анх бүртгэснээс хойш ЗҮЦХА-д мэдэгдэхүйц өссөн эсэхийг авч үзнэ.

Дээр дурдсан процесс дээр тулгуурлан, Банк нийт зээлийн багцаа зээлийг шатлал 1, шатлал 2, шатлал 3 гэж ангилсан:

Шатлал 1: Зээлийг анх хүлээн зөвшөөрөх үед Банк нь 12 сарын ЗҮЦХА-г бүртгэнэ. Мөн шатлал 1-рүү үүсч болох эрсдэл
нь буурсан шатлал 2-ын зээлүүд дахин ангилагдана.
Шатлал 2: Анх хүлээн зөвшөөрсөн үеэс зээлийн үүсч болох эрсдэл ихэссэн үед Банк нь нийт хугацааны ЗҮЦХА-г
бүртгэнэ. Мөн шатлал 2-руу үүсч болох эрсдэл нь буурсан шатлал 3-ын зээлүүд дахин ангилагдана
Шатлал 3: Үнэ цэнийн бууралтад орсон зээлүүд багтана. Банк нь нийт хугацааны турш ЗҮЦХА-г бүртгэнэ.

Банк нь санхүүгийн хөрөнгийг төлөгдөх нийт дүн эсвэл зарим хэсгийг төлөгдөх боломжгүй гэж үзвэл санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулна. Үүнийг санхүүгийн хөрөнгийн (хэсэгчилсэн) үл хүлээн зөвшөөрөлт гэнэ.

**ЗҮЦХА тооцоолол**

Банк нь үр ашигт хүүгээр хорогдуулсан хүлээгдэж буй мөнгөний дутагдлыг хэмжих магадлалын-жигнэсэн гурван хувилбараар ЗҮЦХА-г тооцоолдог. Мөнгөний дутагдал нь гэрээний дагуух мөнгөн гүйлгээ болон эргэн төлөгдөхөөр хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний зөрүү юм.

ЗҮЦХА тооцооллын механизмийг болон гол элементүүдийн хамт доор үзүүлэв:

| | |
|---|---|
| ЧМ | Чанаргүйдлийн магадлал (ЧМ) нь өгөгдсөн цаг хугацаанд төлбөрийн чадваргүй болох магадлалаар тооцоолно. Хэрвээ хэрэгсэл нь өмнө нь үл хүлээн зөвшөөрч байгаагүй мөн харгалзах багцад үргэлжлүүлэн байгаа бол үнэлсэн хугацааны тодорхой хугацаанд нэг удаа алдагдал үүсэх боломжтой. |
| ЧӨД | Чанаргүйдэлд өртөх дүн (ЧӨД) нь тайлагналын дараах зээлийн хүлээгдэж буй өөрчлөлт, гэрээний дагуух үндсэн төлбөр болон хүүгийн эргэн төлөлт, зээлийн үүргийн хүрээнд нэмж олгосон дүн болон төлбөр хоцорсноор үүсэх хуримтлагдсан хүүг харгалзсан тооцоолол. |
| АХЧ | Алдагдалд хүргэх чанаргүйдэл (АХЧ) нь өгөгдсөн цаг хугацааны турш чанаргүйдлийн үеийн алдагдлын тооцоолол юм. Энэ нь гэрээний дагуу мөнгөн урсгал болон зээлдэгч хүлээн авахаар тооцоолсон дүн, барьцаа хөрөнгө борлуулсан дүнгийн нийлбэрийн зөрүүнээс тооцно. |



УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
5183835
9021 31195 СТС2420
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
БУЛЛЕКС ҮЦК ХХК
ТТ5674 5206173

СЗХ
2022 .08сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022 -09- 14
БҮРТГЭВ-03



## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

**Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)\
ЗҮЦХА тооцоолол (Үргэжлэл)**

ЗҮЦХА тооцоолох үед Банк 4 хувилбарыг авч үздэг (суурь, эерэг, бага зэрэг сул тал (сөрөг тал 1) болон илүү сул тал (сул тал 2). Эдгээр нь өөр өөр ЧМ, ЧӨД болон АХЧ-д хамаарагдана. Хамааралтай үед олон тооны хувилбарыг үнэлэхдээ төлбөр төлөгдөхгүй байх магадлал, алдагдал хүлээх магадлал, зээлийн эргэн төлөгдөх магадлал болон барьцаа хөрөнгийн үнэ цэнэ эсвэл борлуулснаар олж болох дүнгүүдийн нэгдлийг авч үзнэ.

Кредит карт болон бусад хөрөнгүүдийг үл харгалзан, зээлийн алдагдлын хамгийн урт хугацаа нь хууль эрх зүйн үндэслэлээр гэрээний хугацааг сунгаагүй тохиолдолд санхүүгийн хэрэгслийн гэрээний хугацааг авч үздэж байгаа. Үнэ цэнийн бууралт нь бүтцийн өөрчлөлтийн ашиг, алдагдлаас тусдаа санхүүгийн хөрөнгийн цэвэр дүнгийн залруулга гэж тайлагнаж бүртгэгдэнэ.

Үнэ цэнийн бууралтын зардал болон буцаалт нь санхүүгийн хөрөнгийн дансны үнийн өөрчлөлтийн ашиг алдагдлын тохируулгаас тусад нь бүртгэх болон толилуулна. ЗҮЦХА-ын аргыг доор хураангуйлав:

| | |
|---|---|
| Шатлал 1: | Ирээдүйн 12 сарын ЗҮЦХА нь нийт хугацааны ЗҮЦХА загварын нэг хэсэг байх бөгөөд тайлагналын өдрийн дараах 12 сард санхүүгийн хэрэгслийн чанаргүйдлийн үр дүнгээр ЗҮЦХА-ыг илэрхийлнэ. Банк нь ирээдүйн 12 сарын ЗҮЦХА тайлагналын өдрөөс хойш 12 сарын дотор ЧМ-д үндэслэн тооцдог. ЧӨД-ийн урьдчилсан төсөөлөлд 12 сарын дотор хүлээгдэж буй ЧМ-ыг хэрэглэх бөгөөд хүлээгдэж буй АХЧ-аар үржүүлэгдэж анхны үр ашигт хүүтэй ойролцоо дүнгээр хорогдуулна. Энэхүү тооцооллыг дээр дурдсан гурван хувилбар тус бүрт авч үзнэ. |
| Шатлал 2: | Зээлийг анх олгосноос хойш тухайн зээлд зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлттэй байгаа нь тогтоогдсон зээлүүдэд Банк нь нийт хугацааны ЗҮЦХА-ын сан байгуулан бүртгэнэ. Санг байгуулахдаа дээрхийн адилаар хэд хэдэн хувилбарууд дээр үндэслэн тооцоолох боловч ЧМ болон АХЧ-ыг нь нийт хугацаанд тооцоолж гаргана. Хүлээгдэж буй мөнгөний дутагдал нь үр ашигт хүүтэй ойролцоо дүнгээр хорогдуулна. |
| Шатлал 3: | Үнэ цэнэ буурсан гэж үзсэн зээлийн хувьд, Банк нь нийт хугацааны ЗҮЦХА-ыг бүртгэнэ. Энэ аргачлал нь Шатлал 2-т ашигласантай ижил бөгөөд ЧМ-ыг 100% гэж үзнэ. |
| Зээлийн үүрэг болон аккредитив | Зээлийн үүрэгт нийт хугацааны ЗҮЦХА тооцоход, Банк нь ирээдүйд олгогдох зээлийн үүргийн дүнг тооцоолно. Зээл олгогдох тохиолдолд ЗҮЦХА нь магадлал жигнэсэн гурван хувилбараар хүлээгдэж буй мөнгөний дутагдлын өнөөгийн үнэ цэнээр тооцогдоно. Хүлээгдэж буй мөнгөний дутагдал нь хүлээгдэж буй үр ашигт хүүгээр хорогдуулсан байна. Зээлийн үүрэг болон аккредитивын хувьд, ЗҮЦХА нь бусад өглөгт хүлээн зөвшөөрөгдөнө. |
| Санхүүгийн баталгааны гэрээнүүд | Банкны санхүүгийн баталгаа тус бүрийн үүрэг нь анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрөгдсөн хуримтлагдсан хорогдол хассан дүн болон ЗҮЦХА сангийн аль их нь хэмжигдэнэ. Банк нь ЗҮЦХА-г эзэмшигчид нөхөн олгох дүнгийн өнөөгийн үнэ цэнэ дээр үндэслэн тооцно. Эрсдэлээр тохируулсан хүүгээр дутагдлыг хорогдуулна. Тооцоолол нь магадлалын-жигнэсэн гурван хувилбар дээр хийгдэнэ. Санхүүгийн баталгааны ЗҮЦХА нь бусад өглөгт хүлээн зөвшөөрөгдөнө. |

***Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэх өрийн хэрэгсэл***

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэгслийн ЗҮЦХА нь санхүү байдлын тайланд санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулахгүй бөгөөд бодит үнэ цэнээр байна. Үүний оронд, хэрвээ хөрөнгө нь хорогдуулсан өртгөөр бүртгэсэн байсан бол үүсэх үнэ цэнийн бууралтыг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хуримтлагдсан үнэ цэнийн бууралтаар болон нөгөө талд ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ. Бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэсэн хуримтлагдсан алдагдлын хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх үед ашиг, алдагдлын тайланд шилжүүлэн бүртгэнэ.

***Кредит карт ба бусад зээлийн шугамууд***

Банкны бүтээгдэхүүний санал нь олон төрлийн аж ахуйн буюу жижиглэнгийн зээлийн болон кредит картын хэрэгслийг багтаасан бөгөөд үүнд Банк нэг өдрийн өмнөх мэдэгдлээр хэрэгслийг цуцлах, эсвэл бууруулах эрхтэй. Банк зээлийн алдагдлын эрсдэлийг гэрээний мэдэгдлийн хугацаагаар зөвхөн хязгаарладаггүй бөгөөд үүний оронд үйлчлүүлэгчдийн зан төлөв, чанаргүйдлийн магадлал болон цаашдын эрсдэлийг бууруулах журмыг харгалзан хугацааны туршид үнэ цэнийн бууралтын алдагдлыг тодорхойлон тооцдог. Банкны өмнөх туршлага болон банкны хүлээлт дээр үндэслэн эдгээр бүтээгдэхүүнүүдийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг тооцдог хугацаа нь зээлийн картын хувьд арван хоёр сар, зээлийн төлбөрийг хэтрүүлсэн тохиолдолд гучин зургаан сар байдаг.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183253
СТС2430

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341468
ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК
ТТБ6874 5208173

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭВ-03



## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

***Кредит карт ба бусад зээлийн шугамууд (үргэлжлэл)***

Эдгээр бүтээгдэхүүнүүдийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэх талаар одоо байгаа үнэлгээ нь зээлийн бусад бүтээгдэхүүнтэй адил байна. Энэ нь харилцагчийн дотоод зээлийн зэрэглэлд суурилсан боловч хэрэглээний өөрчлөлт зэрэг чанарын хүчин зүйлүүдээс ихээхэн шалтгаалж байгаа. Зээлийн карт болон овердрафт-д үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлыг дискаунтлахад ашигладаг зээлийн хүүгийн хэмжээ нь тухайн бүтээгдэхүүнүүдийн өртөж болзошгүй хугацааны туршид тооцогдох жилийн үр ашигт хүүгийн жилийн түвшинг үндэслэнэ. Энэхүү тооцоонд олон бүтээгдэхүүнүүд сар бүр бүрэн төлөгддөг тул хүү тооцоогүй болно.

***Ирээдүйн мэдээлэл***

ЗҮЦХА-ын загварт, Банк эдийн засгийн өгөгдлүүд дээр суурилсан ирээдүйн мэдээлэл дээр тулгуурладаг. Үүнд нь:

- Инфляц
- Эдийн засгийн өсөлт
- АНУ-н долларын ханш
- Зээлийн өсөлт
- Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт (M2)
- Хадгаламжийн хүүгийн түвшин (жигнэсэн дундаж ханш)
- Зээлийн хүүгийн түвшин (жигнэсэн дундаж ханш)

ЗҮЦХА-ын тооцоололд ашиглаж буй мэдээлэл нь санхүүгийн тайлангийн өдрөөрх зах зээлийн бүх шинж тэмдгийг агуулаагүй байх магадлалтай. Үүнийг шийдэхийн тулд, эдгээр ялгаа нь мэдэгдэхүйц материаллаг үед заримдаа түр тохируулга хийдэг.

***Зээлийн сайжруулалт: Барьцаа хөрөнгийн үнэлгээ болон санхүүгийн баталгаа***

Санхүүгийн хөрөнгийн эрсдэлийг бууруулах үүднээс, Банк нь боломжтой үедээ барьцаа хөрөнгийг ашигладаг. Барьцаа хөрөнгө нь төрөл бүрийн хэлбэрээр байдаг, жишээ нь: мөнгөн хөрөнгө, үнэт цаас, аккредитив болон баталгаа, үл хөдлөх хөрөнгө, авлага, бараа материал, бусад санхүүгийн бус хөрөнгө болон үр дүнгийн тооцооны гэрээ байна. Барьцаа хөрөнгийг эзэмшээгүй тохиолдолд Банкны санхүүгийн байдлын тайланд бүртгэхгүй.

Зээлийн сайжруулалтаас хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг, СТОУС-ын дагуу тусад нь хүлээн зөвшөөрөх шаардлагагүй бөгөөд өр төлбөрийн хэрэгслийн гэрээний нөхцлүүдийн салшгүй хэсэг гэж тооцогддог ба зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын хэмжилтэд оруулдаг. Үүний үндсэн дээр барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ нь үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын тооцоонд нөлөөлдөг. Барьцаа хөрөнгийг ерөнхийд нь хамгийн багадаа анх хүлээн зөвшөөрөхдөө болон хагас жилийн хугацаанд дахин үнэлдэг.

Боломжийг нэмэгдүүлэх зорилгоор, Банк нь барьцаа хөрөнгийн зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгийг үнэлэхдээ идэвхтэй зах зээлийн мэдээллийг ашигладаг. Идэвхтэй зах зээл байхгүй бусад санхүүгийн хөрөнгийг үнэлгээний аргийг ашиглан үнэлдэг. Санхүүгийн бус барьцаа хөрөнгийг (жишээ нь: үл хөдлөх хөрөнгө) ипотекийн зуучлагч буюу 3 дагч этгээдээс ирсэн мэдээлэлд эсвэл орон сууцны үнийн индексүүдэд үндэслэн үнэлнэ. Барьцаалагдсан зээл нь зээлийн гэрээний нөхцөлд тусгагдсан эсвэл зээлийн салшгүй хэсэг болох ба зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын тооцоонд хамрагдсан болно.

Зээлийн гэрээний нөхцөлтэй холбоогүй баталгааг балансын гадуурх зүйл ангид салангид үзүүлэх бөгөөд үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын тооцооллыг хийдэг.

**Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө**

Хураан авсан барьцаа хөрөнгө нь уг хөрөнгийг бүртгэсэн өдрөөрх холбогдох зээлийн үлдэгдлийн хорогдуулсан өртөг болон бодит үнэ цэнээс борлуулах өртгийг хассан дүнгийн аль багаар анхлан хүлээн зөвшөөрдөг ба холбогдох зээл болон урьдчилгаа мөн тэдгээрийн үнэ цэнийн бууралтын сан балансын бүртгэлээс хасдаг. Дараагийн тайлант үеүдэд, хураан авсан барьцаа хөрөнгийг өртөг болон бодит үнэ цэнээс түүний борлуулахтай холбоотой гарах зардлыг хассан дүнгийн аль багаар бүртгэдэг ба эдгээр хөрөнгүүд нь тайланд бусад хөрөнгө хэсэгт тайлагнагддаг.

Борлуулах зориулалттай хөрөнгийн ангиллын шалгуур нь зөвхөн борлуулах өндөр магадлалтай байх бөгөөд хөрөнгийг одоогийн нөхцөлд нь шууд борлуулах боломжтой тохиолдолд л энэхүү шаардлагыг хангагдсан гэж үзнэ. Тухайн хөрөнгийн борлуулах шийдвэр нь буцаагүй байх эсвэл борлуулахад ямар нэгэн өөрчлөлт орох эсэхээс хамааран борлуулах үйл ажиллагаа нь тодорхойлогдоно. Удирдлага нь хөрөнгийг зарах төлөвлөгөөтэй байх шаардлагатай бөгөөд, ангилал хийсэн өдрөөс хойш нэг жилийн хугацаанд борлуулахаар төлөвлөж байх ёстой.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183835
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5241459 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ГҮЙЦЭТГЭХ ТЕРГҮҮН
ТТБ8874 5208173

СЗХ 2022 он 09 сар 21 өдөр БҮРТГЭВ № 01

2022-09-14 БҮРТГЭВ-03

**ТӨРИЙН БАНК ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2021 ОНЫ 12 САРЫН 31**

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

***Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө (үргэлжлэл)***

Борлуулах зорилалттай хөрөнгө гэж ангилсны дараа эд хөрөнгө, тоног төхөөрөмжийн элэгдлийг тооцохгүй. Худалдах зорилалттай гэж ангилагдсан хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд эргэлтийн зүйл болгон тусад нь үзүүлнэ. Нэмэлт тодруулгыг Тодруулга 19 болон Тодруулга 20-д тусгасан болно.

**Данснаас хасах**

Банк нь хөрөнгийн эргэн төлөлтийг зогсоосон үед санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн данснаас хасна. Хэрвээ данснаас хасах үнэ хуримтлагдсан алдагдлаас их тохиолдолд, зөрүүгээр нь алдагдлыг нэмэгдүүлж дараа нь дансны нийт үнийн дүнг бууруулна. Дараах үеийн эргэн төлөлтүүд нь зээлийн алдагдлын зардлыг бууруулна.

**Гэрээний нөхцөлд өөрчлөлт орсон зээлүүд**

Банк заримдаа барьцаа хөрөнгийг хураах гэхээсээ илүү зээлдэгчийн санхүүгийн хүндрэлийн улмаас зээлийн анхны нөхцөлд хөнгөлөлт, өөрчлөлт оруулдаг.

Зээлдэгчийн одоогийн эсвэл хүлээгдэж буй санхүүгийн хүндрэлээс үүдэн хөнгөлөлт, өөрчлөлтийг Банк хийж болно гэж үздэг бөгөөд зээлдэгч санхүүгийн хувьд хэвийн байсан бол Банк энэхүү хөнгөлөлт, өөрчлөлтийг зөвшөөрөхгүй болно. Санхүүгийн хүндрэлийг харуулсан үзүүлэлтүүд нь Гэрээг биелүүлээгүй байх эсвэл Зээлийн Эрсдэлийн хэлтсээс гаргасан үзүүлэлтүүдээр тодорхойлогдоно. Энэхүү өөрчлөлтүүдэд төлбөрийн хугацааг сунгах, зээлийн шинэ нөхцлийг зөвшөөрөх зэрэг орно. Гэрээний нөхцөл өөрчлөгдсөний дараа аливаа үнэ цэнийн бууралтыг тооцохдоо өөрчлөлтөөс өмнө тооцоолсон анхны үр ашигт хүүг ашиглан хэмжинэ. Шинэчилсэн зээлийн ирээдүйн төлбөрийг үргэлжлэх боломжтой гэдгийг хянах нь Банкны бодлого юм.

Зээлийг дахин тохируулж, өөрчилсөн боловч хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд зээлийн эрсдэл их хэмжээгээр нэмэгдсэн гэж үздэг тул зээлийг 2-р шатанд ангилдаг. Хөрөнгө нь 2-р шатанд ангилагдсаны дараа зөвхөн дараах шалгууруудыг хангаж байж төрөлд ангилагдах боломжтой:

- Бүх зээлүүд нь хэвийн байх ёстой
- Шинэчилсэн төлбөрийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу зургаан сарын хугацаанд тогтмол төлбөрийг хийж байсан байх
- Үйлчлүүлэгч хугацаа нь 30 хоногоос хэтэрсэн ямар ч гэрээ байгуулаагүй байх

Шинэчлэгдсэн буюу Өөрчлөлт орсон хөрөнгийн талаарх мэдээллийг 34-р тодруулгад тусгасан болно.

**Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө**

Мөнгөн гүйлгээний тайланд зааснаар бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд касс дахь мөнгө, Монголбанкин дахь хязгаарлалтгүй харилцах данс, Засгийн газрын үнэт цаас болон бусад Банкин дахь харилцах ба 3 сар түүнээс бага хугацаатай хадгаламжууд орно.

***Төв Банкинд байршуулсан, заавал байлгах нөөцийн үлдэгдэл***

Монголбанкинд байршуулсан, заавал байлгах нөөцийн үлдэгдлийг хорогдуулсан өртгөөр бүртгэх бөгөөд Банкны өдөр тутмын үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашиглах боломжгүй, заавал байлгах нөөцийн хүүгүй хадгаламж тул үүнийг мөнгөн гүйлгээний тайлан дахь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд оруулахгүй.

***Буцаан худалдан авах хэлцлүүд***

Ирээдүйд тодорхой заасан хугацаанд буцаан худалдан авах нөхцөлтэй хэлцэл ("репо")-ийн дор худалдсан үнэт цаасыг санхүүгийн байдлын тайлангаас үл хүлээн зөвшөөрөхгүй. Учир нь Банк эзэмшилтэй холбоотой их эрсдэлийг хүлээж, өгөөжийг хүртэж байна. Санхүүгийн байдлын тайланд хүлээн авсан бэлэн мөнгөө хөрөнгөөр, репо хэлцлийн хуримтлагдсан хүүг өр төлбөрөөр тус тус тустах ба энэ нь Банкинд олгосон зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлнэ. Борлуулсан ба ирээдүйд буцаан худалдан авах үнийн зөрүүг хүүгийн зардал гэж үзэж үр ашигт хүүгийн аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна. Нөгөө тал нь үнэт цаасыг худалдах эсвэл дахин барьцаалах эрхтэй бол, Банк нь тухайн үнэт цаасуудыг санхүүгийн байдлын тайландаа арилжаалах зорилалттай барьцаанд тавьсан санхүүгийн хөрөнгө эсвэл арилжаалах зорилалттай барьцаанд тавьсан санхүүгийн хөрөнгө оруулалтын аль тохиромжтой ангилалд үлдээнэ.



УЛААНБААТАР ХОТ ... 5163035 2021031155 СТС2420

УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК 5341469 ГСТ5332

УЛААНБААТАР ХОТ ГҮЙЦЭТГЭХ ҮЙЛ ХХК ТТБ9674 5208173

СЗХ
2022 .08 сар 24 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14
БҮРТГЭВ-03



## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

***Буцаан худалдан авах хэлцлүүд (үргэжлэл)***

Эсрэгээрээ, буцаан худалдах хэлцэл ("урвуу репо")-ийн дор худалдан авсан үнэт цааснуудыг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөггүй. Төлсөн мөнгөө хуримтлуулсан хүүгийн хамт тайлан тэнцэлд "Зээлсэн үнэт цаас ба урвуу буцаан худалдан авах хэлцлүүдийн бэлэн мөнгөөрх барьцаа" гэж тусгах ба энэ нь Банкнаас авсан зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлнэ. Худалдан авсан ба буцаан худалдах үнийн зөрүүг "Хүү болон түүнтэй адилтгах орлого" гэж бүртгэх ба үр ашигт хүүгийн аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна. Хэрэв буцаан худалдах хэлцлээр худалдан авсан үнэт цаасыг гуравдагч талд худалдсан бол үнэт цаасыг буцаан өгөх үүргийг "Худалдах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн өр төлбөр" гэж бүртгэх ба бодит үнэ цэнээр нь хэмжиж, бодит үнэ цэнийн аливаа олз эсвэл гарзыг "Арилжааны цэвэр орлого"-д бүртгэнэ.

**Үнэт цаасны зээллэгүүд ба өр төлбөр**

Үнэт цаасны зээллэг, зээлийн гүйлгээг ихэвчлэн үнэт цаас эсвэл бэлэн мөнгөөр барьцаалдаг. Үнэт цаасыг гэрээт этгээдэд шилжүүлэхдээ өмчлөлийн эрсдэл, өгөөжийг шилжүүлсэн тохиолдолд зөвхөн санхүүгийн байдлын тайланд тусгадаг. Барьцаалах хэлбэрээр урьдчилж авсан эсвэл хүлээн авсан бэлэн мөнгө нь хөрөнгө, өр төлбөр хэлбэрээр бүртгэгддэг.

Зээл авсан үнэт цаасыг дараа нь гуравдагч этгээдэд худалдахаас бусад тохиолдолд санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд энэ тохиолдолд үнэт цаасыг буцааж өгөх үүргийг арилжих зорилалттай санхүүгийн өр төлбөр дотор богино хугацааны борлуулалт хэлбэрээр бүртгэдэх бөгөөд бодит үнэ цэнийг нь ашиг алдагдалтай нь үнэлж цэвэр арилжаанаас олсон орлогод тайлагнана.

**Түрээс**

Банк нь гэрээ байгуулагдах үед түрээсийн шинж чанар агуулсан эсэхийг үнэлдэг. Өөрөөр хэлбэл гэрээнд тодорхойлогдож байгаа хөрөнгийг хэсэг хугацааны турш ашиглан хянах эрхийг шилжүүлсэн болно.

***Банк - түрээслэгч***

Банк нь богино хугацаатай түрээс эсвэл бага өртөгтэй хөрөнгийг түрээслэхээс бусад тохиолдолд бүх түрээсийг хүлээн зөвшөөрөх, хэмжих нэг аргыг ашигладаг. Банк нь түрээсийг төлөх түрээсийн өр төлбөрийг болон хөрөнгийг ашиглах эрхийг хүлээн зөвшөөрдөг.

*Ашиглах эрхийн хөрөнгө*

Банк нь ашиглах эрхийн хөрөнгийг түрээсийн өдрөөс эхлэн хүлээн зөвшөөрдөг (жишээлбэл, үндсэн хөрөнгийг ашиглах боломжтой болсон өдөр). Ашиглах эрхийн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтын алдагдлыг хасч өртгөөр нь хэмжиж, түрээсийн өр төлбөрийг дахин үнэлэхэд тохируулна. Ашиглах эрхийн хөрөнгийн өртөг түрээсийн өр төлбөр, хүлээн авсан түрээсийн эхний өртөг, түрээсийн урамшууллыг авалгүйгээр эхлэхээс өмнө хийсэн түрээсийн төлбөр орно. Ашиглах эрхийн эд хөрөнгийг түрээсийн хугацаанд шулуун шугамын дагуу элэгдэлд оруулдаг. Ашиглах эрх нь 24-р тодруулгад тусгагдсан бөгөөд Банкны бодлогын дагуу үнэ цэнийн бууралтад орно.

*Түрээсийн өр төлбөр*

Түрээсийн эхлэх өдөр Банк нь түрээсийн хугацаанд хийгдэх түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр хэмжсэн түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Түрээсийн төлбөрт тогтмол төлбөр (түрээсийн урамшууллыг аваагүй), индекс эсвэл хувь хэмжээнээс хамаарах хувьсах түрээсийн төлбөрүүд, үлдэгдэл үнийн баталгааны дагуу төлөх хүлээгдэж буй төлбөрүүд орно. Индекс эсвэл хувь хэмжээнээс хамааралгүй хувьсах түрээсийн төлбөрийг өдөөх үйл явдал, нөхцөл байдлын үеийн зардал гэж хүлээн зөвшөөрнө.

***Банк - түрээслүүлэгч***

Түрээсийн хөрөнгийн бүх эрсдэл ба өгөөжийн их хэмжээгээр шилжүүлээгүй түрээсийг үйл ажиллагааны түрээс гэж ангилдаг. Түрээсийн орлого нь түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар ашиг алдагдлын тайлангийн бусад орлогод хүлээн зөвшөөрөгдөнө. Үйл ажиллагааны түрээсийг тохиролцох, зохицуулахтай холбоотой анхны шууд зардлыг түрээслэсэн хөрөнгийн дансанд нэмж, түрээсийн хугацаанд орлоготой адил зарчмаар бүртгэнэ. Болзошгүй түрээсийн орлогыг тухайн хугацаанд бусад орлогод хүлээн зөвшөөрнө.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ
ҮЦДК ХХК

СЗХ
2022.09.21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14
БҮРТГЭВ-03



**2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)**

**2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)**

**Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө**

Хөрөнгө оруулалтын зорилалттай үндсэн хөрөнгийг анх шууд холбогдон гарсан аливаа зардлыг шингээсэн өртгөөр хүлээн зөвшөөрнө. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа бодит үнэ цэнийн аргаар тайлант өдөрөөрх зах зээлийн үнэлгээгээр тодлуулна. Бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн аливаа олз ба гарзыг холбогдох татварын нөлөөг тооцсон дүнгээр тайланд үед ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнийг тодорхойлохдоо Олон улсын үнэлгээний стандартын хорооноос зөвлөсөн үнэлгээний загварыг мөрдсөн хараат бус мэргэшсэн үнэлгээчний жилийн үнэлгээний тайланг үндэслэнэ.

Хөрөнгө оруулалтын зорилалттай хөрөнгийг борлуулсан үед(жишээ нь худалдан авагч тал тухайн хөрөнгийг бүрэн ашиглах эрхийг авсан өдрөөр) эсвэл ашиглалтаас бүрэн гарсан болон тухайн хөрөнгийг борлуулснаар хүртэх эдийн засгийн өгөөж байхгүй болсон үед данснаас хасна. Тухайн хөрөнгө оруулалтын зорилалттай хөрөнгийг данснаас хасахдаа бусад хувьсах хүчин зүйлүүд болох гол санхүүгийн бүрэлдэхүүн оршиж байгаа эсэх, мөнгөн бус шинжтэй давуу талууд болон худалдан авагч талд өгөх өглөг(зарим тохиолдолд) зэргийн нөлөөг авч үзнэ.

Хэрэв хөрөнгийн зорилалтад өөрчлөлт орсон бол хөрөнгө оруулалтын зорилалттай үл хөдлөх хөрөнгөөс/-д шилжүүлдэг. Хөрөнгө оруулалтын зорилалттай үл хөдлөх хөрөнгийг банкны ашиглалтад буй үндсэн хөрөнгөрүү шилжүүлэх тохиолдолд ашиглалтад өөрчлөлт орсон өдрөөрх бодит үнэ цэнээр хөрөнгийн өртгийг тооцож дараагийн хэмжилтүүдийг хийнэ. Үндсэн хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зорилалттай үл хөдлөх хөрөнгөд шилжвэл, Банк нь тухайн өдрөөр дагаж мөрдөж буй Үндсэн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу хүлээн зөвшөөрнө.

**Үндсэн хөрөнгө болон ашиглах эрхийн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтын алдагдлыг хасч тооцсон өртгөөр бүртгэнэ. Хүлээгдэж буй ашиглалтын хугацааны өөрчлөлтийг тооцохдоо, нөхөн төлбөрийн хугацаа, аргачлалыг өөрчлөх замаар тооцно. Ашиглах эрхтэй хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд хөрөнгө, тоног төхөөрөмжөөс тусад нь харуулав. Ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн хугацаанд шулуун шугамын дагуу элэгдүүлнэ.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тухайн хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцно:

| | |
|---|---|
| Барилга | 40 жил |
| Компьютер | 2 жил |
| Оффисын тавилга, тоног төхөөрөмж | 10 жил |
| Тээврийн хэрэгсэл | 10 жил |

Үйлчлүүлэгчээс шилжсэн эд хөрөнгө, тоног төхөөрөмжийг хяналтандаа авсан өдрөөс эхлэн бодит үнэ цэнээр нь хэмждэг.

Барилгыг дараагийн тайлант хугацаанд хуримтлагдсан элэгдэл болон үнэлгээ хийсэн өдөр хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр хэмжинэ. Дахин үнэлж буй хөрөнгийн дансны үнийг бодит үнэ цэнээс материаллаг байдлаар зөрүүгүй байлгах давтамжтайгаар хөрөнгийн үнэлгээг хийнэ.

Барилгыг дахин үнэлэх давтамж нь үнэлж буй тэдгээрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс хамаарна. Үнэлж буй хөрөнгийн бодит үнэ цэнэ нь бүртгэлийн дүнгээсээ материаллаг хэмжээгээр зөрж буй үед цаашдын дахин үнэлгээ шаардлагатай. Зарим барилгын бодит үнэ цэнэ нь их хэмжээгээр, хувьсан өөрчлөгддөг тул жил бүр үнэлэх шаардлагатай байдаг. Бодит үнэ цэнэ нь бага хэмжээгээр өөрчлөгддөг барилгын хувьд тогтмол үндсэн хөрөнгийн үнэлгээ шаардлагагүй. Үүний оронд гурав эсвэл таван жил тутам үнэлэх шаардлагатай.

Үндсэн хөрөнгө дахин үнэлснээс үүссэн нэмэгдлийг эздийн өмчийн тайлангийн үндсэн хөрөнгө дахин үнэлсний нэмэгдэл хэсэгт тайлагнана. Хэрэв үндсэн хөрөнгийг өмнө нь дахин үнэлээд дахин үнэлгээний бууралтыг орлого үр дүнгийн тайланд тусгасан байсан хөрөнгийг дахин үнэлснээр нэмэгдэл бүртгэхээр байвал өмнөх тайлант хугацаанд хүлээн зөвшөөрсөн зардлыг буцааж орлого үр дүнгийн тайланд тайлагнаж болно.

Хөрөнгийн үнэлгээний илүүдлээс хуримтлагдсан ашиг руу шилжүүлгийг дахин үнэлэгдсэн хөрөнгийн илүүдэл элэгдэлтэй тэнцэх хэмжээний дүнтэй хийнэ. Нэмж дурдвал, дахин үнэлгээний өдөр хуримтлагдсан элэгдлийг хөрөнгийн дансны нийт дүнгээс хасч, цэвэр дүнг хөрөнгийн дахин үнэлэгдсэн дүнгээр буцаана. Борлуулсан тохиолдолд, зарагдаж буй тодорхой хөрөнгөтэй холбоотой дахин үнэлгээний үлдэгдлийг хуримтлагдсан ашиг руу шилжүүлнэ.



УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГУРАВЫН
ҮЦК ХХК

СЗХ
2022 .09. 21
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭВ-03

**ТӨРИЙН БАНК ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2021 ОНЫ 12 САРЫН 31**

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

**Үндсэн хөрөнгө болон ашиглах эрхийн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашгийн хүлээлт үгүй болсон үед үл хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого (борлуулснаас олсон орлого болон хөрөнгийн дансны үнийн зөрүүгээр тооцно), дансны цэвэр үнэ хоёрын зөрүүг орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдүүлэх аргыг санхүүгийн жилийн эцэс бүрт хянаж үздэг ба зохистой үед залруулж тохируулдаг.

Дуусаагүй барилгын өртөгт барилгын материал болон бусад холбогдох нэмэлт зардал орох ба үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр бүртгэгддэг. Дуусаагүй барилгын ажил дуусч ашиглалтанд орох хүртэл элэгдэл тооцогддоггүй.

**Биет бус хөрөнгө**

Банкны биет бус хөрөнгөд компьютерийн програм хангамж лиценз болон газар ашиглах эрх орно.

Зөвхөн биет бус хөрөнгийн өртгийг зохистойгоор хэмжиж болох ба хүлээгдэж буй эдийн засгийн ирээдүйн өгөөж Банкинд орж ирэх нь магадлалтай болсон үед биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Тусд нь авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Бизнесийн нэгдлийн үед олж эзэмшсэн биет бус хөрөнгийн өртөг нь олж эзэмшсэн өдрийн бодит үнэ цэнэ байна. Анх хүлээн зөвшөөрсний дараа, биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт болон үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан өртгөөр нь тайланд тусгадаг.

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхой эсвэл тодорхой бус эсэхийг үнэлнэ. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай хугацааны туршид нь хорогдуулна. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон аргыг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үздэг. Хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загварт орсон өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсвэл аргын аль тохиромжтойг нь өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ. Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг орлогын тайланд биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцсэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө. Газар ашиглах эрхийн хугацаа тодорхойгүй бөгөөд тайлант жил бүр үнэ цэнийн бууралтад орсон эсэхийг үнэлдэг.

Биет бус хөрөнгийн өртгийг дараах ойролцоогоор тооцоолсон ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргыг ашиглан, үлдэх өртөг хүртэл нь хорогдуулна. Үүнд:

| | |
|---|---|
| Компьютерийн програм хангамж (Банкны үндсэн програм хангамж) | 2-10 жил |
| Програм хангамж, лиценз | 1-3 жил |

**Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт**

Хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсон байж болох шинж тэмдэг байгаа эсэхийг Банк тайлант хугацаа тутамд шалгаж үздэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрсэн эсвэл жилд нэг удаа хийдэг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын тестийг хийж гүйцэтгэх үед Банк нь хөрөнгөөс цуглуулан авах боломжтой дүнг тооцож үздэг. Цуглуулан авах дүн нь хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн бодит үнэ цэнэ (борлуулалтын зардлыг хасаж тооцсон) ба ашиглалтын өртөг хоёрын аль өндөр нь байна. Цуглуулан авах боломжтой дүнг тооцохдоо хөрөнгө нь бусад бүлэг хөрөнгийн хамт эсвэл хамааралтай байдлаар мөнгөн урсгал бий болгодоггүй бол хөрөнгө тус бүрээр тооцоолно. Хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн дансны дүн нь цуглуулан авах дүнгээс илүү байгаа үед хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн цуглуулан авах дүн хүртэл нь бууруулж бүртгэнэ.

Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөд харгалзах эрсдэлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр бууруулан өнөөгийн үнэ цэнийг олно. Борлуулалтын зардлыг хассаны дараах бодит үнэ цэнийг тодорхойлохдоо тохиромжтой үнэлгээний загварыг ашиглан тооцоолно. Үнэлгээний үржүүлэгч, нийтэд хувьцаагаа зардаг охин компанийн хөрөнгийн бирж дээрх хувьцааны үнэ эсвэл бодит үнэ цэнийн бусад үзүүлэлтүүдээр эдгээр тооцооллыг хэмжиж болно. Тасралтгүй үйл ажиллагааны үнэ цэнийн бууралтын алдагдал нь орлого үр дүнгийн тайланд тайлагнана. Зөвхөн дахин үнэлгээгээр үнэлэгдсэн өмч хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг хөрөнгийн дүнтэй нийцүүлэн дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Гүүдвиллээс бусад хөрөнгүүд дээр, тайлагналын өдөр бүр өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал арилсан эсвэл буурсан эсэх талаар ямар нэгэн шинж тэмдэг байгаа эсэх талаар үнэлгээ хийдэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл Банк нь тухайн хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн нөхөн төлөгдөх дүнг ойролцоогоор тооцож үзнэ.



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ГУУХСЕЙН ЦЕ ХХК
ТТБ9674 № 5208173

СЭХ
2022.09.21
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭВ-03



## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

**Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэжлэл)**

Хамгийн сүүлд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн цуглуулан авах дүнг тодорхойлоход ашигласан тооцоолуудад өөрчлөлт гарсан тохиолдолд л өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг буцаана. Буцаалт нь хязгаартай байх ба ингэснээр хөрөнгийн бүртгэлийн дүн нь цуглуулан авах дүн ба өмнөх жилүүдэд хөрөнгийн үнэ цэнийн алдагдлыг хүлээн зөвшөөрөөгүй байсан бол байх ёстой байсан бүртгэлийн цэвэр дүнгээс (элэгдлийг хассан цэвэр дүнгээс) хэтрэхгүй байна. Хөрөнгө нь дахин үнэлсэн дүнтэй адил байгаа тохиолдолд дахин үнэлгээний нэмэгдлээр тооцогдох бөгөөд бусад тохиолдолд дээр дурдсан буцаалтуудыг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.
Хязгааргүй хугацаатай биет бус хөрөнгийг жил бүр эсвэл дансны үнэ нь бодит үнэ цэнээс бага байх шинж илэрсэн тухай бүрт мөнгө бий болгогч нэгжийн түвшинд үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг шалгадаг.

**Сангууд**

Банкинд өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг (хуулийн эсвэл ёс зүйн) байгаа энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед нөөцийг хүлээн зөвшөөрнө. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ материаллаг нөлөөтэй байх үед Банк нь тухайн өглөгтэй холбогдох хүүгийн түвшинг татварын өмнөх түвшинд тохируулж дискаунтлах замаар нөөцийн хэмжээг тодорхойлно. Аливаа нэг нөөцтэй холбоотой зардлыг ашиг, алдагдлаар аливаа нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр нь бусад үйл ажиллагааны зардалд толилуулна.

**Сегмент тайлан**

Үйл ажиллагааны сегментийн гишүүд нь нөөцийг хуваарилах, үйл ажиллагааны сегментүүдийн гүйцэтгэлийг үнэлэх үүрэгтэй гүйцэтгэх удирдлагын хороонд өгсөн дотоод тайлагналын дагуу тайлагнадаг.

**Ажиллагсдын тэтгэмж**

***Богино хугацаат тэтгэмж***
Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Банкны ажилчдаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог.

***Заавал төлөх даатгалын шимтгэлүүд***
Монгол улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол улсын эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлнө. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь ашиг, алдагдлын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

**Татвар**

***Тайлант хугацааны орлогын албан татвар***
Одоогийн болон өмнөх тайлант хугацааны өнөөгийн албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар Банкны үйл ажиллагаагаа явуулж буй улсад хүчин төгөлдөр үйлчилж байсан.

Эздийн өмч ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн зүйлтэй холбоотой тайлант хугацааны орлогын албан татвар нь ашиг алдагдлын тайланд бус эздийн өмч эсвэл бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тухайлан хүлээн зөвшөөрөгдөнө. Удирдлага нь татварын тайланд тусгасан өөрийн байр суурийг үе үе үнэлж, тайлбар тодруулга шаардлагатай холбогдох татварын зохицуулалтыг харгалзан үздэг.

***Хойшлуулсан татвар***
Хойшлуулсан орлогын албан татварыг тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь, тэдгээрийн санхүүгийн бүртгэлийн дүн хоёрын хооронд түр зөрүүний дүнгээс тайлан тэнцлийн аргыг хэрэглэн тооцдог.

Дараахаас бусад бүх түр зөрүүнүүд дээр хойшлуулсан орлогын албан татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хэрэв хойшлуулсан орлогын албан татварын өр төлбөр нь гүүдвиллээс эсвэл бизнесийн нэгдлийн үеийн бус гүйлгээнээс үүссэн ба гүйлгээ хийх үед нягтлан бодох бүртгэлийн ашиг ба татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бол
- Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт, хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотой татвар ногдох түр зөрүүнүүдийн хувьд, үүссэн түр зөрүүний буцаалт нь ойрын ирээдүйд арилахгүй ба түр зөрүүг ашиглаж болох татвар ногдох ашиг олох магадлалгүй байгаа бол



УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ҮНЦ ХХК

СЭХ 2022.09.21 он сар өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-09-14 БҮРТГЭВ-03

**ТӨРИЙН БАНК ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2021 ОНЫ 12 САРЫН 31**

Хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр хянаж үздэг ба энэхүү хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого орж ирэх магадлал буурах үед уг бүртгэлийн дүнг бууруулна.

Үл хүлээн зөвшөөрсөн хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр дахин үнэлж үздэг ба хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг ашиглахыг зөвшөөрсөн татвар ногдох орлого ирээдүйд орж ирэх магадлалтай болсон үед хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгийг олж авах эсвэл өр төлбөрийг барагдуулах тэр тайлант хугацаанд хэрэглэгдэнэ гэж хүлээж байгаа (тайлант жилийн эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан татварын хувь хэмжээ, татварын хуулиуд дээр үндэслэн) татварын хувь хэмжээгээр хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө, өр төлбөрийг хэмжинэ.

Арилжаалах зориулалттай хөрөнгийн бодит үнэ цэнийн дахин үнэлгээ, гадаад валютын ханшийн тэгшитгэл болон мөнгөн гүйлгээний хейджийн өөрчлөлттэй холбоотой бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагдсан татвараас бусад хойшлогдсон татвар ба орлогын албан татвар нь орлогын тайланд орлогын албан татварын буцаан авалт эсвэл зардлаар хүлээн зөвшөөрөгдөнө. Энэ нь дараагаар бусад дэлгэрэнгүй орлогоос (БДО) орлогын тайлан руу холбогдох хойшлуулсан ашиг алдагдлын хамт дахин ангилагдана.

Мөн Банк нь, өөрийн хөрөнгө гэж ангилсан санхүүгийн хэрэгслүүдтэй холбоотой зардал, төлбөрийн татварын үр дагаврыг өөрийн хөрөнгө гэж шууд хүлээн зөвшөөрнө.

Банк нь хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнах хуулиар олгогдсон эрхтэй ба тооцоог цэвэр дүнгээр барагдуулах зорилготой бол цэвэршүүлэн тайлагнаж болно.

**Өөрийн хөрөнгө ба энгийн хувьцааны ногдол ашиг**

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөд ангилна. Өөрийн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой гүйлгээний зардлыг татвар суутгасан дүнгээр нь өөрийн хөрөнгөөс хасна. Өөрийн хөрөнгийн гүйлгээний өртөгт зөвхөн өөрийн хөрөнгийн гүйлгээнд шууд холбоотой гадны нэмэгдүүлсэн өртгөөс бусад өртгийг оруулахгүй.

Энгийн хувьцааны ногдол ашгийг өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх ба Банкны хувьцаа эзэмшигчид баталсан үед өөрийн хөрөнгөөс хасна. Хугацааны дундуурх ногдол ашгийг зарласан, Банк буцаах аргагүй болсон үед өөрийн хөрөнгөөс хасна.

**Бусад нөөц**
Банкны санхүүгийн байдлын тайлан дээрх өөрийн хөрөнгөд бүртгэгдсэн бусад нөөцөд дараах нөөцүүд орно. Үүнд:

***Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц***
Банкны барилга болон газар дахин үнэлснээс үүссэн нэмэгдлийг бүртгэдэг нөөцийн сан

***Бодит үнэ цэнийн нөөц***
Бодит үнэ цэнийн нөөц нь орлого -д ангилагдсан өрийн хэрэгслийн бодит үнийн хуримтлагдсан цэвэр өөрчлөлт, хүлээгдэж буй алдагдлыг хассан дүнгээр, хувьцааны хэрэгслийн бодит үнийн хуримтлагдсан цэвэр өөрчлөлтөөс бүрдэнэ.

***Нийгмийн хөгжлийн сан***
Удирдлагын шийдвэрээр хуримтлагдсан орлогын тодорхой хувийг Банкны ажилчдын нийгэм, эдийн засгийн хэрэгцээг хангахад зарцуулагддаг сан юм.

***Эрсдэлийн сангийн нөөцүүд***
Банк нь урьдчилан тооцоолоогүй эрсдлээс урьдчилан сэргийлэхийн тулд нөөцийг байгуулдаг. Удирдлагын шийдвэрээр хуваарилагдаагүй үлдсэн орлогын тодорхой хэсгийг эдгээр нөөцөд шилжүүлдэг.



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК 5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-14
БҮРТГЭВ-03



## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

**Холбоотой талуудын ажил гүйлгээ**

Холбоотой талууд гэдэгт Банктай дараах байдлаар холбогдсон аж ахуйн нэгж болон хувь хүн орно. Үүнд:

(а) Банктай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан:
- (i) Банкинд дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;
- (ii) Банкинд томоохон нөлөөлөлтэй эсвэл;
- (iii) Банкны гол удирдах албан тушаалтнуудын нэг.

(б) Дараах нөхцлүүдийн аль нэг нь биелсэн тохиолдолд аж ахуйн нэгж нь Банкинд хамааралтай болно. Үүнд:
- (i) Аж ахуйн нэгж болон Банкны нэг нэгж Группийн гишүүд байх (толгой компани, охин компани болон нөгөө охин компани тус бүр нь бусадтайгаа холбоотой).
- (ii) Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат компани эсвэл хамтын хэлэлцээрт компани (эсвэл нөгөө аж ахуйн нэгж нь гишүүн болох Банкны хараат компани эсвэл хамтарсан хэлэлцээрт компани).
- (iii) Аль аль аж ахуйн нэгж нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан хэлэлцээрт компаниуд.
- (iv) Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан хэлэлцээрт компани бөгөөд нөгөө этгээд нь гуравдагч аж ахуйн нэгжийн хараат компани.
- (v) Аж ахуйн нэгж нь Банкны эсвэл Банктай холбоотой аж ахуйн нэгжийн ажилчдыг урамшуулах зорилгоор ажил эрхлэлтийн дараах тэтгэмж олгодог. Хэрвээ Банк нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бол дэмжлэг хүртэж буй ажиллагсад нь мөн Банктай холбоотой тал болно.
- (vi) Аж ахуйн нэгжийг (а)-д тодорхойлсон хувь хүн дангаараа эсвэл хамтран хяналт тогтоодог.
- (vii) (а)(i)-д тодорхойлсон хувь хүн нь аж ахуйн нэгжид томоохон нөлөөлөлтэй эсвэл уг аж ахуйн нэгжийн (эсвэл аж ахуйн нэгжийн толгой компанийн) гол удирдах албан тушаалтнуудын нэг.
- (viii) Аж ахуйн нэгж нь эсвэл Банкны аль нэг гишүүн эсвэл Банкны толгой компанид гол удирдах албан тушаалтай.

Холбоотой талуудын боломжит бүх хамаарлыг харгалзахдаа зөвхөн хуулийн хэлбэрийг биш хамаарлын мөн чанарыг чухалчлан анхаарсан болно. Холбоотой талуудтай хийсэн бүх материаллаг ажил гүйлгээ болон үлдэгдлийг санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудад тодруулсан бөгөөд дэлгэрэнгүйг тодруулга 36-с харна уу.

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ ҮНЭЛЭМЖ, ТООЦООЛОЛ БОЛОН ТӨСӨӨЛЛҮҮД

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх ажил нь санхүүгийн тайлангийн өдрийн байдлаарх орлого, зардал, хөрөнгө ба өр төлбөр дээр үнэлэмж, ойролцоолсон тооцоолол, төсөөлөл хийх ба тэдгээрийн дагалдах тодруулгууд болон болзошгүй өр төлбөр дээр тодруулга хийхийг удирдлагаас шаардлаг. Эдгээр тооцоолол, төсөөллүүдийн тодорхойгүй байдал нь ирээдүйд хөрөнгө ба өр төлбөрийн бүртгэлийн дүнд материаллаг залруулга хийхэд хүргэж болно. Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэх явцад удирдлага нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг тодорхойлохдоо тайлагналын өдрөөр хөрөнгө өр төлбөрийн дансны үнэд дараагийн санхүүгийн жилд ноцтой материаллаг залруулга орж болохуйц ирээдүйн болон бусад чухал эх үүсвэрээс гарч болохуйц тооцооллын тодорхой бус байдлыг харгалзан үзэж дараах үнэлэмж, ойролцоолсон тооцооллуудыг хэрэглэдэг.

Ирээдүйн хөгжлийн талаарх одоо байгаа нөхцөл байдал, таамаглал нь Банкны хяналтаас гадуур нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөж болох ба хэзээ болох тухай таамаглалд тусгагдсан байдаг. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүн, удирдлагын нягт нямбай үнэлгээтэй хамгийн их нөлөө үзүүлсэн зүйлсийг холбогдох шүүмж / тооцоотой харьцуулж дор харуулав.

**Үнэлэмжүүд**

*Ковид 19*

Ковид 19-ийн цар тахлын эхний тохиолдол 2019 оны сүүлээр бүртгэгдсэн. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2020 оны 3-р сарын 11-ний өдөр коронавирусыг дэлхийн цар тахал гэж зарласан.



УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ
ТТБ8674 5208173

СЗХ
он сар өдөр
2022 09 21
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -09- 14
БҮРТГЭВ-03



## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ ҮНЭЛЭМЖ, ТООЦООЛОЛ БОЛОН ТӨСӨӨЛЛҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

*Ковид 19 (үргэлжлэл)*

Ковид-19 цар тахал нь хөрөнгө, өр төлбөртэй холбоотой таамаглал, тооцооллын тодорхой бус байдлыг бий болгож байна. Тиймээс Банк санхүүгийн тайланг уншигчдад санхүүгийн тайланд ашигласан аргачлалыг ойлгоход нь туслах үүднээс нэмэлт тодруулга шаардлагатай эсэхийг үнэлж үзсэн

*Гэрээг сунгах, цуцлах сонголт бүхий түрээсийн хугацааг тодорхойлох (Банк түрээслэгчээр)*
Банк түрээсийн хугацааг цуцлах боломжгүй гэж тодорхойлсон бөгөөд түрээсийн гэрээг хэрэгжүүлэх үндэслэлтэй бол хугацааг сунгах сонголт, эсвэл түрээсийн гэрээг цуцлах сонголтод хамаарах хугацаатай хамт тогтооно.

Банк нь хугацааг сунгах, цуцлах сонголтыг багтаасан хэд хэдэн түрээсийн гэрээтэй. Банк түрээсийн гэрээг сунгах, цуцлах сонголтыг хэрэгжүүлэх эсэх нь үндэслэлтэй эсэхийг үнэлэхэд тунгааж бодох шийдвэрийг хэрэгжүүлдэг. Шинэчлэх эсвэл дуусгавар болгох эдийн засгийн хөшүүргийг бий болгох бүхий л хүчин зүйлийг харгалзан үздэг. Ажиллаж эхэлсэн өдрөөс хойш түүний хяналтад хамаарах чухал үйл явдал, нөхцөл байдалд өөрчлөлт, шинэчлэлт хийх, цуцлах сонголтыг хэрэгжүүлэх, хэрэгжүүлэхгүй байдалд нөлөөлөхүйц томоохон үйл явдал, өөрчлөлт гарсан тохиолдолд Банк түрээсийн хугацааг дахин үнэлнэ (жишээлбэл, түрээсийн зориулалттай үлэмж сайжруулалт хийх эсвэл түрээслэх хөрөнгийг мэдэгдэхүйц өөрчлөх).

*Сангууд болон болзошгүй өр төлбөр*
Банкны шүүхийн зарга маргааны эрсдэл нь үйл ажиллагааны нэг хэсэг байх хууль эрх зүйн зохицуулалтын орчинд үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнээс үүдэн, Банк Монгол Улсад өөрийн ердийн үйл ажиллагааны явцад үүсэх төрөл бүрийн шүүхийн болон арбитрын хэрэгт оролцох магадлалтай юм.

Банк нь аливаа шүүхийн маргаантай хэргээс үүсэх магадлалтай хохирлын хэмжээг зохистойгоор тооцоолж түүнд ногдох үнэ цэнийн бууралтын санг тухай бүрт нь байгуулдаг. Хохирол үүсэх магадлалтай ч хохирлын хэмжээг зохистойгоор үнэлэх боломжгүй тохиолдолд Банк болзошгүй өр төлбөрөөр толилуулдаг. Гэсэн хэдий ч Банк дээрх тооцооллуудыг маргаантай хэрэг тус бүрээр толилуулах нь тухайн хэргийн үр дүнд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл санхүүгийн тайландаа хэрэг тус бүрээр нь дэлгэрэнгүй толилуулдаггүй.

Банк нь учирч болох алдагдлын хэмжээ, үүсэх магадлалын болон тодорхой бус байдлыг харгалзан мэргэжлийн зөвлөгөө авах, хэргийн үе шат болон адил төсөөтэй хэргийн түүхэн баримтууд цуглуулах зэрэг арга хэмжээг авч ажилладаг. Эдгээр тооцооллыг хийхэд их хэмжээний үнэлэмж шаардагддаг. Үнэ цэнийн бууралтын сан болон бусад болзошгүй өр төлбөрийн талаарх дэлгэрэнгүйг тодруулга 33-ээс үзнэ үү.

**Тооцоолол болон төсөөллүүд**

*Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт*
СТОУС-9 дагуу бүх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тооцоход Банкны удирдлагын үнэлэмж шаардагддаг. Ялангуяа ирээдүйн мөнгөн урсгалын дүн болон хугацаа, барьцаа хөрөнгийн үнэлгээг тодорхойлох шаардлагатай байдаг. Эдгээр тооцоолол нь хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалан өөрчлөгдөх бөгөөд эдгээрийн өөрчлөлт нь өөр өөр түвшний үнэ цэнийн бууралтын сан байгуулахад хүргэдэг.

Банкны зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын (ЗҮЦХА) тооцоолол нь хувьсах өгөгдөл болон тэдгээрийн харилцан хамаарлыг сонгоход ашигласан олон төсөөллүүдээс бүрдсэн цогц загварын үр дүн юм. ЗҮЦХА загварын элементүүд нь доорх нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж болон тооцооллыг шингээсэн байна:

- Тус тусын үнэлгээ бүрт ашиглах чанаргүйдлийн магадлалыг (ЧМ) тодорхойлдог Банкны дотоод зээлийн үнэлгээний загвар
- Банкны шатлалын үнэлгээ
- Банкны санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр ихэссэн байна гэж үнэлэх шалгуур үзүүлэлтүүд болон санхүүгийн хөрөнгүүдийн нөөц санг нийт хугацааны ЗҮЦХА болон чанарын үнэлгээ ашиглан тооцно
- ЗҮЦХА нь бүлгийн үнэлгээгээр тооцоологддог бол санхүүгийн хөрөнгийн сегментчлэл
- Өгөгдлүүдийн сонголт болон томъёонуудыг ашиглан ЗҮЦХА загварын хөгжүүлэлт
- Макро эдийн засгийн өгөгдлүүдийн харилцан холбоо хамаарлыг тодорхойлох болон эдгээрийн чанаргүйдлийн магадал (ЧМ), чанаргүйдэлд өртөх дүн (ЧӨД), алдагдалд хүргэх чанаргүйдэл (АХЧ) үзүүлэх нөлөө зэрэг
- ЗҮЦХА загварт ирээдүйг чиглэсэн макро эдийн засгийн хувилбаруудаас сонгох, тэдгээрийн жигнэсэн дундаж магадлалыг тодорхойлох, эдийн засгийн өгөгдлүүдийг гаргах

Банк нь бодит алдагдал хүлээсэн дүн дээрээ үндэслэн өөрийн загварыг жил бүр үнэлж, шаардлагатай бол залруулж байх журамтай.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДЖИ ТЦК ХХК

СЗХ
2022 .09. 21
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-14
БҮРТГЭВ-03

**ТӨРИЙН БАНК ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2021 ОНЫ 12 САРЫН 31**

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ ҮНЭЛЭМЖ, ТООЦООЛОЛ БОЛОН ТӨСӨӨЛЛҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

**Тооцоолол болон төсөөллүүд (үргэлжлэл)**

*Ковид-19-ийн үнэ цэнийн бууралтын нөөцөд үзүүлэх нөлөө*
Ковид-19 ба Банкны цаашдын эдийн засгийн хүлээлтийн хувьд Банк ЗҮЦХА-ын тооцоонд ашигласан эдийн засгийн нөлөөллүүд болон таамаглалуудыг шинэчлэн боловсруулсан болно. Бүлгийн үнэлгээн дээр нөөцийн тооцоог хийхдээ эдийн засгийн хувилбар, макро эдийн засгийн таамаглалыг үнэлсэн. Ковид-19 цар тахлын эсрэг зээлийн загвар, таамаглал, түүний дотор макро эдийн засгийн таамаглалуудыг шинэчлэн боловсруулсан бөгөөд үүнээс харахад Банкны ЗҮЦХА-н тооцоог үндэслэсэн зээлийн үндсэн загвар, арга зүй нь өмнөх онтой нийцсэн хэвээр байна.

*Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ*
Ердийн хэлцлийн үед үндсэн (эсвэл хамгийн ашигтай) зах зээл дээр хөрөнгө борлуулахад эсвэл өр төлбөрийг шилжүүлэхэд төлөх шууд ажиглах боломжтой эсвэл үнэлгээний бусад аргыг ашигласан эсэхээс үл хамааран зах зээлийн одоогийн нөхцлийн дагуу хэмжилтийн өдрөөрх үнийн дүн нь (өөрөөр хэлбэл гарах үнэ нь) санхүүгийн хэрэгслийн бодит үнэ болно. Санхүүгийн байдлын тайланд бүртгэгдсэн санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь идэвхтэй зах зээл дээр байхгүй үед тоон загваруудыг ашиглах төрөл бүрийн үнэлгээний аргаар тодорхойлно. Эдгээр загваруудын өгөгдлийг ажиглах боломжтой зах зээлийн мэдээллээс авах бөгөөд мэдээлэл байхгүй үед үнэ цэнийг тодорхойлохын тулд үнэлэмж ашиглана. Үнэлэмж, тооцооллууд нь төлбөрийн чадвар болон (өөрийн болон харилцагч талын) зээлийн эрсдэлийн загвар өгөгдлүүд, санхүүжилтийн дүнгийн залруулга, харилцан хамаарал болон тогтворгүй байдлыг авч үзнэ. Бодит үнэ цэнэ тодорхойлох талаар дэлгэрэнгүй мэдээллийг тодруулга 35-ыг харна уу.

*Хөрөнгийн дахин үнэлгээ*
Банк нь өөрийн газар болон барилгыг дахин үнэлгээгээр хэмжиж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг. 2018 онд Банк нь хөрөнгийн үнэлгээний хараат бус компанитай гэрээ байгуулж Банкны газар болон барилгуудыг үнэлүүлсэн. Үнэлгээнд харьцуулсан үнэ болон орлогын аргыг зах зээлд суурилан байршил, барилгын чанар, нөхцөл зэрэг тодорхой зах зээлийн хүчин зүйлүүдээр тохируулан ашигласан. Зах зээлд суурилсан мэдээлэл байхгүй үед (байршил хол гэх мэтчилэн) ижил төстэй барилгыг дахин бостох зардалтай дүйцүүлж үнэлсэн. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар удирдлага нь барилгын бодит үнэ цэнэ нь бүртгэлийн дүнгээсээ материаллаг хэмжээнд өөрчлөгдөөгүй гэж үзсэн байна. Уг үнэлгээнд тухайн хөрөнгөтэй холбоотой удирдлагын үнэлэмж, туршлага болон төсөөллийг шаарддаг. Дэлгэрэнгүйг тодруулга 35-д толилуулсан.

*Зээлийн өсөн нэмэгдэх хүүг тодорхойлох нь*
Банкны зүгээс түрээсийн нуугдмал хүүгийн түвшинг шууд тодорхойлох боломжгүй тул түрээсийн өглөгийн тооцоололдоо зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшинг ашигласан. Зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшин гэдэг нь ижил эдийн засгийн орчинд ижил үнэ цэнэ бүхий ашиглах эрхтэй хөрөнгийг худалдаж авахад шаардагдах эх үүсвэрийг ижил нөхцөлтэй, ижил үнэт цаасаар санхүүжүүлэхэд төлөх хүүгийн түвшин байна. Тиймээс зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшин нь банкны зүгээс төлөгдөх хүү гэж ойлгогдох ба хэрэв тооцоололд ашиглагдах ажиглагдахуйц хувь хэмжээ байхгүй бол түрээсийн нөхцөл ба хугацаанд тохируулан залруулга хийх хэрэгтэй байдаг. Банк зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшинг тодорхойлохдоо ашиглаж болохуйц мэдээлэл (жишээ нь зах зээлийн хүү)-үүдийг оруулсан ба мөн аж ахуйн нэгжийн онцлогоос хамааран тохируулга хийхийг шаарддаг (жишээ нь зээлжих зэрэг эсвэл түрээсийн нөхцөл ба хугацаанд тохируулах).



УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК

СЭХ
20__ он __ сар __ өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -09- 14
БҮРТГЭВ-03



## 4. СЕГМЕНТИЙН ТАЙЛАН

Удирдлагын зорилгоор Банк нь бүтээгдэхүүн, үйлчилгээн дээрээ суурилан үйл ажиллагааны дараах гурван сегментэд хуваагддаг. Үүнд:

- *Иргэдийн үйл ажиллагаа:* Харилцагчдын харилцах данс, хадгаламжийн данс, дебет болон кредит карт, хөдөө аж ахуйн зээл, хэрэглээний зээл, эко зээл, хөдөө аж ахуйн зээл, төлбөр шилжүүлгүүд.
- *Бизнесийн үйл ажиллагаа:* Төрийн өмчит аж ахуйн нэгжүүд, жижиг, дунд үйлдвэр болон банкны харилцагчдад үзүүлдэг арилжааны банкны үйл ажиллагаа нь дебет хэрэгслүүд, харилцах данс, хадгаламж, овердрафт, зээл, худалдааны санхүүжилт, бусад кредит хэрэгслүүд, олон улсын шилжүүлэг.
- *Хөрөнгө удирдлага:* Бэлэн мөнгөний удирдлага, Монголбанкны үнэт цаас, банк хоорондын зээл, хадгаламж, санхүүгийн хэрэгслүүдийн арилжаа.

Сегментийн мэдээллийг Банкны бизнесийн сегментэд үндэслэн тайлагнадаг. Банкны удирдлагын болон дотоод тайлагналын бүтэц зохион байгуулалтад суурилан сегментийн тайлангийн бүтэц болон үйл ажиллагааны сегментийг толилуулдаг.

Хөрөнгө зохицуулалтын газар нь банкны хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааг зохион байгуулан ажилладаг. Үүнд зээл авах, өрийн бичиг гаргах, эрсдэлийн удирдлагын зорилгоор дериватив хэрэгсэл ашиглах, богино хугацаат хадгаламж хийх, Монголбанк, Засгийн Газрын болон компанийн өрийн бичиг зэрэг түргэн хөрвөх хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийх зэргээр Банкны санхүүжилт, эрсдэлийг төвлөрсөн удирдлагаар хангах үүргүүд багтдаг.

Банкны удирдлага нь нөөцийн хуваарилалт, гүйцэтгэлийн үнэлгээний талаар шийдвэр гаргахдаа хэрэглэх зорилгоор өөрийн бизнесийн үйл ажиллагааны үр дүнг тусад нь хянаж байдаг. Сегментийн гүйцэтгэлийг үйл ажиллагааны ашиг, алдагдал (зарим тохиолдолд санхүүгийн тайлангууд дээрх үйл ажиллагааны ашиг алдагдлаас өөрөөр хэмждэг) дээр нь үндэслэн үнэлдэг.

Удирдлага нь гүйцэтгэлийн хэмжүүр нь нийт орлого, зардал биш цэвэр хүүгийн орлого байдаг учраас хүүгийн орлогыг цэвэр дүнгээр нь тайлагнадаг.

*Бүс нутгийн мэдээлэл:*
2020 болон 2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон тайлант жилүүдэд Банкны бүхий л үйл ажиллагаа Монгол Улсад хийгдсэн. Иймд бүс нутгийн мэдээлэл толилуулаагүй. Гадаад харилцагч болон хамтрагч байгууллагуудтай хийсэн гүйлгээний орлого нь 2021 онд Банкны нийт орлогын 10 ба түүнээс дээш хувийг эзэлдэггүй болно.



УЛААНБААТАР ХОТ
ӨГӨӨЖ ЭМЖ ЛЭ КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341169 ГСТ5392

УЛААНБААТАР ХОТ
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА
ТТБ0674 5208173

**ТӨРИЙН БАНК ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2021 ОНЫ 12 САРЫН 31**

**4. СЕГМЕНТИЙН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)**

| 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх | Хэрэглэгч мян. төг | Бизнес мян. төг | Хөрөнгө удирдлага мян. төг | Нийт мян.төг |
|---|---|---|---|---|
| Үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон хүүгийн орлого | 213,729,985 | 74,860,864 | 74,909,339 | 363,500,188 |
| Бусад хүү болон түүнтэй адилтгах орлого | 10,436,277 | 6,733,225 | 4,804,139 | 21,973,641 |
| Хүү болон түүнтэй адилтгах зардал | (106,940,673) | (43,637,465) | (40,062,383) | (190,640,521) |
| **Хүүгийн цэвэр орлого** | 117,225,589 | 37,956,624 | 39,651,095 | 194,833,308 |
| Хураамж ба шимтгэлийн орлого | 16,664,172 | 12,389,435 | – | 29,053,607 |
| Хураамж ба шимтгэлийн зардал | (3,800,459) | (2,451,961) | (466,211) | (6,718,631) |
| **Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого** | 12,863,713 | 9,937,474 | (466,211) | 22,334,976 |
| Арилжааны цэвэр орлого | – | 2,016,181 | 1,990,460 | 4,006,641 |
| Үйл ажиллагааны бусад зардал | (17,776,663) | 1,141,651 | (906,741) | (17,541,753) |
| Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн зардал | 1,189,058 | (32,001,467) | (1,200,481) | (32,012,890) |
| Үйл ажиллагааны зардал | (61,909,517) | (25,387,930) | (23,307,976) | (110,605,423) |
| **Сегмент татварын өмнөх ашиг (алдагдал)** | 51,592,180 | (6,337,467) | 15,760,146 | 61,014,859 |
| Орлогын албан татварын зардал * | (12,909,508) | 1,585,775 | (3,943,538) | (15,267,271) |
| **Тайлант жилийн ашиг** | 38,682,672 | (4,751,692) | 11,816,608 | 45,747,588 |
| | | | | |
| **Нийт хөрөнгө** | 1,621,931,546 | 1,046,429,568 | 1,124,373,142 | 3,792,734,256 |
| **Нийт өр төлбөр** | 1,954,737,758 | 1,261,147,793 | 188,364,767 | 3,404,250,318 |

| 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх | Хэрэглэгч мян. төг | Бизнес мян. төг | Хөрөнгө удирдлага мян. төг | Нийт мян.төг |
|---|---|---|---|---|
| Үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон хүүгийн орлого | 223,944,590 | 45,510,127 | 75,636,656 | 345,091,373 |
| Бусад хүү болон түүнтэй адилтгах орлого | 13,442,759 | 5,168,818 | 4,146,450 | 22,758,027 |
| Хүү болон түүнтэй адилтгах зардал | (148,361,817) | (34,367,701) | (51,292,662) | (234,022,180) |
| **Хүүгийн цэвэр орлого** | 89,025,532 | 16,311,244 | 28,490,444 | 133,827,220 |
| Хураамж ба шимтгэлийн орлого | 11,318,463 | 14,899,270 | – | 26,217,733 |
| Хураамж ба шимтгэлийн зардал | (3,410,497) | (790,035) | (1,179,101) | (5,379,633) |
| **Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого** | 7,907,966 | 14,109,235 | (1,179,101) | 20,838,100 |
| Арилжааны цэвэр орлого | – | – | 13,601,732 | 13,601,732 |
| Үйл ажиллагааны бусад зардал | (4,486,329) | (1,039,249) | (1,551,045) | (7,076,623) |
| Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн зардал | (21,014,968) | 3,885,995 | (110,870) | (17,239,843) |
| Үйл ажиллагааны зардал | (66,377,135) | (15,376,123) | (22,948,357) | (104,701,615) |
| **Сегмент татварын өмнөх ашиг (алдагдал)** | 5,055,066 | 17,891,102 | 16,302,803 | 39,248,971 |
| Орлогын албан татварын зардал * | (1,112,412) | (3,937,097) | (3,587,577) | (8,637,086) |
| **Тайлант жилийн ашиг** | 3,942,654 | 13,954,005 | 12,715,226 | 30,611,885 |
| | | | | |
| **Нийт хөрөнгө** | 1,570,568,766 | 603,892,644 | 1,307,806,992 | 3,482,268,402 |
| **Нийт өр төлбөр** | 2,187,911,854 | 841,264,581 | 105,330,366 | 3,134,506,801 |

*Сегмент тус бүрт орлогын албан татварын зардлыг тооцоолохдоо үр ашигт татварын түвшинг ашигласан 2021: 25%, (2020: 22.0%). (Тод 12.1)

СЗХ
2022 .08 сар 24 өдөр
БҮРТГЭВ
№ 01



Монголын Хөрөнгийн Бирж
ТӨРИЙН БАНК
2022 -09- 14
БҮРТГЭВ-03

**ТӨРИЙН БАНК ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2021 ОНЫ 12 САРЫН 31**

## 5. ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО

| | 2021<br>мян.төг | 2020<br>мян.төг |
|---|---|---|
| *Үр ашигт хүүгийн аргачлалаар бодсон хүүгийн орлого* | | |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 284,110,046 | 260,753,588 |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэгсэл | 66,874,415 | 73,168,163 |
| Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах | 4,717,491 | 8,244,767 |
| Свопын хүүгийн орлого | 2,957,016 | 1,911,546 |
| Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж | 227,926 | 756,755 |
| Урвуу репо хэлцэл | 27,112 | 256,554 |
| Хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн хэрэгсэл | 4,586,182 | – |
| | **363,500,188** | **345,091,373** |
| *Бусад хүү болон түүнтэй адилтгах орлого* | | |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх өрийн хэрэгсэл | 4,804,139 | 4,146,450 |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 17,169,502 | 18,611,577 |
| | **21,973,641** | **22,758,027** |

2021 онд бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдсэн өрийн хэрэгсэлд орж байгаа Засгийн газрын бонд нь 8,312,960 мянган төгрөг (2020: 9,433,916 мянган төгрөг) байна.

## 6. ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗАРДАЛ

| | 2021<br>мян.төг | 2020<br>мян.төг |
|---|---|---|
| *Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн зардал* | | |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 163,871,036 | 208,369,694 |
| Зээлээр авсан эх үүсвэр | 7,201,098 | 11,736,041 |
| Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж | 7,011,837 | 7,975,439 |
| Репо хэлцэл | 6,330,750 | 2,099,365 |
| Свопын хүүгийн зардал | 5,880,838 | 2,895,637 |
| Түрээслийн өглөгийн хүүгийн зардал (Тодруулга 24) | 344,962 | 946,004 |
| | **190,640,521** | **234,022,180** |

## 7. ХУРААМЖ БА ШИМТГЭЛИЙН ЦЭВЭР ОРЛОГО

| | 2021<br>мян.төг | 2020<br>мян.төг |
|---|---|---|
| **Хураамж ба шимтгэлийн орлого** | | |
| Дансны үйлчилгээний шимтгэл, хураамж | 8,549,436 | 9,137,292 |
| Картын үйлчилгээний шимтгэл, хураамж | 10,816,596 | 8,713,120 |
| Мобайл үйлчилгээний шимтгэл, хураамж | 7,331,789 | 5,835,682 |
| Бонус болон бусад тэтгэмжүүд | 1,018,716 | 1,030,042 |
| | **3,469,404** | **3,420,538** |

***Банкны захирлууд болон гол удирдах албан тушаалтнуудтай хийсэн ажил гүйлгээ***

| | 2021<br>мян.төг | 2020<br>мян.төг |
|---|---|---|
| Гол удирдах албан тушаалтнуудад олгосон зээл | 2,950,450 | 159,337 |
| Гол удирдах албан тушаалтнуудын байршуулсан харилцах, хадгаламж | 10,524,547 | 5,660,588 |

Гол удирдах албан тушаалтнууд Банкны бизнесийн ердийн үйл ажиллагааны хүрээнд энгийн нөхцөлтэйгөөр (бусад харилцагчид болон ажилтнууд ижил үйлчилгээ авахад санал болгодогтой ижил хүү болон барьцааны нөхцөл) Банкнаас үйлчилгээгээ авдаг. Эдгээр ажил гүйлгээнүүдэд энгийн ажил гүйлгээнийхээс ялгарах онцлог эрсдэл байхгүй байна.

Гол удирдах албан тушаалтнуудад олгосон зээл болон урьдчилгаа нь барьцаатай бөгөөд жилийн *5.0%*-иас *36.0%* (*2020: 6.0%-иас 19.7%*) хувийн хүүтэй ба 1-ээс 29 хүртэл жилийн эргэн төлөгдөх хугацаатай байна. Уг санхүүгийн жилд эдгээр зээлээс олсон хүүгийн орлого нь *107.0* сая төгрөг болно (2020 онд *139.9* сая төгрөг).

Гол удирдах албан тушаалтнуудын харилцах, хадгаламж нь жилийн 0.0%-иас 10.2%-ийн хүүтэй байсан (2020 онд 0.0%-иас 15.2% байсан). Тухайн санхүүгийн жилд эдгээр харилцах, хадгаламжид *25.6* сая төгрөгийн Хүүгийн зардал төлсөн (2020 онд *17.1* сая төгрөг).

**Банкны хувьцаа эзэмшигчидтэй хийсэн ажил гүйлгээ**

Тайлант жилийн эцсийн байдлаар Банк нь бизнесийн ердийн үйл ажиллагааныхаа хүрээнд дараах голлох ажил гүйлгээнүүдийг Банкны хувьцаа эзэмшигчидтэй хийсэн байна. 12 сарын 31-ээрх балансын үлдэгдлийг доор харуулав.

| | 2021<br>мян.төг | 2020<br>мян.төг |
|---|---|---|
| Харилцах, хадгаламж | (12,244,245) | (50,061,304) |
| Зээлээр авсан эх үүсвэр | (80,210,910) | (80,797,660) |
| Хоёрдогч өр төлбөр | – | (44,100,000) |
| Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй засгийн газрын үнэт цаас | 141,759,715 | 148,132,425 |

Хувьцаа эзэмшигчдийн харилцах, хадгаламж нь жилийн хүүгийн түвшингүй (2020: 0.0%-иас 3.0%) байсан. Тухайн санхүүгийн жилд эдгээр харилцах, хадгаламжид хүүгийн зардал төлөгдөөгүй (2020 онд 878 сая төгрөг).

Хувьцаа эзэмшигчдээс авсан зээл нь жилийн 1.5%-иас 7.3%-ийн (2020: 1.0% -иас 7.3%) хүүтэй байсан. Тухайн санхүүгийн жилд эдгээр зээлд 3,570 сая төгрөгийн хүүгийн зардал төлсөн (2020 онд 4,026 сая төгрөг).

Уг санхүүгийн жилд Засгийн газрын үнэт цааснаас олсон хүүгийн орлого 8,312,960 мянган төгрөг байсан (2020: 9,433,916 мянга) (Тодруулга 5). Хоёрдогч өглөг нь хүүгүй бөгөөд Төрийн банкны 44,100 ширхэг хувьцаа руу 2021 оны 3-р сард хөрвөсөн байна (Тодруулга 31-г харна уу).



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

СЗХ 2022 .09 .21 Бүртгэв № 01
MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-09-14 БҮРТГЭВ-03



## 36. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

**Монголбанктай хийсэн ажил гүйлгээ**

12 сарын 31-нээрх балансын үлдэгдэлийг доор харуулав.

| | 2021 мян.төг | 2020 мян.төг |
|---|---|---|
| Монголбанк дахь харилцах (Тодруулга 13) | 205,185,650 | 185,109,624 |
| Төв банкны үнэт цаас (Тодруулга 18) | 825,556,052 | 921,893,131 |
| Зээлээр авсан эх үүсвэр (Тодруулга 28) | (84,194,700) | (37,825,007) |

Уг санхүүгийн жилд Монголбанкнаас авсан хүүгийн орлого болон төлсөн хүүгийн зардлыг доор харуулав.

| | 2021 мян.төг | 2020 мян.төг |
|---|---|---|
| *Хүүгийн орлого:* | | |
| Монголбанк дахь харилцах (Тодруулга 13) | 4,717,491 | 8,244,767 |
| Төв банкны үнэт цаас (Тодруулга 18) | 56,737,058 | 46,088,001 |
| | 61,454,549 | 54,332,768 |
| *Хүүгийн зардал:* | | |
| Зээлээр авсан эх үүсвэр | 943,259 | 943,845 |

**Бусад Төрийн оролцоот байгууллагуудтай хийсэн ажил гүйлгээ**

12 сарын 31-ээрх балансын үлдэгдэлийг доор харуулав.

| | 2021 мян.төг | 2020 мян.төг |
|---|---|---|
| Харилцагчдын харилцах, хадгаламж | (319,951,794) | (412,836,285) |
| Зээлээр авсан эх үүсвэр | – | (39,719,461) |
| Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж | (14,730,849) | (12,137,215) |
| Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй засгийн газрын үнэт цаас | 67,467,667 | – |
| Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаас Давуу Эрхтэй Бонд | 318,930 | – |
| Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаас Энгийн Бонд | 156,931 | – |
| Бусад хөрөнгө: Авлага | 7,436,601 | 7,436,601 |

Уг санхүүгийн жилд бусад төрийн оролцоот байгууллагуудаас авсан хүүгийн орлого болон төлсөн хүүгийн зардлыг доор харуулав.

| | 2021 Мян.төг | 2020 мян'төг |
|---|---|---|
| *Хүүгийн орлого:* | | |
| Засгийн газрын бонд | 4,586,182 | – |
| Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаас Давуу болон Энгийн эрхтэй бонд | 36,201 | – |
| | 4,622,383 | – |

Уг санхүүгийн жилд Төрийн оролцоот байгууллагуудаас авсан хүүгийн зардал нь тус 5,690 сая төгрөг байсан (2020 онд 30,186 сая төгрөг байсан).



УЛААНБААТАР ХОТ ... ЗЭЭЛИЙН ЭНД КО ... ХХК 5183885
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ ГҮЙЦЭТГЭХ ... ХХК

СЗХ
2022 ОН 09 САР 21 ӨДӨР
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭВ-03



## 36. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

**Холбоотой талуудтай хийсэн гүйлгээний нөхцөлүүд**

Бизнесийн ердийн үйл ажиллагааны үр дүнд дээр дурдсан үлдэгдэл дүнгүүд үүссэн болно. Холбоотой талуудын төлсөн болон хүлээн авсан хүү нь ердийн арилжааны хүүгээр тооцогдсон. Тайлант жилийн эцсээр зээл болон урьдчилгаанаас бусад үлдэгдэл дүн барьцаа хөрөнгөгүй болно. 2020 болон 2021 оны 12 сарын 31-ээр бусад холбоотой талуудын өглөг эсвэл авлагын дүнд ямар нэгэн хүлээн авсан эсвэл гаргасан баталгаа байхгүй.

Банк нь НББОУС 24-ийн өөрчлөлт болох "Төрийн оролцоот байгууллагуудын хувьд шаардлагатай тодруулгын хэсэгчилсэн хөнгөлөлт" хэсгийг хэрэгжүүлсэн. Иймд төрийн оролцоот байгууллагуудтай хийсэн дангаар материаллаг бус ажил гүйлгээнүүд нь санхүүгийн тайлангийн тодруулгад тусгагдаагүй болно.

## 37. ХӨРӨНГӨ БОЛОН ӨР ТӨЛБӨРИЙН ХУГАЦААНЫ ШИНЖИЛГЭЭ

Дараах хүснэгтэнд Банкны хөрөнгө, өр төлбөрийг эргэн төлөгдөх, барагдах хугацаагаарх шинжилгээг харуулсан байна. Тодруулга 34 "Төлбөрийн чадварын эрсдэл ба эх үүсвэрийн удирдлага"-аас Банкны зүгээс барагдуулах хорогдуулж тооцоогүй гэрээт үүргүүдийг харна уу.

| **2021 оны 12 сарын 31** | **12 сараас доош мян.төг** | **12 сараас дээш мян.төг** | **Нийт мян.төг** |
|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | |
| Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах | 250,920,691 | – | 250,920,691 |
| Банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж | 28,534,316 | – | 28,534,316 |
| Үүсмэл санхүүгийн хэрэгсэл | 759,107 | – | 759,107 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 249,277,745 | 1,987,869,603 | 2,237,147,348 |
| Санхүүгийн хөрөнгө оруулалт – арилжаалах зорилготтай | – | 7,310,813 | 7,310,813 |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө | – | 80,844,572 | 80,844,572 |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэгсэл | 838,882,914 | 128,432,853 | 967,315,767 |
| Хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн хэрэгсэл | 471,197 | 67,315,400 | 67,786,597 |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэгсэл | – | 118,385 | 118,385 |
| Бусад хөрөнгө | 11,280,077 | 9,986,722 | 21,266,799 |
| Борлуулах зорилготой хөрөнгө | 6,762,299 | – | 6,762,299 |
| Хөрөнгө оруулалтын үл хөдлөх хөрөнгө | – | 2,364,878 | 2,364,878 |
| Үндсэн хөрөнгө | – | 115,918,630 | 115,918,630 |
| Биет бус хөрөнгө | – | 5,630,775 | 5,630,775 |
| Ашиглах эрхийн хөрөнгө | 53,279 | – | 53,279 |
| Нийт хөрөнгө | 1,386,941,625 | 2,405,792,631 | 3,792,734,256 |
| **Санхүүгийн өр төлбөр** | | | |
| Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж | 115,673,495 | 279,304 | 115,952,799 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 2,494,486,129 | 362,311,916 | 2,856,798,045 |
| Репо хэлцэл | 153,809,693 | – | 153,809,693 |
| Үүсмэл санхүүгийн хэрэгсэл | 1,549,920 | – | 1,549,920 |
| Зээлээр авсан эх үүсвэр | 128,950,809 | 123,425,512 | 252,376,321 |
| Бусад өр төлбөр | 7,037,031 | 8,810,945 | 15,847,976 |
| Түрээсийн өглөг | 234,557 | – | 234,557 |
| Орлогын татварын өр төлбөр | 4,865,246 | – | 4,865,246 |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | – | 2,815,761 | 2,815,761 |
| **Нийт** | 2,906,606,880 | 497,643,438 | 3,404,250,318 |
| **Цэвэр дүн*** | **(1,519,665,255)** | **1,908,149,193** | **388,483,938** |



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕН ҮЦК ХХК

СЭХ
он 2022 сар 09 өдөр 21
БҮРТГЭВ
№ 01



2022 -09- 14
БҮРТГЭВ-03



## 37. ХӨРӨНГӨ БОЛОН ӨР ТӨЛБӨРИЙН ХУГАЦААНЫ ШИНЖИЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

| 2020 оны 12 сарын 31 | 12 сараас доош мян.төг | 12 сараас дээш мян.төг | Нийт мян.төг |
|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | |
| Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах | 238,774,076 | – | 238,774,076 |
| Банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж | 21,932,821 | – | 21,932,821 |
| Үүсмэл санхүүгийн хэрэгсэл | 165,759 | – | 165,759 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 313,761,419 | 1,440,317,461 | 1,754,078,880 |
| Санхүүгийн хөрөнгө оруулалт – арилжаалах зорилготтай | – | 47,955,448 | 47,955,448 |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө | – | 41,984,457 | 41,984,457 |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэгсэл | 935,508,343 | 282,032,396 | 1,217,540,739 |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэгсэл | – | 119,658 | 119,658 |
| Бусад хөрөнгө | 12,736,085 | 14,100,481 | 26,836,566 |
| Борлуулах зорилготой хөрөнгө | 4,593,611 | – | 4,593,611 |
| Үндсэн хөрөнгө | – | 119,645,215 | 119,645,215 |
| Биет бус хөрөнгө | – | 5,445,776 | 5,445,776 |
| Ашиглах эрхийн хөрөнгө | 3,142,157 | 53,239 | 3,195,396 |
| **Нийт хөрөнгө** | 1,530,614,271 | 1,951,654,131 | 3,482,268,402 |
| | | | |
| **Санхүүгийн өр төлбөр** | | | |
| Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж | 134,125,267 | 40,526 | 134,165,793 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 2,385,332,926 | 293,109,430 | 2,678,442,356 |
| Репо хэлцэл | 66,214,576 | 5,027,880 | 71,242,456 |
| Үүсмэл санхүүгийн хэрэгсэл | 596,957 | – | 596,957 |
| Зээлээр авсан эх үүсвэр | 103,595,763 | 123,425,511 | 227,021,274 |
| Бусад өр төлбөр | 8,846,205 | 4,143,073 | 12,989,278 |
| Түрээсийн өглөг | 3,947,982 | 63,863 | 4,011,845 |
| Орлогын татварын өр төлбөр | 2,126,460 | – | 2,126,460 |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | – | 3,910,382 | 3,910,382 |
| **Нийт** | 2,704,786,136 | 429,720,665 | 3,134,506,801 |
| | | | |
| **Цэвэр дүн*** | (1,174,171,865) | 1,521,933,466 | 347,761,601 |

*Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн тодорхой ангиллыг гэрээний үүрэг дээр үндэслэсэн байна. Гэсэн хэдий ч, Банк харилцагчдын дийлэнх нь гэрээт хугацаанаасаа өмнө зарлагын гүйлгээ хийхгүй гэсэн хүлээлттэй байгаа ба хадгаламжийн татан авалтын түүхэн өгөгдлүүд дээр үндэслэн Банкны хүлээж буй мөнгөн урсгалыг хүснэгтэд тусгаагүй болно.

## 38. ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

Монголбанкнаас тогтоосон дүрэм, харьцаануудыг ашиглах замаар Банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хянадаг. 2020 болон 2021 оны турш Банк нь өөрийн хөрөнгөд хөндлөнгөөс тавьдаг бүх шалгууруудыг бүрэн хангаж ажилласан.

**Капиталын удирдлага**

Банкны капиталын удирдлагын үндсэн зорилго нь хөндлөнгөөс тавигдсан зохистой харьцааны шалгууруудыг биелүүлэх ба сөрөг цочролыг дааж чадах өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хадгалахад оршдог.

Банк өөрийн хөрөнгийн бүтцийг удирдаж, эдийн засгийн нөхцөл байдал болон үйл ажиллагааных нь эрсдэлийн шинж чанарт орсон өөрчлөлтүүдийг харгалзан капиталын бүтэцдээ зохих тохируулгуудыг хийдэг.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -09- 14
БҮРТГЭВ-03

**ТӨРИЙН БАНК ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2021 ОНЫ 12 САРЫН 31**

## 38. ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (ҮРГЭЛЖЛЭЛ)

**Капиталын зохицуулалт**

Монголбанкнаас арилжааны Банкуудын нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааг хамгийн багадаа 9% (2020 онд 9%), өөрийн хөрөнгийн эрсдэлээр жигнэсэн активын харьцааг 12% (2020 онд 12%)-иас доошгүй байхаар тогтоосон байдаг бөгөөд эдгээр харьцаа нь эрсдэлийн уг шинж чанараар нь тохируулсан хөрөнгө болон нийт капиталыг авч тооцоологдсон байдаг. Банкны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх өөрийн хөрөнгийн зохистой харьцааг доор үзүүлэв:

| | 2021 | 2020 |
|---|---|---|
| Өөрийн хөрөнгийн эрсдэлээр жигнэсэн харьцаа | 15.3% | 12.8% |
| Эрсдэлээр жигнэсэн хөрөнгийн харьцаа | 15.3% | 15.6% |

| | 2021 мян.төг | 2020 мян.төг |
|---|---|---|
| I-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө | | |
| Энгийн хувьцаа | 178,000,000 | 133,900,000 |
| Бусад нөөц | 693,669 | 693,669 |
| Хуримтлагсан ашиг | 181,115,726 | 135,368,138 |
| СТОУС болон МБ журмын зөрүү* | (18,665,389) | (18,571,225) |
| Нийт I-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө | 341,144,006 | 251,390,582 |
| II-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө | | |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | – | 11,333,013 |
| Хоёрдогч өглөг | – | 44,100,000 |
| Нийт II-р зэрэглэлийн өөрийнхөрөнгө | – | 55,433,013 |
| **Нийт капитал/капиталын суурь** | **341,144,006** | **306,823,595** |

* Тохируулга нь голчлон МБ-ны журмын дагуу байгуулсан эрсдэлийн сан болон СТОУС-ын дагуу байгуулсан хүлээгдэж буй эрсдэлийн сан хоорондын зөрүү болно. МБ-ны шаардлагын дагуу зөрүүг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тооцоололд тохируулж өгсөн болно.

12 дугаар сарын 31-ний байдлаар эрсдэлээр нь жигнэсэн хөрөнгийг эрсдэлийн ангилал тус бүрээр үзүүлбэл:

| % | 2021 Хөрөнгө мян.төг | 2021 жигнэсэн мян.төг | 2020 Хөрөнгө мян.төг | 2020 жигнэсэн мян.төг |
|---|---|---|---|---|
| 0 | 1,214,180,617 | – | 1,306,941,300 | – |
| 20 | 19,225,416 | 3,845,083 | 16,380,177 | 3,276,035 |
| 50 | 471,495,586 | 235,747,793 | 328,806,015 | 164,403,007 |
| 70 | – | – | – | – |
| 80 | – | – | – | – |
| 90 | – | – | 105,156,772 | 94,641,095 |
| 100 | 1,882,074,432 | 1,882,074,432 | 1,598,798,437 | 1,598,798,437 |
| 120 | – | – | – | – |
| 150 | 28,602,097 | 42,903,146 | 20,038,202 | 30,057,303 |
| *Тохируулгууд:* | | | | |
| Бүлгийн, тархалтын эрсдэлийн сан | – | (2,803,684) | – | (2,200,000) |
| Үйл ажиллагааны эрсдэлийн харьцаа | – | 33,708,759 | – | 47,577,098 |
| Гадаад валютын эрсдэлийн харьцаа | – | 37,437,829 | – | 30,886,053 |
| **Нийт** | **3,615,578,148** | **2,232,913,358** | **3,376,120,903** | **1,967,439,028** |



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2022 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -09- 14
БҮРТГЭВ-03



## 39. ТАЙЛАНГИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

**Ковид-19 нөлөөлөл**

Банк нь Ковид-19 цар тахлын хөл хориотой холбоотой өөрчлөлтийн нөлөөллийг 2021 оны 12 сарын 31-ны өдрөөс хойших байдлаар авч үзсэн бөгөөд энэ жилийн санхүүгийн тайланг бэлдэхэд авч үзсэн нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, төсөөллүүд нь зохимжтой байна гэж дүгнэсэн. Хэрэгжүүлсэн нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, төсөөллүүдийг тодруулга 3-аас харна уу. Тайлагналын өдрийн байдлаар, Ковид-19-ийн хөл хориог засгийн газар цуцалсан тул банкны үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

**Орос, Украины зөрчилдөөнөөс банкинд үзүүлэх нөлөө**

Оны төгсгөлийн дараа хэд хэдэн улс Орос Украины хооронд үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан Оросын засгийн газар болон засгийн газрын холбогдох байгууллагуудын эсрэг хориг арга хэмжээ авсан. Хориг арга хэмжээнд SWIFT-ийн гүйлгээг хэсэгчлэн хориглох, мөн санхүү, эдийн засгийн хязгаарлалт багтсан. 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар банк нь Оросын хэд хэдэн банк, санхүүгийн байгууллагад одоогийн хориг арга хэмжээ авсан эсэхээс үл хамааран 6 тэрбум төгрөгийн харилцах дансгай байгаа. Удирдлага санхүүгийн тайлангууд гарах өдөр хүртэл эдгээр дансанд учирч болзошгүй хориг арга хэмжээний нөлөөлөл, зээлийн эрсдэлийг идэвхтэй хянаж, үнэлж байна.

Удирдлага нь тайлангийн өдрөөс хойш санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх өөр бусад үйл явдал гараагүй гэж үзэж байна.

## 40. МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХ ОРЧУУЛГА

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Англи хэл дээр мөн бэлтгэсэн болно. Монгол, Англи хувилбарын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Англи хувийг дагана.



УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

ХАВСРАЛТ-2 Үнэлгээний тайлан



# БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН № 16-01'

## "ТӨРИЙН БАНК" ХХК – ИЙН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ШИНЭЭР ХУВЬЦАА ГАРГАХ ЗОРИЛГООР ЭЗДИЙН ӨМЧИЙН 100.0%-ИЙН ХУВЬ ОРОЛЦООНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ ЦЭНИЙГ ТОДОРХОЙЛОХ

**ГҮЙЦЭТГЭГЧ "МӨНХ-ОРГИЛ ТРЕЙД" ХХК**
**УЛААНБААТАР ХОТ**
**2022 он**

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭВ-03



**МӨНХ-ОРГИЛ ТРЕЙД ХХК**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1-р хороо, Сүхбаатарын талбай-7, МҮЭ-
ийн Холбооны төв байр, 2-р давхар,
211 тоот

Утас: 70123256, Факс: 70133256
Гар утас: 99183250, 98113250
E-mail: bestcon6@gmail.com

**2022.05.30 № 16-01'**

"ТӨРИЙН БАНК ХХК - ийн
Төлөөлөн -Удирдах Зөвлөлийн
Дарга Ж.Ганбат танаа

Бизнесийн үнэлгээ хийсэн
тухай

2022 оны 4-р сарын 26-ны өдөр танай байгууллагатай байгуулсан ТБ/МОТ-08-2022, 01а/305 тоот "Бизнесийн болон хөрөнгийн үнэлгээ хийх гэрээ" – нд заасны дагуу үнэт цаасны зах зээлд шинээр хувьцаа гаргах зорилгоор "Төрийн банк" ХХК - ийн бизнесийн үнэ цэнийг тогтоох ажлын хүрээнд Банкны Эзэмшигчдийн өмчийн 100.0 хувийн хувь оролцоог 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар үнэлж, үнэлгээний тайланг боловсруулла.

Бидний тодорхойлсон үнэ, цэнэ нь "Үнэлгээний Олон Улсын Стандарт-2020-200. Бизнес ба бизнесийн хувь оролцоо"-ны 20.3 (г)-д заасны дагуу "Өмчийн бүх хувьцаа эзэмшигчдэд хамаарах бизнесийн үнэ, цэнэ" болно.

"Мөнх-оргил трейд" ХХК - ийн Үнэлгээний баг нь 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар хийсэн мэргэжлийн дүн, шинжилгээ, хязгаарлалтын нөхцөл, төсөөлөл, тусгай төсөөллийн хүрээнд "Төрийн банк" ХХК - ийн Эзэмшигчийн өмчийн зах зээлийн үнэ цэнийн байх боломжтой түвшинг **484,765.0 – 503,828.0 сая төгрөг**-өөр тодорхойлж дүгнэлт гаргав.

Бизнесийн үнэлгээний тайланг ТБ/МОТ-08-2022, 01а/305 тоот "Бизнесийн болон хөрөнгийн үнэлгээ хийх гэрээ"-ний холбогдох заалтын дагуу "Үнэт цаас гаргагч"-д 3% хэвлэж, хүргүүлсэн болно.

Хүндэтгэсэн,

Б. Эрдэнэбаатар

"Мөнх-Оргил трейд" ХХК – ийн Ерөнхий захирал, тэргүүлэх үнэлгээчин



УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ТТБ5874

СЗХ
он сар өдөр
2022 08 31
БҮРТГЭВ
№ 01

2022 -09- 14
БҮРТГЭВ-03



## ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, ХУРААНГУЙ

| Зөвлөх үйлчилгээний захиалагч | "Төрийн банк" ХХК |
|---|---|
| Үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэх үндэслэл | 2022 оны 4 дүгээр сарын 26 – ны өдөр байгуулсан ТБ/МОТ-08-2022, 01а/305 тоот гэрээ |
| Үнэлгээний зорилго | Үнэт цаасны зах зээлд шинээр хувьцаа гаргах зорилгоор, "Төрийн банк" ХХК - ийн бизнесийн үнэ цэнийг тогтоох ажлын хүрээнд банкны "Эзэмшигчийн өмчийн 100.0%-ийн хувь оролцоо"-ны зах зээлийн үнэ, цэнийг тодорхойлох |
| Үнэлгээний зориулалт | Энэхүү Бизнесийн үнэлгээний үр дүнг "Төрийн банк" ХХК – ийн ТУЗ-өөс үнэт цаасны зах зээлд шинээр хувьцаа гаргах зорилгоор, "Төрийн банк" ХХК - ийн нэгж хувьцааны нэрлэсэн үнэ цэнийг тогтооход ашиглана |
| Үнэлгээний зүйл | "Төрийн банк" ХХК – ийн "Эзэмшигчийн өмчийн 100.0%-ийн хувь оролцоо" |
| Үнэлгээний үнэ цэнийн суурь | Зах зээлийн үнэ цэнэ |
| Үнэлгээний огноо | 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр |
| Үнэлгээний төсөөлөл, хязгаарлалт | Төсөөлөл болон тусгай төсөөллүүд, хязгаарлах нөхцөлүүдийг үзнэ үү |
| Үнэлгээний зориулагдсан хэрэглээ, хэрэглэгч | Энэхүү хөрөнгийн үнэлгээний үр дүнг "Төрийн банк" ХХК – ийн хувьцааг үнэт цаасны зах зээлд анх удаа олон нийтэд санал болгох зориулалтаар хэрэглэх ба зориулагдсан хэрэглэгч нь Монгол улсын үнэт цаасны зах зээлийн зохицуулагч байгууллагууд байна. |
| **Үнэлгээний дүн:** | **484,765.0 – 503,818.0 сая төгрөг** |

Үнэ тогтоосон үндэслэл, тайлбар:

Бизнесийн үнэлгээг доорх хандлага, аргаар хийж, үнэ, цэнийг тодорхойлсон.

| Үнэлгээний хандлага | Үнэлгээний арга | Үнэлгээ тогтоосон хувилбар | Үнэлгээний дүн, сая төгрөг |
|---|---|---|---|
| Зах зээлийн хандлага | Жишиг компанийн арга | Дотоодын жишиг компаниудын мэдээлэлд тулгуурласан | 621,652.0 |
| | | Гадаадын жишиг компаниудын мэдээлэлд тулгуурласан | 484,765.0 |
| Орлогын хандлага | Мөнгөн гүйлгээг хорогдуулан тооцох арга | Мөнгөн гүйлгээний "Post Money" төсөөлөлд тулгуурласан | 503,818.0 |
| | | Мөнгөн гүйлгээний "Pre Money" төсөөлөлд тулгуурласан | 422,137.0 |



УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК
ТТ58674

| | | | |
|---|---|---|---|
| Өртгийн хандлага | Цэвэр хөрөнгийн арга | - | 408,374.0 |

Бид зах зээлийн хандлагаар, жишиг компанийн аргаар үнэлэхэд бизнесийн үнэлгээний дүн нь 484,765 - 621,652.0 сая төг-ийн, орлогын хандлагаар, мөнгөн гүйлгээг хорогдуулах аргаар үнэлэхэд 422,137.0 - 503,818.0 сая төг, өртгийн хандлагаар, цэвэр хөрөнгийн аргаар үнэлэхэд 408,374 сая төг гарсан.

Үнэ, цэнийн дүн, интервалуудыг доорх схем-зурагт үзүүлэв.




*Зураг 1. Тодорхойлсон бизнесийн үнэ, цэнийн интервал, дүнгийн бүдүүвч*

*Эх үүсвэр: МОТ шинжилгээ*

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 31



2022-09-14
БҮРТГЭВ-03



## ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ ........ 9

1.1 Захиалагчийн талаарх мэдээлэл ........ 9
1.2 Гүйцэтгэгчийн талаарх мэдээлэл ........ 9
Үнэлгээчдийн хараат бус бие даасан байдлын талаарх мэдэгдэл ........ 9
Мэргэшсэн үнэлгээчдийн талаарх мэдээлэл ........ 10
1.3 Үнэлгээний ажлын даалгавар ........ 10
Үнэлгээний зүйл ........ 11
Үнэлгээний зорилго ........ 11
Үнэлгээний зориулалт ........ 11
Үнэлгээний зориулагдсан хэрэглэгч, хэрэглээ ........ 11
Үнэлгээний хугацаа ........ 11
Үнэлгээний тайлагнал ........ 11
1.4 Ажлын хамрах хүрээ ........ 11
Тодорхойлох үнэ, цэнийн түвшин ........ 11
Ажлын хамрах хүрээний өөрчлөлт ........ 12
Хөрөнгийн үнэлгээнд баримталсан ҮОУС-ууд ........ 12
1.5 Үнэ цэнийн суурь ........ 12
Үнэлгээнд хэрэглэсэн валют ........ 14
1.6 Үнэлгээний төсөөллүүд ........ 14
1.7 Үнэлгээнд ашигласан нийтлэг арга зүй ........ 15
Үнэлгээний аргын сонголтын талаарх тайлбар ........ 15
Үнэлгээний зүйлийн хамгийн сайн ашиглалт ........ 16
ҮОУС-ын гажилт ........ 16
1.8 Үнэлгээнд ашигласан арга зүй, баримт, мэдээллийн эх үүсвэр ........ 16
Захиалагчаас гаргаж өгсөн мэдээллүүд ........ 16
Үнэлгээнд ашигласан хууль эрхзүй, арга зүйн материалууд ........ 17
Зах зээлийн болон бусад ашигласан мэдээллийн эх сурвалж ........ 17
Ашигласан материал ........ 18
1.9 Үнэлгээний үйл явц ........ 18
Үнэлгээний ажлын хуваарилсан хуваарь ........ 19

2 ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА ........ 20

2.1 Дэлхийн эдийн засгийн өнөөгийн байдал, хэтийн төлөв ........ 20
2.2 Монгол улсын макро эдийн засгийн өнөөгийн байдал, хэтийн төлөв ........ 22
2.3 Банкны салбарын чиг хандлага, өнөөгийн нөхцөл байдал ........ 28
Монгол Улсын банкны салбарын өнөөгийн нөхцөл байдал ........ 28
Пост коммунизмын зарим улсын банкны салбарын өнөөгийн байдал ........ 33

3 ҮНЭЛГЭЭНИЙ ЗҮЙЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ ........ 36

3.1 Компанийн үндсэн үйл ажиллагааны танилцуулга ........ 36
3.2 Компанийн засаглал, бүтэц зохион байгуулалт ........ 39
3.3 Банк санхүүгийн салбарт эзлэх байр суурь ........ 40
3.4 Санхүүгийн үзүүлэлт, шинжилгээ ........ 45



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341459 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК

3.4.1 Түүхэн санхүүгийн байдлын тайлангийн шинжилгээ ....... 45
3.4.2 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, динамик хөдөлгөөний шинжилгээ ....... 49
3.5 Үйл ажиллагаанд гаргасан хөндлөнгийн байгууллагын дүгнэлт ....... 52
3.6 Бизнес төлөвлөгөөний санхүүгийн үзүүлэлт /төсөөлөл/ ....... 53
3.7 Дүгнэлт ....... 57

4 БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТООЦООЛОЛ ....... 59

4.1 Зах зээлийн хандлага ....... 59
4.1.1 Зах зээлийн хандлагаар тооцсон үнэлгээний арга зүй ....... 59
4.1.2 Үнэлгээнд ашигласан төсөөллүүд ....... 59
4.1.3 Үнэлгээний тооцооллын хандлага, аргууд ....... 59
A. Дотоодын зах зээлийн мэдээлэлд үндэслэн тодорхойлсон үнэлгээ ....... 60
a. Ижил төстэй компаниудын мэдээлэлд хийсэн судалгаа шинжилгээ ....... 60
b. Үржүүлэгчийн тооцоолол, шинжилгээ ....... 61
c. Бизнесийн 100%-ийн өмчлөлийн үнэ цэнэ ....... 61
B. Гадаадын зах зээлийн мэдээлэлд үндэслэн тодорхойлсон үнэлгээ ....... 62
a. Ижил төстэй компаниудын мэдээлэлд хийсэн судалгаа шинжилгээ ....... 62
b. Үржүүлэгчийн тооцоолол, шинжилгээ ....... 64
c. Бизнесийн 100%-ийн өмчлөлийн үнэ цэнэ ....... 64
4.1.4 Үнэ цэнийн тооцооллын нэгтгэл, үр дүн ....... 65
Үнэлгээний үр дүнгийн шинжилгээ ....... 65
4.2 Бизнесийн орлогын хандлагаарх үнэлгээ ....... 67
4.2.1 Бизнесийн үнэлгээг "Post Money" буюу хөрөнгө оруулалт хийсний дараах төсөөллөөр тооцсон тооцоолол ....... 69
4.2.2 Бизнесийн үнэлгээг "Pre Money" буюу хөрөнгө оруулалт хийхээс өмнөх үеийн төсөөллөөр тооцсон тооцоолол ....... 74
4.3 Өртгийн хандлага - цэвэр хөрөнгийн үнэ цэнэ ....... 77
4.3.1 Өртгийн хандлагаарх цэвэр хөрөнгийн үнэлгээний арга зүй ....... 77
4.3.2 Актив хөрөнгийн тодорхойлолт, мэдээлэл ....... 78
4.3.3 Өр төлбөрийн мэдээлэл, тодорхойлолт ....... 83
4.3.4 Цэвэр хөрөнгийн аргын үнэлгээний тооцоолол ....... 84
4.4 үнэлгээний эцэслэсэн дүн, нэгтгэл ....... 86
Бизнесийн үнэлгээний хувьцааны багцын хяналтгүйн хорогдуулгын тооцоолол ....... 87

5 ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГ ХЭРЭГЛЭХ, ХЯЗГААРЛАХ НӨХЦӨЛ ....... 91

6 НИЙЦЭЛТИЙН МЭДЭГДЭЛ ....... 92

ХАВСРАЛТ 1. Зах зээлийн хандлагын үнэлгээний тооцоолold ашигласан тоон мэдээлэл ....... 93
ХАВСРАЛТ 2. Цэвэр хөрөнгийн үнэлгээний аргын тооцоололд ашигласан тоон мэдээлэл ....... 96
ХАВСРАЛТ 3. Зээлийн багцын шинжилгээ ....... 110
ХАВСРАЛТ 4. Үнэлгээний байгууллагын бичиг баримт ....... 115
ХАВСРАЛТ 3. Үнэлгээчдийн мэдээлэл, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ ....... 120

СЭХ
он 2022 сар 09 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ-03



**Тайлангийн хүснэгтийн жагсаалт**

*Хүснэгт 1. Хөгжиж буй улс орнуудын макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн дунд хугацааны таамаглал (ОУВС)* ....20
*Хүснэгт 2. Монгол ба Азийн орнуудын макро эдийн засгийнгол үзүүлэлтүүдийн харьцуулалт (ОУВС)* ....20
*Хүснэгт 3. Монгол ба Азийн хөгжиж буй орнуудын макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн харьцуулалт* 21
*Хүснэгт 4. Банкны зарим индикаторууд, хувиар* ....23
*Хүснэгт 5. Хөрөнгийн зах зээлийн индикаторууд, хувиар* ....24
*Хүснэгт 6. Индексийн үзүүлэлт* ....26
*Хүснэгт 7. Арилжааны банкуудын активын бүтэц* ....29
*Хүснэгт 8. Арилжааны банкуудын пассивын бүтэц, өөрчлөлт* ....31
*Хүснэгт 9. Банкны салбарын гол үзүүлэлтүүдийн судалгаа* ....32
*Хүснэгт 10. Киргистан улсын банкны салбар гол үзүүлэлт, хувиар* ....33
*Хүснэгт 11. Узбекстан улсын банкны салбар гол үзүүлэлт, хувиар* ....34
*Хүснэгт 12. Казакстан улсын банкны салбар гол үзүүлэлт, хувиар* ....35
*Хүснэгт 13. ТОП5 банкны активын өөрчлөлт* ....41
*Хүснэгт 14. ТОП5 банкны зээлийн өөрчлөлт* ....42
*Хүснэгт 15. ТОП5 банкны чанаргүй зээл* ....43
*Хүснэгт 16. ТОП5 банкны пассивын өөрчлөлт* ....43
*Хүснэгт 17. ТОП5 банкны депозитын өөрчлөлт* ....43
*Хүснэгт 18. ТОП5 банкны өөрийн хөрөнгийн өөрчлөлт* ....44
*Хүснэгт 19. ТОП5 банкны цэвэр ашгийн өөрчлөлт* ....44
*Хүснэгт 20. Арилжааны нөлөө бүхий банкуудын зохистой харьцаа /2021.04 улирал/* ....51
*Хүснэгт 21. Төрийн банкны тайлан тэнцэл, активаар 2022-2024* ....53
*Хүснэгт 22. Төрийн банкны Тайлан тэнцэл, эх үүсвэрээр 2022-2024* ....54
*Хүснэгт 23. Төрийн банкны орлого, зардлын тайлан, 2022-2024 оноор* ....56
*Хүснэгт 24. Жишиг компаниудын мэдээлэл* ....60
*Хүснэгт 25. Үржүүлэгчийн тооцоолол, шинжилгээ* ....61
*Хүснэгт 26. Жишиг компанийн аргаар тооцсон үнэ цэнийн тооцоолол* ....62
*Хүснэгт 27. Жишиг компаниудын мэдээлэл* ....63
*Хүснэгт 28. Үржүүлэгчийн тооцоолол, шинжилгээ* ....64
*Хүснэгт 29. Үржүүлэгчийн тооцоолол, шинжилгээ* ....64
*Хүснэгт 30. Хүснэгт. Зах зээлийн хандлагаар тооцоолсон үр дүнгийн нэгтгэл* ....65
*Хүснэгт 31. Хүснэгт. Зах зээлийн хандлагаар тооцоолсон үр дүнгийн нягтлан шалгалт* ....66
*Хүснэгт 32. Үнэ цэнийн тооцооллын дүгнэлт* ....67
*Хүснэгт 33. Эзэмшигчийн өмчийн өртөг* ....68
*Хүснэгт 33. Борлуулалтын орлогын өсөлтийн төсөөлөл* ....69
*Хүснэгт 34. "Төрийн банк" ХХК-ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх бизнесийн үнэлгээний тооцоолол I /сая.төг/* ....70
*Хүснэгт 35. "Төрийн банк" ХХК-ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх цэвэр ажлын капиталын тооцоолол I /сая.төг/* ....71
*Хүснэгт 36. "Төрийн банк" ХХК - ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх чөлөөт мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн тооцоолол I /сая.төг/* ....71
*Хүснэгт 37. "Төрийн банк" ХХК - ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх бизнесийн үнэлгээний эцсийн хугацааны терминал үнийн өнөөгийн үнэ цэнийн тооцоолол I /сая.төг/* ....72
*Хүснэгт 38. "Төрийн банк" ХХК - ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх үнэ цэнийн тооцоо I /сая.төг/* ....72
*Хүснэгт 39. "Төрийн банк" ХХК - ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх бизнесийн үнэлгээний үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ I /сая.төг/* ....72
*Хүснэгт 40. "Төрийн банк" ХХК - ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх бизнесийн үнэлгээний үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ I /сая.төг/* ....73
*Хүснэгт 41. "Төрийн банк" ХХК - ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх бизнесийн үнэлгээний тооцоолол II /сая.төг/* ....74
*Хүснэгт 42. "Төрийн банк" ХХК - ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх цэвэр ажлын капиталын тооцоолол II /сая.төг/* ....75



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341462 ГСТ5182
УЛААНБААТАР ХОТ
ГҮЙДЭЛ ҮЦК ХХК

СЗХ
он 2022 сар 09 өдөр 21
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭВ-03



*Хүснэгт 43. "Төрийн банк" ХХК - ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх чөлөөт мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн тооцоолол II /сая.төг/......75*
*Хүснэгт 44. "Төрийн банк" ХХК - ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх бизнесийн үнэлгээний "терминал үнэ, цэнэ"-ийн тооцоолол II /сая төг/......76*
*Хүснэгт 45. "Төрийн банк"ХХК - ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх үнэ цэнийн дүн, II /сая төг/ ..76*
*Хүснэгт 46. "Төрийн банк" ХХК – ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх бизнесийн үнэлгээний үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ II /сая.төг/......76*
*Хүснэгт 47."Төрийн банк" ХХК-ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх бизнесийн үнэлгээний үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ II /сая.төг/......77*
*Хүснэгт 48. Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний үр дүн......80*
*Хүснэгт 49. Үндсэн хөрөнгийн үнэлгээний үр дүн......81*
*Хүснэгт 50. Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн үнэлгээний үр дүн......82*
*Хүснэгт 51. Борлуулах зориулалттай хөрөнгийн үнэлгээний үр дүн......82*
*Хүснэгт 52. Биет бус хөрөнгийн үнэлгээний үр дүн......83*
*Хүснэгт 53. Цэвэр хөрөнгийн үнэ цэнийн тооцоолол......84*
*Хүснэгт 54. Үнэлгээний дүн......86*
*Хүснэгт 55. Дотоодын компанийн бизнесийн үнэлгээнд тооцсон хорогдуулах хувийн судалгаа......87*
*Хүснэгт 56. ОХУ-д бизнесийн үнэлгээний хорогдуулыг хийж байгаа байдал /зарим тайланд хийсэн судалгаагаар/......88*
*Хүснэгт 57. Хяналтгүйн хорогдуулгын тооцоолол......90*
*Хүснэгт 58. Зах зээлийн хандлагын үнэлгээ: Түүвэр аргаар сонгосон 3 улсын 38 банкны "Үнэ/Өөрийн хөрөнгө" (P/BV) харьцааны тооцоолол......93*
*Хүснэгт 59. Жишиг гадаадын компаниудын танилцуулга......94*
*Хүснэгт 60. Хөрөнгийн тодорхойлолт......96*
*Хүснэгт 61. Өртгийн хандлагын тооцооллын хураангуй......104*
*Хүснэгт 62. Зах зээлийн хандлагын тооцооллын хураангуй......107*
*Хүснэгт 63. Багцын чанарын үзүүлэлт (сая төгрөг)......113*

**Тайлангийн зургийн жагсаалт**

*Зураг 1. Тодорхойлсон бизнесийн үнэ, цэнийн интервал, дүнгийн бүдүүвч......3*
*Зураг 2. Монгол улсын ажилгүйдэл, Инфляци, Бодит ДНБ болон Гадаад худалдааны үзүүлэлтүүдийн ДНБ-д эзлэх хувь......22*
*Зураг 3. Гол валютын ханшийн индекс (суурь он 2017)......23*
*Зураг 4. Монгол улсын төлбөрийн тэнцэл, Монгол улсын гадаад эдийн засгийн бусад үзүүлэлтүүд, сая ам.доллар......23*
*Зураг 5. Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ......25*
*Зураг 6. Хувьцааны хөрвөх чадвар, хувиар......26*
*Зураг 7: Арилжааны хэмжээ......27*
*Зураг 8. Банкуудын активын бүтэц......28*
*Зураг 9. Арилжааны банкуудын дотоодын зээл, сая төгрөг......29*
*Зураг 10. Арилжааны банкны зээлийн бүтэц, сая төгрөг......29*
*Зураг 11. Арилжааны банкуудынг нийт олгосон зээл......30*
*Зураг 12. Арилжааны банкуудын пассивын бүтэц......30*
*Зураг 13. Аж ахуйн нэгж, иргэдийн харилцах, сегментээр......31*
*Зураг 14. Хугацаагүй болон хугацаатай хадгаламж, сегментээр......32*
*Зураг 15. Арилжааны банкуудын өөрийн хөрөнгийн бүтэц /сая.төг/......32*
*Зураг 16. Пост коммунизмын зарим улсын банкны салбарын гол үзүүлэлт, хувиар......35*
*Зураг 17. Төрийн банкны үйл ажиллагааны бүдүүвч......37*
*Зураг 18. Банкны түүхэн замналын зураглал......38*
*Зураг 19. Төрийн банкны бүтэц, зохион байгуулалт......40*
*Зураг 20. Арилжааны банкуудын салбар нэгжийн тоо......40*
*Зураг 21. Системийн нийт активт банкуудын эзлэх хувь /2021.12.31//......41*
*Зураг 22. Банкуудын системийн зээлд эзлэх хувь......42*
*Зураг 23. Төрийн банкны нийт хөрөнгийн бүтэц......45*
*Зураг 24. Төрийн банкны нийт өр төлбөрийн бүтэц......46*



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183535
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
БҮХҮҮСЕК ҮЦК ХХК
5208173

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
2022-08-14
БҮРТГЭВ-03



*Зураг 25. Төрийн банкны өөрийн хөрөнгийн бүтэц*......47
*Зураг 26. Төрийн банкны өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтэц*......47
*Зураг 27. Төрийн банкны тайлант үеийн цэвэр ашиг*......48
*Зураг 28. Төрийн банкны орлогын тайлангийн үзүүлэлт*......48
*Зураг 29. Тодорхойлсон бизнесийн үнэ, цэнийн интервал, дүнгийн бүдүүвч*......86
*Зураг 30. Чанаргүй зээлийн үзүүлэлт*......113
*Зураг 31. Төрийн банкны зээлийн багц, эдийн засгийн салбараар*......114



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183835
9011031195 СТ02420
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341459 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ТҮҮДСЕК
ТТБ8674 5208173

СЗХ
2022 .09 .21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -09- 14
БҮРТГЭВ-03

# 1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

## 1.1 Захиалагчийн талаарх мэдээлэл

| Захиалагч байгууллага | "Төрийн банк" ХХК |
|---|---|
| Захиалагч байгууллагын албан ёсны хаяг, утас | УБ хот, ЧД, 1-р хороо, Бага тойруу, 7/1 |
| Үндсэн үйл ажиллагааны чиглэл | Мөнгөн хадгаламж, зээл, төлбөр тооцоо, гадаад валют, үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах, үнэт зүйл хадгалах, гадаад төлбөр тооцоо хийх, үнэт цаас гаргах, худалдах, худалдаж авах |

## 1.2 Гүйцэтгэгчийн талаарх мэдээлэл

| Гүйцэтгэгч байгууллага | "Мөнх-Оргил трейд" ХХК |
|---|---|
| Гүйцэтгэгч байгууллагын албан ёсны хаяг, утас | УБ хот, ЧД, 1-р хороо, Сүхбаатарын талбай-7, МҮЭ-ийн Холбооны төв байр, 2-р давхар, 211 тоот. Утас: 70123256 |
| Гүйцэтгэгч байгууллагын тусгай зөвшөөрлийн мэдээлэл | "Мөнх-Оргил трейд" ХХК нь Үнэт цаасны зах зээлд оролцогчдод үнэлгээний үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй /СЗХ-ны 2013.09.18-ны 297 тоот тогтоол/. |
| Тусгай зөвшөөрөлтэй үнэлгээчид | Үнэлгээний компани нь Сангийн яамнаас олгогдсон тусгай зөвшөөрөлтэй үндсэн болон гэрээт хөрөнгийн үнэлгээчдийн багаар тус ажлыг гүйцэтгүүлсэн бөгөөд үнэлгээний багийг компанийн ерөнхий захирал, МУ – ын тэргүүлэх үнэлгээчин Б. Эрдэнэбаатар ахлан ажилласан. Үнэлгээчдийн тусгай зөвшөөрлийн мэдээлэл, ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан талаарх мэдээллийг хавсралт 1 – ээс харна уу. Хөрөнгийн тусгай зөвшөөрөлтэй үнэлгээчид нь Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтын гишүүд бөгөөд мөн Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан сургалтанд хамрагдаж сертификат авсан. |
| Мэргэжлийн хариуцлага | "Мөнх-Оргил Трейд" ХХК нь Монгол улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасанчлан мэргэжлийн хариуцлагыг "Монгол даатгал" ХХК – иар даатгуулсан. Мөн үнэлгээний багийн гишүүд нь үнэлгээний мэргэжлийн хариуцлагыг даатгуулсан, даатгалын мэдээллийг захиалагч талд баталгаажуулан хүргүүлж, байгуулсан гэрээнд хавсаргасан болно. |

***Үнэлгээчдийн хараат бус бие даасан байдлын талаарх мэдэгдэл***

| Д/д | Шалгуур | Тийм | Үгүй |
|---|---|---|---|
| 1 | Үнэлгээчид нь Төрийн банктай ямар нэг хамааралтай эсэх /урьд нь хамтран ажиллаж байсан, удирдах түвшний этгээдтэй хамаатан, садан, бусад төрлийн хобоотой/ | | + |



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183835
СТС2420
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469
ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ГҮЖИСЭН ҮЦК ХХК
ТТБ8674 5208173

СЗХ
20__ оны __ сар __ өдөр
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭВ-03



| | | |
|---|---|---|
| 2 | Үнэлгээчид нь Төрийн банкинд ямар нэг хувьцаа, хувь оролцоотой эсэх | + |
| 3 | Үнэлгээчид нь нь Төрийн банктай урьд өмнө үүссэн өр, авлагын тооцоотой эсэх | + |
| 4 | Үнэлгээчид нь үнэлж байгаа хөрөнгийн өмчлөгч /эзэмшигч/-тэй хамааралтай эсэх /урьд нь хамтран ажиллаж байсан, удирдах түвшний этгээдтэй хамаатан, садан, бусад төрлийн хобоотой/ | + |
| 5 | Үнэлгээчид нь үнэлж байгаа хөрөнгийн өмчлөгч /эзэмшигч/ хуулийн этгээдэд ямар нэг хувьцаа, хувь оролцоотой эсэх | + |
| 6 | Үнэлгээчид нь үнэлж байгаа хөрөнгийн өмчлөгч /эзэмшигч/-тэй урьд өмнө үүссэн өр, авлагын тооцоотой эсэх | + |
| 7 | Үнэлгээ хийхэд нь Төрийн банкны зүгээс хөрөнгийн үнэ, цэнэд нөлөөлж болох ямар нэг нөлөө үзүүлсэн эсэх | + |
| 8 | Үнэлгээчид нь тухайн хөрөнгийг урьд, өмнө нь үнэлж байсан эсэх | + |
| 9 | Тухайн бизнес болон хөрөнгийн үнэ, цэнийн түвшин нь үнэлгээчинд ямар нэг ашиг авчрах эсэх | + |
| 10 | Үнэлгээний ажлын хөлс нь үнэлгээний ажлын үр дүнтэй хамааралтай эсэх | + |
| 11 | Үнэлгээчид нь тухайн ажлыг гүйцэтгэх хангалттай ур чадвартай эсэх | + |

*Мэргэшсэн үнэлгээчдийн талаарх мэдээлэл*

| Нэр | Албан тушаал | Үнэлгээний чиглэлээр ажилласан жил | Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар | Ажлын оролцоо |
|---|---|---|---|---|
| Б.Эрдэнэбаатар | Ерөнхий захирал | 25 | 07120004 | Төслийн удирдагч |
| Э.Цацрал | Үнэлгээчин | 16 | 131200016 | Төслийн менежер |
| Ц.Сэржээ | Үнэлгээчин | 25 | 071200016 | Бизнесийн үнэлгээ |
| П.Болормаа | Үнэлгээчин | 14 | 081100113 | Бизнесийн үнэлгээ |
| Б. Энхтуяа | Үнэлгээчин | 13 | 091100179 | Бизнесийн үнэлгээ |
| Б. Бурмаа | Үнэлгээчин | 14 | 081100130 | Бизнесийн үнэлгээ |
| Д. Барсболд | Үнэлгээчин | 14 | 081100115 | Зөвлөх |
| Ц. Баатар | Үнэлгээчин | 25 | 071200038 | Зөвлөх |

## 1.3 ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

Үнэлгээний ажлын даалгавар нь Захиалагчтай байгуулсан 2022 оны 04-р сарын 26-ны өдрийн ТБ/МОТ-08-2022, 01а/305 тоот гэрээний 3.3-р зүйлийн дагуу дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

- Олон улсын стандарт, "Хөрөнгийн үнэлгээний тухай" Монгол улсын хууль, тогтоомж болон холбогдох бусад заавар, аргачлалын дагуу Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийж, тайлан гаргах, үнэт цаас гаргагчийн нэгж хувьцааны үнэ цэнийг тодорхойлох;
- Үл хөдлөх ба хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг бизнесийн үнэлгээнд ашиглах зориулалтаар тооцож, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5.16-д заасан хөрөнгийн үнэлгээний тайланг боловсруулах;
- Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний тайлан нь Олон улсын Стандарт, "Хөрөнгийн үнэлгээний тухай" Монгол улсын хууль болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн шаардлагыг хангасан байх;



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
5183835
9021031195 СТС2420
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК
ТТБ874 5208173

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭВ-03



- Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2011 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 274/240 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Бизнесийн үнэлгээ хийх аргачлал"-ын хүрээнд дүгнэлт, зөвлөмж өгөх;

***Үнэлгээний зүйл***

Үнэлгээний зүйл нь "Төрийн банк" ХХК – ийн "Эзэмшигчийн өмчийн 100.0%-ийн хувь оролцоо" байна.

***Үнэлгээний зорилго***

Үнэт цаасны зах зээлд шинээр хувьцаа гаргах зорилгоор, "Төрийн банк" ХХК - ийн бизнесийн буюу "Эзэмшигчийн өмчийн 100.0%-ийн хувь оролцоо"-ны зах зээлийн үнэ цэнийг тодорхойлох.

***Үнэлгээний зориулалт***

Энэхүү Бизнесийн үнэлгээний үр дүнг "Төрийн банк" ХХК – ийн ТУЗ-өөс үнэт цаасны зах зээлд шинээр хувьцаа гаргах зорилгоор, "Төрийн банк" ХХК - ийн нэгж хувьцааны нэрлэсэн үнэ цэнийг тогтооход ашиглана.

***Үнэлгээний зориулагдсан хэрэглэгч, хэрэглээ***

Энэхүү хөрөнгийн үнэлгээний үр дүнг "Төрийн банк" ХХК – ийн хувьцааг үнэт цаасны зах зээлд анх удаа олон нийтэд санал болгох зориулалтаар хэрэглэх ба зориулагдсан хэрэглэгч нь Монгол улсын үнэт цаасны зах зээлийн зохицуулагч байгууллагууд байна.

***Үнэлгээний хугацаа***

Үнэлгээг 2022 оны 04-р сарын 23-ны өдрөөс 2022 оны 05-р сарын 30-ны хооронд хийсэн бөгөөд үнэлгээний дүгнэлтийг 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар гаргасан болно.

Үнэлгээний огноо: 2021.12.31.

Үнэлгээний тайлангийн огноо: 2022 оны 05-р сарын 30.

***Үнэлгээний тайлагнал***

Бид үнэлгээний тайланг дэлгэрэнгүй бичин, хэвлэмэл хэлбэрээр тамга дарж, 3% хүргүүлнэ. Мөн үнэлгээний тооцоолол, дүн болон үнэлгээний тайланг цахим хэлбэрээр хүргүүлэх болно. Гарын үсэг зурж, тамга дарсан хэвлэмэл болон цахим тайлангууд аль, аль нь хүчин төгөлдөр байна.

### 1.4 АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Үнэлгээний Олон Улсын Стандарт 2020 /цаашид ҮОУС гэх / нь үнэлгээний ажлуудын цар хүрээг хамарч ашиглагдахаар зориулагдсан байдаг. Энэхүү үнэлгээний ажлын хамрах хүрээг ҮОУС 101- ийн холбогдох заалтын дагуу 2022 оны 04-р сарын 26-ны өдрийн ТБ/МОТ-08-2022, 01а/305 тоот гэрээний 3.3-р зүйлд зааснаар захиалагчтай тохиролцсон болно.

***Тодорхойлох үнэ, цэнийн түвшин***

"Үнэлгээний Олон улсын Стандарт 200. Бизнес ба бизнесийн хувь оролцоо"-ны 20.3-т "Үнэлгээг аж ахуйн нэгжийн хувьд бүхэлд нь гүйцэтгэж байгаа ч гэсэн тухайн үнэ цэнийг илэрхийлж болох өөр өөр түвшингүүд байж болох учраас үнэлж буй бизнес болон бизнесийн хувь оролцоог оновчтой тодорхойлох нь маш чухал юм" гэж заасны дагуу



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183835
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 СТ5382
УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК
ТТ58674 5208173

СЭХ
он 2022 сар 09 - 2 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022 -09- 14
БҮРТГЭВ-03



энэхүү үнэлгээнд уг стандартын 20.3-ын "г"-д заасан "Өмчийн үнэ цэнэ: Түүний бүх хувьцаа эзэмшигчдэд хамаарах бизнесийн үнэ цэнэ юм".

*Ажлын хамрах хүрээний өөрчлөлт*

Үнэлгээний хамрах хүрээнд өөрчлөлт оруулах асуудал үнэлгээний явцад талуудын зүгээс гаргаагүй болно.

*Хөрөнгийн үнэлгээнд баримталсан ҮОУС-ууд*

Энэхүү үнэлгээнд дараах стандартуудыг баримталсан. Үүнд:

- ҮОУС-101-2020. Үнэлгээний ажлын цар хүрээ,
- ҮОУС-103-2020. Тайлагнал,
- ҮОУС-104-2020. Үнэ, цэнийн сууриуд,
- ҮОУС-105-2020. Үнэлгээний хандлагууд болон аргууд,
- ҮОУС-200-2020. Бизнес ба бизнесийн хувь оролцоо
- ҮОУС-210-2020. Биет бус хөрөнгийн үнэлгээ
- ҮОУС-400-2020. Үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоо

## 1.5 Үнэ цэнийн суурь

Энэхүү үнэлгээнд ажлын зориулалт болон захиалагчтай тохирсны дагуу "ҮОУС 104 Үнэ, цэнийн сууриуд" стандартад тодорхойлсон "Үнэ цэнийн суурь – Зах зээлийн үнэ цэнэ" -ийг хэрэглэв. ҮОУС 104-ийн догол мөр 30-д "Зах зээлийн үнэ цэнийн суурь"-ийн талаар доорх байдлаар тодорхойлсон.

Зах зээлийн үнэ цэнэ гэдэг нь зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа, талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагчийн хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гэрээгээр хөрөнгө, өр төлбөрийг арилжвал зохино гэж уг үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн юм.

Зах зээлийн үнэ цэнийн энэ тодорхойлолтыг дараах онолын үзэл баримтлалын дагуу хэрэглэнэ.

*(а) "Тооцоолсон дүн" нь харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгийн төлөө төлөх мөнгөөр илэрхийлэгдэх үнэ юм.*

*Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын дагуу зах зээлийн үнэ цэнэ нь тухайн зах зээлээс үл үндэслэлтэйгээр олж авч болох, үнэлгээчний өдрөөрх хамгийн их магадлалтай үнэ байдаг. Энэ нь борлуулагчийн үл үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн сайн үнэ ба худалдан авагчийн үл үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн давуу талтай үнэ байна. Харин ерөнхий санхүүжилт, борлуулалт ба буцаан түрээслэх тохиролцоо, борлуулалттай холбоотойгоор хэн нэгнээс олгосон тусгай хөтөлбөр, хөнгөлөлт гэх мэт тусгай нөхцөл буюу заалтаар, эсвэл зөвхөн тодорхой нэг өмчлөгч буюу худалдан авагчид үнэ цэнийн ямар нэг элементээр нэмэгдүүлэх буюу бууруулах байдлаар тооцоолсон үнийг энэхүү тооцоололд тусгайлан хамруулдаггүй.*

*(б) "Хөрөнгө, болон өр төлбөрийг арилжвал зохино" гэдэг нь хөрөнгө ба өр төлбөрийн үнэ цэнэ бол урьдчилан тодорхойлсон дүн эсвэл бодит борлуулалтын үнэ биш, харин тооцоолсон дүн байх нөхцлийг илэрхийлнэ. Энэ нь Зах зээлийн үнэ цэнийн*



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА
2022-09-14
БҮРТГЭВ-03



*тодорхойлолтын бүх элементүүдийг үнэлгээний өдрөөр хангах уг ажил гүйлгээний үнэ байдаг.*

*(в) "Үнэлгээний өдрөөр" гэдэг нь тухайн үнэ цэнэ уг өдрийн байдлаар гэх мэт тусгай хугацаатай байхыг шаарддаг. Зах зээл ба зах зээлийн нөхцөл байдал нь өөрчлөгдөж болох учраас уг тооцоолсон үнэ цэнэ нь өөр нэг хугацаанд буруу эсвэл тохиромжгүй байж болох юм. Үнэлгээний дүн нь өөр бусад өрийн биш, харин үнэлгээний тэр өдрийн байдлаарх зах зээлийн төлөв байдал ба нөхцлүүдийг тусган илэрхийлдэг.*

*(г) "Бэлэн байгаа худалдан авагч" гэдэг нь худалдан авах сэдэл санаачлагатай болович тийм албан үүрэг хүлээлгээгүй талыг илэрхийлнэ. Уг худалдан авагч нь ямар ч хамаагүй үнээр худалдан авахаар хэт хүссэн эсвэл худалдан авна гэж урьдчилан тодорхойлогдсон этгээдийн аль нь ч биш юм. Мөн худалдан авагч нь оршин байгаа гэдгийг батлан харуулж эсвэл урьдчилан баримжаалж чадахгүй тийм төсөөллийн буюу таамаглалын зах зээлтэй холбоотойгоор биш, харин одоогийн зах зээлийн бодит байдал одоогийн зах зээлийн хүлээлтийн дагуу худалдан авах этгээд байдаг. Уг төсөөлсөн худалдан авагч нь зах зээлээр шалгагдахаас илүү өндөр үнийг төлөхгүй. Одоогийн эзэн нь "тухайн зах зээл"-ийг бүрдүүлэгчийн нэг болдог.*

*(д) "Бэлэн байгаа борлуулагч" нь ямар ч хамаагүй үнээр борлуулахаар хэт хүссэн буюу албадлагын дагуу борлуулагч эсвэл одоогийн зах зээлийг ул үндэслэлтэйгээр харгалзан үзэхгүйгээр үнэ тогтоож буй этгээдийн аль нь ч биш юм. Бэлэн байгаа борлуулагч нь зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа нээлттэй зах зээлээс олж авах хамгийн сайн үнэ бүхий зах зээлийн нөхцлөөр хөрөнгийг борлуулах сэдэл санаачлагатай байдаг, гэхдээ уг сайн үнэ нь хэд ч байж болох юм. Бэлэн байгаа борлуулагч бол таамагласан эзэн бөгөөд жинхэнэ бодит эзний үнэн бодит нөхцөл байдал нь энэхүү хэлэлцүүлгийн хэсэг болохгүй.*

*(е) "Хамааралгүй талуудын ажил гүйлгээ" нь жишээлбэл, толгой ба охин компаниуд эсвэл газрын эзэн ба хөлслөгч гэх мэт үнийг зэх зээлийн шинж, агуулгагүй болгох буюу нэмэгдүүлж болох тийм тусгайлсан буюу тусгай харилцаа хамааралтай биш байх талуудын хоорондох ажил гүйлгээ юм. Зах зээлийн үнэ цэнээр тооцогдох ажил гүйлгээ нь тус бүрдээ хараат бусаар үйл ажиллагаа явуулж буй холбоогүй талуудын хооронд хийгдэнэ гэж урьдчилан таамагладаг.*

*(ж) "Зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа" гэдэг нь Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын дагуу ул үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн сайн үнээр борлуулахад нөлөө үзүүлэхийн тулд тухайн хөрөнгийг хамгийн тохиромжтой арга замаар зах зээлд гарган танилцуулахыг хэлнэ. Борлуулагчийн хандан нэвтрэх зах зээлээс хамгийн сайн үнийг олж авахад борлуулалтын арга нь хамгийн тохиромжтой гэж үздэг. Зах зээлд гарган танилах хугацаа нь тодорхой тогтсон байдаггүй бөгөөд хөрөнгийн төрөл, зах зээлийн нөхцөл байдлаас хамааран өөр өөр байдаг. Цорын ганц шалгуур нь зах зээлд оролцогчдын зохих тоон хэсгийн анхааралд уг хөрөнгийг хандуулах боломж олгох хангалттай хугацаатай байх ёстой. Зах зээлд гарган танилах хугацаа нь үнэлгээний өдрөөс өмнө байна.*

*(и) "Талууд тус бүрийн зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй" гэдэг нь тухайн хөрөнгийн төрөл ба шинж чанар, түүний бодит болон боломжит*



УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНТЕРПРАЙЗ ХХК
6162836
9021031155

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 СТ5383

УЛААНБААТАР ХОТ
ТУХАЙН ҮНЭТ ЗҮЙЛ
ТТБ8674 д.5208173

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭВ-03



*ашиглалт, зах зээлийн төлөв байдлын талаар уг бэлэн байгаа худалдан авагч болон бэлэн байгаа борлуулагчийн аль алинд үнэлгээний өдрийн байдлаар ул үндэслэлтэйгээр мэдээлсэн байсан гэсэн урьдчилсан нөхцлийг илэрхийлнэ. Талууд тус бүр нь уг ажил гүйлгээ дэх өөрийн хэтийн байр суурины хувьд хамгийн тааламжтай байх үнийг олохыг тулд тухайн мэдлэгийг бодол төлөвлөгөөтэйгээр ашиглана гэж урьдчилан төсөөлдөг. Хожмын нэгэн өдрийн урьдчилан харах боломжгүй ур ашгийг биш, харин тухайн үнэлгээний өдрөөрх зах зээлийн байдлыг лавлагаа болгосноор "бодол төлөвлөгөө"-г үнэлдэг. Жишээлбэл: борлуулагч нь зах зээлийн үнэ буурсан үед хөрөнгийг зах зээлийн өмнөх үүнээс бага үнээр борлуулах нь заавал бодол төлөвлөгөөгүй байна гэсэн үг биш юм. Ийм тохиолдолд энэ нь үнэ өөрчлөгдсөн зах зээл дэх өөр арилжааны хувьд зөв байх бөгөөд бодол төлөвлөгөөтэй худалдан авагч буюу борлуулагч нь тухайн үед бэлэн боломжтой байгаа зах зээлийн хамгийн сайн мэдээллийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг.*

*(к) "Албан шахалт шаардлагагүй" гэдэг нь тал тус бүр уг ажил гүйлгээг хийх сэдэл санаачлагатай болович түүнийг гүйцэтгэхээр аль ч талыг хүчлээгүй буюу хэт албадан шахаагүй байхыг илэрхийлнэ.*

***Зах зээлийн үнэ цэнийн үзэл баримтлал*** **нь зах зээлд оролцогчид чөлөөтэй ажиллах нээлттэй, өрсөлдөөнт зах зээлд хэлцэн тохирох үнийг урьдчилан төсөөлдөг. Хөрөнгийн зах зээл нь олон улсын зах зээл эсвэл орон нутгийн зах зээл байж болно. Зах зээл нь маш олон тооны худалдан авагчид ба борлуулагчдаас бүрддэг эсвэл зах зээлийн хязгаарлагдмал тооны оролцогчдоос тогтсон байж болно. Хөрөнгийг борлуулахаар гарган танилцуулна гэж төлөвлөсөн зах зээл нь борлуулна гэж хийсвэрээр төсөөлсөн хөрөнгийг хэвийн байдлаар арилжих зах зээл байна.**

***Үнэлгээнд хэрэглэсэн валют***

Тухайн бизнесийн үнэлгээг төгрөгөөр тооцоолсон бөгөөд үр дүнг сая төгрөгөөр илэрхийлсэн болно.

## 1.6 Үнэлгээний төсөөллүүд

ҮОУС /2020/-ын Ерөнхий стандарт "104 – Үнэ цэнийн сууриуд"-ын догол мөр 200 – "Төсөөллүүд ба тусгай төсөөллүүд"-ийн талаар дараах байдлаар тусгасан байдаг. Үүнд:

*Догол мөр 200.1. Үнэ цэнийн суурийг тогтоохоос гадна төсөөлсөн арилжаан дахь уг хөрөнгийн төлөв байдал эсвэл хөрөнгийг арилжихаар төсөөлсөн нөхцөл байдлын аль алиныг тодруулахын тулд төсөөлөл буюу олон төсөөллүүдийг байнга хийх шаардлагатай байдаг. Ийм төсөөллүүд нь үнэ цэнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлж болно. Төсөөллүүд нь ямар нэг баталгаа, нотолгоогүйгээр үнэлгээний ажлын нөхцөл байдалд үнэн гэж зөвшөөрөгдөх үндэслэл бүхий зүйлс болно.*

Дээрх ҮОУС-ын шаардлагын хүрээнд дараах төсөөллүүдийг дэвшүүлсэн болно.

Үүнд:

- "Төрийн банк" ХХК-ийн бизнес нь цаашид тасралтгүй үргэлжилнэ,
- "Төрийн банк" ХХК-ийн бизнесийн үйл ажиллагааны чиглэлд ирээдүйд, мэдэгдэхүйц өөрчлөлт орохгүй,
- Бизнесийн орчин /эдийн засгийн байдал, татвар, тарифын зохицуулалт, бодлогын хүү/-д огцом, мэдэгдэхүйц өөрчлөлт орохгүй,
- Аливаа "давагдашгүй хүчин зүйл"-ийн нөлөөлөл байхгүй.



УЛААНБААТАР ХОТ
ОЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ
5183835
2021031165 СТС2926

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГС75392

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК
ТТБ0674 5208173

СЭХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭВ-03



***Тусгай төсөөлөл.*** Энэхүү үнэлгээнд доорх тусгай төсөөллүүдийг хийсэн болно.

Үүнд:

- Захиалагчтай байгуулсан 2022 оны 04-р сарын 26-ны өдрийн ТБ/МОТ-08-2022, 01а/305 тоот гэрээний 6.1.1-ийн дагуу Захиалагчаас Гүйцэтгэгчид гаргаж өгсөн "Төрийн банк" ХХК-тай холбоотой мэдээлэл, материалууд нь үнэн зөв бөгөөд гүйцэтгэгчийн зүгээс хууль, эрхзүйн чиглэлээр аудит хийгээгүй болно,
- Захиалагчийн гаргаж өгсөн "Төрийн банк" ХХК-ний дунд хугацааны бизнес төлөвлөгөө нь үндэслэл, судалгаатай боловсруулагдсан, биелэх боломжтой,
- Компанийн мөнгөн гүйлгээний төсөөлөл нь "Төрийн банк" ХХК-ний ойрын хугацааны бизнес төлөвлөгөөнд суурилсан бөгөөд түүний агуулга, тооцоолол нь ул үндэстэй,
- Компанийн санхүүгийн тайланд тусгагдсан бизнесийн хэвийн үйл ажиллагаанаас бусад тодруулаагүй хөрөнгө, өр төлбөр, хэвийн бус үүрэг, хариуцлага, шийдвэрлэгдээгүй шүүхийн маргаан зэрэг үнэлгээний үр дүнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлж болзошгүй аливаа зүйл байхгүй,
- "Төрийн банк" ХХК-ний бизнес нь тусдаа 100.0% бие даасан байдлаар борлогдох боломжтой.
- "Төрийн банк" ХХК-ний хувьцааны багц нь 100.0% энгийн хувьцаанаас бүрдэх бөгөөд ямар нэг давуу эрхийн болон бусад төрлийн хувацаа байхгүй.

*Тайлангийн энэхүү дэд бүлэг болон бусад бүлэг, дэд бүлгүүдэд үнэлгээчний зүгээс хийсэн төсөөлөл болон тусгай төсөөллүүд нь бүгд нэг адил хүчин төгөлдөр байна.*

## 1.7 ҮНЭЛГЭЭНД АШИГЛАСАН НИЙТЛЭГ АРГА ЗҮЙ

### *Үнэлгээний аргын сонголтын талаарх тайлбар*

ҮОУС 2020 -105-ын 10.4 дэх догол мөрд "Хөрөнгийн үнэлгээний хувьд, ялангуяа үнэлгээчин нь тухайн үнэлгээний гэрээт ажлын бодит байдал ба нөхцөл байдлуудыг харгалзан үзсэнээр нэг аргыг үнэн зөв бөгөөд найдвартай гэдэгт өндөр түвшний итгэлтэй байгаа тохиолдолд нэгээс олон арга ашиглахыг үнэлгээчнээс шаардагдахгүй. Гэвч ялангуяа нэг аргын хувьд бодит баримтын буюу ажиглалтын хангалттай орцууд байхгүй тохиолдолд үнэлгээчин нь найдвартай дүгнэлт гаргахын тулд олон хандлагууд ба аргуудын хэрэглээг, мөн түүнчлэн үнэ цэнийн үзүүлэлтийг гаргахдаа харгалзан үзвэл зохистой ба ашиглаж болох нэгээс олон хандлага буюу аргыг авч үзвэл зохино. Нэгээс олон хандлага ба аргыг эсвэл нэг хандлагын хүрээн дэх олон аргуудыг ашигласан тохиолдолд тэдгээр олон хандлагууд ба/буюу аргуудад үндэслэсэн үнэ цэнийн дүгнэлт нь ул үндэслэлтэй байвал зохистой бөгөөд үнэлгээчин нь тэдгээр өөр өөр үнэ цэнүүдийг дундажлахгүйгээр, харин шинжилж, тохируулах замаар нэг дүгнэлтэнд хүргэсэн үйл явцаа үнэлгээний тайланд тусган илэрхийлвэл зохино." гэж заасан байдаг

"Хөрөнгийн үнэлгээний тухай" хуулийн 13.1.1-р заалт болон ҮОУС-105-ын дагуу үнэлгээний аргачлалыг доор заасначаар сонгосон болно. Үүнд:

Энэхүү үнэлгээг хийхдээ тухайн компанийн одоогийн нөхцөл байдлыг судалж үзээд орлогын, зах зээлийн, өртгийн хандлагуудаар үнэлгээний тооцооллыг хийхээр сонгосон бөгөөд Үнэлгээний Олон Улсын Стандарт /IVS/-2020-105-ын 10.4 дэх догол мөрд дэх заалтын дагуу зах зээлийн, өртгийн хандлагуудын үнэлгээний үр дүнг орлогын хандлагаар хийсэн үнэлгээний дүнг шалгах, магадлах чиглэлээр ашиглана.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
2021031195 СТС2620
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5362
УЛААНБААТАР ХОТ
ГҮЖИЙБАНК ҮЦК ХХК
ТТБ8674 5208173

Үнэлгээний хандлага, ашигласан аргуудын талаарх дэлгэрэнгүй тайлбар, мэдээллийг тайлангийн 5-р бүлэгт, үнэлгээний хандлага тус бүрээр оруулсан болно.

*Үнэлгээний зүйлийн хамгийн сайн ашиглалт*

Бидний зүгээс "хамгийн өндөр ба үр ашигтай хэрэглээ"-ний дүн шинжилгээг хийгээд "Төрийн банк" ХХК – ийн одоогийн оршин байгаа ашиглалтыг хамгийн сайн ашиглалт байна гэж үзсэн болно.

*ҮОУС-ын гажилт*

Энэхүү үнэлгээг хийхэд ҮОУС болон Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм журмаас гажих онцгой нөхцөл байгаагүй.

## 1.8 ҮНЭЛГЭЭНД АШИГЛАСАН АРГА ЗҮЙ, БАРИМТ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

Энэхүү үнэлгээний ажилд доор дурдсан баримт бичиг, материал, мэдээллийг ашигласан болно:

*Захиалагчаас гаргаж өгсөн мэдээллүүд*

| ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ | | Хэлбэр |
|---|---|---|
| 1 | Банкны танилцуулга, /түүхчилсэн мэдээлэл/, бүтэц, ЗБ | Файлаар |
| 2 | ААН-н улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар | Хуулбар |
| 3 | Компанийн дүрмийн хуулбар | Хуулбар |
| 4 | Тусгай зөвшөөрөл (эзэмшдэг бол)-ийн хуулбар | Хуулбар |
| САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ | | |
| 5 | Жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан, сүүлийн 5 жилийн | Аудитын тайлангийн хамт, файлаар |
| 6 | Санхүүгийн тайлангийн тодруулга, сүүлийн 5 жилийн | Файлаар |
| 7 | Актив хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, 2021 оны 12-р сарын 31-ний байдлаарх | Файлаар |
| 7.1 | Мөнгөн хөрөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө | Файлаар |
| 7.2 | Хөрөнгө оруулалт | Файлаар |
| 7.6 | Үндсэн хөрөнгийн бүртгэл /үл хөдлөх хөрөнгө, газар, барилга, байгууламж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, компьютер, дагалдах хэрэгсэл, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, борлуулах зориулалттай хөрөнгө, бусад/ | Файлаар |
| 8 | Пассив хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, 2021 оны 12-р сарын 31-ний байдлаарх | Файлаар |
| 7.1, 7.2-т тусгасан үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой мэдээлэл | | |
| 8 | 7.6. Барилга, байгууламжийн УБ-ийн гэрчилгээний хуулбар | Файлаар |
| 9 | Барилгын талаарх мэдээлэл: Барилгын зураг, зориулалт, хийц бүтээц, ашиглалтанд орсон он, инженерийн шугам сүлжээний шийдэл, чанар байдал | Барилгын давхаруудын байгуулалтын зураг, ерөнхий төлөвлөгөө г.м |
| 10 | Барилгад хийгдсэн засвар сайжруулалт, өөрчлөлт | Тайлбар |
| 11 | Байгууламжийн талаарх мэдээлэл: хүчин чадал, зураг, зориулалт, хийц бүтээц, ашиглалтанд орсон он ... | Жагсаалтаар |
| 7.1-д тусгасан Тээврийн хэрэгслийн мэдээлэл | | |
| 12 | Үнэлгэдэх тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар | Файлаар |
| 13 | Тээврийн хэрэгслийн дэлгэрэнгүй бүртгэл: марк, тоо, гүйлт, техникийн засвар үйлчилгээ | тайлбар |
| 7.1-д тусгасан Тоног төхөөрөмжийн мэдээлэл | | |

| | | | |
|---|---|---|---|
| | 14 | Үнэлгэдэх тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй бүртгэл | Техникийн баримт бичгийн хуулбар |
| | 15 | Тоног төхөөрөмжийн техникийн паспортын хуулбар | Файлаар |
| | 16 | Худалдан авсан гэрээний хуулбар | Файлаар |
| **7.1-д тусгасан Компьютер, дагалдах хэрэгслийн мэдээлэл** | | | |
| | 17 | Үнэлгэдэх компьютер, дагалдах хэрэгслийн жагсаалт, тайлбар, тодруулга | Жагсаалт /файлаар/ |
| **7.1-д тусгасан Тавилга эд хогшлийн мэдээлэл** | | | |
| | 18 | Үнэлгэдэх хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл | Файлаар |
| **7.5-д тусгасан Биет бус хөрөнгийн мэдээлэл** | | | |
| | 19 | Үнэлгэдэх биет бус хөрөнгийн жагсаалт, тайлбар, тодруулга | Жагсаалт /файлаар/ |
| | 20 | Биет бус хөрөнгийн эрхийн гэрчилгээний хуулбар | Файлаар |
| | 21 | ББХ-г эзэмших, хөгжүүлэхтэй холбоотой гарсан зардал, өгөөж... | Файлаар |
| **БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ /ирэх 3 жилийн үйл ажиллагааг тусгасан/** | | | |
| | 22 | **Бизнес төлөвлөгөө /ирэх 3 жилийн үйл ажиллагааг тусгасан/** | Файлаар |
| | 23 | Бизнес төлвлөгөөтэй уялдуулан гаргасан, ирэх 3 жилийн санхүүгийн баланс | Файлаар |
| **Судалгаа, мэдээллүүд** | | | |
| | А | **Удирдлагын баримт бичиг** | |
| | 24 | НББ-н бодлогын баримт бичиг | Файлаар |
| | 25 | Олон улсын / Олон улсын Үнэлгээний байгууллагууд /Moody's г.м/-ын дүгнэлтүүд/ болон дотоодын Зөвлөх, эксперт, хяналтын байгууллагаас гаргасан дүгнэлт, тайлан | Файлаар |
| | 26 | МБ-наас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийн тайлан, динамик, дүгнэлт | Файлаар |
| | Б | **Бусад** | |
| | 29 | Үндсэн хөрөнгийн үнэлгээний тайлан | Файлаар |
| | 30 | Банкны ноогдол ашиг хуваарилах бодлого /төсөл/ | Файлаар |

***Үнэлгээнд ашигласан хууль эрхзүй, арга зүйн материалууд***

- Хөрөнгийн үнэлгээний тухай хууль,
- ҮОУС, Ерөнхий стандартууд,
- ҮОУС, Хөрөнгийн стандартууд,
- Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2011 оны 274/240 тоот тушаалаар баталсан "Бизнесийн үнэлгээний аргачлал",
- Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 122 тоот тогтоолоор батлагдсан "Аудит, үнэлгээ, эрх зүйн дүгнэлт гаргах болон тайланг хянахад мөрдөх заавар".

***Зах зээлийн болон бусад ашигласан мэдээллийн эх сурвалж***

- www.mongolbank.mn /валютын ханшийн мэдээлэл/,
- www.unegui.mn гэх мэт дотоодын зарын интернет сайтууд,
- газрын биржийн нэгдсэн сангийн мэдээлэл,
- худалдааны байгууллагуудын үнийн санал.
- https://www.investing.com/
- www.mse.mn
- Тайлан эх сурвалжаар дурдсан бусад мэдээлэл байна.

СЭХ 2022 он 09 сар 21 өдөр БҮРТГЭВ № 01



ТӨРИЙН БАНК 2022-09-14 БҮРТГЭВ-03



*Ашигласан материал*


- BTI. (2022). Bertelsmann Stiftung’s Transformation Index (BTI) 2022. Retrieved from BTI 2022 Country Report: Kazakhstan: https://bti-project.org/fileadmin/api/content/en/downloads/reports/country_report_2022_KAZ.pdf
- CBU. (2022, February 9). Statistic Bulletin of CBU 2021. Retrieved from Credit Institutions Performance: https://cbu.uz/upload/medialibrary/565/Statistical-bulletin-of-the-Central-bank-2021.pdf
- Kahiani, M. (2021, May 4). The Law Reviews. Retrieved from The Banking Regulation Review: Kazakhstan: https://thelawreviews.co.uk/title/the-banking-regulation-review/kazakhstan
- The Global Economy. (2022, April 30). The Global Economy.com. Retrieved from Non-performing loans country rankings: https://www.theglobaleconomy.com/rankings/nonperforming_loans/
- World Bank. (2009, June). The World Bank Group. Retrieved from Financial Sector Assessment: Republic of Kazakhstan: https://openknowledge.worldbank.org/handle/10986/3058
- Asian Development Bank, A. D. (2022). Asian Development Outlook 2022: Mobilizing taxes for development. Mandaluyong.
- European Bank for Reconstruction and Development. (2021). Transition Report 2021-2022. London.
- International Monetary Fund. (2021). World Economic Outlook: Recovery during a Pandemic-Health Concerns, Supply Disruptions, Price Pressures. Washington, DC.,.
- The World Bank Group. (2022). A World Bank Report: Commodity Markets Outlook. Washington DC.
- М.Энхтөр нарын 4 цуврал бүхий “Чанаргүй зээл барагдуулалтын судалгаа” https://www.mongolbank.mn/list_sudalgaa.aspx?id=1


## 1.9 Үнэлгээний үйл явц

Энэхүү үнэлгээний ажлыг ҮОУС 101-ын ажлын хамрах хүрээ, захиалагчтай байгуулсан гэрээ, хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7.1-д нийцүүлэн үнэлгээ хийх ажлын бэлтгэл хангасан. Үүнд:

1. Үнэлгээ хийх төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж, баталгаажуулсан.

2. Үнэлгээний ажлын талаарх захиалагчийн шийдвэр, үнэлгээний зүйлтэй холбоотой бүрдүүлж өгсөн баримт, мэдээлэлтэй танилцаж, шаардлагатай баримт бичиг, холбогдох материалыг нэмэлтээр гаргуулан авсан.

3. Үнэлгээний ажлын даалгаврын талаар уулзалтыг 2022 оны 04-р сарын 26, 28-ны өдрүүдэд компанийн удирдлагуудтай уулзалт хийж, ажлын цар хүрээг тодорхойлсон.

4. Бизнесийн үнэлгээний стандарт, аргачлал, журам, норм норматив болон шаардлагатай бусад материал бэлтгэж, ажлын төлөвлөгөө гаргасан.

5. Үнэлгээний зүйлийн талаарх захиалагчийн өгсөн мэдээлэл, холбогдох баримт бичгүүд, ижил төстэй хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийг үндэслэн, ажлын төлөвлөгөө,



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

СЗХ
2022 09 21
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭВ-03



хуваарийн дагуу үнэлгээг хийж гүйцэтгэв.

***Үнэлгээний ажлын хуваарилсан хуваарь***

| Ажлын нэр | Хариуцсан үнэлгээчид |
|---|---|
| Тайлан нэгтгэл | Э. Цацрал |
| Орлогын хандлагын үнэлгээ | Б. Эрдэнэбаатар, Ч. Дарамбазар |
| Орлогын хандлагын үнэлгээний МГ-ний тооцоололд орлогын өсөлтийн хувиас бусад прогноз, хорогдуулгын хувь дахь зах зээлийн өгөөжийн түвшин, компанийн хэмжээний тохируулгын тооцоолол | Д.Барсболд |
| Зах зээлийн хандлагын үнэлгээ | П. Болормаа, Б. Бурмаа, Б. Эрдэнэбаатар |
| Цэвэр хөрөнгийн үнэлгээ | Ц. Сэржээ, Б. Эрдэнэбаатар |
| Зах зээлийн судалгаа | Б. Энхтуяа, Б. Бурмаа |
| Үнэлгээний зүйлийн судалгаа | Үнэлгээний багийн гишүүд |
| **Дүн, дүгнэлт** | **Үнэлгээний багийн гишүүд** |



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕН ҮЦК ХХК
ТТБ0674 5208173

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14



# 2 ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

## 2.1 Дэлхийн эдийн засгийн өнөөгийн байдал, хэтийн төлөв

**Хөгжиж буй улс орнуудын макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд дунд хугацааны таамаглалаар буурах хандлагатай байна[1].**

*Хүснэгт 1. Хөгжиж буй улс орнуудын макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн дунд хугацааны таамаглал (ОУВС)*

| | Дундаж | | 2019 | 2020 | Прогноз | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2003-2012 | 2013-2022 | | | 2021 | 2022 | 2019-2022 | 2023-2026 |
| Бодит ДНБ | 6.6 | 4.1 | 3.7 | -2.1 | 6.4 | 5.1 | 3.2 | 4.5 |
| Импорт | 9.8 | 3.2 | -0.9 | -8 | 12.1 | 7.1 | 2.3 | 5 |
| Экспорт | 8.3 | 3.5 | 0.4 | -5.2 | 11.6 | 5.8 | 2.9 | 4.5 |
| Худалдааны нөхцөл | 1.6 | -0.5 | -1.2 | -1 | 1.6 | -0.1 | -0.2 | -0.6 |
| Дэлхийн үнэ: | | | | | | | | |
| Үйлдвэрлэл | 3.1 | -0.2 | 0.5 | -3.2 | 5.5 | 4.4 | 1.7 | 1.6 |
| Газрын тос | 15.5 | -4.8 | -10.2 | -32.7 | 59.1 | -1.8 | -1.4 | -3.3 |
| Түлшний бус анхдагч түүхий эд[2] | 10.3 | 0.7 | 0.8 | 6.7 | 26.7 | -0.9 | 7.8 | -0.3 |
| Хэрэглээний үнэ | 6.4 | 4.9 | 5.1 | 5.1 | 5.5 | 4.9 | 5.1 | 4.1 |
| Хүүний түвшин: | | | | | | | | |
| 6 сарын бодит LIBOR | 0.2 | -0.9 | 0.5 | -0.5 | -3.1 | -2.4 | -1.4 | -0.4 |
| Дэлхийн урт хугацаат бодит хүүний түвшин | 1.4 | -0.2 | -0.2 | -0.3 | -2.2 | -1.4 | -1 | -0.2 |
| Урсгал баланс | 2.5 | 0.2 | 0 | 0.6 | 0.8 | 0.6 | 0.5 | 0 |
| Нийт гадаад өр | 28.2 | 30.6 | 30.6 | 32.6 | 31.3 | 30.4 | 31.2 | 29.4 |
| Өрийн үйлчилгээ | 9.2 | 11 | 10.9 | 11.4 | 10.8 | 10.7 | 11 | 10.5 |

*Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын" тайланд (ОУВС, 2021)*

**Монгол ба Азийн орнуудын макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд мөн буурах хандлагатай байгаа хэдий ч хөгжиж буй улс орнуудын макро эдийн засгийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад илүү өссөн, тогтвортой байх хандлага ажиглагдаж байна.**

*Хүснэгт 2. Монгол ба Азийн орнуудын макро эдийн засгийнгол үзүүлэлтүүдийн харьцуулалт (ОУВС)*

| | Бодит ДНБ-ий өөрчлөлтийн хувь | | | Хэрэглээний үнийн өөрчлөлтийн хувь | | | Урсгал тэнцлийн ДНБ-д эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2020 | 2021 | 2022 | 2020 | 2021 | 2022 | 2020 | 2021 | 2022 |
| *Ази* | -1.3 | 6.5 | 5.7 | 2.5 | 2.1 | 2.4 | 2.6 | 2.2 | 2 |
| *Азийн хөгжилтэй орнууд* | -2.9 | 3.8 | 3.5 | 0.2 | 1 | 1.2 | 4.6 | 4.9 | 4.5 |
| *Азийн хөгжиж буй орнууд* | -0.8 | 7.2 | 6.3 | 3.1 | 2.3 | 2.7 | 1.6 | 1.1 | 0.9 |
| *Азийн бусад* | -1.3 | 1.7 | 6.3 | 5.2 | 4.9 | 5.6 | -2 | -2.1 | -2.2 |
| *Монгол* | -5.3 | 5.2 | 7.5 | 2.3 | 7 | 7.5 | -5.1 | -8.5 | -13.3 |

*Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын" тайланд (ОУВС, 2021)*

**Азийн эдийн засгийн хөгжлийн төлөв байдлын талаар 2023 хүртэл хугацаанд дараах таамаглалыг Азийн хөгжлийн банк(АХБ) дэвшүүлжээ. Дэлхийг хамарсан тодорхой бус байдлын орчинд хөгжиж буй азийн эдийн засаг 5.2% өснө. Дотоодын эрэлт хурдтай сэргэж,**

[1] *Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын" тайланд (ОУВС, 2021)*
[2] *Хүнс, ус ундаа, хөдөө аж ахуйн түүхий эд, метал зэрэг орно*



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ХХК

экспорт өсөн нэмэгдсэнээр Ази тивийн хөгжиж буй орнуудын эдийн засаг энэ онд 5.2%, 2023 онд 5.3%-иар өсөх төлөвтэй байна.

*Хүснэгт 3. Монгол ба Азийн хөгжиж буй орнуудын макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн харьцуулалт*

| | | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 хүнд ногдох ДНБ-ий өсөлтийн хувь | *Азийн хөгжиж буй орнууд* | 5.0 | 5.2 | 4.3 | -1.3 | 6.5 | **4.8** | **4.8** |
| | *Монгол* | 3.7 | 5.7 | 3.7 | -6.2 | -0.2 | **0.5** | **3.8** |
| Инфляцийн хувь | *Азийн хөгжиж буй орнууд* | 2.6 | 2.7 | 3.3 | 3.2 | 2.5 | **3.7** | **3.1** |
| | *Монгол* | 4.3 | 6.8 | 7.3 | 3.7 | 7.1 | **12.4** | **9.3** |
| Урсгал тэнцлийн ДНБ-д эзлэх хувь | *Азийн хөгжиж буй орнууд* | 1.3 | 0.1 | 0.8 | 2.1 | 1.3 | **0.9** | **1.0** |
| | *Монгол* | -10.1 | -16.7 | -15.2 | -5.1 | -13.0 | **-16.3** | **-12.7** |

*Эх сурвалж: Азийн эдийн засгийн хөгжлийн төлөв байдлын тайлан (АХБ, 2022)*

Гэвч Украин дахь Оросын Холбооны Улс (ОХУ)-ын халдлага, коронавируст цар тахал (КОВИД-19)-ын улмаас үүссэн тодорхойгүй байдал, мөн Америкийн Нэгдсэн Улсын Холбооны нөөцийн банкны мөнгөний хатуу бодлого нь эдийн засгийн хэтийн төлөвт эрсдэл учруулж байна. Өмнөд Ази, Зүүн Ази зэрэг хэд хэдэн дэд бүсүүдийн эдийн засгийн өсөлтийн түвшин цар тахлын өмнөх үеийн түвшиндээ хүрэх төлөвтэй байна. Бүс нутгийн хэмжээнд инфляцийн түвшин энэ онд 3.7%-д хүрч өсөх, харин 2023 онд 3.1% болж буурах төлөвтэй байна[3].

КОВИД-19-ийн эсрэг вакцинжуулалт нэмэгдсэнтэй холбоотойгоор хөл хорио суларч, дотоодын эрэлт нэмэгдсэн, мөн экспорт өссөн нь өнгөрсөн онд хөгжиж буй Азийн эдийн засаг сэргэхэд эергээр нөлөөлсөн[4]. Бүс нутгийн хэмжээнд урсгал шилжүүлгүүд ч нэмэгдэж байна[5].

Хөгжиж буй Азийн ихэнх орнууд 2022-2023 онд тогтвортой өсөлт үзүүлэхээр байна. Кавказ болон Төв Азийн орнуудын эдийн засаг энэ онд дунджаар 3.6%, ирэх онд 4.0%-иар өсөх төлөвтэй. Гадаад худалдаанаас ихээхэн хамааралтай Зүүн өмнөд Азийн эдийн засаг энэ онд 4.9%, 2023 онд 5.2%-иар өсөхөөр байна[6].

Зүүн Азийн эдийн засгийн өсөлт энэ онд 4.7%, ирэх онд 4.5% байх төлөвтэй байна. Тус бүс нутгийн хамгийн том эдийн засаг болох Бүгд Найрамдах Хятад Ард Улсын эдийн засаг экспортын өсөлтийн эерэг нөлөөгөөр энэ онд 5.0%, ирэх онд 4.8%-иар тус тус өсөх төсөөлөлтэй байгаа юм. Өмнөд Азийн эдийн засаг 2022 онд 7.0%, 2023 онд 7.4%-иар тэлэх бол тус дэд бүсийн хамгийн том эдийн засаг болох Энэтхэг улсын дотоодын нийт

---

*[3] Азийн Хөгжлийн Банк (АХБ)-наас нийтэлсэн Азийн хөгжлийн төлөв 2022 тайлан*

*[4] АХБ-ны Ерөнхий эдийн засагч Альберт Парк хэлсэн үг, Филиппин улс, Манила хот (2022 оны 4 дүгээр сарын 6)*

*[5] Ялангуяа Бангладеш, Киргизстан, Пакистан, Тажикистан зэрэг гадаад орноос шилжүүлэх мөнгөн гуйвуулгаас ихээхэн хамааралтай орнуудад мөнгөн гуйвуулгын дотогшлох урсгал тогтвортой сэргэж байна. Мальдив, Шри Ланка болон Номхон далайн зарим орнууд хилээ нээсэнтэй уялдан олон улсын аялал жуулчлалд сэргэх шинж тэмдэг ажиглагдаж эхэлжээ.*

*6 Аялал жуулчлалаас ихээхэн хамаардаг Номхон далайн орнуудын эдийн засаг 2021 онд 0.6%-иар агшсан бол энэ онд 3.9%, 2023 онд 5.4%-иар өсөх төлөвтэй байна.*



СЗХ
он 2022 сар 2 өдөр
БҮРТГЭВ
№ 01
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-14
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2022 оны 05 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -05- 1
БҮРТГЭВ-03



бүтээгдэхүүн энэ төсвийн жилд 7.5%, ирэх төсвийн жилд 8.0%-иар тус тус өсөх төлөвтэй байна.

## 2.2 Монгол улсын макро эдийн засгийн өнөөгийн байдал, хэтийн төлөв

Энэхүү хэсэгт Монгол улсын эдийн засаг болон санхүүгийн салбарын өнөөгийн нөхцөл байдал ямар байгааг дараах хэмжигдэхүүнүүдийн хүрээнд авч үзнэ. Үүнд:

1. Макро эдийн засгийн хөгжлийн төлөв
2. Санхүүгийн системийн өргөжилт ба тогтвортой байдал
3. Ковидын үеийн эдийн засгийн гүйцэтгэл ба төрөөс авч хэрэгжүүлж байгаа бодлого

### Макро эдийн засгийн төлөв

Монгол улсын хэмжээнд эдийн засгийн голлох үзүүлэлтийг 2017-2021 оны байдлаар авч үзлээ. 2021 оны үзүүлэлтийг 2017 онтой харьцуулбал ажилгүйдэл буурсан, бодит ДНБ, имфляци өссөн байна.

Дэлхий нийтийг хамарсан Ковидын улмаас Монгол улсын бодит ДНБ 2020 онд 5.3% унасан ч 2021 онд эргээд 1.4% өссөнөөр аажим сэргэх шинж ажиглагдаж байна. Харин инфляци 2020 онд бага байсан нь иргэд цаашид үүсч болох эрсдэлд зориулж мөнгөө хадгалах, илүү хэрэглээгээ танаж хүнс болон эрүүл мэнддээ л түлхүү зарцуулах болсонтой холбоотой. 2021 онд инфляци улсын хэмжээнд 13.4%, Улаанбаатар хотын хэмжээнд 14.8%-д хүрч огцом өссөн нь БНХАУ ковидын эсрэг тэмцэх дотоод бодлого хэрэгжүүлж, хил гаалийн асуудал үүссэнтэй холбоотой байна. 2021 онд Засгийн газраас эдийн засгийг сэргээх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн ч ажилгүйдлийн түвшин өмнөх жилээс 1 пунктээр өссөн байна. 2020 онд Монгол улсын эдийн засгийн хөгжлийн цаашдын хандлага Ковидтой хэрхэн тэмцэхээс хамаарч байсан бол одоо Хятад улсын цар тахалтай хийх тэмцэл болон ОХУ ба Украйн хоорондын дайны нөхцөл байдлаас хамаарах болоод байна.




*Зураг 2. Монгол улсын ажилгүйдэл, Инфляци, Бодит ДНБ болон Гадаад худалдааны үзүүлэлтүүдийн ДНБ-д эзлэх хувь*

Гадаад худалдааны нийт эргэцийн ДНБ-д эзлэх хувь 2020 онд 98% болж 2018 оноос 6.3 пунктээр буурсан ч 2021 онд эргээд өсч 106.6% болсноор 2018 оны түвшингээс давсан байна. Экспорт жил бүр жигд өсөлттэй байгаа бол импорт 2018 оноос хойш 2 жил дараалан буурч, 2021 онд ДНБ-д эзлэх хувь 5 пунктээр өссөн нь гадаад худалдааны тэнцлийн ДНБ-д эзлэх хувь өмнөх оноос 1.4 пунктээр буурах шалтгаан болжээ.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341459 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ТҮЦДЕБ... ҮЦК ХХК

СЗХ
2022 оны 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01
2022-09-14




*Зураг 3. Гол валютын ханшийн индекс (суурь он 2017)*




*Зураг 4. Монгол улсын төлбөрийн тэнцэл, Монгол улсын гадаад эдийн засгийн бусад үзүүлэлтүүд, сая ам.доллар*

**Гадаад валютын гол ханшуудыг авч үзэхэд сүүлийн жил рублийн ханш суларч, ам.долларын ханш тогтвортой байсан бол юаний ханш тогтвортой өсөх хандлагатай байна.**

## Санхүүгийн системийн өргөжилт ба тогтвортой байдал[7]

**Санхүүгийн системийн тогтвортой байдал нь улс орны эдийн засгийн байдалд, өргөжилт нь эдийн засгийн өсөлтөд чухал үүрэгтэй. Санхүүгийн системийн өргөжилт ба тогтвортой байдлыг олон улсын хэмжээнд дараах хүснэгтүүд дэх үзүүлэлтээр хэмжиж байна.**

*Хүснэгт 4. Банкны зарим индикаторууд, хувиар*

| Үзүүлэлт | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|---|
| *Цэвэр хүүний маржин* | 2.45 | 3.91 | 4.51 | 4.77 | 4.48 |
| *Банкны нийт хөрөнгийн өгөөж* | 0.15 | 0.14 | 0.88 | 1.08 | 0.73 |
| *Банкны өөрийн хөрөнгийн өгөөж* | 1.64 | 1.62 | 8.30 | 10.60 | 7.20 |
| *Банкны зээл/Банкны хадгаламж* | 119.98 | 102.22 | 84.72 | 89.44 | 75.74 |
| *Валютын нөөц/Засгийн газрын өр төлөлт* | 95.00 | 248.89 | 793.80 | 381.53 | 544.47 |
| *Банкны өөрийн хөрөнгө/нийт хөрөнгө* | 12.29 | 11.58 | 10.37 | 10.35 | 10.25 |
| *Олон улсад гаргасан өр/ДНБ* | 47.58 | 58.6 | 51.1 | 60.6 | 0 |

[7] https://databank.worldbank.org/source/global-financial-development



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ХХК

СЭХ 2022.09.21 БҮРТГЭВ № 01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-09-14 БҮРТГЭВ-03



| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| *Гадаадын банкнаас авсан цэвэр зээл/ДНБ* | - | 7 | 3.7 | - | 4.6 |
| *Банкны татан төвлөрүүлсэн хөрөнгө/ДНБ* | 66.47 | 60.6 | 58.78 | 53.36 | 51.9 |

Хүснэгтийн судалгаанаас харахад банкны зарим индикатор үзүүлэлт 2016-2019 онд өссөн бол цар тахлын нөлөөгөөр 2020 оны үзүүлэлт буурсан үр дүн харагдаж байна. Цар тахалын эдийн засагт үзүүлсэн нөлөөг тусад нь судалсан болно.

*Хүснэгт 5. Хөрөнгийн зах зээлийн индикаторууд, хувиар*

| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|---|
| **Зах зээлийн үнэлгээ/ДНБ** | 6.16 | 8.7 | 7.7 | 7.11 | 8.08 | 13.9 |
| **Хувьцааны арилжааны үнийн дүн/ДНБ** | 0.2 | 0.27 | 0.64 | 0.35 | 0.14 | 3.29 |
| **Арилжигдсан хувьцааны тоо/ДНБ (сая,ш)** | 93.7 | 106.1 | 666.8 | 450.4 | | 733.3 |
| **Засгийн газрын бондын арилжаа/ДНБ** | 1.17 | 2.25 | | | | |
| **Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа/ДНБ** | 0.08 | 2.7 | 0.11 | 0.07 | | |
| **Компаний бондын арилжаа/ДНБ** | | 0.04 | | | | 2.44 |
| **ТОП-20 индекс хаалт** | 12456.1 | 20736.9 | 21466.8 | 19621.9 | 19285.8 | 44411.6 |

- *Эх үүсвэр: Монгол банк, Монголын хөрөнгийн бирж*

Хөрөнгийн зах зээлийн индикатаор үзүүлэлтүүдийн хувьд 2016-2021 онд өссөн эерэг үр дүнг илэрхийлж байна.

### Эдийн засаг дахь Ковидын нөлөө ба төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого

2019 оны 12 сараас эхэлсэн Ковид-19 цар тахал нь дэлхий нийтийг хамарч улс орнуудын нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээнд сөрөг нөлөө үзүүлсээр байна. Ковидын үеийн нөхцөл байдлыг тогтворжуулахаар Монгол төрөөс бодлого боловсруулж олон арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд цар тахлын эсрэг нийтдээ 555 өдөр хатуу хөл хорио, өндөржүүлсэн бэлэн байдалд байсан[8]. Гурван сарын хатуу хөл хорионы улмаас ДНБ 3.5-аас 4.5 хувиар буурсан байж болохоор байна[9]. Ковидын эсрэг авч буй төсвийн бодлогын арга хэмжээ ДНБ-ий 43.2% болж байна. Банкны секторын хувьд хүү буурах, зээлийн бүтцийг өөрчлөх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн[10].

Банкуудад цар тахлын нөлөө намжаах бодлогууд явуулсан боловч нийт зээлийн 8.5-10 хувь нь чанаргүй байна[11].

2021 он гараад хөтөлбөрийн нөлөөгөөр зээл огцом өссөн нь 10 их наядын хөтөлбөрийг хэрэгжүүлсэнтэй холбоотой гэж дүгнэхэд хүргэж байна[12]. Зээлийн хүү эрчимтэй буурч байна.

[8] *Хатуу хөл хорио – хүн амын 50-90%-д нөлөөлөх хөл хорио*
[9] *Oxford Economics, 2021*
[10] *Монголбанк, Сангийн яам, ikon.mn*
[11] *Банк Санхүүгийн Академи*
[12] *Сангийн яам. 2017 онд банкны салбарын зээлийн үлдэгдэл 13,5 их наяд басан бол 2021 оны эхний хагс жилийн байдлаар 19,0 их наяд болсон байна. Сангийн Яамны мэдээлснээр 10 их наядын хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй бол банкны салбарын зээлийн үлдэгдэл 16 их наяд байх төсөөлөлтэй байсан байна.*



УЛААНБААТАР ХОТ Өлзий энд ко капитал ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК 5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ ҮЦК ХХК

Үүнд Засгийн газрын хөнгөлөлттэй зээл, Монголбанкны репо санхүүжилт голчлон нөлөөлж байна.

Иргэдийн зээлийн чанар түлхүү муудаж байгаа нь иргэдийн чанаргүй зээл 2019 оны эцэст 334 тэрбум төгрөг байсан бол 2021 оны 6 дугаар сарын байдлаар 544 тэрбум төгрөг болж огцом өссөн, ажлаа алдсан, хувиараа эрхэлдэг бизнес нь хүндэрсэн зээлдэгчид банкнаас хөнгөлөлт авах боломж бага байгаатай холбоотой.

Одоогоор банкны системийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ /ӨХХ/ хангалттай байгаа боловч цаашид буурах хандлагатай. Энэ нь бодлого хөнгөлөлтүүд зогсох үед ӨХХ муудна, 2021 оны 6 дугаар сард зарим банкууд ногдол ашиг тараасан, зээлийн багц нэмэгдсэн зэргээс шалтгаалан ӨХХ 1.2 нэгж хувиар буурсантай холбоотой.

### Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн төлөв[13]

Монгол улсын хөрөнгийн зах зээл нь үнэт цаасны зах зээл, үл хөдлөх хөрөнгийн зах зээл гэсэн хоёр салбартай.

*Үнэт цаасны зах зээлийн төлөв.* Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үзүүлэлтийг олон улсад үнэлэх нийтлэг шалгуур үзүүлэлтийн дагуу зах зээлийн төлөв байдлыг 2017-2021 онуудаар нэгтгэн харуулав.

*Зах зээлийн үнэлгээ.* Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2021 оны жилийн эцсийн байдлаар 5.98 их наяд төгрөг болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 97.47 хувиар өссөн бөгөөд уг үзүүлэлт ДНБ-ний 13.91 хувийг эзэлж байна.




*Зураг 5. Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ*

*Эх сурвалж: СЗХ, МХБ-ийн мэдээлэл*

Үнэт цаасны зах зээлийн үнэлгээг бүрдүүлж байгаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 180 компаниас 30 компанийн зах зээлийн үнэлгээ зах зээлийн үнэлгээний 93.67 хувийг бүрдүүлж байна.

*Хөрвөх чадвар.* Дэлхийн банкнаас гаргасан үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын багтдаг дунджаас бага орлоготой орнуудын хөрвөх чадварын үзүүлэлт 53.6

[13] *ОУВС, ДБ-аас хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хөгжлийн түвшинг үнэлж, тогтоох хүрээнд хөрөнгийн зах зээлийн хөгжлийн голлох үзүүлэлтүүдийг зах зээлийн үнэлгээ, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хөрвөх чадвар, хувьцааны индекс гэсэн үзүүлэлтээр тооцдог.*

СЗХ
2022 оны 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-14

хувь байгаа[14] бол өндөр орлоготой орнуудын хөрвөх чадварын үзүүлэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар 98.6 хувь байна.

Монгол Улсын хувьд хувьцааны хөрвөх чадвар энэ оны жилийн эцсийн байдлаар 2.25 пунктээр өсөж 3.85 хувьд хүрсэн бөгөөд хувьцааны арилжаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.66 дахин өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна.




*Зураг 6. Хувьцааны хөрвөх чадвар, хувиар*

*Эх сурвалж: СЗХ, МХБ-ийн мэдээлэл*

Хөрвөх чадварын үзүүлэлт олон улсын дундаж үзүүлэлттэй харьцуулахад маш бага түвшинд байгаа нь хувьцааны төвлөрөлтэй хамааралтай байна.

*Үнэт цаасны зах зээлийн индексүүд*[15]. *Зах* зээлийн үнэлгээ болон хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг нэр бүхий 20 компаниас бүрдэж буй ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 2021 оны жилийн эцсийн байдлаар 49,252.48 нэгж, доод үзүүлэлт 19,024.52 нэгж, дундаж үзүүлэлт 35,046.43 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25,125.8 нэгжээр буюу 130.28 хувиар өссөн байна.

MSE-A индексийн дээд үзүүлэлт 2021 оны жилийн эцсийн байдлаар 15,482.77 нэгж, доод үзүүлэлт 8,630.36 нэгж, дундаж үзүүлэлт 11,438.34 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6,360.76 нэгжээр буюу 69.73 хувиар өсөж 15,482.77 нэгж болсон байна. Харин MSE-B индексийн дээд үзүүлэлт 13,309.64 нэгж, доод үзүүлэлт 7,337.79 нэгж, дундаж үзүүлэлт 11,119.50 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,621.43 нэгжээр буюу 60.96 хувиар өсөж 12,202.56 нэгж болсон байна.

*Хүснэгт 6. Индексийн үзүүлэлт*

| Индекс | 2020.12.31 | 2021.12.31 | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| ТОП 20 | 19,285.8 | 44,411.60 | 130.28% |
| MSE A | 9,122.01 | 15,482.77 | 69.73% |
| MSE B | 7,581.13 | 12,202.56 | 60.96% |

*Үнэт цаасны зах зээлийн нийлүүлэлт.* 2021 онд нийт 1.41 их наяд төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн байна. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага дээр өмнөх онуудад

[14] *Stocks traded, turnover ratio of domestic shares (%)*

[15] *МХБ дээр ТОП-20, MSE-A, MSE-B гэсэн гурван төрлийн хувьцааны үнийн индексүүдийг тооцдог. МХБ 2018 онд үнэт цаасны бүртгэлийн I, II ангилалд багтсан компаниудын хамаарах MSE-A болон MSE-B индексийг тооцон гаргадаг болсон.*



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 .. сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14
БҮРТГЭВ-03

зөвхөн хувьцаа, өрийн хэрэгсэл, ЗГҮЦ гэсэн 3 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагддаг байсан бол 2020 онд анх удаа хамтын хөрөнгө оруулалтын сан, 2021 оны 1 дүгээр улиралд хамгийн анхны нийтэд санал болгон гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас амжилттай арилжаалагдсан. Мөн энэ онд компанийн өрийн хэрэгслийн арилжааны хэмжээ огцом өссөн бөгөөд нийт үнэт цаасны арилжааны 21.56 хувийг хувьцаа, 74.12 хувийг компанийн өрийн хэрэгсэл, 4.02 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, 0.30 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа тус тус эзэлж байна.




| | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|
| ХБҮЦ /MSE/ | 0.00% | 0.00% | 0.00% | 0.00% | 0.30% |
| ХОС нэгж эрх /MSE/ | 0.00% | 0.00% | 0.00% | 7.76% | 4.02% |
| Компанийн бондын арилжаа | 1.18% | 0.69% | 0.14% | 8.86% | 74.12% |
| Засгийн газрын үнэт цаасны арилжаа | 89.74% | 13.65% | 6.75% | 0.90% | 0.00% |
| Хувьцааны арилжаа | 9.08% | | | | |

*Зураг 7: Арилжааны хэмжээ*

Нийт үнэт цаасны арилжааны хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.64 дахин өссөн бөгөөд компанийн бондын арилжаа 180.93 дахин өссөн[16].

*Үнэт цаасны зах зээлийн эрэлт.* 2021 онд 42,899 данс нэгдэж өссөн дүнгээр нийт 2,463,052 данс, 84,652 холболтын данс нэгдэж нийт 516,245 холболтын данстай болсон байна.

2021 оны нийт арилжаанд дотоодын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 74.34 хувь буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.86 функтээр өссөн, дотоодын иргэний хийсэн арилжаа 24.22 хувь буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.33 функтээр буурсан бол гадаадын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 0.84 хувь буюу 0.34 функтээр өссөн, гадаадын иргэний хийсэн арилжаа 0.61 хувь буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.03 функтээр буурсан үзүүлэлттэй байна.

*Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа.* СЗХорооноос 2020 онд “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан. 2021 оны жилийн эцсийн байдлаар биржийн бус зах зээлд нийт 26 үнэт цаас гаргагч 36 өрийн хэрэгсэл гаргасан бөгөөд нийт 284.75 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлээд байна.

СЗХ-с тусгай зөвшөөрөл авсан 155, үнэт цаасаа бүртгүүлсэн 314 ХК, хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг нь бүртгэсэн 23, үнэт цаасны зах зээлд хууль, үнэлгээ, аудитын үйлчилгээ үзүүлэх этгээдээр бүртгүүлсэн 110 этгээд байна.

---

[16] *Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-нд зээл, санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойлогдсон томоохон төслүүдийн бүтээн байгуулалтыг идэвхжүүлж, эдийн засгийг сэргээх хөшүүрэг болгох чиглэлээр “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан 692.5 тэрбум төгрөгийн бондын арилжаа гол нөлөөг үзүүлсэн байна.*



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
534 469 ГСТ5362
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14



Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад зуучлах үйл ажиллагааны зөвшөөрөл авсан нийт 13 ҮЦК байгаагаас 2021 оны байдлаар 6 ҮЦК нь 17,475 удаагийн хэлцлээр 1,264 харилцагчийн 1.10 их наяд төгрөгийн гадаад арилжаанд зуучилсан байна. Үүнээс "Голомт Капитал ҮЦК" ХХК нь хамгийн өндөр буюу нийт арилжааны 74.5%-ийг бүрдүүлсэн байна.

## 2.3 Банкны салбарын чиг хандлага, өнөөгийн нөхцөл байдал

### *Монгол Улсын банкны салбарын өнөөгийн нөхцөл байдал*

Банкны системийн хэмжээнд /татан буугдсан банк орсон дүнгээр/ 2021 оны жилийн эцсийн байдлаар 41.01 их наяд төгрөгийн актив хөрөнгө байршиж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 4.33 их наяд төгрөгөөр буюу 11.79 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Актив хөрөнгийн энэхүү өсөлтөд үнэт цаас /цэвэр/ 23.52 хувиар, дотоодын зээл /цэвэр/ 21.69 хувиар, төв банкны үнэт цаас 12.20 хувиар, банкны нөөц 9.95 хувиар, бусад актив 7.04 хувиар, биет бус хөрөнгө 5.70 хувиар, засгийн газрын авлага 2.61 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.




*Зураг 8. Банкуудын активын бүтэц*

*Эх сурвалж: Монгол банк, МОТ шинжилгээ*

Системийн хэмжээн дэх актив хөрөнгийн бүтцийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр зэрэгцүүлэн авч үзэхэд 2018 онд хамгийн өндөр буюу 14.88 хувийн өсөлтийг үзүүлсэн, харин 2020 онд хамгийн бага буюу 2.30 хувийн өсөлтийг үзүүлсэн байгаа нь ковид-19 цар тахалын улмаас эдийн засгийн хямрал нь банкны салбарт нөлөө үзүүлсэн байна.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
БҮДСЕК ҮЦК ХХК

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01
2022-09-14

*Хүснэгт 7. Арилжааны банкуудын активын бүтэц*

| Активын бүтэц | Өөрчлөлт 2017/2018 | Өөрчлөлт 2018/2019 | Өөрчлөлт 2019/2020 | Өөрчлөлт 2020/2021 |
|---|---|---|---|---|
| Нийт актив | 14.88% | 8.49% | 2.30% | 11.79% |
| Банкны нөөц | 33.10% | 37.08% | -34.24% | 9.95% |
| Төв банкны үнэт цаас | 29.07% | -0.50% | 73.71% | 12.20% |
| Гадаад актив | 29.33% | 21.56% | 53.79% | -9.59% |
| Засгийн газрын авлага | -42.67% | -2.56% | 14.18% | 2.61% |
| Үнэт цаас /цэвэр/ | -25.62% | -14.66% | 28.17% | 23.52% |
| Дотоодын зээл /цэвэр/ | 23.57% | 4.96% | -5.84% | 21.69% |
| Бусад санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж | -29.01% | -44.95% | -74.23% | -19.33% |
| Бусад банкнаас авах авлага | -16.88% | 3.37% | -57.97% | -41.05% |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит бус ашиг | 23.89% | 8.88% | -38.65% | -22.42% |
| Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө | 91.73% | 0.79% | 38.23% | -16.17% |
| Үндсэн хөрөнгө | 14.66% | 5.78% | -1.91% | -6.81% |
| Биет бус хөрөнгө | -2.67% | 9.06% | 14.06% | 5.70% |
| Үнэт металл | 4387.97% | 1555.96% | -23.97% | -12.80% |
| Бусад актив | 6.49% | 27.30% | 17.50% | 7.04% |

*Эх сурвалж: Монгол банк, МОТ шинжилгээ*

Дотоодын зээл тайлант хугацаанд буюу 2021 оны жилийн эцсийн байдлаар 21.22 их наяд төгрөг, байгуулсан эрсдэлийн сангийн хэмжээ 1.97 их наяд төгрөг болж цэвэр дүнгээр дотоодын зээлийн хэмжээ 19.24 их наяд төгрөг байна. Дотоод зээл /цэвэр дүнгээр/ өмнөх оны мөн үеэс 3.43 их наяд төгрөг буюу 21.7 хувиар өссөн байна.




*Зураг 9. Арилжааны банкуудын дотоодын зээл, сая төгрөг*

*Эх сурвалж: Монгол банк, МОТ шинжилгээ*

Нийт дотоодын зээлийн багцын 96.8 хувийг аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээл, 0.6 хувийг банкнаас бусад санхүүгийн байгууллагад олгосон зээл, 2.6 хувийг хуримтлуулж тооцсон хүүгийн авлага бүрдүүлж байна.




*Зураг 10. Арилжааны банкны зээлийн бүтэц, сая төгрөг*

*Эх сурвалж: Монгол банк, МОТ шинжилгээ*

Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн 85.4 хувь нь хэвийн зээл, 4.5 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 10.1 хувь нь чанаргүй зээл, харин банкнаас бусад санхүүгийн байгууллагад



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 .09. 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

олгосон зээлийн 94.3 хувь нь хэвийн зээл, 0.7 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 5.0 хувь нь чанаргүй зээл байна.




Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээл өмнөх оны мөн үеэс 21.2 хувиар өссөн, үүнд хэвийн зээл 28.1 хувиар, чанаргүй зээл 3.5 хувиар өссөн, харин хугацаа хэтэрсэн зээл 26.3 хувиар буурсан зэрэг үзүүлэлттэй байна.

*Зураг 11. Арилжааны банкуудынг нийт олгосон зээл*

*Эх сурвалж: Монгол банк, МОТ шинжилгээ*

Банкнаас бусад санхүүгийн байгууллагад олгосон зээл өмнөх оны мөн үеэс 50.0 хувиар өссөн, үүнд хэвийн зээл 52.7 хувиар, чанаргүй зээл 2.5 хувиар өссөн байна.

Банкны системийн хэмжээнд 37.58 их наяд төгрөгийн пассив хөрөнгө буюу өр төлбөр байршиж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 3.96 их наяд төгрөгөөр буюу 11.77 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Пассивын энэхүү өсөлтөд аж ахуйн нэгж, иргэдийн харилцах 40.08 хувиар, аж ахуйн нэгж иргэдийн хадгаламж 5.16 хувиар, бусад төрлийн харилцах, хадгаламж 16.78 тэрбум төгрөгөөр, мөнгөний захын хэрэгслүүд 145.30 хувиар, төв банкинд өгөх өглөг 172.39 хувиар, гадаад пассив 3.36 хувиар, бусад пассив 0.38 хувиар өссөн нь нөлөөлжээ.




*Зураг 12. Арилжааны банкуудын пассивын бүтэц*

*Эх сурвалж: Монгол банк, МОТ шинжилгээ*

СЗХ
2022 .04. 21
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ-03



Системийн хэмжээн дэх пассив хөрөнгийн бүтцийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр зэрэгцүүлэн авч үзэхэд 2018 онд хамгийн өндөр буюу 16.28 хувийн өсөлтийг үзүүлсэн, харин 2020 онд хамгийн бага буюу 2.43 хувийн өсөлтийг үзүүлсэн байна.

*Хүснэгт 8. Арилжааны банкуудын пассивын бүтэц, өөрчлөлт*

| Пассивын бүтэц | Өөрчлөлт 2017/2018 | Өөрчлөлт 2018/2019 | Өөрчлөлт 2019/2020 | Өөрчлөлт 2020/2021 |
|---|---|---|---|---|
| Нийт пассив | 16.28% | 10.19% | 2.43% | 11.77% |
| Аж ахуйн нэгж, иргэдийн харилцах | 37.48% | 2.36% | -4.20% | 40.08% |
| Аж ахуйн нэгж, иргэдийн хадгаламж | 26.75% | 11.43% | 28.64% | 5.16% |
| Бусад санхүүгийн байгууллагад төлөх өглөг | -13.80% | 16.25% | -16.95% | -25.31% |
| Бусад төрлийн харилцах, хадгаламж | -2.83% | -97.25% | 29.52% | 478252.99% |
| Мөнгөний захын хэрэгслүүд | -15.82% | 11.77% | -51.47% | 145.30% |
| Тусгай зориулалттай болон хязгаарлагдмал хадгаламж | 18.18% | 86.47% | 5.34% | -8.19% |
| Бусад банкинд төлөх өглөг | -16.97% | 3.52% | -57.97% | -40.98% |
| Төв банкинд өгөх өглөг | -26.16% | 30.61% | -5.66% | 172.39% |
| Гадаад пассив | 10.10% | -3.28% | -26.19% | 3.36% |
| Засгийн газарт өгөх өглөг | 30.77% | 29.64% | -23.31% | -30.15% |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит бус алдагдал | -49.62% | 736.76% | 120.11% | -15.19% |
| Бусад пассив | -5.47% | 22.50% | 1.96% | 0.38% |

*Эх сурвалж: Монгол банк, МОТ шинжилгээ*

Харилцахыг бүтцээр нь авч үзвэл хувийн байгууллага 55.1 хувийг, иргэд 34.4 хувийг, улсын байгууллага 8.2 хувийг, 2.3 хувийг бусад байгууллага эзэлж байна. Улсын байгууллагын харилцах нь өмнөх оны мөн үеэс 49.22 хувиар буюу 197.68 тэрбум төгрөгөөр, хувийн байгууллагын харилцах 30.45 хувиар буюу 940.67 тэрбум төгрөгөөр, иргэдийн харилцах 57.98 хувиар буюу 922.09 тэрбум төгрөгөөр, бусад байгууллагын харилцах 22.76 хувиар буюу 31.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.



*Зураг 13. Аж ахуйн нэгж, иргэдийн харилцах, сегментээр*

*Эх сурвалж: Монгол банк, МОТ шинжилгээ*



УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ТТБ8674 № 5208173

СЗХ
2022 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14






*Зураг 14. Хугацаагүй болон хугацаатай хадгаламж, сегментээр*

*Эх сурвалж: Монгол банк, МОТ шинжилгээ*

Хугацаагүй хадгаламжийн 92.3 хувийг иргэдийн, 4.2 хувийг улсын байгууллага, 3.4 хувийг хувийн байгууллага, үлдэх хувийг бусад байгууллага эзэлж байна.

Хугацаатай хадгаламжийн хувьд 88.6 хувийг иргэдийн, 9.9 хувийг хувийн байгууллага, 0.8 хувийг улсын байгууллага, үлдэх хувийг бусад байгууллага эзэлж байна.

Улсын байгууллагын хугацаагүй хадгаламж өмнөх оны мөн үеэс 53.74 хувиар буюу 177.48 тэрбум төгрөгөөр буурсан, харин хугацаатай хадгаламж 3.77 хувиар буюу 4.29 тэрбум төгрөгөөр өссөн байна. Иргэдийн хугацаагүй хадгаламж 5.36 хувиар буюу 191.49 тэрбум төгрөгөөр буурсан байхад хугацаатай хадгаламж 9.53 хувиар буюу 1.13 их наяд төгрөгөөр өссөн байна. Хувийн байгууллагын хугацаагүй хадгаламж 74.97 хувиар буюу 377.73 тэрбум төгрөгөөр буурсан байхад хугацаатай хадгаламж 52.03 хувиар буюу 496.55 тэрбум төгрөгөөр өссөн байна.




*Зураг 15. Арилжааны банкуудын өөрийн хөрөнгийн бүтэц /сая.төг/*

Системийн хэмжээн дэх нийт банкны өөрийн хөрөнгө 3.43 их наяд төгрөг бөгөөд өмнөх оны мөн үеэс 11.99 хувиар буюу 366.85 тэрбум төгрөгөөр өссөн. Тухайн оны ашиг 542.02 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 104.26 хувиар буюу 276.66 тэрбум төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 9. Банкны салбарын гол үзүүлэлтүүдийн судалгаа*

| Үзүүлэлтүүд | 2017.IV | 2018.IV | 2019.IV | 2020.IV | 2021.IV |
|---|---|---|---|---|---|
| ROE (niit orlogo/ooriin hurungu) | 0.12 | 0.11 | 0.12 | 0.12 | 0.10 |



УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮДСЕН
ҮЦК ХХК

СЗХ
он сар өдөр
2022 09 21
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14
БҮРТГЭВ-03

Хөрөнгийн үнэлгээний "Мөнх-Оргил трейд" ХХК

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| ROA (niit orlogo/niit hurungu) | 1.08 | 1.05 | 1.14 | 1.15 | 0.98 |
| ТТГЧ | 59.78% | 50.37% | 39.17% | 37.41% | 34.30% |
| Нийт активт эзлэх өөрийн хөрөнгийн харьцаа | 0.12 | 0.10 | 0.10 | 0.10 | 0.10 |
| Чанаргүй зээл | 0.03 | 0.02 | 0.02 | 0.03 | 0.02 |
| Нийт хувийн байгууллагуудад олгосон зээл | 6,806,103.9 | 7,955,116.6 | 8,489,896.1 | 7,928,519.3 | 9,815,206.4 |
| ДНБ | 28,010,710.5 | 32,582,629.0 | 37,839,225.4 | 37,453,275.3 | 43,018,624.3 |
| Бизнесийн зээл болон ДНБ-ийн харьцаа (Дотоодын бизнесийн зээлийн хэмжээ) / (Дотоодын нийт бүтээгдэхүүн) | 0.24 | 0.24 | 0.22 | 0.21 | 0.23 |

*Эх сурвалж: Монгол банк, МОТ шинжилгээ*

Банкны салбарын ROE, ROA 2021 онд өмнөх оноос бага зэрэг буурсан байна. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар салбарын хэмжээнд сүүлийн 5 жил дараалан буурсан байна. ДНБ-д эзлэх бизнесийн зээлийн хэмжээ 2021 онд өмнөх оноос бага зэрэг өссөн хандлагатай байна.

### *Пост коммунизмын зарим улсын банкны салбарын өнөөгийн байдал*

Монгол улстай ижил төстэй орнуудын банкны салбарын өнөөгийн байдлыг судлах зорилгоор хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан зарим орнуудыг сонгон авсан ба банкны салбарын гол үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлттэй харьцуулсан болно.

Киргизстан улс. Санхүүгийн салбар нь банкны систем давамгайлсан бөгөөд бүтэц, хөгжлийн хувьд Монгол улстай ихээхэн төстэй. Нийтдээ 24 банк (11 банкны 50%-аас дээш гадаадын хөрөнгө оруулагчтай), 634 банк бус санхүүгийн байгууллага, 19 даатгалын компани, 9 хөрөнгө оруулалтын сантай. Санхүүгийн салбарын зээлийн эрсдэлийн гол үзүүлэлт болох чанаргүй зээлийн хэмжээ 2019-2021 оны байдлаар нийт зээлийн багцын 7.8%-иас 11.1% болж өссөн байна. Хөрвөх чадварын харьцааны доод хэмжээг Киргизстаны төв банкнаас 45% гэж тогтоосон боловч 2020 онд 64.9%, 2021онд 71.3% тус тус үзүүлэлттэй гарчээ. Энэ нь тус улсын банкны системийн түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ өндөр болохыг харуулж байна. Ижил орлогын түвшинтэй орнуудтай харьцуулахад дижитал үйлчилгээ, финтек компаниуд хөгжлийн эхний шатандаа яваа ажээ.

*Хүснэгт 10. Киргистан улсын банкны салбар гол үзүүлэлт, хувиар*

| | 2010 | 2015 | 2019 | 2021 |
|---|---|---|---|---|
| Банкны актив/ ДНБ | 28% | 42% | 42% | 49.9% |
| Банкны зээл/ ДНБ | 15% | 22% | 24% | 27.1% |
| Банкны депозит/ ДНБ | 12% | 21% | 24% | 34.3% |
| Бодлогын хүү | 5.5% | 10% | 4% | 8% |
| Зээлийн хүү | 20.9% | 18.8% | 14.8% | 14.19% |
| Хадгаламжийн хүү | 3.7% | 4.8% | 4.2% | 3.68% |



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ
ГЭЙДЕК ҮЦК ХХК

СЭХ
он сар өдөр
2022 09 21
БҮРТГЭВ
№ 01

2022 -09- 14
БҮРТГЭВ-03



Эх сурвалж: https://www.nbkr.kg/index1

Узбекстан улс. Тус улс нь төрийн оролцоог багасгах зорилгоор 2017 оноос хийж буй санхүүгийн салбарын шинэчлэл, ерөнхийлөгчийн бодлогын үр дүнд томоохон өөрчлөлтүүд гарч байгаа бөгөөд сүүлийн 4 жилийн дотор шинээр 55 зээл олгох том жижиг банк, банк бус санхүүгийн компани байгуулагдаж өөрийн хөрөнгийн хэмжээ нь 2020 онд 2017 оныхтой харьцуулахад 120%-иар өсчээ. Зээлийн энэхүү огцом өсөлт нь зээлийн чанарт томоохон эрсдэлийг үүсгэнэ хэмээн олон улсын үнэлгээний агентлагууд анхааруулсаар байна. Гэвч төрийн эзэмшлийн хувь 2021 оны 10 дугаар сарын байдлаар нийт банкны системийн 84%-ийг зээлсэн хэвээр байгаа нь чанаргүй зээлийн эрсдэл олон улсын дунджаас[17] бага буюу 2019-2020 онуудад 1.5%-2.6% байхад нөлөөлж байж болзошгүй юм. 2021 онд Хөрвөх чадварын харьцааны доод хэмжээ Монгол улстай ижил буюу 25% болж өөрчлөгдсөн бөгөөд дундаж үзүүлэлт нь 95.5%-тай байна[18].

*Хүснэгт 11. Узбекстан улсын банкны салбар гол үзүүлэлт, хувиар*

| | 2010 | 2015 | 2019 | 2021 |
|---|---|---|---|---|
| Банкны актив/ ДНБ | 35% | 41% | 52% | 61% |
| Банкны зээл/ ДНБ | 20% | 24% | 41% | 46% |
| Банкны депозит/ ДНБ | 22% | 22% | 17% | 19% |
| Бодлогын хүү | 14% | 9% | 16% | 14% |
| Зээлийн хүү | 20.9% | 13.9% | 24.8% | 20.8% |
| Хадгаламжийн хүү | 9.3% | 13.5% | 17.3% | 18.3% |

Эх сурвалж: https://cbu.uz/upload/medialibrary

Казакстан улс. Казакстан улсад 1993 онд хийгдсэн хууль эрх зүйн зохицуулалт, шинэ бодлогын үр дүнд Банкны хоёр шатлалт систем нь улам боловсронгуй болж төв банкны шаардлагууд нь нэмэгдсээр Казакстаны банкны систем олон улсын стандартад нийцэхүйц тогтвортой мэргэжлийн болж хөгжсөн. Дэлхийн томоохон банкны салбарууд тус улсад нээгдэж 200 гаруй арилжааны банкууд 2021 оны байдлаар 26 болтлоо буурсан байна[19]. Үүний 15 банк гадаадын хөрөнгө оруулалттай (олон улсын банкны 12 салбар багтсан), төрийн өмчит нэг банк үйл ажиллагаа явуулж байгаа ба банкны салбарын нийт хөрөнгийн 78%-ийг[20] томоохон 5 банк нь эзэмшдэг. 2020 оны нефтийн үнийн уналт, Ковид-19 цар тахал ба дотоодын улс төрийн тогтворгүй байдал зэрэг нь Казакстаны эдийн засаг, банкны салбарт сөрөг нөлөө үзүүлсэн нь 2020 онд чанаргүй зээлийн хэмжээ 8.1% - 9.5% болтлоо өссөн ба олон улсын үнэлгээний Moody's, Fitch Ratings байгууллагууд тус улсыг "тогтвортой" төлөвөөс "сөрөг" гэсэн ангилалд хамааруулсанаас харагдаж байна[21]. Хөрвөх чадварын харьцааны үзүүлэлтүүд Казакстан улсын хэрэгжүүлж буй олон улсын Basel III стандартаар 42.2% байсан.

[17] *2020 онд 102 улсын нийт банкны зээлийн дундаж эрсдэл 5.86% байна хэмээн The Global Economy байгууллагаас мэдээлсэн (2022)*
[18] *(CBU, 2022)*
[19] *(Kahiani, 2021)*
[20] *(World Bank, 2009)*
[21] *(BTI, 2022)*



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТ56974 Д.5203173

СЗХ
2022 оны 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -09- 14



Финтек компаниудын хөгжил эрчимтэй явагдаж эхэн үедээ бичил зээл цаашлаад 2021 оны эхний сард нийт төлбөр тооцооны 70% дижитал байдлаар хийгдэж, ковидын өмнөх үеэс 2.5 дахин нэмэгдсэн.

*Хүснэгт 12. Казакстан улсын банкны салбар гол үзүүлэлт, хувиар*

| | 2010 | 2015 | 2019 | 2021 |
|---|---|---|---|---|
| Банкны актив/ ДНБ | 39.34% | 36.87% | 25.38% | 27.81% |
| Банкны зээл/ ДНБ | 32.22% | 34.33% | 24.2% | 28.08% |
| Банкны депозит/ ДНБ | 27.33% | 37.66% | 25.25% | 29.90% |
| Бодлогын хүү | 7,0% | 5,5% | 9.25% | 9,75% |
| Зээлийн хүү | 8,16% | 10,95% | 12,5% | 10,75% |
| Хадгаламжийн хүү | 0,71% | 21,62% | 8,28% | 9,07% |

Эх сурвалж: https://www.ceicdata.com/en/indicator/kazakhstan/liquid-assets-ratio




*Зураг 16. Пост коммунизмын зарим улсын банкны салбарын гол үзүүлэлт, хувиар*

Зураг . Пост коммунизмын зарим улсын банкны салбарын гол үзүүлэлт, хувиар

Судалгаанаас харахад Киргистан болон Узбекстан улсын банкны актив, зээлийн хэмжээ сүүлийн 10 жилд өссөн бол Казакстан улсын хувьд буурсан байна. Энэ хугацаанд Киргистан улсын банкны дипозит өссөн бол Узбекстан улсынх буурсан, Казакстан улсын хувьд тогтвортой бус байна. Бодлогын хүүг 10 жилийн өмнөхтэй харьцуулан харахад Киргистан, Казакстан улсынх өссөн, Узбекстан улсынх өмнөх түвшинтэй ойролцоо байна. Мөн Киргистан улсын зээлийн хүү буурсан, Казакстан улсынх аажим өссөн, Узбекстан улсынх 2010 оны түвшинтэй ижил байна. Хадгаламжийн хүү сүүлийн 10 жилд Киргистан улсад тогтвортой байгаа бол Узбекстан улсынх өссөн, Казакстан улсынх харьцангүй өөрчлөлт их байдал ажиглагдаж байна. Банкны салбарын эдгээр үзүүлэлтийн үр дүн нь тухайн улс орон бүрт авч хэрэгжүүлсэн макро түвшний бодлого, эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор харилцан адилгүй байна.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469
УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

СЗХ
он сар өдөр
2022 09 21
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА
2022-09-14



# 3 ҮНЭЛГЭЭНИЙ ЗҮЙЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

## 3.1 Компанийн үндсэн үйл ажиллагааны танилцуулга

Төрийн банк ХХК нь банк санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, харилцагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор Монгол Улсын Банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 375 тоот тушаалаар батлагдсан "Банк, түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам"-ыг тус тус үндэслэн 2009 оны арван нэгдүгээр сарын 23-ны өдөр байгуулагдаж, №26 дугаар бүхий банкны зөвшөөрлийн гэрчилгээг авсан. Банк нь байгуулагдснаас хойш мэргэшсэн хүний нөөц, дэвшилтэт технологи, СВИФТ сүлжээ болон найдвартай үйлчилгээгээр дамжуулан харилцагч иргэд, байгууллагын санхүүгийн хэрэгцээг найдвартай, түргэн шуурхай хангаж ажиллаж байна.

Алсын хараа: Дэлхийн жишигт нийцсэн үйлчилгээ, үнэ цэнэ бүхий үндэсний тэргүүлэгч банк байна.

Эрхэм зорилго: Бид санхүүгийн цогц, хүртээмжтэй үйлчилгээгээр ард иргэдийн сайн сайхан амьдрал, улс орны тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулж, байгаль экологийг хамгаалах, хариуцлагатай хэрэглээг дэмжих бизнесийн дэвшилтэт шийдэл бүхий үйл ажиллагаа явуулна.

Үнэ цэнэ: Итгэлцэл – Итгэл, сэтгэл, хүндэл; Хариуцлага – Сахилга бат, сайн үр дүн; Ур чадвар – Хүний хөгжил, хөгжлийн түлхүүр; Ил тод, нээлттэй – Шилэн банк

Төрийн банк ХХК нь Монголбанкнаас олгосон зөвшөөрлийн дагуу дараах үйл ажиллагааг эрхэлж байна. Үүнд:

1. Мөнгөн хадгаламж
2. Зээл
3. Төлбөр тооцоо
4. Гадаад валют худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах
5. Үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах
6. Үнэт зүйл хадгалах
7. Гадаад төлбөр тооцоо хийх
8. Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах
9. Гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх
10. Даатгалын зуучлалын үйлчилгээ
11. Эх үүсвэртэй баталгаа, батлан даалт гаргах
12. Эх үүсвэргүй баталгаа, батлан даалт гаргах

Төрийн банк нь 349 АТМ, 3400 картаар үйлчлэгч байгууллага, Монгол орны бүхий л сум суурин бүрт байршиж буй нийт 495 салбар нэгжээрээ дамжуулан 2.3 сая харилцагчиддаа банкны үйлчилгээг эрсдэлгүй, найдвартай хүргэж, үндэсний хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг байна. Банкны нийт активийн хэмжээ 3.8 их наяд төгрөгт хүрч, өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон бусад үзүүлэлтээрээ Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллаж байна.

*Харилцах, хадгаламж* - харилцах дансны бүтээгдэхүүн нь иргэдийн болон хуулийн этгээдийн харилцах данс, хадгаламжийн бүтээгдэхүүн нь иргэдийн хугацаатай болон хугацаагүй хадгаламж, хүүгээр арвижих хугацаатай хадгаламж, урьдчилсан хүүт



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГС 5382
УЛААНБААТАР ХОТ
ГҮЮСЕК ҮЦК ХХК

СЗХ
он 2022 сар 09 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01
2022-09-14

хугацаатай хадгаламж, хүүхдийн хадгаламж, малчны хадгаламж зэрэг нийт 6 нэр төрөлтэй байна. Байгууллага буюу хуулийн хугацаагүй харилцах данс, хугацаатай хадгаламжийн данс гэсэн төрөлтэй байна.

*Зээлийн бүтээгдэхүүн* - иргэдийн хувьд бизнесийн зээл, ахуйн хэрэглээний зээл, хэрэглээний зээл, ажлын байр дэмжих зээл, орон сууцны зээл, малчны зээл, газар тариалангийн зээл, хуулийн этгээдийн хувьд бизнесийн хөрөнгө оруулалтын зээл, эргэлтийн хөрөнгийн зээл, ажлын байр дэмжих зээл, зээлийн шугам, төслийн зээлийн төрөлтэй байна.

*Гадаад төлбөр тооцоо* - Swift гадаад гуйвуулга хүлээн авах, илгээх, контакт мөнгөн гуйвуулга, вестерн юнион гуйвуулга, фастер олон улсын гуйвуулга зэрэг бүтээгдэхүүнтэй.

*Картын бүтээгдэхүүн үйлчилгээ* - дебит карт, кредит карт, ОУ-ын эрхтэй карт гэсэн төрлүүдтэй, үүн дотроо энгийн карт, бизнес карт, алтан карт гэх мэт ангилалтай байна.

*Цахим банк бүтээгдэхүүн* - тухайд интернэт банк, онлайн гялс банк, и-биллинг үйлчилгээ, Qpay үйлчилгээ, мессэж мэдээ гэх зэрэг төрөлтэй байна.

*Валют арилжаа* - ОУ-ын бүх төрлийн валют арилжаа хийгддэг. Энэ нь Монголбанкнаас тухайн өдөр зарлагдсан ханшинд суурилдаг ба өндөр дүнтэй арилжааны хувьд хэлцлийн үнийг санал болгодог байна.

*Үнэт цаасны арилжаа* - ЗГ-ын болон Монголбанкнаас гаргасан үнэт цаасы арилжаанд оролцдог мөн бусад үнэт цаасны арилжаанд сул чөлөөтэй мөнгөн хөрөнгөөр оролцож байна.

*Бусад үйлчилгээ* - даатгалын зуучлалын үйлчилгээ, автомат хуримтлалын үйлчилгээ, үнэт зүйл хадгалах хайрцагийн үйлчилгээ, захиалгат шилжүүлэг, эскроу буюу дундын дансны үйлчилгээ, банкны баталгаа гаргах, халамж нэрийн данс авах зэрэг үйлчилгээнүүдийг хамруулдаг байна.




*Зураг 17. Төрийн банкны үйл ажиллагааны бүдүүвч*

Үйлчлэх хүрээ: Иргэд болон хуулийн этгээд



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
БУМБАТ ҮЦК ХХК

Хүчин чадал: Төрийн банк ХХК нь 35 салбар, 449 тооцооны төв, 9 валют солих цэг, 1 төлөөлөгчийн газар, бусад нэгж гэсэн нийт 495 салбар, нэгжийн хүчин чадалтайгаар Улаанбаатар хот болон Монгол улсын 21 аймаг, сумдуудад бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэж ажиллаж байна.




*Зураг 18. Банкны түүхэн замналын зураглал*

Төрийн банк ХХК-ийн дүрмийн дагуу дотоод бодлогын баримт бичгийг боловсруулсан байдаг бөгөөд уг бодлогын баримт бичгийн хүрээнд дараах үйл ажиллагааны чиглэл тус бүрээр дэд бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажилладаг. Үүнд:

- *Зээлийн бодлого* – Банкны зээлийн бодлогын зорилго нь банкнаас зээлийн үйл ажиллагаа болон зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаар баримтлах бодлого, мөрдөх хязгаар хяналтын тогтолцоог тодорхойлж зээлийн эрсдэлийг бууруулахад оршино.
- *Эрсдэлийн удирдлагын бодлого* – Банкны эрсдэлийн удирдлагын зорилго нь банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, хянах замаар банкны хүлээж болзошгүй хохирлыг бууруулах эрсдэлийн удирдлагын үр ашигтай тогтолцоог бий болгож хэрэгжүүлэхэд чиглэнэ.
- *Хүний нөөцийн бодлого* – Банкны хүний нөөцийн бодлогын гол зорилго нь мэргэжлийн болон харилцааны чадвар, чадавхитай, өндөр бүтээмжтэй хүний нөөцийг бүрдүүлэх, сургаж хөгжүүлэх, банк өмнөө тавьсан зорилго, зорилтод хүрэхэд дэмжин ажиллах хүсэлт эрмэлзэлтэй ажилтанг төлөвшүүлэх, ажлын гүйцэтгэл сайн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, ажилтан бүрийн хувийн үр чадварыг бүрэн нээж, хөгжүүлэн оновчтой, үр бүтээлтэй ашиглах банкны хүний нөөцийн менежментийн үндсэн чиглэл, баримтлах үндсэн зарчим, эрхэмлэх зүйлсийг тодорхойлох, банкны ажилтанд оруулсан хувь нэмрээ шударгаар үнэлүүлэн урамшуулан, шагнагдах, алан тушаал ахих, нөхцөлүүдийг бүрдүүлэхэд оршино.
- *Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг* – Төрийн банк ХХК-ийн системийн өдөр тутмын санхүүгийн мэдээллийг данс бүртгэлд тусгах, санхүүгийн тайлан бэлтгэх, толилуулахад туушгай мөрдөгдөх зүй тогтол

СЗХ
он 2022 сар 09 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01
2022-09-14

болон тогтсон дэг журмыг тодорхойлон, санхүүгийн үнэн зөв тоон мэдээллээр хэрэглэгчдийг хангах зорилготой.

- *Мэдээлэл аюулгүй байдлын бодлого* – Банкны мэдээллийн аюулгүй байдлын бодлого нь банкны эзэмшлийн цахим мэдээлэл, мэдээллийн системийн аюулгүй байдлыг зохистой байдлаар хангахад оршино.
- *Комплаенсийн бодлого* – Төрийн банк ХХК нь зөвшөөрөл бүхий бизнесийн байгууллага болохын хувьд дотоод, гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор олон улсын банкны системд баритлаж бий чиг хандлагад үндэслэсэн Банкны бүхий л хүрээг хамрах "комплаенс"-ийн бодлогоо тодорхойлж хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагаар энэхүү баримт бичгийг боловсруулсан байна.

## 3.2 Компанийн засаглал, бүтэц зохион байгуулалт

Төрийн банк ХХК нь 100 хувь төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани юм.

| *Хувьцаа эзэмшигч* | *Эзэмшлийн хувь* | *Үйл ажиллагааны чиглэл* |
|---|---|---|
| Сангийн яам | 52.25% | БНМАУ-ын улсын төлөвлөгөөний комисс нь БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дэргэдэх Улсын төлөвлөгөөний комисс нэртэйгээр 1945 оны 11 сарын 23-ны өдөр БНМАУ-ын бага хурлын тэргүүлэгчдийн 106 дугаар тогтоолоор байгуулагдсан. Сангийн яамны үйл ажиллагааны зорилго нь Монгол улсын иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн санхүү, төсвийн таатай орчин бүрдүүлэх, санхүүгийн оновчтой удирдлагаар хангах юм. |
| Хадгаламжийн даатгалын корпораци | 47.75% | Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийг УИХ-аар хэлэлцэн 2013 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталснаар хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Хадгаламжийн даатгалын корпораци байгуулагдах эрх зүйн үндэс тогтсон. Хадгаламжийн даатгалын корпораци нь хадгаламжийн даатгалын үйл ажиллагааг эрхлэн явуулах ашгийн төлөө бус, төрийн өмчит хуулийн этгээд юм. |

| *ТУЗ-ийн бүрэлдэхүүн* | *Гишүүн Тоо* | *Чиг үүрэг* |
|---|---|---|
| *Сангийн яам<br>*ЗГ-ын хэрэг эрхлэх газар<br>*Хууль зүй, дотоод хэргийн яам<br>*Хараат бус гишүүн | 6 | Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын дагуу ТУЗ-ийн ээлжит хурлыг сар бүр тогтмол зохион байгуулж, хурлаар банкны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, гүйцэтгэх удирдлагыг томилох, банкны жилийн стратегийг тодорхойлох, зохистой засаглалын болон эрсдэлийн удирдлагын бодлого, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлттэй танилцах, батлах, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж ажилладаг. |



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



Төрийн банк ХХК нь дараах бүтэц зохион байгуулалтаар бизнесийн үйл ажиллагаа явуулж байна.



*Зураг 19. Төрийн банкны бүтэц, зохион байгуулалт*

## 3.3 Банк санхүүгийн салбарт эзлэх байр суурь

Монгол улсын банкны секторт 2021 оны эцсийн байдлаар нийт 11 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Төрийн банк нь 2021 оны жилийн эцсийн үзүүлэлтээр 3.8 их наяд төгрөгийн актив хөрөнгөтэй, өөрийн хөрөнгийн хүрэлцээ зохистой харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон бусад үзүүлэлтээрээ Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллаж байгаа бөгөөд Монголбанкны ерөнхийлөгчийн 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А-105 тушаалаар банкны системийн нөлөө бүхий ТОП5 банкны нэгээр зарлагдсан байна.

***Банкуудын салбар, нэгжийн мэдээлэл:***

Системийн хэмжээнд Төрийн банк ХХК нь салбар, нэгжийн тоогоор Хаан банк ХХК-ийн дараа буюу хоёрдугаарт жагсаж байгаа бөгөөд нийт 495 салбар, нэгжтэйгээр Улаанбаатар хот болон Монгол улсын 21 аймаг, сумдууд бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж ажиллаж байна.




*Зураг 20. Арилжааны банкуудын салбар нэгжийн тоо*

*Эх сурвалж: Монгол банк*

Банкны системийн нийт актив /татан буугдсан банкууд ороогүй/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 40.9 их наяд төгрөг бөгөөд ТОП5 банкны нийт актив банкны системийн активын 93.6 хувь буюу 38.3 их наяд төгрөг бөгөөд үүнд 8.5 хувийг Хас банк,



УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он 2022 сар 09 өдөр
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
2022 -09- 14
БҮРТГЭВ



9.3 хувийг Төрийн банк, 19.5 хувийг Голомт банк, 23.3 хувийг ХХБанк, 32.9 хувийг Хаан банк тус тус бүрдүүлж байна.




*Зураг 21. Системийн нийт активт банкуудын эзлэх хувь /2021.12.31//*

*Эх сурвалж: Банкуудын вэб сайт дахь санхүүгийн тайлан*

*Хүснэгт 13. ТОП5 банкны активын өөрчлөлт*

| Нийт актив /их наяд төгрөг/ | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 2020.12.31 | 2021.12.31 | Жилийн Зөрүү | | 4 жилийн Тренд |
| Хаан банк | 12.11 | 13.46 | ▲ | 1.35 | |
| Худалдаа хөгжлийн банк | 8.05 | 9.55 | ▲ | 1.50 | |
| Голомт банк | 7.28 | 7.99 | ▲ | 0.72 | |
| Төрийн банк | 3.48 | 3.79 | ▲ | 0.31 | |
| Хас банк | 3.37 | 3.50 | ▲ | 0.13 | |

*Эх сурвалж: Банкуудын вэб сайт, МОТ шинжилгээ*

Банкуудын активын өсөлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

- Худалдаа хөгжлийн банк 1,503.1 тэрбум төгрөгөөр буюу 18.7 хувиар,
- Хаан банк 1,352.3 тэрбум төгрөгөөр буюу 11.2 хувиар,
- Голомт банк 716.1 тэрбум төгрөгөөр буюу 9.8 хувиар,
- Төрийн банк 310.5 тэрбум төгрөгөөр буюу 8.9 хувиар,
- Хас банк 130.5 тэрбум төгрөгөөр буюу 3.9 хувиар тус тус өссөн байна.

Банкны системийн зээл 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 20.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 их наяд 664.9 тэрбум төгрөгөөр буюу 22.0 хувиар өссөн байна.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341464 ГСТ5392
УЛААНБААТАР ХОТ
ҮНДЭСЕН ҮЦК ХХК

СЗХ
он сар өдөр
2022 09 21
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14

*Хүснэгт 14. ТОП5 банкны зээлийн өөрчлөлт*

| Нийт зээл /их наяд төгрөг/ | 12/31/2020 | 12/31/2021 | Жилийн Зөрүү | 4 жилийн Тренд |
|---|---|---|---|---|
| Хаан банк | 5.29 | 7.02 ▲ | 1.73 | |
| Худалдаа хөгжлийн банк | 4.47 | 4.78 ▲ | 0.31 | |
| Голомт банк | 3.19 | 3.50 ▲ | 0.31 | |
| Төрийн банк | 1.90 | 2.41 ▲ | 0.51 | |
| Хас банк | 1.44 | 1.78 ▲ | 0.34 | |

*Эх сурвалж: Банкуудын вэб сайт, МОТ шинжилгээ*

ТОП5 банкны нийт зээл банкны системийн нийт зээлийн 95.9 хувийг буюу 19.5 их наяд төгрөг, үүнээс Төрийн банк системийн нийт зээлийн 11.8 хувийг бүрдүүлж байна.




*Зураг 22. Банкуудын системийн зээлд эзлэх хувь*

*Эх сурвалж: Банкуудын вэб сайт дахь санхүүгийн тайлан*

Банкны системийн чанаргүй зээл 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,737.5 тэрбум төгрөг байна. Үүнд, Хаан банк 361.7 тэрбум төгрөг буюу 20.8 хувийг, Худалдаа хөгжлийн банк 644.8 тэрбум төгрөг буюу 37.1 хувийг, Голомт банк 259.9 тэрбум төгрөг буюу 15.0 хувийг, Төрийн банк 229.6 тэрбум төгрөг буюу 13.2 хувийг, Хас банк 85.0 тэрбум төгрөг буюу 4.9 хувийг тус тус эзэлж байна. ТОП5 банкны чанаргүй зээлийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:



УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 оны 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01
2022-09-14

*Хүснэгт 15. ТОП5 банкны чанаргүй зээл*

| | Чанаргүй зээл /тэрбум төгрөг/ | | | |
|---|---|---|---|---|
| | 2020.12.31 | 2021.12.31 | Жилийн зөрүү | 4 жилийн Тренд |
| Хаан банк | 357.90 | 361.66 ▲ | 3.77 | |
| Худалдаа хөгжлийн банк | 572.02 | 644.80 ▲ | 72.77 | |
| Голомт банк | 256.75 | 259.86 ▲ | 3.12 | |
| Төрийн банк | 189.27 | 229.62 ▲ | 40.35 | |
| Хас банк | 80.58 | 85.00 ▲ | 4.42 | |

*Эх сурвалж: Банкуудын вэб сайт, МОТ шинжилгээ*

Банкны системийн нийт пассив 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 36.9 их наяд төгрөгт хүрсэн байна.

*Хүснэгт 16. ТОП5 банкны пассивын өөрчлөлт*

| | Нийт пассив /их наяд төгрөг/ | | Зөрүү | |
|---|---|---|---|---|
| | 2020.12.31 | 2021.12.31 | Оны эхнээс | Мөн үеэс |
| Хаан банк | 10.88 | 12.18 ▲ | 1.30 ▲ | 1.30 |
| Худалдаа хөгжлийн банк | 7.12 | 8.53 ▲ | 1.41 ▲ | 1.41 |
| Голомт банк | 6.65 | 7.34 ▲ | 0.69 ▲ | 0.69 |
| Хас банк | 3.06 | 3.12 ▲ | 0.06 ▲ | 0.06 |
| Төрийн банк | 3.18 | 3.40 ▲ | 0.23 ▲ | 0.23 |

*Эх сурвалж: Банкуудын вэб сайт, МОТ шинжилгээ*

Банкны системийн нийт пассивт 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Хаан банк 33.0 хувь, Худалдаа хөгжлийн банк 23.1 хувь, Голомт банк 19.9 хувь, Төрийн банк 9.2 хувь, Хас банк 8.4 хувийг тус тус эзэлж байна.

**ТОП5 банкны депозитын өөрчлөлт**

*Хүснэгт 17. ТОП5 банкны депозитын өөрчлөлт*

| Банкууд | 2020.12.31 | 2021.12.31 | Зөрүү: Оны эхнээс | Зөрүү: Мөн үеэс |
|---|---|---|---|---|
| Хаан банк | 9,370.8 | 10,211.5 ▲ | 840.6 ▲ | 840.6 |
| Худалдаа хөгжлийн банк | 5,311.4 | 6,266.3 ▲ | 954.9 ▲ | 954.9 |
| Голомт банк | 5,285.7 | 5,463.5 ▲ | 177.9 ▲ | 177.9 |
| Төрийн банк | 2,667.6 | 2,845.8 ▲ | 178.3 ▲ | 178.3 |
| Хас банк | 2,025.5 | 2,252.1 ▲ | 226.6 ▲ | 226.6 |



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК 5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЕТКХК

СЭХ
он сар өдөр 2022 09 21
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14



*Эх сурвалж: Банкуудын вэб сайт, МОТ шинжилгээ*

Ковид-19 цар тахал дотоодод гарсантай холбоотой хорио цээрийн дэглэм тогтоосны улмаас иргэд, аж ахуйн нэгж (ААН)-ийн бизнесийн үйл ажиллагаа түр зогсож, бизнесийн эргэлтэд оруулдаг мөнгөн хөрөнгөө банканд хадгаламж хэлбэрээр байршуулсан. "Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль"-ийн 10.4 дэх заалтаар харилцах дансанд хүү тооцохгүй болсонтой холбоотойгоор иргэд, ААН-үүд харилцах дансанд байршуулсан мөнгөн хөрөнгөө хадгаламжид шилжүүлсэн нь банкуудын хадгаламж өсөхөд гол нөлөөг үзүүлсэн байна.

Банкны системийн өөрийн хөрөнгө 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4.0 их наяд төгрөг бөгөөд үүнээс Төрийн банк 388.5 тэрбум төгрөг буюу 9.7 хувийг бүрдүүлж байна.

*Хүснэгт 18. ТОП5 банкны өөрийн хөрөнгийн өөрчлөлт*

| Банкууд | 2020.12.31 | 2021.12.31 | Зөрүү | |
|---|---|---|---|---|
| | | | Оны эхнээс | Мөн үе |
| Хаан банк | 1,229.2 | 1,284.5 ▲ | 55.3 ▲ | 55.3 |
| Худалдаа хөгжлийн банк | 930.4 | 1,020.1 ▲ | 89.8 ▲ | 89.8 |
| Голомт банк | 631.6 | 658.7 ▲ | 27.1 ▲ | 27.1 |
| Төрийн банк | 303.7 | 388.5 ▲ | 84.8 ▲ | 84.8 |
| Хас банк | 305.6 | 311.6 ▲ | 6.0 ▲ | 6.0 |

*Эх сурвалж: Банкуудын вэб сайт, МОТ шинжилгээ*

Банкны системийн ашиг /татан буугдсан банкууд ороогүй/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 548.6 тэрбум төгрөгийн ашигтай бол Төрийн банкны ашиг 45.7 тэрбум төгрөг буюу нийт системийн ашгийн 8.3 хувийг эзэлж байна.

*Хүснэгт 19. ТОП5 банкны цэвэр ашгийн өөрчлөлт*

| [illegible] | | | | |
|---|---|---|---|---|
| | 2020.12.31 | 2021.12.31 | Мөн үетэй харьцуулсан | 4 жилийн тренд |
| Хаан банк | 161.2 | 291.5 ▲ | 130.3 | |
| Худалдаа хөгжлийн банк | 21.0 | 89.7 ▲ | 68.7 | |
| Голомт банк | 10.4 | 25.9 ▲ | 15.5 | |
| Төрийн банк | 30.6 | 45.7 ▲ | 15.1 | |
| Хас банк | 33.7 | 75.3 ▲ | 41.6 | |

*Эх сурвалж: Банкуудын вэб сайт, МОТ шинжилгээ*



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮЛДЭН ҮЦК ХХК

СЗХ
2022 09 21
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14
БҮРТГЭВ-03

### 3.4 Санхүүгийн үзүүлэлт, шинжилгээ

Төрийн банк ХХК-ийн санхүүгийн байдлын шинжилгээг сүүлийн 5 жилийн хугацааны буюу 2017-2021 оны жилийн эцсийн аудитлагдсан тайлангийн үзүүлэлтийг ашиглан шинжилгээг хийсэн болно.

Төрийн банк ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын иж бүрэн тайланд хөндлөнгийн **"Эрнст энд янг монголия аудит" ХХК** нь аудит хийж гүйцэтгэсэн байна.

#### 3.4.1 Түүхэн санхүүгийн байдлын тайлангийн шинжилгээ




*Зураг 23. Төрийн банкны нийт хөрөнгийн бүтэц*

***Эх сурвалж: Төрийн банк ХХК-ийн аудитлагдсан тайлан, МОТ шинжилгээ***

Тайлант хугацаанд буюу 2021 оны жилийн эцсийн тайлангийн үзүүлэлтээр нийт активын хөрөнгийн дүн **3.8 их наяд төгрөг**, өмнөх оны мөн үеэс 9 хувь буюу 310.5 тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтөд банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө өмнөх оны мөн үеэс 52.96 тэрбум төгрөг буюу 36 хувиар, зээл /цэвэр дүнгээр/ өмнөх оны мөн үеэс 483.1 тэрбум төгрөг буюу 28 хувиар, дериватив санхүүгийн хөрөнгө 593.35 сая төгрөг буюу 358 хувиар, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө 2.36 тэрбум төгрөгөөр, борлуулах зориулалттай хөрөнгө 2.17 тэрбум төгрөг буюу 47 хувиар, биет бус хөрөнгө 185.0 сая төгрөг буюу 3 хувиар өссөн байгаа нь нөлөөлсөн байна.

Харин мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь 184.58 тэрбум төгрөг буюу 18 хувиар, хөрөнгө оруулалт 33.86 тэрбум төгрөг буюу 8 хувиар, бусад санхүүгийн хөрөнгө 306.79 сая төгрөг буюу 32 хувиар, бусад санхүүгийн бус хөрөнгө 5.41 тэрбум төгрөг буюу 21 хувиар, үндсэн хөрөнгө 6.72 тэрбум төгрөг буюу 5 хувиар буурсан байна.

Нийт хөрөнгийн дунд зээл /цэвэр дүнгээр/ 59 хувийг, мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө 21.6 хувийг, хөрөнгө оруулалт 10.2 хувийг, банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө 5.3 хувийг, үндсэн хөрөнгө 3.1 хувийг, бусад хөрөнгө үлдэх хувийг эзэлж байна.

Нийт зээл /цэвэр дүнгээр/-д хэвийн зээл 96.6 хувь, хугацаа хэтэрсэн зээл 0.8 хувь, хэвийн бус зээл 1.2 хувь, эргэлзээтэй зээл 1.5 хувь, муу зээл 7.6 хувь, зээлийн хойшлогдсон төлбөр 0.5 хувь, зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага 1.6 хувь, зээлийн эрсдэлийн сан 8.6 хувийг тус тус эзэлж байна.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183035

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ХХК
5208173

СЗХ
2022 оны 09 сарын 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дунд мөнгөтэй адилтгах хөрөнгө 90.2 хувь, бэлэн мөнгө 5.6 хувь, банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө 4.2 хувийг тус тус эзэлж байна.

Хөрөнгө оруулалтын дунд барьцаанд байгаа үнэт цаас 51.3 хувь, борлуулахад бэлэн үнэт цаас 30 хувь, зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас 17.4 хувь, үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага 1.7 хувь, үнэт цаасны эрсдэлийн сан 0.3 хувийг тус тус эзэлж байна.




*Зураг 24. Төрийн банкны нийт өр төлбөрийн бүтэц*

***Эх сурвалж: Төрийн банк ХХК-ийн аудитлагдсан тайлан, МОТ шинжилгээ***

Нийт өр төлбөрийн дүн тайлант хугацааны жилийн эцсийн үзүүлэлтээр 3.4 их наяд төгрөг ба өмнөх оны мөн үеэс 225.64 тэрбум төгрөг буюу 7 хувиар өссөн байна. Өр төлбөрийн энэхүү өсөлтөд харилцах 323.71 тэрбум төгрөг буюу 97 хувиар, банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 45.58 тэрбум төгрөг буюу 20 хувиар, бусад эх үүсвэр 44.20 тэрбум төгрөг буюу 20 хувиар, бусад санхүүгийн өр төлбөр 2.62 тэрбум төгрөг буюу 22 хувиар, дериватив санхүүгийн өр төлбөр 952.96 сая төгрөг буюу 160 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Харин хадгаламж 145.43 тэрбум төгрөг буюу 6 хувиар, бусад санхүүгийн бус өр төлбөр 1.89 тэрбум төгрөг буюу 17 хувиар, хоёрдогч өглөг 44.1 тэрбум төгрөг буюу 100 хувиар буурсан байна. Хадгаламжийн нийт дунд хугацаагүй хадгаламж 303.86 тэрбум төгрөг буюу 43 хувиар, хадгаламжид хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг 8.19 тэрбум төгрөг буюу 15 хувиар буурсан, хугацаатай хадгаламж 166.61 тэрбум төгрөг буюу 11 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт өр төлбөрийн дунд хадгаламж 64.3 хувь, харилцах 19.3 хувь, банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 7.9 хувь, бусад эх үүсвэр 7.8 хувь, бусад санхүүгийн өр төлбөр 0.4 хувь, бусад санхүүгийн бус өр төлбөр 0.3 хувийг тус тус бүрдүүлж байна.

Хадгаламжийн нийт дүнгийн 79.3 хувийг хугацаатай хадгаламж, 18.5 хувийг хугацаагүй хадгаламж, 2.2 хувийг хадгаламжид хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг бүрдүүлж байна.

Бусад эх үүсвэрийн нийт дүнгийн 57.8 хувийг буцаан худалдан авах нөхцөлөөр худалдсан үнэ цаас /репо/, 36.8 хувийг төслийн зээлийн санхүүжилт, 4.1 хувийг бусад, 1.2 хувийг бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг бүрдүүлж байна.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

СЭХ
2022 оны 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14






*Зураг 25. Төрийн банкны өөрийн хөрөнгийн бүтэц*

***Эх сурвалж: Төрийн банк ХХК-ийн аудитлагдсан тайлан, МОТ шинжилгээ***

**Өөрийн хөрөнгийн нийт дүн тайлант хугацаанд буюу жилийн эцсийн үзүүлэлтээр 388.48 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 84.82 тэрбум төгрөг буюу 28 хувиар өссөн байна. Өөрийн хөрөнгийн нийт дүнгийн энэхүү өсөлтөд хувь нийлүүлсэн хөрөнгө 44.1 тэрбум төгрөг буюу 33 хувиар, хуримтлагдсан ашиг, алдагдал 45.75 тэрбум төгрөг буюу 34 хувиар өссөн нь нөлөөлсөн байна. Харин бусад өөрийн хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеэс 5.03 тэрбум төгрөг буюу 43 хувиар буурсан байна.**

**Өөрийн хөрөнгийн нийт дүнгийн 45.8 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгө, 46.6 хувийг хуримтлагдсан ашиг, алдагдал, 5.8 хувийг дахин үнэлгээний нэмэгдэл, 1.7 хувийг бусад өөрийн хөрөнгийн дүн эзэлж байна.**

**Хувь нийлүүлсэн хөрөнгө нь 100 хувь энгийн хувьцаат хэлбэртэй байна.**

**Бусад өөрийн хөрөнгийн нийт дүнгийн 78.2 хувийг бусад, 11.4 хувийг нийгмийн хөгжлийн сан, 10.3 хувийг нөөц сан бүрдүүлж байна.**




*Зураг 26. Төрийн банкны өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтэц*

***Эх сурвалж: Төрийн банк ХХК-ийн аудитлагдсан тайлан, МОТ шинжилгээ***

Нийт өр төлбөр нь **өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүнгийн 89.8 хувийг**, нийт өөрийн хөрөнгө нь **өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүнгийн 10.2 хувийг** бүрдүүлж байна.



УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

СЭХ
2022 .09. 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022 -09- 14



*Түүхэн орлогын дэлгэрэнгүй тайлангийн шинжилгээ*

Орлогын тайлангийн үзүүлэлтийг сүүлийн 5 жилээр зэрэгцүүлэн авч үзлээ. 2021 онд тайлант үеийн цэвэр ашиг **45.75 тэрбум төгрөг** буюу өмнөх оны мөн үеэс 15.14 тэрбум төгрөг буюу 49 хувиар өссөн байна.




*Зураг 27. Төрийн банкны тайлант үеийн цэвэр ашиг*

***Эх сурвалж: Төрийн банк ХХК-ийн аудитлагдсан тайлан, МОТ шинжилгээ***

Хүүгийн орлого жилийн эцсийн үзүүлэлтээр **385.5 тэрбум төгрөг** ба өмнөх оны мөн үеэс 22.4 тэрбум төгрөг буюу 6 хувиар өссөн байна. Хүүгийн орлогод зээлийн хүүгийн орлого 78.2 хувийг, үнэт цаасны хүүгийн орлого 19.8 хувийг, Монголбанкинд байршуулсан хөрөнгөөс олсон хүүгийн орлого 1.2 хувийг, бусад хүүгийн орлого 0.8 хувийг, банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөөс олсон хүүгийн орлого 0.1 хувийг бүрдүүлж байна.




*Зураг 28. Төрийн банкны орлогын тайлангийн үзүүлэлт*

***Эх сурвалж: Төрийн банк ХХК-ийн аудитлагдсан тайлан, МОТ шинжилгээ***

Хүүгийн цэвэр орлого тайлант хугацаанд **194.8 тэрбум төгрөг** буюу өмнөх оны мөн үеэс 65.8 тэрбум төгрөг буюу 51 хувиар өссөн байна. Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлогын хэмжээ тайлант хугацаанд 163.2 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 51.0 тэрбум төгрөг буюу 45 хувиар өссөн. Бусад орлого тайлант хугацаанд 33.97 тэрбум төгрөг ба өмнөх оны мөн үеэс 9.7 тэрбум төгрөг буюу 22 хувиар буурсан байна. Хүүгийн бус орлого нь тайлант хугацаанд 33.2 тэрбум төгрөг ба өмнөх оны мөн үеэс 10.2 тэрбум төгрөг буюу 23 хувиар буурсан байна.

**Тайлант хугацааны дэлгэрэнгүй орлогын дүн 40.7 тэрбум төгрөг** гарсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 3.89 тэрбум төгрөгр буюу 11 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан байна.



УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341165 ГСТ5362
УЛААНБААТАР ХОТ
ГҮЙХЭСЕН ҮНЭ ХХК

СЭХ
2022 оны 09 сарын 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-14
БҮРТГЭВ-03



### 3.4.2 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, динамик хөдөлгөөний шинжилгээ

Монголбанкнаас арилжааны банкуудад зохистой харьцааны дараах шалгуур үзүүлэлт тавигддаг[22]. Үүнд:

| № | Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд |
|---|---|
| 1 | *Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ => 12%<br>*Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа => 9% |
| 2 | Зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлтүүд:<br>• А.Нэг зээлэгч, түүнд холбогдогдох этгээдэд олгосон зээлийн нийт өөрийн хөрөнгөд эзлэх хувь <=20%<br>• Б. Хувь нийлүүлэгч, банкны ажилтан, тэдгээрт холбогдох этгээдэд олгосон зээл:<br>- Нийлбэр нь өөрийн хөрөнгөд эзлэх хувь <= 20%<br>- Нэг этгээдийн хувьд өөрийн хөрөнгөд эзлэх хувь <=5% |
| 3 | Үндсэн хөрөнгийн харьцаа <=8% |
| 4 | Гадаад валютын актив, пассивын зохистой харьцаа:<br>Нэгж валюты хувьд <+/-15%<br>Нийт валютын хувьд <+/-40% |
| 5 | Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа >=25% |

*Банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааны доод хэмжээ*

| Огноо | 2012.06.30 | 2012.12.31 | 2013.06.30 |
|---|---|---|---|
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрдслээр жигнэсэн активын зохистой харьцаа | 7% | 8% | 9% |
| Өөрийн хөрөнгө эрсдлээр жигнэсэн активын зохистой харьцаа | 12% | 12% | 12% |
| Нэмэлт өөрийн хөрөнгийн шаардлага* | 0.5% | 1% | 2% |
| Нийт өөрийн хөрөнгө эрсдлээр жигнэсэн активын зохистой харьцаа | 12.5% | 13% | 14% |

**Сүүлийн 6 сарын туршид банкны системийн нийт активын 5 хувиас дээш хувийг бүрдүүлж байгаа банкуудад Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар нэмэлт өөрийн хөрөнгийн хэмжээг тогтооно.*

Төрийн банк ХХК нь Монголбанкны холбогдох журамд заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаж байна. Тайлант хугацааг хамруулан сүүлийн 5 жилийн хугацааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн динамик хөдөлгөөнийг дор харуулав. Үүнд:

[22] *Эх сурвалж:* Монгол банк – Санхүүгийн тогтвортой байдал – Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

СЭХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14



| Шалгуур үзүүлэлт | Банкны өөрийн зохистой харьцааны шинжилгээ |
|---|---|

1. Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа 2017, 2018 онд >14%

   Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа 2019, 2020, 2021 онд >12%




2. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа >9%




3. Нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгосон зээл, батлан даалт, аккредитивын нийлбэр нь өөрийн хөрөнгийн 20%-иас хэтрэхгүй




4. Хувьцаа эзэмшигч, банкны ажилтан тэдгээрт холбогдох этгээдэд олгосон зээл, батлан даалт аккредитивын:

   *Нийлбэр өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй*




*4.1.Нэг этгээдийн хувьд өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй*






УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он 2022 сар 09 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



5. **Гадаад валютын актив, пассивын зохистой харьцаа:**
   *5.1. Нэгж валютын хувьд (+/-15%)*




   *5.2.Нийт валютын хувьд 2017, 2018 онд (+/-40%)*
   - *Нийт валютын хувьд 2019, 2020, 2021 онд (+/-30%)*




6. **Үндсэн хөрөнгийн харьцаа <8%**




7. **Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 2017, 2018, 2019, 2021 онд >25%**
   - **Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 2020 онд >20%**




*Эх сурвалж: Төрийн банк ХХК-ийн мэдээлэл, МОТ шинжилгээ*

**Системийн нөлөө бүхий банкуудын 2021 оны 4 дүгээр улирлын байдлаарх зохистой харьцааг дор харуулав. Үүнд:**

*Хүснэгт 20. Арилжааны нөлөө бүхий банкуудын зохистой харьцаа /2021.04 улирал/*

| Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд | *Зохистой түвшин* | Төрийн банк | Худалдаа хөгжлийн банк | Хаан банк | Хас банк | Голомт банк | Дундаж |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ | *>9%* | 15.68% | 15.10% | 15.60% | 17.40% | 12.98% | *15.35%* |



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 оны 09 сарын 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01





| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Өөрийн хөрөнгийн хүрэлцээ | *>12%* | 15.68% | 15.10% | 15.60% | 17.40% | 13.28% | 15.41% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар | *>25%* | 31.72% | 40.57% | 46.87% | 44.30% | 41.30% | 40.95% |
| Нийт зээл, активын харьцаа | *<65%* | 63.70% | 48.67% | 51.61% | 53.08% | 43.30% | 52.07% |
| Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа /нэгж валютаар/ | *<+/-15%* | 9.32% | -10.47% | -1.87% | -1.10% | 11.98% | 6.95% |
| Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа /нийт/ | *<+/-30%* | 10.66% | -15.34% | -2.20% | -16.30% | 15.11% | 11.92% |

*Эх сурвалж: Банкуудын вэб сайт,, МОТ шинжилгээ*

Системийн нөлөө бүхий банкууд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн ханган ажиллаж байна. Системийн нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт харьцангуй тогтвортой байсан бөгөөд Худалдаа хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт өмнөх улирлаас 0.54 пунктээр буурсан бол бусад банкуудынх бага зэрэг сайжирсан байна. Тайлант хугацааны буюу 2021 оны 4 дүгээр улиралд банкуудын ашиг 73.51 тэрбум төгрөгөөр өсч, өөрийн хөрөнгийн дүнг нэмэгдүүлсэн нь эерэгээр нөлөөлсөн байна. Системийн нөлөө бүхий банкуудаас Төрийн банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлт хамгийн бага буюу 31.72 хувьтай байгаа бол бусад нөлөө бүхий банкуудын хувьд 40.57-46.87 хувьтай зохистой түвшинг хангаж байна.

### 3.5 ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАРГАСАН ХӨНДЛӨНГИЙН БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТ

2021 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Төрийн банк ХХК-ийн бүх үнэлгээг баталгаажуулж, банкны урт хугацааны хадгаламжийн B3 үнэлгээний хэтийн төлөвийг Moody’s үнэлгээний байгууллага нь “сөрөг”-өөс “тогтвортой” болгон шинэчлэн тогтоосон байна.

| Moody's үнэлгээ | Түвшин |
|---|---|
| Хэтийн төлөв | Тогтвортой |
| Эрсдэлийн үнэлгээ – Гадаад валют | B3/NP |
| Эрсдэлийн үнэлгээ – Дотоод валют | B2/NP |
| Банкны хадгаламж | B3/-- |
| Зээлжих чадамжийн үнэлгээ | b3 |
| Өөрчилсөн суурь зээлийн чадамжийн үнэлгээ | b3 |
| Харилцагч талын эрсдэлийн үнэлгээ | B2(cr)/NP(cr) |



УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар ... өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14



Төрийн банк ХХК-ийн хадгаламжийн B3 үнэлгээ нь суурь зээлийн чадамжийн b3 үнэлгээ (BCA)-тэй ижил түвшинд байна. Банкны суурь зээлийн чадамжийн b3 үнэлгээ нь иргэдийн банкны давуу байдлыг харуулж байгаа бөгөөд энэ нь тогтвортой санхүүжилт, хөрвөх чадварыг хадгалах боломжийг олгодог, иргэдийн зээлдэгч давамгайлсан харьцангуй эрсдэл багатай зээлийн багц, шууд бус эзэмшдэг Монгол улсын Засгийн газраас (B3 тогтвортой) дэмжлэг авдаг тул тогтвортой хөрөнгөтэй гэж үзсэн байна. Төрийн банк ХХК-ийн үнэлгээ нь Монгол улсын зэрэглэлтэй адил үнэлгээтэй байгаа юм.

## 3.6 Бизнес төлөвлөгөөний санхүүгийн үзүүлэлт /төсөөлөл/

Төрийн банк нь IPO гаргахтай холбоотой санхүүгийн үзүүлэлтийн төсөөллийг 2022-2024 оны дунд хугацаанд дараах байдлаар гаргасан байна.

*Хүснэгт 21. Төрийн банкны тайлан тэнцэл, активаар 2022-2024*

| | Тайлан тэнцэл | | | /мян.төг/ |
|---|---|---|---|---|
| | **Актив** | **12/31/2022** | **12/31/2023** | **12/31/2024** |
| 1. | Бэлэн мөнгө | 53,265,563 | 53,341,679 | 53,348,524 |
| 2. | Монголбанкинд байршуулсан хөрөнгө | 301,060,499 | 413,387,884 | 442,352,732 |
| 3. | Бусад БСБ-д байршуулсан хөрөнгө | 50,000,000 | 50,000,000 | 50,000,000 |
| 3.1 | Дотоодын банкуудад байршуулсан | 10,000,000 | 10,000,000 | 10,000,000 |
| | Харилцах | 10,000,000 | 10,000,000 | 10,000,000 |
| | Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | - | - | - |
| | Хадгаламж /3 хүртэлх сар/ | - | - | - |
| | Хадгаламжид хуримтлуулж тооцсон хүүгийн авлага /3 хүртэлх сар/ | - | - | - |
| 3.2 | Гадаадын банкуудад байршуулсан | 40,000,000 | 40,000,000 | 40,000,000 |
| | Гадаадын банкуудад байршуулсан харилцах | 40,000,000 | 40,000,000 | 40,000,000 |
| | БСБ-д байршуулсан хөрөнгийн эрсдлийн сан | - | - | - |
| 4. | Үнэт цаас | 1,138,179,831 | 1,171,134,123 | 1,252,218,207 |
| | ТБҮЦ | 876,000,000 | 933,000,000 | 1,009,000,000 |
| | Засгийн газрын ҮЦ | 129,695,150 | 153,006,750 | 153,006,750 |
| | Вексель | - | - | - |
| | Бусад үнэт цаас /репо орсон/ | 129,838,065 | 82,423,497 | 87,423,497 |
| | ҮЦ эрсдлийн сан | (1,717,868) | (1,255,275) | (1,255,275) |
| | ҮЦ хорогдуулалт | - | - | - |
| | Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 4,364,484 | 3,959,152 | 4,043,235 |
| 5. | Цэвэр зээл | 2,450,321,742 | 2,674,982,556 | 2,960,264,519 |
| 5.1 | Нийт зээл | 2,636,680,606 | 2,879,500,000 | 3,155,900,000 |
| | Хэвийн зээл | 2,370,085,560 | 2,595,818,980 | 2,879,534,449 |
| | Анхаарал хандуулах зээл | 23,048,829 | 24,526,020 | 23,893,551 |
| | Чанаргүй зээл | 243,546,217 | 259,155,000 | 252,472,000 |
| | Хэвийн бус зээл | 31,350,738 | 33,359,995 | 32,499,719 |
| | Эргэлзээтэй зээл | 26,095,099 | 13,556,769 | 16,331,191 |
| | Муу зээл | 186,100,379 | 212,238,236 | 203,641,090 |



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ХХК

СЗХ
он 2022 сар 2-1 өдөр
БҮРТГЭВ
№ 01





| | | | | |
|---|---|---|---|---|
| 5.2 | ЗТУБАХС | (212,524,599) | (234,144,974) | (228,106,924) |
| 5.3 | Зээлийн хойшлогдсон төлбөр | (12,042,031) | (13,241,780) | (14,512,843) |
| 5.4 | Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 38,207,766 | 42,869,309 | 46,984,287 |
| 6. | ӨБҮХХ | 595,181 | 3,768,263 | - |
| | Нийт ӨБҮХХ | 12,455,417 | 12,750,737 | 8,819,866 |
| | ӨБҮХХ-ийн сан | (11,860,235) | (8,982,474) | (8,819,866) |
| 7. | Бусад хөрөнгө | 7,882,437 | 9,921,689 | 9,911,016 |
| 7.2 | Авлага | 2,945,194 | 4,986,816 | 4,986,816 |
| | Нийт авлага | 9,120,300 | 11,983,601 | 11,983,601 |
| | Авлагын сан | (6,175,106) | (6,996,785) | (6,996,785) |
| 7.3 | Бусад | 4,937,242 | 4,934,873 | 4,924,200 |
| 8. | Аргилжаа | - | - | - |
| 9. | Биет хөрөнгө | 124,733,624 | 121,060,334 | 127,416,873 |
| | Барилга | 112,906,311 | 115,906,311 | 118,906,311 |
| | Борлуулах зориулалттай хөрөнгө | 1,609,471 | - | 11,388,728 |
| | Барилын ХЭ | (24,875,766) | (27,254,223) | (29,632,681) |
| | Компьютер, техник хэрэгсэл | 44,890,811 | 51,624,432 | 56,786,876 |
| | Компьютер, техник хэрэгслийн ХЭ | (36,408,175) | (45,047,200) | (55,239,802) |
| | Автомашин, тээврийн хэрэгсэл | 10,261,540 | 10,261,540 | 10,261,540 |
| | Автомашин, тээврийн хэрэгслийн ХЭ | (5,963,053) | (6,679,060) | (7,395,068) |
| | Тоног төхөөрөмж | 26,912,698 | 29,671,249 | 32,044,949 |
| | Тоног төхөөрөмжийн ХЭ | (11,952,082) | (14,542,905) | (17,133,728) |
| | Эд хогшил | 15,610,642 | 16,859,493 | 18,545,442 |
| | Эд хогшлын ХЭ | (8,362,910) | (9,739,302) | (11,115,694) |
| | ҮХСанхүүжилт /дуусаагүй барилга/ | 104,137 | - | - |
| 10. | Биет бус хөрөнгө | 5,729,477 | 5,844,928 | 5,962,707 |
| | **НИЙТ АКТИВ** | **4,131,768,353** | **4,503,441,456** | **4,901,474,578** |

Төрийн банкны 2022-2024 оны төсөөллөөр активийн үзүүлэлтийн нийт дүн нь жил тутам дунджаар 9 орчим хувь өсөхөөр төлөвлөсөн байна. Төсөөллийн 3 жилд бэлэн мөнгийг тогтвортой байхаар, Монгол банкинд байршуулах хөрөнгийг 2022-2023 онд 37 хувь өсөхөөр, 2023-2024 онд 7 хувь өсөхөөр, бусад банк санхүүгийн байгууллагад байршуулах хөрөнгийг тогтмол байхаар, үнэт цаасыг жил тутам бага зэргийн өсөлттэй байхаар төсөөлж байна. Мөн цэвэр зээл, бусад хөрөнгө, биет бус хөрөнгийн хэмжээг ирэх 3 жилд бага зэргийн өсөлттэй байхаар төсөөлжээ.

*Хүснэгт 22. Төрийн банкны Тайлан тэнцэл, эх үүсвэрээр 2022-2024*

| | **Тайлан тэнцэл** | | | **/сая.төг/** |
|---|---|---|---|---|
| | **Эх үүсвэр** | **12/31/2022** | **12/31/2023** | **12/31/2024** |
| 1. | Харилцах | 739,588,427 | 888,238,000 | 958,931,200 |
| | Харилцахын үлдэгдэл | 739,588,427 | 888,238,000 | 958,931,200 |
| | Харилцахын хүүний өглөг | - | - | - |



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ-03



| | | | | |
|---|---|---|---|---|
| 2. | Хадгаламж | 2,368,810,411 | 2,470,354,208 | 2,666,965,076 |
| | Хугацаагүй хадгаламж | 365,607,259 | 396,240,000 | 427,776,000 |
| | Хугацаагүй хадгаламжид хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | - | - | - |
| | Хугацаатай хадгаламж | 1,949,939,326 | 2,017,522,000 | 2,178,092,800 |
| | Хугацаатай хадгаламжид хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | 53,263,826 | 56,592,208.18 | 61,096,276.11 |
| 3. | Репо нөхцөлөөр худалдсан үнэт цаас /хүүгийн өглөг орсон/ | 87,201,433 | 76,193,375 | 110,193,375 |
| | Репо нөхцөлөөр худалдсан үнэт цаас | 84,841,604 | 74,750,000 | 108,750,000 |
| | Репо нөхцөлөөр худалдсан үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | 2,359,829 | 1,443,375 | 1,443,375 |
| 4. | БСБ-с татсан эх үүсвэр | 348,986,105 | 450,788,631 | 469,831,792 |
| 4.1 | Дотоодын БСБ-аас татсан эх үүсвэр | 122,631,192 | 290,253,647 | 313,354,391 |
| | Харилцах | 26,812,147 | 63,476,502 | 68,528,478 |
| | Хадгаламж | 94,470,267 | 223,653,933 | 241,454,131 |
| | БСБ-с татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | 1,348,778 | 3,123,212 | 3,371,782 |
| 4.2 | БСБ-с авсан зээл | 226,354,913 | 160,534,984 | 156,477,401 |
| | Монголбанкнаас авсан төслийн зээл | 99,149,013 | 58,232,253 | 54,175,265 |
| | Монголбанкнаас авсан төслийн зээлийн хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | 3,246 | 2,860 | 2,266 |
| | Бусад дотоодын БСБ-аас авсан зээл | 31,527,778 | - | - |
| | Бусад дотоодын БСБ-аас авсан зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | 536,565 | - | - |
| | Гадаадын БСБ-аас авсан зээл | 94,550,000 | 100,750,000 | 100,750,000 |
| | Гадаадын БСБ-аас авсан зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | 588,311 | 1,549,871 | 1,549,871 |
| 4.3 | Гадаадын банкуудаас татсан харилцах хадгаламж | - | - | - |
| | Гадаадын банкуудаас татсан харилцах | - | - | - |
| | Гадаадын банкуудад байршуулсан харилцахад хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | - | - | - |
| | Гадаадын банкуудаас татсан хадгаламж | - | - | - |
| | Гадаадын банкуудад байршуулсан хадгаламжид хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | - | - | - |
| 5. | Бусад эх үүсвэр | 127,944,199 | 100,792,440 | 94,412,256 |
| | Зарим эх үүсвэр | 8,336,869 | 10,148,516 | 11,387,170 |
| | Төслийн санхүүжилтийн эх үүсвэр | 118,865,895 | 90,364,751 | 82,770,057 |
| | Төслийн санхүүжилтийн хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | 741,435 | 279,173 | 255,029 |
| 6. | Бусад өр төлбөр | 21,690,010 | 20,000,000 | 20,000,000 |
| | Бусдад өгөх өглөг | 11,690,010 | 12,000,000 | 12,000,000 |
| | Банк, Салбар хоорондын тооцоо | 10,000,000 | 8,000,000 | 8,000,000 |
| 7. | Аригжаа | 23,640 | 25,000 | 25,000 |
| 8. | Хоёрдогч өглөг | - | - | - |
| | **НИЙТ ПАССИВ** | **3,694,244,225** | **4,006,391,654** | **4,320,358,699** |
| 1. | Дүрмийн сан | 187,368,421 | 187,368,421 | 187,368,421 |
| 2. | Дахин үнэлгээний нэмэгдэл | 22,666,025 | 22,666,025 | 22,666,025 |



УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
2022 09 21
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14



| | | | | |
|---|---|---|---|---|
| 3. | Өнгөрсөн оны ашиг (алдагдал) | 173,390,691 | 206,063,737 | 268,734,675 |
| 4. | Тухайн оны ашиг (алдагдал) | 32,673,047 | 62,670,937 | 84,066,076 |
| 5. | Нөөцийн сан | 14,991,498 | 14,991,498 | 14,991,498 |
| 6. | Нийгмийн хөгжлийн сан | 289,183 | 289,183 | 289,183 |
| 8. | ББҮЦ-ны дахин үнэлгээ | 6,145,263 | 3,000,000 | 3,000,000 |
| | **НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | **437,524,129** | **497,049,803** | **581,115,879** |
| | **НИЙТ ПАССИВ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | **4,131,768,353** | **4,503,441,456** | **4,901,474,578** |

Төрийн банкны 2022-2024 оны төсөөллөөр пассивийн үзүүлэлтийн нийт дүн нь жил тутам дунджаар 8 хувь өсөхөөр төлөвлөсөн байна. Төсөөллийн 3 жилд харилцах, хадгаламж, банк санхүүгийн байгууллагаас татах эх үүсвэрийг бага зэргийн өсөлттэй байхаар, харин бусад эх үүсвэр, өр төлбөрийг бууруулахаар төсөөлжээ. Өөрийн хөрөнгө нь 2022-2023 онд 13.6 хувиар, 2023-2024 онд 16.9 хувиар өсөхөөр төсөөлсөн байна.

*Хүснэгт 23. Төрийн банкны орлого, зардлын тайлан, 2022-2024 оноор*

| | **Орлого, зардлын тайлан** | | | **/мян.төг/** |
|---|---|---|---|---|
| ОРЛОГО, ЗАРДЛЫН ТАЙЛАН | | **12/31/2022** | **12/31/2023** | **12/31/2024** |
| 1. | **Хүүгийн орлого** | **411,172,863** | **488,632,564** | **514,208,955** |
| 1.1 | Зээлийн хүүгийн орлого | 321,050,202 | 350,444,317 | 379,825,146 |
| 1.2 | Зээлийн хойшлогдсон шимтгэлийн орлого | 10,132,103 | 10,436,066 | 11,636,213 |
| 1.3 | Хөрөнгө оруулалтын хүүгийн орлого | 79,990,559 | 127,752,182 | 122,747,596 |
| | ЗГҮЦ-ны хүүгийн орлого | 7,116,287 | 14,877,529 | 14,524,104 |
| | ТБҮЦ-ны хүүгийн орлого | 53,901,890 | 96,535,479 | 92,544,767 |
| | Бусад үнэт цаасны хүүгийн орлого | 11,930,831 | - | - |
| | Бусад БСБ-аас авсан хүүгийн орлого | 7,041,550 | 16,339,174 | 15,678,724 |
| 2. | **Хүүгийн зардал** | **220,186,044** | **251,518,796** | **266,991,847** |
| | Харилцахын хүүгийн зардал | - | - | - |
| | Хугацаагүй хадгаламжийн хүү | 19,581,443 | 19,241,173 | 20,856,639 |
| | Хугацаатай хадгаламжийн хүү | 167,938,853 | 187,014,408 | 200,124,042 |
| | БСБ-аас татсан эх үүсвэрийн хүүгийн зардал | 7,529,176 | 20,408,101 | 22,184,903 |
| | БСБ-аас авсан зээлийн хүүгийн зардал | 6,513,050 | 15,352,557 | 14,838,132 |
| | Төслийн санхүүжилтийн хүүгийн зардал | 4,993,513 | 3,652,557 | 3,138,132 |
| | Үнэт цаасны хүүгийн зардал | - | - | - |
| | Бусад эх үүсвэрт төлсөн хүүгийн зардал | 13,630,007 | 5,850,000 | 5,850,000 |
| 3. | **Цэвэр хүүгийн орлого** | **190,986,820** | **237,113,769** | **247,217,108** |



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 оны 09 сарын 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14
БҮРТГЭВ-03



| | | | | |
|---|---|---|---|---|
| 4. | **Хүүгийн бус орлого** | **197,413,179** | **210,183,557** | **228,123,444** |
| | Шимтгэл хураамжийн орлого | 30,104,492 | 33,114,941 | 38,082,182 |
| | Арилжааны орлого | 2,996,440 | 3,000,000 | 3,000,000 |
| | Ханшийн тэгшитгэлийн орлого | 164,176,753 | 173,968,616 | 186,941,262 |
| | Бусад орлого | 135,495 | 100,000 | 100,000 |
| 5. | **Хүүгийн бус зардал** | **329,416,781** | **348,126,963** | **372,040,644** |
| | Арилжааны зардал | - | - | - |
| | Ханш тэгшитгэлийн зардал | 163,177,939 | 172,968,616 | 185,941,262 |
| | Боловсон хүчний зардал | 86,075,671 | 90,379,455 | 95,802,222 |
| | Захиргаа аж, ахуйн зардал | 62,931,606 | 66,078,187 | 70,042,878 |
| | Элэгдлийн зардал | 15,199,194 | 16,700,706 | 18,254,282 |
| | Үндсэн бус үйл ажиллагааны зардал | 2,032,370 | 2,000,000 | 2,000,000 |
| 6. | **Цэвэр хүүгийн бус орлого** | **(132,003,602)** | **(137,943,406)** | **(143,917,199)** |
| | | | | |
| 7. | **Эрсдэлийн сангийн өмнөх ашиг** | **58,983,218** | **99,170,363** | **103,299,908** |
| | | | | |
| 8. | **Эрсдэлийн сангийн зардал** | **15,311,236** | **19,101,700** | **(6,200,658)** |
| | Зээлийн эрсдэлийн сангийн зардал | 15,666,984 | 21,620,375 | (6,038,050) |
| | Авлагын сангийн зардал | (534,500) | 821,679 | - |
| | ӨБҮХХ-ийн сангийн зардал | (1,539,116) | (2,877,762) | (162,608) |
| | Үнэт цаасны эрсдэлийн сангийн зардал | 1,717,868 | (462,592) | - |
| 9. | **Эрсдлийн сангийн дараахь ашиг** | **43,671,982** | **80,068,662** | **109,500,566** |
| | | - | | |
| 10. | Татварын зардал | 10,998,935 | 17,397,725 | 25,434,490 |
| 11. | **Татварын дараахь ашиг /алдагдал/** | **32,673,047** | **62,670,937** | **84,066,076** |

Төрийн банкны төсөөллөөр татварын дараах ашиг 2022-2023 онд 92 хувь өсөхөөр, 2023-2024 онд 34 хувь өсөхөөр төлөвлөсөн байна. Төсөөллийн 3 жилд цэвэр хүүний орлого 2022-2023 онд 24 хувь өсөхөөр, 2023-2024 онд 4 хувь өсөхөөр төсөөлжээ.

### 3.7 Дүгнэлт

Банк нь Монгол Улсын банкны тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан журмын дагуу үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. 2021 оны 03 дугаар сард банкны урт хугацааны хадгаламжийн B3 үнэлгээний хэтийн төлөвийг "сөрөг" үнэлгээнээс



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮХЭСЕК ҮЦК ХХК

СЗХ
он 2022 сар 09 өдөр 21
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14



"тогтвортой" болгон шинэчлэсэн байгаа нь банкны үйл ажиллагааны эерэг үзүүлэлтийг харуулж байна.

Банкны хувь эзэмшигчийн бүртгэлээр 52.25 хувийг Сангийн яам, 47.75 хувийг Хадгаламжийн даатгалын корпораци эзэмшдэг. Өнгөрсөн хугацаанд банк хувьцаа эзэмшигчдэд девидент буюу ногдол ашиг хуваарилж байгаагүй үндсэн үйл ажиллагаандаа хөрөнгө оруулсан.

Төрийн банк ХХК нь төрийн өмчийн хэлбэртэй боловч үйл ажиллагаа нь ашгийн төлөө бөгөөд бусад арилжааны банкуудын адил төв банкнаас тавигддаг шаардлага, шалгуур үзүүлэлтийг мөрдөгдөж байна.

Системийн хэмжээнд нөлөө бүхий ТОП5 банкны нэгээр удаа дараа шалгарч байсан ба 3.8 их наяд төгрөгийн актив хөрөнгөтэй. Системийн хэмжээн дэх нийт актив хөрөнгийн 9.3 хувийг бүрдүүлж дөрөвдүгээрт эрэмбэлэгдэж байна. Тайлант хугацааны үзүүлэлтээр Төрийн банк ХХК-ийн актив хөрөнгө 310.5 тэрбум төгрөгөөр буюу 8.9 хувиар өссөн бөгөөд ирэх 4 жилийн трендээр өсөх хандлагатай байна.

Өөрийн хөрөнгийн хэмжээ тайлант хугацаанд 388.4 тэрбум төгрөг ба өмнөх оны жилийн эцсийн үзүүлэлтээс 84.8 тэрбум төгрөг буюу 28 хувиар өссөн байна. Үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа арилжааны банкуудын хэмжээнд авч үзвэл Цэвэр ашгийн 8.3 хувийг Төрийн банк бүрдүүлж байгаа бөгөөд 2021 онд 45.7 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Төрийн банк ХХК нь Монголбанкнаас тавигддаг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилладаг бөгөөд ТОП5 банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн дундажаас 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ 0.33 хувиар илүү, өөрийн хөрөнгийн хүрэлцээ 0.27 хувиар илүү, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар 9.23 хувиар дутмаг буюу хамгийн бага 31.72 хувьтай байгаа бол бусад нөлөө бүхий банкуудын хувьд 40.57-46.87 хувьтай зохистой түвшинг хангаж байна.

Ковид 19 цар тахлаас үүдэлтэй БНХАУ-ын хилийн зурвас хязгаарлалттай байгаа, Орос Украин улсуудын хооронд үүссэн дайн, дэлхийн улс орнуудаас ОХУ- д авч хэрэгжүүлж буй хориг арга хэмжээнүүд нь гадаад төлбөр тооцооны үйлчилгээнд эрсдэл үүсгэж, валютын ханш өсөхөд, валютын хомсдол, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт доголдоход хүрч банкны эдийн засагт тодорхой бус байдлыг улам нэмэгдүүлэх хүлээлтийг бий болгож байна.



УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

# 4 БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТООЦООЛОЛ

## 4.1 Зах зээлийн хандлага

### 4.1.1 Зах зээлийн хандлагаар тооцсон үнэлгээний арга зүй

Зах зээлийн хандлага нь тухайн бизнесийг зах зээл дээр арилжигдсан ижил төстэй бизнес, бизнесийн хувь оролцоо болон ижил төстэй бизнесийн арилжаатай холбоотой ажил гүйлгээтэй харьцуулж үнэ цэнийг тогтоодог.

Зах зээлийн хандлагыг хэрэглэх, гарсан үр дүнд нь мэдэгдэхүйц ач холбогдол өгөхөд дараах нөхцөл байдлыг харгалзан үздэг[23]. Үүнд:

20.2. а) Тухайн үнэ цэнийн суурийн дагуу харгалзан үзэхэд тохиромжтой тийм ажил гүйлгээгээр уг үнэлж буй хөрөнгийг саяхан борлуулсан бол,

20.2. б) Үнэлж буй хөрөнгийг эсвэл түүнтэй ихээхэн ижил төстэй хөрөнгийг нийтэд идэвхитэй арилжаалсан бол,

20.2. в) Ихээхэн ижил төстэй хөрөнгийн хувьд байнга буюу сүүлийн үед гарсан ажиглаж болох ажил гүйлгээнүүд бол.

Зах зээлийн хандлагаар тооцоолсон үнэ цэнэ нь бодит худалдан авагч ба худалдагч нарын хүлээлт, үр дүнгийн тэнцвэржилтийг хамгийн сайн харуулдаг, үнэлгээчний нөлөөллийг багасгадаг давуу талтай. Зах зээлийн хандлагыг хэрэглэх гол шаардлагыг хангах мэдээллийн хүрэлцээ хомс, баталгаажилт нь хангалтгүй, тооцоололд ашигласан мэдээлэл нь үнэлэх бизнесийг илэрхийлсэн мэдээлэлтэй харьцуулагдах байдал нь бодитой эсэх нь эргэлзээтэй байдаг нь сул тал болдог.

### 4.1.2 Үнэлгээнд ашигласан төсөөллүүд

- Үнэлгээний зүйлтэй ижил төсөөтэй бизнес гэдэгт банк санхүүгийн салбарт үйл ажиллагаагаа явуулдаг, бүс нутаг ойролцоо, макро эдийн засгийн нөхцөл байдал төсөөтэй бизнесийн мэдээллүүдийг жишиг мэдээллээр сонгож авах нь үндэслэлтэй;
- Үнэлгээний тооцоололд ашиглагдах, бизнесийн үйл ажиллагааг илэрхийлэх жишиг мэдээллүүд нь үнэлгээний өдрийн байдлаар олон нийтэд мэдээллэгдсэн, нээлттэй ба хүрэлцээтэй, албан ёсны эх сурвалжуудаар түгээгдсэн тул бодитой ба найдвартай гэж төсөөлөв.
- Зах зээлийн хандлагаар тооцоолсон үнэ цэнэ нь орлогын хандлагаар тооцсон үнэ цэнийн дүгнэлтийг нягтлах, дэмжих үндэслэл болно гэж төсөөлсөн.

### 4.1.3 Үнэлгээний тооцооллын хандлага, аргууд

Үнэлгээний олон улсын стандарт 200:Бизнес ба бизнесийн хувь оролцоо стандартад:

- Жиших ажил гүйлгээний арга
- Нийтэд арилжаалагддаг жиших зүйлсийн арга,

Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2011 оны 12-р сарын 30-

[23] *ҮОУС 2017: Үнэлгээний хандлагууд ба аргууд 105 стандарт, 33 тал*

ны өдрийн 274/240 тоот тушаалаар батлагдсан "Бизнесийн үнэлгээ хийх аргачлал" -д:

- Арилжааны буюу жишиг хэлцлийн арга
- Жишиг компанитай харьцуулах арга- уудыг дурдсан байдаг.

Бизнесийн 100%-ийн өмчийн үнэ цэнийг "Жишиг компанитай харьцуулах арга"-аар тооцов. Зах зээлийн хандлагын энэхүү арга нь үнэ цэнэд нөлөө үзүүлэгч гол хүчин зүйлүүдээрээ ижил төстэй компаниудын голлох үзүүлэлтүүдийг харьцуулан жишиж үнэ цэнийг тооцоолдог арга юм.

Дараах арга зүйг баримтлан үнэ цэнийн тооцооллыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Ижил төстэй гэж төсөөлсөн компаниудын мэдээлэлд шинжилгээ хийх;
2. Үнэ цэнийн тооцололд шаардлагатай үржүүлэгчийг тооцох;
3. Үнэлэх бизнесийн санхүүгийн үзүүлэлтүүдийг үржүүлэгчээр үржүүлэн бизнесийн 100%-ийн өмчлөлийн зах зээлийн үнэ цэнийг тодорхойлов.

Зах зээлийн дотоод, гадаад эх сурвалжийн мэдээллийг судалж үзээд доорх хоёр хувилбараар үнэ цэнийн тооцооллыг хийж гүйцэтгэв. Үүнд:

А: Дотоодын зах зээлийн мэдээлэлд үндэслэн тодорхойлсон үнэлгээ,

Б: Гадаадын зах зээлийн мэдээлэлд үндэслэн тодорхойлсон үнэлгээ.

## А. Дотоодын зах зээлийн мэдээлэлд үндэслэн тодорхойлсон үнэлгээ

### а. Ижил төстэй компаниудын мэдээлэлд хийсэн судалгаа шинжилгээ

Зах зээлийн хандлагын дагуу бизнес ба бизнесийн хувь оролцооны үнэ цэнийг тогтооход ашиглагддаг мэдээллийн нийтлэг эх үүсвэр нь[24] төсөөтэй бизнесийн өмчлөлийн хувь оролцоог арилжаалдаг нийтийн хувьцааны зах зээл байдаг. Иймд ижил төсөөтэй бизнесүүдийн мэдээллийг сонгохдоо дотоод буюу үндэсний хэмжээнд банк санхүүгийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй 4 хувьцаат компаниудын нээлттэй мэдээлэлд үндэслэн төсөөтэй бизнесийн жишиг мэдээллийн ул үндэслэлтэй байдлыг доорх үзүүлэлтээр шинжлэв.

*Хүснэгт 24. Жишиг компаниудын мэдээлэл*

| Үзүүлэлт | BOGD | ADB | INV | LEND |
|---|---|---|---|---|
| Нэг ижил буюу эдийн засгийн хувьсагчдад ижил харилцуу үйлдэл үзүүлэх салбарт оршиж буй байдал | 4 | 3 | 3 | 3 |
| Банк | Банк | ББСБ | ББСБ | ББСБ |
| Үнэт цаасны зах зээлд арилжаа хийгдсэн байдал | 1 | 1 | 1 | 1 |
| Компанийн | 20% | 25% | 25% | 25% |
| Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж /ROE/ | 4 | 2 | 1 | 1 |
| 12% | 10.6% | 17.4% | 25.4% | 20.20% |
| Үнэ/Цэвэр орлогын харьцаа | 4 | 3 | 3 | 1 |
| 14.27 | 14.71 | 15.68 | 15.11 | 7.46 |
| Үнэ/Нийт хөрөнгийн харьцаа | 3 | 2 | 1 | 2 |
| 0.17 | 0.48 | 0.84 | 1.37 | 0.76 |
| Үнэ/Өр, төлбөрийн харьцаа | 4 | 2 | 1 | 3 |

[24] *ҮОУС 2020: Бизнес ба бизнесийн хувь оролцоо стандарт 200. 50.2*

СЭХ
он 2022 сар 09 өдөр 21
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-14
БҮРТГЭВ-03



| | | | | |
|---|---|---|---|---|
| 0.19 | 0.70 | 1.21 | 2.12 | 1.53 |
| **ДҮН:** | 20 | 13 | 10 | 11 |
| ***Сонгосон компани:*** | **BOGD** | **ADB** | **INV** | **LEND** |

Жишиг бизнес болон үнэлж буй бизнесийн мэдээлэл хоорондын зөрүүтэй байдлыг оноогоор үнэлэхэд Богд банк ХК(**BOGD**) илүү нийцтэй, Ард кредит ББСБ ХК (**ADB**) төстэй, Инвескор ББСБ ХК (**INV**), ЛэндМН ББСБ ХК (**LEND**) ялгаатай боловч салбарыг төлөөлөх боломжтой гэж үзэн мэдээллийг үнэлгээний тооцоололд ашиглахаар сонгов.

### b. Үржүүлэгчийн тооцоолол, шинжилгээ

Зах зээлийн хандлагаар бизнесийн өмнөх үеийн ажил, гүйлгээн дэх бизнесийн үнэ, цэнэ болон олон нийтэд зориулан худалдсан, худалдан авсан ижил төстэй бизнесийн үнэ, цэнийн дүнг орлого, нийт хөрөнгө, цэвэр хөрөнгө зэрэг суурь үзүүлэлтүүдэд харьцуулан гаргасан нэг эсвэл хэд хэдэн үржүүлэгчийг тооцдог[25] аргачлалын дагуу жишиг бизнесийн хүрээнд, Үнэ/Цэвэр орлогын харьцаа, Үнэ/Нийт хөрөнгийн харьцаа, Үнэ/Өөрийн хөрөнгийн харьцаа гэсэн 3 үржүүлэгчийг дараах байдлаар тодорхойлов.

*Хүснэгт 25. Үржүүлэгчийн тооцоолол, шинжилгээ*

| Компани | ROE | Жин | Үнэ/Цэвэр орлогын харьцаа | Үнэ/Нийт хөрөнгийн харьцаа | Үнэ/Өөрийн хөрөнгийн харьцаа |
|---|---|---|---|---|---|
| **Төрийн банк** | **11.78%** | | | | |
| **BOGD** | 10.6% | 4 | 14.71x | 0.48x | 1.56x |
| **ADB** | 17.4% | 3 | 15.68x | 0.84x | 2.72x |
| **INV** | 25.4% | 1 | 15.11x | 1.37x | 3.84x |
| **LEND** | 20.2% | 2 | 7.46x | 0.76x | 1.51x |
| *Жинлэсэн утга:* | | | 13.59x | 0.73x | 2.12x |
| **Сонгосон утга:** | | | 13.59x | 0.73x | 2.12x |

*Эх үүсвэр: МОТ шинжилгээ*

Жишиг 4 бизнесийн 2021 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаар аудитлагдсан санхүүгийн тайлангаар толилуулсан мэдээллийг эх сурвалж болгон санхүүгийн харьцаа үзүүлэлтийг тооцсон бөгөөд үнэлэх бизнесийн өмчийн өгөөж 11.78%-тэй харьцуулахад жишиг бизнесүүдийн өмчийн өгөөжийн харьцааны ялгаатай байдлыг 4-1 оноогоор эрэмбэ өгч жинлэн, Үнэ/Цэвэр орлогын харьцаа, Үнэ/Нийт хөрөнгийн харьцаа, Үнэ/Өөрийн хөрөнгийн харьцааны жинлэсэн дундаж утгыг тооцов.

### c. Бизнесийн 100%-ийн өмчлөлийн үнэ цэнэ

**Жишиг компанитай харьцуулах аргаар** Монгол улсад банк санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй нэлттэй, жиших компаниудын голлох үзүүлэлтүүдээс тооцсон үржүүлэгчээр үнэлэх бизнесийн санхүүгийн холбогдох дүнг үржүүлж, хамгийн бага утгаар бизнесийн 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг тодорхойлов.

[25] *Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 274/240 тоот тушаалаар батлагдсан "Бизнесийн үнэлгээ хийх аргачлал" 3.3.4 дэх заалт*



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

СЗХ 2022 .09 .21 өдөр БҮРТГЭВ № 01
2022-09-14

*Хүснэгт 26. Жишиг компанийн аргаар тооцсон үнэ цэнийн тооцоолол*

| Үнэ цэнийн үржүүлэгч | | Төрийн банкны санхүүгийн үзүүлэлт /сая.төг/ | Бизнесийн үнэ цэнийн тооцоолсон дүн /сая.төг/ |
|---|---|---|---|
| Үнэ/Цэвэр орлогын харьцаа | 13.59x | 45,748 | 621,652 |
| Үнэ/Нийт хөрөнгийн харьцаа | 0.73x | 3,792,734 | 2,777,487 |
| Үнэ/Өөрийн хөрөнгийн харьцаа | 2.12x | 388,484 | 825,490 |
| Дундаж | | | 1,408,210 |
| Медиан | | | 825,490 |
| MAX | | | 2,777,487 |
| MIN | | | 621,652 |
| **Өнөөгийн үнэ цэнэ /сая.төг/** | | | **621,652** |

## B. Гадаадын зах зээлийн мэдээлэлд үндэслэн тодорхойлсон үнэлгээ

### a. Ижил төстэй компаниудын мэдээлэлд хийсэн судалгаа шинжилгээ

Жишиг компанитай харьцуулах аргаар бизнесийн үнэ цэнийг тооцоолоход ашигладаг жишиг гадаадын компаниудын мэдээллийг олон улсын хөрөнгийн биржүүдийн нэгдсэн https://www.investing.com/ цахим мэдээллийн сангаас үнэлэх бизнестэй адил банкны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг, хөгжиж буй зах зээлийн төлөв бүхий, Олон улсын Moody`s зэрэглэлээр B3, B2 ангилалд хамаарах, улс орны эрсдлийн түвшин [5.33 : 6.30] завсарт орших, 4 улс орнуудын 17 банкны мэдээллийг сонгон авч, уг мэдээллийн ул үндэслэлтэй байдлыг доорх үзүүлэлтээр шинжлэв.



УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14



*Хүснэгт 27. Жишиг компаниудын мэдээлэл*

| Үзүүлэлт | Sabanci Holding | Abu Dhabi Islamic Bank | National Bank of Pakistan | Bank of Punjab | [illegible] | Askari Bank | Housing& Develop Bank | Albaraka Turk | Turkiye Halk Bk | Qnb Finansbank | Bank of Khyber | Meezan Bank | Standard Chartered Bank Pakistan | Bank Islami Pakistan | United Bank | Zenith Bank | Sterling Bank |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Симбол | SAHOL | ADIB | NBPK | BOPU | [illegible] | [illegible] | [illegible] | ALBRK | HALKB | QNBFB | BOK | [illegible] | SCBP | BIPL | UBL | ZENITHB | STERLNB |
| Улс | Турк | Египет | Пакистан | Пакистан | Нигери | Пакистан | Египет | Турк | Турк | Турк | Пакистан | Пакистан | Пакистан | Пакистан | Пакистан | Nigeria | Nigeria |
| Moody's rating | B2 | B2 | B3 | B3 | B2 | B3 | B2 | B2 | B2 | B2 | B3 | B3 | B3 | B3 | B3 | B2 | B2 |
| Монгол B3 | 3 | 3 | 4 | 4 | 3 | 4 | 3 | 3 | 3 | 3 | 4 | 4 | 4 | 4 | 4 | 3 | 3 |
| Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж /ROE/ 11.8% | 17.3% | 5.6% | 1.4% | 6.9% | 3.0% | 5.2% | 4.1% | 14.8% | 3.2% | 5.9% | 2.0% | 10.4% | 4.8% | 1.1% | 3.5% | 6.0% | 2.9% |
| | 3 | 2 | 0 | 3 | 1 | 2 | 2 | 4 | 1 | 3 | 1 | 4 | 2 | 0 | 1 | 3 | 1 |
| Ашгийн хандлагын түвшин 23.5% | 91.7% | 35.9% | 16.3% | 46.6% | 30.3% | 36.9% | 54.2% | 87.8% | 7.0% | 29.7% | 15.1% | 45.3% | 31.2% | 9.1% | 40.8% | 97.6% | 22.4% |
| | 0 | 3 | 3 | 1 | 3 | 2 | 1 | 0 | 2 | 3 | 3 | 1 | 1 | 2 | 2 | 0 | 4 |
| Үнэ/Цэвэр орлогын харьцаа | 3.0 | 8.2 | 17.7 | 6.0 | 8.1 | 9.7 | 15.0 | 2.6 | 16.1 | 100.6 | 52.6 | 24.0 | 35.9 | 55.5 | 21.4 | 9.3 | 10.7 |
| | 2 | 4 | 2 | 3 | 4 | 4 | 2 | 2 | 2 | 0 | 0 | 1 | 1 | 0 | 1 | 4 | 3 |
| Үнэ/Нийт хөрөнгийн харьцаа | 0.03 | 0.03 | 0.02 | 0.02 | 0.02 | 0.02 | 0.08 | 0.02 | 0.02 | 0.34 | 0.05 | 0.12 | 0.16 | 0.04 | 0.06 | 0.08 | 0.03 |
| | 2 | 2 | 1 | 1 | 1 | 1 | 4 | 1 | 2 | 0 | 3 | 4 | 3 | 2 | 3 | 4 | 2 |
| Үнэ/Өөрийн хөрөнгийн харьцаа | 0.5 | 0.3 | 0.2 | 0.4 | 0.2 | 0.5 | 0.6 | 0.4 | 0.5 | 5.9 | 1.0 | 2.5 | 1.7 | 0.8 | 0.8 | 0.6 | 0.3 |
| | 2 | 2 | 1 | 1 | 1 | 2 | 3 | 1 | 2 | 0 | 4 | 0 | 1 | 3 | 3 | 3 | 1 |
| ДҮН: | 12 | 16 | 11 | 13 | 13 | 15 | 15 | 11 | 12 | 9 | 15 | 14 | 12 | 11 | 14 | 17 | 14 |
| Сонгосон: | Sabanci Holding | | | Bank of Punjab | | Askari Bank | | Albanka Turk | | | | Meezan Bank | | | | Zenith Bank | |

**Moody's зэрэглэлээр B3 ба B2 ангилалд орших улс орны зах зээлд нээлттэй, жишиг банкны бизнесийн мэдээллээс, Эздийн өмчийн өгөөжөөрөө үнэлж буй бизнестэй илүү ойролцоо түвшний 6 банкны мэдээллийг сонгож үнэлгээний тооцоолold ашигласан болно.**

**Жишиг компанийн мэдээллийг хавсралт 1-д оруулав**



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
9021031155 СТС2430

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕКЬЮРИТИЗ ҮЦК ХХК
ТТ58674 ф.5208173

СЗХ
он сар өдөр
2022 09 21
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭЭ-03



### b. Үржүүлэгчийн тооцоолол, шинжилгээ

Зах зээлийн хандлагаар бизнесийн үнэлгээнд нэг эсвэл хэд хэдэн үржүүлэгчийг тооцдог аргачлалын дагуу жишиг бизнесийн хүрээнд, Үнэ/Цэвэр орлогын харьцаа, Үнэ/Нийт хөрөнгийн харьцаа, Үнэ/Өөрийн хөрөнгийн харьцаа гэсэн 3 үржүүлэгчийг дараах байдлаар тодорхойлов.

*Хүснэгт 28. Үржүүлэгчийн тооцоолол, шинжилгээ*

**Хүснэгт. Үржүүлэгчийн тооцоолол, шинжилгээ**

| Компани | ROE | Жин | Үнэ/Цэвэр орлогын харьцаа | Үнэ/Нийт хөрөнгийн харьцаа | Үнэ/Өөрийн хөрөнгийн харьцаа |
|---|---|---|---|---|---|
| Төрийн банк | 11.78% | | | | |
| Sabanci Holding | 17.30% | 3 | 3x | 0.03x | 0.52x |
| Albaraka Turk | 14.81% | 4 | 2.65x | 0.02x | 0.39x |
| Meezan Bank | 10.36% | 5 | 24.04x | 0.12x | 2.49x |
| Zenith Bank | 6.57% | 2 | 9.35x | 0.08x | 0.61x |
| Bank of Punjab | 6.86% | 2 | 5.99x | 0.02x | 0.41x |
| Askari Bank | 5.19% | 1 | 9.66x | 0.02x | 0.50x |
| | | *Жинлэсэн утга:* | 10.60x | 0.06x | 1.07x |
| | | **Сонгосон утга:** | 10.60x | 0.06x | 1.07x |

*Эх үүсвэр: МОТ шинжилгээ*

Олон улсын хөрөнгийн биржүүдийн нэгдсэн https://www.investing.com/ цахим мэдээллийн санд Жишиг 6 компанийн 2021 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаар толилуулсан санхүүгийн мэдээлэлд тулгуурлан харьцаа үзүүлэлтийг тооцсон бөгөөд үнэлэх бизнесийн өмчийн өгөөж 11.78%-тэй харьцуулахад жишиг бизнесүүдийн өмчийн өгөөжийн харьцааны ялгаатай байдлыг 5-1 оноогоор эрэмбэ өгч жинлэн, Үнэ/Цэвэр орлогын харьцаа, Үнэ/Нийт хөрөнгийн харьцаа, Үнэ/Өөрийн хөрөнгийн харьцааны жинлэсэн дундаж утгыг тооцов.

### c. Бизнесийн 100%-ийн өмчлөлийн үнэ цэнэ

**Жишиг компанитай харьцуулах аргаар** Гадаад улсад тухайлбал, Пакистан, Нигериа, Турк улсад банкны үйл ажиллагаа явуулж буй нэлттэй, жиших компаниудын голлох үзүүлэлтүүдээс тооцсон үржүүлэгчээр үнэлэх бизнесийн санхүүгийн холбогдох дүнг үржүүлж, медиан утгаар бизнесийн 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг тодорхойлов.

*Хүснэгт 29. Үржүүлэгчийн тооцоолол, шинжилгээ*

| Үнэ цэнийн үржүүлэгч | | Төрийн банкны санхүүгийн үзүүлэлт /сая.төг/ | Бизнесийн үнэ цэнийн тооцоолсон дүн /сая.төг/ |
|---|---|---|---|
| Үнэ/Цэвэр орлогын харьцаа | 10.60x | 45,748 | 484,765 |



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

СЭХ
он 2022 сар 09 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА
2022-09-14
БҮРТГЭВ-03



| | | | |
|---|---|---|---|
| Үнэ/Нийт хөрөнгийн харьцаа | 0.06x | 3,792,734 | 217,251 |
| Үнэ/Өөрийн хөрөнгийн харьцаа | 1.07x | 388,484 | 414,290 |

| Үнэ, цэнийн утгын сонголт | | | |
|---|---|---|---|
| Үнэ/Цэвэр орлогын харьцаагаар тооцсон үнэ | 10.60x | 45,748 | 484,765 |
| Үнэ/Өөрийн хөрөнгийн харьцаагаар тооцосон үнэ | 1.07x | 388,484 | 414,290 |
| Дундаж | | | 449,527 |
| Медиан | | | 449,527 |
| MAX | | | 484,765 |
| MIN | | | 414,290 |
| **Сонгосон утга** | | | 484,765 |
| **Үнэ, цэнийн дүн** | | | **484,765** |

*Эх үүсвэр: МОТ тооцоолол*

### 4.1.4 Үнэ цэнийн тооцооллын нэгтгэл, үр дүн

**Жишиг компанитай харьцуулах аргаар** дээрх 2 хувилбар буюу дотоодын 4 банк, банк бус санхүүгийн байгууллага, гадаадын 3 улсын 6 банк, нийт жишиг 10 компанийн мэдээлэлд үндэслэж тооцсон үнэлгээний үр дүнг доор нэгтгэн үзүүлэв.

*Хүснэгт 30. Хүснэгт. Зах зээлийн хандлагаар тооцоолсон үр дүнгийн нэгтгэл*

| Үзүүлэлт | Тооцоолсон үнэ цэнэ /сая.төг/ | |
|---|---|---|
| Жишиг мэдээллийн эх үүсвэр | Дотоод | Гадаад |
| Жишиг компанийн тоо | 4 | 6 |
| Дундаж | 1,408,210 | 449,527 |
| Медиан | 825,490 | 449,527 |
| MAX | 2,777,487 | 484,765 |
| MIN | 621,652 | 414,290 |

Нэгтгэлээс харахад:

- Дотоодын банк, банк бус санхүүгийн байгууллагын мэдээлэлд тулгуурлан тооцсон үнэ цэнийн дүн гадаадын банкны мэдээлэлд тулгуурласан үнэ цэнээс дунджаар 1.4 дахин өндөр гарч байна. Үүнд үнэлэх бизнестэй ижил дотоодын банк санхүүгийн салбарын нэлттэй, харьцуулагдахуйц компанийн түүврийн хэмжээ бага, жишиг компанийн мэдээлэл нь банк ба банк бус санхүүгийн байгууллагын мэдээллээс бүрдсэн, улс орны эрсдлийн түвшин мөн гадаад банкуудын ялгаатай байдлыг тооцоололд бүрэн шингээгээгүй байх боломжтой зэрэг хүчин зүйлүүд нөлөөлсөн байх үндэслэлтэй байна.
- Дотоод ба Гадаад мэдээлэл ашиглан тооцоолсон Медиан утгын зөрүү нь 1.84, Хамгийн бага утгын зөрүү нь 1.50 байна.

***Үнэлгээний үр дүнгийн шинжилгээ***

Зах зээлийн хандлагаар тооцоолсон үр дүнгийн ул үндэслэлтэй байдлыг үнэлгээний үр дүнд шууд нөлөө үзүүлж буй үржүүлэгчийн түвшинд шинжиллээ. Ингэхдээ үржүүлэгчийг тооцоход ашигласан мэдээллийн түүврийн хүрээг өргөтгөн, үнэлгээний үйл явцад тооцож



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

СЭХ
он 2022 сар 09 өдөр 21
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14
БҮРТГЭВ-03



гаргасан үржүүлэгч боломжит завсарт орших буй эсэхийг Үнэ/Өөрийн хөрөнгийн харьцаагаар шалгасан болно.

*Хүснэгт 31. Хүснэгт. Зах зээлийн хандлагаар тооцоолсон үр дүнгийн нягтлан шалгалт*

| Үзүүлэлт/хувилбарууд | Тооцоолсон үнэ цэнэ /сая.төг/ | | Үнэ/Өөрийн хөрөнгийн харьцаа: Тооцоолсон үржүүлэгч | |
|---|---|---|---|---|
| | Дотоод | Гадаад | Дотоод | Гадаад |
| Дундаж | 1,408,210 | 449,527 | 3.62 | 1.16 |
| Медиан | 825,490 | 449,527 | 2.12 | 1.16 |
| MAX | 2,777,487 | 484,765 | 7.15 | 1.25 |
| MIN | 621,652 | 414,290 | 1.60 | 1.07 |
| TOP 20: 6 компанийн харьцаа: Дундаж | | | 1.78 | |
| Медиан | | | 1.38 | |
| MAX | | | 4.22 | |
| MIN | | | 0.51 | |
| Гадаадын 38 банкны харьцаа: Дундаж | | | | 1.51 |
| Медиан | | | | 1.47 |
| MAX | | | | 4.65 |
| MIN | | | | 0.31 |

Зах зээлийн хандлага, жишиг компанийн аргаар бизнесийн үнэ цэнийг тооцоолсон үр дүнгийн хувилбаруудыг 2021 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаарх өөрийн хөрөнгийн дүнд харьцуулан дундаж, медиан, хамгийн их ба бага утгуудад үржүүлэгч хэдээр тооцогдсоныг харахад:

а) Дотоод мэдээлэл ашиглан тооцсон үнэ цэнийн тооцоололд үржүүлэгч [1.6:7.15] завсарт тооцогдсон байна. Шалгахдаа Монголын хөрөнгийн биржийн ТОП20 индексийг бүрдүүлэгч компаниудаас санхүү, хөрөнгийн зах зээл дээр үйлчилгээ эрхлэгч 6 компанийг сонгон Үнэ/Өөрийн хөрөнгийн харьцааг тооцон үзвэл [0.51:4.22] завсарт байна. Иймд бид үржүүлэгчийг [1.6:4.22] завсарт орших хувилбараас сонгох боломжтой.

б) Гадаад мэдээлэл ашиглан тооцсон үнэ цэнийн тооцоололд үржүүлэгч [1.13:1.25] завсарт тооцогдсон байна. Нягтлахдаа Гадаадын 3 орны 38 банкны Үнэ/Өөрийн хөрөнгийн харьцааг тооцон үзвэл [0.31:4.65] завсарт байна. Иймд бид үржүүлэгчийг [1.13:1.25] завсарт орших хувилбараас сонгох боломжтой.

Жишиг гадаадын компанийн үржүүлэгчийн мэдээллийг хавсралт 1-д оруулав.

Иймд бид жишиг компанийг харьцуулах аргаар бизнесийн үнэ цэнийг:

ТОП20 индексийг бүрдүүлэгч компаниудаас санхүү, хөрөнгийн зах зээл дээр үйлчилгээ эрхлэгч 6 компанийг сонгон Үнэ/Өөрийн хөрөнгийн харьцааны медиан утга 1.38-тай хамгийн ойр орших 1.6х үржүүлэгчид харгалзах үнэ цэнийн дүн нь 621,652 сая төгрөг бөгөөд энэ нь үнэ цэнийн хувилбаруудын хамгийн бага утгад харгалзаж байна.

Гадаадын улс орноос сонгосон 3 орны 38 банкны Үнэ/Өөрийн хөрөнгийн харьцааны медиан утга 1.47-тай хамгийн ойр орших 1.25х үржүүлэгчид харгалзах үнэ цэнийн дүн нь 484,765 сая төгрөг байна.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮЖЭЭСЕК ҮЦК ХХК

СЭХ
2022 .03. 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022 -03- 14
БҮРТГЭВ-03



*Хүснэгт 32. Үнэ цэнийн тооцооллын дүгнэлт*

| Үзүүлэлт/хувилбарууд | Тооцсон үнэ цэнэ /сая.төг/ | |
|---|---|---|
| | Дотоод | Гадаад |
| Дундаж | 1,408,210 | 372,102 |
| Медиан | 825,490 | 414,290 |
| MAX | 2,777,487 | 484,765 |
| MIN | 621,652 | 217,251 |
| **Сонгосон утга** | **621,652** | **484,765** |
| **Бизнесийн 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ /сая.төг/** | **621,652** | **484,765** |

**Зах зээлийн хандлагаарх "жишиг компанийн арга"-аар** Төрийн банк ХХК-ийн өмчийн үнэ цэнийг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 621,652.0 сая төгрөгөөс 484,765.0 сая төгрөгийн хооронд байх боломжтойг тодорхойлов.

## 4.2 Бизнесийн орлогын хандлагаарх үнэлгээ

Бизнесийн үнэлгээний орлогын хандлагаарх аргуудаас хорогдуулсан мөнгөн урсгалын арга нь тооцоолол шаарддаг нарийн төвөгтэй аргын нэг юм. Энэ аргын давуу тал нь тухайн банкны бизнесийг сонирхож буй худалдан авагчийн ирээдүйн жил тутам олох орлогын өнөөгийн үнэ цэнийн нийлбэрийг тооцдогт оршино. Тиймээс ч худалдан авагч банкны бизнесээс орж ирэх орлого болон өгөөжийг сонирхох, өөрөөр хэлбэл банкны бизнесийн зах зээлийн үнэ нь хөрөнгийн ашиглалтаас ирээдүйд гарах үр ашгийн өнөөгийн үнэ цэнэтэй тэнцүү байна гэсэн үг юм. Үнэлгээчин хорогдуулсан мөнгөн урсгалын аргаар бизнесийн үнэлгээг тооцохдоо тооцоолол их шаарддаг байдлыг харгалзан үзэж "DCF model" загварыг ашиглалаа.

Энэхүү аргаар үнэлгээг тооцоолоход дараах 2 хүчин зүйлээс хамаарч бизнесийн үнэ цэнэ хир зэрэг үнэн бодитой гарах эсэх нь шалтгаална. Үүнд:

- Ирээдүйн мөнгөн урсгалын төсөөлөл болон төсөөлж буй хугацааны эцэст үлдэх өртөг буюу Терминал үнэ
- Хорогдуулалтын хувийг оновчтой тооцоолол

Бизнесийн үнэлгээний Орлогын хандлагын үнэлгээнд доорх төсөөллийг хийсэн болно. Үүнд:

- Жишиг компанийн хүрээнд сонгон авсан компаниудын татварын үзүүлэлт болон банкны ирээдүйн хугацаанд төлөвлөсөн татварын үзүүлэлтийг банкны 2021 оны санхүүгийн тайлангийн татварын үзүүлэлт болох 25.02 хувь байхаар төсөөлсөн,
- Жишиг компанийн хүрээнд сонгон авсан компаниудын хувьцааны үнийн сүүлийн хагас жилийн мэдээлэл нь үнэлгээний өдрөөрх зах зээлийн нөхцөлийг төлөөлөх боломжтой гэж төсөөлсөн,
- Том компани болон жижиг компанийн өгөөжийн өөрчлөлт болох тоон хэмжээний шагналыг Монголын хөрөнгийн зах зээлийн хүрээнд "тухайн тохиолдол"-д тооцох боломжтой гэж төсөөлсөн,
- Банкны 2022-2026 оны санхүүгийн мөнгөн урсгалын төлөвлөлтөнд элэгдэл, хорогдуулалтын зардал болон капитал зарцуулалтын зардлыг үйлчилгээний салбарын байгууллагуудын нийтлэг үзүүлэлт болох нийт борлуулалтын орлогын 2 хувь байхаар төсөөлсөн,



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДЕСК ҮЦК ХХК

СЭХ
он 2022 сар 09 өдөр 21
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ-03



- Банкны санхүүгийн мөнгөн урсгалын төлөвлөлтөнд татвар, хүү, элэгдэл, хорогдуулалтын өмнөх ашгийн үзүүлэлтийг үйлчилгээний байгууллагуудын нийтлэг үзүүлэлт болох нийт борлуулалтын орлогын 16 хувь байхаар төсөөлсөн.

Бид үнэлж байгаа зүйл /өмчийн үнэ, цэнийн үнэлгээ/-тэй уялдуулан хорогдуулах хувийг тооцохдоо Хөрөнгийн үнэлгээний загвар (CAPM)-ыг сонгосон болно.

Прогнозын хугацааг Төрийн банк ХХК – ийн боловсруулж ирүүлсэн дунд хугацааны бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөлөлд тулгуурлан 2022 оныг суурь он болгон 2022 – 2026 оноор авсан.

Хорогдуулалтын хувь /CAPM/-ийг тооцохдоо эрсдэлгүй хүүгийн түвшинг тухайн үеийн Монгол банкны бодлогын хүү 6.0%-иар, вета коэффициентийг олон улсын зах зээлийн https://www.stern.nyu.edu/~adamodar/New_Home_Page/datafile/variable.htm сайтад тусгагдсан банкны салбарт харгалзах утга "0.82"-оор "Төрийн банк" ХХК - ийн хувьд тооцогдсон. Банкны терминал буюу сүүлчийн жилээс цаашид өсөх өсөлтийг 6 хувь буюу УИХ-ын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 тоот тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын баримт бичигт манай орны эдийн засгийн өсөлтийг 6 хувиар тодорхойлсныг үндэслэл болгон олон улсын байгууллагуудын өгч буй мэдээлэл, хандлага зэргийг судлан 1%-иар буурлан 5.0%-иар тооцох нь зүйтэй гэж үзсэн болно.

*Хүснэгт 33. Эзэмшигчийн өмчийн өртөг*

| Эзэмшигчийн өмчийн өртөг\ CAPM | |
|---|---|
| Эрсдэлгүй хүүгийн түвшин (1) | 6.0% |
| Зах зээлийн эрсдэлийн шагнал (2) | 80% |
| Хөшүүрэгдсэн вета (3) | 0.82 |
| Тоон хэмжээний шагнал (4) | 3.8% |
| **Эзний өмчийн зардал** | **16.3%** |
| **Хөрөнгийн оруулагчийн шаардагдаж байгаа өгөөжийн түвшин\ CAPM** | **16.32535%** |

*Эх үүсвэр: МОТ тооцоолол*

*Тайлбар:*

1. Үнэлгээчин зах зээлийн өгөөжийн түвшинг Монголын хөрөнгийн биржийн сүүлийн 10 жилийн TOP20 индексийн өгөөж Erm = 13.98 хувиар, зах зээлийн эрсдэлийн шагналыг 8.0 хувиар тооцсон.
2. Монгол улсын хөрөнгийн зах зээл дээрх 10 сая төгрөгөөс доошгүй зах зээлийн үнэлгээтэй, сүүлийн жилд 5 сая төгрөгөөс доошгүй борлуулалтын орлоготой эсвэл 1 сая төгрөгөөс доошгүй цэвэр ашигтай I ангилалын болон 1 сая төгрөгөөс доошгүй зах зээлийн үнэлгээтэй, 100 сая төгрөгөөс доошгүй ашигтай II ангилалын компанийг сонгон тоон хэмжээний шагналыг 3.8 тооцсон. Судалгаанд хөрөнгийн зах зээлийн TOP20 индексэд хамааргдаж байгаа компаниудыг хамааруулсан өмчийн харьцааг тооцон гаргасан. Мөн татварын хувь хэмжээг 25.02% -иар тооцсон.

Дээрх тооцоололд банкны санхүүгийн тайлангийн шинжилгээнээс өр төлбөрийн болон эзэмшигчийн өмчийн харьцааг авсан бөгөөд татварын хувь хэмжээг 25.02%-иар тооцсон.

"Төрийн банк" ХХК - ийн орлогын хандлагаарх үнэлгээг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2012 оны 122 тоот тушаалаар батлагдсан "Аудит, үнэлгээ эрхзүйн дүгнэлт гаргах



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469
УЛААНБААТАР ХОТ
УЦК ХХК

СЗХ 2022 сар 09 21 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 2022-09-14 БҮРТГЭВ-03

**болон тайланг хянахад мөрдөгдөх заавар"-ын 3.1.4-т "Бизнесийн үнэлгээг хөрөнгө оруулалт хийхээс өмнөх болон хийсний дараах 2 үеэр хийж ирүүлэх" гэж заасны дагуу 2 хувилбараар тооцсон.**

### 4.2.1 Бизнесийн үнэлгээ "Post Money" буюу хөрөнгө оруулалт хийсний дараах төсөөллөөр тооцсон тооцоолол

**2022-2026 онуудын хоорондох борлуулалтын прогнозыг тооцохдоо банкны түүхэн тайлан баланс, компанийн өөрсдийн боловсруулсан дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд тулгуурласан бөгөөд 2026 оноос хойших компанийн зах зээлийн өсөлтийг манай орны макро эдийн засгийн төсөөлсөн өсөлтийн хувийг үндэслэл болгон 5%-иар байхаар тооцсон. Санхүүгийн төлөвлөлт дэх борлуулалтын дундаж өсөлтийн хувийг 2022-2026 онд 20.12 хувиар тооцсон. Өсөлтийн борлуулалтын орлогын өсөлтийг тооцсон тооцооллыг доорх хүснэгтэд харуулав.**

*Хүснэгт 34. Борлуулалтын орлогын өсөлтийн төсөөлөл*

| Он | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025-2026 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Борлуулалтын орлогын дүн, сая төг | 357,509.5 | 408,085.9 | 407,668.9 | 418,534.1 | 608,586.04 | 698,816.1 | 742,332.4 | |
| Өсөлтийн хувь, % | | *14.15%* | *-0.10%* | *2.67%* | *45.41%* | *14.83%* | *6.23%* | |
| Цаашдын өсөлтийн төсөөлөл, % | | 14.15% | - | - | 45.41% | 14.83% | 6.23% | 20.15% |

***Тайлбар:***

1. **Дээрх хүснэгтэд 2018-2021 онуудын өгөгдөл нь Төрийн банкны санхүүгийн тайлангийн мэдээлэл, 2022-2024 онуудад хамаарах мэдээлэл нь тус банкны дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан, IPO хийсний дараах байдлаар төсөөлсөн дүнгүүд болно.**
2. **Үнэлгээчин Төрийн банкны 2019 – 2024 оны хоорондох борлуулалтын өсөлтийн дундаж хувь буюу 20.15%-иар 2025-2026 онуудын борлуулалтын орлогын төсөөллийг хийсэн болно. Энэ тооцоололд КОВИД-ын үе буюу 2020-2021 оны өгөгдлийг оруулж тооцоогүй болно.**

**Бизнесийн үнэлгээг хөрөнгө оруулалт хийсний дараах үеэр буюу "Post Money" төсөөллөөр тооцсон тооцооллыг доорх тооцооллуудад харуулав.**



УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК 5341469 ГТ5362

УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр 2022 09 21
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14



*Хүснэгт 35. "Төрийн банк" ХХК-ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх бизнесийн үнэлгээний тооцоолол I /сая төг/*

| Үзүүлэлт | Гүйцэтгэл | | | | CAGR (2018 - 2021) | Төсөв | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2018 | 2019 | 2020 | 2021 | | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 |
| Борлуулалт | 357,509.0 | 408,085.0 | 407,668.0 | 418,534.0 | *5%* | 608,586.0 | 698,816.1 | 742,332.4 | 891,929.4 | 1,071,673.5 |
| *өсөлтийн хувь* | | *14.1%* | *-0.1%* | *2.7%* | | **45.4%** | **14.8%** | **6.2%** | **20.2%** | **20.2%** |
| Нийт зардал | - 355,506.0 | - 385,402.0 | - 368,419.0 | - 357,519.0 | *0.2%* | - 511,212.3 | - 587,005.5 | - 623,559.2 | - 749,220.7 | -900,205.8 |
| *борлуулалтанд эзлэх хувь* | *99.4%* | *94.4%* | *90.4%* | *85.4%* | | 84.0% | 84.0% | 84.0% | 84.0% | 84.0% |
| **Татвар, хүү, элэгдэл болон хорогдуулалтын өмнөх ашиг\EBITDA** | **2,003.0** | **22,683.0** | **39,249.0** | **61,015.0** | *212%* | **97,373.8** | **111,810.6** | **118,773.2** | **142,708.7** | **171,467.8** |
| *ашгийн хувь* | *0.6%* | *5.6%* | *9.6%* | *14.6%* | | ***16.0%*** | ***16.0%*** | ***16.0%*** | ***16.0%*** | ***16.0%*** |
| Элэгдэл & Хорогдол | -7,869.0 | -10,000.0 | -16,202.0 | -17,214.0 | | -12171.7 | -13976.3 | -14846.6 | -17838.6 | -21433.5 |
| *борлуулалтанд эзлэх хувь* | 2.2% | 2.5% | 4.0% | 4.1% | | **2.0%** | **2.0%** | **2.0%** | **2.0%** | **2.0%** |
| **Татвар хүүгийн өмнөх ашиг\ EBIT** | **-5,866.0** | **12,683.0** | **23,047.0** | **43,801.0** | *-295%* | **85,202.0** | **97,834.3** | **103,926.5** | **124,870.1** | **150,034.3** |
| Татвар (25.02%) | 0.0 | -2,411.0 | -8,637.0 | -15,267.0 | | -21,317.6 | -24,478.1 | -26,002.4 | -31,242.5 | -37,538.6 |
| Капиталын зарцуулалт | 0.0 | -20,138.0 | -25,378.0 | -14,908.0 | | -12,171.7 | -13,976.3 | -14,846.6 | -17,838.6 | -21,433.5 |
| *борлуулалтанд эзлэх хувь* | | *4.9%* | *6.2%* | *3.6%* | | ***2.0%*** | ***2.0%*** | ***2.0%*** | ***2.0%*** | ***2.0%*** |
| **Цэвэр ажлын капиталын өсөлт бууралт** | | **150,217.9** | **-92,193.8** | **13,460.1** | | **-41,343.3** | **-19,579.9** | **-9,443.0** | **-32,462.5** | **-39,004.5** |
| **Төсөвлөөгүй чөлөөт мөнгөн урсгал** | | **150,351.9** | **-86,959.8** | **44,300.1** | | **22,541.2** | **53,776.2** | **68,481.1** | **61,165.1** | **73,491.2** |





Мөнгөн урсгалын хүрээнд цэвэр ажлын капиталын тооцоололд нийт эргэлтийн капитал болон эргэлтийн өр төлбөрийн тооцох утганд банкны салбарын онцлогыг харгалзан борлуулалтын орлогоос дунджаар 2 дахин нэмэгдүүлэн авсан. Тиймээс ч цэвэр ажлын капиталыг нийт борлуулалтын орлогын 22%-иар хангаж ажиллахаар тооцсон.

*Хүснэгт 36. "Төрийн банк" ХХК-ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх цэвэр ажлын капиталын тооцоолол I /сая төг/*

| Цэвэр ажлын капитал | Гүйцэтгэл | | | | Төсөв | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 |
| Дансны авлага | | | | | | | | | |
| Бараа материал | | | | | | | | | |
| Урьдчилж төлсөн зардал ба бусад | | | | | | | | | |
| **Нийт эргэлтийн хөрөнгө** | **731,781.0** | **856,955.0** | **1,193,591.0** | **1,201,030.0** | **1,746,641.9** | **2,005,602.3** | **2,130,494.0** | **2,559,837.3** | **3,075,703.0** |
| *борлуулалтанд эзлэх хувь* | 204.7% | 210.0% | 292.8% | 287.0% | **287.0%** | **287.0%** | **287.0%** | **287.0%** | **287.0%** |
| Дансны өглөг | | | | | | | | | |
| Хуримтлагдсан өглөг | | | | | | | | | |
| Богино хугацаат өглөг | | | | | | | | | |
| **Нийт богино хугацаат өр төлбөр** | **-569,579.0** | **-844,971.0** | **-1,089,414.0** | **-1,110,313.0** | -1,614,578.8 | -1,853,959.2 | -1,969,407.9 | -2,366,288.6 | -2,843,149.9 |
| *борлуулалтанд эзлэх хувь* | 159.3% | 207.1% | 267.2% | 265.3% | **265.3%** | **265.3%** | **265.3%** | **265.3%** | **265.3%** |
| **Цэвэр ажлын капитал** | **162,204.0** | **11,986.1** | **104,179.9** | **90,719.9** | **132,063.2** | **151,643.1** | **161,086.1** | **193,548.7** | **232,553.2** |
| *борлуулалтанд эзлэх хувь* | *45%* | *3%* | *26%* | *22%* | *22%* | *22%* | *22%* | *22%* | *22%* |

*Хүснэгт 37. "Төрийн банк" ХХК - ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх чөлөөт мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн тооцоолол I /сая төг/*

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Төсөвлөөгүй чөлөөт мөнгөн урсгал** | | **150,351.9** | **-86,959.8** | **44,300.1** | | **22,541.2** | **53,776.2** | **68,481.1** | **61,165.1** | **73,491.2** |
| **Эзэмшигчийн өмчийн зардал\ CAPM** | **16.32535%** | | | | | | | | | |
| **Хөнгөлөлтийн үе** | | | | | | 0.5 | 1.5 | 2.5 | 3.5 | 4.5 |
| **Хөнгөлөлтийн хүчин зүйл** | | | | | | 0.93 | 0.80 | 0.69 | 0.59 | 0.51 |
| **Чөлөөт мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ** | | | | | | **20,899.7** | **42,862.6** | **46,922.9** | **36,028.3** | **37,213.5** |

**Жич: Дээрх тооцооллоор 2022 оны 22,541.2 сая төгрөгийн мөнгөн урсгал өнөөгийн үнэ цэнээр тооцоход 20,899.7 сая төгрөг болж байна.**



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
2022.09.21
№ 01
2022-09-14
БҮРТГЭВ-03



*Хүснэгт 38. "Төрийн банк" ХХК - ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх бизнесийн үнэлгээний эцсийн хугацааны терминал үнийн өнөөгийн үнэ цэнийн тооцоолол I /сая.төг/*

| Терминал үнэ цэнэ | |
|---|---|
| Эцсийн жилийн чөлөөт мөнгөн урсгал | 73,491.2 |
| Хугацаагүй өсөлтийн түвшин | 5.0% |
| эцсийн жилийн EBITDA | 171,468 |
| эцсийн үнэ цэнэ | 681,355 |
| **Нийлмэл үеүдийн таамаглал** | **4.3x** |
| хөнгөлөлтийн үе | 5.0 |
| хөнгөлөлтийн хүчин зүйл | 0.47 |
| **Эцсийн үнэ цэнийн өнөөгийн үнэ цэнэ** | **319,891** |

*Хүснэгт 39. "Төрийн банк" ХХК - ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх үнэ цэнийн тооцоо I /сая.төг/*

| Эздийн өмчийн үнэ цэнэ | |
|---|---|
| Чөлөөт мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ | 183,927 |
| **Терминал үнэ цэнэ** | 681,355 |
| хөнгөлөлтийн хүчин зүйл | 0.47 |
| **Терминал үнэ цэнийн өнөөгийн үнэ цэнэ** | **319,891** |
| **Эздийн өмчийн үнэ цэнэ** | **503,818** |

Дээрх тооцооллоор "Төрийн банк" ХХК - ийн орлогын хандлагаарх бизнесийн үнэ цэнэ нь "Post Money" төсөөллөөр 503,818 сая төгрөг болж байна.

Хорогдуулсан мөнгөн урсгалын тооцооллоор дан ганц үр дүн гаргах, түүндээ үнэлгээчний зүгээс хэт их итгэл өгөх нь зохимжгүй байдаг тул боломжит янз бүрийн хувилбаруудыг судалж үзэхийг холбогдох ҮОУС-д зөвлөсөн байдаг. Иймд үнэлгээнд сонгон авсан гол гол хүчин зүйлээс хамаарч үнэ хэрхэн өөрчлөгдөхийг мэдрэмжийн шинжилгээгээр тооцлоо. Мэдрэмжийн шинжилгээ нь хугацаагүй өсөлтийн хувь болон хорогдуулгын хувь, жилийн борлуулалтын өсөлт болон татвар хүү, элэгдэл хорогдлын өмнөх ашгийн түвшингээс хамаарч 2 янзаар хийгддэг. Энэ нь үнэлгээчинд үндэслэлтэй үнэ, цэнийг сонгох боломжийг олгож байдаг.

*Хүснэгт 40. "Төрийн банк" ХХК - ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх бизнесийн үнэлгээний үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ I /сая.төг/*

| | | Хугацаагүй өсөлтийн % | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 4.0% | 4.5% | 5.0% | 5.5% | 6.0% |
| САРМ | 14.9% | 540,177 | 558,775 | 579,252 | 601,906 | 627,107 |
| | 15.9% | 492,834 | 507,846 | 524,234 | 542,198 | 561,977 |
| | 16.3% | 475,064 | 488,833 | 503,818 | 520,186 | 538,140 |
| | 17.3% | 437,835 | 449,182 | 461,450 | 474,755 | 489,235 |
| | 18.3% | 405,900 | 415,365 | 425,540 | 436,508 | 448,367 |

Үнэлгээчин хугацаагүй өсөлтийн түвшинг 5 хувиас 4 хувь болгон тооцвол бизнесийн үнэ цэнэ буурч 475,064 сая төгрөг болж байна. Мөн хорогдуулах хүүний түвшинг 16.3 хувиас 15.9 хувьд шилжүүлхэд бизнесийн үнэ цэнэ 524,234 сая төгрөг болох боломжтой байна.



УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК

*Хүснэгт 41. “Төрийн банк” ХХК - ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх бизнесийн үнэлгээний үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ I /сая.төг/*

| | | Жилийн борлуулалтын өсөлт % | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 19.2% | 19.7% | 20.2% | 20.7% | 21.2% |
| EBITDA % | 14.0% | 393,407 | 393,407 | 393,407 | 393,407 | 393,407 |
| | 15.0% | 448,612 | 448,612 | 448,612 | 448,612 | 448,612 |
| | 16.0% | 503,818 | 503,818 | 503,818 | 503,818 | 503,818 |
| | 17.0% | 559,023 | 559,023 | 559,023 | 559,023 | 559,023 |
| | 18.0% | 614,228 | 614,228 | 614,228 | 614,228 | 614,228 |

Жилийн борлуулалтын өсөлтийн өөрчлөлтөөс хамааран бизнесийн үнэ цэнийг янз бүрээр өөрчлөн тооцсон байдаг. Мөн элэгдэл хорогдол, татвар, хүүгийн өмнөх ашиг EBITDA-г 18 хувиар тооцоход бизнесийн үнэ цэнийн дүн 614,228 сая төгрөгөөр тооцогдох боломжтой байна.

“Төрийн банк” ХХК - ийн “100.0%-ийн эздийн өмчийн үнэ, цэнэ”-ийг орлогын хандлагаар, “Post Money” буюу хөрөнгө оруулалт хийсний дараах төсөөллөөр тооцоход **503,818.0 сая төгрөг /таван зуун гурван тэрбум найман зуун арван найман сая/** гарч байна.

СЭХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА
2022-09-14



**4.2.2 Бизнесийн үнэлгээг "Pre Money" буюу хөрөнгө оруулалт хийхээс өмнөх үеийн төсөөллөөр тооцсон тооцоолол**

"Төрийн банк" ХХК - ийн орлогын хандлагаарх үнэлгээг хөрөнгө оруулалт хийхээс өмнөх үе буюу өнгөрсөн 2018-2021 оны орлогын өсөлтийн түвшингээр тооцсон 2 дахь хувилбарын тооцооллыг доорх байдлаар хийв. 2022-2026 он хүртэлх борлуулалтын прогнозыг тооцон гаргахдаа юуны өмнө байгууллагын тайлан балансад тулгуурлан, компанийн боловсруулж прүүлсэн дунд хугацааны бизнес төлөвлөгөө, цаашид баримтлах зорилго, стратегийн хүрээнд (2027 оноос хойших компанийн зах зээлийн өсөлтийг 5%-иар байхаар) боловсруулсан төслийн материалтай уялдуулан хийж гүйцэтгэлээ. Санхүүгийн тайлангийн шинжилгээний хүрээнд борлуулалтын орлогын өсөлтийн түвшинг 2022-2026 онд 14.15 хувь байхаар тооцсон.

*Хүснэгт 42. "Төрийн банк" ХХК - ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх бизнесийн үнэлгээний тооцоолол II /сая төг/*

| Үзүүлэлт | Гүйцэтгэл | | | | CAGR | Төсөө | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2018 | 2019 | 2020 | 2021 | (18 - 21) | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 |
| Борлуулалт | 357,509 | 408,085 | 407,668 | 418,534 | 5% | 477,757 | 545,359 | 622,527 | 710,615 | 811,167 |
| *өсөлтийн хувь* | | *14.1%* | *-0.1%* | *2.7%* | | 14.2% | 14.2% | 14.2% | 14.2% | 14.2% |
| Нийт зардал | -355,506 | -385,402 | -368,419 | -357,519 | 0.2% | -401,316 | -458,102 | -522,923 | -596,917 | -681,380 |
| *борлуулалтанд эзлэх хувь* | *99.4%* | *94.4%* | *90.4%* | *85.4%* | | 84.0% | 84.0% | 84.0% | 84.0% | 84.0% |
| **Татвар, хүү, элэгдлийн өмнөх ашиг\ EBITDA** | **2,003** | **22,683** | **39,249** | **61,015** | *212%* | **76,441** | **87,257** | **99,604** | **113,698** | **129,787** |
| *ашгийн хувь* | *0.6%* | *5.6%* | *9.6%* | *14.6%* | | *16.0%* | *16.0%* | *16.0%* | *16.0%* | *16.0%* |
| Элэгдэл & Хорогдол: | -7,869 | -10,000 | -16,202 | -17,214 | | -9,555 | -10,907 | -12,451 | -14,212 | -16,223 |
| *борлуулалтанд эзлэх хувь* | 2.2% | 2.5% | 4.0% | 4.1% | | 2.0% | 2.0% | 2.0% | 2.0% | 2.0% |
| **Татвар хүүгийн өмнөх ашиг\ EBIT** | -5,866 | 12,683 | 23,047 | 4,801 | -295% | 66,886 | 76,350 | 87,154 | 99,486 | 113,563 |
| Татвар (25.02%) | 0.0 | -2.4 | -8.6 | -15.3 | | -16.7 | -19.1 | -21.8 | -24.9 | -28.4 |
| Капиталын зарцуулалт | 0.0 | -20,138 | -25,378 | -14,908 | | -9,555 | -10,907 | -12,451 | -14,212 | -16,223 |
| *борлуулалтанд эзлэх хувь* | | *4.9%* | *6.2%* | *3.6%* | | *2.0%* | *2.0%* | *2.0%* | *2.0%* | *2.0%* |
| Цэвэр ажлын капиталын өсөлт бууралт | | 150,165 | -93,021 | 13,518 | | -10,087 | -14,670 | -16,746 | -19,115 | -21,820 |
| **Төсөвлөөгүй чөлөөт мөнгөн урсгал** | | **150,299** | **-87,787** | **44,358** | | **40,064** | **42,578** | **48,602** | **55,480** | **63,330** |





2-р хувилбарын тооцоололд мөн мөнгөн урсгалын хүрээнд цэвэр ажлын капиталын тооцоололд нийт эргэлтийн капитал болон эргэлтийн өр төлбөрийг тооцох утгыг банкны салбарын онцлогыг харгалзан борлуулалтын орлогоос дунджаар 2 дахин нэмэгдүүлэн авч тооцсон.

*Хүснэгт 43. "Төрийн банк" ХХК - ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх цэвэр ажлын капиталын тооцоолол II /сая төг/*

| Цэвэр ажлын капитал | Гүйцэтгэл | | | | Төсөө | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 |
| Бэлэн мөнгө ба Монголбанк дах харилцах | | | | | | | | | |
| Бусад банк ба байгууллагын харилцах, хадгаламж | | | | | | | | | |
| Урьдчилж төлсөн зардал ба бусад | | | | | | | | | |
| **Нийт эргэлтийн хөрөнгө** | 731,781 | **856,955** | **1,193,591** | 1,201,030 | **1,371,161** | **1,565,181** | **1,786,654** | **2,039,465** | **2,328,050** |
| *борлуулалтанд эзлэх хувь* | 204.7% | 210.0% | 292.8% | 287.0% | **287.0%** | **287.0%** | **287.0%** | **287.0%** | **287.0%** |
| Өр төлбөр | | | | | | | | | |
| Бусад банк ба байгууллагын харилцах, хадгаламж | | | | | | | | | |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | | | | | | | | | |
| **Нийт богино хугацаат өр төлбөр** | -569,579 | -844,971 | -1,089,414 | -1,110,313 | -1,267,488 | -1,446,838 | -1,651,565 | -1,885,262 | -2,152,026 |
| *борлуулалтанд эзлэх хувь* | 159.3% | 207.1% | 267.2% | 265.3% | 265.3% | 265.3% | 265.3% | 265.3% | 265.3% |
| **Цэвэр ажлын капитал** | **164,249** | **14,084** | **107,105** | **93,587** | **103,673** | **118,343** | **135,088** | **154,203** | **176,023** |
| *борлуулалтанд эзлэх хувь* | *46%* | *3%* | *26%* | *22%* | *22%* | *22%* | *22%* | *22%* | *22%* |

*Хүснэгт 44. "Төрийн банк" ХХК - ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх чөлөөт мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн тооцоолол II /сая төг/*

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Төсөвлөөгүй чөлөөт мөнгөн урсгал** | | **172,878.4** | **-52,978.8** | **74,444.9** | **37,197.8** | **42,577.7** | **48,602.4** | **55,479.7** | **63,330.0** |
| Эзэмшигчийн өмчийн зардал\ CAPM | 16.32535% | | | | | | | | |
| Хөнгөлөлтийн үе | | | | | 0.5 | 1.5 | 2.5 | 3.5 | 4.5 |
| Хөнгөлөлтийн хүчин зүйл | | | | | 0.93 | 0.80 | 0.69 | 0.59 | 0.51 |
| **Чөлөөт мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ** | | | | | **34,488.9** | **33,936.8** | **33,302.1** | **32,679.4** | **32,068.2** |

Жич: Дээрх тооцооллоос 2026 оны 63,330 сая төгрөгийн мөнгөн урсгал өнөөгийн үнэ цэнээр тооцоход 32,068.2 сая төгрөг болж байна.



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ-03



*Хүснэгт 45. "Төрийн банк" ХХК - ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх бизнесийн үнэлгээний "терминал үнэ, цэнэ"-ийн тооцоолол II /сая төг/*

| Терминал үнэ цэнэ | |
|---|---|
| Прогнозын сүүлчийн жилийн чөлөөт мөнгөн урсгал | 63,330.0 |
| Хугацаагүй өсөлтийн түвшин | 5.0% |
| Прогнозын сүүлчийн жилийн EBITDA | 129,787 |
| Терминал үнэ цэнэ | 587,148 |
| **Нийлмэл үеүүдийн таамаглал** | **4.9x** |
| хөнгөлөлтийн үе | 5.0 |
| хөнгөлөлтийн хүчин зүйл | 0.47 |
| **Терминал үнэ цэнийн өнөөгийн үнэ цэнэ** | **275,661** |

*Хүснэгт 46. "Төрийн банк"ХХК - ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх үнэ цэнийн дүн, II /сая төг/*

| Эздийн өмчийн үнэ цэнэ | |
|---|---|
| Чөлөөт мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ | 166,475 |
| **Терминал үнэ цэнэ** | 587,148 |
| хөнгөлөлтийн хүчин зүйл | 0.47 |
| **Терминал үнэ цэнийн өнөөгийн үнэ цэнэ** | **275,661** |
| **Эздийн өмчийн үнэ цэнэ** | **442,137** |

Дээрх тооцооллоор "Төрийн банк" ХХК - ийн орлогын хандлагаарх бизнесийн үнэ цэнэ нь "Pre Money" төсөөллөөр 442,137.0 сая төгрөг болж байна.

## Мэдрэмжийн шинжилгээ

Хорогдуулсан мөнгөн урсгалын тооцооллоор дан ганц үр дүн гаргах, түүндээ үнэлгээчний зүгээс хэт их итгэл өгөх нь зохимжгүй байдаг тул боломжит янз бүрийн хувилбаруудыг судалж үзэхийг холбогдох ҮОУС-д зөвлөсөн байдаг. Иймд үнэлгээнд сонгон авсан гол гол хүчин зүйлээс хамаарч үнэ хэрхэн өөрчлөгдөхийг мэдрэмжийн шинжилгээгээр тооцлоо. Мэдрэмжийн шинжилгээ нь хугацаагүй өсөлтийн хувь болон хорогдуулгын хувь, жилийн борлуулалтын өсөлт болон татвар хүү, элэгдэл хорогдлын өмнөх ашгийн түвшингөөс хамаарч 2 янзаар хийгддэг. Энэ нь үнэлгээчинд үндэслэлтэй үнэ, цэнийг сонгох боломжийг олгож байдаг.

*Хүснэгт 47. "Төрийн банк" ХХК – ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх бизнесийн үнэлгээний үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ II /сая.төг/*

| | | Хугацаагүй өсөлтийн % | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | **4.0%** | **4.5%** | **5.0%** | **5.5%** | **6.0%** |
| САРМ | **14.3%** | 500,401 | 518,672 | 538,902 | 561,424 | 586,652 |
| | **15.3%** | 455,147 | 469,748 | 485,764 | 503,409 | 522,946 |
| | **16.3%** | 417,359 | 429,224 | 442,137 | 456,242 | 471,714 |
| | **17.3%** | 385,348 | 395,126 | 405,698 | 417,163 | 429,641 |
| | **18.3%** | 357,896 | 366,053 | 374,821 | 384,273 | 394,492 |



УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

СЭХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Үнэлгээчин хугацаагүй өсөлтийн түвшинг 5 хувиас 4 хувь болгон тооцвол бизнесийн үнэ цэнэ буурч 417,359 сая төгрөгөөр тооцогдохоор байна. Мөн хорогдуулах хүүний түвшинг 16.3 хувиас 15.3 хувьд шилжүүлэхэд бизнесийн үнэ цэнэ 485,764 сая төгрөг болох боломжтой байна.

*Хүснэгт 48. "Төрийн банк" ХХК-ийн хорогдуулсан мөнгөн урсгалын аргаарх бизнесийн үнэлгээний үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ II /сая.төг/*

| | | Жилийн борлуулалтын өсөлт % | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 13.2% | 13.7% | 14.2% | 14.7% | 15.2% |
| EBITDA % | **14.0%** | 353,325 | 355,273 | 357,194 | 359,087 | 360,951 |
| | **15.0%** | 394,247 | 396,963 | 399,665 | 402,352 | 405,023 |
| | **16.0%** | 435,168 | 438,653 | 442,137 | 445,617 | 449,094 |
| | **17.0%** | 476,090 | 480,344 | 484,608 | 488,882 | 493,165 |
| | **18.0%** | 517,011 | 522,034 | 527,079 | 532,147 | 537,237 |

Жилийн борлуулалтын өсөлтийн өөрчлөлтөөс хамааран бизнесийн үнэ цэнийг янз бүрээр өөрчлөн тооцсон байдаг. Мөн элэгдэл хорогдол, татвар, хүүгийн өмнөх ашиг EBITDA-г 18 хувиар тооцоход бизнесийн үнэ цэнийн дүн 527,079 сая төгрөгөөр тооцогдох боломжтой байна.

"Төрийн банк" ХХК - ийн "100.0%-ийн эздийн өмчийн үнэ, цэнэ"-ийг орлогын хандлагаар, "Pre Money" буюу хөрөнгө оруулалт хийхийн өмнөх /2-р/ төсөөллөөр, тооцоход **422,137.0 сая төгрөг /дөрвөн зуун хорин хоёр тэрбум нэг зуун гучин долоон сая/** гарч байна.

## 4.3 ӨРТГИЙН ХАНДЛАГА - ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНЭ

### 4.3.1 Өртгийн хандлагаарх цэвэр хөрөнгийн үнэлгээний арга зүй

Үнэлгээний зорилгоор Өртгийн хандлагын хүрээнд цэвэр хөрөнгийн тохируулгын аргыг ашигласан. Цэвэр хөрөнгийн тохируулах арга нь компанийн хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийн шинжилгээнд суурилдаг.

Энэ аргыг ашиглах нь их хэмжээний биет болон санхүүгийн хөрөнгөтэй аж ахуйн нэгжийг үнэлэхэд хамгийн сайн үр дүнг өгдөг.

Цэвэр хөрөнгийн үнэ цэнэ гэдэг нь үнэлгээний өдрөөр байгаа актив хөрөнгөөс өр төлбөрийг хассан зөрүүгээр гарсан зах зээлийн өртгийн үнэ цэнэ гэж ойлгоно.

**Цэвэр хөрөнгө = Актив хөрөнгө – Өр төлбөр**

Цэвэр хөрөнгийн үнэ цэнийг тооцоолох арга зам нь нягтлан бодох бүртгэлийн балансад тусгагдсан хөрөнгө, өр төлбөрийг судлах явдал юм.

Инфляци, зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлт, ашигласан нягтлан бодох бүртгэлийн арга болон бусад хүчин зүйлээс шалтгаалсан дансны үнэ нь тухайн өдрийн зах зээлийн үнээс ялгаатай байж болзошгүй тул балансын зүйлүүдийг тухайн үеийн зах зээлийн үнэд нийцэж байгаа эсэхийг шинжилдэг.

Бие даасан тусдаа хөрөнгийг эсвэл бүлэг хөрөнгийн үнэлгээг хийхдээ тухайн үеийн зах зээлийн үнэ, элэгдлийн хамт бий болгох өртөг, эсвэл хөрөнгийн орлого, ашгийн шинжилгээг ашиглан үнэлдэг.



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК 5341469
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2022 оны 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ-03



### 4.3.2 Актив хөрөнгийн тодорхойлолт, мэдээлэл

#### Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг хуримтлуулан тооцсон хүүг нэмсэн дүнгээр санхүүгийн тайланд **толилуулсан** бөгөөд дараах хөрөнгөөс бүрдэж байна. Үүнд:

1. *Бэлэн мөнгө:*
   - Цаасан мөнгөн тэмдэгт
   - Цаасан мөнгөн тэмдэгт /ATM&ABM/
   - Замд яваа бэлэн мөнгө
2. *Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө /3 хүртэлх сарын хугацаатай/:*
   - Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, барьцаа, харилцахын хүү
3. *Мөнгөтэй адилтгах хөрөнгө:*
   - МБ-ны үнэт цаас /3 хүртэлх сарын хугацаатай/
   - МАҮЦ-ны хорогдуулаагүй хямдруулалт

Тайлант хугацаанд буюу 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн аудитлагдсан тайланд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн нийт дүнг **817,604.43 сая төгрөгөөр** толилуулсан байгааг хүлээн зөвшөөрч тохируулга хийх шаардлагагүй гэж дүгнэлээ.

#### Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө

Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөд:

- Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц
- Монголбанк болон бусад гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан гурван сараас дээш хугацаатай хадгаламж
- Гурван сараас дээш хугацаатай болон гурав хүртэлх сарын хугацаатай Монголбанк, Засгийн газрын үнэт цаасаар баталгаажаагүй урвуу репо үнэт цаас
- Хамтын зээлжүүлэлт хийх зорилгоор бусад байгууллагад байршуулсан мөнгө
- Гурван сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан мөнгө зэрэг багтана.

Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийг хуримтлуулан тооцсон хүүг нэмж, эрсдэлийн санг хассан дүнгээр санхүүгийн тайланд **толилуулсан** байна.

Тайлант хугацаанд банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөд Монголбанкинд байшуулсан төгрөг болон валютын харилцах дансны хөрөнгө, хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, эрсдэлийн сангийн хэмжээг тусган нийт **199,081.54 сая төгрөгөөр** толилуулсан байгааг хүлээн зөвшөөрч тохируулга хийх шаарлагагүй гэж дүгнэлээ.

#### Хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалтыг өрийн болон өмчийн үнэт цаасны зориулалтаас хамааран арилжааны, хугацааны эцэс хүртэл эзэмших, зээл ба авлага, борлуулахад бэлэн гэж ангилна. Өмчийн үнэт цаасны хувьд банкны эзэмшиж буй хувьцаа нь аж ахуйн нэгж байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн 20 хувиас их тохиолдолд дээрх байдлаар ангилахгүй ба харин охин компани, хараат болон хамтын хяналттай компанид оруулсан хөрөнгө оруулалтад бүртгэнэ. Банк санхүүгийн байгууллага болон аж ахуйн нэгжийн хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт нь охин, хараат компани, хамтын хяналттай компанийн аль болох эсэхийг банк СТОУС болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэлнэ.



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2022 он 09 сар 21 өдөр БҮРТГЭВ № 01

2022-09-14



Арилжааны үнэт цаасны ангилалд бодит үнэ цэнийн зөрүүг орлого, зардалд хүлээн зөвшөөрөх өрийн болон өмчийн үнэт цаасыг хамруулна.

Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасны ангилалд тодорхой тогтмол төлбөрийн хуваарьтай, тогтсон хугацаанд дуусгавар болох өрийн үнэт цаасыг банк хугацааг дуустал эзэмшихээр шийдвэрлэсэн бөгөөд ийм боломжоотой үнэт цаасыг хамруулна.

Зээл ба авлага үнэт цаасны ангилалд идэвхитэй зах зээл дээр жишиг үнэгүй өрийн үнэт цаасыг оруулна.

Борлуулахад бэлэн үнэт цаасны ангилалд дээрх гурван ангилалд ангилагдаагүй өрийн болон өмчийн үнэт цаасыг оруулна.

Тайлант хугацаанд хөрөнгө оруулалт хөрөнгөд нийт 10 гаруй байгууллагын болон Засгийн газрын үнэт цаас, хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, эрсдэлийн сангийн хэмжээг тусган нийт **385,834.39 сая төгрөгөөр** толилуулсан байгааг хүлээн зөвшөөрч тохируулга хийх шаардлагагүй гэж дүгнэлээ.

### Зээл /цэвэр дүнгээр/

Зээлийн бүтээгдэхүүнийг төрлөөр нь ангилна. Зээлийг зээлийн үлдэгдэл дээр хуримтлуулж тооцсон хүүгийн авлагыг нэмж, хойшлуулан бүртгэсэн шимтгэлийн орлого, эрсдэлийн санг хассан дүнгээр санхүүгийн тайланд **толилуулсан** байна. Банк зээлийн эрсдэлийн санг "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу тухай бүрдээ байгуулж байна.

Тайлант хугацаанд зээл /цэвэр дүнгээр/ болон зээлийн хойшлогдсон төлбөр, хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, зээлийн эрсдэлийн сангийн хэмжээг тусган нийт цэвэр дүнгээр **2,237,147.35 сая төгрөгөөр** толилуулсан байгааг бид зээлийн багцад шинжилгээг хийсний үр дүнд чанаргүй зээлийн ангилалд шилжсэн дүнгээр хасагдуулга хийж, чанаргүй зээлд байгуулсан эрсдэлийн сангийн дүнгээр нэмэгдүүлэх байдлаар активыг цэвэршүүлэн тохируулж тайлангийн дүнд залруулга хийсэн. *Хавсралтаар зээлийн багцын шинжилгээг оруулсан болно.*

### Дериватив санхүүгийн хөрөнгө

Гадаад валют, үнэт металлын арилжааны своп, форвард, опцион, фьючерс гэрээ, хейджийн хэрэгсэл, нуугдмал дериватив хэлцлээр үүссэн хөрөнгийг оруулна. Деривативыг бодит үнэ цэнээр үнэлж, санхүүгийн тайланд **толилуулж** байна.

Тайлант хугацаанд дериватив санхүүгийн хөрөнгөд своп арилжааны хүүгийн авлагыг **759.1 сая төгрөгөөр** толилуулсан байгааг хүлээн зөвшөөрч тохируулга хийх шаардлагагүй гэж дүгнэлээ.

### Бусад санхүүгийн хөрөнгө

Бусад санхүүгийн хөрөнгөд бусдаас мөнгө болон бусад санхүүгийн хөрөнгийг хүлээн авахаар зөвшөөрөгдсөн гэрээний эрхийг хамруулна. Үүнд: бусдаас авах авлага, банк, салбар хороондын тооцооны авлага, санхүүгийн хөрөнгийн хэлбэртэй өмчлөх бусад хөрөнгө болон бусад хөрөнгө хамрагдана.

Тайлант хугацаанд бусад санхүүгийн хөрөнгөд бусдаас авах авлага цэвэр дүнгээр **646.59 сая төгрөгөөр** толилуулсан байгааг хүлээн зөвшөөрч тохируулга хийх шаардлагагүй гэж



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК 5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ ТТБ5674 5208173

СЗХ
2022 .09. 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01
2022 -09- 14

дүгнэлээ.

### Бусад санхүүгийн бус хөрөнгө

Бусад санхүүгийн бус хөрөнгөд санхүүгийн хөрөнгийн тодорхойлолтыг хангаагүй хөрөнгүүд хамрагдана. Үүнд, урьдчилгаа, зах зээлийн хүүгээс доогуур хүүтэйгээр ажилтнуудад олгосон зээлийн урьдчилгаа, бараа материал үнэ бүхий зүйлс, үнэт металл, хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн хэлбэртэй өмчлөх бусад хөрөнгө, тайлант үеийн татварын авлага, хойшлогдсон татварын хөрөнгө, бусад санхүүгийн бус хөрөнгө хамрагдана.

Эрсдэлийн санг тооцох хөрөнгийн хувьд дансны үнийг гаргахдаа холбогдох эрсдэлийн сангхассан дүнгээр санхүүгийн тайланд **толилуулж** байна.

Тайланд хугацаанд бусад санхүүгийн бус хөрөнгөд бусад тооцоо, бараа материал, үнэ бүхий зүйл, өмчлөх бусад хөрөнгө /цэвэр дүнгээр/, татварын авлага, бусад хөрөнгө нийт **20,469.62 сая төгрөгөөр** толилуулсан байгаагаас бид бусад тооцоо, бараа материал, үнэ бүхий зүйл, татварын авлага, бусад хөрөнгийн дүнг хүлээн зөвшөөрч, харин өмчлөх бусад хөрөнгийн хувьд зах зээлийн үнэ ханшийн өөрчлөлтөөр дахин үнэлгээг хийж **дахин үнэлгээний дараах дүнгээр тохируулгыг хийх шаардлагатай** гэж дүгнэлээ.

Өмчлөх бусад хөрөнгийн хувьд банкны санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр 9,986.72 сая төгрөг байгаа хэдий ч бүртгэлийн дүнгээр 19,111.53 сая төгрөг байгаа нь өмчлөх бусад хөрөнгийн сангийн бууралтыг тооцож санхүүгийн байдлын тайланд тусгадагтай холбоотой юм. Иймд бид өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний үр дүнд гарсан өөрчлөлтийг санхүүгийн байдлын тайлангийн тохируулгад тусгахдаа байгуулсан сангийн хувь хэмжээгээр бууруулан цэвэр дүнгээр тохируулгыг хийнэ.

Өмчлөх бусад хөрөнгөд тайланд хугацаанд нийт 49 ширхэг хөрөнгө бүртгэлтэй ба үүнээс 3 хөрөнгийн хувьд мэдээлэл байхгүй тул үнэлээгүй, үлдэх 46 хөрөнгийг үнэлгээнд хамруулав.

*Хүснэгт 49. Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний үр дүн*

| Актив хөрөнгө | Бүртгэлийн дүн | Үнэлгээний дүн /2021.12.31/ сая.төг | | | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| | 12/31/2021 | Өртгийн хандлага | Зах зээлийн хандлага | Үнэлгээний үр дүн | БҮ/ҮД |
| Өмчлөх бусад хөрөнгө | 19,111.53 | 13,487.72 | 70,872.05 | **70,872.05** | 270.8% ↑ |
| Сангийн хэмжээ /ӨБХ/ | 52.3% | - | - | **52.3%** | - |
| Өмчлөх бусад хөрөнгө /цэвэр дүнгээр/ | 9,986.72 | | | **37,034.16** | 270.8% ↑ |

Өмчлөх бусад хөрөнгийн дахин үнэлгээний үр дүн 70,872.05 сая төгрөг болж үнэлэгдсэн бөгөөд бүртгэлд авсан үнээс 270.8 хувиар буюу 51,760.52 сая төгрөгөөр өссөн байгаа нь банк өмчлөх бусад хөрөнгөд хөрөнгө тооцож авахдаа тодорхой хэмжээний эрсдэлийг тооцоолон зах зээлийн үнэ ханшаас хэт багаар тооцож авдагтай холбоотой байна. Өмчлөх бусад хөрөнгийг зах зээлийн үнэ цэнээр санхүүгийн байдлын тайланд тохируулга хийхдээ **"цэвэр дүн"**-гээр буюу өмчлөх бусад хөрөнгөд байгуулсан **сангийн 52 хувиар бууруулан 37,034.16 сая төгрөгөөр залруулга** хийсэн болно. *Хавсралтаар өмчлөх бусад хөрөнгийн танилцуулга, үнэлгээний тооцооллыг оруулсан болно.*



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

СЭХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



**Үндсэн хөрөнгө**

Банкны үйл ажиллагаа, удирдлагын зориулалтаар ашиглах үүднээс банкны эзэмшилд байгаа, нэгээс дээш жилээр ашиглагдах барилга байгууламж, компьютер, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил зэрэг биет хөрөнгө үндсэн хөрөнгөд хамаарна. Үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн үеэс эхлэн хөрөнгийн элэгдлийг тооцоолно. Үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тайланд тусгасан.

Хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтаар анхны өртөгөө бүрэн нөхсөн хөрөнгийн хувьд хөрөнгийг данснаас хасах хүртэл нэмж элэгдэл тооцохгүй. Мөн агуулахад нөөцөлсөн хөрөнгийн хувьд ашиглалтанд тавьж олгох хүртэл элэгдэл тооцохгүй ба зөвхөн үнэ цэнийн бууралтыг үнэлж бүртгэнэ.

Банк салбар, нэгжийн барилга байгууламж барихтай холбоотой дуусаагүй барилга, үндсэн хөрөнгийн санхүүжилтэд холбогдох зардлыг бүртгэж байгаа харин түрээсийн хөрөнгийн хувьд үйл ажиллагаа явуулахаар бусдын эзэмшлийн объектыг түрээслэн ашиглаж байгаатай холбоотой зардлыг тусгасан байна.

Бид үндсэн хөрөнгөд бүртгэлтэй дуусаагүй барилга, үндсэн хөрөнгийн санхүүжилт, түрээсийн хөрөнгийн бүртгэлийн үнийг хүлээн зөвшөөрч, **тохируулга хийх шаардлагагүй** гэж дүгнэсэн. Харин үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгасан бусад хөрөнгийн хувьд үлдэх өртөг нь өнөөгийн зах зээлийн үнийг илэрхийлэхгүй тул бид үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт хөрөнгийг тайлант хугацаагаар дахин үнэлж, **дахин үнэлгээний дараах үр дүнгийн зөрүүгээр тохируулгыг тооцож тайланд залруулга хийсэн** болно. *Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ нь тусдаа бие даасан тайлан хэлбэрээр банкны бизнесийн үнэлгээний хүрээнд боловсруулагдсан. Хавсралтаар үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний үр дүнгийн товчоог оруулав.*

*Хүснэгт 50. Үндсэн хөрөнгийн үнэлгээний үр дүн*

| Бүлгийн нэр | Хөрөнгийн мэдээлэл | | Үнэлгээний дүн /2021.12.31/ сая.төг | | | Зөрүү |
|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Үлдэх өртөг | Өртгийн хандлага | Зах зээлийн хандлага | Үнэлгээний үр дүн | БҮ/ҮД |
| Барилга байгууламж-/190200/ | 193 | 78,611.48 | 59,353.21 | 99,958.77 | 99,958.77 | 27.2% ↑ |
| Компьютер-/190300/ | 32,303 | 9,719.57 | 20,621.29 | 17,997.93 | 26,153.91 | 169.1% ↑ |
| Тээврийн хэрэгсэл-/190301/ | 156 | 2,610.06 | 3,549.86 | 4,619.00 | 4,619.00 | 77.0% ↑ |
| Тавилга эд хогшил-/190400/ | 36,401 | 5,664.52 | 6,802.59 | 5,626.94 | 7,513.78 | 32.6% ↑ |
| Техник, тоног төхөөрөмж-190302 | 17,692 | 16,388.34 | 18,255.19 | 17,026.87 | 17,501.19 | 6.8% ↑ |
| Дуусаагүй барилга | - | 2,924.65 | - | - | 2,924.65 | 0.0% |
| Үндсэн хөрөнгийн санхүүжилт (урьдчилгаа) | - | 150.59 | - | - | 150.59 | 0.0% |
| Түрээсийн хөрөнгө | - | 53.28 | - | - | 53.28 | 0.0% |
| **Нийт дүн** | **86,745** | **116,122.5** | **108,582.14** | **145,229.52** | **158,875.17** | **36.8%** |

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний дүн **158,875.17 сая төгрөгөөр** үнэлэгдсэн тул санхүүгийн байдлын тайлангийн тохируулгад тусгасан болно.

**Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө**

Банк хөрөнгө оруулалтын зорилгоор үл хөдлөх хөрөнгө эзэмшихгүй гэсэн бодлогын баримт бичигт тусгагдсан заалттай хэдий ч тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө 2,364.89 сая төгрөгөөр тодилуулагдсан байна. Уг хөрөнгийн бүртгэлийн үнэ нь өнөөгийн зах зээлийн үнийг бүрэн илэрхийлэхгүй тул бид тайлант хугацаагаар дахин үнэлж, **дахин үнэлгээний дараах үр дүнгийн зөрүүгээр тохируулгыг тооцож тайланд залруулга хийсэн** болно.

*Хүснэгт 51. Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн үнэлгээний үр дүн*

| Актив хөрөнгө | Бүртгэлийн дүн | Үнэлгээний дүн /2021.12.31/ сая.төг | | | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| | 12/31/2021 | Өртгийн хандлага | Зах зээлийн хандлага | Үнэлгээний үр дүн | БУ/ҮД |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 2,364.88 | 159.83 | 414.98 | **414.98** | -82.5% ↓ |

Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн дахин үнэлгээний үр дүн **414.98 сая төгрөгөөр** үнэлэгдсэн тул санхүүгийн байдлын тайлангийн тохируулгад тусгасан болно. *Хавсралтаар хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн танилцуулга, үнэлгээний тооцооллыг оруулсан болно.*

**Борлуулах зориулалттай хөрөнгө**

Банк хөрөнгийн дансны үнийг үргэлжлүүлэн ашиглах замаар бус нэг жилийн дотор худалдан борлуулж, өртгийг нөхөхөөр шийдвэрлэсэн тохиолдолд хөрөнгийг борлуулах зориулалттай хөрөнгөөр ангилна. Борлуулах зориулалттай хөрөнгийг элэгдүүлэхгүй ба зөвхөн үнэ цэнийн бууралтыг үнэлж бүртгэнэ.

Банк хөрөнгийн дансны үнийг үргэлжлүүлэн ашиглах замаар бус нэг жилийн дотор худалдан борлуулж, өртгийг нөхөхөөр шийдвэрлэсэн тохиолдолд хөрөнгийг **борлуулах зориулалттай хөрөнгөөр** ангилна. **Борлуулах зориулалттай хөрөнгийг** элэгдүүлэхгүй ба зөвхөн үнэ цэнийн бууралтыг үнэлж бүртгэнэ. Хөрөнгийг худалдааны хэвийн нөхцөлөөр одоогийн байдлаар нь нэг жилийн дотор худалдан борлуулах боломжтой бөгөөд хөрөнгийг худалдан авах магадлал өндөр байх үед борлуулах зориулалттай хөрөнгийг хүлээн зөвшөөрч, бүртгэдэг байна.

Борлуулах зориулалттай хөрөнгийн бүртгэлийн үнэ нь өнөөгийн зах зээлийн үнийг бүрэн илэрхийлэхгүй тул бид тайлант хугацаагаар дахин үнэлж, **дахин үнэлгээний дараах үр дүнгийн зөрүүгээр тохируулгыг тооцож тайланд залруулга хийсэн** болно.

*Хүснэгт 52. Борлуулах зориулалттай хөрөнгийн үнэлгээний үр дүн*

| Актив хөрөнгө | Бүртгэлийн дүн | Үнэлгээний дүн /2021.12.31/ сая.төг | Зөрүү |
|---|---|---|---|

СЗХ
2022 он 08 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01
2022-08-14

| | 12/31/2021 | Өртгийн хандлага | Зах зээлийн хандлага | Үнэлгээний үр дүн | БУ/УД |
|---|---|---|---|---|---|
| Борлуулах зориулалттай хөрөнгө | 6,762.30 | 4,192.71 | 7,633.39 | **7,633.39** | 12.9%↑ |

Борлуулах зориулалттай хөрөнгийн дахин үнэлгээний дүн **7,633.39 сая төгрөгөөр** үнэлэгдсэн тул санхүүгийн байдлын тайлангийн тохируулгад тусгасан болно. *Хавсралт 2-д борлуулах зориулалттай хөрөнгийн танилцуулга, үнэлгээний тооцооллыг оруулсан болно.*

**Биет бус хөрөнгө**

Нэгээс дээш жилийн хугацаанд банкны үйл ажиллагаа, удирдлагын зориулалтаар ашиглах, биет шинж чанаргүй программ хангамж, гүдвилл, патент, лиценз, худалдааны тэмдэг ба худалдааны нэр, зохиогчийн эрх, тусгай зөвшөөрөл зэрэг хөрөнгүүд биет бус хөрөнгөд хамрагдана.

Хуримтлагдсан хорогдол, үнэ цэнийн бууралтаар анхны өртгөө нөхсөн биет бус хөрөнгийн хувьд хөрөнгийг данснаас хасах хүртэл нэмж хорогдол тооцохгүй. Биет бус хөрөнгийг санхүүгийн тайланд хуримтлагдсан хорогдол, үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тусгаж байна. Уг биет бус хөрөнгийн бүртгэлийн үнэ нь өнөөгийн зах зээлийн үнийг бүрэн илэрхийлэхгүй тул бид тайлант хугацаагаар дахин үнэлж, **дахин үнэлгээний дараах үр дүнгийн зөрүүгээр тохируулгыг тооцож тайланд залруулга хийсэн** болно.

*Хүснэгт 53. Биет бус хөрөнгийн үнэлгээний үр дүн*

| Актив хөрөнгө | Бүртгэлийн дүн | Үнэлгээний дүн /2021.12.31/ сая.төг | | | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| | 12/31/2021 | Өртгийн хандлага | Зах зээлийн хандлага | Үнэлгээний үр дүн | БУ/УД |
| Бие бус хөрөнгө | 5,630.77 | 6,246.19 | 2,586.39 | **7,762.71** | 37.9% |

Биет бус хөрөнгийн дахин үнэлгээний дүн **7,762.71 сая төгрөгөөр** үнэлэгдсэн тул санхүүгийн байдлын тайлангийн тохируулгад тусгасан болно. *Хавсралтаар биет бус хөрөнгийн мэдээллийг үндсэн хөрөнгийн тайланд хамруулан оруулсан болно.*

### 4.3.3 Өр төлбөрийн мэдээлэл, тодорхойлолт

Харилцах, хадгаламжийн данс гэж иргэд байгууллагаас банкинд төлбөр тооцоо хийх, хуримтлал үүсгэх зорилгоор гэрээ байгуулан байршуулсан эх үүсвэр бөгөөд харилцах, хадгаламжийн дансыг санхүүгийн тайланд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөгийг нэмсэн дүнгээр тусгадаг.

Монголбанк, бусад банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, бусад банк, санхүүгийн байгууллагаас банкинд байршуулсан харилцах, хадгаламжийн данс, банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр хамрагдана. Банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийг санхүүгийн тайланд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөгийг нэмсэн дүнгээр тусгадаг.

Тодорхой зориулалт, нөхцөлтэй байршуулсан эх үүсвэр болон төлбөр тооцооны бусад хэрэгслийн эх үүсвэр болгон ашиглахаар байршуулсан төслийн зээлийн эх үүсвэр, банкнаас гаргасан өрийн бичиг, үнэт цаас, репо үнэт цаас, аккредитив, баталгаа, хамтын



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341169 ГСТ5362
УЛААНБААТАР ХОТ
ТҮЛДЕК ҮЦК ХХК

СЗХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022 -09- 14
БҮРТГЭВ-03

зээлжүүлэлтийн эх үүсвэр, түрээсийн өр төлбөр хамрагдана. Бусад эх үүсвэрийг санхүүгийн тайланд эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөгийг нэмсэн дүнгээр тусгадаг.

Санхүүгийн өр төлбөр гэж бусад этгээдэд мөнгө ба бусад санхүүгийн хөрөнгийг шилжүүлэхээр гэрээгээр хүлээсэн үүргийг ойлгоно. Санхүүгийн өр төлбөрт дансны өглөг, банкны дотоод ажил гүйлгээгээр гарах тооцооны өглөг, банк хоорондын төлбөр тооцоо, салбар хороондын тооцооны өглөг, ногдол ашгийн өглөг, давуу эрхийн хувьцааны өр төлбөр болох хэсэг, хоёрдогч өглөг, бусад өглөгийг хамруулж байна. Санхүүгийн бус өр төлбөр гэж санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангахгүй цалингийн өглөг, татварын өглөг, өр төлбөрөөр хүлээн зөвшөөрсөн. Нийгмийн хөгжлийн сан, болзошгүй өр төлбөр, зээлтэй холбоотойгоор хүлээсэн үүрэгт байгуулсан нөөц, мөнгөөр төлөгдөх хугацааны опцион, хойшлогдсон орлогууд багтаж байна.

Төрийн банк ХХК-ийн тайлант хугацаанд дах санхүүгийн байдлын аудитлагдсан тайланд өр төлбөрт хамаарах харилцах, хадгаламж, банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, бусад эх үүсвэр, дериватив санхүүгийн өр төлбөр, бусад санхүүгийн өр төлбөр, бусад санхүүгийн бус өр төлбөр, хоёрдогч өглөг, давуу эрхийн хувьцаа зэрэг өр төлбөрүүд нийт **3,404,250.32 сая төгрөгөөр** толилуулагдсан байгааг хүлээн зөвшөөрч, тохируулга хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

### 4.3.4 Цэвэр хөрөнгийн аргын үнэлгээний тооцоолол

Өртгийн хандлагын цэвэр хөрөнгийн үнэ цэнийн аргаарх "Төрийн банк" ХХК-ийн бизнесийн үнэ цэнийг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тодорхойлоход **408,373.82 сая төгрөг /Дөрвөн зуун найман тэрбум гурван зуун далан гурван сая/** болов. Тооцооллыг дараах хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 54. Цэвэр хөрөнгийн үнэ цэнийн тооцоолол*

| № | Үзүүлэлт | Тайлангийн үзүүлэлт 2021.12.31 | Тохируулгын коэффициент | Тохируулагдсан дүн /сая.төг/ |
|---|---|---|---|---|
| 1 | **ХӨРӨНГӨ** | | | |
| 1.1 | Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 817,604.43 | 1.00 | 817,604.43 |
| 1.1.1 | Бэлэн мөнгө | 45,780.31 | 1.00 | 45,780.31 |
| 1.1.2 | Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө /3 хүртэлх сарын хугацаатай/ | 34,282.37 | 1.00 | 34,282.37 |
| 1.1.3 | Мөнгөтэй адилтгах хөрөнгө | 737,541.74 | 1.00 | 737,541.74 |
| 1.1.4 | Мөнгөн хөрөнгөд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | - | - | - |
| 1.2 | Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө | 199,392.32 | 1.00 | 199,392.32 |
| 1.2.1 | Монголбанкинд байршуулсан хөрөнгө | 199,081.54 | 1.00 | 199,081.54 |
| 1.2.2 | Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө | - | - | - |
| 1.2.3 | Бусад хөрөнгө | - | - | - |



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ БА КО КАПИТАЛ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ3382
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК

СЗХ
2022 оны 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022 -09- 14



| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.2.4 | Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөд хуримтлуул тооцсон хүүгийн авлага | 356.05 | 1.00 | 356.05 |
| 1.2.5 | Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сан | (45.27) | 1.00 | (45.27) |
| 1.3 | Хөрөнгө оруулалт | 385,834.39 | 1.00 | 385,834.39 |
| 1.3.1 | Арилжааны үнэт цаас | 11.42 | 1.00 | 11.42 |
| 1.3.2 | Борлуулахад бэлэн үнэт цаас | 115,563.14 | 1.00 | 115,563.14 |
| 1.3.3 | Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас | - | - | - |
| 1.3.4 | Зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас | 67,000.00 | 1.00 | 67,000.00 |
| 1.3.5 | Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт | - | - | - |
| 1.3.6 | Барьцаанд байгаа үнэт цаас | 197,777.69 | 1.00 | 197,777.69 |
| 1.3.7 | Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 6,716.76 | 1.00 | 6,716.76 |
| 1.3.8 | Үнэт цаасны эрсдэлийн сан | (1,234.61) | 1.00 | (1,234.61) |
| 1.4 | Зээл /цэвэр дүнгээр/ | 2,237,147.35 | 0.98 | 2,186,184.00 |
| 1.4.1 | Хэвийн зээл | 2,160,416.37 | 1.00 | 2,160,416.37 |
| 1.4.2 | Хугацаа хэтэрсэн зээл | 17,220.59 | 1.00 | 17,220.59 |
| 1.4.3 | Хэвийн бус зээл | 26,692.27 | - | - |
| 1.4.4 | Эргэлзээтэй зээл | 32,587.05 | - | - |
| 1.4.5 | Муу зээл | 170,345.05 | - | - |
| 1.4.6 | Зээлийн хойшлогдсон төлбөр | (11,819.00) | 1.00 | (11,819.00) |
| 1.4.7 | Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 35,049.15 | 1.00 | 35,049.15 |
| 1.4.8 | Зээлийн эрсдэлийн сан | (193,344.13) | 0.08 | (14,683.11) |
| 1.5 | Дериватив санхүүгийн хөрөнгө | 759.11 | 1.00 | 759.11 |
| 1.6 | Бусад санхүүгийн хөрөнгө | 646.59 | 1.00 | 646.59 |
| 1.6.1 | Бусдаас авах авлага /цэвэр дүнгээр/ | 646.59 | 1.00 | 646.59 |
| 1.6.2 | Банк, салбар хоорондын тооцоо | - | - | - |
| 1.6.3 | Өмчлөх бусад хөрөнгө /цэвэр дүнгээр/ | - | - | - |
| 1.6.4 | Бусад | - | - | - |
| 1.7 | Бусад санхүүгийн бус хөрөнгө | 20,469.62 | 1.00 | 47,517.06 |
| 1.7.1 | Бусад тооцоо | 7,564.67 | 1.00 | 7,564.67 |
| 1.7.2 | Бараа материал, үнэ бүхий зүйл | 2,849.61 | 1.00 | 2,849.61 |
| 1.7.3 | Үнэт металл /цэвэр дүнгээр/ | - | 1.00 | - |
| 1.7.4 | Өмчлөх бусад хөрөнгө /цэвэр дүнгээр/ | 9,986.72 | 3.71 | 37,034.16 |
| 1.7.5 | Татварын авлага | 67.35 | 1.00 | 67.35 |
| 1.7.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | - | - | - |
| 1.7.7 | Бусад | 1.27 | 1.00 | 1.27 |
| 1.8 | Үндсэн хөрөнгө | 116,122.50 | 1.37 | 158,875.17 |
| 1.9 | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 2,364.88 | 0.18 | 414.98 |
| 1.10 | Борлуулах зориулалттай хөрөнгө | 6,762.30 | 1.13 | 7,633.39 |
| 1.1 | Биет бус хөрөнгө | 5,630.77 | 1.38 | 7,762.71 |
| * | **ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН** | **3,792,734.26** | - | **3,812,624.14** |
| ** | **ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН** | **3,404,250.32** | - | **3,404,250.32** |



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341409 ГСТ5352
УЛААНБААТАР ХОТ
ХУДАЛДААНЫ ҮЦК ХХК

СЗХ
2022.09.21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



| | | | | |
|---|---|---|---|---|
| *** | **ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНЭ** | **388,483.94** | **-** | **408,373.82** |

## 4.4 ҮНЭЛГЭЭНИЙ ЭЦЭСЛЭСЭН ДҮН, НЭГТГЭЛ

Бизнесийн үнэлгээг үнэлгээний 3 хандлагын аргаар хийж, үнэ, цэнийг тодорхойлсон.

*Хүснэгт 55. Үнэлгээний дүн*

| Үнэлгээний хандлага | Үнэлгээний арга | Үнэлгээ тогтоосон хувилбар | Үнэлгээний дүн, сая төгрөг |
|---|---|---|---|
| Зах зээлийн хандлага | Жишиг компанийн арга | Дотоодын жишиг компанийн мэдээлэлд тулгуурласан | 621,652.0 |
| | | Гадаадын жишиг компанийн мэдээлэлд тулгуурласан | 484,765.0 |
| Орлогын хандлага | Мөнгөн гүйлгээг хорогдуулан тооцох арга | Мөнгөн гүйлгээний "Post Money" төсөөлөлд тулгуурласан | 503,818.0 |
| | | Мөнгөн гүйлгээний "Pre Money" төсөөлөлд тулгуурласан | 422,137.0 |
| Өртгийн хандлага | Цэвэр хөрөнгийн арга | - | 408,374.0 |

Бид зах зээлийн хандлагаар, жишиг компанийн аргаар үнэлэхэд бизнесийн үнэлгээний дүн нь 484,765 – 621,652.0 сая төг-ийн, орлогын хандлагаар, мөнгөн гүйлгээг хорогдуулах аргаар үнэлэхэд 422,137.0 – 503,818.0 сая төг, өртгийн хандлагаар, цэвэр хөрөнгийн аргаар үнэлэхэд 408,374 сая төг гарсан.

Үнэ, цэнийн дүн, интервалуудыг доорх схем-зурагт үзүүлэв.




*Зураг 29. Тодорхойлсон бизнесийн үнэ, цэнийн интервал, дүнгийн бүдүүвч*

*Эх үүсвэр: МОТ шинжилгээ*

Дээрх бүдүүвч зургаас харахад зах зээлийн хандлагаар үнэлсэн үнэлгээний дүнгийн доод дүн буюу гадаадын жишиг банкнуудын мэдээлэлд тулгуурлан хийсэн үнэлгээний дүн 484,756.0 сая төг болон орлогын хандлагаар үнэлсэн үнэлгээний дүнгийн дээд дүн буюу мөнгөн гүйлгээг банкны IPO хийсэн үр дүнгээр тооцсон төсөөлөлд тулгуурлан хийсэн үнэлгээний дүн 503,818.0 сая төг хоорондын дүн нь 2 интервалын хувьд давхцалтай байгаа бөгөөд эдгээр үнэлгээний дүнгүүдийн хувьд "Үнэ/Өөрийн хөрөнгө" (P/BV)-ийн харьцаанууд нь 1.24x болон 1.29x байгаа нь ТОП20 индексийн ижил чиглэлийн компаниудын медиан утга /1.38/

СЭХ
2022 09 21
БҮРТГЭВ
№ 01
2022-09-14

болон гадаадын ижил төрлийн 38 банкны медиан утга /1.47/-тай харьцангуй ойрхон байна. Иймд дээрх дүгнэлт нь үндэслэлтэй байна гэсэн дүгнэлтийг бидний зүгээс хийсэн болно.

*Бизнесийн үнэлгээний хувьцааны багцын хяналтгүйн хорогдуулгын тооцоолол*

Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2011 оны 274/240 тоот тушаалаар батлагдсан "Бизнесийн үнэлгээ хийх аргачлал"-ын 2.6.1-д "Бизнесийн үнэлгээ хийхдээ хяналттайн нэмэгдүүлэг, хяналтгүйн болон хөрвөх чадваргүйн хорогдуулгыг тооцно. Нэмэгдүүлэг, хорогдуулгын хувийг эрх бүхий мэргэжлийн байгууллагаас шинжлэн тогтоосон хязгаар дотор сонгоно." гэж заасан байдаг.

Үнэлгээний үйл ажиллагаанд компанийн нийт 100.0%-ийн үнэ, цэнийг биш тухайлсан багцын үнэ, цэнийг тооцох асуудал гардаг бөгөөд энд жижиг /хяналтын биш/ багцыг үнэлэхдээ хяналтгүй хорогдуулыг хийх шаардлагатай болдог.

Хяналтын багцын үнэ, цэнэ нь ямагт жижиг багцын үнээс дээгүүр байдаг.

Бидний үнэлсэн үнэлгээний зүйл буюу "Төрийн банк" ХХК – ийн "Эзэмшигчийн өмчийн 100.0%-ийн хувь оролцоо"-ны зах зээлийн үнэ, цэнийг тодорхойлсон нь компанийн хувьцааны хяналтын болон хяналтын бус тодорхой багцыг биш 100.0%-ийн багц тул хяналтгүйн хорогдуулга хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

Харин "Төрийн банк" ХХК – ийн "Эзэмшигчийн өмчийн 100.0%-ийн хувь оролцооноос тодорхой хэсэг буюу 5.0 – 20.0% буюу хяналтгүй багцыг Үнэт цаасны зах зээлд нээлттэй гаргах үед нэг хувьцааны үнэ, цэнийг тооцоход "хяналтгүйн хорогдуулга"-ыг хийх шаардлага үүсэж болох юм.

Энэ үед "хяналтгүйн хорогдуулга"-ыг хийх үед ямар хэмжээний тохируулга хийх нь оновчтой байх талаар "зөвлөмж"-ийг доорх хэсэгт нэмэлтээр оруулсан болно.

Манайд энэхүү нэмэгдүүлэг, хорогдуулгын хувийг өнөөдрийн байдлаар Эрх бүхий байгууллагаас тогтоогоогүй байгаа тул бизнесийн үнэлгээний дүнг тохируулах хорогдуулгын хувь, хэмжээг тодорхойлох зорилгоор доорх нэмэлт шинжилгээг хийсэн болно.

***1. Дотоодод хорогдуулгыг хэрхэн тодорхойлж байгаа талаар***

Манайд Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд хувьцаагаа санал болгох замаар нээлттэй ХК болох үйл явц идэвхижсэн 2018 оноос эхлэн IPO-нд зориулан хийгдсэн компаниудын бизнесийн үнэлгээнд уг нэмэгдэл, хорогдлыг хэрхэн хийсэн талаар судлахад нийт 12 үнэлгээнээс зөвхөн 1 тайланд буюу Богд банк ХХК-ийн бизнесийн үнэлгээнд хяналтгүйн хорогдуулгыг 23.7%-иар тооцсон байна. Энэ хорогдуулгын хувийг авахдаа "20.0% - 30.0%" гэсэн интервалаас сонгож авсан байна.

*Хүснэгт 56. Дотоодын компанийн бизнесийн үнэлгээнд тооцсон хорогдуулах хувийн судалгаа*

| № | Он | ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ | ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИУЛАЛТ | ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН КОМПАНИ | ХЯНАЛТЫН ТОХИРУУЛГА | ХӨРВӨХ ЧАДВАРЫН ТОХИРУУЛГА |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2018 | Монгол базальт ХХК | IPO | МОТ ХХК | - | - |
| 2 | 2018 | Ард даатгал ХХК | IPO | БДО аудит ХХК | - | - |
| 3 | 2018 | Ард кредит ХХК | IPO | БДО аудит ХХК | - | - |
| 4 | 2018 | Лэнд МН ХХК | IPO | Гэрэгэ эстимейт ХХК | - | - |
| 5 | 2018 | Мандал даатгал ХХК | IPO | БДО аудит ХХК | - | - |



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5332
УЛААНБААТАР ХОТ
БУХАРЕСТ ҮЦК ХХК

СЗХ
2022 09 21
БҮРТГЭВ
№ 01
2022-09-14
БҮРТГЭВ-03

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6 | 2018 | Тумэн шувуут ХХК | IPO | Итгэлт эстимейт ХХК | - | - |
| 7 | 2018 | Хөвсгөл алтан дуулга ХК | FPO | БДО аудит ХХК | - | - |
| 8 | 2019 | Инвескор ББСБ ХХК | IPO | Гэрэгэ эстимейт ХХК | - | - |
| 9 | 2019 | Монос хүнс ХХК | IPO | Итгэлт эстимейт ХХК | - | - |
| 10 | 2020 | Бодь даатгал ХХК | IPO | Гэрэгэ эстимейт ХХК | - | - |
| 11 | 2021 | Central express | IPO | Гэрэгэ эстимейт ХХК | - | - |
| 12 | 2021 | Богд банк | IPO | БДО аудит ХХК | 23.7% | - |

*Эх үүсвэр: МОТ тооцоолол*

Иймд манайд бизнесийн үнэлгээнд хяналттайн нэмэгдүүлэг, хяналтгүйн болон хөрвөх чадваргүйн хорогдуулгыг үндсэндээ хийдэггүй гэсэн дүгнэлт өгч болохоор байна.

***2. Гадаад оронд хорогдуулгыг хэрхэн тодорхойлж байгаа талаар***

Гадаад оронд хорогдуулгыг хэрхэн тооцдог талаар манай улстай хөгжлийн түвшин болон газарзүйн байрлалаар ойрхон ОХУ-ын хөрөнгийн зах зээл, компаниудын бизнесийн үнэлгээний тайлангаас хайлт хийж, нийт 20 тайланг судлахад 7 тайланд ямар нэг хэлбэрээр хяналттайн нэмэгдүүлэг, хяналтгүйн болон хөрвөх чадваргүйн хорогдуулгыг хийсэн байна. Дүнг доорх хүснэгтэд оруулав.

*Хүснэгт 57. ОХУ-д бизнесийн үнэлгээний хорогдуулгыг хийж байгаа байдал /зарим тайланд хийсэн судалгаагаар/*

| № | Он | Мэдээллийн эх үүсвэр | Үнэлгээний зүйл | Үнэлгээний компани | Хяналтгүйн тохируулгын хэмжээ | Хөрвөх чадваргүйн тохируулгын хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2018 | https://tfg.ru/upload/iblock/050/Отчет 500-30-57-0118 ОКС с прил - подписан.pdf | ПАО "ОКС" компанийн 2.0%-ийн багц хувьцаа | ООО "Сюрвей.ру" | 40.0% | - |
| 2 | 2018 | https://ausib.ru/files/download/102629852/Отчет об оценке № 604-Г-2018 от 01.10.2018 (акции СРК).pdf | АО "Сибирская регистрационная компания" компанийн 34.21%-ийн багц хувьцаа | ООО "Бюро оценки" | 20.0 | 35.0 |
| 3 | 2018 | https://bankrupt.alfalot.ru | АО "ГеоПром" компанийн 46.2%-ийн багц акц | ООО "Юрдис" | 15.0 | 7.0% |
| 4 | 2017 | https://tkbip.ru/Lawyers/attachments/disclosure-of-information/reporting-of-mutual-funds/21535000935845761/00 Отчет 04-05-02 НП 16 июня 17.pdf | ЗАО "Независимые инвестиции" компанийн 20.0%-ийн багц хувьцаа | ЗАО "Центр Независимой Оценки" | 10.0% | - |
| 5 | 2016 | https://rus-on.ru | ООО "Санлайф" компанийн 50.0%-ийн багц хувьцаа | ООО "Независимая консалтинговая компания" | 10.0 | - |
| 6 | 2003 | https://www.ocenchik.ru/accounts/business/893/ | ОАО "Куба- Сахар" компаний 49.0%-ийн багц хувьцаа | ООО "КОМИТ-Инвест" | 20.0 | 35.0 |
| 7 | 2000 | https://ocenka-men.ru/about/examples/stock/1055/ | ОАО "XXX горно-обогатительный комбинат" компаний 20.0%-ийн багц хувьцаа | ЗАО "Эксперт-Оценка" | 25.0 | 35.0 |

*Эх үүсвэр: МОТ тооцоолол*



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДЕВИЛ ҮЦК ХХК

СЗХ
2022 .09. 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -09- 14

Мөн бизнесийн үнэлгээнд хяналтгүйн болон хөрвөх чадваргүйн хорогдуулгын хэмжээг тодорхойлсон талаарх бусад эх үүсвэрээс авсан мэдээллийг доор оруулав. Үүнд:

### Хяналтгүй хорогдуулгыг тодорхойлсон байдал

Хэд хэдэн мэргэжлийн ном, хэвлэлүүдэд хяналттайн нэмэгдүүлэг болон хяналтгүйн хорогдуулгын хэмжээг тодорхойлсон байдаг. Үүнд:

1. Хяналттай дундаж нэмэгдэл 30.0 – 40.0% (Бизнесийн үнэлгээ. Сурах бичиг. 2 дахь хэвлэл, ред. А.Г.Грязнова, М.А.Федотова, 2004),

2. Хяналтгүй хорогдуулгын хувь 21.0 – 30.0% (Компанийн нэгдэл, нийлэлтийн үеийн үнэлгээ, зохиогч Эванс Фрэнк Ч, Бишоп Дэвид М, 2004. 221-р хуудас),

3. Хяналттай нэмэгдүүлэг, хяналтгүй хорогдуулгын хувь 20.0-40.0% ("Mergerstat Review" www.mergerstat.com),

4. Хяналтгүй хорогдуулгын хувь 10.0 – 65.0% ("Роснефть" компанийн хувьцааны үнэлгээг хийсэн "Drezdner Kleinwort Benson" компани нь 1996-1997 онуудад хийгдсэн 21 том компанийн хувьцааны арилжааг судалж гаргасан),

5. ОХУ-ын Засгийн Газрын 2002 оны 05-р сарын 31-ний өдрийн 369 тоот тогтоолын 1-р хавсралтаар Хувьцааны багцын хяналтын илтгэлцүүрийг тогтоосон байдаг.

| ХУВЬЦААНЫ БАГЦЫН ХУВЬ, ХЭМЖЭЭ | ХЯНАЛТЫН ИЛТГЭЛЦҮҮР |
|---|---|
| 75.0 – 100.0% | 1.0 |
| "50.0% + 1 хувьцаа"-гаас "75.0% - 1 хувьцаа" хүртэл | 0.9 |
| "25.0% + 1 хувьцаа"-гаас "50.0% - 1 хувьцаа" хүртэл | 0.8 |
| 10.0% - 25.0 | 0.7 |
| "1 хувьцаа"-гаас "10.0% - 1 хувьцаа" хүртэл | 0.6 |

6. "Вопросы оценки" сэтгүүлийн 2003 оны 3-рт В.Козлов, Е.Козлова нар хувьцааны багцын хяналтын "нэмэгдүүлэг/хорогдуулга"-ыг тооцоолох хэрэгсэл болгон "Матриц премий" буюу "Нэмэгдэл/хорогдолын матриц"-ыг судалгааны үндсэн дээр тодорхойлж, санал болгосон байна. Уг матрицыг доорх хүснэгтэд оруулав.

| № | ХӨРӨНГИЙН БҮТЭЦ | "НЭМЭГДҮҮЛЭГ/ХОРОГДУУЛГА"-ЫН ХУВЬ |
|---|---|---|
| 1 | 98%:100% | 40% |
| 2 | 90%+10% | 35%+5% |
| 3 | 80%+20% | 32%+8% |
| 4 | 80%+10%+2%+1% | 32%+5%+1%+0.5% |
| 5 | 75%+25% | 20%+10% |
| 6 | 75%+20%+2%+1% | 20%+8%+1%+0.5% |
| 7 | 75%+10%+10%+2%+2%+1% | 27.5%+5%+5%+1%+1%+0.5% |
| 8 | 50%+50% | 20%+20% |
| 9 | 51%+49% | 25%+15% |
| 10 | 49%+49%+2% | 17.5%+17.5%+5% |
| 11 | 50%+25%+25% | 22%+9%+9% |
| 12 | 51%+25%+20%+ | 23%+10%+6% |
| 13 | 50%+20%+20%+2%+1%+ | 22%+10%+10%+1%+0.5% |
| 14 | 50%+10%+10%+10%+10%+2%+1%+ | 22%+4%4%+4%+4%+1%+0.5% |
| 15 | 25%+20%+10%+2%+1%+ | 10%+8%+5%+1%+0.5% |



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ ТҮҮДЭЕВ ҮЦК ХХК

СЭХ
2022 .03 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-03-14

7. НЦПО СРД № 12 /ред. Яскевич Е.Е/, хуудас 24-ийн Хүснэгт 2.5.1

Хяналтын илгэлцүүр

| Хөрөнгийн бүтэц | ФБК судалгаа | Лейфер Л.А-гийн судалгаа | Пп РФ № 87 | Хэмжээний судалгаа /дотоодын судлаачдийн/ | Хяналтын илгэлцүүрийн дундаж утга |
|---|---|---|---|---|---|
| 75% - 100% | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 50% - 75% | 0.96 | 1.00 | 0.90 | - | 0.95 |
| 25% - 50% | 0.74 | 0.55 | 0.80 | - | 0.70 |
| 10% - 25% | 0.60 | 0.42 | 0.70 | - | 0.57 |
| 0% - 10% | 0.49 | 0.42 | 0.60 | 0.30 | 0.45 |

8. "Вестник Финансового университета" сэтгүүлд нийтлэгдсэн Евстафьевой Е.М-ын "Хяналтын нэмэгдүүлэг, хорогдуулга"-ын талаар хийсэн судалгаа. Мэдээллийн эх үүсвэр: http://cyberleninka.ru/article/n/premii-i-skidki-za-kontrol-issledovanie-sredney-velichiny-popravok-dannym-rossiyskogo-rynka

| Багцын хэмжээ | Нэмэгдүүлгийн дундаж утга | Хорогдуулгын дундаж утга |
|---|---|---|
| 25.0%-иас бага | 31.0% | 24.0% |
| 50.0%-иас бага | 30.0% | 23.0% |
| Дүн | 20.0% - 30.0% | |

Дээрх судалгаа, тооцооллуудыг нэгтгэн дүгнэж, Төрийн банкны бизнесийн үнэлгээнд хэрэглэх боломжтой хяналтгүйн хорогдуулгын хувийг **21.0% - 30.0%**-иар тооцож болохоор байна. Тооцоолльг доорх хүснэгтэд оруулав.

*Хүснэгт 58. Хяналтгүйн хорогдуулгын тооцоолол*

| № | Мэдээллийн эх үүсвэр | Хяналтгүйн хорогдуулга | |
|---|---|---|---|
| 1 | Бизнесийн үнэлгээ. Сурах бичиг. 2 дахь хэвлэл, ред. А.Г.Грязнова, М.А.Федотова, 2004 | 30.00% | 40.00% |
| 2 | Компанийн нэгдэл, нийлэлтийн үеийн үнэлгээ, зохиогч Эванс Фрэнк Ч, Бишоп Дэвид М, 2004. 221-р хуудас | 21.00% | 30.00% |
| 3 | "Mergerstat Review" www.mergerstat.com | 20.00% | 40.00% |
| 5 | ОХУ-ын Засгийн Газрын 2002 оны 05-р сарын 31-ний өдрийн 369 тоот тогтоолын 1-р хавсралт | 30.00% | 30.00% |
| 6 | В.Козлов, Е.Козлова нар хувьцааны багцын хяналтын "Нэмэгдэл/хорогдолын матриц" /"Вопросы оценки" сэтгүүлийн 2003 оны 3-рт хэвлэгдсэн/ | 10.00% | 20.00% |
| 8 | "Вестник Финансового университета" сэтгүүлд нийтлэгдсэн Евстафьевой Е.М-ын "Хяналтын нэмэгдүүлэг, хорогдуулга" Мэдээллийн эх үүсвэр: http://cyberleninka.ru/article/n/premii-i-skidki-za-kontrol-issledovanie-sredney-velichiny-popravok-dannym-rossiyskogo-rynka | 20.00% | 30.00% |
| 9 | Богд банкны үнэлгээ /BDO/ | 23.70% | 23.70% |
| 10 | ОХУ-ын 7 компанийн бизнесийн үнэлгээнд хэрэглэсэн тохируулга | 20.00% | 25.00% |
| | Хамгийн их утга | 30.00% | 40.00% |
| | Хамгийн бага утга | 10.00% | 20.00% |
| | Дундаж утга | 21.47% | 29.87% |
| | Медиан | 21.00% | 30.00% |
| | Дундаж утгын интервалын дундаж | 25.67% | |
| | Медианы интервалын дундаж | 25.50% | |



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК 5344469
УЛААНБААТАР ХОТ ТҮҮДСЕК

СЗХ
2022 он .09 сар 21 . өдөр
БҮРТГЭВ
№ 01
2022 -09- 14

## 5 ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГ ХЭРЭГЛЭХ, ХЯЗГААРЛАХ НӨХЦӨЛ

Энэхүү үнэлгээний ажил нь зөвхөн энэ тайлангийн зорилгод хүчин төгөлдөр байх бөгөөд тайлангийн зорилгоос гадуур ашиглаж үл болно.

Бизнесийн үнэлгээ хийлгэхээр бүрдүүлж ирүүлсэн мэдээллийн үнэн бодитой байдлыг материал өгсөн ажилтан, үнэлгээ хийх явцад ашигласан баримт мэдээллийн нууцлалыг үнэлгээ хийхдээ ашигласан үнэлгээчин тус тус хариуцна.

Үнэлгээ хийлгэхээр захиалга өгсөн захиалагч шаардлагатай баримт мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, бүрэн гүйцэд гаргаж өгөөгүйгээс үүсэх хариуцлагыг үнэлгээчин хариуцахгүй.

Захиалагч талаас бидэнд гаргаж өгсөн мэдээллийн үнэн, зөв, иж бүрэн байдалд бид ямар нэг үүрэг, хариуцлага хүлээхгүй.

Захиалагчийн гаргаж өгсөн компани болон үнэлгээтэй холбоотой мэдээллүүдэд аудитын болон хууль, эрхзүйн шинжилгээ хийж, дүгнэлт гаргаагүй, энэ чиглэлийн үйлчилгээ үзүүлээгүй болно.

Энэхүү ажил хийхтэй холбоотой гэрээгээр урьдчилан тохироогүй эсвэл захиалагчийн зүгээс хүсэлт тавьж, нэмэлт төлбөр санал болгож, урьдчилсан тохиролцоо хийгээгүй л бол бид үнэлсэн хөрөнгөтэй холбоотой ямар нэгэн гэрчийн мэдүүлэг өгөх, шүүх хурал, захиргааны үйл ажиллагаанд оролцох үүрэг хүлээхгүй.

Тухайн хөрөнгөтэй холбоотой аливаа материаллаг өөрчлөлтийн талаарх ирээдүйн нөхцөл байдлыг таамаглах боломжгүй байсныг үнэлгээний өдрөөрх тодорхойгүй нөхцөл байдал гэж үзнэ. Энэ нь хөрөнгийн үнэ цэнэд цаашид орох өөрчлөлтийг урьдчилан мэдэх боломжгүй хязгаарлалтын нөхцөл болно. Үнэлгээний өдрөөс хойш гарсан, үнэлгээний дүгнэлтэд нөлөөлж болох аливаа үйл явдал, нөхцөл байдалд бид ямар нэг үүрэг, хариуцлага хүлээхгүй.

Энэхүү тайланг зөвхөн тайланд дурьдсан зориулалтаар хэрэглэх бөгөөд бусад зориулалтаар хэрэглэхийг хориглоно. Тайлан нь иж бүрнээрээ байхдаа хүчинтэй байна. Тайланд эцсийн байдлаар тодорхойлсон дүгнэлт нь зөвхөн үнэлгээний өдрөөр хүчин төгөлдөр байна.

Энэхүү үнэлгээний тайланг бичгээр зөвшөөрөл авалгүй бүхэлд нь эсвэл хэсэгчлэн зар сурталчилгаа хийх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулж олон нийтэд түгээх, СЗХ, МХБ эсвэл эрх бүхий бусад байгууллагын зайлшгүй шаардлагаас бусад тохиолдолд хувийн болон олон нийтэд мэдээлэл өгөхдөө иш татах зэргээр нийтэд дэлгэх, түгээхийг хориглоно. Энэхүү үнэлгээний тайлангийн хэсгүүд болон тайланг бүхэлд нь гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр бусад гуравдагч этгээдэд дэлгэхийг хориглоно.



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

СЭХ
он сар өдөр
2022 09 21
БҮРТГЭВ
№ 01



2022 -09- 14



## 6 НИЙЦЭЛТИЙН МЭДЭГДЭЛ

6.1. Үнэлгээчин энэхүү үнэлгээг хийхдээ ОУҮС-ийн "Дүрэм"-ийн дагуу мэргэжлийн болон ёсзүйн шаардлагуудыг мөрдсөн гэдгээ баталж байна.

- Тайланд тусгагдсан баримт мэдээлэл нь үнэлгээчний мэдэж байгаагаар үнэн;
- Шинжилгээ ба дүгнэлт нь тайлагнасан таамаглал, нөхцөл байдлаар хязгаарлагдсан;
- Үнэлгээчин нь хөрөнгөө үнэлүүлж буй байгууллагатай ашиг сонирхлын ямар нэгэн холбоогүй;
- Үнэлгээний ажлын хөлс тайлангийн аль нэг хэсгээс хамааралгүй;
- Үнэлгээчин мэргэжлийн боловсролын шаардлагыг хангасан;
- Үнэлгээчин үнэлж буй хөрөнгийн төрөл, зүйлийн талаар туршлагатай;
- Тайланд тусгайлан дурьдсанаас бусад ямар ч этгээд тухайн тайланг бэлтгэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлээгүй болохыг баталж байна.

6.2. Үнэлгээ Олон Улсын Үнэлгээний Стандарт, Монгол улсын холбогдох хууль, тогтоомжуудыг удирдлага болгон үйлчлүүлэгчийн танилцуулсан албан ёсны баримт бичиг, бусад материалуудад тулгуурлан хийлээ.

6.3. Үнэлгээ Сангийн сайдын 2021 оны 167 тоот тушаалаар сунгагдсан хөрөнгийн үнэлгээ хийх эрхийн 07120004 тоот гэрчилгээтэй үнэлгээчин Б.Эрдэнэбаатараар ахлуулсан баг гүйцэтгэсэн болно. Энэхүү үнэлгээний ажилд үнэлгээчин Ч.Дарамбазар, П. Болормаа, Ц.Сэржээ, Б.Энхтуяа, Б.Бурмаа, Д.Барсболд /зөвлөх/, Ц.Баатар /зөвлөх/ нар ажиллав. Компаний бүртгэлийн гэрчилгээ болон хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрлийн хуулбаруудыг тайланд хавсаргав.

6.4. Үнэлгээний явцад ашигласан мэдээллийн нууцлал, гэрээнд заагдсан холбогдох бусад асуудлыг гүйцэтгэгч хариуцна.

6.5. Үнэлгээний тайланг 2022 оны 05-р сарын 30-ны өдөр дуусгавар болгон бичив.

Бизнесийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн:

| | |
|---|---|
| Тэргүүлэх үнэлгээчин: | Б.Эрдэнэбаатар |
| Тэргүүлэх үнэлгээчин: | Ч.Дарамбазар |
| Тэргүүлэх үнэлгээчин: | Ц.Сэржээ |
| Тэргүүлэх үнэлгээчин: | Б.Энхтуяа |
| Мэргэшсэн үнэлгээчин: | П.Болормаа |
| Мэргэшсэн үнэлгээчин: | Б.Бурмаа |

Үнэлгээний тайлан боловсруулж, нэгтгэсэн:

| | |
|---|---|
| Мэргэшсэн үнэлгээчин: | Э.Цацрал |

Хянаж шалгасан:

| | |
|---|---|
| Тэргүүлэх үнэлгээчин: | Б.Эрдэнэбаатар |



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ТӨВДӨЙ ҮЦК ХХК

СЭЗХ 2022 он 09 сар 21 өдөр № 01

2022-09-14

# ХАВСРАЛТ-3 Компанийн дүрэм

**“ТӨРИЙН БАНК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ**
/ТӨСӨЛ/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

**1. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү Дүрэм нь Банкны эрхлэх үйл ажиллагааны чиглэл, банкны удирдлага, бүтэц зохион байгуулалт, өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө болон бусад сан, санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл, тайлан, хяналт, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл, ногдол ашиг, банкийг өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. “ТӨРИЙН БАНК” (цаашид “*Банк*” гэх) нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хууль, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан холбогдох журам, энэхүү Дүрэм (цаашид “*Дүрэм*” гэх)-ийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах нээлттэй хувьцаат компани (цаашид “*ХК*” гэх) мөн.

1.3. Банк нь Засгийн газрын 2009 оны 348 дугаар тогтоол, Монголбанкны 2009 оны 652, 653 дугаар зөвшөөрлүүдийг үндэслэн өмчлөлийн хувьд төрийн өмчийн оролцоотой, энэ Дүрмийн хүрээнд ашгийн төлөө, банкны нийтлэг үйл ажиллагаа явуулах нээлттэй хувьцаат компани байна.

1.4. Банк нь хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд оноосон нэрнийхээ дараа “ХК” гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.

1.5. Монголбанкнаас банкны зөвшөөрлийг цуцалсан, банкийг татан буулгахаар шийдвэрлэсэн, шүүх дампуурлыг зарласан болон эрх зүйн бусад шалтгааны улмаас банк үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэн явуулах үндэслэлгүй болсноос бусад тохиолдолд банкны үйл ажиллагаа хугацаагүй байна.

1.6. Банк нь Монгол Улсад болон гадаадад өөрийн салбар буюу төлөөлөгчийн газартай байж болно. Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхгүй болно.

1.7. Энэхүү Дүрэм болон Төлөөлөн Удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-өөс батлах журмууд нь Компанийн тухай, Банкны тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн байх бөгөөд тусгайлан зохицуулаагүй харилцаа холбогдох хууль тогтоомжид зааснаар зохицуулна.

1.8. Энэхүү Дүрмийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид үндэслэн боловсруулсан бөгөөд тус хууль, тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлт нь Дүрмийн зүйл, хэсэг, заалттай зөрчилдөх тохиолдолд хуулийн зохицуулалтыг мөрдөх ба шаардлагатай тохиолдолд энэхүү Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

**2. Банкны оноосон нэр, хаяг, тэмдэг, туг**

2.1. Банкны оноосон нэрийг Монгол хэлээр “ТӨРИЙН БАНК”, англи хэлээр “STATEBANK” гэх бөгөөд оноосон нэрийг үгийн утгын хувьд цаашид дэлгэрүүлж тайлбарлахгүй, орчуулахгүй болно.

2.2. Банкны албан ёсны хаяг:
Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу, 7/1 тоот
Харилцах утас: 976-11-310103, Лавлах төв: 1800-1881



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК 5341469
УЛААНБААТАР ХОТ БҮДДЕСК ҮЦК ХХК ТТБ0674 5208173

СЗХ
2022 09 21
БҮРТГЭВ
№ 01

Факс: (976-11)-319044
Шуудангийн хайрцаг 314
Цахим шуудан: contact@statebank.mn
Веб сайт: http://www.statebank.mn.

2.3. Банкны нэгж нь тус бүрийн хаягтай байна.

2.4. Банк нь өөрийн оноосон нэр, бэлгэдэл бүхий тэмдэг, хууль ёсны хаяг бүхий албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Тэмдгийг итгэмжлэн хариуцуулсан этгээд хадгална.

2.5. Банкны бэлгэдэл буюу барааны тэмдгийн зөвшөөрлийг Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас холбогдох хууль тогтоомжийн дагуу авна.

2.6. Банк нь өөрийн бэлгэдэл бүхий тугтай байна.

2.7. Банкны бэлгэдэл, туг, тэмдгийн загварыг Төлөөлөн Удирдах зөвлөлөөс батална.

### 3. Банкны эрхэм зорилго

3.1. Банкны эрхэм зорилго нь харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, ил тод, сайн засаглалтай, дундаж давхаргыг дэмжих, бойжуулахад чиглэсэн санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт технологи ашиглан хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ХОРИГЛОХ ЗҮЙЛ

### 4. Банкны эрхлэх үйл ажиллагааны чиглэл

4.1. Банкны зорилго нь харилцагч иргэн, хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалах, түүнийг зохистой байршуулах, өөрийн нэрийн өмнөөс бусдад зээл олгох, ашиглалтад хяналт тавих, харилцагчийн итгэмжлэл, шаардлагын дагуу төлбөр тооцооны ажил үйлчилгээ үзүүлэх, банкны үйл ажиллагаатай холбогдох асуудлаар бусадтай бие даан гэрээ хэлцэл хийх, банкны орлогыг нэмэгдүүлэх, зардлыг зохистой хэмжээнд байлгах, хөрөнгийн санг арвижуулан бэхжүүлэхэд оршино.

4.2. Банк нь дор дурдсан үйл ажиллагааг явуулна. Үүнд:

4.2.1 мөнгөн хадгаламж;
4.2.2 Зээл;
4.2.3 Төлбөр, тооцооны үйлчилгээ;
4.2.4 Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;
4.2.5 Гадаад төлбөр тооцоо хийх;
4.2.6 Өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах;
4.2.7 Үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах;
4.2.8 Үнэт зүйл хадгалах;
4.2.9 Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах;
4.2.10 Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа;
4.2.11 Хууль тогтоомжоор хориглоогүй бөгөөд Монголбанкнаас зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил үйлчилгээ;
4.2.12 Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх.

4.3. Банк нь тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагааг холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авснаар эрхлэх бөгөөд тухайн зөвшөөрлийн нөхцөл, хугацааг чанд мөрдөж ажиллана.

4.4. Банк нь өөрийн нэгжийг Монгол Улсын аймаг, хот, дүүрэг, сумын төвд байгуулан ажиллуулж болно.



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

4.5. Банкны нэгжид салбар, тооцооны төв, тооцооны касс, төлөөлөгчийн газрыг хамааруулах бөгөөд нэгж байгуулах хүсэлтийг Монголбанканд гаргаж, холбогдох журмын дагуу зохих зөвшөөрөл авсан байна.

4.5.1. “Банкны салбар” гэж Монголбанкны тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагааг бүхэлд нь буюу зарим хэсгийг эсхүл хэсэгчлэн эрхэлдэг хуулийн этгээдийн эрхгүй нэгжийг хэлнэ. Банкны төвөөс салбарын үйл ажиллагааг удирдах, хянах, зохион байгуулах ажлыг гүйцэтгэж, салбарын хэмжээнд мөрдөгдөх зээлийн эрх хэмжээний хязгаарлалтыг тогтооно. Салбар нь өөрийн харьяалалд тооцооны төв, тооцооны касстай байж болно.

4.5.2. “Банкны тооцооны төв” гэж хуулийн этгээд, иргэдийн харилцах, хадгаламж байршуулах, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх, харьяалах салбар болон банкны төвөөс тогтоосон зээлийн эрхийн хэмжээний хязгаарлалтын хүрээнд зээлийн үйл ажиллагаа эрхлэх банкны төв, салбарын харьяалалд байх нэгжийг хэлнэ.

4.5.3. “Банкны тооцооны касс” гэж хуулийн этгээд болон иргэдийн харилцах, хадгаламж байршуулах гадаад төлбөр тооцооны энгийн зөвшөөрлийн хүрээнд гадаад валют худалдах худалдан авах болон төлбөр тооцооны үйлчилгээ эрхлэх нэгжийг хэлнэ.

4.5.4. “Банкны төлөөлөгчийн газар” гэж банкны аливаа үйл ажиллагаа эрхэлдэггүй, банкны оршин байгаа газраас өөр газар байрладаг бөгөөд банкны хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс хэлцэл хийх зэрэг эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа явуулах нэгжийг хэлнэ.

4.6. Банк нь хилийн чанад дахь үйл ажиллагаагаа Монгол Улсын Олон улсын гэрээ, хэлэлцээр, тухайн улсын хууль тогтоомжид нийцүүлэн банкны үйл ажиллагаанд мөрдөгддөг олон улсын бизнесийн харилцааны түгээмэл зарчмуудыг баримтлан явуулна.

4.7. Банк нь үйл ажиллагаагаа явуулахтай холбогдуулж дараах шаардлагыг хангаж ажиллана:

4.7.1. Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Монголбанкнаас баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах;

4.7.2. Төлбөр тооцоог түргэн шуурхай, үнэн зөв явуулж ажлын өдөр, сар, улирал, жилээр гүйлгээ, үлдэгдлийн тэнцэл гаргаж ажиллах;

4.7.3. Иргэд, хуулийн этгээдийн тус банк дахь хөрөнгийн найдвартай байдлыг хангаж, тэдгээрийн анхны шаардлагаар гаргаж өгөх, шилжүүлэх;

4.7.4. Харилцагчийн данс, хадгаламж, гүйлгээ, мөнгөн хөрөнгийн төрөл, хэмжээтэй холбоотой нууцыг хадгалах, түүнтэй холбогдсон мэдээллийг гагцхүү тэдний өөрийнх нь бичгээр зөвшөөрснөөр буюу хуульд заасан үндэслэл, журмаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргаж өгөх;

4.7.5. Хуулийн дагуу албан татвар төлөх;

4.7.6. Банкнаас аливаа этгээд, түүнтэй болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь банкны өөрийн хөрөнгийн 20 /хорь/ хувиас хэтрэхгүй байх;

4.7.7. Банкнаас гаргах батлан даалтын нийт дүн нь банкны өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй байх.

4.7.8 Банкны холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын дээд хэмжээ нь банкны өөрийн хөрөнгийн таван



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ТУЛГАТ ҮЦК ХХК

хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь банкны өөрийн хөрөнгийн 20 /хорь/ хувиас тус тус хэтрэхгүй байх;

4.7.9 Монголбанкнаас тогтоосон заавал байлгах нөөц, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг зохих хэмжээ, хэлбэрээр хангах, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, активын эрсдэлийн сан, гадаад валютын болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах.

4.8. Банк нь дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

4.8.1. Ашиг олох зорилгоор банкны бус үйл ажиллагаа эрхлэх. Зээлийн барьцаалсан эд хөрөнгийг зээл төлүүлэх зорилгоор түр эзэмших болон өмчлөх, үйл ажиллагааны зардлаа нөхөх зориулалтаар хөлслүүлэх, түрээслүүлэх, худалдах үйл ажиллагаа үүнд хамаарахгүй;

4.8.2. Дангаараа буюу бусадтай хамтран санхүүгийн зах зээл дээр ноёрхох, өөр хоорондоо, эсхүл гуравдагч этгээдэд шударга бусаар давуу байдал бий болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулах, ийм үйл ажиллагаанд хууль бусаар оролцох;

4.8.3. Өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх;

4.8.4. Хуульд зааснаас бусад тохиолдолд харилцагчийн зөвшөөрөлгүйгээр данснаас нь зарлагын гүйлгээ хийх;

4.8.5. Харилцагч хэд хэдэн банкаар үйлчлүүлэхэд хязгаарлалт тавих;

4.8.6. Банкнаас үзүүлэх үйлчилгээний урьдчилсан нөхцөл болгож өөрийн харьяа нэгжээр үйлчлүүлэхийг харилцагчаас шаардах;

4.8.7. Улс төрийн аливаа нам, эвсэлд хандив өгөх;

4.8.8. Хуулиар хориглосон бусад үйл ажиллагаа.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ.
## БАНКНЫ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

**5. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа**

5.1.Банк нь өөрийн хөрөнгөтэй байна.

5.2.Банкны өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгө болон бусад сангаас бүрдэнэ.

5.3.Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө нь Хувьцаа эзэмшигчээс зохих журмын дагуу оруулсан хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний хэмжээ нь Банкны тухай хуульд заасан арилжааны банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээнээс доошгүй байна.

5.4.Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд хууль тогтоомжид заасан журмын дагуу өөрчлөлт оруулна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт ороход Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтран баталсан "Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам"-ын дагуу Монголбанканд мэдэгдэх эсхүл зөвшөөрөл авна.

5.5.Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө нь банкны нийт гаргасан бөгөөд эргэлтэд байгаа хувьцаанаас бүрдэх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгөд зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй.

5.6.Банк нь хувь нийлүүлсэн хөрөнгөөс гадна доорх сангуудыг байгуулна:

5.6.1. Зээл болон авлага төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтран баталсан журмын дагуу байгуулна;

5.6.2. Банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй ерөнхий эрсдэлээс хамгаалах зориулалттай нөөцийн сан ашгаасаа байгуулна. Нөөцийн сангийн байгуулалт, зарцуулалтыг банкны ТУЗ шийдвэрлэнэ;

5.6.3. Банкны ажилтнуудыг сургах, давтан сургах ажлын эцсийн үр дүнгээр урамшуулах, нэмэгдэл цалин, нөхөн олговор, бусад хөнгөлөлтүүдийг

СЭХ
өн 2022 сар 09 өдөр 21
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14

санхүүжүүлэх, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, шинээр боловсон хүчин бэлтгэх, банкны материаллаг баазыг бэхжүүлэх зориулалтаар Нийгмийн хөгжлийн сант байгуулна. Нийгмийн хөгжлийн сант байгуулах, зарцуулах журмыг банкны ТУЗ батална;

5.6.4. Банк жил бүрийн цэвэр ашгаас энэ Дүрмийн 5.6.6-д заасны дагуу хуримтлалын сант байгуулна. Банкны хуримтлалын сант үүсгэн байгуулагчаас баталсан журмын дагуу зарцуулна;

5.6.5. Банк хөрөнгийнхөө тэнцлийн үнэлгээг зах зээлийн үнэлгээнд тохируулан холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр дахин үнэлж нэмэгдүүлэн, дахин үнэлсэн хэмжээгээр Дахин үнэлгээний сант байгуулна;

5.6.6. Банкны жил бүр цэвэр ашгийн 10 хүртэлх хувийг нөөцийн санд, 5-аас ихгүй хувийг Нийгмийн хөгжлийн санд, үлдэх хувийг улсын төсөвт болон банкны хуримтлалын санд тус тус ТУЗ-ийн шийдвэрээр хуваарилна. Нийгмийн хөгжлийн сангийн зарцуулалтад ажилчдын нийгмийн халамж, ар гэрийн гачигдал хамаарна.

5.7. Банк нь нэг бүр нь 250 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 749,475,000 ширхэг энгийн хувьцаатай буюу нийт 187,368,750,000 төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.

5.8. Банкны нийт хувьцааны 372,000,000 /Гурван зуун далан хоёр сая/ ширхгийг Сангийн яам, 340,000,000 /Гурван зуун дөчин сая/ ширхгийг Хадгаламжийн даатгалын корпораци эзэмшиж, 37,475,000 /Гучин долоон сая дөрвөн зуун далан таван мянга/ ширхгийг нээлттэй зах зээлийн арилжаагаар худалдан авсан бусад хувьцаа эзэмшигчид эзэмшинэ.

5.9. Банкны энгийн хувьцаа нэг бүр нь нэг саналын эрхтэй байна.

5.10. Тухайн жилийн санхүүгийн тайлангаар Банкны өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд уг нөхцөл байдал бүртгэгдсэн албан ёсны санхүүгийн тайлан гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор ТУЗ хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаж, хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах, Банкийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл татан буулгах асуудлыг шийдвэрлүүлэх үүрэгтэй.

5.11. Банкны зарласан боловч гаргаагүй хувьцааг нэмж гаргаж болно.

**6. Банкны хувьцаа эзэмшигч**

6.1. Хувьцаа эзэмшигчид нь хувь хүн, хуулийн этгээд байж болно.

6.2. Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг үнэт цаасны хадгаламж, бүртгэлийн эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

**7. Банкны болон хувьцаа эзэмшигчдийн хариуцлага**

7.1. Банкны эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд банк нь эдгээр бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.

7.2. Банк нь Хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд Хувьцаа эзэмшигч нь Банкны хүлээх үүргийг хариуцахгүй.

7.3. Банкны хувьцаа эзэмшигчид нь гагцхүү өөрийн эзэмшиж буй хувьцааныхаа хэмжээгээр Банкны эрсдэл, хариуцлага хүлээнэ.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАНКНЫ УДИРДЛАГА, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

**8. Хувьцаа эзэмшигчдийн хурал**

8.1. Банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.



УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГУУДСЕК

СЭХ
2022 09 21
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ-03

8.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит ба ээлжит бус байх бөгөөд ээлжит хурлыг ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан хугацаанд буюу санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор жилд нэг удаа зарлан хуралдуулна.

8.3. Дараах тохиолдолд ТУЗ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна:

- 8.3.1. ТУЗ-ийн нийт гишүүний 50-аас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;
- 8.3.2. ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, эсхүл саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцааг дангаар эзэмшигч санал, шаардлага гаргасан;
- 8.3.3. Банкны алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн;
- 8.3.4. ТУЗ шаардлагатай гэж үзэж шийдвэр гаргасан;
- 8.3.5. Аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан;
- 8.3.6. Компанийн тухай хууль болон Дүрэмд заасан бусад тохиолдол.

8.4. Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал нь дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх бүрэн эрхтэй. Үүнд:

- 8.4.1. Банкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу банкны Дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
- 8.4.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
- 8.4.3. Банкны өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
- 8.4.4. Банкны хэлбэрийг өөрчлөх, өөрчлөн байгуулах;
- 8.4.5. Банкийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
- 8.4.6. Хувьцааг хуваах буюу нэгтгэх;
- 8.4.7. ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
- 8.4.8. Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигч нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх;
- 8.4.9. Банкны тухай хуулийн 29.2.6, 29.2.7 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- 8.4.10. ТУЗ-өөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Компанийн тухай хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах;
- 8.4.11. ТУЗ-өөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
- 8.4.12. Хуульд заасны дагуу компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;
- 8.4.13. Монголбанкны мэдэгдлийг хүлээн авсны үндсэн дээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, чөлөөлөх;
- 8.4.14. ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- 8.4.15. ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
- 8.4.16. Хууль болон банкны дүрмээр тогтоосон бусад асуудал.

8.5. Дараах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор батална. Үүнд:



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

8.5.1. Банкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, Дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг батлах;
8.5.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
8.5.3. Банкны хэлбэрийг өөрчлөх;
8.5.4. Банкны өрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, түүний тоог тогтоох;
8.5.5. Давуу эрхийн хувьцаа гаргах;
8.5.6. Банкийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
8.5.7. Хувьцааг хуваах буюу нэгтгэх;
8.5.8. Хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх.

8.6. Энэхүү Дүрмийн 8.5-д заасснаас болон ТУЗ гишүүдийг сонгохоос бусад асуудлаар гаргах шийдвэр нь хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонх дэмжсэнээр хүчин төгөлдөр болно.

8.7. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ. Энэ аргыг хэрэглэхдээ тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоог ТУЗ-д сонгогдох 9 гишүүний тоогоор үржүүлж саналын эрхийн тоог тодорхойлно. ТУЗ-ийн гишүүнд сонгогдохоор нэр дэвшсэн хүмүүсийн нэрийг саналын хуудсанд оруулахдаа ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй хүмүүсийн нэрсийг тус тусад нь жагсаана.

8.8. Хувьцаа эзэмшигч нь ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй хүмүүст тус тусад нь саналаа өгнө. Энэ тухай заавтрыг Компанийн тухай хууль, СЗХ-ны журмыг баримтлан тухайн хурлын санал авах хуудсанд тусгана.

8.9. Банкны ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тоолохдоо тус бүрд нь тоолж, хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр тус тус сонгоно.

8.10. Хуралд оролцох журам:

8.10.1. Хувьцаа эзэмшигч нь иргэний үнэмлэхтэйгээ ирж, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас бүртгэлийн өдрөөр тодорхойлсон хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган бүртгүүлж хуралдаа оролцоно. Хэрэв хуралд биеэр оролцох боломжгүй бол өөрийгөө төлөөлүүлж хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох этгээдэд нотариатаар гэрчлүүлсэн итгэмжлэл олгосны үндсэн дээр оролцуулж болно.

8.10.2. Төлөөлөх тухай итгэмжлэл нь тодорхой хугацаа заагаагүй бол гагцхүү тухайн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүчинтэй. Хувьцаа эзэмшигчдийн хурал хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл хойшлогдсон хуралд хүчинтэй хэвээр байна.

8.10.3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирүүлсэн саналын хуудас, мөн хувьцаа эзэмшигчийн итгэмжлэлийг хурлыг зарласан өдрөөс эхлэн хурал хуралдах өдрийн хурал эхлэх цаг хүртэл хүлээн авч бүртгэнэ. Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг энэхүү Дүрэмд заасанаар тогтоосон бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тодорхойлж, тооллогын комисс эсхүл түүний үүргийг гүйцэтгэхээр ТУЗ-өөс тусгайлан томилсон этгээд гүйцэтгэнэ.

8.10.4. Хувьцаа эзэмшигчид нь хэлэлцэж буй асуудлын талаар саналаа санал авах хуудсаар ирүүлсэн тохиолдолд түүнийг тухайн хуралд оролцсонд тооцно. Хурлын ирцийг хэлэлцэх асуудал бүрээр гаргах ба тухайн хэлэлцэх асуудалд санал ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг тухайн асуудал хэлэлцэхэд оролцсонд тооцно. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хориглоно.

8.10.5. Банкны саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.

8.10.6. Хурлын ирц хүрээгүй тохиолдолд хурлыг хойшлуулах бөгөөд харин хэлэлцэх асуудал хэвээр байна. Хойшлогдсон хурлыг ажлын 20 өдрийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас ажлын долоогоос доошгүй өдрийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.

8.10.7. Саналын эрхийн 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно. Банкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу банкны Дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах; нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах; банкны өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох; банкны хэлбэрийг өөрчлөх; банкийг татан буулгах; хувьцааг хуваах буюу нэгтгэх тухай асуудлыг хэлэлцэх хойшлогдсон хурал нь саналын эрхийн гуравны нэгээс доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор хүчин төгөлдөр болно.

8.11. Банкны бүртгэлийн өдрийг ТУЗ хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргах үед тогтоох бөгөөд энэ өдөр нь хурал хуралдуулах тухай шийдвэр гарсан өдрөөс өмнө байж болохгүй.

8.12. Санал авах хуудас, түүнийг хүчинтэйд тооцох:

8.12.1. Банкны хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлаар саналыг санал авах хуудсаар авч болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргахдаа тогтооно.

8.12.2. Санал авах хуудасны агуулгыг ТУЗ хурал хуралдуулах тухай шийдвэртээ тогтооно. Санал авах хуудсанд Банкны оноосон нэр, хурал хийх газар, өдөр, цаг, хувьцаа эзэмшигчдийн нэр, эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо хэмжээ, санал хураалтаар шийдвэрлэх асуудлын нэр, хурлаас хэлэлцэх асуудал бүрээр гарах шийдвэрийн төсөл зэргийг тусгана.

8.12.3. Санал авах хуудсанд (ТУЗ-ийн гишүүнийг сонгохоос бусад тохиолдолд) санал өгөх хувилбарын зөвхөн нэгийг тэмдэглэсэн тохиолдолд хүчинтэй байна. Санал авах хуудсыг хурал зарласан өдрөөс эхлэн тухайн асуудлыг хэлэлцэж дуусах хүртэлх хугацаанд авна.

8.12.4. Банк санал хураалтыг цахим хэлбэрээр явуулж болно. Энэ тохиолдолд хуралд оролцогчийг системд бүртгэх, түүний саналыг авах, ирцийн мэдээ болон авсан саналын дүнг өөрчлөх боломжгүйгээр, үнэн зөв илэрхийлэх боломжтой програмыг бүтээх үүргийг мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж хүлээнэ. Түүнчлэн мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж нь энэхүү үүргээ баталгаажуулсан албан бичгийг банканд хүлээлгэж өгнө.

8.13. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдох зардлыг банк бүрэн хариуцна.

8.14. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэр гарах бөгөөд хурал дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор хурлын шийдвэр, тэмдэглэлийг албажуулж, хурлын дарга гарын үсэг зурах бөгөөд хурлын дарга тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцна.

8.15. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлд тусгах мэдээлэл, санал хураалтын дүнг зарлах болон бусад тэмдэглэлтэй холбоотой харилцааг Компанийн болон Банкны тухай хуульд заасны дагуу зохицуулна.

8.16. Банк нь ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр боловсруулж, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн хэрэгжүүлж болно.

СЗХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭВ-03

**9. Төлөөлөн Удирдах зөвлөл**

9.1.Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт банкны эрх барих байгууллага нь ТУЗ байна. ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, чиг үүрэг, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг зэргийг Компанийн тухай болон Банкны тухай хуульд нийцсэн "Төлөөлөн Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-аар тогтоох бөгөөд уг журмыг ТУЗ батлан мөрдүүлнэ.

9.2.Банкны ТУЗ нь 9 (ес) гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 3 (гурав) нь хараат бус гишүүн байна.

9.3.ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 1 (нэг) жил байна. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа сонгогдсоноос хойш болох хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд ТУЗ-ийн гишүүнийг хэдэн ч удаа улируулан сонгож болно.

9.4.ТУЗ-ийн гишүүнд урамшуулал олгож болох бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно. Урамшуулалтай холбоотой асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

9.5.Удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл ТУЗ түр томилж болно. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох үндэслэлийг хууль, Банкны дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

9.6.Банкны тухай хуулийн 31.4-т заасан ТУЗ-ийн дарга, гишүүний үүргийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заавал тусгасан байна.

9.7.ТУЗ нь Банкны дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурал, Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхэд хамааруулснаас бусад асуудал буюу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 9.7.1. Банкны үйл ажиллагааны үндсэн чиглэл, стратегийг тодорхойлох, хянан үзэж түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, эрсдэлийн удирдлагын бодлого, жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах;
- 9.7.2. Банкны зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;
- 9.7.3. Банкны үндсэн үйл ажиллагаа санхүүжүүлэх, стратеги, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд арилжааны эх үүсвэр татан төвлөрүүлэх;
- 9.7.4. Банкны Гүйцэтгэх захиралтай нэг жилийн хугацаатай гэрээ байгуулж, гэрээний нөхцөл, бүрэн эрх, түүнд олгох цалин, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох, ажлын гүйцэтгэлийг хэмжих санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт бүрэн хангагдсан тохиолдолд гэрээг сунгах;
- 9.7.5. Банкны Гүйцэтгэх захирал болон бусад шийдвэр гаргах шатны удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, ажлын үр дүнгийн тайланг тодорхой цаг хугацааны давтамжтайгаар авч хэлэлцэх, шаардлагатай гэж үзсэн асуудлаар тайлбар гаргуулан авах;
- 9.7.6. Монголбанкны зөвшөөрснөөр банкны гүйцэтгэх захирлыг томилох, түүний бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
- 9.7.7. Банкны хөндлөнгийн Аудитын талаар баримтлах бодлогыг тодорхойлох, хөндлөнгийн аудитыг сонгож, гэрээ байгуулах эрх олгох;
- 9.7.8. Ногдол ашгийн хэмжээг тогтоож, төлөх журмыг батлах;
- 9.7.9. Банкны бүтэц, зохион байгуулалтыг батлах;
- 9.7.10. Банкны эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох;
- 9.7.11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- 9.7.12. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийг тодорхойлох бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
- 9.7.13. Өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД НО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

СЗХ 2022 .09. 21 БҮРТГЭЛ № 01
2022 -09- 14 БҮРТГЭЛ-03

9.7.14. Банкны зохистой засаглалын бодлого, журмыг тогтоож хэрэгжилтэд хяналт тавих;
9.7.15. Банкны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудит, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хамарсан зохистой хяналтын тогтолцоог бүрдүүлэх;
9.7.16. Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;
9.7.17. Салбар, тооцооны төв, тооцооны касс, төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах;
9.7.18. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам батлах;
9.7.19. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг батлах;
9.7.20. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон банкны засаглалын дотоод журмуудыг батлах;
9.7.21. Компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
9.7.22. Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
9.7.23. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
9.7.24. Эрх бүхий албан тушаалтны банканд учруулсан хохирлын талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;
9.7.25. Өөрийн хөрөнгийн хэмжээгээр барьцаалан тодорхой хугацааны дараа тогтоосон хүү төлж, эргүүлэн худалдаж авах нөхцөлтэй өрийн бичгийг гаргах;
9.7.26. Зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, энэхүү Дүрэмд заасан бусад үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэр гаргах;
9.7.27. Банкны дотоод аудитын нэгжийг гүйцэтгэх захирлаас хараат бусаар зохион байгуулж, түүний төсөв, орон тоог батлах, удирдлага, ажилтныг томилох, үйл ажиллагааны журмыг тогтоох, цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
9.7.28. Банкны дотоод аудитын нэгжээс хийсэн шалгалтын акт материал, ажлын тайлан зэргийг цаг тухайд нь авч хэлэлцсэний үр дүнд зохистой удирдлага болон дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгох талаар банкны удирдлагад үүрэг даалгавар өгөх, авсан арга хэмжээний үр дүнг тооцох;
9.7.29. Банкны тухай хуулийн 37, 38 дугаар зүйлд заасан санхүүгийн тайлан, бусад мэдээллийг нийтэд мэдээлэх явцад хяналт тавих;
9.7.30. Банкны болон ТУЗ-ийн дэргэдэх Хороодын үйл ажиллагааны журмыг батлах
9.7.31. Банкны гүйцэтгэх удирдлагаас бусад шийдвэр гаргах шатны удирдлага /Газрын захирал, түүнээс дээш албан тушаалтан/-ыг томилох, чөлөөлөхөд Гүйцэтгэх захиралд зөвшөөрөл өгөх;
9.7.32. Банкны Дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал, түүнчлэн Компанийн тухай хууль, банкны дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурал, гүйцэтгэх удирдлагын эрхэд хамааруулснаас бусад буюу ТУЗ шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх.

9.8. ТУЗ нь хууль тогтоомжид зөвхөн ТУЗ хэрэгжүүлэхээр зааснаас бусад бүрэн эрхээ Гүйцэтгэх захиралд хариуцуулан гүйцэтгүүлж болно.
9.9. ТУЗ-ийн үйл ажиллагаа явуулах хэлбэр нь ТУЗ-ийн хурал байна. Шаардлагатай тохиолдолд хурлыг цахим хэлбэрээр хийж болох бөгөөд хурлыг техник хэрэгсэл ашиглан баримтжуулна.
9.10. ТУЗ-ийн хурлыг сард нэгээс доошгүй удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн дарга, Банкны Гүйцэтгэх захирлын санаачилгаар эсвэл ТУЗ-ийн дэргэдэх хорооны саналаар нэмэлт хурал хуралдуулж болно.
9.11. ТУЗ-ийн хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүд бүр саналын нэг эрхтэй байна.ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хурал хүчин төгөлдөр болж,



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

СЗХ
2022.09.21
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ-03

хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхын саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.

9.12. ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.

9.13. ТУЗ хурлаас тогтоол гаргах бөгөөд түүнд ТУЗ-ийн хурлын дарга гарын үсэг зурж, банкны тэмдэг дарж баталгаажуулна. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд оролцсон бүх гишүүд гарын үсэг зурна.

9.14. Банкны ТУЗ нь хувьцаа эзэмшигчдэд зориулан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан бичиж хүргүүлэх бөгөөд тайланд дараах зүйлийг тусгана:

9.14.1. Тайлангийн хугацаанд банкны эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, бүтэц, зохион байгуулалт, түүний өөрчлөлт;

9.14.2. Тайлангийн хугацаанд банкны эрх бүхий албан тушаалтанд олгосон шагнал урамшуулал удирдлагын зардлын хэмжээ;

9.14.3. Хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.

9.15. Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасны дагуу банк, түүний харилцагч болон гуравдагч этгээдийн "нууц" гэж үзсэн аливаа мэдээллийг задлах, ашиглахыг банкны ТУЗ-ийн дарга, гишүүдэд хориглоно. Банкнаас олгосон зээлийн талаарх банк хоорондын мэдээлэл хамаарахгүй болно.

10. **Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга**

10.1. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос тэдгээрийн олонхын саналаар сонгоно.

10.2. Банкны ТУЗ-ийн дарга нь бусад гишүүдтэй адил эрх эдлэхээс гадна ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлж, хяналт тавина.

10.3. ТУЗ-ийн даргын түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын томилсон, эсхүл ТУЗ-ийн томилсон аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

11. **Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүн**

11.1. ТУЗ-ийн гишүүнд ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо нь Банкны тухай хуульд заасан дараах шалгуурыг хангасан хүнийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу сонгон шалгаруулж ХЭХ-д нэр дэвшүүлнэ:

11.1.1. Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй;

11.1.2. Эдийн засаг, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;

11.1.3. Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь банкийг удирдахад харшлахгүй байх;

11.1.4. Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын эрх бүхий албан тушаалтан бол сонирхлын зөрчилгүй, банкны шийдвэр гаргах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөргүй байх;

11.1.5. Зөрчлийн улмаас банк ба банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөл хүчингүй болох үед эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш гурван жил өнгөрсөн байх;

11.1.6. Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээсэн бол үүнээс хойш гурван жил өнгөрсөн байх.

11.1.7. Дээд боловсролтой, банк, санхүү, эдийн засаг, хууль эрх зүй, мэдээллийн технологи, компанийн засаглалын чиглэлээр мэргэшсэн, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүнээс таваас доошгүй жил банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаал хашсан туршлагатай байх.



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

11.2. Төрийн өмчийн оролцооны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн Банкны ТУЗ-ийн бүрэлдэхүүнд төрийг төлөөлөх гишүүний нэрийг Сангийн яамнаас "Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо"-нд санал болгох бөгөөд "Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо" тэрхүү нэр дэвшигдэж байгаа этгээд нь хууль болон энэхүү дүрэмд заасан шаардлага хангасан бол ТУЗ гишүүнээр томилуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд оруулах үүрэгтэй.

11.3. Энэхүү Дүрмийн 11.2-т заасны дагуу сонгогдсон ТУЗ-ийн гишүүн нь бусад гишүүдийн адил эрх, үүрэгтэй байхаас гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан дараах нэмэлт эрх, үүргийг хүлээнэ:

11.3.1. Гишүүдийн болон ТУЗ-ийн хуралд таслах эрхтэй оролцох;

11.3.2. Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах;

11.3.3. Олгогдсон эрх хэмжээнийхээ дотор төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх.

**12. Төлөөлөн Удирдах зөвлөлийн хараат бус гишүүн**

12.1. ТУЗ нь хараат бус гишүүнтэй байна. ТУЗ-ийн хараат бус гишүүнд Компанийн тухай хууль болон Банкны тухай хууль, Монголбанкны "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам"-д заасан дараах шалгуурыг хангасан хүний нэрийг ТУЗ-ийн нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо дэвшүүлнэ:

12.1.1. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран банкны энгийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэггүй;

12.1.2. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь банкны болон банкны оролцогч болж байгаа нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;

12.1.3. Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй;

12.1.4. Банктай бизнесийн аливаа холбоогүй;

12.1.5. Банкны эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолгүй, тэдгээрийн төрөл, садан, гэр бүлийн гишүүн биш;

12.1.6. Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй;

12.1.7. Эдийн засаг, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;

12.1.8. Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь банкийг удирдахад харшлахгүй байх;

12.1.9. Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын эрх бүхий албан тушаалтан бол сонирхлын зөрчилгүй, банкны шийдвэр гаргах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөргүй байх;

12.1.10. Зөрчлийн улмаас банк ба банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөл хүчингүй болох үед эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш гурван жил өнгөрсөн байх;

12.1.11. Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээсэн бол түүнээс хойш гурван жил өнгөрсөн байх.

12.1.12. Банк, санхүү, эдийн засаг, хууль эрх зүйн чиглэлээр дээд боловсролтой, мэргэшсэн, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүний таваас доошгүй жилд банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажилласан туршлагатай;

12.1.13. Тухайн банк, түүний нэгдлийн оролцогчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч биш байх;
12.1.14. Тухайн банк, түүний нэгдлийн оролцогчид сүүлийн таван жилийн хугацаанд ТУЗ-ийн хараат бус гишүүнээс бусад эрх бүхий албан тушаалтан, сүүлийн гурван жилийн хугацаанд бусад ажилтнаар тус тус ажиллаж байгаагүй;
12.1.15. Тухайн банкны үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтээс хамаарч урамшуулал авч байгаагүй, авдаггүй байх;
12.1.16. Банкны үйл ажиллагаа, гүйцэтгэх захиралд хяналт тавихад саад учруулах аливаа нөхцөл байдал үүсээгүй байх;
12.1.17. Төрийн, улс төрийн болон төрийн жинхэнэ албан тушаал хашдаггүй байх;
12.1.18. Эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тухайн этгээдээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон байх;
12.1.19. Банкны тухай хуулийн 33.3.2-33.3.3-т заасан этгээдийн холбогдох этгээд биш байх;
12.1.20. Хууль тогтоомжид заасан бусад шаардлага.

12.2.ТУЗ-ийн хараат бус гишүүн нь бусад гишүүдийн адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүргийг хүлээнэ:
12.2.1. ТУЗ, гүйцэтгэх захирлын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь тухайн компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, Дүрэм, журамд нийцэж буй эсэхэд хяналт тавих, зөрчихөөс урьдчилан сэргийлэх, зөрчсөн тохиолдолд холбогдох этгээдэд тавьж шийдвэрлүүлэх, шаардлагыг эс биелүүлбэл ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах шаардлага хүргүүлэх;
12.2.2. Банкны үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх захиралд үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;
12.2.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн зарим шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлэх эрхтэй;
12.2.4. Банкны нөхцөл байдал, ТУЗ, гүйцэтгэх захирлын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэрийн талаар хувьцаа эзэмшигчдээс асуусан асуултад хариу өгөх, тодруулга хийх;
12.2.5. Компанийн тухай хуульд заасан бусад эрх, үүрэг.

12.3.Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүд дараах асуудлыг хэлэлцэхэд заавал оролцож саналаа өгнө. Үүнд:
12.3.1. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
12.3.2. Санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
12.3.3. Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох.

**13. Төлөөлөн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга**

13.1.ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилно.
13.2.ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурал ба ТУЗ-ийн бичиг хэргийг хариуцан хөтлөх, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх зэрэг ТУЗ-ийн журмаар тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлнэ.
13.3.Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах бөгөөд хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл болон гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэх, хүргэх ажлыг зохион байгуулна.

СЭХ он 2022 сар 04 өдөр 21 БҮРТГЭВ № 01

13.4. Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг хөтлөх, гарах шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавина.

13.5. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах ажлыг зохион байгуулна.

13.6. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эзгүйд түүний үүргийг орлох этгээдийг ТУЗ-ийн дарга томилно.

13.7. Банкны ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг хариуцан зохицуулна.

**14. Төлөөлөн Удирдах зөвлөлийн дэргэдэх хороо**

14.1. ТУЗ нь Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Эрсдэл /комплаенс/-ийн удирдлагын хороо гэсэн байнгын хороодтой байна.

14.2. Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Эрсдэл /комплаенс/-ийн удирдлагын хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.

14.3. Банкны ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороо байгуулан ажиллуулж болно.

14.4. Эрсдэл /комплаенс/-ийн удирдлагын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна:

14.4.1. Эрсдэлийн удирдлагын бодлого, зохицуулалтын орчныг тодорхойлох;

14.4.2. Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг оновчтой удирдан чиглүүлэх;

14.4.3. Банкны үйл ажиллагааны гүйцэтгэл, эрсдэлийн түвшинд хяналт тавих.

14.5. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна:

14.5.1. Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

14.5.2. Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах;

14.5.3. Аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;

14.5.4. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;

14.5.5. Аудитын хорооны үйл ажиллагааны журам, аудитын бодлогын баримт бичгийг боловсруулж, ТУЗ-өөр батлуулж хэрэгжүүлэх;

14.5.6. Банкны Дүрэмд заасан болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

14.6. Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна :

14.6.1. Банкны ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх захиралд нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;

14.6.2. Монголбанкны "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам"-ын дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулж, нэр дэвшүүлэх;

14.6.3. ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх захиралд нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүний хувьд энэ Дүрэм болон Компанийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;

14.6.4. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;

14.6.5. ТУЗ болон Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ БУМСЕНТ ҮЦК ХХК

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ-03

14.6.6. Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;

14.6.7. ТУЗ-ийн гишүүнээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд Гүйцэтгэх захирлаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;

14.6.8. Компанийн тухай хуулийн 59.5-д заасан үндэслэлээр ТУЗ-ийн бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш гурван жилийн хугацаанд тухайн ТУЗ-ийн гишүүн байсан этгээдийн нэрийг аливаа хувьцаат компанийн ТУЗ-ийн гишүүнд дэвшүүлэхээс татгалзах;

14.6.9. Банкны ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

14.6.10. ТУЗ болон Гүйцэтгэх захирал, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;

14.6.11. Банканд мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон банкны урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;

14.6.12. ТУЗ-д нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичиг, цалин урамшууллын журам, цалин урамшууллын бодлогын баримт бичгийг боловсруулж ТУЗ-өөр батлуулж, хэрэгжүүлэх.

14.7. ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журмаар тогтооно.

## 15. Гүйцэтгэх захирал

15.1. Банкны гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

15.2. Гүйцэтгэх захирал нь банкны Дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажлаа ТУЗ-д тайлагнана.

15.3. Банкны гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болох бөгөөд ТУЗ-ийн дарга байхыг хориглоно.

15.4. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн зөвшөөрөлгүйгээр өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад давхар ажиллахыг хориглоно.

15.5. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан онцгой нөхцөл бүхий гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Гэрээнд Гүйцэтгэх захирлын эрх үүрэг, хариуцлагын хэмжээ, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хэрэгжүүлэх ажил үүргийн хуваарь, хэрэгжүүлэх ажлын чиглэл, цалин хөлс, хугацаа, гэрээ дүгнэх шалгуур, шагнал, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.

15.6. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, банкийг төлөөлөх зэргээр банкны нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

15.7. Гүйцэтгэх захирал нь Банкны үйл ажиллагааг удирдан зохион байгуулахдаа Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, зохистой эрсдэлийн түвшинд компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдах зохион байгуулах зарчмыг баримталж ажиллана.

15.8. Гүйцэтгэх захирал нь банкны үйл ажиллагааг холбогдох хууль эрх зүйн орчин, энэхүү Дүрэм, стратеги, бизнес төлөвлөгөө, жил бүрийн санхүү, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв болон ТУЗ-ийн шийдвэрээр түүнд олгосон эрх хэмжээний хүрээнд удирдах бөгөөд сар, улирал, жилийн тайлан, шаардлагатай бусад тайлант ТУЗ, Хувьцаа эзэмшигчид болон холбогдох байгууллагад тухай бүр хүргүүлнэ.

15.9. Банкны дүрэм, стратеги зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар Гүйцэтгэх захиралд зөвлөх үүрэгтэй Удирдлагын хороод ажиллана.

15.10. Гүйцэтгэх захирал ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай саналыг ТУЗ-ийн дарга болон гишүүнд гаргаж болно.

15.11. Гүйцэтгэх захирал ажлаа ТУЗ-д тайлагнана.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

СЗХ 2022 .09. 21 өдөр БҮРТГЭВ № 01
2022-09-14 БҮРТГЭВ-03

15.12. Гүйцэтгэх удирдлага нь төрийн болон хувийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлд орох, тэдгээрийн захиргаанд, төрийн бус байгууллага болон шашны байгууллага, сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно.

15.13. Гүйцэтгэх захирал нь ээлжийн амралт эдлэх, гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, чөлөө авах, өвчлөх тохиолдолд өөрийн эрх, үүргийг бүхэлд нь Банкны Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу эрх бүхий этгээдэд зөвхөн ТУЗ-ийн зөвшөөрлөөр шилжүүлнэ. Түүнчлэн, Гүйцэтгэх захирал тодорхой бүрэн эрхээ банкны холбогдох албан тушаалтнууд болон ажилтнуудад итгэмжлэн хариуцуулж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй. Гүйцэтгэх захирал нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх, Банкны тухай хуульд заасан болон Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах талаар хүлээсэн үүргээ санаатай тасалдуулсан, энэхүү дүрэм, гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлээгүй, тэдгээрийг ноцтой зөрчсөн тохиолдолд ТУЗ нь Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцөн түүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудлыг шийдвэрлэж тогтоол гаргана. Гүйцэтгэх захирал нь ажлаас чөлөөлөгдөхдөө хүндэтгэн үзэхээс бусад тохиолдолд үүрэгт ажлаа өөрийн биеэр биечлэн хүлээлгэн өгнө.

15.14. Гүйцэтгэх захирал нь дараах шалгуурыг хангасан байна:

15.14.1. Банк, санхүү, эдийн засгийн дээд боловсролтой, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүний таваас доошгүй жилд банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай;

15.14.2. Банк, банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнтэй сонирхлын зөрчилгүй, нэгдмэл сонирхолтой этгээд биш байх;

15.14.3. Бусад банк, түүний нэгдэл, эсхүл банктай харилцан хамаарал бүхий санхүүгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан биш байх;

15.14.4. Монголбанкны эрх бүхий албан тушаалтнаар сүүлийн хоёр жилийн хугацаанд ажиллаагүй байх;

15.14.5. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхээ хасуулаагүй байх;

15.14.6. Банкны хууль тогтоомж, Монголбанкны шийдвэрийг ноцтой зөрчиж байгаагүй;

15.14.7. Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй;

15.14.8. Төрийн эсрэг болон эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;

15.14.9. Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь банкийг удирдахад харшлахгүй байх;

15.14.10. Монголбанкнаас тогтоосон банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон удирдлагын чадварыг хангаж ажиллах;

15.14.11. Хууль тогтоомжид заасан бусад шаардлага.

15.15. Гүйцэтгэх захирал нь дор дурдсан үүрэг хүлээж, эрх эдэлнэ:

15.15.1. Банкны стратегийн төлөвлөгөө болон эрсдэлийн удирдлагын талаарх дотоод заавар, дүрэм, журмыг боловсруулж ТУЗ-д өргөн барьж, батлуулах;

15.15.2. ТУЗ-өөс баталсан стратеги төлөвлөгөөг болон дүрэм, журам, заавар, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах;

15.15.3. Банкны үндсэн үйл ажиллагаа болон эрсдэлийн талаарх бүхий л заавар журам болон стандартыг ажилтнуудаараа мөрдүүлэн хэвшүүлэх, энэ талаар зохих гарын авлага болон зөвлөмжийг баталсан байх;



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

15.15.4. Банкны дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн жигд ажиллагааг ханган ажиллах;

15.15.5. Дотоод хяналтын тогтолцоонд гажуудал үүссэн, эрсдэлийн удирдлагыг хангах талаар тогтоосон үйл ажиллагааны хязгаарлалт зөрчигдсөн бол холбогдох мэдээллийг цаг тухайд нь авч, зохих арга хэмжээг авах;

15.15.6. Банкны үндсэн эрсдэлүүдэд тогтмол хяналт тавьж, зохистой түвшинд барих талаар санаачилга гарган ажиллах;

15.15.7. Банкны дотоод хяналтын тогтолцоо болон үйл ажиллагааны зохистой хэм хэмжээг хангаж ажилласан байдалд үнэлэлт дүгнэлт өгөх;

15.15.8. Банкны үйл ажиллагааны онцлог болон хүлээж болох эрсдэлийн нэр төрөлтэй уялдаатай удирдлагын мэдээллийн тогтолцоог бий болгох;

15.15.9. Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, Банкны хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, тухайн жилийн бизнес төлөвлөгөө, ТУЗ болон Монголбанкны шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

15.15.10. Хууль тогтоомж, банкны дүрэмд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;

15.15.11. Харилцагч, үйлчлүүлэгчдийн өмнө хүлээсэн үүргийг биелүүлэх, өөрийн банкны санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

15.15.12. Банкнаас мөрдөх хадгаламж, зээлийн хүү, төлбөр тооцоо, үйлчилгээний үнэ тарифыг тогтоон, мөрдөж ажиллах;

15.15.13. Банкны үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;

15.15.14. Гүйцэтгэх захирал нь хууль тогтоомж, гэрээгээр тогтоосон эрх хэмжээний хүрээнд Банкны нэрийн өмнөөс гэрээ, хэлэлцэл байгуулах, гарын үсэг зурах, баталгаа, батлан даалт гаргах, банкны эрх ашгийг төлөөлөх зэргээр итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах;

15.15.15. Банкнаас хөрөнгө захиран зарцуулах төлбөрийн баримтад гарын үсэг зурах;

15.15.16. Банканд учруулсан хохирлыг төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах, банканд холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон оролцуулах;

15.15.17. Банкны нэгжийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээ, нэг этгээдэд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох, зээлийн үлдэгдэлд хязгаарлалт хийж, хяналт тавих;

15.15.18. Банк, банкны хадгаламж эзэмшигчид, харилцагчийн эрх ашгийг хувийн эрх ашгаасаа илүүд тавьж, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан банк, түүний салбар, тооцооны төв, кассуудын үйл ажиллагааг зохицуулан удирдах;

15.15.19. ТУЗ-өөс баталсан зардлын хэмжээнд багтаан банкны ажилтнуудын орон тоо, үндсэн болон нэмэгдэл цалин, тэтгэмж, хөнгөлөлт, урамшууллын хэмжээг тогтоох;

15.15.20. Ажилтнуудын ажил үүргийн хуваарийг тогтоох, ажилтныг ажилд авах, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах, дуусгавар болгох;

СЭХ
он 2022 сар 09 өдөр 21
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК

15.15.21. Банкны газар, нэгж, салбар, тооцооны төв, касс, төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах, тэдгээрийн удирдлага, ажилтнуудыг ажилд авах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах, дуусгавар болгох;

15.15.22. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах;

15.15.23. Банкны ажилтнуудын хувьд өөрт ногдсон үүргээ аливаа ашиг сонирхлын зөрчилгүйгээр гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх;

15.15.24. Гүйцэтгэх захирал нь үүрэг гүйцэтгэх явцад олж авсан банк, банкны харилцагчийн талаарх мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;

15.15.25. Хувийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй байх;

15.15.26. Өөрт нь болон өөртэй нь холбогдох этгээдэд тухайн банктай бизнесийн харилцаанд орсон этгээдийн санхүүгийн үр дүнг сонирхох шалтгаан байгаа бол сонирхлын зөрчил байна гэж үзэж, энэ тухайгаа төлөөлөн удирдах зөвлөл, түүний нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэх;

15.15.27. Банкны нууцад хамаарах зүйлийн жагсаалтыг батлах;

15.15.28. Энэхүү дүрэмд болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан үүргээ биечлэн гүйцэтгэх, эсхүл хариуцсан захирлууд зэрэг албан тушаалтнуудад эрхээ шилжүүлэх замаар гүйцэтгүүлэх;

15.15.29. Санхүүжилт, зээлтэй холбогдсон хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээртэй байгуулсан гэрээний үндсэн дээр холбогдох мэдээ, тайланг харилцагчаас шаардан авах, тэдний тайлан тэнцэлтэй танилцах, шалгах, хууль тогтоомжийн дагуу хөрөнгийг барьцаанд авах, дансны гүйлгээг түр хаах;

15.15.30. Банкны санхүүгийн тайлан, тэнцэл, бусад төрлийн мэдээний үнэн зөвийг хариуцах;

15.15.31. Хууль тогтоомж болон гэрээнд заасан бусад эрх, үүрэг.



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
2022 04 21
БҮРТГЭВ
№ 01



**16. Банкны ажилтан**

16.1.Банк нь өөрийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх зорилгоор банкны ажилтнуудыг сургаж бэлтгэх, давтан сургах, тэдгээрийг тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллуулах нөхцөлийг бүрдүүлж, шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангана.

16.2.Банк болон ажилтнуудын хоорондын харилцааг Хөдөлмөрийн хууль, бусад хууль тогтоомж, банкны хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээ, онцгой нөхцөл бүхий гэрээгээр зохицуулна.

16.3.Банкны ажилтнууд дараах шаардлагыг хангаж ажиллана:

16.3.1. Аливаа байгууллага, аж ахуйн нэгжийн ашиг сонирхлыг төлөөлөхгүй байх;

16.3.2. Албан үүрэгтээ үнэнч шударга хандаж, банкны үйл ажиллагаа, тогтоосон горимд харш байдлаар өөртөө, гэр бүл, төрөл төрөгсөд, ажил төрлийн болон хувийн харьцаатай хүмүүст хуулиас гадуур давуу байдал олгохгүй байх;

16.3.3. Харилцагчийн данс, зээл, төлбөр тооцоо, бизнесийн ажиллагаатай холбоотой албан материал, тоон үзүүлэлт, дотоод дүрэм, журам, заавар нөхцөлүүдийг хууль тогтоомж, дотоод заавар, журамд зааснаас бусад тохиолдолд бусдад танилцуулах, ашиглуулах, нууцлалыг алдагдуулах, хувийн хэрэгцээнд ашиглахгүй байх.

16.3.4. Банкны ажилтан нь хууль тогтоомжийн хүрээнд банкны хөрөнгийн чадвар, боломжийн хэмжээнд нийгмийн баталгаагаар хангагдана.

16.4.Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасны дагуу банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд “нууц” гэж үзсэн аливаа мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд задруулах, ашиглахыг ТУЗ-ийн дарга, гишүүн, Гүйцэтгэх захирал, ажилтанд хориглоно.

**17. Дотоод хяналт**

17.1.Банкны Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТУЗ өөрийн аудитын хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

17.2.Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооноос санал болгосноор ТУЗ-ийн томилсон Дотоод аудитын газар хэрэгжүүлнэ.

17.3.Банкны дотоод аудитын газар нь банкны бодлого, тухайн жилийн бизнес төлөвлөгөө, төсөв, үйл ажиллагаанд мөрдөх журмын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан зөв эсэхэд хяналт тавьж, актив хөрөнгийг хамгаалан үр ашгийг дээшлүүлэх чиг үүрэгтэйгээр банкны ТУЗ-д ажлаа тайлагнах зарчмаар ажиллана.

17.4.Дотоод аудитын газар нь банкны үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, комплаенс, санхүү бүртгэл, эрх зүйн мэдлэг, туршлагатай ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ТУЗ-аас баталсан Дотоод хяналтын дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.

17.5.Банкны дотоод аудитын газар нь бүх нэгжийн үйл ажиллагааг шалгах эрхтэй, бие даасан, хараат бус байж дараах үүргийг хэрэгжүүлнэ:

17.5.1. Банкны гүйцэтгэх шатны удирдлага нь ТУЗ-өөс баталсан бодлого болон дүрэм, журмыг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;

17.5.2. Банкны зохистой удирдлага, хяналтын үйл ажиллагаа болон эрсдэлийн удирдлага зэрэг нь тогтоосон хэм хэмжээний хүрээнд явагдаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;

17.5.3. Гүйцэтгэх удирдлагаас банкны хувь нийлүүлэгч болон ТУЗ-д хүргүүлж буй тайлан мэдээ нь үнэн зөв байсан эсэхэд хяналт тавих;

17.5.4. Бодлогын хэрэгжилтийн талаар ТУЗ-д улирал тутам тайлагнах;

17.5.5. ТУЗ болон банкны удирдлага хоорондын харилцаа, ажлын уялдаа холбоог сайжруулах талаар санаачилга гарган ажиллах;



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ТТБ0674 5208173

СЗХ
он 2022 сар 09 өдөр 21
БҮРТГЭВ
№ 01

17.5.6. Банкны эрсдэлийн удирдлагын талаар авсан арга хэмжээ нь хүлээж болзошгүй алдагдал, гэрээ хэлцлийн дүн зэрэгтэй уялдаж байгаа эсэхэд дүгнэлт өгөх;
17.5.7. Банкны нээлттэй позици болон хүлээж болзошгүй эрсдэлийн мөн чанарын талаар нарийвчилсан судалгаа, шинжилгээ хийсэн байх;
17.5.8. Банкны шалгуур үзүүлэлтүүд хангагдаж байгаа эсэх, хангагдаагүй тохиолдолд авсан арга хэмжээнд хяналт тавих;
17.5.9. Банкны удирдлагууд нь банкны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмын талаар зохих хэмжээний ойлголттой байх бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэх талаар хангалттай хэмжээний туршлагатай эсэхийг баталгаажуулах;
17.5.10. Банкны үйл ажиллагаанд үнэлэлт өгч, шаардлагатай бол боловсронгуй болгох талаар тодорхой санал боловсруулж ТУЗ-д танилцуулах.

17.6.Банкны дотоод аудитын газар нь шалгалтын талаар дэлгэрэнгүй танилцуулга, тайлан материал үйлдэж, ТУЗ-д тайлагнаж, банкны Гүйцэтгэх захиралд танилцуулна.

**18. Хөндлөнгийн аудит**

18.1.Аудитын тухай хуульд заасны дагуу Банк нь санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор хөндлөнгийн аудитын байгууллагыг ТУЗ сонгож, түүнтэй заавал гэрээ байгуулж ажиллуулна.

18.2.ТУЗ–ийн дэргэдэх аудитын хороо нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хөндлөнгийн аудитын талаар баримтлах бодлогын дагуу СЗХ-нд бүртгүүлсэн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална.

18.3.Дараах этгээдийг банкны хөндлөнгийн Аудитоор сонгон ажиллуулахыг хориглоно:
18.3.1. Банкны нэгдмэл сонирхолтой этгээд, банкны эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд, банкны буюу нэгдмэл сонирхолтой банкны эрх бүхий албан тушаалтан,
18.3.2. Банкны болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, эсвэл банкны болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшдэг,
18.3.3. ТУЗ-өөс тухайн этгээд нь аудитороор ажиллахад харшилна гэж үзсэн үндэслэл бүхий бусад нөхцөл.

18.4.Аудитын байгууллагатай байгуулах гэрээнд банкны болон аудитын байгууллагын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заасан байна.

18.5.Аудитын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.

18.6. Банкны санхүүгийн жилийн тайланг баталгаажуулахын тулд ээлжит шалгалт хийнэ.

18.7.Ээлжит бус шалгалтыг ТУЗ, эсвэл нийт хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигчдийн шаардлагаар хэдийд ч хийж болно. Шалгалтын явцад эрх бүхий албан тушаалтан банк болон хувь эзэмшигчдэд хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээд төлөх ба бусад тохиолдолд банк өөрөө буюу шаардлага тавьсан талууд хариуцна.

**19. Банкны санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл тайлан**

19.1.Банкны санхүүгийн жил нь жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, тухайн жилийн 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна.

19.2.Банкны санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан хэвлүүлнэ.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341409 ГС75282
УЛААНБААТАР ХОТ
ТУЛХҮҮР ҮЦК ХХК
ТТ58674 5208173

СЭХ
он 2022 сар 09. 21
БҮРТГЭВ
№ 01

19.3.Санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдэнэ.

19.4.Банкны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон эрх бүхий байгууллагын журмаар тогтоосон мэдээ, тайлангийн үнэн зөвийг банкны Гүйцэтгэх захирал хариуцна. Санхүүгийн мэдээллийн үнэн зөвийг Гүйцэтгэх захирал, Санхүүгийн асуудал хариуцсан захирал хамтран хариуцна.

19.5.Банкны санхүүгийн тайлан нь дараах шаардлагыг хангасан байна:

19.5.1. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд нь олон улсын жишгийг үндэслэн Монголбанкнаас тогтоосон нягтлан бодох бүртгэлийн зарчимд нийцсэн байх;

19.5.2. Санхүүгийн тайланг энэхүү дүрмийн 19.2-т заасны дагуу үнэн зөв гаргасан гэдгээ албан ёсоор нотолсон баримт бичиг үйлдэн огноог тэмдэглэж, банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх захирал, Санхүүгийн асуудал хариуцсан захирал гарын үсгээ зурж, тэмдэг дарсан байх.

19.6.Банк нь санхүүгийн тайлан, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, хадгаламж, зээл, төлбөр тооцооны болон бусад мэдээнүүдийг Монголбанкнаас баталсан заавар, журам, маягтын дагуу сар, улирал, жилээр гаргаж Сангийн яам, Монголбанкинд тогтоосон хугацаанд нь хүргүүлнэ. Монголбанкнаас шаардсан Банкны санхүүгийн тайлантай холбогдсон нэмэлт мэдээлэл баримтыг гаргаж өгнө.

19.7.Банк нь энэ дүрмийн 19.3, 19.5-т заасан шаардлагыг хангасан санхүүгийн тайланг улирал тутам, аудитаар баталгаажуулсан тухайн жилийн санхүүгийн тайланг дараа оны 1 дүгээр улиралд багтаан хэвлэн нийтэлнэ.

19.8. Банк нь энэ дүрмийн 19.7-д заасан тайлангаас гадна Банкны тухай хуулийн 38.2 дахь хэсэгт заасан мэдээллийг нийтлэх, өөрийн цахим хуудсанд байрлуулах зэргээр шийдвэр гарснаас хойш тав хоногийн дотор нийтэд мэдээлнэ.

19.9.Банк нь банк, санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн санг давагдашгүй хүчин зүйл, бусад аюулаас сэргийлэх зорилгоор архивын биет болон цахим хэлбэрээр стандартын дагуу хадгалах нөөц төвтэй байна.

19.10. Банк нь жилийн эцсийн санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт, материалаа аудитын байгууллагаар жилд нэгээс доошгүй удаа шалгуулж баталгаажуулан, дүгнэлтийг банкны Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна.

19.11. ТУЗ нь банкны санхүүгийн тайлангийн талаарх хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна.

19.12. Банк Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон нэмэлт, мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрх газруудад тогтоосон хугацаанд нь хүргүүлж байх үүрэгтэй.

**20. Их хэмжээний хэлцэл**

20.1.Их хэмжээний хэлцэлд дараах хэлцлийг тооцно. Үүнд:

20.1.1. Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /банкны өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/,

20.1.2. Банкны урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсвэл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт.

20.2.Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг ТУЗ-ийн саналын эрхтэй гишүүд санал нэгтэйгээр гаргана. ТУЗ их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтэйгээр гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд

СЭХ
он 2022 сар 09 27
БҮРТГЭВ
№ 01

оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

20.3. Их хэмжээний хэлцлийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ тогтооно.

20.4. Их хэмжээний хэлцэл мөн эсэхийг тодорхойлохдоо ТУЗ нь Аудитын зөвлөмжийн дагуу эд хөрөнгийн балансын үнийг инфляцийн /мөнгөний ханшны уналт/ түвшинтэй зохицуулан шинэчилж дахин тогтоож болно.

## 21. Сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийх хэлцэл

21.1. Нэгдмэл сонирхолтой этгээд, түүнтэй хийх хэлцлийг тодорхойлох Банкны үйл ажиллагаан дахь сонирхлын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг тусдаа журмаар зохицуулна. Уг журмыг ТУЗ батална.

21.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад санал өгөх эрхгүй байна.

21.3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн олонхын саналаар гаргана.

21.4. Банк өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжийг хангах үүрэгтэй.

21.5. Банк тухайн тайлангийн хугацаанд байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн дүнгийн талаарх мэдээллийг тухайн жилийн тайланд тусган нийтэд мэдээлэх үүрэгтэй.

## 22. Банкны эрх бүхий албан тушаалтан, хүлээх хариуцлага

22.1. Банкны эрх бүхий албан тушаалтанд ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн гишүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Ерөнхий эдийн засагч, Зээлийн асуудал хариуцсан захирал, Иргэдийн банк, Байгууллагын банкны асуудал хариуцсан захирал, Хөрөнгө зохицуулалтын асуудал хариуцсан захирал, Санхүүгийн асуудал хариуцсан захирал, Төлбөр тооцоо, тайлан мэдээ, бүртгэл хариуцсан захирал, Үйл ажиллагааны асуудал хариуцсан захирал, Эрсдэлийн удирдлагын асуудал хариуцсан захирал, Бизнесийн эрсдэл хариуцсан захирал, Салбарын удирдлагын асуудал хариуцсан захирал, Бүтээгдэхүүн, маркетинг, олон нийтийн асуудал хариуцсан захирал, Худалдан авалтын асуудал хариуцсан захирал, Даатгалын асуудал хариуцсан захирал, Төлөөлөгчийн газрыг хариуцсан албан тушаалтан хамаарна.

22.2. Банкны эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:

- 22.2.1. Компанийн тухай хууль, энэхүү Дүрэм, ТУЗ-өөс баталсан дотоод журам, бодлогын баримт бичигт заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, банкны эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтална;
- 22.2.2. Компанийн тухай хуулийн 99 дүгээр зүйлд заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг банканд гаргаж өгнө;
- 22.2.3. Банкны нууцад хамаарах мэдээ, тайлан, гэрээ, баримт бичиг, материалыг бусдад дамжуулах, задруулахаас сэргийлэх бөгөөд хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй;
- 22.2.4. Шийдвэр гаргах, шийдвэр гаргах ажиллагаанд оролцохдоо холбогдох бүх баримт бичиг, мэдээллийг бүрэн судалж, шийдвэрийн үндэслэлд бүрэн итгэлтэй байх;
- 22.2.5. Шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухайгаа заавал мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцохгүй байх;
- 22.2.6. Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдээс бэлэг урамшуулал авахгүй, аливаа хэлбэрээр нөлөөнд автахгүй байх.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
БУЯНТ ҮЦК ХХК

СЗХ он 2022 сар 09 21 БҮРТГЭВ № 01

2022-09-14 БҮРТГЭВ-03

22.3.Эрх бүхий албан тушаалтан нь албан тушаалаасаа өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн турш энэ Дүрмийн 22.2.3-д заасан үүргийг хүлээнэ.

22.4.Эрх бүхий албан тушаалд нэр дэвших үедээ өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад гарсан өөрчлөлтийн талаар өөрчлөлт гарснаас хойш 10 хоногийн дотор мэдэгдэж байна.

22.5.Эрх бүхий албан тушаалтан нь Дүрмийн 22.2.5-д заасан үүргээ биелүүлээгүйн улмаас компанид хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

22.6.Банкны эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг Компанийн тухай хууль, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөлсөөр ажиллах болон хөдөлмөрийн гэрээ, банкны дотоод журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД

**23. Үнэт цаас худалдах, эргүүлэн авах**

23.1.Банк давуу эрхийн хувьцаа, өрийн хэрэгсэл болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг зохих хууль журамд заасны дагуу гаргаж болно.

23.2.Банк өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр, эсхүл Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу худалдан авч болох бөгөөд энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

23.3.Банк нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь буюу зарим хэсгийг эргүүлэн худалдан авч болно.

23.4.Банк нь үнэт цаас эргүүлэн худалдаж авахдаа худалдаж байгаа этгээдтэй тохиролцсоны дагуу түүний төлбөрийг мөнгөөр хийнэ.

**24. Ногдол ашиг хуваарилан олгох**

24.1. ТУЗ нь ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь заалтад заасан хугацаанд гаргах бөгөөд уг шийдвэрт нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана.

24.2. Нэг төрлийн хувьцаа бүрийн хувьд нэгж хувьцааны ногдол ашгийн дүн нь ижил байна.

24.3. Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн банкны болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

24.4. Ногдол ашгийг банкны татвар төлсний дараах цэвэр ашгаас Ногдол ашгийн бодлогын дагуу хуваарилна.

24.5. ТУЗ нь ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнах үүрэгтэй.

24.6. Банк нь хууль тогтоомжид заасан бүх нөхцөл биелэгдсэн тохиолдолд энгийн хувьцаанд хамаарах ногдол ашгийг хуваарилж болно.

24.7. Банк нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг хуваарилна. Энэ хугацаанд ногдол ашгаа аваагүй нь тухайн хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг авах эрхийг үгүйсгэх, эсхүл банк нь ногдол ашиг олгохгүй байх үндэслэл болохгүй.

24.8. Хуваарилахаар шийдвэрлэсэн ногдол ашгийг ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигч бүрээр түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэж хадгалах бөгөөд банк хувьцаа эзэмшигчийн анхны шаардлагаар ногдол ашгийг олгох үүрэгтэй.



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ТУЛГАТ ҮЦК ХХК

СЗХ он 2022 сар 09 21 БҮРТГЭВ № 01

2022-09-14 БҮРТГЭВ-03

24.9. Банк нь ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

24.10. ТУЗ нь ногдол ашиг хуваарилалтын тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд заавал тайлагнана.

24.11. Хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах буюу бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэл хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн бол ногдол ашиг авах эрх нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол уг хувьцааны хуучин эзэмшигчид үлдэнэ.

24.12. ТУЗ нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, энэ Дүрэмд нийцүүлэн Ногдол ашгийн бодлого батална.

## 25. Банкийг өөрчлөн байгуулах, татан буулгах

25.1. Банкийг өөрчлөн байгуулах, татан буулгах, татан буулгахад өр төлбөрийг барагдуулах асуудлыг Иргэний хууль, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон энэ Дүрэмд заасны дагуу шийдвэрлэнэ.

25.2. Банкийг Монголбанкны зөвшөөрлөөр хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хууль тогтоомжид заасан журмаар татан буулгана.

25.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар банкийг татан буулгахаар шийдвэрлэсэн тохиолдолд ТУЗ-өөс банкийг татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараа банканд үлдэх эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам, банкны бүртгэлд байгаа эд хөрөнгө, үнэт зүйлсийг нягтлан шалгах эрх бүхий хянан шалгах комисс, тэдгээрийн бүрэлдэхүүнийг томилох болон аудитыг сонгох зэргийг тусгасан татан буулгах төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.

25.4. Татан буулгах комисс томилсноор гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ. Уг комисс нь банкийг бүрэн төлөөлж, шүүхэд нэхэмжлэгч, хариуцагч байх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

25.5. Банкийг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай шийдвэрт өөрчлөн байгуулах, татан буулгах комисс, банкны бүртгэлд байгаа эд хөрөнгө, үнэт зүйлсийг нягтлан шалгах эрх бүхий хянан шалгах комисс, тэдгээрийн бүрэлдэхүүнийг томилох болон аудитыг сонгох тухай тусгасан байна.

25.6. Банкийг өөрчлөн байгуулах, татан буулгах зөвшөөрөл авахад Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарснаас хойш 3 /гурав/ хоногийн дотор дор дурдсан баримт бичгийг Монголбанканд хүргүүлнэ:

- 25.6.1. Банкийг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр;
- 25.6.2. Банкийг өөрчлөн байгуулах, татан буулгах шаардлага, хэлбэр, нөхцөл, хугацааг заасан баримт бичиг, банкнаас үйл ажиллагаагаа дуусгавар болгохтой холбогдуулан авах арга хэмжээ, тэдгээрийн хугацаа, үе шат, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;
- 25.6.3. Банкийг өөрчлөн байгуулсны үр дүнд байгуулагдах хуулийн этгээдийн зохион байгуулалт, эрх зүйн хэлбэр, байршил, банкны эрхлэх үйл ажиллагааны төрөл, бизнес төлөвлөгөө, өөрчлөн байгуулалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, тайлан тэнцлийн төсөөллийн тухай шаардлагатай бусад мэдээлэл;
- 25.6.4. Банкийг өөрчлөн байгуулснаас гарах санхүүгийн үр дүнгийн тооцоо, өөрчлөн байгуулсны дараа байгуулагдах банкны эхлэлтийн тайлан тэнцэл.



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ ТУУЛСАН ҮЦК ХХК

25.7. Банкийг татан буулгах тухай шийдвэрийг ТУЗ нь Санхүүгийн зохицуулах хороо болон Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад ажлын 3 өдрийн дотор хүргүүлнэ.

**26. Бусад зүйл**

26.1. Энэхүү Дүрэм нь банкны хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталж, улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

26.2. Энэхүү дүрмийг 5 /тав/ эх хувь үйлдэн, баталгаажуулж, Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газар, Монголбанк, Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпораци болон Төрийн банк тус бүр нэг хувийг хадгална. Эх хувиудын хооронд зөрүүтэй зүйл гарвал Улсын бүртгэлийн газар хадгалагдаж буй хувийг баримтална.

26.3. Энэхүү дүрмийг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

26.4. Банкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор батлах бөгөөд тухайн нэмэлт, өөрчлөлт нь улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэхүү Дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.

~oOo~

СЗХ 2022 он 04 сар 21 БҮРТГЭВ

## ХАВСРАЛТ-4 Улсын бүртгэлийн гэрчилгээ

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000252499

2009.11.24
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9016001018
/ Хувийн хэргийн дугаар /

5341469
/ Регистрийн дугаар /

Төрийн банк — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Тогтоол | 348 | 2009.11.23 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| 6419 | Мөнгөн хадгаламж, зээл, төлбөр тооцоо, гадаад валют, үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах, үнэт зүйл хадгалах, гадаад төлбөр тооцоо хийх, үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах /2009.11.23-/ |
|---|---|
| / Код/ | / Үйл ажиллагааны чиглэл / |

| Хугацаагүй | 2 | 178,000,000.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / хувьцаа эзэмшигчдийн тоо / | / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Чингэлтэй, 1-р хороо, 7/1, 00 тоот, Утас1: 330103, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ /тамга/ Д.ГАНГАМӨРӨН /гарын үсэг/

*Гэрчилгээ дахин олгосон 2022 он 03 сар 10 өдөр*

УЛААНБААТАР ХОТ — ТӨРИЙН БАНК 5341469

УЛААНБААТАР ХОТ — ГҮЙДСЕН ҮЦК ХХК

СЗХ 2022.09.21 он сар БҮРТГЭВ № 01

2022-09-14 БҮРТГЭВ-03

**Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл**

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| *1* | *Өлзий овогтой Гантөр-в Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.* | *2020.05.21* | *Э.Эрдэнэбилэг* |
| *2* | *Дахин гэрчилгээ олгов.* | *2022.06.10* | *Д.Ганзаморен* |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000252499

УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕКЬЮРИТИЕС ҮЦК ХХК

СЭХ
2022.09.21
№ 01
2022-09-14
БҮРТГЭВ-03

# ХАВСРАЛТ-5 Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ

**МОНГОЛ УЛС**

**МОНГОЛБАНК**

**БАНКНЫ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**

*2009 оны 11-р сарын 23-ны өдөр* *Дугаар 26* *Улаанбаатар хот*

Монгол улсын Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 375 тоот тушаалаар батлагдсан "Банк, түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам"-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн Газар-д Төрийн банк оноосон нэр бүхий банк байгуулах зөвшөөрөл олгов.

Монгол банкны бүртгэлийн дугаар 33

*/Энэхүү Гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй/*

ЕРӨНХИЙЛӨГЧ Л. ПҮРЭВДОРЖ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

СЗХ
2022.09.21
БҮРТГЭВ

ТӨРИЙН БАНК
2022-09-14

МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 210/23

2013 оны 09 сарын 18 өдөр

Монгол улсын "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль", бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 09 сарын 18 өдрийн 296 дугаар тогтоолоор

"ТӨРИЙН БАНК" ХХК -д

Даатгалын зуучлагчийн

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА С.ДАВААСҮРЭН
"тамга"

Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
ГСТ5302

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮСЕК ҮЦК ХХК
ТТ50674

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-14
БҮРТГЭВ-03

# ХАВСРАЛТ-6 Хуулийн дүгнэлт

**ТӨРИЙН БАНК ХХК-ИЙН НИЙТЭД САНАЛ БОЛГОН АНХ УДАА ХУВЬЦАА ГАРГАЖ БАЙГААТАЙ ХОЛБОГДУУЛАН БЭЛТГЭСЭН**
**ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ**

**2022 оны 6 дугаар сарын 30-ны өдөр**

Төрийн банк ХХК /цаашид **“Үнэт цаас гаргагч”** эсхүл **“Банк”** гэх/ нь Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар заасан нөхцөл, журмын дагуу компанийн хэлбэрээ өөрчилж нээлттэй хувьцаат компани болох, хувьцаагаа олон нийтэд санал болгохоор ажиллаж байна.

Үнэт цаасаа олон нийтэд санал болгох ажлын хүрээнд Үнэт цаас гаргагч Төрийн банк ХХК нь №01а/307 тоот Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээг 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН болон Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН /цаашид хамтад нь **“Зөвлөх”**, **“Зөвлөхүүд”** эсхүл **“Хуулийн фирм”** гэх/ нартай байгуулан, энэхүү хууль зүйн дүгнэлтийг гаргуулахаар тохиролцсон. Тус тохиролцсон асуудлын хүрээнд Үнэт цаасны гаргагч Төрийн банк ХХК-ийн үйл ажиллагаанд хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, хуулийн дүгнэлт /цаашид **“Хуулийн дүгнэлт”** гэх/-ийг бэлтгэж үүгээр хүргүүлж байна.

Хуулийн дүгнэлтийг андеррайтерийн компани болох Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК, туслах андеррайтер болох Гүүдсек ҮЦК ХХК, үнэлгээний компани болох Мөнх-Оргил трейд ХХК болон Үнэт цаас гаргагч Төрийн банк ХХК, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, холбоотой этгээдүүдтэй аливаа байдлаар харилцан хамааралгүй хийж гүйцэтгэсэн бөгөөд ашиг сонирхлын хувьд хамааралгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **“гаргаж өгсөн баримт бичигт”** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.

**Хуудас 1/125**

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР
ТӨРИЙН БАНК
5341469

УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

СЭХ
2022 он 09 сар 1 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-09-14
БҮРТГЭВ-03

**Зөвлөхүүдийн мэдээлэл:**

**Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН**

| | |
|---|---|
| Хуулийн фирмийн нэр: | Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс ХХН |
| Үйл ажиллагааны чиглэл: | Хууль зүйн зөвлөх үйлчилгээ |
| Хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Сентрал Тауэр, 13 давхар, 1301 тоот |
| Утас: | +976 11 330048 |
| Факс: | +976 11 330049 |
| Вэб хуудас: | www.mdsa.mn |
| Цахим шуудан: | info@mdsa.mn |

Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН нь 2011 онд байгуулагдсан. Тус фирмийн хуульчид нь олон улсын эрх зүйг үндэсний хууль тогтоомж, туршлагатай уялдуулан үндэсний болон олон улсын хөрөнгө оруулагчдад төрөл бүрийн салбарт эрх зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

Өмгөөллийн Эм Ди Эс энд ХаанЛекс ХХН нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1-д заасан үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр бүртгэгдсэн, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд бөгөөд тус зах зээлээс санхүүжилт татаж буй компаниудтай хамтран ажиллаж байсан арвин туршлагатай. Үүнд, тухайлбал:

- Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Монгол, Хонг Конг, Лондонгийн хөрөнгийн бирж дээр хувьцаа нийтэд анх удаа санал болгох "Wolf" төслийн Монголын хууль тогтоомжтой холбоотой зөвлөгөөг өгөх, эрх зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлтийн төсөл боловсруулах;
- Монгол Улсын Хөрөнгийн Бирж дээр гаргасан анхны 100% даатгагдсан Эрчим бонд гаргах ажилд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хууль зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлт гаргах;
- ЛэндМН ББСБ ХК-ийн IPO, 3 удаа бонд гаргаж олон нийтэд санал болгох төсөл;
- Инвескор ББСБ ХК-ийн IPO, бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган олон нийтэд санал болгох, нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох төслүүд, биржийн бус зах зээлд компанийн өрийн хэрэгсэл гаргах төсөл;
- Түмэн шувуут ХК-ийн IPO гаргах төсөл;
- Хөвсгөл Алтандуулга ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах төсөл;
- Сүү ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах төсөл;
- Монголын Ипотекийн Корпораци ХХК-ийн 1-13, 21, 23, 24, 28, 29 дэх орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах төсөл дээр хууль

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичиг"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
СТС2420

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ
ТҮЛСЕН ҮЦК ХХК

ТӨРИЙН БАНК
ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА
СЗХ 2022 он 09 сар 21 өдөр БҮРТГЭВ № 01
2022-09-14 БҮРТГЭВ-03

зүйн судалгаа шинжилгээ хийж, хууль зүйн дүгнэлт гаргах ажлуудыг тус тус гүйцэтгэсэн туршлагатай.

Хуульч, хуулийн фирмүүдийн чансаа тогтоодог AsiaLaw сэтгүүл Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс ХХН-ийг "2021 оны Монгол Улсын шилдэг хуулийн фирм"-ээр шалгаруулсан бөгөөд тус фирмийн хөрөнгийн зах зээлд үзүүлсэн үйлчилгээг онцлон тэмдэглэсэн байна.

**Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН**

| | |
|---|---|
| Хуулийн фирмийн нэр: | Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН |
| Үйл ажиллагааны чиглэл: | Хууль зүйн зөвлөгөө өгөх |
| Хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-8, Монгол ТВ цамхаг, 10-р давхар. |
| Утас: | +976 7711 9008 |
| Факс: | +976 7711 9008 |
| Вэб хуудас: | www.bnp.mn |
| Цахим шуудан: | contact@bnp.mn |

Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН нь 2013 оны 6 дугаар сарын 18-ны өдөр хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн мэргэшсэн бизнесийн хуулийн фирм юм. Тус Хуулийн фирм нь концесс, төр хувийн хэвшлийн түншлэл (дэд бүтэц - төмөр зам, авто зам, угаах үйлдвэр, барилга, эрчим хүчний салбар), бизнес, компанийн хууль, эрх зүйн түгээмэл тохиолддог асуудлуудаар аж ахуй нэгж, бизнес эрхлэгч, компаниудад хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд уул уурхай, барилга, ашигт малтмал, санхүүгийн салбарт мэргэшсэн туршлагатай.

Хуулийн фирм нь үнэт цаасны зах зээлийн оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны №72 тоот тогтоолын дагуу авсан бөгөөд үнэт цаасны зах зээлийн оролцогчдод хууль зүйн туслалцаа, хөндлөнгийн дүгнэлт гаргаж өгөх үйлчилгээ үзүүлэх эрхтэй, гадаад, дотоодын хөрөнгийн биржид хувьцаа, өрийн бичиг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахад үнэт цаасны зах зээлийн бүхий л үе шатанд ажиллаж байсан туршлагатай. Тухайлбал:

- Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн хэлбэрийг өөрчлөх замаар анх удаа нийтэд санал болгон үнэт цаас гаргах төсөл;
- Симпл Ассет ТЗК хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажилд хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийх, хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх төсөл;
- Монголын Ипотекийн Корпораци ОССК ХХК-ийн олон улсын хөрөнгийн зах зээл 250 сая ам.доллар болон 300 сая ам.долларын өрийн хэрэгсэл буюу бонд гаргах;

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичигт"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ТӨРИЙН БАНК 5341469
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 .09 .21 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ-03

- Канад Улсын Торонтогийн хөрөнгийн бирж (TSX) дээр арилжаалагдаж буй хувьцааг Монгол Улсын нэр бүхий арилжааны банк барьцаалахтай холбоотой барьцааны гэрээ байгуулах, барьцааг гадаад улсын хууль тогтоомжийн дагуу бүртгүүлэх, хуулийн хүчин төгөлдөр байдлыг хангуулах төсөл;
- Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх, 2 их наяд төгрөг хүртэлх өрийн хэрэгсэл/бондыг 24-36 сарын хугацаатай, жилийн төгрөгийн 10%, ам.долларын 6.8%-ийн хүүтэйгээр гаргах ажилд хуулийн зөвлөхөөр ажиллаж, хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх төсөл;
- Хар хорум пропертийс ХК-ийг Эрдэнэс Сольюшинс ХК-д нэгтгэх, нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдсэн үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах төсөл;
- Монголын даатгалын салбарт анхдагч IPO болох Мандал даатгал ХХК-ийн хэлбэрийг өөрчлөх замаар анх удаа нийтэд санал болгон үнэт цаас гаргах төсөл;
- Монгол Улсын анхны финтек компани МОСТ Финтек ХХК-ийн хэлбэрийг өөрчлөх замаар анх удаа нийтэд санал болгон үнэт цаас гаргах төсөл;
- АПУ ХК-аас нэмж хувьцаа гаргах замаар нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдсэн үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах төсөл;
- Монголын Ипотекийн Корпораци ХХК-ийн ипотекийн зээлээр баталгаажсан бонд гаргах, тусгай зориулалтын компаниар дамжуулан үнэт цаас гаргах 2-8, 11, 12, 15, 16, 17, 22, 25, 26 дугаар ээлжийн хэлцэлд хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийх, хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх төсөл;
- Улаанбаатар БҮК ХК-аас хувьцаа нэмж гаргах, өрийг хувьцаагаар сольж, үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах ажилд хуулийн дүн шинжилгээг тус тус хийж гүйцэтгэсэн туршлагатай.

Энэхүү Хуулийн дүгнэлтийг зөвхөн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, түүний дотор Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 42 дугаар зүйлийн 42.4 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А-105 тоот "Банкны системд нөлөө бүхий банкны жагсаалтыг шинэчлэн батлах тухай" тушаалын 4 дэх зүйлд заасны дагуу Банк нь анх удаа хувьцаа гарган олон нийтэд санал болгох эрх зүйн үндэслэлтэй гэж үзсэний үндсэн дээр гаргаж байна. Уг Банк нь Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйл (Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх), 42 дугаар зүйл (Үнэт цаас гаргах тухай шийдвэр), Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйл (Үнэт цаас), 6 дугаар

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичигт**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
2021031195 СТС2420

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 СТ5362

УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК
ТТБ0674 д. 5208173

зүйл (Үнэт цаас гаргах) 7 дугаар зүйл (Үнэт цаас гаргагч), 8 дугаар зүйл (Нийтэд санал болгон үнэт цаас гаргах журам), 9 дүгээр зүйл (Үнэт цаас бүртгэх, нийтэд санал болгохыг зөвшөөрөх), 10 дугаар зүйл (Үнэт цаасны танилцуулга), 11 дүгээр зүйл (Үнэт цаасыг нийтэд санал болгох)-д заасны дагуу анх удаа хувьцаагаа гарган Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "**СЗХ**" гэх), Монголын хөрөнгийн бирж ТӨХК (цаашид "**МХБ**" гэх)-д бүртгүүлж, нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн байна.

**Үнэт цаас гаргах шийдвэрийн тухай**

Үнэт цаас гаргагч Төрийн банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 06 дугаар сарын 30-ны №04 тоот "Төрийн банк" ХХК-ийг нээлттэй хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах, нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох тухай тогтоол гаргасан байна. Тус тогтоолын дагуу хувьцаа эзэмшигч Засгийн газрын эрх олгосноор Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпорацийн зүгээс Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт, 4 дүгээр зүйлийн 4.2, 28 дугаар зүйлийн 28.1, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 29.2.4 дэх заалт, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 болон 7 дугаар зүйл, Компанийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 , 23 дугаар зүйлийн 23.1, 23.5 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.8, 42.4, 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.2, 62.1.3, 62.1.4 дэх заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсэг, "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 34 дүгээр тэмдэглэл, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 130/А191 дугаартай хамтарсан тушаалаар баталсан "Төрийн банк" ХХК-ийг олон нийтэд нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжүүлэх хөтөлбөр, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хурлын н/08 тоот тогтоол, "Төрийн банк" ХХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4, 7 дугаар зүйлийн 7.2.2, 7.3, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн "Төрийн банк" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 04 тоот тэмдэглэлийг тус тус үндэслэн "Төрийн банк" ХХК-ийн хэлбэрийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулахаар шийдвэрлэсэн байна. Тус хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр "Төрийн банк" ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж компанийн гаргасан 250 (хоёр зуун тавь) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 712,000,000 (долоон зуун арван хоёр сая) ширхэг энгийн хувьцаа дээр 250 (хоёр зуун тавь) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 37,475,000 (гучин долоон сая дорвон зуун далан таван мянга) ширхэг энгийн хувьцааг "Монголын Хөрөнгийн бирж" ТӨХК-аар дамжуулан олон нийтэд санал болгохоор нэмж гаргаж, хөндлөнгийн үнэлгээний эрх бүхий байгууллагын үнэлгээний

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичигт**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.

СЭХ
2022.09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭВ-03

тайлан, бусад нөхцөл байдлыг харгалзан олон нийтэд санал болгох нэгж хувьцааны үнийг 590 (таван зуун ер) төгрөгөөр тогтоож шийджээ.

Түүнчлэн тус шийдвэрээр одоогийн хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн байгааг дурдаж байна.

Мөн үнэт цаасны анхдагч зах зээлд хувьцааны захиалгын эрэлтийн хэмжээ нь нийлүүлэлтийн хэмжээнээс давж гарсан нөхцөлд нийтэд санал болгож гаргасан хувьцааны 15 хувь хүртэлх хэмжээний хувьцааг нэмж гаргах, нэмж гаргасан тохиолдолд тухайн хэмжээгээр хувь хэмжээнд өөрчлөлт оруулахаар зөвшөөрч шийдвэрлэж татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалтыг баталсан байна.

**Дүн шинжилгээ хийсэн арга, аргачлал**

Энэхүү дүн шинжилгээг Үнэт цаас гаргагчтай тохиролцсон асуудлын хүрээнд гаргаж өгсөн.

Дүн шинжилгээг Үнэт цаас гаргагчийн гаргаж өгсөн баримт материалд үндэслэсэн бөгөөд хараат бус байх зарчмыг баримталсан.

Хууль тогтоомжоор тодорхойлсон төрийн эрх бүхий байгууллагын бүрэн эрхэд хамаарах буюу Төв банкны бүрэн эрхэд хамаарах болон Төв банкнаас нууцын зэрэглэл болохыг тодорхойлсон асуудлаар Хуулийн фирм дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргаагүй бөгөөд холбогдох төрийн эрх бүхий байгууллагаас гаргаж өгсөн лавлагаа, тодорхойлолтын хүрээнд томъёолж дүн шинжилгээндээ ашигласан болохыг тусгайлан анхаарч Хуулийн дүгнэлтэд дурдагдаагүй асуудлаар Үнэт цаас гаргагчаас, лавлагаа тодруулга бүхий албан бичигт дурдагдсан асуудлаар тухайн шатны төрийн эрх бүхий байгууллагаас тодруулж лавлана уу.

Хөндлөнгийн эрх бүхий байгууллагуудаас гаргуулан авсан лавлагаа, тодорхойлолтууд нь үнэн зөв бөгөөд дурдагдсан үйл баримт нь Хуулийн дүгнэлт гаргах өдрийг хүртэл хугацаанд хэвээр хадгалагдаж байгаа гэж үзсэн.

**Хангагдсанд тооцох нөхцөл**

Энэхүү Хуулийн дүгнэлтийг боловсруулахдаа Зөвлөхүүд дараах нөхцөл хангагдсан гэж үзсэн болно. Үүнд:

1. Судлан шинжилсэн бүх баримт бичгийн хуулбар, эсхүл маягтууд нь үнэн зөв, тэдгээр дээрх аливаа тэмдэглэгээ, гарын үсэг, тамга тэмдэг нь үнэн;
2. Бүх баримт бичгүүд нь тэдгээрийг үйлдсэн талуудын бүрэн эрхийн хүрээнд үйлдэгдсэн;

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичиг"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК

СЗХ 2022 .09 сар 21 өдөр БҮРТГЭВ № 01

2022-09-14 БҮРТГЭВ-03

3. Гаргаж өгсөн аливаа баримт бичгийн хуулбар нь тухайн баримт бичгийн эх хувьтайгаа нийцсэн бөгөөд тэдгээрийг бүрэн хуулбарласан, үнэн зөв;
4. Гаргаж өгсөн баримт бичгийн дагуу үүсэх аливаа үүрэг нь Монгол Улсаас бусад эрх зүйн тогтолцоонд хүчин төгөлдөр байх ба тэдгээр үүргийн хэрэгжилт хууль бус, хүчин төгөлдөр бус, эсхүл хэрэгжих боломжгүй биш байна;
5. Монгол Улсаас өөр улсад үйлдэгдсэн аливаа баримт бичиг нь тийнхүү үйлдэгдсэн улсын хуулийн шаардлагыг хэлбэрийн болон агуулгын хувьд бүрэн хангасан, хүчин төгөлдөр баримт бичиг ба тэдгээрийн хэрэгжилт нь тийнхүү хэрэгжих улсын хуулийн шаардлагыг мөн хангасан;
6. Загвар хувилбараар ирсэн баримт бичиг нь тухайн хувилбарыг үндэс болгон баталгаажсдаг;
7. Банк, түүний ажилтнуудаас аливаа хэлбэрээр хүлээн авсан аливаа мэдээлэл нь үнэн зөв, бодитой;
8. Шүүх, төрийн эрх бүхий болон бусад байгууллагаас авсан мэдээлэл, баримт бичиг нь үнэн зөв;
9. Үнэт цаасны танилцуулгад тусгасан андеррайтер, аудитор, хөрөнгийн үнэлгээчний хийсэн судалгаа, дүгнэлт, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв;
10. Бидний судалж ашигласан бичиг баримтыг бэлтгэсэн болон түүнд гарын үсэг зурсан этгээд нь тийнхүү уг баримт бичгийг бэлтгэх, гарын үсэг зурах бүрэн эрхтэй.

Үнэт цаас гаргагч нь хувьцаагаа нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлснээр үнэт цаасны арилжааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7 дахь хэсэг, СЗХ-ны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн №225 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон МХБ-ийн ТУЗ-ийн 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн №02 тоот тогтоолоор батлагдсан МХБ-ийн "Арилжааны журам"-ын дагуу явуулна гэж бид ойлгож байна.

Зөвлөхүүд дүн шинжилгээ хийхдээ Үнэт цаас гаргагчаас шаардлагатай гэж үзсэн бичиг баримтын эх хувь болон хуулбарыг гаргуулан авч, хууль зүйн үндэслэл болон мэдээллийг тулган шалгаж, судалсан болно. Түүнчлэн төрийн эрх бүхий байгууллагуудаас шаардлагатай гэж үзсэн хөндлөнгийн лавлагаа, мэдээллийг гаргуулж судалсан болно. Ийнхүү судалгаа шинжилгээ (due diligence) хийж, дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн дор дурдсан дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичигт**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183655 002031195 СТС2420

УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК 5341469 ГСТ 362

УЛААНБААТАР ХОТ ... ХУУЛЬ ЗҮЙН ... ҮЦК ХХК ТТБ0074 5208173

СЗХ
2022.09.21 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

2022-09-14
БҮРТГЭВ-03

## 1. КОМПАНИ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ҮҮСГЭН БАЙГУУЛАГДАЖ БҮРТГЭГДСЭН ЭСЭХ, ҮНЭТ ЦААС ГАРГАХ ШИЙДВЭР НЬ ХУУЛИЙН ДАГУУ ГАРСАН ЭСЭХ

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд Үнэт цаас гаргагч Төрийн банк ХХК-ийн улсын бүртгэлийн холбогдох мэдээллийг нэн тэргүүнд гаргуулан авч дүн шинжилгээ хийлээ. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн зохицуулалтын дагуу компанийн хэлбэрээр үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд нь улсын бүртгэлийн байгууллагад мэдээллээ бүртгүүлэх бөгөөд хуулийн этгээд бүхэн хувийн хэрэгтэй байхаар зохицуулжээ[1]. Тус зохицуулалтыг үндэслэн улсын бүртгэлийн байгууллагын улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь Төрийн банк ХХК-ийн хувийн хэргээс лавлагааг гаргуулан авч дүн шинжилгээнд голлох баримтаар ашиглалаа.

Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангаас 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн №22900002002655 дугаар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаанаас үзвэл улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд Үнэт цаас гаргагчийг 2009 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр бүртгэсэн байна. Тус Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаанд хавсаргаж ирүүлсэн баримт материалаас үзвэл Засгийн газрын 2009 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн №348 тоот Банк санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангаж, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Төрийн

[1] **Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль (2018)**
**4 дүгээр зүйл Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**
4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:
4.1.4."**хуулийн этгээдийн хувийн хэрэг**" гэж улсын бүртгэлийн мэдээллийн санд цаасан болон цахим хэлбэрээр байгаа, энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан мэдээллийн бүрдлийг;
4.1.6."**хуулийн этгээдийн мэдээлэл**" гэж хуулийн этгээдийн хувийн хэрэгт агуулагдаж байгаа энэ хуулийн 10.1-д заасан болон бусад мэдээллийг;
**10 дугаар зүйл Хуулийн этгээдийн хувийн хэргийн агуулга**
10.1.Хуулийн этгээдийн хувийн хэрэг дараах мэдээллийг агуулна:
10.1.1.хуулийн этгээдийн нэр, регистрийн болон хувийн хэргийн дугаар;
10.1.2.хуулийн этгээдийн төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл;
10.1.3.хуулийн этгээдийн ерөнхий захиргаа оршин байгаа газрын албан ёсны хаяг, хэрэв байнгын ажиллагаатай ерөнхий захиргаа байхгүй бол тухайн хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн оршин байгаа газрын хаяг;
10.1.4.хуулийн этгээдийг шинээр байгуулах, эсхүл өөрчлөн байгуулах, татан буулгах тухай;
10.1.5.үүсгэн байгуулагчийн талаарх мэдээлэл;
10.1.6.үүсгэн байгуулах баримт бичиг;
10.1.7.өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдах болон үйл ажиллагаа нь зогссон хуулийн этгээд тус бүрийн эрх залгамжлалын талаар;
10.1.8.хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн тухай мэдээлэл, түүнийг бүртгэсэн он, сар, өдөр;
10.1.9.компанийн хувьд үүсгэн байгуулах баримт бичигт заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;
10.1.10.хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхийн хуулбар, гадаадын иргэн бол паспортын хуулбар;
10.1.11.хуулийн этгээд нь салбар, төлөөлөгчийн газартай бол түүний оршин байгаа газрын албан ёсны хаяг, эрх бүхий этгээдийн иргэний үнэмлэхийн хуулбар;
10.1.12.хуулийн этгээдийн эрх барих этгээдийн гишүүдийг сонгосон, өөрчилсөн тухай үүсгэн байгуулагчийн шийдвэр, хурлын тэмдэглэл;
10.1.13.төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуулийн этгээдийн улсын бүртгэлд хориг тавьсан, цуцалсан тухай баримт бичиг, хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, шийтгэлийн хуудас;
10.1.14.хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон түүний хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээлэл.

**Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "гаргаж өгсөн баримт бичигт" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.**



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГС15382

УЛААНБААТАР ХОТ
ГҮЛДЭН ҮЦК ХХК

СЗХ
2022 оны 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14
БҮРТГЭВ-03

болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг[2], Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулийг тус тус үндэслэн Зоос банкин дахь төрийн зарим мөнгөн хөрөнгөөр төрийн өмчийн банк байгуулах тухай Монголбанк, Сангийн яамны саналыг зөвшөөрч, үүсгэн байгуулагчаар Сангийн яамыг томилсон байна. Мөн тус тогтоолоор Сангийн сайдад шинээр үүсгэн байгуулах төрийн өмчит банкны дүрмийг батлах, Монголбанкнаас банк үүсгэн байгуулах зөвшөөрөл авахыг даалгасан байна.

Хуулийн фирмийн зүгээс Монголбанканд хандаж Үнэт цаас гаргагчийн тусгай зөвшөөрөлтэй холбоотой дэлгэрэнгүй лавлагаа хүссэн бөгөөд Монголбанкны 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн №Б-10/454 тоот Албан бичгийн хариу хүргүүлэх албан тоотоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2009 оны Банк байгуулах зөвшөөрөл олгох тухай №652 дугаар тушаал болон 2009 оны №26 дугаартай Банкны зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлсэн. Тус баримт бичгээс харвал Монголбанкны Ерөнхийлөгчийн 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн №652 дугаар Банк байгуулах зөвшөөрөл олгох тухай тушаалын дагуу Засгийн газарт "Төрийн банк" банкийг үүсгэн байгуулах зөвшөөрөл олгосон байна. Төрийн банкийг үүсгэн байгуулагдах үед хүчин төгөлдөр үйлчилж, мөрдөгдөж байсан Банкны тухай хуулийн холбогдох зохицуулалтыг харвал 1996 онд батлагдаж 2010 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцогдсон Банкны тухай хуулийн 20 дугаар зүйлээр Монголбанкны зүгээс банк үүсгэн байгуулах зөвшөөрөл олгох журмыг зохицуулжээ. Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт "хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах" эрхийг Засгийн газарт олгож зохицуулжээ.

Дурдсан эдгээр хуулийн зохицуулалт, баримт бичгийн хүрээнд Хуулийн фирм нь Төрийн банк ХХК-ийг хуульд тогтоомжид нийцүүлэн Засгийн газраас үүсгэн байгуулсан байна гэж дүгнэлээ. Түүнчлэн тус хуулийн 1996 онд батлагдаж 2010 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцогдсон Банкны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт "банкны эрх барих байгууллага нь хувь нийлүүлэгчдийн хурал байна. ... төрийн өмчит банкны хувьд Засгийн газар, түүнээс эрх олгосон этгээд тус тус хэрэгжүүлнэ", энэхүү Хуулийн дүгнэлтийг гүйцэтгэх явцад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт "банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд төрийн өмчит банкны хувьд Засгийн газар, түүнээс эрх олгосон этгээд тус тус хэрэгжүүлнэ" гэж заасныг үндэслэн хуулиар Засгийн газар төрийн өмчит банкны хувьд

[2] **Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг (1996)**
9 дүгээр зүйл. **Төрийн өмчийн талаарх Засгийн газрын бүрэн эрх**
5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичигт**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2022 оны 09 сар 2 өдөр БҮРТГЭВ № 01

2022-09-14 БҮРТГЭВ-03

хувь нийлүүлэгчдийн хурлын эрхийг шилжүүлж болох журмын дагуу Сангийн яам банкийг үүсгэн байгуулжээ гэж үзлээ.

Дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагч Төрийн банк ХХК-ийг хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулж бүртгүүлжээ гэж дүгнэлээ.

Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулах баримт бичиг, эрх зүйн байдлын хувьд дурдах шаардлагатай гэж үзсэн асуудлын хувьд дараах асуудлыг дурдаж байна.

Хуулийн дүгнэлт өгөх өдрийн байдлаар үзвэл Үнэт цаас гаргагч Төрийн банк нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үйл ажиллагаа эрхэлж байх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүр нь 250 (хоёр зуун тавин) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 712,000,000 (долоон зуун арван хоёр сая) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна. Хувьцаа эзэмшигчдийн хувьд тус Банкны нийт хувьцааны 372,000,000 (гурван зуун далан хоёр сая) ширхэг хувьцаа буюу хувь нийлүүлсэн хөрөнгийн 52.25%-ийг Сангийн яам, 340,000,000 (гурван зуун дөчин сая) ширхэг буюу хувь нийлүүлсэн хөрөнгийн 47.75%-ийг Хадгаламжийн даатгалын корпораци эзэмшиж байгаа талаар бүртгэсэн байна.

Хувьцаа эзэмшигч Сангийн яамны хувьд тус Банкийг үүсгэн байгуулах үед буюу Засгийн газрын 2009 оны №348 дугаар тогтоолоор Сангийн яаманд эрх олгосон байна. Харин хувьцаа эзэмшигч Хадгаламжийн даатгалын корпорацийн хувьд 2014 оны 01 дүгээр сарын 14-ний өдрөөр хувьцаа эзэмшигчээр бүртгүүлсэн байгааг лавлагаанд дэлгэрэнгүй тусгажээ.

Банкны тухай хуульд төрийн өмчит банкны хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг Засгийн газар, түүнээс эрх олгогдсон этгээд хэрэгжүүлэхээр заасны дагуу Төрийн банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын эрхийг дээр дурдсаны дагуу Сангийн яам буюу Сангийн сайдын зүгээс хэрэгжүүлж хувь нийлүүлсэн хөрөнгийг тухай бүр нэмэгдүүлж ажилласан байна.

Хувьцаа эзэмшигч Хадгаламжийн даатгалын корпорацийн хувьд Хадгаламжийн даатгалын үндэсний хорооны 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн №09 тоот Зөвшөөрөл олгох тухай тогтоолоор Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт "банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хүрээнд банкны актив, пассивыг шилжүүлэн авч байгаа банкинд санхүүгийн дэмжлэг үзүүлэх", Монголбанкны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.5 дахь заалтад "санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Хадгаламжийн даатгалын корпорацид хуульд заасны дагуу зээл олгох", Монголбанкны Ерөнхийлөгчийн А-194, А-195 дугаар тушаал, Хадгаламжийн даатгалын үндэсний хорооны 2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Монголбанкнаас Хадгаламжийн даатгалын корпораци санд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, Төрийн банктай байгуулах Хувьцаа худалдах. худалдан авах гэрээг

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичигт**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ ГҮЛДЕН ҮЦК ХХК

СЗХ 2022 он .09 сар 21 өдөр БҮРТГЭВ № 01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-09-14 БҮРТГЭВ-03

байгуулахыг зөвшөөрсний дагуу Төрийн банкны нэмж гаргах энгийн хувьцаа худалдах, худалдан авах гэрээг 2013 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Төрийн банк ХХК болон Хадгаламжийн даатгалын корпораци нар хоорондоо байгуулсан байх бөгөөд Банкны нэмж гаргасан 85,000 (наян таван мянган) ширхэг энгийн хувьцааг нэрлэсэн үнээр худалдаж авахаар тохиролцож худалдан авч хувьцаа эзэмшигч болсон байна.

Хадгаламжийн даатгалын корпораци Төрийн банк ХХК-ийн хувьцаа эзэмшигч болсноор тус Банк төрийн өмчит хуулийн этгээд хэвээр байх эсэх асуудлын хувьд тодруулах нь зүйтэй гэж Хуулийн фирмийн зүгээс үзсэн.

Учир нь Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасны дагуу "Банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд төрийн өмчит банкны хувьд Засгийн газар, түүнээс эрх олгосон этгээд тус тус хэрэгжүүлнэ" гэж заасан. Иймд тус банкийг төрийн өмчит банк гэж үзсэн нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг Засгийн газар, түүнээс эрх олгосон этгээд буюу энэ тохиолдолд Сангийн яам хэрэгжүүлэх юм.

Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангаас ирүүлсэн дэлгэрэнгүй лавлагаа, хавсралт баримт бичгээс харвал Хадгаламжийн даатгалын корпораци нь Төрийн банк ХХК-ийн нэмж гаргасан хувьцааг худалдан авч хувьцаа эзэмшигч болсон байна. Хадгаламжийн даатгалын корпораци нь Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад заасны дагуу банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын үйл ажиллагааг эрхлэн явуулах тусгайлсан чиг үүрэг бүхий хуулийн этгээд бөгөөд хадгаламжийн даатгалын сангийн удирдлагыг хэрэгжүүлэгч Хадгаламжийн даатгалын корпораци /цаашид "**Корпораци**" гэх/ нь хадгаламжийн даатгалын үйл ажиллагааг эрхлэх тусгайлсан чиг үүрэг бүхий ашгийн төлөө бус, төрийн өмчит хуулийн этгээд[3] юм. Хэдийгээр Хадгаламжийн даатгалын корпораци нь төрийн өмчит хуулийн этгээд боловч тус хуулийн этгээдийн эзэмшиж байгаа хувьцаа нь санхүүгийн тайлан тэнцэлд хуулийн этгээдийн хөрөнгөөр бүртгэгдэх учир Хадгаламжийн даатгалын корпорацийн эзэмшиж буй Төрийн банк ХХК-ийн хувьцааг шууд төрийн өмч гэж дүгнэх хууль зүйн үндэслэлгүй гэж үзлээ. Учир нь төрийн өмчийн хуулийн этгээдийн эзэмшиж байгаа санхүүгийн хэрэгсэл, хувьцаа нь тухайн хуулийн этгээдийн хөрөнгөнд тооцогдох бөгөөд тус хувьцааг эзэмших төрийн эзэмшлийг шууд тодорхойлохгүй гэж дүгнэлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх, онцлогийг зохицуулж өгсөн байна. Тус зүйлийн 21.1 дэх хэсэгт "төрийн өмчийн

---

[3] **Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль (2013)**
19 дүгээр зүйл **Хадгаламжийн даатгалын корпорацийн эрх зүйн байдал**
19.1 Хадгаламжийн даатгалын корпораци нь хадгаламжийн даатгалын үйл ажиллагааг эрхлэх тусгайлсан чиг үүрэг бүхий ашгийн төлөө бус, төрийн өмчит хуулийн этгээд байна.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичигт**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК

хувьцаатай буюу төр хувь хөрөнгө оруулсан хуулийн этгээдийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэнэ" гэж тодорхойлж өгсөн.

Эдгээр зохицуулалтыг дүгнэж үзээд Төрийн банк ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 52.25%-ийг Засгийн газраас эрх олгосноор Сангийн яам, 47.25%-ийг төрийн өмчит хуулийн этгээд болох Хадгаламжийн даатгалын корпораци эзэмшиж байх тул Төрийн банк ХХК-ийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэж үзэх нь илүү үндэслэлтэй байна гэж үзсэн болохоо дурдаж байна.

Цаашлаад дурдах асуудлын хувьд хувьцаа эзэмшигч Хадгаламжийн даатгалын корпорацийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож ирсэн хэлбэрийг дурдах нь ач холбогдолтой гэж үзлээ. Хувьцаа эзэмшигч Хадгаламжийн даатгалын корпораци нь Төрийн банк ХХК-ийн нэмж гаргасан энгийн хувьцааг худалдах, худалдан авах гэрээ байгуулахдаа тус гэрээний 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгээр "Худалдан авагч нь Худалдагч (Төрийн банк)-ийн хувьцаа эзэмшигч болсноор Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан эрхийг[4] хэрэгжүүлэх бөгөөд үүнээс 34.1.1 дэх заалт болон 62 дугаар зүйлд заасан эрхийг Монгол Улсын Засгийн газар (Сангийн яам) итгэмжлэлээр шилжүүлнэ гэж тохиролцжээ.

Улмаар Хадгаламжийн даатгалын үндэсний хорооны 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн №09 тоот Зөвшөөрөл олгох тухай тогтоолоор Төрийн банк ХХК-тай байгуулах Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний дагуу хувьцаа эзэмшигчийн

---

[4] **Компанийн тухай хууль (2011)**
34 дүгээр зүйл.**Компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн эрх**
34.1.**Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:**
34.1.1.хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;
34.1.2.давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлсний дараагаар компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-өөс тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах;
34.1.3.компанийг татан буулгах үед энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх.
62 дугаар зүйл **Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх**
62.1.Дараах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:
62.1.1.компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
62.1.2.нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
62.1.3.компанийн орийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
62.1.4.компанийн хэлбэрийг өөрчлөх;
62.1.5.компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
62.1.6.хувьцааг хуваах буюу нэгтгэх;
62.1.7.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
62.1.8.энэ хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигч нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх;
62.1.9.компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
62.1.10.төлөөлөн удирдах зөвлөлөөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд энэ хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах;
62.1.11.төлөөлөн удирдах зөвлөлөөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд энэ хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
62.1.12.энэ хуульд заасны дагуу компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;
62.1.13.компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
62.1.14.энэ хуулийн 96.4-т заасан тайлан;
62.1.15.төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
62.1.16.энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал.

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичигт"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.

СЗХ
2022.09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭВ-03

эзэмших эрх, хувьцаа эзэмшигчдийн хуралд хувьцаа эзэмшигчийн эдлэх эрх, үүргийг Сангийн яаманд итгэмжлэлээр шилжүүлэхийг зөвшөөрсөн байна.

Дурдсан гэрээний тохиролцсон нөхцөл болон Хадгаламжийн даатгалын үндэсний хорооны 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн №09 тоот Зөвшөөрөл олгох тухай тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигч Хадгаламжийн даатгалын корпорацийн хувьд тухай бүр Сангийн сайдад итгэмжлэл өгч Хадгаламжийн даатгалын корпорацийн Төрийн банк ХХК дахь хувьцаа эзэмшигчийн эрхийг Сангийн сайд хэрэгжүүлж эдэлж ирсэн байна.

Тухайлбал Хадгаламжийн даатгалын корпорацийн зүгээс 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн №А-1/134 тоот Итгэмжлэл олгох албан бичгийн дагуу Хадгаламжийн даатгалын корпорацийн эзэмшиж буй Төрийн банкны 85,000 (наян таван мянган) ширхэг энгийн хувьцаанд холбогдох саналын эрхийг хэрэгжүүлэх эрхийг Иргэний хуулийн 7 дугаар бүлэгт заасны дагуу Монгол Улсын Сангийн сайдад 1 (нэг) жилийн хугацаатай олгожээ.

Итгэмжлэлийн харилцааг Иргэний хуульд тодорхой [5] хуульчилж өгсөн гэж Хуулийн фирм үзэж байна. Тухайлбал хуулийн этгээдийн зүгээс олгож буй

[5] 62 дугаар зүйл. **Хэлцэлд төлөөлөх**
62.1.Хэлцлийг төлөөлөгчөөр дамжуулан хийж болно.
62.2.Хэлцлийг төлөөлөгчөөр дамжуулан хийхийг хуулиар хориглосон, эсхүл хэлцлийн шинж чанараас шалтгаалан хэлцэл хийгч заавал биечлэн хийвэл зохих хэлцлийг төлөөлөгчөөр дамжуулан хийж болохгүй.
62.3.Төлөөлөгчийн бүрэн эрх хуулийн дагуу буюу итгэмжлэлийн үндсэн дээр үүсэх.
62.4.Төлөөлөгч итгэмжлэлээр эрх олгосон үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх үүрэгтэй.
62.5.Итгэмжлэлд уг үйл ажиллагааг бусдаар гүйцэтгүүлж болохоор заасан, эсхүл итгэмжлэгчийн ашиг сонирхлын үүднээс зайлшгүй шаардлагатай байвал итгэмжлэлийг шилжүүлж болно.
62.6.Шилжүүлсэн итгэмжлэлийн хугацаа үндсэн итгэмжлэлийн хугацаанаас их байж болохгүй. Үндсэн итгэмжлэл дуусгавар болсноор шилжүүлсэн итгэмжлэл нэг адил дуусгавар болно.
62.7.Төлөөлөгч эрхээ бусдад шилжүүлсэн тухай болон итгэмжлэлийг шилжүүлэн авсан этгээдийн талаар төлөөлүүлэгчид мэдэгдэх үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлээгүй бол эрх шилжүүлэн авсан этгээдийн үйл ажиллагаанаас бий болох үр дагаврыг төлөөлөгч хариуцна.
63 дугаар зүйл. **Төлөөлөгч**
63.1.Итгэмжлэлээр төлөөлөхөд төлөөлөгч нь иргэний эрх зүйн бүрэн, бүрэн бус, эсхүл хязгаарлагдмал чадамжтай иргэн болон хуулийн этгээд байж болно.
63.2.Төлөөлөгч төлөөлүүлэгчээс олгосон бүрэн эрхийн хүрээнд, түүний нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй хэлцэл хийх бөгөөд уг хэлцлээс үүсэх эрх, үүрэг нь гагцхүү төлөөлүүлэгчид бий болно.
63.3.Төлөөлөгч нь бүрэн эрхээ шударгаар, төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй.
63.4.Энэ хуулийн 63.3-т заасан үүргээ биелүүлээгүйгээс төлөөлүүлэгчид учирсан гэм хорыг төлөөлөгч хариуцан арилгах үүрэгтэй.
63.5.Хууль ёсны төлөөлөгчийнх нь зөвшөөрлийг авалгүйгээр иргэний эрх зүйн бүрэн бус буюу хязгаарлагдмал чадамжтай иргэнээр төлөөлүүлсэн этгээд нь ийнхүү төлөөлүүлснээс бусдад учруулсан гэм хорыг өөрөө хариуцна.
64 дүгээр зүйл. **Төлөөлөх бүрэн эрх**
64.1.Төлөөлүүлэгч нь төлөөлөгч болон түүнтэй хэлцэл хийх гуравдагч этгээдэд төлөөлүүлэх тухайгаа болон төлөөлөгчийн бүрэн эрхийн талаар амаар буюу бичгээр мэдэгдсэнээр төлөөлөгчид бүрэн эрх олгож болно.
64.2.Бичгээр олгосон итгэмжлэл нь дараах шаардлагыг хангасан байвал зохино:
64.2.1.итгэмжлэлд төлөөлүүлэгч гарын үсэг зурсан байх, хуулийн этгээдийн итгэмжлэлд эрх баригч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарсан байх;
64.2.2.хуулийн этгээдийн эд хөрөнгийг хүлээн авах, бусдад шилжүүлэх, захиран зарцуулах эрх олгосон итгэмжлэлд эрх баригчаас гадна нягтлан бодогч гарын үсэг зурсан байх;
64.2.3.олгосон он, сар, өдрийг заах;
64.2.4.хуульд заасан бол нотариатаар гэрчлүүлэх;
64.2.5.итгэмжлэлийг тодорхой хугацаагаар олгох бол хугацааг заах.
64.3.Энэ хуулийн 64.2-т заасан шаардлагыг хангаагүй итгэмжлэл хүчин төгөлдөр бус байна.
64.4.Цэргийн алба хаагчийн итгэмжлэлийг түүний алба хааж байгаа анги, байгууллагын удирдлага, хоригдлын итгэмжлэлийг хорих байгууллагын дарга гэрчилж болно.

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичигт**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ-03

итгэмжлэлийн хувьд Иргэний хуулийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсэгт "итгэмжлэлээр төлөөлөхөд төлөөлөгч нь иргэний эрх зүйн бүрэн, бүрэн бус, эсхүл хязгаарлагдмал чадамжтай иргэн болон хуулийн этгээд байж болно" гэж тодорхой заасан.

Гэтэл энэ нөхцөлд хувьцаа эзэмшигч Хадгаламжийн даатгалын корпораци нь хуульд заасан иргэний эрх зүйн бүрэн, бүрэн бус, эсхүл хязгаарлагдмал чадамжтай иргэн болон хуулийн этгээдэд олгох итгэмжлэлийг Сангийн сайд буюу Монгол Улсын төрийн гүйцэтгэх дээд байгууллагын улс төрийн албан тушаалтанд Иргэний хуулийн 7 дугаар зүйлд заасныг үндэслэн олгож байгаа нь төлөөллийн зарчмыг хангаагүй, хуульд заасан журмын дагуу итгэмжлэлийг үйлдээгүй байна гэж Хуулийн фирмийн зүгээс үзсэн. Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт "корпорацийн удирдах дээд байгууллага нь Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо байна" гэж тодорхой заасан байх тул хувьцаа эзэмшигч Хадгаламжийн даатгалын корпораци нь хуульд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх нь зүйтэй байна гэж үзлээ.

Түүнчлэн Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, тогтоолд зарим тохиолдолд Сангийн сайд дангаараа, зарим тохиолдолд Хадгаламжийн даатгалын корпорацитай хамт гарын үсэг зурсан байх бөгөөд аль ч тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг тодорхой оруулж байх нь зүйтэй гэж үзсэн болохоо дурдаж байна.

Цаашид нээлттэй хувьцаат компани болж үнэт цаасаа нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлснээр Хадгаламжийн даатгалын корпорацийн зүгээс хувьцаа эзэмшигчийн эрхээ Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт "корпорацийн удирдах дээд байгууллага нь Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо байна" гэж заасныг үндэслэн тус хороогоороо дамжуулан саналын эрхээ эдлэх нь зүйтэй байна гэж үзсэн болохоо уламжилж байна.

**Үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх асуудлын хувьд:**

Үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх асуудлын хувьд Үнэт цаас гаргагч Төрийн банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдөр №04 тоот "Төрийн банк" ХХК-ийг нээлттэй хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах, нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох тухай тогтоол гаргасан байна.

Хувьцаа эзэмшигч Засгийн газрын эрх олгосноор Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпорацийн зүгээс Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт,

64.5 Тодорхой хугацаагаар олгох итгэмжлэл гурван жилээс илүүгүй хугацаагаар, хугацаа заагаагүй итгэмжлэл олгосон өдрөөс хойш нэг жил хүчин төгөлдөр байна.
64.6.Хуульд өөрөөр заагаагүй бол төлөөлөгчөөр дамжуулан хийх хэлцлийн хэлбэрт тавигдах шаардлага төлөөлүүлэх хүсэл зоригоо илэрхийлэхэд хамаарахгүй.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичигт"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК
5183655
9011031195 СТС2420
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГС75382
УЛААНБААТАР ХОТ
ГХУУЛЬСЕЙ ҮЦК ХХК
ТТ56874 ф.5209173

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ-03

4 дүгээр зүйлийн 4.2, 28 дугаар зүйлийн 28.1, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 29.2.4 дэх заалт, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 болон 7 дугаар зүйл, Компанийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 , 23 дугаар зүйлийн 23.1, 23.5 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.8, 42.4, 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.2, 62.1.3, 62.1.4 дэх заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсэг, "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 34 дүгээр тэмдэглэл, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 130/А191 дугаартай хамтарсан тушаалаар баталсан "Төрийн банк" ХХК-ийг олон нийтэд нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжүүлэх хөтөлбөр, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хурлын н/08 тоот тогтоол, "Төрийн банк" ХХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4, 7 дугаар зүйлийн 7.2.2, 7.3, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн "Төрийн банк" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 04 тоот тэмдэглэлийг тус тус үндэслэн "Төрийн банк" ХХК-ийн хэлбэрийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулахаар шийдвэрлэсэн байна. Тус хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр "Төрийн банк" ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж компанийн гаргасан 250 (хоёр зуун тавь) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 712,000,000 (долоон зуун арван хоёр сая) ширхэг энгийн хувьцаа дээр 250 (хоёр зуун тавь) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 37,475,000 (гучин долоон сая дөрвөн зуун далан таван мянга) ширхэг энгийн хувьцааг "Монголын Хөрөнгийн бирж" ТӨХК-аар дамжуулан олон нийтэд санал болгохоор нэмж гаргаж, хөндлөнгийн үнэлгээний эрх бүхий байгууллагын үнэлгээний тайлан, бусад нөхцөл байдлыг харгалзан олон нийтэд санал болгох нэгж хувьцааны үнийг 590 (таван зуун ер) төгрөгөөр тогтоож шийджээ.

Түүнчлэн тус шийдвэрээр одоогийн хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн байгааг дурдаж байна.

Мөн үнэт цаасны анхдагч зах зээлд хувьцааны захиалгын эрэлтийн хэмжээ нь нийлүүлэлтийн хэмжээнээс давж гарсан нөхцөлд нийтэд санал болгож гаргасан хувьцааны 15 хувь хүртэлх хэмжээний хувьцааг нэмж гаргах, нэмж гаргасан тохиолдолд тухайн хэмжээгээр хувь хэмжээнд өөрчлөлт оруулахаар зөвшөөрч шийдвэрлэж татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалтыг баталжээ.

Тогтоолын үндэслэлийг дүгнэж үзвэл Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 29.2.4 дэх заалт, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 болон 7 дугаар зүйл,

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичиг"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183835
2021031195 СТО2420

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК
ТТБ5674 5208173

Компанийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 , 23 дугаар зүйлийн 23.1, 23.5 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.8, 42.4, 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.2, 62.1.3, 62.1.4 дэх заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсэг, "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 34 дүгээр тэмдэглэл, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн №130/А191 дугаартай хамтарсан тушаалаар баталсан "Төрийн банк" ХХК-ийг олон нийтэд нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжүүлэх хөтөлбөр, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хурлын н/08 тоот тогтоол, "Төрийн банк" ХХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4, 7 дугаар зүйлийн 7.2.2, 7.3, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт тус тус нийцсэн байна.

Тус Хуулийн дүгнэлтийг гүйцэтгэх өдрийн байдлаар Монгол Улсад 2010 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан Банкны тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж байна. Тус Банкны тухай хуульд УИХ-аас 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр өөрчлөлт оруулсан бөгөөд тус нэмэлт өөрчлөлтөөр банкны системд нөлөө бүхий банк нь нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаагаа эрхлэхээр тогтоож өгсөн[6]. Тус нэмэлт өөрчлөлтийг 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Түүнчлэн 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар[7] тус нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулагдсан банк 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор холбогдох хуулийн дагуу компанийн хэлбэрээ өөрчилсөн байхаар зохицуулж тодорхой тусгасан.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн №А-105 дугаар Банкны системд нөлөө бүхий банкны жагсаалтыг шинэчлэн батлах тухай тушаалаар Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Төрийн банк, ХасБанк гэх 5 (тав) арилжааны банкийг системд нөлөө бүхий банк гэж тооцжээ.

Эдгээр хуулийн зохицуулалтын дагуу Үнэт цаас гаргагч Төрийн банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас дээрх хуульд заасан системд нөлөө бүхий банканд тавих шаардлагыг хангах зорилгоор компанийн хэлбэрээ өөрчилж нээлттэй хувьцаат

[6] **Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2021)**
1 дүгээр зүйл.Банкны тухай хуулийн дараах зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:
1/3 дугаар зүйлийн 3.1.20 дахь заалт:
"3.1.20."банкны системд нөлөө бүхий банк" гэж банкны хөрөнгө, өр төлбөрийн хэмжээ, төлбөрийн систем дэх гүйлгээний нийт дүнд эзлэх хувь, банкны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн тогтолцоо дахь хамаарал зэрэг шалгуурыг нэгэн зэрэг баримтлан банкны тогтолцоонд нөлөөтэй гэж Монголбанкнаас тогтоосон банкийг."
2/4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг:
"4.2.Банкны системд нөлөө бүхий банк нь нээлттэй хувьцаат компани, бусад банк нь хувьцаат компанийн хэлбэртэй байна."
[7] **Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль (2021)**
4 дүгээр зүйл. Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулагдсан банк 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор холбогдох хуулийн дагуу компанийн хэлбэрээ өөрчилсөн байна.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичигт"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ-03

компанийн хэлбэрээр зохион байгуулагдах шийдвэрээ Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 34 дүгээр тэмдэглэл, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтран баталсан 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн №130/А191 тоот Төрийн банк ХХК-ийг олон нийтэд нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжүүлэх хөтөлбөрийг үндэслэн хэлбэрээ өөрчлөх, нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгохоор шийдвэрээ гаргасан байна.

Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт "банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд төрийн өмчит банкны хувьд Засгийн газар, түүнээс эрх олгосон этгээд тус тус хэрэгжүүлнэ", 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт "Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд банкийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулж, татан буулгаж болно", Компанийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт "компанийг энэ хуульд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулж болно", 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт "... хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болох замаар компанийн хэлбэрийг өөрчилж болно", 23.2 дахь хэсэгт "энэ хуулийн 23.1-д заасны дагуу компанийг өөрчлөх төслийг ... хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ", 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг "дараах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ", 62.1.2 дахь заалт " ... өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах", 62.1.3 дахь заалт "... хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт "компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт үндэслэн дор дурдсан хэлбэрээр өөрчилж болно, 31.2.2 дахь заалт "хувьцаа нэмж гаргах замаар өсгөх" зэрэг заалтаас үзвэл компанийн хэлбэрийг өөрчлөх, нэмж хувьцаа гаргах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох зэрэг эрх нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх байх бөгөөд УИХ-ын 2022 оны №46 тоот тогтоолын дагуу энгийн хувьцааг нэмж гаргах, биржээр олон нийтэд нээлттэй худалдаж, нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/-нд даалгасны дагуу Засгийн газраас эрх олгож нэг талаас Сангийн сайд нөгөө талаас хувьцаа эзэмшигч Хадгаламжийн даатгалын корпорацийн зүгээс хувьцаа эзэмшигчдийн хурлаар тус асуудлыг шийдвэрлэсэн байх тул Төрийн банк ХХК-ийн нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулагдах, хувьцаа нэмж гаргах, хувьцааг биржээр дамжуулан олон нийтэд санал болгох шийдвэрийг хуулийн дагуу гарсан байна гэж дүгнэлээ.

*Тус шалгуур асуудлын хүрээнд Үнэт цаас гаргагч Төрийн банк ХХК нь Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгийн шаардлага болон өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тус тус хангаж ажиллаж*

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичигт**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.

СЗХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
2022 -09- 14

*байгааг Монголбанкны 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн №Б-10/454 тоот албан бичгээр тодорхойлсон болохыг онцгойлон дурдаж байна.*

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичигт"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГС75382
УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК
ТТБ8674 5208173

СЗХ
2022 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ-03

## 2. КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА, ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД НЬ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ХОРООНООС БАТАЛСАН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСТ ЗААСАН ШААРДЛАГЫГ ХАНГАЖ БАЙГАА ЭСЭХ, ТЭДГЭЭРИЙН УДИРДАХ ЧАДВАР, ДАДЛАГА ТУРШЛАГЫН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ

Төрийн банк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекст заасан шаардлага хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагатай холбоотойгоор тус Банкнаас гаргаж өгсөн баримт материалд үндэслэн дүн шинжилгээ хийлээ.

**Төлөөлөн удирдах зөвлөл**

Хуулийн дүгнэлт гаргаж өгөх өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн зохицуулалтын хүрээнд үзвэл Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсэгт “Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байна”, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Банкны төлөөлөн удирдах зөвлөл ес ба түүнээс дээш гишүүнтэй байна”, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүний гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна” гэж хуульчилсан байна.

Үнэт цаас гаргагч Төрийн банк ХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт “Банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 (ес) хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүн нь Сангийн яам, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Хууль зүйн яам болон хараат бус гишүүдээс бүрдэнэ. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг Сангийн сайд 3 (гурван) жилийн хугацаатай томилох бөгөөд түүнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд хамаарахгүй”, 8.2.1 дэх заалтад “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлд 3 (гурав) хараат бус гишүүн байна”, 8.2.2 дахь заалтад “Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т заасны дагуу Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох чөлөөлөх журмыг Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн $31^2$ дугаар зүйлд заасан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл тогтооно” гэж тусгасан.

Банкны дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэгт “Банк нь Засгийн газрын 2009 оны №348 дугаар тогтоол, Монголбанкны 2009 оны №652, №653 дугаар зөвшөөрлүүдийг үндэслэн өмчлөлийн хувьд төрийн өмчит, энэ дүрмийн хүрээнд ашгийн төлөө, банкны нийтлэг үйл ажиллагаа явуулах хязгаарлагдмал хариуцлагатай компани байна”, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Банкны хувьцаа эзэмшигч гэж Сангийн яам,

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **“гаргаж өгсөн баримт бичиг”** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

СЭХ
2022 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 1

2022-09-14
БҮРТГЭВ-03

Хадгаламжийн даатгалын корпорацийг ойлгоно. Банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасны дагуу төрийн өмчит банкны хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг Засгийн газар, түүнээс эрх олгосноор зөвхөн Сангийн сайд хэрэгжүүлнэ" гэж тусгасан байна.

Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.4 дэх хэсэгт "Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанид төрийн болон орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмыг ТБОНӨтХ-аар, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгох, гүйцэтгэх удирдлагыг томилох, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга болон тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна" гэж заасан. ТБОНӨтХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт[8] заасноор төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчийн оролцооны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн тухайн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийг төлөөлөх гишүүнийг томилохоор хуульчилсан байна.

Төрийн банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит хурлын №03 тоот тогтоолоор даргаар Б.Тэлмүүн, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Б.Ганбат, Г.Золбоо, Б.Сүх-Очир, Л.Сонор, Д.Цолмон Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит хурлын №02 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Д.Энхжаргал, С.Цэнд-Аюуш, М.Батжаргалыг тус тус сонгосон байна.

Төрийн банк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар дараах 9 (ес) гишүүдийн бүрэлдэхүүнтэй байгааг доорх хүснэгтээр харуулав. Үүнд:

*Хүснэгт №1. Төрийн банк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн*

| № | Овог, нэр | Албан тушаал | Төлөв |
|---|---|---|---|
| 1. | Б.Тэлмүүн | Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга | Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга |
| 2. | Б.Ганбат | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга | Ердийн гишүүн |
| 3. | Г.Золбоо | Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга | Ердийн гишүүн |
| 4. | Б.Сүх-Очир | Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга | Ердийн гишүүн |

[8] **Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль (1996).**
**21 дүгээр зүйл. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх, онцлог**
2. Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг дараах байдлаар томилно
2/төрийн өмчийн оролцооны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн тухайн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийг төлөөлөх гишүүний нэрийг төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд тухайн компанийн нэр дэвшүүлэх хороонд санал болгох бөгөөд нэр дэвшүүлэх хороо тэрхүү нэр дэвшигдэж байгаа этгээд нь хуульд заасны дагуу төрийг төлөөлөх этгээд мөн бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд оруулах үүрэгтэй.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичигт**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК
ТТ60874 рд.5209173

СЭХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ-03

| | | | |
|---|---|---|---|
| 5. | Л.Сонор | Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга | Ердийн гишүүн |
| 6. | Д.Цолмон | Хууль зүйн дотоод хэргийн яамны Хууль зүйн газрын даргын үүрэг түр орлон гүйцэтгэгч | Ердийн гишүүн |
| 7. | М.Батжаргал | Монголбанкны ахмад ажилтан | Хараат бус гишүүн |
| 8. | С.Цэнд-Аюуш | Сангийн яамны ахмад ажилтан | Хараат бус гишүүн |
| 9. | Д.Энхжаргал | Азийн дэд бүтэц хөрөнгө оруулалтын банкийг байгуулах ажлын хэсгийн Санхүүгийн зөвлөх | Хараат бус гишүүн |

Төрийн банк ХХК-ийн ТУЗ-ийн гишүүд болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь холбогдох хуульд заасан шаардлага хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагатай холбоотойгоор ийн боловсрол, ажлын туршлагыг дэлгэрүүлэн авч үзлээ. Үүнд:

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга**

**Б.Тэлмүүн нь** Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга бөгөөд Төрийн банк ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн №03 тоот тогтоолоор тус Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар сонгогдсон. Тэрээр Монгол Улсын Их Сургууль (цаашид "МУИС" гэх)-ийн Олон улсын харилцааны сургуулийг 2010 онд Олон улсын эдийн засгийн харилцаа мэргэжлээр бакалаврын зэрэгтэй, Санхүү эдийн засгийн дээд сургууль (цаашид "СЭЗДС" гэх)-ийг Санхүүгийн удирдлага мэргэжлээр бакалаврын зэрэгтэй, МУИС-ийн Хууль зүйн сургуулийг 2014 онд Олон улсын эрх зүйч мэргэжлээр магистрын зэрэгтэй, Америкийн Нэгдсэн Улс (цаашид "АНУ" гэх)-ын Корнеллийн Их сургуулийг 2017 онд Нийтийн удирдлага мэргэжлээр магистрын зэрэгтэй тус тус төгссөн. Тэрээр 2010-2012 онд Сангийн яамны Дэлхийн банкны Эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх техник туслалцааны төсөлд Худалдан авалтын мэргэжилтэн, 2012-2015 онд Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтэст Мэргэжилтэн, 2015-2015 онд ДЦС-3 ТӨК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн, 2015 оны 6 сард Дарханы дулааны сүлжээ ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо гишүүн, 2017-2018 онд Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтэст Мэргэжилтэн, 2018 онд Баруун бүсийн эрчим хүчний сүлжээ ТӨК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн, 2018-2022 онд Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтэст Хэлтсийн дарга, 2018-2022 онд Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн, 2018-2022 онд Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн бодлогын хэлтэст Хэлтсийн даргаар тус тус ажиллаж байсан бөгөөд 2018 оноос хойш өнөөдрийг хүртэл Шивээ овоо ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн болон Татварын Ерөнхий газрын дэргэдэх Татварын маргаан таслах зөвлөлд Гишүүн, Дарга, 2022 оноос өнөөдрийг хүртэл Сангийн яамны Татварын бодлогын газрын даргаар тус тус ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Тэлмүүн нь Компанийн

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "гаргаж өгсөн баримт бичиг" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

СЭХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14
БҮРТГЭВ-03

төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2015 оны 4 сард хамрагдаж №0130345 дугаартай гэрчилгээ авсан байна.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүд**

**Б.Ганбат нь** Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга бөгөөд Төрийн банк ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн №03 тоот тогтоолоор тус Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон. Мөн Төрийн банк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хурлын №60 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх цалин урамшууллын хорооны гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Тэрээр Оросын Холбооны Улс (цаашид "ОХУ" гэх)-ын Дотоод явдлын яамны Академийг 1990 онд Эрх зүйч мэргэжлээр бакалавр зэрэгтэй, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хант Улс (цаашид "ИБУИНВУ" гэх)-ын Коммонвэлт Ло коллеж /Commonwealth Law college/-ийг 2008 онд Эрх зүйч мэргэжлээр магистрын зэрэгтэй тус тус төгссөн. Тэрээр 1990-1995 онд Цагдаагийн байгууллагад Төлөөлөгч, Мөрдөн байцаагч, 1995-1996 онд Сангийн яамны Тамгын газарт Хуулийн зөвлөх, 1996-1998 онд Сангийн яамны Хуулийн хэлтэст Хуулийн зөвлөх, Мэргэжилтэн, 1998-1999 онд Сангийн яамны Хуулийн хэлтэст Хуулийн ахлах мэргэжилтэн, сайдын зөвлөлийн нарийн бичгийн дарга, 1999-2000 онд Сангийн яамны Төрийн захиргааны удирдлага, эрх зүйн газарт Хуулийн ахлах мэргэжилтэн, 2000-2001 онд Санхүү, эдийн засгийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт Хуулийн ахлах мэргэжилтэн, 2001-2004 онд Санхүү, эдийн засгийн яамны Төрийн захиргааны газарт Орлогч дарга бөгөөд Хуулийн хэлтсийн дарга, Сайдын зөвлөлийн нарийн бичгийн дарга, 2004-2006 онд Сангийн яамны Төрийн захиргааны газрын Орлогч дарга бөгөөд Захиргаа, хуулийн хэлтсийн дарга, Сайдын зөвлөлийн нарийн бичгийн дарга, 2006 онд Сангийн яамны Хууль, эрх зүйн газарт Газрын дарга, 2008-2009 онд Сангийн яамны Хууль, эрх зүйн газарт Орлогч дарга, 2009-2013 онд Сангийн яамны Хууль, эрх зүйн газарт Газрын дарга, 2013-2014 онд Дэлхийн банкны Олон салбарын техник туслалцааны төсөлд Эксперт, 2013-2016 онд Монголын Хуульчдын холбоонд Өмгөөлөгч, 2016 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт Газрын дарга, 2016-2018 онд Монголбанкны Хууль, эрх зүйн газарт Газрын захирал, 2018-2019 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт Газрын даргаар тус тус ажиллаж байсан бөгөөд 2019 оноос хойш өнөөдрийг хүртэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Тэргүүн дэд даргаар ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Б.Ганбат нь Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын газар болон Компанийн засаглалын Хөгжлийн Төвөөс хамтран зохион байгуулсан Компанийн засаглалын ахисан түвшний сургалтад 2019 оны 12 сард хамрагдаж №0000001 дугаартай гэрчилгээ авсан байна.

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичиг"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ
ГУУЛЬСЕН ҮЦК ХХК

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14
БҮРТГЭВ-03

**Г.Золбоо** нь Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга бөгөөд Төрийн банк ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн №03 тоот тогтоолоор тус Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон. Мөн Төрийн банк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хурлын №60 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх цалин урамшууллын хорооны дарга, Эрсдэлийн удирдлагын асуудал эрхэлсэн хорооны гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Тэрээр МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг 2002 онд Банкны эдийн засагч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хант Улс (цаашид "ИБУИНХУ" гэх)-ын Вельсийн их сургуулийг 2011 онд Олон улсын бизнесийн менежмент мэргэжлээр бакалаврын зэрэгтэй тус тус төгссөн. Тэрээр 2013-2018 онд Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн нэгтгэлийн хэлтэст дотоодын зөвлөх, 2018-2022 онд Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн нэгтгэлийн хэлтэст Хэлтсийн даргаар тус тус ажиллаж байсан бөгөөд 2019 оноос хойш өнөөдрийг хүртэл Сангийн яамны Тогтвортой амьжиргаа төслийн Захирал, мөн 2022 оноос хойш Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газарт Газрын даргаар тус тус ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Г.Золбоо нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2019 оны 5 сард хамрагдаж №0430670 дугаартай гэрчилгээ авсан байна.

**Б.Сүх-Очир нь** Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга бөгөөд Төрийн банк ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн №03 тоот тогтоолоор тус Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон. Мөн Төрийн банк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хурлын №60 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн болон Нэр дэвшүүлэх цалин урамшууллын хорооны гишүүнээр тус тус сонгогдон ажиллаж байна. Тэрээр МУИС-ийг 2005 онд Эдийн засгийн математик загварчлал мэргэжлээр бакалаврын зэрэгтэй, Австралийн холбооны Улсын Сиднейн их сургуулийг 2012 онд Эдийн засгийн онол мэргэжлээр магистрын зэрэгтэй тус тус төгссөн. Тэрээр 2005-2010 онд Сангийн яамны Төрийн сангийн газарт Мэргэжилтэн, 2012-2013 онд Сангийн яамны Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний газарт Мэргэжилтэн, 2013 онд Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хэлтсийн дарга, 2013-2017 онд Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний Хэлтсийн дарга, 2017-2021 онд Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын, Өрийн удирдлагын хэлтэст Хэлтсийн дарга, 2021 онд Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, газрын даргаар тус тус ажиллаж байсан бөгөөд 2021 оноос хойш өнөөдрийг хүртэл Сангийн яамны Санхүүгийн бодлогын Газрын даргаар ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Б.Сүх-Очир нь

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичиг"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341169 ГС15362

УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

СЗХ 2022 он 09 сар 21 өдөр БҮРТГЭВ № 01

2022-09-14 БҮРТГЭВ-03

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2015 оны 02 сард хамрагдаж №0730157 дугаартай гэрчилгээ авсан байна.

**Л.Сонор** нь Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга бөгөөд Төрийн банк ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн №03 тоот тогтоолоор тус Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон. Мөн Төрийн банк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хурлын №60 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын асуудал эрхэлсэн хорооны гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Тэрээр АНУ-ын Такома коммюнити коллежийг 2010 онд Бизнесийн удирдлага мэргэжлээр бакалаврын зэрэгтэй, АНУ-ын Вашингтоны их сургуулийг 2014 онд Санхүү бизнесийн удирдлага мэргэжлээр бакалаврын зэрэгтэй тус тус төгссөн. Тэрээр 2015-2016 онд Сангийн яамны Дэлхийн банкинд Зөвлөх, 2017 онд Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтэст Гэрээт ажилтан, 2017-2018 онд Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтэст Мэргэжилтнээр тус тус ажиллаж байсан бөгөөд 2018 оноос хойш өнөөдрийг хүртэл Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн даргаар ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Л.Сонор нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2018 оны 3 сард хамрагдаж №0520647 дугаартай гэрчилгээ авсан байна.

Энэ талаар Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчаас тодруулахад Банк нь эрхзүйн актуудыг тухай бүр Монголбанкинд холбогдох журмын дагуу хүргүүлж Монголбанкнаас эрхзүйн актыг хүлээн авч бүртгэсэн тухай Төрийн банк ХХК-д албан бичгээр буцаан мэдэгддэг байна. Монголбанк 2019-2022 онд хамаарах нийт 119 эрх зүйн актыг бүртгэсэн тухай 9 албан бичгийг Үнэт цаас гаргагчид ирүүлснээс үзвэл Үнэт цаас гаргагч нь Банкны үйл ажиллагааны тусгай зөвшөөрлөөр гүйцэтгэх гадагш чиглэсэн дүрэм, журам болон засаглалд хамаарах дүрэм, журам, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр Монголбанканд бүртгүүлэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн №42 тоот тушаалаар батлагдсан Банкны эрхзүйн баримт бичгийг бүртгэх тухай журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

**(i) Компанийн засаглалд хамаарах дүрэм, журам**

**Компанийн дүрэм**

Төрийн банк ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн хурлын №4 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан, 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн №01 тоот тогтоол, 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн №03 тоот тогтоол, 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн №01 тоот тогтоол, 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн №02 тоот тогтоолоор тус тус өөрчлөлт оруулсан Төрийн банк ХХК-ийн Дүрэм (цаашид **"Дүрэм"** гэх)-ийг хүчин төгөлдөр мөрдөж байна. Дүрэм нь нийт 14 бүлэгтэй бөгөөд банкны оноосон нэр, хаяг, тэмдэг, туг, банкны зорилго, эрхлэх үйл ажиллагаа, банкны үйл ажиллагаанд тавигдах шаардлага хориглох зүйлс, банкны өөрийн хөрөнгө, сангууд, үйл ажиллагаа явуулах хугацаа, банкны хувьцаа эзэмшигчдийн хурал, банкны төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, ажилтан, банкны дотоод хяналт шалгалт, банкны санхүүгийн тайлан, бусад мэдээллийг нийтэд мэдээлэх, банкийг өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

[12] **Банкны эрхзүйн баримт бичгийг бүртгэх тухай журам (2011)**
Нэг. **Нийтлэг үндэслэл.**
1.3. Энэхүү журамд заасан нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:
1.3.1. "Банкны эрхзүйн баримт бичиг" гэж Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий банкнаас өөрийн үйл ажиллагаандаа мөрдүүлэхээр гаргасан, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй, гадагш чиглэсэн, хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг;

**Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "гаргаж өгсөн баримт бичигт" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.**



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ТЕДЕР
ТТ5674 sh.5208173

СЭХ 2022 он 09 сар 21 өдөр БҮРТГЭВ № 01

2022-09-14 БҮРТГЭВ-03

Хуулийн фирмээс Төрийн банк ХХК-ийн дүрэм нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн №А-151 тоот Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журамд тус тус нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн фирм нь Төрийн банк ХХК-ийн дүрмийг хянахад зарим үл нийцэл илэрснийг Үнэт цаас гаргагчид мэдэгдсэн. Төрийн банк ХХК-ийн дүрмийг хянаад хуульд нийцээгүй гурван зөрчил илрүүлснийг Төрийн банк ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн №02 тоот тогтоолоор дүрэмд өөрчлөлт оруулж зассан. Түүнчлэн, Хуулийн фирмийн зөвлөмжийн дагуу IPO бэлтгэх хүрээнд Төрийн банк Хувьцаат компанийн дүрмийн төслийг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 11/22 тоот хурлын тэмдэглэлээр уг дүрмийн төслийг Төрийн банкийг хувьцаат компани болсны дараа Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн анхны хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Энэхүү Хувьцаат компанийн дүрмийн төсөлд Хуулийн фирмээс илрүүлсэн эрсдэл багатай 8 үл нийцлийг холбогдох эрх зүйн актад нийцүүлж тусгасан байна.

Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт зааснаар Хувьцаа эзэмшигч гэдэгт Сангийн яам болон Хадгаламжийн даатгалын корпорацийг ойлгоно гэж заасан. Мөн тус зүйлд Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг Монгол Улсын Засгийн газар, түүнээс эрх олгосны дагуу зөвхөн Сангийн сайд хэрэгжүүлэхээр заасан байна. Энэ нь Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасантай нийцэж байна. Мөн дүрмийн 7 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг болон Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр байна. Түүнчлэн Банкны дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3-д "*Банкийг өөрчлөн байгуулах, татан буулгах, татан буулгахтай холбоотой асуудлыг гагцхүү Засгийн газарт тавьж шийдвэрлүүлнэ*" гэж заасан байна. Ийнхүү Төрийн өмчит банкны хувьцааг олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх үндсэн чиглэлийг Монгол Улсын Их хурлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоолоор баталжээ. Уг үндсэн чиглэлийн 3.1.1-д "Засгийн газар Монголбанктай хамтран төрийн өмчит банкийг олон нийтэд нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжүүлэх хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж...." гэж заасны дагуу 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдөр уг хөтөлбөрийг баталсан байна.

Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь заалтад ТУЗ нь Гүйцэтгэх захирлыг Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр томилно гэж заасан нь Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт заасан Банкны ТУЗ нь Монголбанкны зөвшөөрснөөр Банкны гүйцэтгэх удирдлагыг томилно гэсэнтэй нийцэж байна.

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичигт**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагаа сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК 5183855 9021031195 СТС2420

УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК 5341469 ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕН ТТ58674 5208173

СЗХ 2022.09.21 он сар өдөр БҮРТГЭВ № 01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-09-14 БҮРТГЭВ-03

Төрийн банк ХХК-ийн дүрэм нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг болон Банкны тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан тусгавал зохих зүйлийг тусгасан, агуулгын хувьд Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн №А-151 тоот тушаалаар батлагдсан Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журамд нийцсэн байна гэж Хуулийн фирмээс үзлээ. Мөн Төрийн банк ХХК-ийг "нээлттэй хувьцаат компани" болгох замаар компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулж, нэмж хувьцаа гарган анх удаа нийтэд санал болгохтой холбогдуулан дүрмийн төслийг боловсруулсан дүрмийн төсөл нь цаашид энэхүү найруулгаараа батлагдана гэж үзвэл холбогдох хууль тогтоомжид нийцэхээр байна.

**Банкнаас иргүүлсэн засаглалд хамаарах дүрэм, журам**

Банкнаас иргүүлсэн засаглалд хамаарах дүрэм, журам нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн №А-151 тоот Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн №А-86 тоот тушаалаар батлагдсан Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журамд нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийлээ.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам**

Банкны засаглалд хамаарах дүрэм, журмаас онцгойлон дурдвал Сангийн сайдын 2010 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн №193 дугаартай "Журам батлах тухай" тушаалаар Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмыг баталсан байна.

Тус журмын 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт "гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно", 4.16 дахь хэсэгт "Хуралд оролцож буй гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно" гэсэн нь Компанийн тухай хууль, Банкны тухай хуульд нийцэж байна. Мөн Банкны гүйцэтгэх захирлаас хараат бусаар Дотоод аудитын газрыг байгуулах түүний ажиллах нөхцөл боломжийг хангах, удирдлага болгох дүрэм журмыг батлах зэрэг бүрэн эрхийг тодорхойлсон нь хууль болон Компанийн засаглалын журамд нийцэж байна.

Банкны Дүрмийн 8.5-д "Банкны ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг Сангийн сайд батална" гэж заасныг 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 02 тоот ХЭХ-ын тогтоолоор "Банкны ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг Төлөөлөн Удирдах зөвлөл батална" гэж өөрчлөлт оруулсан. Энэхүү өөрчлөлт нь Компанийн тухай хуулийн 76.1-д "Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хууль болон компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 76.1.13.төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;", 80.4-т "Төлөөлөн удирдах зөвлөл

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичигт"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ ТУЛГАТ ЧАНДМАНЬ БАЯН ҮЦК ХХК

СЗХ 2022.09.21 БҮРТГЭВ №01

2022-09-14 БҮРТГЭВ-03

үйл ажиллагааныхаа журмыг тогтоож батлах бөгөөд төлөөлөн удирдах зөвлөл эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно" гэж заасантай тус тус нийцсэн байна.

**ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журам**

Төрийн банк ХХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын асуудал эрхэлсэн хороо, Аудитын хороо болон Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны ажиллах журам, холбогдох бусад харилцааг зохицуулах зорилгоор нийт 4 бүлгээс бүрдсэн ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журмыг Банкны Дүрмийн 8.3.16-д заасны дагуу 2021 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн ТУЗ-ийн хурлын тогтоолын хавсралтаар баталсан байна.

Банкны Дүрмийн 8.16, энэхүү журмын 1.1-д "Хүний нөөц урамшууллын асуудал эрхэлсэн хороо", "Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо" гэж зөрүүтэй нэрлэсэн байна. Төрийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 45 дугаар тогтоолын хавсралтаар томилсон ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнээс харвал Банк нь "хүний нөөц, урамшууллын асуудал эрхэлсэн хороо"-той гэж үзэхээр байна.

Төрийн банк ХХК-ийн ТУЗ-аас 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр №45 дугаартай "Төрийн Банкны зохистой засаглалын журам"-ыг баталсан байна. Уг журмаар ТУЗ-ийн гишүүдийн Банкны тухай хууль болон Компанийн тухай хуулиар хүлээсэн эрх, үүргийг баталгаажуулахаас гадна Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх чиглэлээр нэмэлт үүргүүдийг оноосон байна. Түүнчлэн журмын 3 дугаар зүйлд төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ (i) аудитын асуудал эрхэлсэн хороо; (ii) эрсдэлийн удирдлагын асуудал эрхэлсэн хороо болон (iii) хүний нөөц, урамшууллын асуудал эрхэлсэн хороо гэсэн байнгын хороодтой байхаар заасан байна. Эдгээр Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод нь зорилго, эрх үүргээ тодорхойлсон дүрэмтэй байх ба хороо тус бүрийн үйл ажиллагаанд ТУЗ-ийн дарга хяналт тавьж ТУЗ шийдвэр гаргахдаа эдгээр хороодын дүгнэлтийг үндэслэх талаар журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэгт заасан байна. Төрийн банк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс хороодын үйл ажиллагааны журмыг дараах байдлаар баталсан байна. Үүнд:

1. "Төрийн банкны Дотоод аудитын дүрэм", Төрийн банк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн №129 дугаартай тогтоолоор шинэчлэн баталсан;
2. "Хүний нөөцийн хорооны үйл ажиллагааны журам", Төрийн банк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн №67 дугаартай тогтоолоор баталсан;
3. "Эрсдэлийн удирдлагын хорооны үйл ажиллагааны журам", Төрийн банк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн №63 дугаартай тогтоолоор баталсан;

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичигт**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕКЬЮРИТИЗ ҮЦК ХХК

СЭХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14
БҮРТГЭВ-03

4. "Зээлийн хорооны ажиллах журам", Төрийн банк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн №70 дугаартай тогтоолоор баталсан;
5. "Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хорооны үйл ажиллагааны журам", Төрийн банк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн №44 дугаартай тогтоолоор баталсан;
6. "Актив, пассивын удирдлагын хорооны үйл ажиллагааны журам", Төрийн банк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн №28 дугаартай тогтоолоор баталсан;
7. "Мэдээллийн технологийн удирдлагын хорооны журам", Төрийн банк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн №23 дугаартай тогтоолоор баталсан.

Түүнчлэн Банк нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар Нийгмийн хөгжлийн сангийн зарцуулалтын журам, Захирлуудын зөвлөлийн үйл ажиллагааны журам, Чанаргүй активыг бууруулах удирдлага, үйл ажиллагааны журам, Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих журам, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны журам, Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, Хүний нөөцийн бодлого, Эрсдэлийн удирдлагын бодлого, Дотоод ашиглан, залилангийн эрсдэлийн удирдлагын бодлого, Зээлийн бодлого, Комплаенсийн бодлого зэргийг тус тус баталж мөрдүүлсэн нь Компанийн тухай хууль болон Банкны тухай хууль, Төрийн банк ХХК-ийн дүрэмд нийцсэн байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн №145 тоот Компанийн Засаглалын Кодексийг шинэчлэн батлах тухай тогтоолд заасны дагуу нээлттэй хувьцаат компани, даатгагч, банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг компанид тус тус үүрэг болгож бусад компаниудад зөвлөсөн байна. Хувьцаат компанийн хувьд компанийн засаглалын дүрэм, журмаа Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст нийцүүлэн батлах үүрэг хүлээнэ. Иймд Банкны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж хувьцаат компани болсноор Компанийн засаглалын кодекст заасан компанийн засаглалтай холбоотой дараах дүрэм, журмыг батлах буюу зарим журамдаа нэмэлт, өөрчлөлт оруулахыг Хуулийн фирмээс зөвлөж байна. Үүнд:

1. Компанийн засаглалын кодексийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам;
2. Компанийн засаглалын кодексийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Комплаенсын хяналтын заавар;
3. Компанийн засаглалын кодексийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан Бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлого;
4. Компанийн засаглалын кодексийн 7 дугаар зүйлийн 7.4-д заасан Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам;

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичиг"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ХХК

5. Компанийн засаглалын кодексийн 9 дүгээр зүйлийн 9.3-д заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай журам.

**Төрийн банк ХХК-ийн сонирхлын зөрчлийг зохицуулах журам**

Үнэт цаас гаргах бэлтгэл ажлын хүрээнд хуулийн фирмийн зүгээс сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах журмыг Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст нийцүүлэн батлахыг зөвлөсний дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 58 дугаар тогтоолоор "Төрийн банк" ХХК-ийн сонирхлын зөрчлийг зохицуулах журмыг баталсан. Уг журмын 2.2-т банкны эрх бүхий албан тушаалтныг, 2.3-т тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийг тус тус тодорхойлсон байна. Эрх бүхий албан тушаалтан нь өөрийн болон нэгдмэл сонирхолтой этгээдийнхээ мэдээллийг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад үнэн зөвөөр мэдүүлэх үүрэгтэй байхаар журамласан. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Банк болон Банкны эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээллийн сан бүрдүүлж, хэлцэл хийгдэхийн өмнө лавлагаа гаргаж өгч байх ба Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд зэрэг журамд заасан тодорхой албан тушаалтанд танилцуулж байх, аливаа сонирхогч этгээдийн хүсэлтээр болон хууль тогтоомжийн дагуу ил болгож болохоор заасан. Сонирхлын зөрчил бүхий этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад санал өгөх эрхгүй байна. Уг журамд зааснаар сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар гаргах бөгөөд уг асуудлыг хэлэлцэхэд ТУЗ-ийн хараат бус гишүүд заавал оролцохоор заасан. Харин Банкнаас холбогдох этгээдтэй хийх хэлцэл нь банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийдэг хэлцлээс илүү таатай нөхцөл олгоогүй бол тийм хэлцэл хийх зөвшөөрөл олгох нөхцөл, журмыг ТУЗ тогтоож болно гэж заасан олон салбартай том банкны хувьд уг асуудлыг бодитоор хэрэгжихүйц байдлаар зохицуулах боломжийг олгосон байна.

Сонирхлын зөрчлийн зохицуулах журам нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекст нийцсэн байна.

**Төрийн банк ХК-ийн Дүрмийн төсөл**

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн №11/22 дугаар тогтоолоор Төрийн банк ХК-ийн дүрмийн төсөлтэй танилцаад дараах шийдвэрийг гаргажээ. Үүнд:

1. Төрийн банк ХК-ийн дүрмийн төслийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуульд нийцүүлж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгов.

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "гаргаж өгсөн баримт бичиг" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14
БҮРТГЭВ

2. Төрийн банкийг хувьцаат компани болсны дараа Төрийн банкны хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.

Хувьцаат компанийн дүрэм нь цаашид энэхүү найруулгаараа батлагдана гэж үзвэл Компанийн тухай зэрэг Монгол Улсын хуулиуд, СЗХ-ны холбогдох журамд нийцэхээр байна.

**Ногдол ашгийн бодлого**

СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын шаардлагын үндсэн дээр хуулийн фирмийн зөвлөмжийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн №57 дугаар тогтоолоор Төрийн банк ХХК-ийн Ногдол ашгийн бодлогыг баталсан болно. Уг бодлогоор хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, түүнийг хуваарилах эсэх тухай шийдвэр гаргах, энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, тайлагнах харилцааг зохицуулсан нь Компанийн тухай хуульд нийцсэн байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл Төрийн банк ХХК-ийн Дүрэм болон засаглалд хамаарах дүрэм, журам нь Компанийн тухай хууль болон Банкны тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан Банкнаас мөрдвөл зохих дүрэм, журамд нийцсэн байна.

**(ii) Хөдөлмөрийн харилцаа хүний нөөцөд хамаарах журам**

Үнэт цаас гаргагч Төрийн банк ХХК нь тасалбар болгосон өдрийн байдлаар Банкны дотоод үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах дүрэм, журмыг Хуулийн фирмд ирүүлсэн. Хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцийн бодлогод хамаарах түлхүүр зарчмыг тодорхойлсон бодлогын шинжтэй бичиг баримт болох "Хүний нөөцийн бодлого"-ыг Төрийн банк ХХК-ийн ТУЗ-ийн 2013 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн №79 дугаартай тогтоолоор баталсан байна. Уг бодлогын бичиг баримтад Төрийн банк ХХК-ийн хүний нөөцийн бодлогын үндсэн гол чиглэл нь "Хүн хөгжвөл байгууллага хөгжинө" гэсэн үзэл санааг баримтлах талаар тодорхой зааж хүний нөөцийн үйл ажиллагаанд Хамтын ажиллагааг эрхэмлэх, Удирдах, удирдуулах ёсыг баримтлах, Нээлттэй, ил тод, шударга байдлыг дэмжих, Шуурхай мэдээлэл солилцоо, нягт харилцаа холбоотой байдлыг дээдлэх, Санал санаачилгыг дэмжин оролцоог идэвхжүүлэх, Байгууллагын соёл, ёс зүйн зохистой хэм хэмжээг төлөвшүүлэх үндсэн зарчмуудыг баримтлахаар тусгасан байна.

Мөн Төрийн банк ХХК нь хүний нөөцийн асуудлуудтай холбоотой эрх зүйн бичиг баримтуудыг батлах, хэрэгжилтийг хангуулахад шаардлагатай арга хэмжээг авах, холбогдох албан тушаалтанд үүрэг, даалгавар өгөх, хөдөлмөрийн маргаантай холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, ажилтанд хариуцлага хүлээлгэх зэрэг эрх үүрэг, бүхий "Хүний нөөцийн хороо"-той байхаар заасан байна. Төрийн банк ХХК-ийн ТУЗ-ийн 2014

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичиг"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
СТС2420

УЛААНБААТАР
ТӨРИЙН БАНК
ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК
ТТБ0874 5208173

СЗХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -09- 14
БҮРТГЭВ-03

оны 12 дугаар сарын 16-ны өдрийн №67 дугаар "Журам батлах тухай" тогтоолоор Хүний нөөцийн хорооны үйл ажиллагааны журмыг баталсан байна. Уг журамд зааснаар Хүний нөөцийн хороо нь саналын эрхтэй 8 гишүүн, ажиглагч 1 гишүүн, 1 нарийн бичигтэй байх ба гишүүдийг Төрийн банк ХХК-ийн Гүйцэтгэх захирал томилохоор журамд заасан байна. Хороо нь хурлын зохион байгуулалттай байх бөгөөд долоо хоног бүр хуралдаж хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргахаар зохицуулагдсан байна. Хэрэв санал тэнцсэн бол Хорооны даргын саналаар шийдвэрлэхээр журмын 6 дугаар зүйлийн 6.1-д заасан байна. Хорооны үндсэн үүрэг нь Төрийн банк ХХК-ийн хүний нөөцтэй холбоотой эрх зүйн бичиг баримтын хэрэгжилтийг хангах, дүгнэх, шаардлагатай өөрчлөлтийг цаг тухай бүр оруулах, ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллах боломжийг хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлээс урьдчилан сэргийлэх, холбогдох албан тушаалтанд үүрэг даалгавар өгөх биелэлтийг хянах зэрэг юм. Түүнчлэн хороо нь хүний нөөцтэй холбоотой боловсруулагдаж буй эрх зүйн баримт бичгийг батлах, хүний нөөцийн стратеги, газар, хэлтсийн бүтэц орон тоог батлах, удирдах түвшний албан тушаалтныг ажилд авах, шилжүүлэх, хөдөлмөрийн гэрээг цуцлах, "Ёс зүйн дүрэм", "Хөдөлмөрийн дотоод журам" зөрчсөн ажилтнуудад өөрт олгогдсон эрхийн хүрээнд хариуцлага хүлээлгэх эрхтэй байхаар журамлагдсан байна.

Төрийн банк ХХК-ийн ТУЗ нь 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн №41 дугаартай тогтоолоор "Ёс зүйн дүрэм"-ийг шинэчлэн баталсан байна. "Ёс зүйн дүрэм"-ийг батлахдаа Банкны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийг үндэс болгосон байна. Уг дүрэм нь банкны ТУЗ-ийн дарга, гишүүд болон бусад бүх ажилтанд хамаарах ба Банкинд хөлсөөр болон контрактаар ажиллаж буй этгээдүүдэд мөн адил үйлчлэхээр заасан байна. Уг дүрэмд нийт ажилтнуудын мөрдвөл зохих ёс зүйн хэм хэмжээг тогтоохоос гадна ажилтан албан үүргээ хэрэгжүүлэхдээ хориглох ёс зүйн хэмж хэмжээ, олон нийтийн мэдээллийн сүлжээг ашиглах, нууц хадгалах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, залилангийн шинжтэй үйл ажиллагаанд оролцох, авилгаас ангид байх зэрэг ёс зүйн үүргүүдийг тусгайлан заасан байна. Ёс зүйн зөрчил гаргасан байдлын талаар мэдээлэл өгсөн ажилтны нэрийг нууцлах, хамгаалах талаар энэхүү дүрэмд тусгасан ба мэдээлэл өгсөн тохиолдолд чиг үүргийн дагуу холбогдох нэгж гомдлыг хүлээн авах боловч Хүний нөөцийн хороо ТУЗ-д тайлагнан ажиллахаар зохицуулсан байна. Ёс зүйн зөрчил гаргасан ажилтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Хөдөлмөрийн тухай хууль болон Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулахаар зохицуулсан байна.

Үнэт цаас гаргагч нь Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэгт заасан ажил олгогч нь хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журам

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичигт**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9020031135 СТС2420

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341409

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТБ5874 5208173

СЗХ
2022.09.21
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
2022-09-14
БҮРТГЭВ-03

баталж мөрдүүлнэ гэж заасны дагуу Гүйцэтгэх захирлын 2022 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн №А/137 тоот тушаалаар Банкны Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталсан байна.

Журмын 1 дүгээр зүйлийн 1.6 дахь хэсэгт зааснаар хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд талууд үл ялгаварлан гадуурхах, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ажлын аятай орчноор хангуулах, барьцаа хэрэглэхгүй байх, эвлэлдэн нэгдэх эрхийг хангах, авлига болон ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зэрэг Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан суурь зарчмуудыг тусгасан байна.

Энэхүү журмаар ажилтныг сонгон шалгаруулах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажил олгогч болон ажилтны эрх, үүрэг, ажлын цаг, ээлжийн амралт, ажилтанд олгох цалин хөлс, урамшуулал, тэтгэмж, нөхөн олговор, эд хөрөнгийн хариуцлага, ажилтанд нөлөөллийн арга хэмжээ авах, сахилгын шийтгэл ногдуулах, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгох, ажилтны гомдлыг шийдвэрлэх асуудлыг тус тус тодорхойлон тусгасан байна. Тухайлбал Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсэгт Банк нь ажиллах хүчний орон тоо, ажил мэргэжлийн жагсаалтыг жил бүрийн 1 дүгээр сард багтаан Гүйцэтгэх захирлын тушаалаар баталдаг байхаар зохицуулсан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.3 дахь заалттай нийцэж байна. Мөн Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу ажил олгогчийн гол үүрэг болох тухайн ажилтны ажлын байрны тодорхойлолтыг заавал баталгаажуулж өгөх үүргийг Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.7 дахь хэсэгт зааж өгсөн байна.

Журмын 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт Банк нь шинээр ажилтан авах, өөр ажилд томилохдоо ажил үүрэг, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, цалин хөлс бусад шаардлагатай мэдээллээр урьдчилан хангахаас гадна ажилтныг ажилд авсан тушаалыг танилцуулж эх хувийг өгөх, хөдөлмөрийн гэрээ болон ажлын байрны тодорхойлолтыг бичгээр үйлдэн гарын үсэг зурж баталгаажуулан эх хувийг өгөх, эд хөрөнгийн хариуцлагын гэрээг бичгээр үйлдсэн байх зэрэг зохицуулалтыг оруулсан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 41, 48 болон 49 дүгээр зүйлтэй нийцэж байна.

Мөн журамд Ажил олгогч болон ажилтны эрх үүргийг нарийвчлан тусгахаас гадна Хөдөлмөрийн гэрээг хугацаатай болон хугацаагүй байгуулж болох талаар зааж тус бүрийн онцлогийг дэлгэрэнгүй зааж оруулсан байна. Журмын 13-17 дугаар зүйлд Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох зохицуулалтыг оруулж өгсөн ба энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 78-83 дугаар зүйлтэй нийцэж байна. Тухайлбал Хөдөлмөрийн дотоод журмын 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэгт [13] ажилтан

[13] **Төрийн банк ХХК-ийн Хөдөлмөрийн дотоод журам (2022).**
15 дугаар зүйл. **Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа ажил олгогчийн санаачлагаар цуцлах**
15.5. Банк Хөдөлмөрийн тухай хуулийн 80.4-д заасны дагуу хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах тухай Ажилтанд 30-аас доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэх бөгөөд ажилтанд мэдэгдэл өгсөн тухайгаа шаардлагатай тохиолдолд ажил олгогч нотлох үүрэгтэй.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичигт"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183856
9021031195 СТС2420
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДЭЙ ҮЦК ХХК

СЗХ 2022 он 09 сар 21 өдөр БҮРТГЭВ № 01

хөдөлмөрийн гэрээг цуцлах саналаа 30-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдсэн байхаар заасан байна. Хөдөлмөрийн дотоод журам нь нийт 15 (арван таван) хавсралттай бөгөөд Хөдөлмөрийн гэрээ, Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ болон бусад дагалдах акт, хуудас зэргийн төслийн баталсан байна.

Төрийн банк ХХК нь тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 27 (хорин долоо) дүрэм, журам иргүүлсэн ба хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах дүрэм, журмууд нь Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомжид нийцэхээр байна гэж үзлээ.

**(iii) Бизнесийн бодлого, төлөвлөлттэй холбоотой дүрэм, журам**

Төрийн банк ХХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн №44 дугаартай "Журам шинэчлэн батлах тухай" тогтоолоор "Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хорооны үйл ажиллагааны журам"-ыг баталсан байна. Хороо нь хорооны дарга, 8 гишүүн, 1 нарийн бичгийн дарга гэсэн бүрэлдэхүүнтэй байх ба бүрэлдэхүүнийг Гүйцэтгэх захирал томилж, чөлөөлөхөөр заасан байна. Хороо нь 14 хоног тутамд нэг удаа хуралдах ба гишүүдийн дийлэнх олонх нь оролцсоноор хурал хүчин төгөлдөр болж хуралд оролцсон гишүүдийн дийлэнх Хороо нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд шинэ бүтээгдэхүүн зах зээлд нэвтрүүлэх, одоо байгаа бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах, шинээр харилцагч татах хөтөлбөр хэрэгжүүлэх, маркетинг болон нийгмийн хариуцлагын чиглэлээр банкнаас баримтлах бодлого, жилийн хөтөлбөрийг батлах, харилцагчийн үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээ авах, банкны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, нэр хүндийг өсгөх хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэрэгжүүлсэн хөтөлбөр, бодлогын үр дүнг тооцох шийдвэрийг гаргах эрхтэй байх юм.

Бизнесийн бодлого төлөвлөлттэй холбоотой дүрэм, журмаас онцгойлон авч үзвэл захирлын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн №А/08 дугаартай тушаалаар баталсан "*Үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл шинэчлэн батлах тухай*" журам байна. болоод үйлчилгээний хүү, шимтгэл, хураамжийн хэмжээг нэгдсэн

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичигт**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК

ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

СЭХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14

байдлаар тогтоосон байна. Тус журамд үйлчилгээний төрлийг дараах байдлаар ангилан авч үзсэн байна. Үүнд:

1. Дансны үйлчилгээний ерөнхий нөхцөл;
2. Харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүний ерөнхий нөхцөл;
3. Бусад бүтээгдэхүүн үйлчилгээний ерөнхий нөхцөл;
4. Картын үйлчилгээний ерөнхий нөхцөл;
5. Цахим үйлчилгээний ерөнхий нөхцөл;
6. Гадаад төлбөр тооцооны ерөнхий нөхцөл;
7. Зээлийн бүтээгдэхүүний ерөнхий нөхцөл;
8. Даатгалын бүтээгдэхүүн;
9. Худалдааны санхүүжилтийн үйлчилгээний ерөнхий нөхцөл.

Дээрх ангилал тус бүрээр бүтээгдэхүүний төрлийг задлан төрөлжүүлсэн байх бөгөөд тухайн бүтээгдэхүүнийг харилцагчдад санал болгохдоо ямар нөхцөлөөр санал болгохыг нэг бүрчлэн тогтоож өгсөн байна. Мөн бүтээгдэхүүн тус бүрээр үйлчилгээний шимтгэл болон хураамжийн хэмжээ ямар байхыг тогтоосон байна. Зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээ болоод хадгаламжийн бүтээгдэхүүний хүү, хугацаа зэргийг мөн нэг бүрчлэн тогтоож өгсөн байна.

Төрийн банк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн №А/206 дугаартай "Журам шинэчлэн батлах тухай" тушаалыг Бизнесийн бодлого төлөвлөлттэй холбоотой дүрэм, журмаас онцгойлон авч үзэх шаардлагатай. Учир нь уг тушаалаар "Төрийн банкны бүтээгдэхүүн үйлчилгээний журам"-ыг шинэчлэн баталсан байна. Уг журмаар Төрийн банкнаас иргэн, аж ахуйн нэгжид дансны болон бусад бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэх нөхцөл, журмыг тодорхойлох, Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг борлуулах, эдгээр үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой зохицуулалтыг тогтоосон байна. Тус журмаар дараах үйлчилгээг илүү нарийвчлан зохицуулсан. Үүнд:

1. Дансны үйлчилгээ (дансны үйлчилгээ үзүүлэх, хүү тооцох аргачлал, гүйлгээ хийх, чекээр үйлчилгээ үзүүлэх, хаагдсан данс нээх, идэвхгүй данс, дансны хамтран эзэмшил гэх мэт);
2. Эскроу буюу дундын дансны үйлчилгээ (дундын данс нээх, зарлага гаргах, дансыг хаах гэх мэт);
3. Үнэт зүйл хадгалах үйлчилгээ (зохицуулалт, эзэмшлийн хэлбэр, хайрцаг нээх, түлхүүр хадгалах, эрх бүхий байгууллагаас хайрцаг нээх гэх мэт);
4. Автомат шилжүүлэг хийх үйлчилгээ (зохицуулалт, үйлчилгээнд бүртгэх, автомат шилжүүлэг хийх, төлбөр тооцоо гэх мэт);
5. Халамж нэрийн дансанд шилжүүлэх (үйлчилгээнд бүртгэх, бусад).

Уг тушаалын хавсралтаар дээрх үйлчилгээнд хамаарах гэрээний төслүүдийг боловсруулан баталгаажуулсан ба дараах байдлаар ангилж болохоор байна. Үүнд:

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "гаргаж өгсөн баримт бичиг" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -09- 14
БҮРТГЭВ

1. Хадгаламжийн гэрээ (хугацаагүй хадгаламж, хугацаатай хадгаламж, хүүхдийн хадгаламж, тусгай нөхцөлт хугацаагүй хадгаламж зэрэг нийт 9 гэрээний төсөл)
2. Харилцах дансны гэрээ (тусгай нөхцөлт харилцах данс, чекээр гүйлгээ хийх, эскроу дансны зэрэг нийт 7 гэрээний төсөл)
3. Үнэт зүйл хадгалах гэрээний 2 төсөл зэрэг болно.

Эдгээр гэрээ нь Иргэний хууль, Банкны тухай хууль болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нийцэж буй эсэхийг дүгнэлтийн 4 дүгээр бүлгийн Үндсэн үйл ажиллагаа буюу зээлийн үйл ажиллагаанд хамаарах гэрээ, хэлцэл хэсгээс танилцана уу.

Төрийн банк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн №А/137 дугаартай тушаалаар "Бүтээгдэхүүн үйлчилгээний тусгай нөхцөл"-ийг шинэчлэн баталсан байна. Энэхүү журмаар урт хугацаагаар эх үүсвэр байршуулсан харилцагчид хүү нэмэгдүүлж олгох эрхийг нэгжийн захиралд олгохоос гадна нэмэгдүүлэн олгох хүүгийн хэмжээг зааж өгсөн байна. Мөн гадаад валютын шимтгэл, хураамжаас чөлөөлөх нөхцөл, гүйлгээний хураамжаас чөлөөлөх нөхцөл, бүтээгдэхүүний хураамжаас чөлөөлөх нөхцөл, урамшуулал олгох нөхцөл болон депозит бүтээгдэхүүний тусгай нөхцөлийг зааж өгсөн байна. Гүйцэтгэх захирлын 2022.06.07-ны өдрийн тушаалаар Бүтээгдэхүүн үйлчилгээний тусгай нөхцөлийг хууль тогтоомжид нийцүүлэн хүчингүй болгосон.

Төрийн банк ХХК-ийн зүгээс тасалбар болгосон өдрийн байдлаар Бизнесийн бодлого, төлөвлөлттэй холбоотой 15 (арван тав) дүрэм, журам ирүүлсэн нь Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжид нийцэхээр байна гэж үзлээ.

**(iv) Харилцагчийн үйлчилгээний дүрэм, журам**

Төрийн банк ХХК нь тасалбар болгосон өдрийн байдлаар Харилцагчийн үйлчилгээтэй холбоотой 7 дүрэм, журам ирүүлсэн байна. Эдгээр нь даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбоотой журам, харилцагчийн үйлчилгээтэй холбоотой журам, касс, үнэт зүйлстэй холбоотой дүрэм журмууд юм. Эдгээрээс Гүйцэтгэх захирлын 2021 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн №А/135 дугаартай тушаалаар баталсан "Харилцагчийн үйлчилгээний журам"-ыг дэлгэрүүлэн авч үзье.

Уг журамд Төрийн банк ХХК-ийн нийт харилцагчдад чанартай, түргэн шуурхай, сэтгэл ханамжтай үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээнд баримтлах зарчим, стандартыг мөрдүүлэх, хяналт тавихтай холбоотой зохицуулалтыг тусгасан байна. Мөн Банкны

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичиг"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ХУУЛИЙН ЗӨВЛӨХ ... КАПИТАЛ ... ХХК
5183855
5071030195 СТС2420

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5344469 ГСТ5383

УЛААНБААТАР ХОТ
... ҮЦК ХХК
ТТБ0874 ... 5208173

СЭХ 2022 .09 сар 21 өдөр БҮРТГЭВ № 01

2022-09-14 БҮРТГЭВ-03

ажилчдын ажлын хувцасны стандарт болон биеэ авч явах байдал, эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын дүр төрхийн стандартыг тодорхой зааж өгсөн байна. Журмын дагуу харилцагчийг үндэс угсаа, нас, хүйс, хэл соёл, хөрөнгө чинээ, албан тушаал, найз нөхөд, гэр бүлийн хэлхээ холбоо зэргээс үл хамааран эрх тэгш үйлчлэх зарчим баримтлахыг нийт ажилтнуудаа үүрэг болгож журмын 3 дугаар зүйлийн 3.2.4-д тусгасан байна. Мөн өндөр настай, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй, 0-3 насны хүүхэдтэй харилцагчид дараалал харгалзахгүй нэн түрүүнд үйлчилнэ гэж заасан байна.

**(v) Аюулгүй байдалтай холбоотой дүрэм, журам**

Төрийн банк ХХК-ийн зүгээс тасалбар болгосон өдрийн байдлаар Банкны аюулгүй байдлыг хангахтай холбоотой хүчин төгөлдөр үйлчилж буй 8 дүрэм, журам ирүүлсэн байна. Эдгээр дүрэм журмыг батлахдаа Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль, Галт зэвсгийн тухай хуулийг удирдлага болгосон байна.

Гүйцэтгэх захирлын 2014 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн №А/171 дугаартай тушаалаар "Төрийн банк ХХК-ийн аюулгүй байдлын стандарт"-ыг баталсан байна. Уг стандартаар хаалганы камер, теллерийн камер, гадна камер, АТМ камер, сүлжээний төхөөрөмж, бичлэг хадгалах компьютерын үзүүлэлт, тог баригч, тэжээлийн төхөөрөмж зэрэг тоног төхөөрөмжийн стандартыг тогтоож өгсөн. Мөн утаа мэдрэг, хөдөлгөөн мэдрэгч, дулаан мэдрэгч төхөөрөмж болон дагалдах тоног төхөөрөмжийн үзүүлэлт зэргийг тогтоосон байна.

Гүйцэтгэх захирлын 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн №А/418 дугаартай тушаалаар "Аюулгүй байдал, хамгаалалтын дотоод журам"-ыг шинэчлэн баталсан байна. Мөн 2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн №А/202 дугаартай Гүйцэтгэх захирлын тушаалаар Банкны үйл ажиллагааны онцлогтой уялдуулан "Аюулгүй байдлын хамгаалагчийн мөрдөх заавар"-ыг шинэчлэн баталсан байна.

Мөн галын аюулгүй байдал, хяналтын камерын системийн үйл ажиллагааны талаар, харуул хамгаалалтын алба хаагчийн галт зэвсэг, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх журам, аюулгүй байдлын техник хэрэгсэл ашиглах журам зэргийг батлаж мөрдүүлсэн байна.

**(vi) Мэдээллийн технологийн дүрэм, журам**

Төрийн банк ХХК-ийн зүгээс тасалбар болгосон өдрийн байдлаар мэдээллийн технологийн зохицуулалттай холбоотой хүчин төгөлдөр үйлчилж буй 6 журмыг Хуулийн фирмд ирүүлсэн. Төрийн банк ХХК-ийн ТУЗ-өөс 2021 оны 02 дугаар сарын 28-ны өдөр №23 дугаартай тогтоолоор "Мэдээллийн технологийн удирдлагын журам"-ыг тусгайлан баталсан байна. Уг хороо нь 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд гишүүдийг Гүйцэтгэх захирал томилж чөлөөлөх эрхтэй байна. Хорооны үйл ажиллагаа нь хурлын зохион байгуулалттай байх ба 5 болон түүнээс дээш гишүүн ирснээр хурал

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичигт**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ ГҮЙДЭЛ

хүчин тогтолдор болно. Хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гарах боловч хорооны дарга хориг тавих эрхтэй байхаар журмын 7 дугаар зүйлийн 7.2-т заасан байна.

Хороо нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд Төрийн банк ХХК-ийн хэмжээнд ашиглагдаж байгаа мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн нөөцийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх, хомсдолтой тоног төхөөрөмжийн нөөцийг шийдвэрлэх, банкны хэмжээнд ажиллаж буй мэдээллийн технологийн ажилтнууд болон салбарын ажилтнуудад удирдлага, арга зүйн зөвлөгөө өгөх, шинэ бүтээгдэхүүн гарах тохиолдолд мэдээллийн технологитой уялдуулах зэрэг ажлыг хариуцахаар журамд заасан байна.

Төрийн банк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн №А/299 дугаартай тушаалаар "Мэдээллийн технологийн үйл ажиллагааны цогц журам"-ыг шинэчлэн баталсан байна. Уг журмаар Банкны мэдээллийн технологийн үйл ажиллагааны үндсэн горим, сүлжээ, программ хангамж болон техникт тавигдах үндсэн шаардлага, системийн аюулгүй байдал, мэдээлэл дамжуулах, хадгалах, хамгаалах цогц үйл ажиллагааг журамласан байна. Энэхүү журамтай холбогдуулан дагалдах хэд хэдэн журам баталж мөрдүүлсэн байх бөгөөд Мэдээллийн технологи хариуцсан салбар нэгжийн үйл ажиллагаанд удирдлага болгох дагаж мөрдөхөд хэрэгтэй журмууд гэж үзэхээр байна.

**(vii) <u>Зээлийг бодлого, зээлийн бүтээгдэхүүний журам</u>**

Үнэт цаас гаргагч нь тасалбар болгох өдрийн байдлаар өөрийн дотоод үйл ажиллагаандаа хүчин төгөлдөр мөрдөж байгаа зээлийн бодлого, зээлийн үйл ажиллагаанд хамаарах нийт 25 журмыг Хуулийн фирмд ирүүлсэн Үүнд:

1. Зээлийн бодлого, Төрийн банк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн №78 дугаартай тогтоолоор баталсан;
2. Зээлийн хорооны ажиллах журам, Төрийн банк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн №70 дугаартай тогтоолоор баталсан;
3. Зээлийн үйл ажиллагааны журам, Төрийн банк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А-237 дугаартай тогтоолоор баталсан;
4. Зээлийн бүтээгдэхүүний журам, Төрийн банк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А-238 дугаартай тогтоолоор баталсан;
5. Бүтээгдэхүүн үйлчилгээний журам, Төрийн банк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А-206 дугаартай тогтоолоор баталсан;

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичигт"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.

СЗХ
2022.09.21
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14

6. Зээлийн төвийн үйл ажиллагааны журам, Төрийн банк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А-241 дугаартай тогтоолоор баталсан;
7. Төрийн банкны зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны журам, Төрийн банк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А-151 дугаартай тогтоолоор баталсан;
8. Скоринг үнэлгээний журам, Төрийн банк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А-203 дугаартай тогтоолоор баталсан;
9. Зээлийн хүлээгдэж буй алдагдлыг тооцох аргачлал, Төрийн банк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А-282 дугаартай тогтоолоор баталсан;
10. Төрийн банкны зээлийн эрхтэй картын журам /2022.06.07-ны тушаалаар хүчингүй болгож шинэчлэн баталсан/;
11. Төслийн зээлийн бүтээгдэхүүний журам, 2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А-466 дугаартай тогтоолоор баталсан;
12. Хөдлөх эд хөрөнгийн болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдэл бүртгүүлэх үйл ажиллагааны журам, Төрийн банк ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А-465 дугаартай тогтоолоор баталсан;
13. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн журам, Төрийн банк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А-310 дугаартай тогтоолоор баталсан;
14. Гялс зээлийн журам /2022.06.07-ны тушаалаар хүчингүй болгож шинэчлэн баталсан/;
15. Ажлын байрыг дэмжих зээлийн журам, Төрийн банк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А-114 дугаартай тогтоолоор баталсан;
16. Репо арилжааны санхүүжилттэй зээлийн журам, Төрийн банк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А-08 дугаартай тогтоолоор баталсан;
| 20. | Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл | - | 172 | 172 |
| 21. | ГЯЛС зээл | - | 477 | 477 |
| 22. | IFAD төслийн зээл | - | 16 | 16 |
| 23. | Байгальд ээлтэй төслийн зээл | - | 416 | 416 |
| 24. | Ажлын байрыг дэмжих зээл | | 8,624 | 8,624 |
| 25. | Бусад | 56 | 12 | 68 |
| 26. | Эргэлтийн хөрөнгийн зээл | 90 | 295 | 385 |
| | **НИЙТ** | **33,287** | **403,821** | **437,108** |

**Төрийн банк ХХК-аас ирүүлсэн гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар байгуулсан хүчин төгөлдөр хэрэгжиж буй зээлийн гэрээний жагсаалтаас санамсаргүй**

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "гаргаж өгсөн баримт бичиг" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХҮК ХХК
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ ГҮХАН ХХК

СЭХ
он 2022 сар 2 1 өдөр
БҮРТГЭВ
№ 01



ТӨРИЙН БАНК
ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

2022 -09- 14

түүврийн аргаар 131 (нэг зуун гучин нэг) гэрээг сонгон авч үзэж танилцлаа. (Хавсралт №02. Төрийн банк ХХК-ийн хуулийн этгээд, хувь хүнтэй байгуулсан зээлийн гэрээний мэдээлэл)

Банк нь үйл ажиллагаа явуулахдаа жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн чиг хандлагад үндэслэн тэргүүлэх ач холбогдол бүхий салбарыг дэмжих, Засгийн газрын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, нийгмийн хөгжлийг дэмжих зорилгоор зээл олгох, байгальд орчинд ээлтэй, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих бодлого баримтлахаа Зээлийн бодлогодоо тодорхой тусгасан байна. Зээлийн үйл ажиллагааг дараах чиглэлээр ангилан, ангилал бүрээр зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлсэн байна. Үүнд:

1. **Хуулийн этгээдийн зээл:** бичил зээл, эргэлтийн хөрөнгийн зээл, хөрөнгө оруулалтын зээл гэх мэт;
2. **Иргэдийн зээл:** цалингийн зээл, санхүүгийн түрээс, хэрэглээний зээл, бизнесийн зээл, орон сууцны зээл, малчдыг дэмжих зээл гэх мэт.

Банк нь гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар 40 орчим төрлийн зээлийн бүтээгдэхүүнийг санал болгож гэрээ байгуулсан ба гэрээ байгуулахдаа “Зээлийн бодлого”-д заасны дагуу хот болон хөдөө орон нутгийн зээлдэгчид, бизнесийн байгууллагууд, шашны болон төрийн бус байгууллагууд, Монгол болон бусад үндэстэн ястан, гадаадын байгууллагуудад санал болгосон байна.

Төрийн банк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2017 оны №А/30 тоот тушаалаар Банкны хэмжээнд хийгдэж буй зээлийн гэрээнүүд болон барьцаа, батлан даалт, ипотекийн гэрээнүүдийн загварыг шинэчлэн баталсан байна.

**(i) Зээл, барьцаат зээл, зээлийн шугамын гэрээ**

ИХ-ийн 281-285 дугаар зүйлд зээлийн гэрээний зохицуулалтыг заасан ба 451-453 дугаар зүйлд банкнаас зээл олгох гэрээний зохицуулалтыг нэмж тусгасан байдаг. Мөн Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19-26 дугаар зүйлд банкны зээлийн үйл ажиллагаа, зээлийн гэрээ, зээлийн хувийн хэргийн талаарх зохицуулалтыг илүү нарийвчлан заасан байна.

Банк нь иргэн, хуулийн этгээдтэй байгуулах зээлийн гэрээгээр тодорхой хугацаа, хүү, үүргийн гүйцэтгэлийг хангах арга, зориулалттайгаар мөнгөн хөрөнгө зээлдүүлэх, зээлдэгч зээлийг хүү, тооцогдсон бол нэмэгдүүлсэн хүүгийн хамт эргэн төлөхтэй холбоотой талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлж зохицуулсан байна. Зээлийн хүүгийн хувь хэмжээ нь зээлийн бүтээгдэхүүнээс хамааран харилцан адилгүй байж болохоор Банк өөрөө тогтоосон хэдий ч зээлийн гэрээнд жилийн буюу 365 хоногт тогтмол байхаар заасан байна. Нэмэгдүүлсэн хүүний хувьд хүүгийн 20%-иар

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **“гаргаж өгсөн баримт бичигт”** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО
КАПИТАЛ ҮЦК
ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН
БАНК

УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

ТӨРИЙН БАНК
ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

СЗХ
он 2022 сар 09 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14

тооцож авахаар зээлийн гэрээнд тусгажээ. Дээрх заалтууд нь ИХ-ийн 282 дугаар зүйлийн 282.1, 452 дугаар зүйлийн 452.1-2 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3, 20 дугаар зүйлийн 20.2.5-7 дахь хэсэгтэй нийцэж байна.

Зээлийн гэрээнд зээлийн дүн, валютын төрөл, гэрээний хугацаа, зээлийн зориулалт, тухайн зээлийн данс, зээлийн данснаас олголт хийх хэлбэр, талуудын оршин байгаа, оршин суугаа газрын хаягийн мэдээлэл зэргийг оруулахаар заасан нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1-12 дугаар заалтыг хангаж байна. Зээлийн гэрээнд зээлдэгч нь авсан зээлээ хугацаанаас нь өмнө төлөх эрхтэй байхаар заасан нь ИХ-ийн 283 дугаар зүйлийн 283.3 болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-2 дугаар заалтыг хангажээ. ИХ-ийн 222 дугаар зүйлийн 222.5 дахь хэсэгт хүүгээс анз тооцохгүй байх тухай заасан. Өөрөөр хэлбэл зээлдэгч нь үүргээ гүйцэтгэх хугацаа хэтрүүлсэн тохиолдолд нэмэгдүүлсэн хүү төлөх ба нэмж анз төлөхгүй. Зээлийн гэрээнд зөвхөн нэмэгдүүлсэн хүүгийн талаар заасан ба ямар нэгэн анзын талаар дурдаагүй нь хуулийн дээрх зохицуулалттай нийцэж байна. Банк нь зээлийн гэрээнд үүргийн гүйцэтгэлийг хангах арга болгож барьцааны гэрээ, ипотекийн гэрээ, фидуцийн гэрээ, батлан даалтын гэрээнээс аль нэгийг байгуулах эсхүл дурдсан бүх гэрээг байгуулж болохоор заасан байна. Эдгээр гэрээ нь тусдаа бие даасан зохицуулалттай бөгөөд зээлийн гэрээний салшгүй нэг хэсэг юм. Мөн зээлдэгч хүсвэл зээлийн гэрээг нотариатаар гэрчлүүлж болох ба дээрх дагалдах гэрээг төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, холбогдох хураамж болон гарах зардлыг зээлдэгч хариуцахаар гэрээнд заасан байна.

Банкны барьцаат зээлийн гэрээ нь зээлийн гэрээтэй ижил зохицуулалттай боловч зээлийн зориулалтын дагуу худалдан авсан хөрөнгөө барьцаалуулдаг онцлогтой. Мөн барьцаа хөрөнгийг шаардлагатай тохиолдолд даатгуулж даатгалын хураамжийг зээлдэгч тал хариуцахаар барьцаат зээлийн гэрээнд заасан байна. Хэрэв гэрээний хугацаанд даатгалын тохиолдол үүсвэл даатгагчаас олгох нөхөн төлбөрөөс тэргүүн ээлжид зээлдэгчээс банкны өмнө гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнг үл маргах журмаар суутган төлүүлэхээр зохицуулсан байна. Барьцаат зээлийн гэрээнд үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцааны гэрээ, фидуцийн гэрээ, ипотекийн гэрээ, батлан даалтын гэрээг байгуулж болохоор заасан. Төрийн банк ХХК-ийн зүгээс мөн хадгаламж барьцаалсан зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгож гэрээ байгуулдаг ба уг гэрээ нь зохицуулалтын хувьд барьцаат зээлийн гэрээтэй ижил байна.

Төрийн банк ХХК нь зээлийн шугамын гэрээгээр зээлдэгчид тодорхой хугацаанд зээлийн эрхийн дээд хэмжээг зааж өгөх байдлаар зээл авах эрхийг олгодог. Энэ хугацаанд зээлдэгч нь зээлийн эрхийн хэмжээнд багтаан зээл авах буцаан төлөх

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "гаргаж өгсөн баримт бичигт" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ
ГҮЙДЭЛ ҮЦК ХХК

СЗХ
он 2022 сар 09 өдөр 21
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14
БҮРТГЭВ-03

харилцааг хэдэн ч удаа үүсгэж болдог онцлогтой. Мөн энгийн зээлийн гэрээнээс ялгаатай нь зээлийн шугамын данснаас зарлагын гүйлгээ хийснээр зээлийг олгосонд тооцдог ба ашиглаагүй зээлийн эрхийн үлдэгдэлд жилийн буюу 365 хоногт тогтмол хувиар шимтгэл төлдөг. Зээлийн шугамын гэрээний бусад зохицуулалт нь зээлийн гэрээтэй ижил байна. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх зээлийг зээлийн шугам хэлбэрээр олгож болохоор зохицуулсан байна.

Овердрафт нь нэг төрлийн зээл ба гэрээгээр тогтоосон эрхийн хэмжээнд зээлдэгч нь өөрийн харилцах данс эсхүл төлбөрийн картын дансны үлдэгдлээс илүү хэмжээгээр зарлагын гүйлгээ хийх, тухайн дансанд хийсэн орлогоор эргэн төлөлт хийх нөхцөлтэй зээлийн эрх юм. Банкны овердрафтын гэрээний гол онцлог нь өрхийн санхүүгийн хэрэглээ, хэрэглээний худалдан авалт зэрэг бага дүнтэй түргэн шуурхай хийгддэг гүйлгээнд түлхүү ашиглагддаг. Овердрафтын гэрээг иргэн, хуулийн этгээдийн аль алинтай нь байгуулж болох ба гэрээгээр зээлжих эрхийн дээд хэмжээ, хугацаа, валютын төрөл, хүү, нэмэгдүүлсэн хүү, шимтгэл, үүргийн гүйцэтгэлийг хангах арга зэргийг тогтоож өгсөн нь ИХ-ийн 451-453 дугаар зүйл, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19-27 дугаар зүйлтэй нийцэж байна.

**(ii) Батлан даалтын гэрээ**

Банкны Батлан даалтын гэрээгээр зээлийн гэрээний дагуу төлбөрийн үүрэг хүлээсэн зээлдэгч үүргээ зөрчсөн буюу үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй эсхүл үүргээ гүйцэтгэж чадахгүй нь илт болсон тохиолдолд батлан даагч нь Банкны шаардлагын дагуу төлбөрийн үүргийг хамтран хариуцахтай холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

ИХ-ийн 459 дүгээр зүйлийн 459.3 дахь хэсэгт батлан даалтын гэрээнд батлан даагчийн хүлээх хариуцлагын дээд хэмжээг заана гэсэн байна. Мөн хуулийн 460 дугаар зүйлийн 460.4 дэх хэсэгт батлан даагч нь батлан даалтын гэрээнд заасан хэмжээгээр хариуцлага хүлээнэ гэсэн байна. Батлан даалтын гэрээнд зээлийн гэрээний үүргийг бүхэлд нь батлан даагч талаас шаардаж болохоор Банкны зүгээс оруулсан байна. Батлан даалтын гэрээнд батлан даагчийн хамтран хариуцах үүргийн хэмжээ нь зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбөр, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр, барьцаа хөрөнгийг хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээ хийх, тээвэрлэх, худалдан борлуулахтай холбоотой Банкнаас гарсан зардал, зээлийн гэрээтэй холбоотой үүссэн маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхтэй холбоотойгоор Банкинд учирсан хохирол, зардал, Банкнаас гарсан бусад зардлуудын нийлбэр дүнтэй тэнцүү байхаар заасан байна. Гэрээний энэхүү заалт нь ИХ-ийн 460 дугаар зүйлийн 460.5 дахь хэсэгт заасан зохицуулалттай зөрчилдөхөөргүй байна гэж үзлээ. Хэрэв зээлдэгч зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлээгүйн улмаас батлан даагч нь батлан даалтын гэрээний

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "гаргаж өгсөн баримт бичигт" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ
ГУУЛИГ ХХК

ТӨРИЙН БАНК
ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

СЭХ
он 2022 сар 09 өдөр 21
БҮРТГЭВ
№ 01

2022-03-14
БҮРТГЭВ

дагуу зээлдэгчийн хүлээсэн үүргийг бүрэн биелүүлсэн бол зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг зээлдэгчээс шаардах бүх эрх батлан даагчид шилжихээр байна.

Батлан даалтын гэрээнд зээлдэгч үндсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд батлан даагчид энэ тухай мэдэгдэх үүргийг Банк хүлээхээр байна. Мөн батлан даагч нь ямар ч тохиолдолд зээлдэгчийн зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргийн биелэлтийн талаарх мэдээллийг Банкнаас авах эрхтэй Банк нь зээлдэгчийн хүлээсэн үүрэг болон үүргийн биелэлтийн талаарх үнэн зөв мэдээллийг гаргаж өгөх үүрэг хүлээсэн байна. Энэ нь ИХ-ийн 462 дугаар зүйлийн 462.1-2 дугаар заалтын дагуу байна. Уг гэрээнд зээлдэгч нь зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй тухай мэдэгдлийг батлан даагчид өөрт нь бичгээр гардуулсан, утсаар мэдэгдсэн, гэрийн хаягаар эсхүл түүний цахим шуудангаар илгээснийг Банк мэдэгдэл хүргүүлсэн, батлан даагч мэдэгдэл хүлээн авсанд тооцохоор заасан байна. Мөн зээлийн гэрээнд орсон өөрчлөлтийг тухай бүр батлан даагчид мэдээлэх үүргийг Банк хүлээсэн ба зээлийн гэрээнд өөрчлөлт орсон нь батлан даагч батлан даалтын гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй юм.

Батлан даалтын гэрээгээр зохицуулагдаагүй, орхигдсон бусад асуудлыг Иргэний хуульд заасны дагуу зохицуулахаар гэрээнд тусгасан байна.

**(iii) Барьцааны гэрээ (хөдлөх эд хөрөнгө болон эрх)**

Барьцааны гэрээгээр Банк болон зээлдэгч нарын хооронд байгуулсан зээлийн гэрээний төлбөрийн үүргээ зээлдэгч тал нь гүйцэтгээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй бол барьцаалуулагч нь барьцааны хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хууль болон гэрээнд заасны дагуу хангахтай холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулдаг. Барьцааны гэрээг талууд бичгээр байгуулж гарын үсэг зурж тамга, тэмдэг дарж баталгаажуулах ба зээлийн гэрээний нэг хэсэг байхаар заасан байна. ИХ-ийн 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэгт барьцааны гэрээг бичгээр байгуулна гэж заасан бол Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг болон 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасаар барьцааны гэрээг бичгээр байгуулах ба талуудын хооронд байгуулсан гэрээнд үндэслэн барьцааны эрх үүснэ гэж зүйлчилсэн байна. Барьцааны гэрээнд харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах, дуусгавар болгох, маргаан гарсан тохиолдолд харилцан тохиролцож шийдвэрлэх, маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх эрх нь талуудад нээлттэй байхаар тусгасан байна.

ИХ-ийн 154 дүгээр зүйлийн 154.1 дэх хэсэг болон Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт барьцааны зүйлийг иргэний гүйлгээнээс хасагдаагүй бусдын өмчлөлд шилжүүлж болох бодитой байгаа эсхүл ирээдүйд бий болох эд хөрөнгө болон бусдын өмчлөлд шилжүүлж болох эд хөрөнгийн эрх байж болно гэж заасан. Банкны зүгээс боловсруулсан барьцааны гэрээнд барьцааны зүйлийг барьцаалуулагчийн хууль ёсны өмчлолийн эрхийн болон биет байдлын доголдолгүй хөдлөх эд хөрөнгө болон эрх, түүний бүрдэл хэсэг, дагалдах

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичигт**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ОЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ
ГҮЙЛГЭЭ ҮЦК ХХК

СЗХ
2022 он 09 сар 2 1 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14
БҮРТГЭВ

зүйлийг хамтад нь ойлгохоор тусгасан байна. Барьцааны гэрээг байгуулах үед барьцаа хөрөнгийн хувьд гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх байгаа бол хамтран өмчлөгч тус бүрээс холбогдох зөвшөөрлийг авч баталгаажуулан барьцааны гэрээнд хавсаргахаар зохицуулсан байна.

ИХ-ийн 156 дугаар зүйл болон Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 10 дугаар зүйлд[14] барьцааны гэрээнд заавал тусгах агуулгыг заасан ба Төрийн банк ХХК-ийн байгуулж буй барьцааны гэрээнд дээрх бүх агуулга багтсан байна.

Барьцаа хөрөнгөөр хангагдах шаардлагын хэмжээг зээлийн гэрээний дагуу хүлээсэн үндсэн зээлийн хэмжээ, хүү, нэмэгдүүлсэн хүү, барьцаа хөрөнгийг худалдан борлуулахад гарсан зардал, улсын тэмдэгтийн хураамж, нөхөн төлүүлэх, шүүхийн зардал, барьцаа хөрөнгийг арчлан хамгаалахад гарсан зардал, уг эд хөрөнгөтэй холбоотой төлсөн татвар, хураамж болон Банкнаас гарсан зардал, хохирлын хэмжээ зэргийн нийлбэрээр хэмжигдэхээр барьцааны гэрээнд оруулсан байна. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь хэсэгт барьцааны гэрээнд барьцаагаар хангагдах шаардах үүргийн хэмжээг тусгана гэж заасныг гэрээний дээрх заалт хангаж байна.

Барьцааны гэрээнд барьцаа хөрөнгийг барьцаалуулагч нь өөрийн эзэмшилд байлган бүрэн бүтэн байдал болоод засвар үйлчилгээг хариуцах ба барьцаа хөрөнгийг барьцааны гэрээний хугацаанд даатгуулах үүргийг хүлээлгэсэн байна. Харин Банк нь барьцаа хөрөнгийн барьцааны мэдэгдэл, тэмдэглэлийг цахим мэдээллийн санд бүртгүүлж барьцааг баталгаажуулах үүрэг хүлээсэн. Энэ тухай Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт зүйлчилсэн байна.

---

[14] **Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль (2015)**
10 дугаар зүйл. **Барьцааны гэрээний агуулга**
10.1 Барьцааны гэрээг Иргэний хуулийн нийтлэг журам, энэ хуулийг баримтлан бичгээр байгуулах бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана:
10.1.1 барьцаалагч болон барьцаалуулагч нь иргэн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар, оршин байгаа газрын хаяг;
10.1.2 барьцаагаар хангах үүрэг, гэрээ байгуулах үед мэдэгдэж байгаа бол барьцаагаар хангагдах шаардлагын хэмжээ;
10.1.3 барьцаалагч, барьцаалуулагч талууд гэрээндээ барьцаагаар хангах үүргийг ирээдүйд үүсэх, эсхүл өөрчлөгдөж болохоор тохиролцсон бол түүнийг тодорхойлох журам, бусад нөхцөл;
10.1.4 барьцааны зүйлийн тодорхойлолт, түүний нэг бүрийн, эсхүл төрлийн шинжээр тодорхойлогдох байдал;
10.1.5 барьцааны гэрээний үргэлжлэх хугацаанд барьцааны зүйлийг эзэмшилдээ байлгах тал;
10.1.6 барьцааны гэрээ байгуулсан он, сар, өдөр.
10.2 Дараах этгээдийн талаар энэ хуулийн 10.1.1-д заасан мэдээллийг барьцааны гэрээнд тусгана:
10.2.1 үүрэг гүйцэтгэгч нь барьцаалуулагч биш бол үүрэг гүйцэтгэгчийн;
10.2.2 барьцааны зүйл нь дундын хөрөнгө бол дундаа өмчлөгчдийн;
10.2.3 үүрэг гүйцэтгүүлэгч буюу барьцаалагч нь хэд хэдэн этгээд бол үүрэг гүйцэтгүүлэгчдийн.
10.3 Барьцааны гэрээнд барьцаалагч, барьцаалуулагч, эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, баталгаажуулсан байна.
10.4 Бичгээр байгуулаагүй барьцааны гэрээ хүчин төгөлдөр бус байна.

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичигт**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

СЗХ 2022 оны 09 сар 21 өдөр БҮРТГЭВ № 01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-09-14 БҮРТГЭВ

Барьцаалуулагч нь барьцааны зүйлийг худалдах, арилжих, бэлэглэх зэргээр бусдын өмчлөлд шилжүүлэх мөн барьцааны зүйлийг бусдад давхар барьцаалах эрхтэй байх ба энэ тохиолдолд барьцаалагч талд заавал мэдэгдэх үүрэгтэй байхаар барьцааны гэрээнд заажээ. Барьцаалуулагч талын бас нэгэн үүрэг нь тухайн шилжүүлж буй хөрөнгөнд барьцааны үүрэг дагалдаж буйг барьцааны зүйлийг шилжүүлэн авч буй талд мэдэгдэх юм. Ийнхүү мэдэгдээгүйгээс үүдэн гарах үр дагаврыг Банк хариуцахгүй байхаар заажээ. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт барьцаалуулагч барьцааны зүйлийг худалдах, арилжих, бэлгэлэх зэргээр захиран зарцуулах эрхтэй байхаар заасан ба энэ тохиолдолд барьцаалагч талд мэдэгдэхээр зохицуулсан байна. Мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт барьцааны зүйлийн өмчлөгч өөрчлөгдсөн тохиолдолд уг хөдлөх эд хөрөнгийн барьцааны эрх хэвээр хадгалагдана гэж заасан байна.

Зээлдэгч нь үүргээ гүйцэтгээгүй, зээлийн гэрээний хугацаа дууссан тохиолдолд Банк нь барьцаа хөрөнгөөс үүргийг хангуулах эрхтэй болох ба ингэхдээ зээлдэгчид зээлийн гэрээний үүргийг гүйцэтгэх хугацаа зааж, барьцаанаас үүргийн гүйцэтгэлийг хангуулах тухай мэдэгдлийг барьцаалуулагч талд мэдэгдэхээр барьцааны гэрээнд заасан байна. Энэ нь ИХ-ийн 158 дугаар зүйл, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 47-49 дугаар зүйлтэй нийцэж байна. Банк нь барьцааны зүйлээс үүргийн гүйцэтгэлийг хангуулахдаа ийнхүү ажиллагаа эхлүүлсэн тухай тэмдэглэлийг цахим мэдээллийн санд оруулж, бүртгэлээр баталгаажсан бусад барьцаалагчид мэдэгдэхээр гэрээнд зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл барьцааны зүйлийг цаашид худалдан борлуулах тухай бусад барьцаалагчид мэдэгдэнэ гэсэн үг юм. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 50 дугаар зүйлд мэдэгдэлтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан заасан ба гэрээний дээрх заалт нь нийцэж байгааг тэмдэглэж байна. Барьцааны зүйлийг хэд хэдэн этгээд барьцаалсан байж болох ч хамгийн түрүүнд барьцаалсан этгээд барьцааны зүйлийг борлуулахыг шаардах эрхтэй байдаг. Энэ тухай ИХ-ийн 158 дугаар зүйлийн 158.1 дэх хэсэгт "Барьцааны зүйл нь хэд хэдэн этгээдэд барьцаалагдсан бол хамгийн түрүүнд түүнийг барьцаалсан этгээд уг зүйлийг борлуулахыг шаардах эрхтэй ..." гэж тодорхойлсон байна.

Банк нь барьцааны зүйлийг худалдан борлуулах зохицуулалтыг ИХ-ийн 159 дүгээр зүйл[15], Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн

[15] **Иргэний хууль (2002)**
159 дүгээр зүйл. **Барьцааны зүйлийг худалдах**
159.1 Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцааны зүйлийг энэ хуульд заасан журмын дагуу дуудлага худалдаагаар худалдана.
159.2 Барьцаалуулагч шаардсан бол барьцааны зүйлийг худалдахын өмнө түүний үнэлгээг шинжээчээр тогтоолгож болох бөгөөд холбогдох зардлыг барьцаалуулагч хариуцна.
159.3 Барьцааны зүйлийг худалдах ажиллагаанд барьцааны зүйлийн өмчлөгч оролцож, уг зүйлээ худалдан авах санал гаргаж болно.
159.4 Барьцааны зүйлийн үнийг төлөөгүй тохиолдолд худалдан авах эрхээ алдахыг дуудлага худалдаанд оролцогчдод тайлбарласан байвал зохино.
159.5 Барьцааны зүйлийг хууль ёсоор, шударгаар олж авсан этгээдэд барьцааны зүйл эрхийн хязгаарлалтгүйгээр шилжинэ.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "гаргаж өгсөн баримт бичигт" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183835 2024031195 СТС2420

УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК 5341465 РСТ5132

УЛААНБААТАР ХОТ ГҮЙЦЭТГЭН ҮЦК ХХК ТТБ0674 5208173

СЗХ
2022 .09. 21
БҮРТГЭВ
№ 01

2022 -09- 14

54 дүгээр зүйлд[16] заасантай нийцүүлэн барьцааны тухай хуульд заасан байна. ИХ-ийн 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэгт барьцааны гэрээг нотариатаар гэрчлүүлж болно гэж заасны дагуу нотариатаар гэрчлүүлж холбогдон гарах зардлыг барьцаалуулагч тал хариуцахаар зохицуулжээ.

**(iv) Ипотекийн гэрээ (үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа)**

Ипотекийн гэрээгээр Банк болон зээлдэгч нарын хооронд байгуулсан зээлийн гэрээний төлбөрийн үүргээ зээлдэгч тал нь гүйцэтгээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй бол барьцаалуулагч нь барьцааны үл хөдлөх хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хууль болон гэрээнд заасны дагуу хангахтай холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулдаг. Ипотекийн гэрээг талууд бичгээр байгуулж гарын үсэг зурж тамга, тэмдэг даран баталгаажуулж улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болох ба зээлийн гэрээний нэг хэсэг байхаар заасан байна. ИХ-ийн 156 дугаар зүйлийн 156.1-2 дэх хэсэг болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан гэрээг заавал бичгээр байгуулж бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байхыг шаардсан ба талуудын хооронд байгуулсан гэрээнд үндэслэн барьцааны эрх үүснэ гэж тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан байна. Ипотекийн гэрээнд харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулах, дуусгавар болгох, маргаан гарсан тохиолдолд харилцан тохиролцож шийдвэрлэх, маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх эрх нь талуудад нээлттэй байхаар тусгасан байна.

ИХ-ийн 154 дүгээр зүйлийн 154.1 дэх хэсэг болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт барьцааны зүйлийг барьцаалуулагчийн өмчлөлд байгаа ИХ-ийн 84.3 дахь хэсэгт заасан үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрх байна гэж заажээ. Тэгвэл Банкны зүгээс боловсруулсан ипотекийн гэрээнд барьцааны зүйлийг барьцаалуулагчийн хууль ёсны өмчлөлийн эрхийн болон биет байдлын доголдолгүй үл хөдлөх эд хөрөнгө, түүний бүрдэл хэсэг, дагалдах зүйл, засан сайжруулалтыг хамтад нь ойлгохоор тусгасан байна. Ипотекийн гэрээг байгуулах үед барьцаа хөрөнгийн хувьд гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх

[16] **Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль (2015).**
54 дүгээр зүйл. **Барьцааны зүйлийг борлуулснаас олсон орлогыг хуваарилах**
54.1 Барьцааны зүйлийг энэ хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу худалдан борлуулахтай холбогдон гарсан зардлыг төлсний дараа барьцаалагч нь барьцааны зүйлийг борлуулснаас олсон орлогыг өөрийн болон бусад барьцаалагчийн барьцааны шаардлагыг энэ хуульд заасан дарааллын дагуу хангаж, үлдэгдлийг нь барьцаалуулагчид олгоно
54.2 Энэ хуулийн 54.1-д зүйлд заасны дагуу барьцааны зүйлийг худалдан борлуулснаас олсон орлогыг хуваарилахаас 10-аас доошгүй хоногийн өмнө энэ хуулийн 50.3-т заасан этгээдэд орлого хуваарилах он, сар, өдөр, газар, орлого хуваарилахад гаргах шаардлага, нотлох баримтыг хүргүүлж болох хаягийн талаарх мэдэгдлийг хүргүүлэх бөгөөд уг мэдэгдлийг энэ хуулийн 50.3-т заасан мэдэгдэлтэй хамт, эсхүл тусад нь хүргүүлж болно
54.3 Барьцаалагч энэ хуулийн 54.1-д заасны дагуу барьцааны зүйлийг борлуулснаас олсон орлогыг хуваарилахдаа дараах дарааллыг баримтална:
54.3.1 барьцааны зүйлийг эзэмшилдээ авах, хадгалах, худалдан борлуулахтай холбогдон гарсан бодит зардал;
54.3.2 энэ хуульд заасан өөрөөс өмнөх дарааллын шаардлага;
54.3.3.барьцааны эрхийг хэрэгжүүлж байгаа барьцаалагчийн өөрийн шаардлага;
54.3.4 барьцааны зүйлийг борлуулснаас олсон орлогыг хуваарилахаас өмнө энэ хуулийн 54.2-т заасан мэдэгдэл, нотлох баримт ирүүлсэн дарааллын хувьд дараах бусад барьцаалагчийн шаардлага

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичигт**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
2021031195 СТС2420

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК
ТТБ8074 5208173

ТӨРИЙН БАНК
ӨРСӨЛДӨӨНГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14
БҮРТГЭВ-03

байгаа бол хамтран өмчлөгч тус бүрээс холбогдох зөвшөөрлийг авч баталгаажуулан ипотекийн гэрээнд хавсаргахаар зохицуулсан байна.

ИХ-ийн 156 дугаар зүйл болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлд[17] ипотекийн гэрээнд заавал тусгах агуулгыг заасан ба Төрийн банк ХХК-ийн байгуулж буй ипотекийн гэрээнд дээрх бүх агуулга багтсан байна.

Барьцаа хөрөнгөөр хангагдах шаардлагын хэмжээг зээлийн гэрээний дагуу хүлээсэн үндсэн зээлийн хэмжээ, хүү, нэмэгдүүлсэн хүү, барьцаа хөрөнгийг худалдан борлуулахад гарсан зардал, улсын тэмдэгтийн хураамж, нөхөн төлүүлэх, шүүхийн зардал, барьцаа хөрөнгийг арчлан хамгаалахад гарсан зардал, уг эд хөрөнгөтэй холбоотой төлсөн татвар, хураамж болон Банкнаас гарсан зардал, хохирлын хэмжээ зэргийн нийлбэрээр хэмжигдэхээр ипотекийн гэрээнд оруулсан байна. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтад барьцааны гэрээнд барьцаагаар хангагдах шаардах үүргийн хэмжээг тусгана гэж заасныг гэрээний дээрх заалт хангаж байна.

Ипотекийн гэрээнд барьцаа үл хөдлөх хөрөнгийг барьцаалуулагч нь өөрийн эзэмшилд байлган бүрэн бүтэн байдал болоод засвар үйлчилгээг хариуцах ба барьцаа үл хөдлөх хөрөнгийг барьцааны гэрээний хугацаанд даатгуулах үүргийг хүлээлгэсэн байна. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 22 дугаар зүйлд даатгалд даатгуулах эсэхийг талууд гэрээгээр тохиролцохоор нээлттэй үлдээсэн байна. Мөн ипотекийн гэрээ, барьцаалбар зэргийг бүртгэлийн байгууллагад бүртгүүлж барьцааг баталгаажуулах үүргийг барьцаалуулагч хүлээсэн. Энэ тухай ИХ-ийн 166 дугаар зүйл, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 12 дахь зүйлд зүйлчилсэн байна.

Барьцаалуулагч нь барьцааны зүйлийг худалдах, арилжих, бэлэглэх зэргээр бусдын өмчлөлд шилжүүлэх мөн барьцааны зүйлийг бусдад давхар барьцаалах эрхтэй байх ба энэ тохиолдолд барьцаалагч талд заавал мэдэгдэх үүрэгтэй байхаар ипотекийн

---

[17] **Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай (2009)**
11 дүгээр зүйл. **Барьцааны гэрээний агуулга**
11.1 Барьцааны гэрээ /цаашид "гэрээ" гэх/-г Иргэний хуулийн нийтлэг журам, энэ хуулийг баримтлан бичгээр байгуулах бөгөөд түүнд Иргэний хуулийн 156.2-т зааснаас гадна дараах зүйлийг тусгана:
11.1.1 барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ, хэрэв үнэ буюу төлбөрийн хэмжээг урьдчилан тогтоогоогүй бол түүнийг тодорхойлох журам;
11.1.2 барьцаагаар хангагдах үүргийг гүйцэтгэх хугацаа, үүрэг нь өөр гэрээнд үндэслэсэн бол уг гэрээний талууд, гэрээг байгуулсан он, сар, өдөр, түүнтэй холбоотой бусад нөхцөл;
11.1.3 барьцааны зүйлийн байршил, тухайн зүйл нь барьцаалуулагчийн өмч мөн болохыг нотлох баримт, эд хөрөнгийн өмчлөх эрхийг бүртгэсэн байгууллагын нэр, өмчлөх эрхийн гэрчилгээний дугаар;
11.1.4 барьцааны зүйлийг өөр этгээдэд барьцаалуулсан эсэх тухай лавлагаа;
11.1.5 барьцаагаар хангагдах үүргийг хэсэгчлэн гүйцэтгэх бол төлбөр гүйцэтгэх хугацаа, давтамж, хэмжээ, эсхүл тэдгээрийг тодорхойлох журам;
11.1.6 барьцааны шаардлагыг хангах журам;
11.1.7 барьцаалагчийн эрх нь барьцаалбараар гэрчлэгдэх эсэх тухай заалт;
11.1.8 барьцааны зүйл нь үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрх бол тухайн эрхийг олж авсан гэрээний үндсэн нөхцөл, хугацаа;
11.1.9 барьцааны зүйлтэй холбоотой гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх;
11.1.10 бусад
11.2 Хуульд заасан бөгөөд талууд гэрээгээр тохиролцсон бол барьцааны зүйлээс шаардлагыг шүүхээс гадуур хангаж болно
11.3 Энэ хуулийн 11.2-т заасан гэрээнд барьцааны зүйлийг шүүхээс гадуур худалдах аргын талаар нарийвчлан заана

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичигт**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
2021031196 СТС2420

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5382

УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК
ТТБ0874 5208173

СЗХ
2022 оны 08 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-08-14

гэрээнд заажээ. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 20 дугаар зүйлд зааснаар "*Барьцаалуулагч барьцааны зүйлийг зориулалтынх нь дагуу ашиглах эрхтэй*" байна. Харин 30 дугаар зүйлд барьцааны зүйлийг гуравдагч этгээдэд түрээслэх, хөлслөх, үнэ төлбөргүйгээр түр ашиглуулах зорилгоор бусдын эзэмшилд шилжүүлэх эрхтэй байхаар заажээ. Хэрэв энэ эрхийг хязгаарласан гэрээний нөхцөл байгаа бол тухайн нөхцөл хүчин төгөлдөр бус байхаар зүйлчилсэн байна. Мөн хуулийн 28 дугаар зүйлд барьцааны зүйлийг өмчлөлдөө шилжүүлэн авсан этгээд өмнөх барьцаалуулагчийн эрх, үүргийг хэрэгжүүлэхээр зүйлчилсэн байна.

Зээлдэгч нь үүргээ гүйцэтгээгүй, зээлийн гэрээний хугацаа дууссан тохиолдолд Банк нь барьцаа хөрөнгөөс үүргийг хангуулах эрхтэй болох ба ингэхдээ зээлдэгчид зээлийн гэрээний үүргийг гүйцэтгэх хугацаа зааж, барьцаанаас үүргийн гүйцэтгэлийг хангуулах тухай мэдэгдлийг барьцаалуулагч талд мэдэгдэхээр ипотекийн гэрээнд заасан байна. Энэ нь ИХ-ийн 174 дугаар зүйл[18], Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 41-42 дугаар зүйлтэй[19] нийцэж байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсэгт "*Барьцаалагч нь тухайн эд хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шаардахын өмнө бусад барьцаалагчид энэ тухай бичгээр мэдэгдэх үүрэгтэй*" байхаар зүйлчилсэн байна. Хуулийн энэ зохицуулалтыг ипотекийн гэрээнд тусгаагүй ч Банкны зүгээс хуулийн хүрээнд ийнхүү мэдэгдэх үүрэг хүлээх юм. Ипотекийн гэрээнд барьцааны зүйлээс үүргийг хангах дараах аргуудыг зааж талууд чөлөөтэй сонгож болохоор заажээ. Үүнд шүүхийн журмаар, шүүхээс гадуур шууд худалдах, шүүхээс гадуур дуудлага худалдаагаар худалдах зэрэг юм. Ипотекийн гэрээнд барьцааны зүйлийг худалдах дээрх аргуудыг задлан арга тус бүрээр зохицуулалтыг тусгасан ба энэ

---

[18] **Иргэний хууль (2002)**
174 дүгээр зүйл. **Үл хөдлөх эд хөрөнгийг худалдахыг шаардах**
174.1. Ипотекийн шаардлагыг хангах хугацааг үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч нь үл хөдлөх эд хөрөнгийг худалдахыг шаардах эрхтэй.
174.4. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмыг хуулиар тогтооно.
[19] **Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль (2009).**
41 дүгээр зүйл. **Үүргийн гүйцэтгэлийг шаардах**
41.1.Үүрэг гүйцэтгэгч болон барьцаалуулагч нь үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол барьцаалагч нь үүргийн гүйцэтгэлийг шаардах эрхтэй.
41.2.Энэ хуулийн 41.1-д заасан барьцаалагчийн шаардлагыг биелүүлээгүй бол үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулахаар барьцааны зүйлийг худалдахыг шаардах эрхтэй.
41.3.Барьцааны зүйлийг давхар барьцаалсан бол барьцаалагч нь энэ хуулийн 41.2-т заасан эрхээ хэрэгжүүлэхдээ бусад барьцаалагч болон барьцаалуулагчид, барьцаалуулагч нь гуравдагч этгээд бол үүрэг гүйцэтгэгчид, барьцааны зүйл нь түрээсийн зүйл бол түрээслүүлэгчид урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.
42 дугаар зүйл. **Барьцаалуулагчид мэдэгдэл хүргүүлэх**
42.1.Барьцаалагч нь энэ хуулийн 41.1-д заасны дагуу үүргийн гүйцэтгэлийг шаардах тухайгаа барьцаалуулагч болон үүрэг гүйцэтгэгчид бичгээр мэдэгдэнэ.
42.2.Барьцаалуулагч болон үүрэг гүйцэтгэгч нь мэдэгдэлд заасан хугацаанд хариу өгөөгүй бол барьцаалагч нь энэ тухай улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж барьцаалуулагч болон тухайн барьцааны зүйлтэй холбоотой эрхээ бүртгүүлсэн гуравдагч этгээдэд үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах тухайгаа бичгээр мэдэгдэнэ.
42.3.Энэ хуулийн 42.2-т заасан мэдэгдэлд 30 хоногийн дотор барьцаалуулагч хариу өгөөгүй буюу үүргээ биелүүлээгүй бол барьцаалагч нь барьцааны зүйлийг худалдах ажиллагааг эхлүүлнэ.
42.4.Энэ хуулийн 42.2-т заасан мэдэгдлийн маягт болон мэдэгдлийг хүргүүлэх журмыг бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичиг**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО
ХАПИТАЛ ҮЦК
ХХК
5183656
21031195 СТС2420

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5282

УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК
ТТБ6674 5208173

СЭХ
он 2022 сар 09 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14

нь ИХ-ийн 175-181 дүгээр зүйл, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 45-52 дугаар зүйлтэй нийцэж байгааг тэмдэглэж байна.

ИХ-ийн 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэгт барьцааны гэрээг нотариатаар гэрчлүүлж болно гэж заасан бол ипотекийн гэрээнд нотариатаар гэрчлүүлж холбогдон гарах зардлыг барьцаалуулагч тал хариуцахаар зохицуулжээ.

**(v) Фидуцийн гэрээ**

Үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргуудын нэг нь фидуцийн гэрээ юм. Фидуцийн гэрээгээр үүрэг гүйцэтгэгч нь мөнгөн хөрөнгө төлөх үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлдэг онцлогтой. Банк нь фидуцийн гэрээний загварыг Гүйцэтгэх захирлын 2017 оны №А/30 дугаартай тушаалын хавсралтаар баталсан байна.

Банкны фидуцийн гэрээнд "үүрэг гүйцэтгэгч нь Хавсралт №01-д заасан хөдлөх эд хөрөнгийг Банкны өмчлөлд зээлийн гэрээний үүрэг бүрэн биелэгдэж дуусах хүртэл хугацаанд шилжүүлэх, Зээлдэгч нь зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэсэн тохиолдолд Банк хөрөнгийн өмчлөх эрхийг буцаан шилжүүлэх, зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой Талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино" гэсэн байна. Энэ нь ИХ-ийн 235 дугаар зүйлийн 235.1 дэх хэсэгт[20] заасантай нийцэж байна.

Фидуцийн гэрээг талууд бичгээр байгуулж гарын үсэг зурж тамга, тэмдэг даран баталгаажуулах ба зээлийн гэрээний нэг хэсэг байхаар заасан байна. ИХ-ийн 235 дугаар зүйлийн 235.5 дахь хэсэгт фидуцийн гэрээг хуульд өөрөөр заагаагүй бол бичгээр байгуулна гэж зүйлчилсэн байна. Фидуцийн гэрээнд харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах, дуусгавар болгох, маргаан гарсан тохиолдолд харилцан тохиролцож шийдвэрлэх, маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх эрх нь талуудад нээлттэй байхаар тусгасан байна.

Фидуцийн гэрээнд фидуцийн хөрөнгө гэж үүрэг хүлээгчийн хууль ёсны өмчлөлийн эрхийн болон биет байдлын доголдолгүй хөдлөх эд хөрөнгө бөгөөд бусдад барьцаалуулаагүй, шилжүүлээгүй, гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх байхгүй байна гэж тодорхойлжээ. Фидуцийн хөрөнгийг дундаа хамтран өмчлөгч байгаа бол фидуцийн гэрээнд мөн гарын үсэг зуруулахаар заасан байна.

[20] **Иргэний хууль (2002)**
235 дугаар зүйл. **Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээ /фидуци/**
235.1 Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээгээр /цаашид "фидуци" гэх/ үүрэг хүлээгч нь мөнгө төлөх үндсэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх, үүрэг хүлээгч үндсэн үүргээ хугацаанд гүйцэтгэсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч уг эд хөрөнгийг түүнд буцаан өгөх үүргийг тус тус хүлээнэ.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
1031195 СТС2420

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5341469 ГСТ5102

УЛААНБААТАР ХОТ
ХУУЛЬЧИД ҮЦК ХХК
ТТБ6874 № 5208173

СЗХ
2022.09.21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14

Фидуцийн хөрөнгөөр хангагдах шаардлагын хэмжээг зээлийн гэрээний дагуу хүлээсэн үндсэн зээлийн хэмжээ, хүү, нэмэгдүүлсэн хүү, барьцаа хөрөнгийг худалдан борлуулахад гарсан зардал, улсын тэмдэгтийн хураамж, нөхөн төлүүлэх, шүүхийн зардал, фидуцийн хөрөнгийг арчлан хамгаалахад гарсан зардал, уг эд хөрөнгөтэй холбоотой төлсөн татвар, хураамж болон Банкнаас гарсан зардал, хохирлын хэмжээ зэргийн нийлбэрээр хэмжигдэхээр фидуцийн гэрээнд оруулсан байна.

Фидуцийн гэрээнд үүрэг хүлээгч нь зээлийн гэрээний дагуу зээл олгогдохоос өмнө фидуцийн хөрөнгийг Банкны өмчлөлд шилжүүлэх, эрх бүхий байгууллагад бүртгүүлж гэрчилгээ авах, даатгуулах зэрэг арга хэмжээг авч холбогдон гарах зардлыг хариуцахаар заасан байна. Хэрэв эдгээр үүргийг гүйцэтгээгүй бол Банк нь зээлийн гэрээний дагуу зээл олгохоос татгалзах эрхтэй байхаар уг гэрээнд тусгасан байна. Фидуцийн гэрээний хугацаанд фидуцийн хөрөнгийг үүрэг хүлээгч тал нь эзэмших ашиглах эрхтэй байхаар заасан ба бүрэн бүтэн байдал болоод засвар үйлчилгээг хариуцах үүрэг хүлээнэ. ИХ-ийн 235 дугаар зүйлийн 235.2 дахь хэсэгт фидуцийн хөрөнгийг гэрээнд заасан бол үүрэг хүлээгч ашиглах эрхтэй байж болохоор заасан байна. Мөн фидуцийн хөрөнгийг ашиглах явцад үүрэг гүйцэтгэгч нь фидуцийн хөрөнгийг гэмтээсэн, устгасан бол ижил төрлийн эсхүл өөр эд хөрөнгөөр сольж Банкны өмчлөлд шилжүүлнэ. Үүрэг хүлээгч нь фидуцийн хөрөнгийг эзэмших, ашиглах явцдаа гуравдагч этгээдийн эд хөрөнгөд хохирол учруулсан бол үүсэн гарах үр дагаврыг бие даан бүрэн хариуцахаар фидуцийн гэрээнд зохицуулсан байна.

Зээлдэгч нь үүргээ гүйцэтгээгүй эсхүл гэрээний үүргээ ноцтой зөрчсөн тохиолдолд Банк нь фидуцийн хөрөнгөөс үүргийг хангуулах эрхтэй болох ба ингэхдээ үүрэг гүйцэтгэгчээс фидуцийн хөрөнгийг бодитоор гаргуулан авч худалдан борлуулж зээлийн гэрээний үүргийг хангуулахаар заасан байна.

Дүгнэж үзвэл Төрийн банк ХХК-ийн хэмжээнд хийгдэж буй зээлийн гэрээ болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад гэрээ нь Иргэний хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн хүчин төгөлдөр гэрээ байна. Эдгээр гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Гүйцэтгэх захирлын 2022 оны №А/224 дугаартай "Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" тушаалаар шинэчлэн баталгаажуулсан байна.

**Б. Харилцах, хадгаламжтай холбоотой гэрээ, хэлцэл**

Төрийн банк ХХК нь тасалбар болгох өдрийн байдлаар дараах харилцах, хадгаламжийн данстай холбоотой гэрээ хэлцэл байгуулсан байна. Үүнд:

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичигт**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

СЗХ
2022 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-08-14

*Хүснэгт №9.* Сүүлийн 3 жилийн хугацаанд байгуулсан нийт хадгаламжийн гэрээ, харилцах дансны гэрээний тоо

| № | Гэрээний нэр | 2019.05.01-2020.05.01 | 2020.05.01-2021.05.01 | 2021.05.01-2022.05.01 |
|---|---|---|---|---|
| 1. | Харилцах | 243.086 | 231.951 | 124.295 |
| 2. | Хугацаатай хадгаламж | 49.233 | 22,238 | 6,021 |
| 3. | Хугацаагүй хадгаламж | 29,104 | 52,929 | 203,161 |
| **НИЙТ** | | **321,423** | **307,118** | **333,477** |

*Хүснэгт №10.* Сүүлийн 3 жилийн хугацаанд хаагдсан буюу хэрэгжсэн нийт хадгаламжийн гэрээ, харилцах дансны гэрээний тоо

| № | Гэрээний нэр | 2019.05.01-2020.05.01 | 2020.05.01-2021.05.01 | 2021.05.01-2022.05.01 |
|---|---|---|---|---|
| 1. | Харилцах | 298.428 | 431,453 | 229.088 |
| 2. | Хугацаатай хадгаламж | 26.893 | 29.594 | 44.593 |
| 3. | Хугацаагүй хадгаламж | 6.936 | 8.779 | 43.745 |
| **НИЙТ** | | **332,257** | **469,826** | **317,426** |

Дээрх хоёр хүснэгтээс үзвэл Үнэт цаас гаргагч нь жилд дунджаар 320,000 (гурван зуун хорин мянга) гаруй харилцах, хугацаатай, хугацаагүй хадгаламжийн гэрээг шинээр байгуулдаг байхад мөн түүнээс дутахгүй тооны (өмнөх оны болон тухайн жилд) гэрээ хэрэгжиж хаагддаг байна.

Төрийн банк ХХК-ийн 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар **хэрэгжиж байгаа** харилцах, хадгаламжтай холбоотой гэрээний тоон үзүүлэлт дараах байдалтай байна. Үүнд:

*Хүснэгт №11. Төрийн банк ХХК-ийн 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй гэрээний тоон мэдээлэл*

| № | Гэрээний төрөл | Гэрээний тоо |
|---|---|---|
| 1. | Харилцах | 1.903.123 |
| 2. | Хугацаагүй хадгаламж | 562.725 |
| 3. | Хугацаатай хадгаламж | 232.001 |
| **НИЙТ** | | **2,697,849** |

Банкны тухай хуулийн 7.2 дахь хэсэг, Байгууллагын нууцын тухай хуулийн 3.1.2, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.11 (хөрөнгө)-д заасны дагуу хуулийн этгээд, иргэний банк дахь харилцах данс, хадгаламжийн дүн мэдээ буюу хувь хүний хөрөнгө, харилцагчийн мэдээлэл нь хүний хувийн нууцад хамаарч байна.

Банкны өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж буй харилцах, хадгаламжтай холбоотой гэрээний загварт "Харилцагчийн мэдээллийн нууцлалыг чандлан хадгалж, хууль, журам, гэрээнд заасанаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй байх" үүргийг

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичигт"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ

Банк хүлээсэн бөгөөд тэдгээр гэрээний загварт харилцагч өөрийн харилцах, хадгаламжийн дүн мэдээг бусдад дамжуулахыг зөвшөөрсөн заалт байхгүй байна. Иймд Хуулийн фирм нь Банкны үндсэн үйл ажиллагааны чухал чиглэл болох харилцах, хадгаламжтай холбоотой тодорхой харилцагчтай байгуулж баталгаажуулсан гэрээ (их хэмжээний, эсхүл сонирхлын зөрчилтэй эсэхийг үл харгалзан)-г сонгон авч хянаагүй ба зөвхөн тэдгээр гэрээний загвар хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийв.

Төрийн банкны Гүйцэтгэх захирлын 2019 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн №А/206 тоот тушаалаар баталсан Бүтээгдэхүүн үйлчилгээний журмын хавсралтаар харилцах, хадгаламжийн үйл ажиллагаатай холбоотой дараах гэрээний загварыг баталсан байна.

*Харилцах дансны гэрээ*

1. Тусгай нөхцөлт харилцах данс /Байгууллага/ - 2022 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн №А/240 Гүйцэтгэх захирлын тушаалаар хүчингүй болсон;
2. Төсвийн байгууллагын шимтгэлгүй харилцах дансны гэрээ;
3. Эскроу буюу дундын дансны үйлчилгээний гэрээ;
4. Халамж нэрийн дансанд автоматаар шилжүүлэх үйлчилгээний гэрээ.

Дээр дурдсан харилцах дансны гэрээний загвар нь БЭБАЭМХМХШЗҮАтХ-ийн 9 дүгээр зүйлд заасан хэлбэрийн шаардлага, тус хуулийн Гуравдугаар бүлэгт тодорхойлсон талуудын хүлээх эрх, үүрэг, журамд нийцсэн байна.

*Мөнгөн хадгаламжийн дансны гэрээ*

1. Хугацаагүй мөнгөн хадгаламжийн гэрээ /иргэн/;
2. Хугацаатай мөнгөн хадгаламжийн гэрээ /иргэн/;
3. Хугацаатай мөнгөн хадгаламжийн гэрээ /иргэн зарлага гаргах эрхтэй/;
4. Хугацаатай мөнгөн хадгаламжийн гэрээ /байгууллага/;
5. Хугацаатай мөнгөн хадгаламжийн гэрээ /байгууллага зарлага гаргах эрхтэй/;
6. Тусгай нөхцөлт хугацаагүй мөнгөн хадгаламжийн гэрээ /иргэн/ - 2022 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн №А/240 Гүйцэтгэх захирлын тушаалаар хүчингүй болсон;
7. Тусгай нөхцөлт хугацаатай мөнгөн хадгаламжийн гэрээ /иргэн/ - 2022 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А/240 Гүйцэтгэх захирлын тушаалаар хүчингүй болсон;
8. Хугацаатай мөнгөн хадгаламжийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээ;
9. Хүүхдийн мөнгөн хадгаламжийн гэрээ /иргэн/.

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичиг"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

СЗХ
2022 оны 09 сарын 2 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ

Хадгаламжийн гэрээ нь Иргэний хуулийн 454.1 дэх хэсэгт заасан банк, эрх бүхий этгээдтэй байгуулах мөнгөн хадгаламжийн гэрээ болохын хувьд банк нь хадгалуулагчийн мөнгийг хадгалах, хадгалуулсан мөнгийг тухайн мөнгөн тэмдэгтээр хүүгийн хамт буцаан олгох харилцааг зохицуулдаг. Мөнгөн хадгаламжийн гэрээ нь Иргэний хуулийн 454 дүгээр зүйлийн 454.2 дахь хэсэгт заасны дагуу хадгалалтын хугацаа, хүүгийн хэмжээ, түүнийг тооцох журам, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс талуудын хүлээх хариуцлага, БЭБАЭМХМХШЗҮАтХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт зааснаар гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох нөхцөлийг тусгахаар хуульчилсан болон гэрээг Иргэний 454 дүгээр зүйлийн 454.3 дахь хэсэгт зааснаар бичгээр байгуулах, БЭБАЭМХМХШЗҮАтХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт зааснаар цахимаар байгуулах хэлбэрийн шаардлагад нийцсэн байна. Цаашилбал, мөнгөн хадгаламжийн гэрээний загвар нь Банкнаас харилцагчид санал болгож байгаа, хуулиар тодорхойлоогүй буюу хуулийн заалтыг тодотгосон журам тогтоосон, байнга хэрэглэгдэх, урьдчилан тогтоосон нөхцөл бүхий стандарт гэрээний хувьд ИХ-ийн 200.1 дэх хэсэг, 202 дахь зүйлд тус тус нийцэж байна.

*Бусад гэрээний төрөл*

1. Чекийн үйлчилгээ үзүүлэх гэрээ /иргэн/;
2. Чекийн үйлчилгээ үзүүлэх гэрээ /байгууллага/;
3. Хуримтлалын үйлчилгээний гэрээ;
4. Свип үйлчилгээний гэрээ;
5. Үнэт зүйл хадгалах үйлчилгээ үзүүлэх гэрээ;
6. Төлбөрийн нэхэмжлэлээр гүйлгээ хийх гэрээ /байгууллага/.

Дээр дурдсан 6 төрлийн гэрээний загвар нь Монгол Улсын Иргэний хууль, БЭБАЭМХМХШЗҮАтХ, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн хэм хэмжээнд нийцсэн байна.

Төрийн банкны Гүйцэтгэх захирлын 2019 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн №А/306 тоот тушаалаар баталсан Картын үйлчилгээ, үйл ажиллагааны журмын хавсралтаар доорх гэрээний загварыг баталсан байна.

*Картын үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой гэрээний төрөл*

1. Интернет үйлчилгээний байгууллагатай хамтран ажиллах гэрээний загвар;
2. Мобайл картаар үйлчлэгч байгууллагатай хамтран ажиллах гэрээний загвар;
3. Бэлэн мөнгөний машин байршуулах гэрээний загвар.

Дээрх картын үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой гэрээний загвар нь Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

## В. Банкны үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ, хэлцэл

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "гаргаж өгсөн баримт бичигт" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он 2022 сар 08 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14
БҮРТГЭВ

Үнэт цаас гаргагчийн зүгээс гэрээг тасалбар болгох өдрийн байдлаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагатай байгуулсан бусад 2,185 (хоёр мянга нэг зуун наян тав) гэрээ байхаас хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа 703 (долоон зуун гурав) гэрээний мэдээллийг Хуулийн фирмд ирүүлсэн. Үүнээс санамсаргүй түүврийн аргаар нийт 40 (дөч) гэрээг үзэж танилцлаа. (Хавсралт №03. Төрийн банк ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл)

Банкны зүгээс бусадтай байгуулсан үйл ажиллагаанд ач холбогдол бүхий бусад гэрээ гэдэгт (i) худалдах, худалдан авах гэрээ (ii) үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээ, (iii) ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, (iv) даатгалын гэрээ, (v) бусад гэрээнүүд багтах ба Хуулийн фирмийн зүгээс эдгээр гэрээнүүдийг хууль тогтоомж, Банкны дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм, журамд нийцсэн эсэхэд дүгнэлт өгөх болно.

**(i) Худалдах, худалдан авах гэрээ**

Банкны бусадтай байгуулсан худалдах, худалдан авах гэрээний хувьд гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар 61 (жаран нэг) гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байна. (Хавсралт №03. Төрийн банк ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл)

Төрийн банк ХХК-ийн Гүйцэтгэх захирал 2015 онд №А/08 тоот "Журам шинэчлэн батлах тухай" тушаалын хавсралтаар "Төрийн банк ХХК-ийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журам"-ыг шинэчлэн баталсан байна. Банк нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд Иргэний хуулиас гадна Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг удирдлага болгохоор заасан. Уг журамд заасны дагуу Төрийн банк ХХК нь жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор дараа онд хэрэгжүүлэх төсөл, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийн захиалга, үндэслэл, судалгаа, тоо хэмжээ зэргийг банкны ТУЗ-аар хэлэлцүүлж жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж холбогдох хуульд заасны дагуу батлуулдаг байна (Хавсралт №01.Төрийн банк ХХК-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам, заавар, аргачлалын мэдээлэл).

Тендер шалгаруулалт явагдсаны дараа тухай хуулийн этгээдтэй Сангийн сайдын 2012 оны №194 дүгээр тушаалын хавсралтаар баталсан шаардлага, гэрээний төслийн хүрээнд худалдах, худалдан авах гэрээг байгуулдаг байна. Зарим тохиолдолд /бага үнийн дүнтэй/ Банк нь өөрийн боловсруулсан гэрээний төслийг ашиглалгүй гэрээний нөгөө талаас боловсруулсан төслийн дагуу худалдах худалдан авах гэрээг байгуулсан байна. Ингэхдээ заавал Банкны хуульч гэрээг хянаж тэмдэг дарсан хянасан болохоо баталгаажуулдаг байна.

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичиг"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

СЗХ
2022 .09. 21
БҮРТГЭВ
№ 01

2022 -09- 14

Банкнаас боловсруулсан худалдах, худалдан авах гэрээнд дараах зохицуулалтуудыг оруулсан байна. Үүнд:

1. Эрхийн болон биет байдлын доголдолгүй барааг Банкны өмчлөлд шилжүүлэх төлбөрийг гэрээнд заасны дагуу шилжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах;
2. Барааны шинж чанар, загвар, тоо ширхэг, үзүүлэлт, иж бүрдэл, бүрэн бүтэн байдал, баталгаа, үйлдвэрлэгчийн мэдээлэл, ашиглалтын байдал, элэгдэл зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг оруулж хавсаргах;
3. Барааг нийлүүлэх хугацаа, хүргэх газар, барааны сав баглаа боодол, тээвэрлэх нөхцөл, барааг хүлээн авах, хүлээлгэн өгөх журам;
4. Талуудын эрх, үүрэг;
5. Бараа нийлүүлэх үед болон хүлээн авсны дараа доголдолтой эсхүл гэрээнд заасан шаардлагыг хангахгүй болох нь илэрхий болсон үед талуудын авах арга хэмжээ;
6. Баталгаат хугацааны явцад гарсан эвдрэл, гэмтлийг хэрхэн шийдвэрлэх талаар;
7. Гэрээний үнэ, төлбөр төлөх журам;
8. Талуудын хүлээх хариуцлага, хариуцлагын хэмжээ, анз;
9. Гэрээг цуцлах нөхцөл, болон бусад.

Талуудын эрх бүхий төлөөлөгчид гэрээнд гарын үсэг зурж тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болохоор худалдах худалдан авах гэрээнд заасан ба ИХ-ийн 243-257 дугаар зүйлд худалдах худалдан авах гэрээний зохицуулалттай нийцэж байна.

**(ii) Үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээ**

Төрийн банк ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан бөгөөд гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээнээс үзвэл нийт 140 (нэг зуун дөч) түрээсийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. (Хавсралт №03. Төрийн банк ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл)

Хуулийн фирмээс үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээг хуульд нийцсэн эсэхийг шалгахдаа Банкны түрээслэж буй байр, талбайн хэмжээгээр үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гарсан тохиолдолд түрээсийн гэрээг ИХ-ийн 318 дугаар зүйлийн 318.3 дахь хэсэгт заасны дагуу улсын бүртгэлийн газрын бүртгүүлэх хуулийн зохицуулалтыг үндэслэл болгон авч үзлээ.

Зарим тохиолдолд Банк нь өөрийн боловсруулсан гэрээний төслийг ашиглалгүй гэрээний нөгөө талаас боловсруулсан төслийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээг байгуулсан байна. Ингэхдээ заавал Банкны хуульч гэрээг хянаж тэмдэг даран хянасан болохоо баталгаажуулдаг байна.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "гаргаж өгсөн баримт бичигт" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ
ТТБ0674 № 5208173

СЭХ
2022 .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022 -09- 14

Банкнаас боловсруулсан үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээнд дараах зохицуулалтуудыг оруулсан байна. Үүнд:

1. Түрээслүүлэгчийн өөрийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийн нийт талбайгаас тодорхой талбайг албан тасалгаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж, ашиглуулахаар түрээслэгчид шилжүүлэх гэрээгээр тохирсон төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах;
2. Түрээслүүлэх үл хөдлөх эд хөрөнгийн байрлал, хэмжээ, ашиглалтын нөхцөл;
3. Гэрээний үргэлжлэх хугацааг тодорхой зааж гэрээний хугацаа дуусахад хэрхэн сунгах нөхцөл;
4. Түрээсийн төлбөрийг тодорхой зааж, хэрхэн төлөх, үнэ өөрчлөгдсөн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх;
5. Түрээсийн хөрөнгөтэй холбогдон гарах урсгал зардлыг хэрхэн хуваарилах, түрээсийн хөрөнгийн засан сайжруулсан тохиолдолд тухайн зардлыг хэрхэх;
6. Талуудын эрх, үүрэг;
7. Түрээсийн хөрөнгийг хүлээлгэн өгөх, хүлээн авах журам;
8. Талуудын хүлээх хариуцлага, хариуцлагын хязгаарлалт, анз;
9. Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах нөхцөл болон бусад.

Гэрээнд зааснаар Түрээслүүлэгч тал нь гэрээг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх холбогдон гарах зардлыг хариуцах ба хэрэв энэ үүргээ хэрэгжүүлээгүй бол холбогдон гарах үр дагаврыг дангаар хариуцахаар заасан байна. Хэдийгээр түрээсийн гэрээг түрээслүүлэгч тал холбогдох төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх үүрэг хүлээж байгаа боловч ийнхүү бүртгүүлээгүй бол гэрээ хүчин төгөлдөр бусад тооцогдох эрсдэлтэй. Иймд Банкны зүгээс тухайн гэрээ бүртгэгдсэн эсэхийг лавлаж хэрэв үгүй бол бүртгүүлэх тал дээр анхаарал хандуулах шаардлагатай. Талуудын эрх бүхий төлөөлөгчид гэрээнд гарын үсэг зурж тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болохоор уг гэрээнд заасан ба ИХ-ийн 318-320 дугаар зүйлд заасан зохицуулалттай нийцэж байна.

**Г.Банкны үнэт цаас гаргах ажиллагаатай холбоотой гэрээ**

Гэрээг тасалбар болгон авсан өдрөөс хойш хийгдсэн дараах 4 (дөрвөн) гэрээг онцгойлон авч мэдээллийг нэмж оруулж байна. Учир нь Төрийн банк ХХК нь нээлттэй хувьцаат компани болох зорилгоор үнэт цаасаа Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржид бүртгүүлж, олон нийтэд нээлттэй арилжаалах үйл ажиллагаанд андеррайтерийн, аудитын, үнэлгээний болон хууль зүйн зөвлөх үйлчилгээг үзүүлсэн хуулийн этгээдүүдтэй хийсэн гэрээний мэдээллийг оруулсан болно.

**(i) Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ**

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичигт"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

СЗХ
2022 .09.21
БҮРТГЭВ
№ 01

2022 -09- 14

Төрийн банк ХХК-ийн ТУЗ-аас баталсан "Төрийн банк ХХК-ийн хэлбэрийг өөрчлөн нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөхтэй холбогдуулан зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд сонгон шалгаруулах" түр журмын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг үндэслэн Үнэлгээний хорооны 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн №01 дугаартай зөвлөмж болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн №29 тоот "Төрийн банк ХХК-ийн хэлбэрийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөхтэй холбогдуулан зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулах тухай" тогтоолын дагуу Төрийн банк ХХК нь 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдөр №01а/162 дугаартай "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г сонгон шалгаруулалтад хамгийн өндөр оноо авсан Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК-тай байгуулсан байна. Тус гэрээний дагуу Өлзий энд Ко ҮЦК ХХК нь үнэт цаас гаргагч Төрийн банк ХХК-ийн үнэт цаасыг Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн биржид бүртгүүлж, олон нийтэд нээлттэй хүрээнд арилжаалах үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээг үзүүлж, Банкны хувьцааг олон нийтэд анх удаа санал болгох, худалдах үйл ажиллагаанд хамтран "Түншлэл" хэлбэрээр ажиллах юм. Энэхүү гэрээний 3 дугаар зүйлд андеррайтерийн үйлчилгээ цар хүрээг тодорхойлсон бөгөөд энэ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасантай нийцэж байна.

Мөн тус гэрээний 7 дугаар зүйлд Төрийн банк ХХК-ийн эрх үүргийг тогтоож өгсөн ба үнэт цаас гаргагчийн үндсэн үүрэг нь андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгчид шаардлагатай анхан шатны материал, мэдээллийг цаг алдалгүй гаргаж огох, огсон мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах юм. Мөн андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгчтэй урьдчилан зөвшилцөлгүй банкийг нээлттэй хувьцаат компани болгохтой холбоотой мэдэгдэл, мэдэгдлийн чанартай үйлдэл хийхгүй байх болон Монголын Хөрөнгийн бирж, Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан аливаа дүрэм журмыг биелүүлэх зэрэг үүргийг тодорхой тусгасан байна. Гэрээний 8 дугаар зүйлд андеррайтерийн эрх, үүргийг зааж өгсөн ба гол үүргийн хувьд гэрээ байгуулсан өдрөөс хойш үнэт цаас амжилттай арилжаалагдаж дуусах өдөр хүртэл ижил төрлийн үйлчилгээг бусад банкинд үзүүлэхгүй байх, үнэт цаасыг арилжаалахтай холбоотой зар сурталчилгаа, стратеги зэрэгт банктай хамтран ажиллах зэрэг үүргүүд багтахаас гадна банкны нийтэд санал болгож арилжсан үнэт цааснаас арилжаалагдаагүй үлдсэн хэсгийг бүхэлд нь нийтэд санал болгосон үнээр худалдан авах үүрэг орсон байна.

Гэрээнд төлбөрийн хэмжээ, төлбөр төлөх нөхцөл болон урамшуулал зэргийг тусгасан байхаас гадна хариуцлага хүлээлгэх нөхцөл, хариуцлагын хэмжээ зэргийг зааж өгсөн байна. Мөн гэрээний нууцлалыг хэрхэн хангах, гэрээ ямар нөхцөлд дуусгавар болох зэрэг нөхцөлүүдийг харилцан тохиролцож оруулсан ба гэрээг баталгаажуулан Төрийн банк ХХК-ийн ТУЗ-ын дарга гарын үсэг зурсан байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.5-д заасны дагуу Андеррайтер нь андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий бусад хуулийн этгээдтэй

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичигт"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ
ҮЦК ХХК

СЗХ
2022 он 09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ

хамтран үзүүлж болох ба энэ тохиолдолд талууд хамтран ажиллах гэрээ байгуулахаар заасан. Ийнхүү үндсэн андеррайтер Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК нь 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн ТБТ-2А/01 тоот гурван талт Хамтран ажиллах гэрээг туслах андеррайтер Инвескор Капитал ҮЦК ХХК, Гүүдсек ҮЦК ХХК нартай байгуулжээ.

Инвескор Капитал ҮЦК ХХК нь 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А-22/70 тоот "Хамтран ажиллах гэрээнээс татгалзах тухай" албан бичигт дурдсанаар ижил төстэй төслийн үндсэн андеррайтераар оролцохоор болсонтой холбогдуулан сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөл байдал үүссэн тул Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК-тай байгуулсан дээр дурдсан гэрээнээсээ татгалзсан байна.

**(ii) Аудиторын үйлчилгээний гэрээ**

Төрийн банк ХХК-ийн ТУЗ-аас баталсан "Төрийн банк ХХК-ийн хэлбэрийг өөрчлөн нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөхтэй холбогдуулан зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд сонгон шалгаруулах" түр журмын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь заалтыг үндэслэн Үнэлгээний хорооны 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн №02 дугаартай зөвлөмж болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн №42 тоот "Төрийн банк ХХК-ийн хэлбэрийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөхтэй холбогдуулан зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулах тухай" тогтоолын дагуу Төрийн банк ХХК нь 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр №01а/318 дугаартай "Төрийн банк ХХК-ийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөхтэй холбоотой харилцан тохиролцсон горим гүйцэтгэх гэрээ"-г сонгон шалгаруулалтад хамгийн өндөр оноо авсан Эрнст энд Янг Монголия Аудит ХХК-тай байгуулсан байна. Тус гэрээний дагуу аудитын үйлчилгээ үзүүлэгч компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 11 дэх хэсэгт заасны дагуу Банкны 2019, 2020, 2021 оны санхүүгийн тайланг хянаж баталгаажуулан 2022 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн дотор дуусгасан байхаар тохиролцсон байна.

Гэрээний төслийг Эрнст энд Янг Монголия Аудит ХХК нь боловсруулсан байх бөгөөд гэрээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд Монгол Улсын хуулийг баримтлан Арбитраар шийдвэрлүүлэхээр заасан ба Англи хэлээр явагдана гэж заасан байна. Мөн гэрээнд Талуудын эрх үүргийг тодорхой зааж өгсөн ба гэрээний нууцлал, хариуцлагын хязгаарлалт, гэрээний үнэ, төлбөрийг нөхцөлийг тусгасан ба гэрээг баталгаажуулан Төрийн банк ХХК-ийн ТУЗ-ийн дарга гарын үсэг зурсан байна.

**(iii)Үнэлгээний зөвлөх үйлчилгээний гэрээ**

Төрийн банк ХХК-ийн ТУЗ-аас баталсан "Төрийн банк ХХК-ийн хэлбэрийг өөрчлөн нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөхтэй холбогдуулан зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд сонгон шалгаруулах" түр журмын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь

---

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичигт**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183835
2021031195 СТС2420
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
5144469 ГСТ5502
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТ55874 5208173

СЭХ
он 2022 сар 09 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022 -09- 14

заалтыг үндэслэн Үнэлгээний хорооны 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн №03 дугаартай зөвлөмж болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн №38 тоот "Төрийн банк ХХК-ийн хэлбэрийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөхтэй холбогдуулан зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулах тухай" тогтоолын дагуу Төрийн банк ХХК нь 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр №01а/305 дугаартай "Үнэлгээний зөвлөх үйлчилгээний гэрээ"-г сонгон шалгаруулалтад хамгийн өндөр оноо авсан Мөнх-Оргил трейд ХХК-тай байгуулсан байна. Энэхүү гэрээний дагуу зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь банк хувьцаагаа анх удаа нийтэд нээлттэй арилжаалах үйл ажиллагааны хүрээнд хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх, тайлан гаргах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэхээр байна. Энэхүү гэрээний 3 дугаар зүйлд зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн ажлын цар хүрээг тодорхойлсон ба зөвлөх нь Хөрөнгийн үнэлгээний шалгаруулалтад хамгийн өндөр оноо авсан Мөнх-Оргил трейд ХХК-тай байгуулсан байна. Энэхүү гэрээгээр бизнесийн үнэлгээг гаргах, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг тодорхойлох, Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2011 оны №274/240 тоот хамтарсан тушаалаар баталсан "Бизнесийн үнэлгээ хийх аргачлал"-ын хүрээнд үнэлэлт, дүгнэлт өгөх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэхээр заажээ.

Гэрээнд заасан ажлыг зөвлөх нь 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор бүрэн гүйцэтгэж дуусгасан байх ба гэрээний үнэ төлбөрийн нөхцөл зэргийг талууд нарийвчлан тохиролцсон байна. Мөн зөвлөх нь банкнаас гаргаж өгсөн мэдээлэлд үндэслэн ажлаа гүйцэтгэх ба анхан шатны баримт, мэдээллийг түргэн шуурхай, бүрэн гаргаж өгөх үүргийг банк хүлээсэн байна.

Тус гэрээнд мэдээллийн нууцлалыг хадгалах нөхцөл орсноос гадна талуудын хариуцлагын хэмжээ, хязгаарлалт, гэрээг дуусгавар болгох нөхцөл маргаан шийдвэрлэх дарааллыг мөн зааж өгсөн ба гэрээг Төрийн банк ХХК-ийн ТУЗ-ын дарга баталгаажуулан гарын үсэг зурсан байна.

**(iv) Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ**

Төрийн банк ХХК-ийн ТУЗ-аас баталсан "Төрийн банк ХХК-ийн хэлбэрийг өөрчлөн нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөхтэй холбогдуулан зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд сонгон шалгаруулах" түр журмын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь заалтыг үндэслэн Үнэлгээний хорооны 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн №04 дугаартай зөвлөмж болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн №38 тоот "Төрийн банк ХХК-ийн хэлбэрийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөхтэй холбогдуулан зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулах тухай" тогтоолын дагуу Төрийн банк ХХК нь 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр №01а/307 дугаартай "Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ"-г сонгон шалгаруулалтад хамгийн өндөр оноо авсан Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН болон Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН-тай байгуулсан байна.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичигт"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183835
2021031195 СТС2420

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ
ГҮЮДОБК
ТТБ0074 5208173

СЗХ 2022 09 21 он сар өдөр БҮРТГЭВ № 01

2022-09-14

Хуулийн зөвлөхүүд нь дараах асуудлуудыг шалган нягталж дүгнэлт гаргахаар гэрээнд нарийвчлан заасан байна. Үүнд:

1. Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх, үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу эсэх;
2. ТУЗ, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т заасан шаардлагыг хангаж буй эсэх;
3. Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журмууд нь холбогдох хууль тогтоомж, Хорооноос аталсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцэж буй эсэх;
4. Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх;
5. Сүүлийн 3 жилийн дотор бусадтай хийсэн их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх;
6. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх;
7. Үнэт цаас, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх;
8. Үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх, үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх;
9. Компанийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох;
10. Үнэт цаас гаргагч нь аж ахуйн эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх;
11. Татвар, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх зэрэг юм.

Дээр заасан Хуулийн зөвлөхийн хийж гүйцэтгэх ажил нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан 2021 оны №225 тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 11 дүгээр зүйл болон, Монголын Хөрөнгийн биржийн ТУЗ-ийн 2018 оны №2018/01 тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2 дугаар зүйлд заасан агуулгатай бүрэн нийцэж байна. Гэрээнд талуудын эрх үүргийг нарийн тодорхой зааж өгсөн ба ажил гүйцэтгэх хугацаа гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл зэргийг Талууд тохиролцсон байна.

---

**Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "гаргаж өгсөн баримт бичигт" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.**



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕН

СЗХ
он сар өдөр
2022 04 21
БҮРТГЭВ
№ 01



2022 -09- 14

Мөн талуудын хүлээх хариуцлагын хэмжээ, хязгаар, нууцлал, гэрээг дуусгавар болгох үндэслэл болон бусад нөхцөлийг харилцан тохиролцсон байх ба гэрээг Төрийн банк ХХК-ийн ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

**D. Банкны гуравдагч этгээдтэй байгуулсан зээлийн болон бусад гэрээ, хэлцэл**

Зээлийн мэдээллийн сангийн 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн дэлгэрэнгүй лавлагаанаас үзвэл Төрийн банк ХХК нь Монголбанкны Зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэгч банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс авсан зээлийн үлдэгдэлгүй болохыг тодорхойлсон байна.

Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээнд 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр ОХУ-ын INTNL Bank for Economic Co-operation банкнаас авсан зээлийн хэлцэл багтаж байна. Банк нь тасалбар болгосон өдрийн байдлаар тус банкнаас 11 сая ам.долларын 1 жилийн хугацаа зээл авсан байна.

Төрийн банкны зүгээс тухай зээлийн гэрээг онлайн платформ ашиглан үйлдсэн гэсэн тайлбар ирүүлсэн тул Хуулийн фирмд гэрээний хувь болон хуулбарыг гаргаж өгөөгүй болно.

*Иймд Хуулийн фирмийн зүгээс энэ гэрээний хүчин төгөлдөр байдал, зохицуулалтын талаар үнэлэлт, дүгнэлт өгөхгүй ба Банк нь хэлбэрээ өөрчлөн хувьцаат компани болохын тулд гэрээний дагуу нөгөө талдаа мэдэгдэх, зөвшөөрөл авах шаардлагын талаар Төрийн банк ХХК-д зөвлөсөн болно.*

**E. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ:**

Хуулийн фирм нь энэхүү асуудлын хүрээнд сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд буюу 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 4 дүгээр сарын 01 өдрийн байдлаар Банкны бусадтай бичгээр байгуулсан, Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээг гаргуулан авч хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээг авч дүн шинжилгээ хийлээ.

Банк нь тасалбар болгох өдрийн байдлаар Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд 3 (гурван) удаа өөрчлөлт оруулж, улсын бүртгэлд бүртгүүлсэн байх тул хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт тухай бүрд Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (таван) хувьтай тэнцэх дүнг дараах байдлаар тооцож, Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх дүн бүхий гэрээ, хэлцлийн тоон үзүүлэлтийг дор дурдсанаар тодорхойлов. Үүнд:

---

**Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "гаргаж өгсөн баримт бичигт" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.**



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК
УЛААНБААТАР ХОТ
ГҮЙДЭЛ ҮЦК ХХК

СЗХ
2022.03 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-09-14
БҮРТГЭВ-03

*Хүснэгт №12. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (тав) хувь болон түүнээс дээш үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл*

| № | Улсын бүртгэлийн гэрчилгээ /хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа/ | 2019.01.01-2019.10.24 | 2019.10.25-2021.03.22 | 2021.03.22-2022.04.01 |
|---|---|---|---|---|
| 1. | Хувь нийлүүлсэн хөрөнгө /төгрөгөөр/ | 113,000,000,000 | 133,900,000,000 | 178,000,000,000 |
| 2. | Хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 хувь /төгрөгөөр/ | 5,650,000,000 | 6,695.000,000 | 8,900,000.000 |
| 3. | Нийт байгуулсан гэрээ | 23 | 14 | 6 |
| 4. | Хэрэгжиж байгаа гэрээ | 1 | 5 | 4 |

Үнэт цаас гаргагч нь тасалбар болгох өдрөөс өмнөх 3 жилийн байдлаар Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн нийт 43 (дөчин гурав) гэрээ байгуулснаас хэрэгжиж байгаа 10 (арав) гэрээний мэдээллийг Хуулийн фирмд гаргаж өгсөн (Хавсралт №04.Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээний мэдээлэл) Эдгээр 10 гэрээ хэвийн хэрэгжиж байгаа талаар Банкны Гүйцэтгэх захирал 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 01/3134 18дугаар албан бичгээр бидэнд мэдэгдсэн. Үнэт цаас гаргагчийн эдгээр гэрээний мэдээлэлтэй доорх дэлгэрүүлэн үзнэ үү.

*Хүснэгт №13. Тасалбар болгох өдрөөр хэрэгжиж байгаа Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (тав) болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл*

| № | Гэрээний дугаар | Гэрээний огноо | Гэрээний нэр | Үнийн дүн | Хуулийн шаардлага хангасан эсэх |
|---|---|---|---|---|---|
| 1. | №01/694 | 2019.12.20 | Актив хөрөнгө шилжүүлэх гэрээ | 27,033,222,887 төгрөг | Хангасан |
| 2. | №01/01 | 2020.01.03 | Шаардах эрх шилжүүлэх гэрээ БЗД | 9,772,777,029 төгрөг | Хангасан |
| 3. | №01/111 | 2020.02.21 | Иргэний тэтгэврийн зээлийн төлбөрийг үнэт цаасаар төлөх тухай гэрээ | 299,708,000,000 төгрөг | Хангасан |
| 4. | №01/236, 0520/671 | 2020.05.15 | Эрдэнэс бонд худалдан авах, шаардах эрх шилжүүлэх гэрээ | 11,453,062,650.00 төгрөг | Хангасан |
| 5. | №01/441, 0520/962 | 2020.09.24 | Эрдэнэс бонд худалдан авах, шаардах эрх шилжүүлэх гэрээ | 45.618.180.075 төгрөг | Хангасан |

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичиг"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6. | №01/481, 0520/1005 | 2020.10.23 | Эрдэнэс бонд худалдан авах, шаардах эрх шилжүүлэх гэрээ | 31,336,658,400 төгрөг | Хангасан |
| 7. | №08-01 | 2020.12.25 | Эрдэнэс бонд худалдан авах, шаардах эрх шилжүүлэх гэрээ | 147,588,391,903.04 төгрөг | Хангасан |
| 8. | №01/188 | 2021.07.22 | Буцаан худалдан авах гүйлгээ Ам доллар | 23,000,000 ам доллар | Хангасан |
| 9. | №54/339 | 2021.12.13 | Батлан даалтын гэрээ | 28,000,000,000 төгрөг | Хангасан |
| 10. | - | 2021.11.10 | Гадаадын банкнаас зээл авах хэлцэл | 11,000,000 ам.доллар | NA |

Дээр дурдсан Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээнүүд нь Монгол Улсын Иргэний хууль, Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль, Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн №74 дүгээр тогтоол "Зээлийн багц шилжүүлэх Төрийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай", 2014 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 27 дугаар тогтоол, Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн №266 дугаар тушаал зэрэг холбогдох бусад хууль тогтоомж, Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд байгуулагдсан хүчин төгөлдөр гэрээ байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Нэгтгэн дүгнэвэл Үнэт цаас гаргагчийн байгуулсан түүний үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой дээр дурдсан гэрээ, гэрээний загвар нь хууль тогтоомжид нийцсэн байна.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичиг"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.

СЭХ
2022 он .09 сар 21 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 5. СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН ДОТОР ХИЙСЭН ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ НЬ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ХИЙГДСЭН ЭСЭХ

Хуулийн фирм нь энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2019 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд Банкны бусадтай бичгээр байгуулсан гэрээ, хэлцэл дотор их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулагдсан эсэх, 2019 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө байгуулагдсан хэдий ч 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар дуусгавар болоогүй хэрэгжиж байгаа их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа эсэх, байгаа нөхцөлд Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийгдсэн эсэх асуудлыг судалж үзлээ.

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, тэдгээрийн холбогдох этгээдийн бүртгэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хөтөлдөг. Харин Төрийн банкны Гүйцэтгэх захирал, газар, хэлтсийн захирал, салбар, тооцооны төвийн захирал, тэдгээрийн холбогдох этгээдийн бүртгэлийг Хүний нөөцийн программд тухайн албан тушаалтан бүртгүүлдэг бөгөөд Хүний нөөцийн үйл ажиллагааны хэлтэс нь тус программыг хариуцаж, холбогдох мэдээллийг татаж гаргадаг талаар Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно.

***Иргэдтэй байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар***

Төрийн банк ХХК-ийн дүрэм, Сонирхлын зөрчлийг зохицуулах журамд Компанийн тухай хуулийн 84.1, 84.2-т заасны дагуу ТУЗ-ийн дарга, гишүүн, Гүйцэтгэх захирал, дэд захирлууд, газар хэлтэс албадын захирал, салбар тооцооны төвийн захирал зэргийг эрх бүхий албан тушаалтан гэж тодорхойлсон. Үнэт цаас гаргагч нь бидэнд 2021.01.01- 2022.05.31-ний хооронд (зөвхөн нэг жил 5 сарын хугацаанд) эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн холбогдох этгээд болох хувь хүмүүстэй байгуулсан 21,393 зээлийн гэрээ байгаа тухай мэдээллийг Гүйцэтгэх захирал бидэнд ирүүлсэн.

Эдгээрээс 16,924 гэрээ хэрэгжиж дууссан, 4,469 гэрээ хэрэгжиж байгаа бөгөөд үүнээс 4,466 "хэвийн" ангилалтай байна. Зээлийн дээд хэмжээ 618,720,000 төгрөг, дундаж хэмжээ 2,616,246.03 төгрөг байна. Зээлийг төрлөөр авч үзвэл хадгаламж барьцаалсан 18,918, цалингийн 589, тэтгэврийн 800, орон сууцны ипотекийн 102, малчны зээл 470 , бусад (карт, гялс, газар тариалан гм) зээл 514 байна.

Эдгээр зээл нь эрх бүхий албан тушаалтан, түүний нэгдмэл сонирхолтой хувь хүмүүст олгосон зээл байх бөгөөд тэдгээрийн 20-оос дээш хувийг нь эзэмшдэг хуулийн этгээдийн талаар бүртгэл хөтөлдөггүй. Харин Сангийн яам болон түүний хувьцааг нь эзэмшдэг 6 компани, Хадгаламжийн даатгалын корпорацитай байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг бидэнд ирүүлсэн болно.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн **"гаргаж өгсөн баримт бичигт"** тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.

СЗХ 2022 он 09 сар 21 өдөр БҮРТГЭВ № 01

2022-09-14

Компанийн тухай хуулийн 89, 92-р зүйлд зааснаар сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрлийг ТУЗ олгох бүрэн эрхтэй. Гэвч дээрх тоон үзүүлэлтээс үзвэл ТУЗ нь сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгохоор хэдэн арван мянга удаа хуралдах бодит боломжгүй байгаа нь Үнэт цаас гаргагчийн хувьд онцлог байна.

Банкны Зээлийн үйл ажиллагааны журмын 9 дүгээр зүйлд "Банкны холбогдох этгээд болон ажилтны зээлийг шийдвэрлэх" асуудлын талаар зохицуулсан ба банкны холбогдох этгээдээс хамаарч зээл судлах, зээл шийдвэрлэх хороодын бүрэн эрх өөр өөр байна. Үүнд:

*Хүснэгт №14. Төрийн банк ХХК-ийн зээл шийдвэрлэх хороодын бүрэн эрх*

| Д/д | Банкны холбогдох этгээд болон ажилтны зээлийн хүсэлт | Зээлийн төрөл | Судлах нэгж | Шийдвэрлэх хороо |
|---|---|---|---|---|
| 1 | Банкны холбогдох этгээд /салбар, тооцооны төвийн захирал хамаарахгүй/ | Бүх төрлийн зээл | ББЗҮАХН | ЗЕХ |
| 2 | Банкны холбогдох этгээд /салбар, тооцооны төвийн захирал хамаарахгүй/-ийн хамаарал бүхий этгээд | Бүх төрлийн зээл | Салбар | ЗЕХ |
| 3 | Банкны газар, хэлтэс, алба, төвийн ажилтан | Орон сууцны зээл | ББЗҮАХН | ЗДХ |
| | | Хэрэглээний зориулалттай зээл | | ББЗҮАХН-ийн захирал, Зээлийн газрын захирал* |
| | | Дээрхээс бусад бүх зээл /малчин болон бизнесийн зориулалттай зээл/ | Төв салбар | СЗХ |
| 4 | Салбарын захирал | Бүх төрлийн зээл | ББЗҮАХН | ЗДХ |
| 5 | Тооцооны төвийн захирал | Бүх төрлийн зээл | Харьяа салбар | СЗХ |
| 6 | Салбар, тооцооны төвийн захирлын хамаарал бүхий этгээд | Бүх төрлийн зээл | Салбар, тооцооны зээл | СЗХ |
| 7 | Нэгжийн ажилтан | Бүх төрлийн зээл | Харьяа салбарын зээлийн ажилтан, тооцооны төвийн захирал | СЗХ |
| 8 | Банкны ажилтны орон сууцны ипотекийн зээлийн хүсэлтийг "Төслийн зээлийн бүтээгдэхүүний журам" -ын дагуу судалж шийдвэрлэнэ. | | | |
| 9 | Банкны ажилтны орон сууцны зээлийн хүсэлтийг "Ажилтны орон сууцны зээлийн журам" -ын дагуу судалж шийдвэрлэнэ. | | | |

*Банкны газар, хэлтэс, албаны ажилтан, салбарын захирлын хэрэглээний зориулалттай зээлийн хүсэлтийг шийдвэрлэх ББЗҮАХН-ийн захирал, Зээлийн газрын захирлын эрхийн түвшинг энэхүү журам, Скорингийн үнэлгээний журам, Зээлийн бүтээгдэхүүний журмаар тус тус зохицуулна.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй. Хуулийн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч банкны өөрийн хөрөнгө, түүний хүрэлцээ, төлбөрийн чадварын талаар аливаа асуудлыг тусгаагүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн "**гаргаж өгсөн баримт бичиг**" тулгуурлан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дүрэм, журамд заасан асуудлын хүрээнд бэлтгэгдсэн болно. Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарт үнэт цаасны танилцуулга, банкны тухай хууль тогтоомж, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БАНК

УЛААНБААТАР ХОТ ГҮЙЦЭТГЭХ

СЭХ
он 2022 сар 09 өдөр 21
БҮРТГЭВ
№ 01

2022-09-14
БҮРТГЭВ-03

Зээлийн үйл ажиллагааны журмаар Банкны холбогдох этгээд болон ажилтны зээлийг шийдвэрлэх эрх мэдлийг хамгийн дээд түвшинд Зээлийн ерөнхий хороонд олгосон. Компанийн тухай хуулиар сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрлийг ТУЗ-ийн бүрэн эрхэд хамааруулсан. Энэхүү журмыг Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан байх тул зохих журмын дагуу бүрэн эрх шилжүүлсэн гэж үзэх үндэслэлгүй байна.

Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журмын биелэлтийг үнэлсэн нэгдсэн үнэлгээтэй Монголбанк танилцан 2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А-6/793 тоот, 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А6/703 тоот үнэлгээний хариу хүргүүлэх тухай албан бичгүүдээр Төрийн банк ХХК-д өгсөн зөвлөмжид “сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл хийхтэй холбоотой журам батлуулан мөрдөн ажиллах” талаар дурдаж байсан бөгөөд уг журам 2022 оны 06 дугаар сарын 07-нд батлагдсан. Сонирхлын зөрчлийг зохицуулах журмын 3.6-д “Банкнаас холбогдох этгээдтэй хийх хэлцэл нь банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийдэг хэлцлээс илүү таатай нөхцөл олгоогүй бол тийм хэлцэл хийх зөвшөөрөл олгох нөхцөл, журмыг ТУЗ тогтоож болно” гэж заасан нь уг асуудлыг Төрийн банк ХХК-ийн онцлог, бодит нөхцөлд нийцүүлсэн журам тогтоох боломжийг ТУЗ-д олгож байна.

Хуулийн дүгнэлт гаргах явцад бид тус Банкинд албан ёсоор хандсанаар тасалбар болгох өдрөөс өмнөх сүүлийн 3 жилийн дотор Банкны хувьцаа эзэмшигчтэй болон хувьцаа эзэмшигчийн хувьцааг нь эзэмшдэг компанитай байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийн талаарх мэдээллийн авч дүн шинжилгээ хийсэн.

***Хуулийн этгээдтэй байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар***

*Хүснэгт №15. Сүүлийн 3 жилийн дотор хуулийн этгээдтэй байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцэл*

| № | Гэрээний нөгөө тал | Гэрээний нэр, эрх бүхий этгээдийн шийдвэр | Их хэмжээний, сонирхлын зөрчилтэй аль нь болох | Хэрэгжилтийн байдал |
|---|---|---|---|---|
| ***Төрийн банк ХХК нь өөрийн хувьцаа эзэмшигчтэй байгуулсан хэлцлүүд*** | | | | |
| 1. | Сангийн Яам, Гаалийн Ерөнхий газар | 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/254 дугаар Арилжааны банкинд төсвийн орлогын тэг үлдэгдэлтэй дансыг нээх, түүний төлбөр тооцоог зохицуулах гэрээ | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжсэн |
| 2. | Сангийн Яам | 2019 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 02а/493 дугаар Жижиг дунд үйлдвэр ба бүтээгдэхүүний удирдлагын хөгжил төсөл нэмэлт санхүүжилтийн /эмэгтэйчүүдийн бүлэгт олгох зээл/ дамжуулан зээлдэх гэрээ | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжсэн |

